

## ХӨДӨЛГӨӨНТ АРАЛ

1865 онд ер бусын хачин явдлууд гарсан нь өнөө хүртэл олон хүний санаанд байсаар байгаа буйзаа. Эдгээр явдлын дуу чимээ эх газрын ард иргэдийн сонирхлыг татаж, далайн замын боомт хотуудын оршин суугчдыг сандраан, ялангуяа далайчдын сэтгэлийг сүрхий түгшүүлэв. Худалдаачин, хөлөг онгоцны эзэн, капитанууд, бага дарга, далайн цэрэг, тэрч байтугай шинэ, хуучин тивүүдийн хэд хэдэн улс гүрний засгийн газар тэр нэгэн хачин явдлыг гойд шохоорох сонирхож байв.

Тэр жил их далайн хэд хэдэн хөлөг онгоц халим загаснаас том, хурдаараа түүнээс хавьгүй илүү, заримдаа өөрийн биеэс хурц гэрэл цацарган байх, хоёр үзүүр рүүгээ шувтан, дундаа цүлхгэр, гонзгой юмтай гадаад далайд дайралдсан байжээ. Тэр юм буюу амьтны гадаад байдлыг өөр өөр онгоцны өдрийн тэмдэглэлүүдэд тодорхойлон бичсэнийг үзвэл өөр хоорондоо ялгаа багатай боловч цөм түүний хөдөлгөөнийг урьд өмнө дуулдаагүй асар хурдан гэж тэмдэглэсэн байв. Түүнийг халим хэмээн таамаглан үзэх боловч шинжлэх ухаанд мэдэгдсэн халим төрөлтний дотроос нэг нь ч ийм асар том хэмжээнд үл хүрнэ. Кювье, Лассенед Дюмериль, Катрфаж<sup>1</sup> нарын хэн нь ч тийм сүрхий гайхал байна гэдгийг нүдээрээ үзэхээс нааш үл итгэхсэн билээ.

Түүнийг нүдээрээ үзсэн зарим хүн уртаараа английн хоёр зуун фут гэх бөгөөд энэ нь хэт багасгаж, нөгөө хэсэг нь уртаашаа гурван миль, өргөөшөө нэг миль гэж тодорхойлсон нь хэтэрхий ихэсгэсэн байв. Улсын ам хэдийгээр ийнхүү зөрөх боловч олон мэдээнүүдийг цэгнэн үзвэл тэр амьтан, хэрэв байдаг нь үнэн л болж гэм амьтны аймаг судлагсдын мэдэж буй бүх адгуус амьтантйа зүйрлэмгүй том юм байсан гэж бардаагаар хэлж болох юм. Гэтэл байгаа баримт нэгэнт маргашгүй болохоор тийм амьтан байгаа эсэх гэж эргэлзэх явдалгүй байв.

Хүн төрөлхтөн ер нь нууц бүрхэг юманд шохоорхдог зантай болохоор ийм юм дуулаад дэлхий дахинаараа гүнээ сэтгэл догдолсон нв зүй буйзаа. Калькутт хотын хөлөг онгоцны нийгэмлэгт харъяалагдах “Губернатор Хингинсон” гэгч онгоц 1866 оны долоодугаар сарын хориноо тэрхүү хөдөлгөөнт бөөн хар юмтай дайралджээ.

Түүнийг зураг дээр тэмдэглэгдээгүй арал хэмээн хөлөг онгоцны капитан Бэккэр газар зүйн координатыг нь нарийн тодорхойлохоор завдаж байтал, тэрхүү юмны дотроос гэв гэнэт хоёр салаа ус нарийхнаар исгэчин олгойдож, зуун тавин фут өндөрт хөөрлөө. Энэ нь хэрвээ л далайн ёроолын грейзер<sup>2</sup> дээшээ олгойдоогүй бол “Губернатор Хингинсон” хоншоороороо ус уур тургиж явах далайн ямар нэгэн сүүгээр

бойжигчидтой тулгарснаас зайлсангүй ээ.

Бас, Дорнот-Энэтхэг болон Номхон далайн хөлөг онгоцны нийгэмлэгт харъяалагдах “Христофор Колумб” онгоцон дээрээс 1866 оны долоодугаар сарын 23-ны өдөр тэрхүү хачин амьтныг Номхон Дөлгөөн далайд байхыг нь харжээ. “Губернатор Хингинсон”, “Христофор колумб” хоёр тэр гайхалтай халимыг гуравхан хоногийн зөрөөтэй хугацаанд нэг нэгнээсээ далайн бүхэл бүтэн долоон зуун миль зайтай газар дэлхийн бөмбөрцгийн хоёр цэгт олж үзсэн болохоор үнэхээр санаанд багташгүй айхтар хурдан хөдлөх чадвартай эд байжээ.

<sup>1</sup> Түмэн бодис судлагч эрдэмтэд

<sup>2</sup> Газрын гүнээс тогтмол хугацаанд оргилж байдаг уур ба халуун усны оргил

Түүнээс арван тав хоногийн дараа Америк, Европ хоёрын хооронд Атлантын гадаад далайд уулзсан үндэсний компанийн “Гельвец”, Роял Мейл компанийн “Ханан” гэдэг хоёр хөлөг умарт өргөрөгийн 45 хоног 15 хувь, умарт уртрагийн ( гренвичээс ) 60 хоног 31 хувьд тэр гайхлыг бас үзжээ. Тэдгээр онгоцны хоёр капитан уул сүүгээр бойжигчийн уртыг адаглаад английн 350 фут гэж гаргасан байв. Гэтэл “Гельвец”, “Ханан” хоёр хөлөг онгоц үзүүрээсээ сүүлээ хүртэл дөнгөж 325 фут болохоор түүнээс богино ажээ. Тэхэд Алеут арлуудын орчинд тохиолдох хамгийн том халим 150 футээс хэтэрсэн түүхгүй.

Эдгээр мэдээ болон цаашдаа Атлантын тээврийн “Перейра” гэх галт онгоц, тэр гайхлыг мөн олж харсан, “Этна” гэгч онгоц түүнтэй мөргөлдсөн зэрэг удаа дараалан гарсан сураг чимээ, эцэстээ францын “Норманди” хэмээх хөлөг онгоцны офицеруудын баталгаа бичиг, “Лорд Клайд” онгоцны дарга Фитуджемсээс Английн тэнгисийн хэрэг эрхлэх газар ирүүлсэн тайлан-энэ бүхэн олон түмний санаа сэтгэлийг хязгааргүй их үймрүүлсэн билээ. тэрхүү ер бусын хачин явдлыг зраим оронд элэг доог болгосон авч Англи, Америк, Герман мэтийн буурьтай орнууд ихэд сонирхон үзэв. Нийслэл хот бүхэнд тэр гайхлын тухай ярилцах болов. Түүний тухай тайзан дээрээс шоолон дуулах, сэтгүүлүүдэд шогчлон зурах, театрууд дүрслэн үзүүлэх болжээ. Бас умарт далайн орчны уснаа орших аймшигт цагаан халимаас эхлээд, 500 тонн хүнд хөлөг онгоцыг тэвэрч аваад далайн ёроолд орчхож чадах зөн болсон наймаалж хүртэл, хүмүүс санаанаасаа бодож гаргасан буюу үнэхээр амьдарч байгаа мьтдыг дүрсэлсэн дүрийг бүх сонин хэвлэж байв. гэтэл архивуудаас эртний баримт бичгүүдийг ухаж эхэлсэн бөгөөд далайн ямар нэгэн аварга амьтан байж

болох тухай Аристотель, Плиний нарын гэрчилгээ, Норвегийн далайчдын өгүүллэг, Пауль Геггедийн мэдэгдэл, хамгийн эцэст далайн асар том могойг 1857 онд нүдээрээ харсан Харрингтоны бодит баталгаа зэргүүдийг үзэв.

Гэтэл бас эрдэм шинжилгээний сэтгүүлүүд болон эрдэмтэн мэргэдийн дунд, итгэгсэд ба үл итгэгсдийн хооронд эцэс хязгааргүй маргаан дэгджээ. Гайхлын тухай асуудал ухаантан бүрийн тархи толгойг эзлэв. Тэрхүү маргааны үед мөн ч их бэх цаас үрсэн байх.

Бүтэн 6 сарын турш ач тач маргалдлаа. “Бразилийн газар зүйн институт”-ийн мэдээлэл, “Берлингийн шинжлэх ухааны хүрээлэн”-гийн сэтгүүл, Вашингтоны Смиттийн институтын сэтгүүл зэрэгт нийтлэгдсэн өгүүллийг нийтийн өмнө элэг доог болгосноор барахгүй, “Энэтхэгийн ольтриг”, петерманны “Мэдээлэл” зэрэг буурьтай сэтгүүлүүдэд гарсан өргөн шүүмжлэл болон евродын сонгодог сэтгүүлүүдийн эрдэм шинжилгээний сонсгол сэлтийг эрээ цээргүй хэвлэлийн зүгээс дайран доромжилжээ. Түүнчлэн гайхлын эсрэг зогсогч хэн нэгэн хүн “Байгаль, тэнэгүүдийг төрүүлддэггүй” гэж Карл Линейн <sup>1</sup> хэлсэн үгээр бамбай барин “Гагцхүү согтуу далайчдын ухаан санаанд орж болох, хэнд ч хэрэггүй тийм гайхлыг бий болголоо гэж байгалийг бүү доромжил” хэмээн эрдэмтдийг сэтгүүлчид ятгаж билээ. тэг тэгсээр хамгийн сүүлд долоо хоног тутам гардаг шог сэтгүүл томоос том зохиолчдын нэрээр гайхлын эсрэг хааж хаацайлахын аргагүй ширүүн дайралт хийсний дараа түүнийг хамгаалагчид нийтийн хүчээс инээд тохуу хийхийн эрхэнд араг буюу ухрахад хүрчээ. Тийнхүү шинжлэх ухааныг хурц оюун ялж билээ.

Гайхлын тухай яриа 1867 оны эхний саруудад сэхэж сэргэх найдваргүй болж булшлагдсан мэт байв. Гэтэл шинэ шинэ баримтат зүйл энэ удаа уншигчдын сонорт дуулдав. Энэ удаа шинжлэх ухааны ерөнхий нэгэн асуудал шийдвэрлэх яриа дэгдсэнгүй, харин ёстой жинхэнэ үнэн бодит аюул хөнөөлтэй тэмцэх тухай яригдаж эхэллээ. тэр асуудал шинэ баримтуудаар баяжив. Гайхал маань одоо арал, хад болон хувирч “арал аралдаа бүр хөдөлгөөнт, баригдашгүй, танигдашгүй, жигтэй хачин арал” болжээ.

<sup>1</sup> *Швейцарийн алдарт байгальч ( 1707 – 1778 )*

Монреалийн тэнгисийн компанийн “Морави” гэдэг хөлөг онгоц 1867 оны 3-р сарын 25-ны шөнө өргөргийн 27 хоног 30 хувь ба уртрагийн 72 хоног 15 хувьд урьд өмнө ямарч газрын зурагт тэмдэглэгдээгүй хад мөргөжээ.”Морави” онгоц 400 морины хүчтэй

мотор ба аясын салхины хүчээр цагт 13 зангилаагийн хурдай явжээ. хэрвээ онгоцны бүх бие тийм бат бэх байгаагүйсэн бол ийм их хурдтай явж байхад энэхүү мөргөлдөөн тун харамсалтайгаар төгсгөл болж, уул онгоцны баг болон сууж явсан 237 хүний амь насанд аюул учрахсан билээ.

Мөргөлдөөн өглөөний таван цагт болжээ. Энэ хэр дөнгөж гэгээ орж байжээ. Ингэж мөргөлдөх үед ээлжийн офицерүүд онгоцны хүрээ хашлага руу гүйлдэн очив. Тэд далайн усыг ихэд анхааран ширтсэн боловч хэрвээ онгоцноос гурван кабельт <sup>1</sup> зайтай ямар нэг хүчирхэг сэнсний далбаагаар дэлсэгдэх мэт оволзон хөөсөрч байгаа давалгааг эс тооцвол өөр сэжигтэй юм огт үзэгдсэнгүй. Тэр явдал болсон газрын координатыг яг гаргаж аваад “Морави” онгоц аян замаа үргэлжлүүлэв. “Морави” онгоцонд сүйдсэн зүйл гаднаасаа л мэдэгдсэнгүй, онгоцны дарга нар тархиа эргэтэл бодсон боловч усан доорхи арал буюу эсхүл живсэн онгоцны сэг, чухам юу мөргөснөө олсонгүй.

Тэгээд, боомт хотноо хүрэлцэн ирж “хуурай” зогсоолдоо орж үзвэл “Морави”-ийн килийн <sup>2</sup> хагас нь зад цохигдсон байжээ.

Хэрвээ энэ хачин явдал 3 долоо хоногийн дараагаар мөн тиймэрхүү нөхцөл байдалд давтагдаагүйсэн бол дээрх явдлын нэг адил даруйхан мартагдахсан билээ. Энэ удаа гайтсан тэр хөлөг онгоц нь дэлхий дахинаа цуутай усан замын нийгэмлэгт харъяалагдаж байсан учир тэр явдал дэлхийг ихэд шуугиулав.

Бодвол Английн усан замын хөлөг онгоцны эзэн Кьюнардыг бүгд сайн мэдэх байлтай. Хамгийн анх түүний хөлгүүд Америк, Европ хоёрын хооронд тогтмол харилцаа барьсан билээ. Кьюнардын хөлөг онгоцны байгууллагын оршин тогтнож ирсэн хорин долоон жилийн дотор түүний хөлгүүд Атлантын гадаад далайг хочр мянга илүү удаа гатлан аялахдаа тогтоосон цагаасаа нэг ч удаа хожимдож, явах цагаа нэг ч удаа хойшлуулж, түүнд итгэмжилсэн шуудангаас нэг ч захидал бичиг гээгдүүлж байсангүй. Кьюнардын хөлөг онгоцны байгууллагын нэр хүнд маш өндөр байсан учир ямар нэгэн өрсөлдөөнөөс айдаггүй байв. Тийм ч учраас түүний шилдэг хөлгүүдийн нэгэнд тохиолдсон тэр явдал төчнөөн их шуугиан дэгдээжээ.

1867 оны 4-р сарын 13-нд өчүүхэн ч салхигүй, далайн ус толь шиг мэлтийн байхад “Шотланд” онгоц уртрагийн 15 хоног 12 хувь, өргөргийн 45 хоног 37 хувьд явж байлаа. Мянган морины хүчтэй аварга машин бүхий хөлөг онгоц цагт арван гурав, зууны дөчин гурван зангилаа хурдтай явж байжээ. “Шотланд”-ын сэлэх хурд далайн усыг цагийн санжлуурын жигд хөдөлгөөнөөр зүсч явлаа.

Түүнд сууж явагсад, онгоцны их танхимд цай ууцгааж байгаа үе өдрийн 4 цаг 7

минутад “Шотланд” баруун бөөрөндөө, сэлэх хүрднээсээ арай хойхон ёврогдох мэт болж үл мэдэг доргижээ.

Ёвролт тун яльгүй байсан тул хэрвээ л онгоцны зоорин дотроос :

- Зооринд ус орлоо! Хүүе, бид живж байна ! гэж хашгиралдаагүйсэн бол гадаа тавцан дээрх улс мэдэхгүй өнгөрөх байсан бизээ.

Зорчигчид сандрах нь мэдээж хэрэг. Гэсэн ч онгоцны капитан Андерсон тэднийг тайтгаруулж байв. Үнэндээ ч ус үл нэвтрэх долоон давхар хамгаалалт хөндийтэй “Шотланд” онгоцонд ганцын зэрэг цоорхой төдий л аюул учруулж чадахгүй ажээ.

Капитан Андерсон зооринд яаравчлан орж тав дахь хамгаалалт өндийд ус дүүрч улмаар ус нэмэгдэж байгааг нь үзвэл бөөрийн цоорхой асар их болотой гэдгийг мэдэв. Заяа дайрахад тэрхүү хөндийд уурын тогоонууд байсангүй.

<sup>1</sup> уртыг хэмжих далайн хэмжээ. 200 орчим метр.

<sup>2</sup> хөлөг онгоцны ёроолын уртаашхи гол холбоос.

Капитан Андерсон онгоцны оньст машиныг даруй зогсоож нэгэн усан цэрэгт ус дүүрсэн хөнлий рүү шумбан орох тушаал өгчээ. Тэр усан цэрэг гарч ирээд хөлөг онгоцны бөөр хоёр метр өргөн цөм цохигдсон байна гэж илтгэв. Тийм том цоорхойг далай дээр бөглөх гэж ярихын ч хэрэггүй тул “Шотланд” сэлэх хүрднийхээ тэн хагаст хүртэл усанд доош сууж арай ядан аян замаа үргэлжлүүлэв.

“Шотланд” тэр үед Кпирийн хошуунаас 300 миль зайтай байсан ба Ливерпуль боомтод хугацаанаас гурав хоног хожимдож ирсний нь Англи даяар тун их сэтгэл түгшин хүлээсэн билээ.

Түүнийг даруй уснаас татаж гаргаад инженерүүд үзэж шалгхдаа өөрсдийн нүдээр олж үзсэндээ үл итгэжээ. Учир нь “Шотланд”-ын их биеийн гол бүслүүр шугамаас доош хоёр метр хагас зайтай, адил талт гурвалжин мэт хэлбэртэй, асар том нүх онгойн үзэгджээ. Түүнийг зориуд нүхэлсэн шиг цөмөрхийний ирмэг тэв тэгшхэн байсан нь их биеийг ёворсон багаж ган сайтай байснаас зайлсангүй.

Түүнээс гадна их биеийн дөрвөн хуруу зузаан төмрийг цөм цохисон тэр багаж тэрхүү нүхэндээ зуурчихсангүй яахин ангижирч салсан асуудал тун гайхалтай үлдэв. түүнийг тайлбарлах ямар ч арга алгаа.

“Шотланд”-тай учирсан тэр тохиолдол хүмүүсийн сэтгэлд унтарч агсан ер бусын гайхамшигтай явдлыг дахин сэргээлээ. Энэ минутаас эхлэн ямар нэгэн үл ойлгогдох шалтгаанаас үүсвэрлэсэн далайн сүйрлийг өнөөх гайхалтай шууд холбох болжээ.

Тийм учраас гадаад далайд жил бүр гарах 3000 орчим сүйрлийн 200-гаас доошгүй хэсгийг “сураггүй алга бологч” вангийн дансанд бүртгэх болсон тул домог болсон өнөө гайхлын хийсэн нүгэл хилэнц өдрөөс өдөрт улам хүнд болж байсан нь зүйн хэрэг буйзаа.

Эдгээр гай тотгорын хариуцлагыг тэрхүү гайхалд үүрүүлэх нь шударга ч байсан, шударгаг бус ч байсан, тив хоорондын зам харилцаа аюултай болсны улмаас айж сандарсан орон бүхний ард олны санал далай тэнгисийн тэрхүү гайхлаас ямар боловч чөлөөлөх хэрэгтэй хэмээн шаардсан бүлгээ.

[Тор](#)

---

## “ЗА”, “ЭСХҮЛ”, “ҮГҮЙ”

Тэрхүү шуугиан дэгдэж ахуй цагт би хойт Америкийн Небраск мужийн зэрлэг хязгаараар жуулчилж явлаа. Миний биеийг байгалийн түүхийн судлалын Парижийн музейн эрдэм шинжилгээний ажилтан ба түмэн бодисыг шинжлэн судлагчийн хувьд эрдэм шинжилгээний экспедицид Францын засгийн газраас томилон явуулсан билээ. Би Небраскт 6 сар байж үнэт чухаг цуглуулга хийгээд 1867 оны 3-р сарын сүүлчээр Нью-Йорк хотноо ирсэн юм. Миний бие 5-р сарын шинэдээр Францдаа буцах хэрэгтэй байсан тул үлдсэн хугацаагаа би өөрийн эрдэс ургамлын болон амьтныхаа цуглуулгийг эмхэлж цэгцлэх ажилд зарцуулахаар шийдлээ.

Олон нийтийн сэтгэл санааг донсолгосон тэр их шуугианыг би мэдэж байлаа. Тиймээ ердөө хамаг сэтгүүл сонин далайн гайхлын тухай мэдээллээр дүүрсэн байсан цагт түүний тухай мэдэхгүй байж болох уу даа? Тэр нэгэн хачин явдал миний сонирхлыг ихэд хөдөлгөж билээ.

Би тэрхүү үйл явдалд чухам ямар тайлбар өхөө мэдэхгүй нэг таавраас нөгөө таавар руу гуйвж байлаа. тэрэнд ч ямар нэг нууц байгаа нь мэдээжийн хэрэг, энүүнд үл итгэгсэд “Шотланд”-ын цөм цохигдсон бөөрийг үзвэл л үнэмших байх.

Нью-Йоркийнхан хот даяараа гайхан сонирхоцгоов. Учрыг бага мэдэх хүмүүсийн гаргасан баригдашгүй далан, хөвөгч арал гэх мэт таамаглалууд аль хэдийн хол хаягдсан байлаа. Үнэндээ ч тэрхүү хөвөгч арал өөртөө л хүчирхэг хөдөлгүүргүй юм

бол яахин тийм асар иххурдтайгаар давхиж чадахыг тайлбарлах аргагүй ажээ. Мнө ямар нэгэн живж сөнөсөн асар том хөлөг онгоцны сэг хөвж явна гэсэн таамаглал тэр гайхлын маш хурлан хөдөлгөөнийг хариуцаж чадахгүй тул бас дээрхийн нэгэн адил орхигдсон байлаа.

Иймээс тэрхүү гайхал эсхүл асар том биетэй аварга амьтан, эсхүл маш хүчирхэг хөдөлгүүртэй усан доогуур явдаг хөлөг онгоц байх ёстой гэсэн үнэнийн хувьтай хоёр асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй боллоо.

Бөмбөрцгийн хоёр талд эрж шинжилж мөрдсөний дараа үнэн байдалднилээд дүйцэх сүүлчийн таавар нурж замхрав. Энэ усан доогуур явдаг хөлөг онгоц ганц хүнд өмчлөгдөн харъяалагдаж болно гэж бодож болохгүй байлаа. Түүнийг хаа нэгэн газар барих хэрэгтэй, тэхдээ ийм аварга том эдийг хүнд мэдэгдэхгүй барьж босгож чадахгүй байх ёстой.

Ийм аймшигтайгаар эвдлэн сүйтгэх хүчтэй механизмыг гагцхүү бүхэл бүтэн улс л хийж чадна. Хүн төрөлхтөн бие биеийг алан хядах шинэ шинэ аймшигт зэвсгийг нэг нэгнээсээ өрсөлдөн хийж байгаа манай энэхүү эмгэнэлт үед ямар нэгэн улс бусдаас нууцгайгаар цэрэг дайны хөлөг онгоцыг үйлдвэрлэн гаргаж хэрэг дээр нь шалгаж байж болох боловч орон бүхний засгийн газар, энэ хэрэгт холбогдолгүй болохоо дэс параалан илэрхийлсэн учраас цэргийн хөлөг онгоцгэдэг таамаглал бусдын нэгэн адил нурж уналаа.

Тэр гайхал олон улсын далайн тээвэр харилцаанд заналхийлж байгаа тул тэдгээр улсын засгийн газрын илэрхийлэлтийн үнэн худал болхыг сэжиглэх явдалгүй байлаа. Түүнээс гадна хэрвээ хувийн өмчтөн, ганц нэгэн этгээд иймэрхүү аварга том хөлөг онгоц үйлдвэрлэн байгааг нуухад бэрх бол аль нэгэн улс, атаархан далдуур ийм онгоц бүтээнэ гэдэг тэр тусмаа болшгүй хэрэг байв.

Тиймээс Англи, Франц, Орос, Герман, Америк түүгээр ч барахгүй Турк улсыг хүртэл байцаан шалгаж мухардсаны эцэст усан доогуур шумбагч хөлөг онгоц байна гэдэг сэжиг бүрмөсөн орхигдлоо.

Эрээ цээргүй хэвлэл элэг доог болохыг харгалзахгүйгээр далайн уснаа өнөөх гайхал дахин хөвж эхэлсэн бөгөөд хүмүүсийн хөөрсөн сэтгэл хамгийн хий хоосон таамаглалуудыг дараа дараагаар нь төрүүлэх боллоо.

Нью-Йоркт байхад энэхүү бүхнийг донсолгож байгаа асуудлын талаар өөрийн бодлыг хэлэхийг хүмүүс надаас гуйсан юм. Би Францаас гарахынхаа өмнөхөн “Далайн ёроолын нууц” гэдэг өөрийн бичсэн хоёр боть номыг нийтлүүлсэн билээ. Эрдэмтэн мэргэдийн дунд сайнаар хүлээн авагдсан энэ ном намайг түмэн бодисын ухааны

энэхүү маш бага судлагдсан салбарын мэргэжилтэн гэдэг нэр авах эрхтэй болгож өгсөн юм.

Намайг бодож байгаагаа хэлэхийг хоргоон шалгаагаад байв. Би элдэв шалтаг зааж энэ явдлаас зайлсхийж байсан боловч “Нью-Йоркийн мэдээлэл”-ийн сурвалжлагчид цөхрөлтгүй дагалдан шалах учир уул сониныг уншигчидтай, далайд болж буй тэрхүү хачин явдлын талаар өөрийн бодлыг хуваалцахаар амлахаас өөр аргагүй боллоо.

Ингэтэл, гайхлын тухай асуудлыг бүхийлэн талаас нь гэрэлтүүлэн нийтэд мэдэгдэж буй баримт мэдээнүүдэд шинжлэх ухааны дүгнэлтийг өгсөн профессор Аронаксын дэлгэрэнгүй өгүүлэл 4-р сарын 30-нд хэвлэгдэн гарав.

Уул өгүүллээс хэсгийг сийрүүлье :

Профессор Аронакс урьд өмнийн таамаглалуудыг тунгаан дүгнэж бичсэн нь : “Ингэхэд бид аль нэгэн талын шүүмжлэлийг тэсвэрлэн давах өөр нэг төсөөлөл, таамаглалгүй болсон учир арга буюу гайхлыг заяанаасаа асар их хүчин чадалтай далайн аварга амьтан гэж үзэхээс өөр замгүй байна.”

Далайн гүний амьдрал бидэнд ерөөсөө мэдэгдээгүй бөгөөд ямар ч зонд <sup>1</sup> тэдгээрийн ёроолд хүрээгүй байгаа юм. Эдгээр ёроолгүй цүнхэлүүдэд юу болж байна вэ? Далайн түвшнээс арван хоёр, арван таван <sup>2</sup> мянган метрийн гүнд ямар амьтан байдаг ба ямар амьтан амьдарч болох вэ ? Тэдгээр амьтдын биеийн бүтэц ямар байвал зохих вэ ? Үүнийг таамаглан хэлэхэд ч хэцүү.

<sup>1</sup> усны гүн хэмжих багаж,

<sup>2</sup> далайн хамгийн их гүн 10000м . 12000-15000м далай гэж байхгүй. \ хэтрүүлээ

Бидний өмнө зогсож байгаа тааврыг хоёр талтайгаар тааж болно. Үүнд : Газар дэлхий дээр амьдран байгаа бүх амьтад бүгдээрээ бидэнд мэдэгдэж байгаа юу, эсвэл тэдгээрийн хагас нь мэдэгдэж байна уу? гэдгээс шалтгаална.

Хэрэв манай ертөнц дээр амьдарч байгаа амьтдыг бид бүгдий нь эс мэдэж байгаа бол, хэрэв байгаль бодис бидэнд нууцаа гүйцэд задлаагүй бол далайн гүнд бидэнд үл мэдэгдсэн, өөртөө тусгай хууль бүхий нөхцөлд оршигч хөхөтөн буюу загасны дүрс буюу түүгэр ч барахгүй төрөл байж болохгүй гэх үндэс үгүй юмаа. Тийм амьтан ямар ч шинжилгээнд үл автах далайн ёроолын давхарга орчимд оршиж болох бөгөөд ямар нэгэн үл мэдэгдэх гэнэтийн өөрчлөлт буюу шалтгааны улмаас үе үе дээш хөвөн гарч ирдэг байж магадгүй.

Гэвч хэрвээ бид бүхий л дүрсийнамыд амьтдыг мэддэг юм бол тэрхүү гайхлыг урьд



өмнө ангилагдсан далайн амьтдын дотор эрэх ёстой. Хэрэг ийм болбол миний бие аварга том нарвал<sup>1</sup> байж болох талыг баримтлах санаатай байна.

Ердийн нарвал уртаараа гучин фут хүрэх нь олонтой тохиолдоно. Тэгээл энэхүү уртыг таваар үржүүл, арваар үржүүл, гарсан хэр хэмжээнд нь тохирсон хүчин чадлыг түүнд хүртээж мөн үүнтэйгээ харьцангуйгаар түүний соёог хүчирхэг болгож үзвэл та бүгд өөрсдийнхө сэтгэлийг хөдөлгөн байгаа нууцыг тааварлаж чадах болно. Иймэрхүү амьтан “Ханан” онгоцны офицеруудын тодорхойлсон хэмжээтэй тэнцэх бөгөөд түүний соёо “Шотланд”-ын их биенд тиймэрхү хэлбэрийн цөмөрхий гарагах чадалтай, далайн том галт онгоцыг живүүлэх хүчтэй болно.

Үнэндээ нарвал бол өвөрмөц ясан соёогоор буюу заримдаа байгальчдын хэлээр сүхэн жадаар зэвсэглэсэн амьтан байдаг. Тэрхүү сүхэн жад хэмээгдэх нь ган мэт хатуу байна. Тиймэрхүү сүхэн жадыг халимын биеэс олон удаа олсон, нэг талаас нөгөөтал хүртэл нэвт сүлбэгдсэн хөлөг онгоцнуудын модон биеэс арай ядан салган авч байсан удаа нэг бус билээ.

Парижийн музейн анагаах ухааны ангид угаараа дөчин найман сантиметр бүдүүн, уртаараа хоёр метр хорин таван сантиметр тиймэрхүү сүхэн жад хадгалагддаг юм. Ингээд бид ердийн нарвалаас арав дахин том нарвалыг асар бүдүүн сүхэн жад буюу соёотой нь санаандаа дүрслэн бодож цагт далайн хорин миль хурдтайгаар давхиж чадах чадлыг олоод түүний жинг хурдаар нь үржүүлж үзвэл тийм амьтантай далайн ямар ч хөлөг онгоц мөргөлдөх аваас, түүний улмаас гарсан аюул сүйрэлд та бүхэн эрхбиш гайхахгүй буйзаа.

Дүгнэж хэлэхэд энэ талаар дэлгэрэнгүй баримт дахин сонсдох хүртэл энэхүү гайхлыг би зөвхөн энгийн соёогоор бус жинхэнэ ган соёогоор зэвсэглэсэн, ёстой жинхэнэ хөлөг онгоцны жин хүнд, чадал хүчин бүхий аварга нарвал хэмээн тооцох болно.

“Хэрвээ л энэ ер бусын гайхамшигт амьтан үнэн хэрэг дээрээ байгаа юм бол зөвхөн ингэж л тайлбарлаж болно. Гэвч тэдгээрийг дахин магадлан шалгах хэрэгтэй байна.” гэжээ.

Энэ сүүлийн өгүүлбэр нь аймхай хулчигар сэтгэлээс нь үүсвэрлэн бичигджээ. Харин би сав л хийвэл шоолон инээлдэх дуртай оэж ч инээлдэн дооглож чаддаг америкуудад идэш болж инээдийг нь хүргэхгүй, эрдэмтнийхээ нэр төрийг хадгалах юмсан гэж бодлоо. Би иймэрхүү янзаар хаяагаа манаж авсан боловч үнэндээ тэрхүү гайхлын байгаад дотроо эс эргэлзэж байлаа.

Миний өгүүлэл нийтийн зүгээс хариу цуурай олж, ихээхэн нэрд гарав. Түүгээр ч барахгүй нилээд хэдэн хүмүүсийг өөрийн талд татаж чадлаа. Миний өгүүллийн дотор

дурьдсан тааврууд нууцыг тайлахад хүмүүсийн сэтгэлд ихээхэн тэжээл боллоо. Хүн гэдэг ер нь байж болшгүй юмыг буй болгон бодох дуртай. Тэгвэл далай бол тийм аварга амьтан оршиж болох нөхцөл бүхий ганцхан орчин мөн бөгөөд түүний дэргэд хуурай газрын хирс, заан мэтийн том амьтан өчүүхэн амьтан мэт байх ажээ. Далайн уснаа, жишээлбэл халим мэтийн хамгийн том хөхтөн амьдардаг билээ.

<sup>1</sup> *далайн ганц эвэрт, халим төрөлтний нэгэн дүрст сүүн тэжээлтэн.*

Тэгвэл, тэнд уртаашаа зуун метр, хүндээрээ хоёр зуун тонн аймшигт сүрхий аалз буюу наймаалж, аль эсхүл аварга том нялцгай биетэн байж яагаад болохгүй гэж ? Газар дэлхийн эриний үед дөрвөн мөчтөн, далавчтай болох мөлхөгчид асар их хэмжээнд хүрч байсан бөгөөд арав, хорь, зуун мянган жилийн дараагаар аяндаа одоогийн хэмжээнд хүртэл багассан юм. Тэгвэл дэлхийн бөмбөрцгийн гадаргуу тасралтгүй хувиран өөрчлөгдсөөр өдийн хүргэхэд, одоо болтол найрлагаа нэг ч удаа өөрчлөөгүй далайн ус, геологийн эртний алслагдсан галбын амьтны ертөнцийн нэгэн төлөөлөгчийг хадгалан үлдэж яагаад эс болдог билээ. Бүхэл бүтэн зуун мянга мянган жилээр наслах ууган аваргуудынхаа сүүлчийн нэгэн дүрийг тэнгис далай өөрийнхөө нууцад одоо болтол хадгалж яагаад болохгүй гэж ? Би энэ хий мөрөөдөлдөө дэндүү автчих шиг бололтой. Гэвч энэ бодол өөр хэн нэгнийг залхааснаас харин намайг залхаасан нь хомс.

Ингээд давтан хэлэхэд : Энэхүү ер бусын явдлын бодит дүр дахин маргаан дэгдээсэнгүй ба хий домог болсон далайн аварга могойтой өчүүхэн ч холбогдолгүй ямар нэгэн аварга амьтан байна гэдгийг олон нийт зөвшөөрөн хүлээв.

Хэрэв энэ асуудалд зарим нэгэн хүмүүс зөвхөн эрдэм шинжилгээний сонирхлын үүднээс хандаж байсан бол усан замын аюулгүй байдлыг сонирхогч, ялангуяа Англичууд, Америкчууд мэтийн бусад, ажлын хүмүүст далайг энэхүү аймшигт гайхлаас даруйхан цэвэрлэх арга хэмжээ авах асуудал чухал боллоо.

Санхүүгийн ба худалдааны хэвлэлүүд одоо гайхлын тухай асуудлыг гагцхүү энэ үзлийн үүднээс авч үзэх болжээ. Түүнчлэн “Далайн тойм”, “Алоид сонин”, “Пакатпот”, “Усан замын худалдааны сонин” зэрэг даатгалын нийгэмлэгийн хэвлэлүүд маш их хэмжээний хохирол учруулах гэж байгаа гайхалд хайр найргүй дайн зарлахыг нэгэн дуугаар шаардаж байв.

Олон нийтийн санал, юуны өмнө хойт Америкийнхны санал даатгалын нийгэмлэгийн талд байлаа. Нью-Йорк хотноо нарвал агнах тухай тусгай экспедиц бэлдэж эхлэв.

Үүний тул “Авраам Линкольн” гэдэг хурдан хөлөг онгоц тоноглон тоөхөөрөхөөр шийдвэрлэв.

Уул хөлгийн капитан Фарагут аль болохуйц түргэн далайд гарахыг хичээх бөгөөд хэрэгцээтэй бүх зүйл нь түүний өмнө нээлттэй байлаа. Гэтэл, ийм хэрэг явдал гарахад тохиолддог шигээр гайхлыг мөрдөх шийдвэр яг гарсан тэр үед, гайхал маань сураг чимээгүй болчихлоо. Бүтэн хоёр сар өнгөрөхөд түүний тухай хэн ч, юу ч олж сонссонгүйд нарвал өөрийн эсрэг аян дайны арга сүвэгчилж байна хэмээн мэдсэн юм шиг ажээ. Энэхүү аянгийн тухай Атлантын далайн усан доогуурхи шугамаар үргэлжлэн ярьж байсан билээ! . . . Шооч хүмүүс, нарвал тэрхүү учир тоймгүй олон цахилгаан мэдээний аль нэгийг нь олж аваад арилж өгөө биз хэмээн даапаалж байлаа.

Ингээд, хөлөг онгоц аян замд бүрэн томилогдож ер бусын ангуучлалд хэрэгтэй бүхнээрээ төхөөрөмжлөгдсөн тэр үед онгоцны маань ахмад чухам аль зүгт хөдлөхөө мэдэхгүй байжээ.

Ингэтэл ч Санфранциско ба шанхай хоёрын хооронд явдаг галт онгоц, өнөө амьтантай Номхон далайн умарт хэсэгт 3 долоо хоногийн өмнө учирсан сураг дуулдаж нийтийн тэвчээр туйлдаа хүрэв. Энэ мэдээ олны санаасэтгэлийг маш их хөдөлгөлөө. Капитан Фарагутада ядаж хорин дөрвхөн цаг ч хойшлох эрх олгосонгүй. Хоол хүнс бүрэн ачигдаж, зооринд нүүрс задартал нь чихээд, онгоцны баг бүрэлдэхүүнээрээ бүрэн байв. Зөвхөн зуухаа галлаж, уур тавиад занганаас мултрах л үлдлээ.

Хэрэв, капитан Фарагут дөнгөж хагас өдөр удааширсан бол түүнийг зүгээр өнгөрүүлэхгүй байсан бизээ. Гэвч тэр өөрөө тэртээ тэргүй аян замдаа тэмүүлж байлаа.

“Авраам Линкольн”-ыг хөдлөхөөс 3 цагийн өмнө над доорхи агуулгатай бичиг гардуулсныг сийрүүлбэл :

*“Эрхэм профессор АРОНАКС” танаа*

*Зочид буудал “Тав дахь авенью”*

*Нью-Йорк хот*

*Энэрэлт эрхэм ээ!*

*Хэрэв, таны бие “Авраам Линкольн” дээр морилж, энэхүү аянд гар бие оролцохыг болгоон хайрлах аваас, Франц улс энэ ажил хэрэгтээ танаар уламжлан хувь нэмрээ хүртээж буй хэмээн нэгдсэн холбооны улсын засгийн газар таалан үзэхсэн байнам.*

*Капитан Фарагут танд тусгай өрөө гарган өх болно.*

*“Танд чин зүрхнээсээ үнэнч,  
далайн хэргийг эрхэлсэн сайд  
Д.Б. Гобсон ёслол” гэжээ.*

[Тор](#)

---

## ЭЗНИЙ Л ТААЛАЛ МЭДЭЖ

Далайн сайдын захидлыг хүлээн авахаас гурван секундйн өмнө би умарт өрнөтийн мөсөн годиролын <sup>1</sup> дундуур зүсэн гарах оролдлогын тухай хичнээн бодддог байсанчлан нарвалын хойноос мөрдөн агнахыг төчнөөн л бодож суулаа. Захиаг хүлээн авснаас хойш гуравхан секундйн дараа миний хувь зохиол, миний амьдралын ганцхан зорилго энэхүү аюулт гайхлыг мөрдөн хөөж хүн төрөлхтнийг түүний хөнөөлөөс ангижруулахад оршино гэдгийг би сая ойлгож билээ.

Гэхэд, би хүнд хүчир жуулчлалаас дөнгөж эргэж ирээд маш их ядарч бие амсхийх явдал шаардагдаж байв. Би өөрийн нөхдийн зүг, өөрийн бяцхан цэцэрлэгийн дэргэдэх өчүүхэн байшингийн зүг өөрийн хорвоод хосгүй үнэт баялгийг цуглуулахыг тэмүүлэн, эх орондоо буцахыг тэмүүлж байв. Гэвч намайг юу ч барьж, тогтоож чадсангүй. Би өөрийн ядаргаа, нөхөд, цуглуулга бүгдийг таг мартаж, Америкийн засгийн урилгыг эргэлзэх юмгүй хүлээн авлаа.

“Аз болоход нарвал намайг Францын эрэгт хөтлөн аваачиж юу магад. Ер нь бүх зам Европийн зүг одсон юм биш билүү. Түүгээр ч барахгүй энэхүү эрхэм нэгэн амьтан өөрийн биеийг Европ орчны далайд дуусвар болгох бололцоог өгвөл би адаглаж түүний том соёлоос тохой хир хэрчмийг Парижийн түмэн бодисын түүхийн музейд аваачиж өх болно” хэмэн бодолхийлж билээ.

Гэвч одоохондоо нарвалыг Номхон Далайн умарт хэсэгт хайх хэрэгтэй болсон тул би Франц орондоо эргэн очиход ертөнцийг бүтэн нэг тойрно гэсэн хэрэг байлаа.

- Консель <sup>2</sup> ! хэмээн би өөрийн зарцыг дуудлаа. Энэ хүн бол миний үнэнч зарц бөгөөд аян замд надад үргэлж бараа болон явдаг байв. Би энэхүү тун бэрх фламанд

хүнд чин зүрхнээсээ хайртай болсон ба тэр ч мөн ачийг ачаар хариулдаг хүн билээ. Энэ бол төрөлхийн нүсэр, ааш зангаар тогтуун томоотой, ажилч хичээнгүй, тулгамдсан цагт тайвуун, юм юманд дүйтэй хөдөлмөрт шунахай, харин өөрийнхөө хочинд ер таараагүй хэзээ ч, хэнд ч, гуйсан зөвлөлөгөөн өгч яваагүй хүн юм.

Миний өчүүхэн гэрт үргэлж цугларан байдаг эрдэмтдийн дунд, Консель их юманд сурч амьтны ба ургамлын аймгийн ангилалтын хүрээ, анги, бүлэг, баг, доод баг, язгуур төрөл, дүрс, доод дүрс зэрэг бүх үе шатаар дамжин дээш доош торохгүй мэддэг байгалийн ухааны ангилалтын мэргэжилтэн болон хувирсан билээ. Гэвч түүний бүх мэдлэг үүгээр хязгаарлагдах ажээ. Ангилалтын онолд айхтармөртлөө, дадлага ажлаас нилээд тасархай, тэр миний бодоход, шүдэт халимыг энгийн халимаас гадаад байдлаар нь ялгахгүй байхаа.

<sup>1</sup> *америк тивийн умарт эргийн орчимд Атлантаас Номхон далайд явж орох нарийхан зурвас газар*

<sup>2</sup> *Францаар “зөвлөх” гэсэн үг.*

Гэлээ ч гэсэн ямар бэрх хөвүүн гэж санана. Консель бүтэн 10 жилийн турш алсын аян замд, эрдэм шинжилгээний жуулчлал бүрд намайг дагалдсан билээ. Би хэзээ ч түүнийг ямар нэгэн бэрхшээлийн өмнө янгуучлан гуншигнаж байхыг сонсоогүй юм. Консесь, Хятад газар ч юмуу, Конго нутагт ч юмуу, ер нь ямар ч оронд, ямар ч эргэлзээгүй, юу ч асуухгүй, хэзээ ч хамаагүй явахад үргэлж бэлэн байдаг хүн.

Тэрний бас мэдрэл булчин чанга, ер нь ямарваа өвчинд саадгүй эрүүл чийрэг биетэй билээ.

Консель одоо гучин настай боловч миний дэргэд арван тав хорьтой харьцахын жишээтэй ажээ. Жич би өөрийн биеийг дөчтэй хэмэн хүлээхийн оронд энэ нэгэн будлиантай хахрьцааг гаргаж ирсэнийг минь уучлахыг хүснэ.

Консельд ердөө цор ганцхан өө бий. Энэ нь : Тэр ёстой засаршгүй ёс баримтлагч бөгөөд надтай харьцахдаа өөрийн биеийг үргэлж гуравдугаар биед хамаатуулан ярьдаг нь намайг үргэлж цухалдуулдаг байв.

- Хөөе, Консель ! гэж би аян замд шуурхайлан бэлтгэхийн ссацуу давтан дуудлаа.

Консель надад хязгааргүй үнэнчийг би мэднэ л дээ. Ер нь би түүнийг аян замд намайг дагалдах эсэхийг нь асуудаггүй боловч энэн удаагийн жуулчлал хэд хичнээн хугацаагаар удаашрах нь мэдэгдэхгүйн дээр амь насанд ч аюултай хэрэг байсан тул түүний саналыг асуухаар шийдлээ. Далайн том хөлөг онгцыг самрын яс шиг няцлан

чадах амьтныг мөрдөнө гэдэг тоглоом бишээ ! Ертөнц дээрх хамгийн амар тайван хүн ч гэсэн юм бодохоор хэрэг байлаа. Консель маань юу гэдэг бол ?

- Ээ, Консель гэж гурав дахь удаагаа дуудлаа.

Консель ч ирэв. Тэр орж ирэх зуураа :

- Эзэн та намайг дуудав уу ? гэж асуухад нь би

- Дуудсан, хонгор минь. Замд хэрэгтэй бүхнийг бэлд. Хоёр цагийн дараа бид хөдөлнө.

- Эзний л таалал мэдэж хэмээн тэр санаанд ч үгүй хариулав.

- Нэг ч минут хий өнгөрөөж болохгүй. Дээл цамц оймс юу л хэрэгтэй бүхнийг аль багтахаар нь ганзаганд хий. Болбол түргэхэн шиг!

- Аа эзний цуглуулгийг яах вэ гэж Конселийн асуухад :

- Тэдгээрийг дараа болъё. Зочид буудалд хадгалуулж үлдээнэ.

- Тэгвэл,

- Хорин халиун гахайгаа яах вэ ?

- Үүнийг бид хоёр тэжээж байх болно. Би амьтдуудыг Франц явуулах талаар ярьчихна.

- Тэгвэл бид Париж руу явахгүй нь ээ ! гэж Консель асуухад би :

- Юу ч гэмээр юм бэ дээ гэж гуйвсхийж хариулаад,

- Юу ч гэсэн бид жаахан тойруу замаар явах нь шиг байна гэлээ.

- Эзний л таалалд нийцсэн бол хичнээн ч тойруу хамаагүй.

- Ялихгүй ээ, ялихгүй ! гэхдээ зам нилээд уртсах байх ... Бид “Авраам Линкольн”-оор явах болно гэхэд,

- Эзний л таалал мэдэж хэмээн хэлээд Консель ажиг ч үгүй байв.

- Өвгөн минь, чи юу бодож байна, гайхлын тухай ... өнөө цууутай нарвалын тухай яриа болж байна шүү ... бид далайг түүнээс чөлөөлөх хэрэгтэй ... “Далайн ёроолын нууц” гэдэг хоёр боть ном бичсэн капитан Фарагуттай хамт аялахаас татагалзаж яаж болох вэ .. Нэр хүндтэй ажил, тэхдээ аюултай ажил ! Нарвал биднийг хаа хүртэл тэнүүчлүүлэх юм бэ, бүү мэд ... энэ амьтан тун олон ааштай байж болно. Гэлээ ч гэсэн бид явна ! Манай капитан ч ёстой л эр хүн дээ

- Эзэн нь л хаашаа бол би тийшээ гэж Консель өчлөө.

- Сайн бодоорой ! Би чамаас юу ч нуухгүй. Энэ бол тэр болгон буцаж ирдэггүй жуулчлалуудын нэг гэж мэдээрэй.

- Эзний л таалал мэдэж ... Нэгэн мөчийн дараа юмаа төхөөрч гүйцэв. Консель юу ч мартсангүй. Энэ хүн өмд цамц хувцас хунарыг яг л өнөөх сүүгээр

бойжигчид ба шувуудыгаа ангилан хуваарилдаг шигээ нябайлан цэгцэлсэн байв.

Бидний ачааг үйлчлэгч үүдний өрөөнд аваачиж тавив. Энэ завсар би доод давхарт бууж үргэлж хүн дүүрэн байдаг албан тасалгаанд орж, өөрийн хатаамал ургамал, чихмэл амьтан элдэв сэлтийг Париж явуулах тухай шийдэн ярилцаад халиун гахайгаа тэжээхэд хүрэлцэхүйц мөнгө төлж тооцоогоо хийгээд гүйн гарч хүлээж буй жуузанд үсрэн суухад, Консель маань тэнд сууж байлаа.

Сүйх тэрэг Бродвейгээр уруудан Юнион цэцэрлэг хүрээд дөрөв дэх авенью рүү эргэж түүгээр давхисаар Катрин гудамж туулаад хамгийн эцэст эргийн гучин дөрөвдүгээр зогсоол дээр очлоо. Тэндээс биднийг гаталга онгоц хүн, мал, сүйхний хамт Гудзоны зүүн эрэг, Нью-Йорк хотын дүүрэгт байгаа Бруклинд аваачлаа. Хэдхэн минутын дараа өтгөн хар утаа баагин байгаа “Авраам Линкольн”-ны гишгүүр шатны дэргэд давхиж хүрэв.

Бидний ачааг эгшин зуур хөлгийн тавцан дээр гаргав. Би шатаар яаравчлан дамжиж капитан Фарагуттай хэрхэн уулзаж болохыг лавлавал, усан цэргүүдийн нэг нь намайг дагуулан явж бяцхан гишгүүр дээр зогсож байгаа өргөн царайтай өндөр далайчныг зааж өгөв. Тэр миний зүг гараа сунган :

- Эрхэм Пьер Аронакс гэдэг та юу ? гэж асуув.
- Яг мөн гэж би хариулаад та Капитан Фаргут уу? Гэхэд
- Яг биеэрээ байж байна. Эрхэм профессор тавтай морилно уу ?Тасалгаа таныг хүлээж байна гэв. Аянд гарахын өмнөх чухал минутанд би түүнд саад болохгүйг хичээн мэхийн ёслоод, над зориулсан өрөө зааж өхийг нөгөө усан цэргээс гуйлаа.

“Авраам Линкольн” уул жуулчлалд аргагүй л зохицсон хөлөг байв.

Энэ нь цагт арван найм, аравны гурван миль хурдалж чадах бололцоо бүхий хамгийн сонгомол машинаар тоноглогдсон хурдан хөлөг байлаа. Гэвч энэхүү асар их хурд нь аварга нарвалыг хөөн гүйцэхэд дутагдалтай ажээ.

Хөлөгний дотоод төхөөрөмж, түүний далай туулан явах чанараас дутахгүй байв. Онгоцны хитгэ талд офицеруудын хэсэг дэх над ноогдсон өрөө миний санаанд их л тохирлоо.

- Энд бид гойд сайн идээших болно гэж би Консельд хэлэхэд
- Эзэн хэрэв зөвшөөрвөл бид энд даяанч хавч, эмгэн хумсын гэрэнд идээших мэт тавтай байрлах болно хэмэн миний эрдэмт зарц хариулав.

Би Конселийг байраа аялуулахаар өрөөндөө үлдээж, хөдлөхийн өмнөх бэлтгэл ажлыг харахаар тавцан дээр гарав.

Яг энэ үед “Авраам Линкольн”-ыг Бруклиний эргийн зогсоолд саатуулж байсан бүх ажлын шувтаргыг дуусгах тушаал капитан Фрагут өгч байв. Хэрэв л би дөнгөж арван таван минут саатсан бол “Авраам Линкольн” надгүйгээр явчих байсан ба миний бие энэхүү ер бусын жуулчлалд оролцож чадахгүй байсан бөгөөд түүний тухай тавих миний хамгийн бодит тайланг, зарим нэгэн үл итгэгчид эргэлзээтэйгээр устгах ч байсан байж магадгүй.

Нарвалын эсрэг аянг капитан Фарагут өдрөөр байтугай цагаар, минутаар ч хойшлуулах дургүй байв.

Капитан хөлөг онгоцны инженерийг дуудан ирүүлж :

- Уурын даралт хүрэлцэхүйц байна уу ? гэж асуув.
- Хүрэлцэхүйц ээ, нөхөр капитан.
- Тэгвэл алгуур хөдөл гэж капитан захирав.

Механикч, энэхүү тушаалыг шахмал хийгээр ажилладаг цахилгаан мэдээгээр хүлээн авмагц уур гүйлгэх бариулыг эргүүлэв.

Цилиндрүүдэд уур шуугин орж бүлүүрүүд цул цал нүдэж эхлэхэд сэлэх гол эргэлдлээ. Сэнсний далбаанууд улам хурдлан эрчлэхэд “Авраам Линкольн” үдэн гаргаж буй үй олон хүмүүсээр пиг дүүрэн хэдэн зуун жижиг хөлөг, чиргүүл онгоцнуудын хамт агуу сүрлэг хөдөллөө.

Эргийн Бруклиний зогсоол сонирхогчдоор дүүрчээ. Хэдэн мянган хоолойноос гурвантаа цууриатсан “Ура” тэнгэрийн дуу мэт нижигнэлээ. “Авраам Линкольн” Нью-Йорк хот төвлөрсөн хагас арлын шувтарга хэрд Гудзон голын цаагуур орон орохыг хүртэл мянга манган алчуур түүнийг даллан үдсээр агаар салхинд намиран байлаа.

Нью-Джерийн үргэлжлэн цуварсан тансаг барилгын дагуу, Гудзон голыг уруудан, усан буудлуудын дэргэдүүр өнгөрөхдөө “Авраам Линкольн” гучин есөн од шигтгэсэн хитгийнхээ тугийг гурвантаа өргөж, гурвантаа буулган, их буугаараа гурвантаа буу тавин хариу ёсоллоо. Дараа нь явдлаа удаашруулан хөвүүр тэмдгүүдээр хязгаарласан сувгийн голдрил дундуур явсаар Сэнди Гукийн элсэн тохой хүрэхэд, мөн олон мянган хүн баяр хүргэн үдсэний сүүлд их далайд хөвж гарлаа.

Түүнийг жижиг хөлгүүд ба тэдгээрийн чиргүүлийн цуваа Нью-Йоркийн боомтын орцыг онгоцнуудад заагч гэрэлт цамхгууд хүртэл үдлээ.

Өдрийн гурван цагийн үе байв. Далайн боомтын замчин үүргээ гүйцэтгэсний дараа, түүнийг онгоцонд нь хүргэж өгөөд “Авраам Линкольн” хурдаа нэмсээр Лонг-Айлендын эргийн дагуу хөвлөө. Оройн найман цагийн үед Файр-Айлендын цамхгийн гэрэл далд орж, Авраам Линкольн Атланын гадаад далайн гүн хар усан дундуур буй байхаараа



хурдлан одсон бүлгээ.

[Тор](#)

---

## НЕД ЛЕНД

Капитан Фарагут бол “Авраам Линкольн” мэтийн мундаг хөлгийн захирах нэр төртэй сайн далайчин билээ. Хөлөг тэр хоёр нэгэн бүтэн бие гэж бодоход, түүний тархи нь капитан мөн ажээ. Тийм нарвал байгаа гэдэгт, түүнд ямар ч эргэлзэх зүйл байсангй тул өөрий нь дэргэд энэ тухай маргаан үүсэхэд тэсвэрлэж үл чадах ажээ. Тийм гайхал бий, түүнээс тэр далайг чөлөөлнө гэдэгт андгай тангараг өгсөн байв.

Эсхүл нарвалыг капитан Фарагут ална, эсхүл нарвал капитан Фарагугыг ална ална. Тиймээс гурав дахь зам байсангүй.

Нарвалтай удахгүй учирна, тэгээд даруйхан төгсгөнө хэмээн маргалдахад тэдний яриаг сонсоход аятайхан. Түүгэр ч барахгүй ээлжнийхээ үүрэгт ажлыг гарцаагүй гүйцэтгэх уйтгарт үе гэж тооцдог зарим офицерууд хүртэл энэ удаа илүү жижүүрлэх ч хүсэлтэй байв.

Гэрэлт наран, тэнгэрийнхээ мандалд аялан явах цагт онгоцны шургууд дээр усан цэргүүд шавалдан сууж гайхлыг харуулдан байв. Гэвч “Авраам Линкольн” Номхон далайгаас хол байлаа.

Онгоцныхон нарвалтай дайралдаж оосорт жадаараа харван алж, онгоцон дээрээ татаж гаргаад тасчиж хэрчих хорхой нь хүрцгээж байлаа. Онгоцны багийн ажлаас чөлөөтэй хэсэг нь далайн толигор гадаргуугаас нүд үл салган ширтэнэ.

Үүний ташрамд хэлэхэд ахмад Фарагут хоёр мянган долларын шагнал амалсан юм.

Хамгийн анхан өнөө гайхлыг олж харах дагалдан сурагч усан цэрэг, боцман буюу офицер хэн нэгнийг энэхүү шагнал хүлээж байв. Иймээс хөлгийн баг ямар их идэвхтэйгээр далайн мандлыг ширтэж байсныг дүрслэн бодоход хэцүү бишээ !

Миний хувьд гэвэл, би бусдаас мөн хожимдсонгүй өдөржингөө онгоцны хашлагын дэргэд сайн дураараа зогсдог байв. Ганцхан Консель л нийтийн санал сэтэлийг үймрүүлэн буй асуудалд амирлангуй хандаж бусдын сонирхлыг үл хуваалцаж билээ.

Каптиан Фарагут аварга халимыг агнахад шаардагдах бүхий л төрлийн тоноглолоор

өөрийн хөлгийг бүрэн тоноглогдон гэж би дээр хэлсэн. Тэгвэл халим агнагч нэг ч онгоц үүнээс илү тоноглогдон явж байгаагүй буйзаа.

Бидэнд, гар жаднаас эхлээд тусгай буугаар бууддаг өргөстэй сум хүртэл халим агнах одоо үеийн бүх зэвсэг байв.

Хөлгийн урд хошуун дээр өөрийн дөрвөн килограмм хүнд сумыг арван зургаан километр шидэж чадах хурдан буу зоосон байв.

Тэхээр “Авраам Линкольн”-ны баг үхлийг түгээх зэвсгээр дутагдалтай гэх газаргүй байлаа. Гэвч онгоцон дээр жад шидэгчийн эзэн хаан Нед Ленд өөрийн биеэр морилж яваагүйсэн бол тэр бүхэн бас л чамлагдах байлаа.

Нед Ленд бол Канад нутгийн хүн бөгөөд дэлхий дээр халимын хамгийн гайхмшигт ангуучин тул энэхүү аймшигт мэгэжилдээ өөртэйгээ тэнцэх хүнийг үл мэдэх нэгэн билээ.

Тэр, тэвдэх сандрахыг хэзээ ч мэдэхгүй маш тайван хүн бөгөөд тун онцгой зориг, авхаалж самбаатай ажээ. Түүний жаднаас мэнд мултрахын тулд маш зальтай аварга халим буюу тун муу санаатай шидэт халим байх хэрэгтэй.

Нед Ленд дөчөөд настай, зургаан фут орчим өндөр, чийрэг догшин авртай хүн. Тэр үг цөөнтэй, түргэн ууртай, үг өчүүхэн сөрөхөд амархан шатдаг хүн.

Түүний гадаад төрх ялангуяа түүний царайнд өвөрмөц тусгалыг өх алсын хараат хурц нүд арга буюу бусдын анхаарлыг өөртөө татна.

Капитан Фарагут халимын алдарт ангуучийг уул жуулчлалд оруулсныг би зөв гэж үзнээ. Учир нь түүний хүчирхэг гар, мэргэн харц ганцаараа, бусад бүх багийн хийх ажлыг гүйцэтгэж чадах байв. Нед Лендийг хүчирхэг яндан дуран, цэнэглэсэн үхэр буу хоёрыг өөртөө нэгтгэсэн хүн гэж зүйрлүүлж болох ажээ.

Энэ канад хүн гэгдэх франц хүн буюу Нед Ленд хэдийгээр үг цөөнтэй боловч надтай амархан дассаны нь зориуд тэмдэглэх ёстой бөгөөд миний бодоход, тэр францаар үг хэлэлцэх энэхүү завшаантай тохиолдолд байярласных буйзаа.

Ер нь Канадын зарим мужуудад, одоо хүртэл Раблегийн <sup>1</sup> үеэс хадгалагдан ирсэн Францын хуучин аялгууг дуулж суухад надад таатай байлаа.

Нед Ленд цөөн бус зоригт далайчдыг төрүүлсэн Квебекийн эртний омгийн хүн бөгөөд Квебек түүхийн тэрхүү алслагдсан үед францын хот байжээ.

Нед бид хоёрын яриа бага багаар хөгжөөнтэй боллоо. Би түүний умарт далайнуудад учирсан адал явдлыг дуртай сонсдогсоон. Ан гөрөө тулалдаануудын тухай түүний яриа маш яруухан бөгөөд үнэнтэй учир, заримдаа би умарт орнуудын “Иллад”-ыг, хуурдаж байгаа канатыч Гомшрыг сонсох мэт санагддагсан.

Бид хуучны найз нөхөд бөгөөд сорилтын хүнд өдрүүдэд үүсвэрлэсэн бидний нөхөрлөл эвдэршгүй бат учраас би эрэлхэг хүний дүрийг яг л одоо мэдэж байгаагаараа дүрсэлж байна.

Далайн гайхлын тухай Нед Ленд юу гэж үзэж байв аа ? Үнэнийг хэлэхэд, олны сэтгэлийг хөдөлгөсөн тэрхүү нарвал байгаа гэдэгт итгэхгүй хүн онгоцон дээр ганцхан Нед Ленд л байлаа. Нэг өдөр би түүний бодлыг мэдэх гэж оролдоход тэр энэ сэдвээр ярилцахаас зайлсхийж байлаа.

Бидний гарсан өдрөөс гурван долоо хоногийн дараа манай хөлөг онгоц Патангониос гучин милийн зайтай байгаа – Блокоос холгүй явж байлаа. Бид, матрын халуун бүсийг огтолж, Магеланы хоолойгоос хойш долоон зуун миль хүрэхгүй зайтай явж байлаа.

<sup>1</sup> *дахин сэргэлтийн үеийн францын том зохиолч \1495 - 1553\*

Дахиад наймхан хоновол “Авраам Линкольн” Номхон Далайн усыг зүсэн явах болноо. Нед бид хоёр хөлгийн урд хошуун дээр сууж, гүн ёроолд нь одоо хүртэл хүний нүд хүрээгүй байгаа нууцат мандлыг ширтэн элдвийг ярьж байв. Ярианы далимаар би аварга нарвалын тухай яриа үүсгэж манай жуулчлалын амжилт ба нурулт шууд шалтгаалах бүх нөхцөлийг дэлгэрүүлэн ярьж эхэлсэн боловч Нед Ленд хариу дуугарахгүй суухыг би ажигласан юм.

- Бидний мөрдөж байгаа асар том нарвал бий гэдэгт та яагаад эргэлзээд байнаа ? Ингэж итгэхгүй байх ямар нэгэн үндэс танд байна уу? хэмээн шууд тулган асуулаа. Ангуучин хэсэг зуур намайг дуугүй ширтэж байснаа, хариулахынхаа өмнө хамаг буй санаагаа төвлөрүүлэх мэт нүдээ аньж, сурсан заншлаараа духаа алгдан бодолхийлсний дараа дөнгөж сая :

- Магад ч үгүй, байж ч, эрхэм Аронакс хэмээн хариуллаа.

- Та бол жад шидэгч мэргэжилтэн хүн, та энэ насандаа сүүгээр бойжигч аваргуудыг хэдэн зуугаар нь үзсэн, тэхээр асар том хэмжээний халим хэлбэртэн байж болно гэдгийг та өөр ямар ч хүнээс илүү амархан үнэмшмээр юм.

- Эрхэм профессор та яг л үүнд эндүүрч байна даа. Юм мэдэхгүй, хүнд бөмбөрцгийн дотоод хөндийд асар том амьтан амьдарч байнагэвэл амархан үнэмшинэ. Тэгвэл, геологич хүн энэ үлгэрт хэзээ ч үнэмшихгүй. Тэрчлэн халимын ангуучаас ялгаагүй би цөөн бус халим, нарвал мөрдөж агнасан. Гэтэл тэдний хэр хэмжээ, хүчин чадал, сүүл соёо юу нь ч тэр хөлөг онгоцны төмрөвч цөм цохих чадал байхгүй ! гэж Нед хариулав.

- Гэвч нарвалын шүд хөлөг онгоцны бөөрийг нэвт сүлбэсэн удаа бий шүү дээ, Нед ээ.

- Модон бөөр, профессор минь, модон бөөр! Гэвч үүнд ч би онц их итгэдэггүй: Би л хувьдаа тиймэрхүү юм үзээгүй. Тэгэхээр би халим нарвал, шүдэт халим зэрэг аврагууд “Шотланд”ын бөөрийг цөм цохисон шиг цоорхойг өөрийн нүдээр олж үзэхээс нааш хэзээ ч үнэмшихгүй л хүн гэж мэд.

- Нед минь, байзаарай.

- Үгүй ээ, үгүй профессор минь. Юу л бол юу, би зөвшөөрнө, зөвхөн энэнээс л өөр юм байг. Магадгүй, асар том наймалж...

- Тэр хэрхэвч байж болохгүй Нед минь! Наймалж гэдэг чинь нялцгай бэлцгэсэн аварга том хэмжээний биетэй амьтан. Хамаагүй тэр таван зуун фут урт ч байг. Наймалж гэдэг сээр нуруутай амьтан болохоор “Шотланд”, “Авраам Линкольн” мэтийн хөлгүүдэд ямар ч аюул байхгүй!

- Тэгвэл, эрхэм байгальч хэмээн ёжлох янзтай та асар том нарвал байна гэдэгт бат итгэж байна уу? гэж Нед асуулаа.

- Тиймээ Нед, би үүнд итгэж байна. Миний итгэл хэд хэдэн няцаашгүй баримтаар нотлогдож байгаа юм. Халим, шүдэт халим далайн гахайн нэгэн адил сээр нуруутны хүрээнд багтах, агуу бөх соёо юм уу, эвэр, шүд зэрэг заяагдсан халим хэлбэрийн асар том амьтан байгаад би эргэлзэхгүй байна.

- Ин! ... гэж жадлагч маань хамраараа хүнгэнэн эргэлзэх байдлаар толгойгоо сэгсрэв.

- Өвгөн минь, бод л доо гээд би, үргэлжлүүлэн, хэрэв ийм амьтан далайн гадаргуугаас доош хэд хэдэн милийн гүнд амьдардаг бол тэр маш чийрэг бие махбодитой байх ёстой.

- Яагаад?

- Яагаад гэвэл тийм их гүнд усны тэр их даралтыг даах дуулдаж сонсдоогүй агуу хүч хэрэгтэй юм.

- Нээрээ юу? гэж Нед итгэхгүй маягтай нүдээ жартайлгав.

- Нээрээ, яг тийм! Үүнийг батлахын тулд би танд хэдхэн тоо хэлэх болно.

- Аа, тоо юу? хэмээн Нед, тоомсоргүй дуугарч тоогоор ч юу дуртайгаа баталж болно гэв.

- Дандаа л тэр бүхнийг батлаад байхгүй шүү, Нед минь. За та миний үгийг сонс. Бид гучин хоёр фут өндөр усан баганын даралтыг нэг атмосферын хэмээн саная. Ер нь үнэн хэрэг дээрээ ердийн цэнгэг усны баганын даралт бол далайн усны баганын даралтаас нэлээд бага юм. Учир нь далайн давстай ус ердийн цэнгэг уснаас нягт,

хүнд чанартай. Тиймээс Нед таны бие, хэрэв далайн усанд шумбан орвол, далайн усны төвшнөөс гучин хоёр футийн доор, хичнээн тооны усан баганын даралт таны биеийн бүх гадаргууд үйлчилж байхчлан таны биеийн квадрат сантиметр тус бүрд төчнөөн килограмм даралт буюу төчнөөн атмосфер дарах болно. Үүнээс авч үзэхэд гурван зуун хорин футийн гүнд энэ даралт арван атмосфер хүртэл нэмэгдэх ба гурван мянга хоёр зуун футийн гүнд зуун атмосфер хүрч өсөөд гучин хоёр мянган футийн гүнд буюу барагцаалбал хоёр хагас милийн гүнд мянган атмосфер болно. Өөрөөр хэлбэл, хэрвээ танд энэхүү гүнд хүртэл нэвтрэн орох боломж олддог юм гэхэд, таны биеийн квадрат сантиметр тус бүр мянган атмосфер буюу бүтэн тоннын даралтыг үзэхсэн билээ. Тэгэхэд, өвгөн минь таны биеийн гадаргуу хичнээн квадрат сантиметр болохыг та өөрөө мэддэг үү?

- Энэ тухай мэдэх юм хумсын чинээ ч алга.

- Арван долоон мянга орчим.

- Тийм их үү?!

- Аа, тэхэд бас миний дээр хэлснээр нэг сантиметр квадратад үйлчлэх нь килограмм атмосфер жаахан ихсэх ёстой тул таны биеийн арван долоон мянган сантиметр квадрат гадаргуу дээр атмосферийн арван мянга таван зуун жаран найман килограмм даралт үйлчлэх юм.

- Надад л мэдэгдэх юм алга.

- Зүйтэй, та үүнийг үнэлэхгүй байдаг чинь аргагүй. Энэ асар их даралттай таны биеийн доторхи агаарын даралт тэнцэж байгаа учраас таныг энэ их даралт шалчийлгачихгүй байгаа юм. Тиймээс танд юу ч мэдэгдэхгүй байдаг нь тэр. Гэвч хэрвээ та усанд шумбаж орвол энэ тэнцвэр алдагдана...

- Аа ха, ойлголоо, хэмээн миний ярианд нэг л сонирхсон бололтой Нед яриаг минь таслан авч, тэгвэл ус намайг хүрээлэхээс биш миний дотор нэвтрэн орохгүй шүү дээ гэв.

- Чухам үнэн, Нед минь. Тэгээд л таны биеийг далайн төвшнөөс гучин хоёр футийн гүнд арван долоон мянга таван зуун жаран найман килограмм атмосферээр дарж, гурван зуун гурван зуун хорин футийн гүнд энэхүү даралт арав дахин өсч зуун далан таван мянга зургаан зуун наян килограмм болж, гурван мянга хоёр зуун футийн гүнд зуу дахин нэмэгдээд сая долоон зуун тавин зургаан мянга найман зуун килограмм хүрч, хамгийн сүүлд гучин хоёр мянган футийн гүнд өнөөх маань мянга дахин ихсээд таны биеийг арван долоон сая таван зуун жаран найман мянган килограммаар дарах болно. Өөрөөр хэлбэл таны биеийг аврага том алх дөш хоёрын хоорондоос гаргаж

авсан мэт та нүд ирмэхийн зуур нимгэнээс нимгэн хальс бин болон хувирах болно.

- А, чөтгөр гэж! хэмээн Нед дуу алдав.

- Ингэхлээр, өвгөн минь, хэрвээ иймэрхүү гүнзгийд хэд хэдэн зуун метр урт сээр нуруутан амьтан амьдарч болох юм бол түүний биеийн сая сая квадрат сантиметр гадаргуу олон миллиард килограммын даралтыг тэсвэрлэх ёстой. Тэгвэл, одоо бод л доо, энэ амьтан тэр их даралтыг тэсвэрлэн чадах бие махбодын ямар их эсэргүүцэлтэй, ямар муйхар мундаг булчин шөрмөстэй амьтан байх вэ!

- Тэгвэл тэд ч зуухны найман ямхын зузаан төмрөөр өвчлөгдсөн болов уу гэмээр ган хуягт амьтан байхаас зайлахгүй гэж канад нутгийн эр маань үгүүлэв.

- Зүйтэй, Нед! Тийм юм бол, хэрвээ усан дотор манай хамгийн хурдан буухиа галт тэрэгнээс хурдан, тэр сүрхий амьтан далайн ямар нэгэн хөлөг онгоцтой мөргөлдвөл ямар аймшигтай сүйрэл гарах байна, бод л доо.

- Тийм ... нээрээ дээ ... хэмээн энэхүү тоо баримтуудаар ягдсан боловч бас л бууж өхийг хүсэхгүй байгаа тэр хүн итгэмжгүйхэн бувтнав.

- За тэгээд би, таныг итгүүлэх биз?

- Хэрэв ийм амьтан үнэндээ далайн гүнд оршдог л юм бол маш их хүчтэй амьтан байх ёстой гэдэгт л намайг итгүүллээ шүү дээ, эрхэм профессор.

- Ёох, үгүй ээ, та ямар зөрүүд хүн бэ! Хэрвээ далайн гүнд тийм амьтан байхгүй юм бол та “Шотланд”-тай болсон явдлыг юу гэж тайлбарлах вэ?

- Магадгүй ... гээд Нед эрс хэлчихэж арай л чадахгүй байхад нь

- Тэгээд, хэл хэл гэв.

- Магадгүй ... тийм явдал болоогүй байж? гэж мань хүн тууж орхив.

Энэ хариулт ч зөвхөн түүний зөрүүдийг л харуулж байв. Тэр өдөртөө би, түүнийг дахин итгүүлэхийг оролдсонгүй. Тэхэд “Шотланд”-тай тохиолдсон явдал маргаангүй хэрэг билээ. Түүний цоорхой яах ч аргагүй бодитой юм болохоор, бөглөхөөс өөр зам байгаагүй юм. Тэрхүү гайхал байгааг батлах, үүнээс илүү баримт олоход бэрх хэмээн би санана. Түүнээс гадна нэг талаар тэр цоорхойд, хар аяндаа гарсан гэж үзэх ямар ч тал алга. Нөгөө талаар усан доорхи хад юм уу, аралтай мөргөлдсөн гэх санаа бүрмөсөн үгүйсгэгдсэн тул далайн аврага амьтны асар том шүдээр үйлдэгдсэн гэдэгт үнэмшихээс өөр замгүй ажээ.

Би л хувьдаа, дээр тодорхойлсон сэтгэмжийн үндсэн дээр энэхүү амьтныг сээр нуруутны хүрээ, сүүгээр бойжигчдын анги халим хэлбэртний багт хамааруулсан юмдаг. Харин халим, шүдэт халим, далайн гахайг хамруулдаг язгуур, доод язгуур дүрсэд түүнийг хэрхэн ангилах асуудлыг зөвхөн ирээдүй л хариулж чадах бизээ.

Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тул үл танигдах тэрхүү амьтныг урьдаар илрүүлэх хэрэгтэй. Түүнийг илрүүлэхийн тул эхлээд барих, барихын тул алах, алах явдал Нед Лендэд хамаарагдах бол алахын тул түүнийг олж үзэх явдал онгоцны бүх багийнхны үүрэг юм. Тэгвэл үзэхийн тул үүнтэй учрах хэрэгтэй бөгөөд энэ нь зүй тохиоллын хэрэг байлаа.

[Top](#)

---

## ХАР ТААМГААР ЭЛДСЭН НЬ

“Авраам Линкольн”-ны аяллын анхны өдрүүдэд онцын гойд тохиолдлууд гарсангүй. Гагцхүү нэгэн өдөр Нед Лендийн гайхамшиг эрдмийг хамгийн эхрэм өндөрт өргөмжилсөн онцгой сонин нэгэн явдал болсон нь жад шидэгч өөрийн биед дүүрэн итгэмжилж болохыг нийтийн өмнө биеэрээ нотолсон билээ.

Фальклендын арлууд үзэгдэхийн хэрд “Авраам Линкольн” халим агнах “Монроэ” гэдэг Америкийн хөлөгтэй дайралдлаа. Тэр онгоцны баг нарвалын тухай у ч сонсоогүй ажээ. Гэтэл “Монроэ” онгоцны капитан “Авраам Линкольн” дээр жад шидэгч алдарт Нед Ленд явааг мэдмэгц, түүний биеийг мөрдөж яваа шүдэт халимыг агнах ажилд туслалцана уу хэмээн гуйсан билээ. Нед Лендийн хэрхэн хөдөлдгийг харахыг хүсэмжлэн агсан капитан Фарагу, жад шидэгчид “Монроэ” онгоцон дээр гарах зөвшөөрөл олгов.

Канадын харъяатын аз болоход, шүдэт халим ганыг шорлохын оронд харин хоёрыг шорложээ. Анхныхы нь яг зүрхэнд жадаа шааж, доор нь алсан бөгөөд дараагийнхы нв хэсэг зуур мөрдсөний сүүлд алжээ.

Ай даа, хэрэв л гайхал хэзээ нэг цагт Нед Лендийн жадтай учрах гай тохиолдвол тэр амьд гардаггүй ээ !

Хөлөг онгоц, зүүн өмнөт Америкийн эргийн дагуу хурдалж гарлаа. Бид, 7-р сарын туршид Магелланы хоолойн аманд Дев хошуу хүрч очлоо.

Гэвч, капитан Фарагут энэхүү махиралдсан хоолойн хажуугаар гарч Горнын хошууг чиглэв.

Онгоцны баг, энэхүү шийдвэрийг нэг дуугаар таалан үзлээ.

Үнэндээ ч энэхүү нарихан хоолойд, тэр том амьтантай золгоно гэдэг найдвар багатай хэрэг бизээ. Тэрхүү гайхал Магелланы хоолойгоор багтаж гарахгүй, дэндүү бүдүүн хэмээн олонхи усан цэрэг үзэж байв.

“Авраам Линкольн” 7-р сарын 6-ны өдрийн 3 цагийн хэрд Голландын далайчид өөрийн төрөлх хотын нэрээр нэрлэсэн Америк тивийн хамгийн өмнөт үзүүрт хаягдаж, Горнын хошуу хэмээгдэх тэрхүү хад, тэрхүү алслагдсан арлыг тойрч билээ. Хөлөг онгоц баруун хойт зүгт чиглэл авч, түүний сэлүүр сэнс Номхон далайн уёыг хөөсрүүлэн эхлэв.

- Сайн хар ! нүд бүү чавч ! хэмээн “Авраам Линкольн”-ны усан цэргүүд сэрэмжлэн явна.

Нээрээ ч тэд нүд чавчихгүй байв. Хоёр мянган долларын шагналд хорхойтсон хүмүүс дадлайн гадаргаас нүд салгахгүй явлаа. Нүд, дуран хоёр өдөр шөнө амар заяагаа үл үзэх ажээ.

Никтаполууд буюу муужгайн хараатай хүмүүс өдөр шөнө ялгалгүй сайн харах тул жирийн хараатай хүмүүсийг бодвол шагнал авах илүү боломжтой байв.

Хэдийгээр мөнгөн шагнал миний сэтгэлийг татахгүй боловч би, мөн л бүхэл өдрөөр далай ширтэн зогсог байлаа. Би унтах нойроо хоногт гурав, дөрвөн цагаар хорогдуулж, ууж идэхдээ тоотой хэдэн минут зарцуулан, бусад бүх цагт онгоцны тавцангаас хагацалгүй яг зогсдог байв.

Эсхүл би, урьд хамрын хашлага модон дээр тохойлдон тал бүр тийшээ нүдний хараа мэдэн үргэлжилсэн их далайн үелсэн давалгааны хөөсөрсөн сэрвэнг шунахайгаар ширтэн байж билээ.

Хааяа далайн мандал дээр халимын гүдгэр сэрвээ бүртийн ил гарахад би, багийн бусад хүмүүсийн хамт сандардаг байв. Энэ үед онгоцны бүх баг нүд ирмэхийн зуур дээшээ гүйлддэг билээ. Халимын хөдөлгөөнийг нүдээ энтэл ажиглаж хүн бүхэн амьсгаадчихсан байдагсан. Би ч гэсэн нүдээ бүрэлзэн чилтэл ширтдэг байлаа.

Ийм цагт миний амгалан тайван зантай зарц Консель :

- Эзэн минь нүдээ хэт бүлтийлгэхгүй байвал илүү сайн харахсан даа хэмээн надад тайвуухан хэлдэгсэн.

Гэтэл онгоцныхон дандаа л дэмий сандарцгаадаг байв.

“Авраам Линкольн” сэжиглэсэн дайсандаа аажуухан ойртон очивч нөгөөх нь жирийн нэгэн халим буюу эсхүл шүдэт халим байхад дахн түрүүчийн чиглэлийг барих бөгөөд онгоцны баг ямар ч гэмгүй хөөрхий тэр амьтныг хараж зүхсээр цаашилдаг байв.

Бөмбөрцгийн өмнөт хагасын 7-р сар, умарт хагасын 1-р сартай яг харгалзах бөгөөд энэ үеэр бороо ид дундаа цутгаж байдаг боловч бидний аялал хамгийн таатай нөхцөлд үргэлжилж, цаг агаар үргэлж сайхан байлаа. Түүгэр ч зогсохгүй далай амгалан, алсын бараа тод ажээ. Нед Ленд урьдын нэгэн адил үнэмшихгүй гэж



гэдийснээрээ гэдийж байв. Тэр, хэрэв л халим харагдахгүй бол зав чөлөөтэй цагтаа далай руу ердөө ч хардаггүйсэн.

Түүний онцгой хурц нүд аялагчдад тун их тус хүргэж болох байсан учир энэ нь эглү хөдөлмөөр байдаг байлаа.

Гэтэл канад нутгийн зөрүүд хүн хоногийн хорин дөрвөн цагийн арван зургааг нь өрөөндөө өнгөрөөхийг илүүд үздэг байв.

Би, түүний амарлингуй занг буруушаан хэдий олон удаа эмлэх боловч, тэр :

- Профессор гуай дэмий чилэхийн хэрэг у байхав ? хэмээн хариулж : юуны өмнө ерөөсөө нарвал гэдэг ямар ч юм байхгүй ямар нэг амьтан байдаг юм гэлээ гэхэд бид түүнтэй дайралдах өчүүхэн ч нйадвар алга, түүний чинь хойноос бид шал сохроор, таамгаар элдэж явна шүү дээ. За яахав, түүнтэй чинь ямар нэг хөлөг онгоц Номхон далайд дайралдсан л юм байж. тэгвэл, тэр нарвалын чинь аашийг ажвал нэг л байранд холхиод байх төдий л дургүй амьтан бололтой.

Түүнчлэн та өөрөө түүнийг тун хурдан гэдгийг зөвшөөрч шүү дээ. Тэхээр байгаль ямарч хэрэггүй юу ч буй болгодоггүй тул заяаны болхи удаан хөдөлгөөнтэй тийм амьтдад хуйнаас хурдан гүйх хувь хүртээхгүйсэн биш үү. Ийм ч учраас тийм амьтан үнэнээсээ байдаг л юм бол эндээс ч асар хол яваа гэж миний бодож байгааай таны санал эрхбиш нийцэхсэн бизээ! гэв.

Энэхүү сэтгэмжийн эсрэг юу ч хэлэхийн арггүй байлаа. Үнэндээ ч бид хар таамгаар явахаас өөр яах билээ ? Гайхалтай золгох бидний найдвар маш бага тул Нед Лендийн зөв бизээ. Хэдий тийм боловч жуулчлалын төгсгөлийн амжилтанд хэн ч эргэлзэхгүй байв.

Бид 7-р сарын 20-нд уртрагийн 105 хоногт матрын халуун бүсийг хоёр дахин гарч, мөн сарын хорин долоны өдөр уртрагийн 110 хоногт экваторыг гэтэллээ. Тэр өдөртөө манай хөлөг Номхон Далайн төв санг чиглэн өрнөт зүгийг барив.

Манай боцманы хэлсэн “түүнд далай ч гүехэн” гэгчээр ахмад фарагут арал, хойг, тивүүдээс алс хол газар, далайн хөлгүй гүнд тэр гайхалтай учирч болно хэмээн үзэж байсан нь зүйтэй байв.

Иймээс манай хөлөг Паумот, Маркиз, Сандвичийн дэргэдүүр өнгөрч, уртрагийн 132 хоногт мэлхийн халуун бүсийг хөндлөн огтлоод, Хятадын далайг чиглэлээ.

Ингэж явсаар бил, гайхалтай хамгийн сүүлд учирсан тэр газар хүрч ирэв. Зүрх дэлсэх гэдэг учраа алдсан бөгөөд үүний улмаас хөлөг онгоцныхон бүгээрээ зүрхний сэвтэй болж болох байлаа. Онгоцны баг тэр чигээрээ энэхүү салшгүй үзэлд автагдан солиорсон мэт ажээ. Хүмүүс унтах, идэхээ ч болилоо. Бид хий юм харчихаад ухаан

жолоогүй хөхин баярлах боловч хууртагдсандаа бүгдээр гонсойн гомдох тул тийнхүү цаг үргэлж сэтгэл мэдрэлийн хүнд байдалд орших нь сайнаа үзэхгүйн ёр бизээ.

Нээрээ ч энэ байдал удааширсангүй, хямралдаан гарахад хүргэв. “Авраам линкольн” бүтэн гурван сарын турш Номхон далайг хөндлөн гулдгүй хэрэн хэсэхэд, өдөр бүхэн жил шиг удаан өнгөрдөг байв. Хөлөг онгоц аль нэгэн харагдсан халимын араас андууран хөөцөлдөж нэг бол хурдлан, нэг бол удаашран, зог тусч, ухасхийж, хажуулдаж хавиргалан эргэлдэх нь машинаа эвдэхийн тэмдэг байлаа. Манай онгоц Японы эргээс Америк тив хүртэл нэг ч хавтгай дөрвөлжин хэсгийг орхигдуулсангүй нэгжиж билээ. Гэтэл энэхүү аса уудам орчинд юу ч олж авсангүй ээ. Асар томнарвалтай адилхан, ядахдаа ямар нэг хад, арал, онгоцны сэг, тэнэмэл шүр арал эсхүл өөр нэгэн чөтгөр шүү юм, юу ч байсангүй!

Ингэ ингэсээр дэмий юманд итгэсэндээ ичингүйрэхийн эрхэнд, орох газраа олохгүй байсан бол ичгүүрээсээ хорсол нь улам илүү хэмлэж байлаа. Бүтэн жилийн турш хуримтлагдсан уул хад мэт их нотолгоо маань ганцхан өдөр л ийнхүү нурж унасан тул одоо хүн бүр дор дороо ингэж тэнэглэн үрэгдүүлсэн цаг хугацаанаасаа хэрхэн нөөгөө талаар бодолхийлэх боллоо.

Хүн гэдэг хэзээний олон ааштай амьтан тул одооч нэсэн тэд нэг үзлээс нөгөөд урваж байв. Аяллын хамгийн идэвхтэй гишүүд маань харин хамгийн аюултай дайсан болжээ. үл итгэх үзэл, хөлгийн доод зоориноос аваад дарга нарын дээд тасалгаа хүртэл ус мэт юүлсэн бөгөөд хэрвээл капитан Фарагутын учир нь олдохгүй нэгэнармайлтгүйсэн бол “Авраам Линкольн” аль хэдийнээ гэдрэг эргэхсэн билээ.

Гэвч энэхүү үр дүнгүй хайгуул эцэс төгсгөлгүй үргэлжилж яахин болох билээ. Гайхлыг эж олох үүргийг амжилттай биелүүлэх ажилд өөрөөсөө шалтгаалах бүхнийг бүгдийг онцгой гүйцэтгэсэн тул “Авраам Линкольн”-ыг уулах буюу өөлөх ямар ч тал байсангүй ээ. Ер нь Америкийн аль нэгэн хөлгийн баг үүнээс урьд, хэзээ ч иймэрхүү тэсвэр хатуужил, идэвхийг үзүүлж байгаагүй юм. Тиймээс аяллын бүтэлгүйн гэмийг тэр чигээр нь тэдэнд хүлээлгэхгүй агсан билээ. Бодвол буцахаас өөр аргагүй мэт...

Капитан Фарагутаг гэдрэг эргэх тухай эрэлт орсон боловч тэр эрс татгалзав.

Усан цэргүүд өөрсдийн дургүйцлийг нуусан чүгүй, түүний лмаас оноцон дээрх дэглэм нуралтын байдалд орлоо. Би онгоцон дээр үймээнгарсан гэх гэж багйаа юм биш, гэвч капитан Фарагут маань хэсэг зуур тэдний эсрэг тэмцэж байсны дараа, өөрийн хөлгийн багаас, эртний Колумбын нэгэн адил, гуравхан хоног тэсвэрлэхийг гуйхаас өөр замгүй боллоо. Хэрэв л энэхүү гурав хоногт гайхлын бара эс харагдвал “Авраам Линкольн” залуураа гэдрэг эргүүлэх ёстой болов.

11-р сарын 2-ноо ийнхүү амалсан билээ. Энэ нь хүмүүсийн санаа сэтгэлийг шууд сэргээв. Хүмүүс далайн усыг дахин анхааралтайгаар ширтэж, луран авай үүрэгт ажилдаа дахин орлоо. Энэ бол аварга нарвалыг тулалдаанд дуудсан эцсийн дуудлага байв.

Иймэрхүүгээр хоёр хонлоо. “Авраам Линкольн” зөөлөн гүйдлээрээ урагшлахад, онгоцны баг нарвалын анхаарлыг татахын тул хэрвээ л тэр үнэхээр байдаг юм бол мянга мянган арга сүвэгчилж билээ.

Хөлөг онгоцныг бүлэг бүлгээрээ дагалдан явах аварга загасны бахыг ханган онгоцны хашлага давуулж асар том өөх бөөн бөөнөөр нь хөнтөрч байв. Хөлөгний жижигзавиар далайн квадрат тус бүрийг нэгжин шинжиж зүг бүр тийшээ хайдаг байв.

Гэтэл 11-р сарын 4-ний орой болсон авч нууц нууцаараа үлджээ. Дараагийн өдөр 11-р сарын 5-ны үд хэрд тогтоосон хугацаа гүйцэх байв. Цагийн харанганы эцсийн цохилтоор хэлсэн үгэндээ эзэн болдог капитан Фарагут өмнө дорно зүг хөлөг онгоцоо эргүүлэх ёстой бөгөөд бид тийнхүү Номхон Далайн умарт хэсгийг үүрд орхих учиртайсан билээ.

Энэ үед онгоц маань умарт өргөргийн 31 хоног 15 хувь, дорнот уртрагийн 136 хоног 42 хувьд явж байлаа. Японы арлууд биднээс 200 хүрэхгүй миль зайтай ажээ. Шөнө боллоо. Оройн найман цагийн харанга цохилоо. Хадуур мэт нарийхан хавирган сарыг өтгн үүлэ бүрхэж, хөлөг онгоцыг далай үл мэдэг халивалзуулж байв.

Энэ үед би, тавцангийн хашлага тохойлдон хөлгийн баруун хажжд зогсож билээ. Консель мөн миний дэргэд зогсон алсыг амарлингуй ширтэнэ. Усан цэргүүд шураг модны хөндөл дээгүүр мацаж, улам бүр бүрэнхийлэн байгаа орчинг ажиглан авай. Офицерууд ч мөн шөнийн дурангаа далайн гадарга тийш чиглүүлжээ. Заримдаа, үүлэн цоорхойгоор цацарсан сарны гэрэл далайн усыг мөнгөлөн өнгөлөх боловч үүлс, дахин аньж битүүрэхэд орчин тойрон дахин харанхуйн дунд сүүдийнэ.

Конселийг энэ удаа би хараад энэ амгалан хүн бусдын нэгэн адил хамгийн анхан сэтгэл хөдөлсөн болохыг нь ажиглалаа.

- яагаа вэ, чи Консел? Хоёр мянганянчаан олж өвөртлөх эцсийн бололцоо тохиов уу? хэмээн би асуулаа.

- Эзэн хэрвээ зөвшөөрөхсөн бол энэхүү шагнал мөнгийг өвөртлөх хүсэл хэзээ ч надад төрөөгүй хэмээн өчихсөн байнам гэж хариулаад Нэгдсэн Холбоон ыулсын засгийн газар яг л иймэрхүү янзаар зуун мянган төгрөгийн шагнал амалсан ч тэрнийхээ улмаас төдий л их хохироогүйсэн билээ гэв.

- Чиний зөв, Консель минь. Яв явсаар энэмундаг аялалд би оролцож шал дэмий юм

боллоо. Хэд хичнээн ч цаг хугацаа үрэгдэж, хичнээн их сэтгэл мэдрэлийн чирэгдэл боловдоо. Бид бүр зургаан сарын өмнө Францад бучих байхгүй юу...

- Ерөө ер. Эзний өчүүхэн өрөө, музейд аль эрт очих байсан гэж Консель маанв дэмжиж аваад

- Би эзний цуглуулгыг анги төрөлд нь хуваарилан, эзний аваачсан амьтны цэцэрлэгт сараалжин торон дотор байраолоод сониуч бүхний дурыг Парижийн өнцөг бүрээс татаж байхсан биш үү гэлээ.

- Яг л тийм байхсан, Консель минь. Бас тэгтэл энэ бүхний эцэст биднийг элэг доог болгон яаж дайоч доромжлох болдоо.

- Гарцаагүй. Эзнийг элэг доог болгон гэдэгт би дүүрэн итгэж байна. Ай бүү мэд цааш нь ярихын ч хэрэг байна уу даа...

- Ярь, ярь Консель!

- Миний бодоход ч элэг доог болохоо эзэн та өөрөө л өдөөсөн л дөө.

- Нээрээ юү?

- Ийм их эрдэмтэн болох хувтай тан шиг хүн, тэгж эрсдэхийн хэрэггүй л байсан ... хэмээн Консель маань надад цаасан малгай өмсгөж дуусгаагүй атал, орчин тойронд налайж байгаа чимээгүйн дундаас :

- Хүүш ! Нөгөөтөх чинь, бидний эсрэг, салхин доор байна! хэмээх дуу цуурайтлаа.

Энэ бол Нед Лендийн дуу ажээ.

[Тор](#)

---

## ХАР ХУРДААРАА

Тэр дууг сонсмогц онгоцны баг капитанаасаа эхлээд дарга нар, усан цэрэг, дагалдан сурагч, инженер, механикч, түүгээр ч барахгүй зуух галлагчид хүртэл зуух машинаа хаячихаад жад шидэгч рүү гүйж очив.

Капитан хөлөг онгоцоо зогсоох тушаал өглөө.

Тэхэд пад харанхуй шөнө байсан учир би хэдийгээр канад нутгийн хүнийг хараа сайтай хэмээн мэдэх боловч ийм пад харанхуйд түүнийг хэрхэн яаж юу олж харсныг гайхах билээ.

Миний зүрх тэр үеэр дэлбэрчихмээр цохилж байв.

Гэвч Нед Ленд андуурсангүй ээ. Би удсан ч үгүй түүний зааж байгаа юмыг олж харлаа.

“Авраам Линкольн”-ны баруун талд, онгоцноос хоёр кабельт хир газар далай дотроосоо гэрэлтэх мэт байлаа. Энэ нь жирийн нэгэн фосфорын цацраг биш ажээ. Усны гадаргуугаас хэдхэн футийн гүнд гайхал, нилээд олон капитаны тайланд дурьдсанчлан, хурц гэрэл цацарган хачин жигтэй туяарч байлаа. Энэхүү туяарал ямар нэгэн хүчтэй гэрэл үүсгэгчээс цацарсан байхаас зайлшгүй, далайн гэрэлтүүлэгдсэн гадаргуу урт гонзгой хэлбэртэй байв. Тэрхүү гонзгой гэрлийн гол хэсэг онц хурц болж ирээд гадагшлах тутам бүдгэрч харагдана.

Энэ ч ердөө л зөвхөн, гэрэл цацаргагч амьтдын бөөгнөрөл байна гэж офицеруудын нэг нь хэлэхэд би:

Үгүй ээ, та эндүүрч байна хэмээн хариулаад-Шөнө гэрэлтэгч ямар ч амьтан ийм тод гэрэл цацаргахгүй. Энэ гэрэл бодвол цаанаа цахилгаан тэжээлтэй биз... Гэвч, хүүе хараач... хараач! хөдөлж байна!... наашаа ирлээ!... гэхэд.

Тавцан дээр чихэлдэгсдийн амнаас хашгиралдах дуун гарвал:

- Дуугаа тат! хэмээн капитан Фарагут зандраад залуураа зүүн тийш! Гэдрэгээ! гэж командаллаа.

Бүгд байр байр руугаа гүйлдэж нүд ирмэхийн зуур тушаал биелүүлэхэд “Авраам Линкольн” хагас дугуй эргэлээ.

- Залуур баруун тийш! Урагшаа! хэмээн капитан тушаасны дараа сэлүүр сэнс дахин эрчиж хөлөг гэрэл үүсгэгчээс түргэн зуур холдож эхэллээ.

Хүүе биш, би худал хэлж байна: Манай хөлөг хэдий зайлахыг оролдсон боловч нөгөө амьтан бидний холдохоос хоёр дахин хурдан ойртож байлаа.

Бид, зөвхөн айсандаа ч биш мөн гайхсандаа амьсгаагаа таг хураан, нэг ч үг дуугарч чадсангүй хөшчихсөн билээ. Нөгөөх маань харин биднийг элэг барьсан мэт арааг гэзэг даран элдэж, бутарч байгаа галт тоос мэт цахилгаан цацарлаар биднийг шилбүүрдэн, арван дөрвөн зангилаа хурдалж манай хөлгийг бүтэн нэг тойрлоо. Дараа ухран хурдалж буй буухиа тэрэг багширсан утаа баагиулж үлээх мэт оч гэрэл цацаргасан мар гаргасаар хоёр гурван милийн зайтай давхиж холдов. Тэгтлээ өнөөх маань хүч авах мэт ухарч байснаа харанхуй дундаас бидний зүг гэв гэнэт аймшигтай хурдлан дайрч ирснээ “Авраам Линкольн”-ны дэргэд хорин фут газар зог тусаад унтарлаа. Тэжээл нь гэнэт дуусах мэт түүний гэрэл тийнхүү түргэн зуур унтарсан нь усан дээр хавж гарсны гэрчлэх бөгөөд, хэрвээ л тэр усан доор байгаа бол аажимдаа

унтархсан билээ.

Түүний дараа хөлөгний нөгөө талаас гайхал дахин бий болж “Авраам Линкольн”-ыг тойрох шиг ч доогуур нь шумбах шиг ч боллоо.

Энэ үед секунд бүрд мөргөлдөхийн аюул заналхийлэх бөгөөд хэрэв л тийм явдал тохиолдсон бол манай онгоц ч сайнаа үзэхгүй агсан билээ.

Гэтэл би өөрийн хөлөг онгоцны маяглахыг ажиг гав гайхлаа. Манай онгоц гайхалтай тулалдахын оронд харин амь зулбан зугтаж байв. Гайхлыг мөрдөхөөр илгээгдсэн маань өөрөө мөрдөгдөн элдэгдэж байв.

Би энэ тухай капитанд үг цухуйлгасан боловч тэрний хэзээд амгалан царайд ер бачимдсан шинжгүй харин гайхаж эргэлзэх байдалтай ажээ.

Профессор минь ингэхэд би ер нь ямар гээч аврага араатантай алалдах гэж байгаа юм бэ бүү мэд, түүнчлэн энэ пад харанхуйд хөлөг онгоцоо гарзанд нь дэмий гаргахыг хүлээхгүй байна, энэ үл мэдэгдмэрий чинь хаанаас нь яаж довтлох, үүнээс чинь яаж биеэ хамгаалахыг бүү мэд.

- Яахав, үүр цайг. Тэхэд л харж байгаарай хэмээн тэр над хэллээ.

- Капитан, танд одоо энэ амьтны талаар эргэлзэх юм байна уу?

- Алга аа, профессор минь алга, бодвол энэ асар том биет нарвал бололтой, тэхдээ бас биедээ цахилгаантай гээч.

- Магадгүй хэмээн би залгуулан авч үүнд чинь хөвөгч галт бөмбөгөнд буюу эсхүл цахилгаан могой загасанд ойртохчлон хавьтаж ч болохгүй юм биш үү гэлээ.

- Үнэн ч биз гэж капитан маань надтай санаа нийлж, хэрвээ л тэр тусмаа цахилгаан цэнэгтэй болов уу тэгвэл ч дэлхий дээр хамгийн аюултай амьтан санж. Тэгээд л би болгоомжилсон юм л даа гэж хариулав.

Хөлгийн баг шөнөжингөө нүд хамхисангүй. Хэн ч онгоцны тавцанг орхисонгүй. “Авраам Линкольн” нарвалтай хурдаа үзэж барахгүйг сая мэдмэгцээ гүйдлээ удаашруулав.

Нарвал ч гэсэн манай онгоцыг дуурайн долгион дээр далбалзан байх нь тулалдааны талбарыг орхихгүй гэсэн мэт байлаа.

Гагцхүү шөнө дөл хэр, тэр амьтан гэрэлт цох мэт паг унтарсан нь дахин довтлоход боломжтой байр эзэлж байгаа бол уу гэмээр алга боллоо. Аль эсвэл зугатчихав уу? Гэвч түүний зугатахыг хүсэхийн оронд харин сэрэмжлэх ёстой байв. Гэтэл цагийн дараагаар ямар нэг давчуу нүхнээс шахагдан ойгдож байгаа ус шаагих мэт чих дүлийрэм шуугисан их чимээ сонсодлоо.

Энэ үед капитан Фарагут, Нед Ленд бид гурав хөлгийн тавцан дээр зогсож

байсан билээ. Бид эргэн тойрон байгаа нүх мэт харанхуй руу шуналтай ширтэж байв.

- Нед Ленд ээ хэмээн капитан халимын тургиж байгаа усны дууг та олон удаа сонссон уу? гэж асуулаа.

- Олоон олон капитан минь гэхдээ харин ганцхан барааг нь харсан төдийд над хоёр мянган доллар заяаж өгүүлдэг тийм халимтай нэг ч удаа дайралдаж яваагүй дээ.

- Нээрээн та шан хүртэх ёстой болсон, гэвч энэ шуугиж байгаа усны дуу халимны хамраас олгойдон гардаг усны дуутай адил байна уу?

- Дуу нь ч сулхан юм харин тэхдээ хавьгүй өөр юм. Бидний өмнө халим хэлбэртэй ямар нэгэн амьтан байгаад эргэлзэх юм алга. Хэрэв капитан та зөвшөөрөх юм бол би маргааш үүрээр үүнтэй чинь хоёр үг сольчихъё гэж жад шидэгч нэмэн хэлэв.

- Хэрвээ тэр таны хэлэхийг сонсохыг хүсэх бол болох юм гэж би хажуугаас нь хэлээд, гэвч би үүнд төдийлөн итгэхгүй байна даа гэв.

- Хэрвээ л би түүнд, жадныхаа урт иш дөрвийн чинээ газар ойртож чадвал тэр надтай танилцах л хэрэг болно доо гэж канад нутгийн хүн татгалзан хэлэв.

- Тэгвэл бас танд завь өх болох нь ээ? гэж капитан асуув.

- Мэдээж хэрэг.

- Бас сэлүүрчдийн амийг үрэхэд хүрэх нь ээ?

- Миний л үрэгдэхтэй яг адил хэмээн жад шидэгч жирийн үгээр хариулав.

Шөнийн хоёр цагийн үед “Авраам Линкольн”-оос тавхан миль зайтай, салхин талаас цахилгаан цацрал дахин гэрэлтлээ. Салхи далай хоёрын шуугиан ба хол зайг харгалзахгүйгээр нөгөө амьтны хэржигнэсэн амьсгаа болон сүүлээрээ ус дэлдэх чимээ тод сонсдож байлаа. Тэрхүү нарвал амьсгалахаар усан дээр ил гарахад түүний уушгинд дүүрч байгаа агаар хоёр мянган морины хүчтэй аврага машины цилиндрт уур хий орж байгаа мэт тийм эрчтэй шиг санагдана.

“Бүхэл бүтэн морин хорооны хүчтэй” халим гэдэг ямар булай нүсэр амьтан байх вэ? Чөтгөр ав гэж! хэмээн бид бодолхийлж байв.

Шөнө тулалдаанд бэлтгэн сэрэмжлэх байдлаар өнгөрлөө. Халим агнуурын бүх зэвсгийг зэхэж, жадаар цэнэглэж бүхэл бүтэн миль газар буудаж чадах үхэр буу болон задрах бөмбөгөөр хамгийн том амьтан боловч үхлийн шарх олгон хөнөөж чадах карбин буу зэргийг байлдаанд бэлхэн болгох тушаал капитаны хоёрдугаар туслагч буулгасан байлаа. Харин Нед Ленд өөрийн жадыг ирлэх төдийгөөр сэтгэлээ хангасан ажээ.

Өглөөний 6 цагт гэгээ орж нарвалын цахилгаан цацрал түрүүчийн гэгээгээр алга боллоо.

Өглөө 7 цагт өдөр болсон авч ямар ч дуран үл нэвтрэх өтгөн манан орчин тойрныг хөшиглөсөн билээ. Ийм үйлсгүй явдалд нийтийн хилэгнэсэн, бачимдсан сэтгэл ямар байсныг дүрслэн бодоход хялбар бизээ.

Би хамгийн хойт талын шураг модны доод хөндөл дээр авиран гарлаа. Өөр хэдэн дарга нар нилээд дээшээ авирчээ.

Өглөө 8 цагт манан, долгион дээгүүр алгуур хөвж бөөн бөөнөөрөө дээш дэгдэж эхэллээ.

Гэтэл, гэв гэнэтхэн өчигдрийн нэгэн адил:

- Өнөөх чинь, салхины дээд талд, хитгийн тэртээ байна хэмээн Нед Лендийн дуун гарлаа.

Бүгд хитгийн зүг ухас хийлээ. Нээрээ ч манай хөлгөөс миль хол зайтай, гонзгой хар юм уснаас, метр хэртэй цухуйж харагдлаа. Бодвол түүний маш түргэн савлан гуядаж буй сүүлний цаанаас бололтой далайн ус долгион боргилж байв. Хүн төрөлхтөний л мэдэх нэг ч амьтан сүүлээрээ иймэрхүү хүчтэй цохилж байгаагүй билээ. Тэр гялбам хурц цагаан хөөсөн зам татуулж байлаа.

Хөлөг, гайхал руу чиглэн очив. Би, амьсгаагаа даран, түүнээс нүд салгалгүй ширтэж байв. Миний харснаар бол “Ханан” ба “Гельвец” хоёр онгоц, түүний хэмжээг нилээд хэтрүүлсэн ажээ. Тэгвэл би түүний уртыг хоёр зуун тавин фут хэмээн тодорхойлов. Түүний бүдүүнийг гаргахад хэцүү байсан боловч тэрхүү амьтан бүх гурван чиглэлдээ яг сайхан харьцангуй хэмжээтэй гэдэг сэтгэгдэл надад төрсөн юм. Миний ажиглаж байх тэр үед, түүний хоншоороос хоёр нарийхан усан багана дөчин метрийн өндөрт оргилж байснаар би түүний хэрхэн амьсгалдаг тухай тааварлан чадсан билээ.

Ингээд миний дүгнэлтээр бол тэрхүү хачин амьтан сээр нуруутны хүрээ, сүүгээр бойжигчдын анги, дан хэвэлтний доод анги, халим хэлбэртний багт багтах ёстой бөгөөд, харин язгуур... ямар язгуурт хамаарахыг нь би мэдэхгүй байв.

Халим хэлбэртний багт халим, шүдэт халим, далайн гахай гурав багтдаг билээ. Энэхүү сүүлчийн далайн гахайн язгуурт нарвал хамаарагдана. Гэтэл эдгээр язгуур тус бүр дотроо төрөлд, төрөл нь дүрсэд тус тус ангилагддаг юм. Одоохондоо би, дүрс, төрөл, доод язгуур, язгууррын талаар юм ч хэлж чадахгүй боловч, капитан Фарагутын авхаалж, дадлага ба Нед Лендийн гайхамшигт чадлын үрээр, тэдгээр асуудалд удахгүй хариулж чадна гэдэгтээ би эргэлзэхгүй байсан билээ.



Онгоцны багийнхан ч даргынхаа тушаалыг хүлээж, байж ядан агсан бүлгээ. Ахмад, өнөөх амьтныг анхааралтай ажиглан байснаа онгоцны инженерийг дуудах тушаал өхөд тэр ч дороо хүрэлцэн ирлээ.

Уур тавьсан уу? хэмээн капитан асуув.

Тавьсаан, нөхөр капитан гэж инженер хариулав.

Тэгвэл сайн. Зууханд гал нэм!

Энэхүү тушаалыг гурав дараалсан “ура” угтан талархлаа. Тулалдах цаг болжээ.

Хэдхэн минутын дараа хөлөг онгоцны бүх бие үл мэдэг чичигнэн доргих, түүний өндөр хоёр яндангаас өтгөн хар утаа баагилаа.

“Авраам Линкольн”-ны хүчирхэг сэнс хөлгийг нөгөө амьтны зүг авч одов. Тэр өөрөө биед хагас кабельт хэр ойртуулж амарлингуй байснаа хөлөг онгоцноос холдсонгүй түрүүчийн зайг хадгалан аяархан хөвж зайллаа.

Түүнийг бүтэн дөрөвний гурван цаг мөрдөн хөөсөн боловч “Авраам Линкольн” ганц ч фут ойртож чадсангүй. Иймэрхүү хурдлаад ч тэр амьтныг яавч гүйцэхгүй болох нь илт байна.

Капитан Фарагут өтгөн сахлаа ууртай ирман зогсоно.

- Нед Ленд! гэж тэр хашгирлаа.

Канадын харьяатыг очиход:

- За халимын эрхэм ангуучин! Танд завь хэрэг байна уу? гэж түүнд хэлэхэд:

- Үгүй ээ, хэрэггүй! Энэ гайхлыг чинь өөрөө гарт орж өхөөс нааш барьшгүй нь хэмээн жад шидэгч маань хариулав.

- Тэгвэл яах вэ?

- Аль болохоор уурын хүчийг нэмчихээд хэрэв та болгоохсон бол жадтайгаа онгоцны урд хушуун дээр зогсож аль л бололцоотой цагт шидье.

- Тэг, Нед минь хэмээн капитан хэлээд харилцах хоолойгоор:

- Уур нэм! гэж тушаал өглөө.

Нед Ленд байранд одов. Зууханд нүүрс дахин нэмэхэд, сэнс минутанд дөчин гурав хүрч эргэлээ. Усанд хаясан хурдны хэмжүүр “Авраам Линкольн” цагт арван найм аравны таван милийн хурдтай давхиж байгааг зааж байв.

Гэтэл, нөгөө золигийн амьтан мөн л цагт арван найм арваны таван миль хурдаллаа. Хөлөг онгоц бүтэн цагийн турш ийм хурдтай явавч нэг ч сантиметр ойртож чадсангүй. Энэ нь Америкийн тэнгисийн албаны хамгийн хурдан хөлөгний нэрэнд даан ч гутамшиг ажээ. Онгоцны баг бүгдээрээ галзуурах дөхлөө. Усан цэргүүд

гайхлыг хичнээн хараавч тэр жигших маягтай дуу эс гарч билээ. Капитан Фарагут сахлаа имрэхээ больж, харин бүр зажилж байлаа.

Инженерийг дахин дуудуулж

- Уураа хэмжээнд нь тулгасан уу? хэмээн капитан асуухад

- Тулгасан.

- Хичнээн атмосфер хүртэл?

- Зургаа аравны тав.

- Арав хүрэг!

Энэ бол үнэндээ ёстой Америк маягийн тушаал байлаа. Миссисип мөрний галт онгоцны капитан өөрийнхөө өрсөлдөгчийг хол хаяхын тул үүнээс илүү юу ч хэлэх аргагүй билээ.

- Консель! Чи мэдэж байна уу? Бид ч ер нь даруйхан онгоцтойгоо зад үсэрч агаарт дэгдэх дэг ээ? хэмээн би дэргэдээ зогсож байсан өөрийн сайн зарцад өгүүлэхэд тэр:

- Эзний л таалал мэдэж хэмээн өчив.

Үнэндээ ч капитаны галзуурсан зориг миний сэтгэлд нийлсэн юм.

Галч нар зуухандаа дахин нүүрс халтал нь чихэхэд салхин сэнсүүд зууханд агаар элдэн оруулж уурын даралт өслөө. “Авраам Линкольн” урагшаа ухасхийв. Түүний шургууд угаараа салгалж утаа нь яндангаараа хахаж цацан, багтаж ядан багширч эхэллээ.

Хурдны хэмжүүрийг усанд дахин буулгахад капитан:

- Хэд вэ? хэмээн асуув.

- Арван ес аравны гурван миль.

- Даралтаа дахиад нэм! гэж тушаажээ. Инженерүүд тушаалыг дагав. Манометрийн зүү арван атмосфер заалаа. Гэвч гайхал ч бас л “уураа тавьсан” бололтой, тэр мөртөө нэг л ядарсан янзгүй мөн л цагт арван ес аравны гурван миль хурдлав.

Ёх доо... ямар хөөцөлдөөн байсан гэж санана! Үгүй ээ, би өөрийн хөдөлсөн сэтгэлийн улмаас хүний тухай бичиж чадахгүй нь.

Би бүр байж ядсандаа салгалж л байлаа.

Нед Ленд гартаа жад барьсаар онгоцны хушуун дээр зогсож байв.

Нөгөө амьтан ашгүй, хэд хэд дахин өөртөө ойртох бололцоо өглөө.

- Гүйцэж байна! Гүйцэж байна хэмээн канад газрын хүн маань хашгачиж байлаа.

Тэр жадаа шидэхээр далайхын сацуу, өнөө амьтан багадахдаа л цагийн гучин миль хурдтайгаар зайлж одлоо. Гэтэл бид хэр чинээгээрээ эрчилж байсан маань бас багадаж, харин тэр дооглох мэт биднийг тойрон давхив. Онгоцны баг үүний хариуд зөвхөн л галзуурах адил бархирахаас өөр юу ч хийж чадахгүй ажээ.

Үд дунд хэрд, бид нарвалаас мөн л өглөө 8 цагт байдаг шигээ зайтай байв.

Гэтэл капитан Фарагут, өөр хэрэгсэл ажиллагаанд оруулахаар шийдвэрлэв.

- Аа, тийм үү! хэмээн тэр уурсаж, энэ амьтан “Авраам Линкольн”-оос ч хурдан л юм байж. За яахав, тэгвэл буун сумнаас хурдан эсэхий нь үзье дээ. Хөөе, Боцман! Буучийг урд буу руу явуул! гэлээ.

Их бууг эгшин зуур цэнэглэн онилжээ. Нир буух чимээ гарч, сум хагас миль зайтай байсан нарвал дээгүүр хэдэн фут хэртэй давж туслаа.

- Өөр буучийг, гавшгайхан шигээс нь! Энэ новшийг оносон хүнд таван зуун доллар шагнана гэж капитан хашгирлаа. Буурал сахалтай өвгөн бууч, одоо ч гэсэн би түүний амгалан харц, хүйтэн царайг тод санаж байна, буу руу ойртож очиж маш хянамгай ониллоо. Буун дуу гарахыг завдалгүй, онгоцныхны “ура” хэмээн хашгирах сүрт чимээ цууриатав. Сум яг барьсандаа тусчээ. Гэтэл, харин сум маань нарвалын арьснаас хальт үсрэн тээр тийшээ далайн уснаа шидэгдсэн билээ.

- Э, чөтгөр гэж! хэмээн хилэгнэж бачимдсан өвгөн бууч өгүүлээд – Арай энэ хог чинь зургаан ямхын ган хуяггүй байлтай даа? Гэлээ.

- Хар гай – хэмээн капитан Фарагут бархирав.

Хөөцөлдөөн үргэлжлэв.

Капитан надад ойртож ирээд:

- Нарвалаас би, онгоцныхоо тогоог дэлбэ үсрэхээс нааш салахгүй гэхэд нь би

- Зүйтэй! Тэгэх л хэрэгтэй! Гэлээ.

Эцэж цуцашгүй уурын машинтай уралдсаар эрт орой хэдийд боловч тэр амьтныг ядарна гэж бодож болох байв. Гэтэл цаг мөч өнгөрөх тутам өнөө амьтанд цуцах шинж ер үгүй ажээ.

“Авраам Линкольн” нэрийг бодож тэмдэглэхэд, тэр маш шургуу мөрдөж билээ. Миний бодож гаргаснаар л бол энэхүү арван нэгдүгээр сарын зургааны нүгэлт өдөр манай хөлөг таван зуун милиэс багагүй газар давхисан юм. Тэгтэл ч дахин шөнө болж догшин далайг битүү харанхуй нөмөрлөө.

Энэ үед би, бидний жуулчлал ингээд л дуусвар болж, бид гайхамшигт амьтанг дахиад хэзээ ч олж үзэхгүй нь ээ гэж бодож билээ.

Гэвч, би эндүүрчээ.

Оройн арван цагт тавин минутад хөлөгнөө гурван милийн хэртэй цахилгаан цацрал дахин бий боллоо.

Нарвал, хөдлөхгүй байгаа бололтой. Тэр одоо, өдөр ядарсандаа болж долгион дээр халибалзан унтаж байлаа. Иймд, үүний нь л ашиглах хэрэгтэй болсон тул капитан маань ч аз заяагаа сориод үзэхээр шийдэв.

Тэр зохих тушаал өгч “Авраам Линкольн” нөгөөх амьтныг аль болохоор сэрээхгүйг хичээнгүйлэн аяархан урагшиллаа. Далайд, ер нь нам унтчихсан халимтай олон удаа тохиолдож болох бөгөөд Нед Ленд ч тэднийг нойрон дунд нь нэг бус удаа шорлож алсан ажээ.

Канад нутгийн хүн урд хоншоор дээр мөн л байраа эзлэн зогсов.

Хөлөг уул амьтанд хоёр кабельт хэр газар сэмхэн ойртож, дараа нь машинаа унтраагаад, цаашаа эрчиндээ хөвлөө.

Онгоцны тавцан дээрх хүмүүс бүгд амьсгаагаа дарахад, орчинд чив чимээгүй ажээ. Бид, тэрхүү туяарч буй гонзгороос дөнгөж зуун алхам хэр зайтай байгаа тэр минутад би, Нед Ленд өөрийн хүчирхэг гарт аймшигт зэвсгээ далайсан байхыг харав.

Хөлөг, үл хөдлөгч амьтанд бүр ч ойртон очиход бидний хооронд хорьхон алхам зай үлджээ.

Ингэтэл ч Нед Лендийн гар агаарт нэг бүтэн эргэлдэхэд дүүгүүрдэгдсэн жад ч нисэж одлоо. Тэрний дараа би, төмөр хангинах мэт дуу сонсож билээ.

Энэ үед цахилгаан цацрал ч таг унтарч, хоёр аварга усан оргил хөлгийн тавцан дээр бууж хүмүүсийг цохилон унагаж, замдаа тохиолдсон бүхнийг арчлаа.

Тэгтэл ч аймшигт чимээ “няр” хийх мэт болж би урьдах хашлагаасаа барьж авч амжсангүй, далай уруу годройтон унасан билээ.

[Тор](#)

---

## ҮЛ ТАНИГДАХ ДҮРСИЙН ХАЛИМ

Би хэдийгээр санамсаргүй гэнэт унасан боловч өөрт тохиолдсон бүхнийг сайн мэдэж байв.

Эхлээд би усанд живсэн, гэвч би сайн самардаг тул үүндээ бардаж, эхлээд

шингэж орсондоо сандарсангүй.

Усан дээр хөвж гармагц би юуны өмнө л онгоцоо эргэж харлаа. Миний онхолдохыг тэд харсан бол уу! Капитан Фарагут миний амийг врах гэж завь буулгасан бол уу! Би ер нь аврагдана гэдэгт итгэх газар байна уу?

Хэдий над харанхуй байсан боловч, би тээр зүүн зүгт ямар нэгэн бөөн хар том юм бүртэлзэхийг таних тэмдэг, галаар нь баримталж, холож байхыг олж харлаа. Энэ нь манай онгоц мөн ажээ. Би ч өөрийгөө нгөрлөө л гэж бодов.

- Наашаа, наашаа! Хэмээн би онгоцоо гүйцэхийг оролдон хашгирч байлаа. Шал норсон хувцас бие барьж наалдаад, самрахад садаа болох ажээ. Би аийсгаадчихлаа. Тэгээд л живж эхэллээ...

-Туслаарай!..

Энэ миний эцсийн цөхөрсөн дуу байсан юм. Би живж байгаагаа мэдрэх тутам амь тавин сарвалзаж билээ.

Гэтэл, миний ар шилнээс булай гүжирмэг гар шүрэн авч, нэгэн дугтралтаар усан дээр татаж гаргалаа.

Тэгтэл ч яг миний чихэнд :

-Хэрвээ эзэн миний мөрөн дээр тулахыг таалан соёрхохсон бол самрахад тань хялбар болохсон! Гэхийг сонслоо.

Тэгээд би өөрийн үнэнч Конселийн гараас татан авсан юм.

-Энэ чинь чи юу ? Чи гэж үү? хэмээн би асуухад :

-Тиймээ, би байна. эзний тусын тул хэзээд бэлэн гэж Консель хариуллаа.

-Тэгвэл доргионд нь чамайг яг л над шиг аваад шидчихжээ?

-Үгүй ээ. Гэлээ ч гэсэн би, эзний дэргэд зогсож байгаад эзний ойчихоор таныг дагалдах нь, таныг дагалдах нь миний үүрэг гэж бодсон юм.

Энэ явдал тэрхүү бэрх хөвгүүнд ердийн л нэг албан үүрэг мэт санагджээ.

-Хөлөг яасан бэ? хэмээн би асуув.

-Хөлөг үү? гэж Консель давтан асуух зуураа араараа эргэлдэн, миний бодоход эзэн минь, түүний тусламжинд горьдсоны ч хэрэггүй биз дээ гэж хариуллаа.

-Яагаад?

-Миний усанд үсрэх үед ээлжийн усан цэрэг “Сэнс, залуур хоёр эвдэрчээ” гэж чарлаж байсан.

-Эвдэрчээ?

-Тиймээ. Гайхал хадарчихсан. Бодвол, “Авраам Линкольн” энэ нэг л

гэмтлээс өөр юмгүй хоёр яс гахацсан байх. Гэсэн ч бидний заяа дутахад тэр залуу жолоогүй үлджээ.

-Тэгвэл бид өнгөрчээ?

-Магадгүй хэмээн Консель тайвуухан хэлээд, гэвчбидний эрхэнд дахиад хэдэн цагийн зай байна, тэгвэл хэдэн цагийн дотор нилээд юм хийдэг шүү дээ гэлээ.

Конселийн энэхүү мохошгүй амгалан авир надад зориг орууллаа. Би нилээд шуурхай сэлж эхэллээ. Гэвч хувцас маань мөн л бие барьж усан дээр хөвөхөд хүнд байлаа.

Консель үүнийг мэдсэн бололтой.

-Эзний хувцсыг огтчин хаяхыг зөвшөөрөхсөн бол уу? гэлээ.

Ийнхүү тэр, мийний хувцсыг дэрээс нь доош нь хүртэл хутгаар хүү татаж хаяхад би түүнийг усан дээр тогтоон барьж байлаа. Мөн би Консельд иймэрхүү тусламж үзүүлэв. Үүний дараа хоёулаа зэрэгцэн самарч гарлаа.

Гэвч бидний байдал үүний улмаас сайжирч гавьсан юм юу ч байхагүй. Биднийг хэн ч үгүйлээгүй байж болно. За мэдлээ ч гээд сэнс, залуургүй болсонхөлөг онгоц салхины эсрэг бидний хойноос тэртээ, тэргүй явж чадахгүй байв. Тийм учраас бид өвхөн капитан Фарагутын илгээх завинд л горьдохоос өөр замгүй ажээ.

Энэ дүгнэлтийн эцэст бид усан дээр аль болохоор л удаан тогтохыг мэрийлээ. Үүний тулд бид хоёулаа зэрэг цуцахгүйн тул, нэг нь гарацээжиндээ зөрүүлэн араараа хэвтэж явахад нөгөө нь түүнийгээ түлхэн урагшилж байлаа. Арван минут тутамд бид бие биеийг халах ёстой байв. Иймэрхүүгээр бид магадгүй нар гартал ч усан дээр удаан тогтож болох ажээ.

Аврагдахын ямар ч болхи арга хомс найдвар бага байв даа. Гэвч хүн гэдэг ямар ч найдвагүй цагт л найдах зантай юм газар.

Хөлөг онгоц нарвалтай шөнийн арван нэгэн цагт мөргөлдсөн юм. Иймээс бид өдөр болтол усан дээгүүр бүтэн найман цаг тэсвэрлэх ёстой билээ. Энэ ч бүрэн бололцоотой л хэрэг.

Далай долгиогүй амгалан ажээ. Мөч тутам л би нүдгүй харанхуйн дунд ямар нэгэн юм олж харахыг хичээх авч эргэн тойрон хов хоосон байх бөгөөд зөвхөн л бидний хөдөлгөсөн долгио гялалзан мэлтэлзэж байв.

Гэвч, би шөнийн нэг цагийн хэрд үхтлээ ядарснаа мэдлээ. Миний гар хөлийн шөрмөс сүрхий татаж байв.

Бидний аврагдах эсэх ганцхан Конселийн толгойд ноогджээ. Удсанчгүй

хөөрхий хөвгүүнамьсгаадаж байхыг би мэдэж, тэр ийнхүү удаан тэсэхгүй гэдгийг би ойлголоо.

-Намайг орхи! Орхи намайг гэж би түүнд хэллээ.

-Эзнийгээ юу? Хэрхэвч үгүй! хэмээн миний муу үнэнч зарцөгүүлээд би танаас түрүүлж өөрөө живж үхэхийг дээрд үзнэ гэлээ.

Энэ үед салхинд зүүн зүг туугдаж буй бөөн үүлний цоорхойгоор сар цухуйв. Далайн гадаргуу түүний туяанд мяралзан харагдав. Энэхүү ивээлт цацрал надад хүч өгч билээ. Би толгойгоо өргөн далайн түвшнийг ажиглав.

Хөлөг онгоцоо олж харахад тэр биднээс таван милийн зайтай харагдав. Ийм зайнд онгоц маань бяцхан цэг мэт дөнгөж бүртийн байв. Нэг ч завь харагдсангүй.

Би хэдий туслахыг эрж, хашгирахыг бодсон авч миний хавдаж хөөсөн уруул бяцхан ч дуу гаргах бололцоогүй ажээ.

-Туслаач ээ! Туслаач! хэмээн Консель орилов.

Секунд хэр бид зогсосхийж чимээ чагналаа... энэ чинь юу билээ? Эсхүл толгойд цус харваснаас чих шуугиж дуулдав уу, эсхүл үнэхээр бидэнд хариу хашгирав уу?

-Дуулав уу? чи хэмээн би Конселиас шивнэн асуухад :

-Дууллаа гэлээ.

Консель дахин цөхөрсөн дуугаар хашгирав. Одооч эргэлзэх юм алга даа! Яах аргагүй ямар нэгэн хүн Консельд хариу хашгирлаа.

Энэ бидний нэгэн адил эх адаггүй их далайн дунд төөрөлдөн хөлөг онгоцдоргих үед үсэрч унасан нэгэнзаяа муутын дуу болов уу? Эсхүл биднийг харанхуйн дундаас харахгүй байгаа завин дээрээс хашгиран дуудав уу?

Консель, миний мөрөн дээр тулж аль байхаараа цоройн бүслэхээ хүртэл уснаас шомбойн орчинг ажиглах гээд хавтгайгаараа пал хийн уналаа.

-Юу үзэв?

-Би ... би хэмээн тэр шивнэж байснаа гэвч, хэлээд хэрэггүй биз, хүчээ хэмнэе ... гэж хэллээ.

Тэр юугаа үзсэн юм бол? Бүү мэд ээ, яагаад ч юм энэ үед миний толгойд гайхлын тухай бодол гэнэт орж ирлээ...

Тэхэд Консель намайг урагш түлхсээр явлаа. Тэхдээ тэр, байсхийгээд л толгойгоо өндийлгөж хэн нэгэнтэй дуугаралцах мэт байв. Гэтэл хэнг нэгэн хүн түүнд даруйхан, хариу хэлж ч байх шиг.

Би, юм дуулахтай үгүйтэй байв. Миний тэнхээ тасарчээ. Миний хэдэн хуруу сарвайж, гарын алга тулгуур болохоосоо өнгөрчээ. таталдан ангайсан аманд минь

далайн шорвог ус орж, ясанд тултал хүйт оргиж байлаа. Би, амьдралдтайгаа салахын ёс хийхээр эцсийн удаа толгойгоо өргөхөд минь ...

Энэ секундэд би ямар нэг хатуу юманд тулав. Би тэр юмнаас зууралдаж авлаа. Тэгтэл намайг уснаас дээш нь татаж гаргах ч шиг, тэгтэл би, цээж дүүрэн амьсгалах ч шиг, гэвч би ухаан алджээ.

Бодвол би, намайг шуурхайлан илбэсний ачаар болотой даруйхан ухаан орж, нүдээ хагас нээлээ.

-Консель хэмээн би шивнэв.

-Эзэн намайг дуудав уу? гэж миний шударга зарц хариу дуугарч билээ.

Сарны эцсийн туяа далд орж байсан энэхэн агшинд би, өөрийн сайн таних өөр нэг хүний царайг олж харав.

-Нед Ленд үү? гэж би дуу алдлаа.

-Яг мөн эрхэм профессор минь. Нед Ленд бас л өөрийнхөө шагнал мөнгөтэй хөөцөлдсөөр явахыг харахгүй байна уу хэмээн канад хүн хариулав.

-Таныг бас доргионоор далайд шидчихээ юу?

-Тиймээ, ноён профессор, зөвхөн намайг шууд л хөвөгч арал дээр шидчихсэн болохоор та нараас арай л илүү үйлстэй санж.

-Арал ий.

-Тиймээ, эсхүл бүр яг үнэнээр нь хэлбэл таны өнөөх аварга нарвалын тань нуруун дээр.

-Та, жаахан тодорхойлон ярь, Нед!

-Тэгээд л би чухам яахаараа миний жад түүний арьсыг цөм шорлож чадалгүй, хальтарч одсоныг дөнгөж тэхэд л ойлголоо л доо гэж канад хүн залгуулан ярилаа.

-Яагаад Нед минь, яагаад?

-Яагаад гэвэл, ноён профессор минь, энэ амьтан чинь ган хуягаар өвчилсөн амьтан санжээ.

Канадын харъяатын хэлсэн үг миний бодолд гэнэтийн шинэ эргэлт өглөө.

Бид дээр нь амь гарасн, тэрхүү уснаас дөнгөж цухуйж байгаа амьтан буюу юмны нуруун дээр би бушуухан босч зогсов. Би хөлөөрөө дэвсэлж үзэхэд энэ нэгэн нуруу хүнд ч даагдашгүй хатуу бөгөөд энгийн том биетэй сүүгээр бойжигч амьтны нуруутай адил бэлцгэнэсэн зөөлөн биш байв.

Би эхлээд өөрсдийгөө эрт балрын сөнөсөн амьтны гавалтай адил ямар нэгэн ясан гавалдээр гарчээ хэмээн бодохыг дөхлөө. Тэгвэл, би гайхлыг яст мэлхий ба



аллигаторын нэгэн адил мөлхөгчдийн ангид ангилах ёстой байв.

Үгүй ээ, тэхгүй. миний зогсож байсан гүдгэр хар нуруу хайрслал бус өнгөлөгдсөн гөлгөр ажээ. Түүнчлэн дэлсэхэд төмөр мэт хангинах чимээгарах бөгөөд зузаан гангаар хуягласан шиг санагдаж байв.

Тэгвэл өнөө амьтан гайхал, ер бусын амьд гайхамшигт эрдэм шинжилгээний бүх ертөнцийг донсолгож бөмбөрцгийн хоёр хагасын далайчдын санаа сэтгэлийг үймрүүлэн агсан өнөө нууц маань, харин одоо аргагүй л алгаараа үзэж, арваараа барьж байгаа юм болохоор хүний гараар бүтээгдсэн бүр ч гайхамшигтай ид шидтэй зүйл болсонд эргэлзэх явдал байхгүй боллоо.

Хэрэв би, хамгийн марзан инээдэмтэй амьтан шинээр нээж олсон бол тэгж их гайхаж сандрахгүйсэн. Байгаль гайхамшигийг буй болгодог, гайхах юм ер алга. Гэтэл хүний гараар бүтээгдсэн тийм этгээд, агуу гайхамшигийг олж үзсэн хүн л харин ухаан алдаж болох байлаа.

Гэлээ ч гэсэн эргэлзэхийн арга алга болжээ. Бид, миний л төсөөлж байгаагаар бол асар том ган загас мэт хэлбэртэй усан доогуур явдаг өвөрмөц хөлөг онгоцны нуруун дээр байв. Энэ талаар Нед Ленд аль хэдийнээ сэдэвлэсэн билээ. Иймээс Консель бид хоёр зөвхөн л түүний сэтгэмжийг хүлээн авах л үлдлээ.

-Хэрэв л энэ ямар нэгэн хөлөг онгоц л юм бол хөдөлгүүр, олон төрлийн оньсон механизм, тэдгээрийг жолооддог хүмүүс заавал байх ёстой биз? гэлээ.

-Тэгэлгүй дээ, би энэхүү хөвөгч арал дээр авиран гарснаас хойш бүтэн гурван цаг болохд амьд амьтан байхын шинж ер алга гэж канад хүн хариулав.

-Онгоц байрнаасаа ер хөдөлсөнгүй юү?

-Үгүй, профессор минь. Энэ зөвхөн л долгион дээр далбилзан байснаас биш урагшилсангүй.

-Тэгвэл бид үүний чинь их хурдан гэдгийг сайн мэднэ шүү дээ. Тийм учраас үүнийг тэгжхурдан гүйлгэхэд машины нь жолоодох хүн хэрэгтэй тул бид аврагджээ гэж би бодож байна.

-Нн!.. хэмээн Нед Ленд итгэмжгүйхэн шүү хамраараа хүнгэнэв.

Яг энэ үед миний нотлох гэсэн юм шиг этгээд хөлөгний хитгэний цаана ямар нэгэн пор пор хийх авиа гарч, онгоц байрнаасаа хөдөллөө. Бодвол тэр далбаат сэлүүр сэнсээр хөдөлдөг болотой. Бид өмнө байгаа багахан булцгар юмнаас санд мэнд зуурч авав. Аз болоход хөлөг аяархан хөвж байлаа. Одоохондоо үүнийг усан дээр хөвж байсан цагт надад мэтгэлцэх юм алга. Харин энэ муу доошоо шумбаж орохыг болгоон соёрхох бол би өөрийнхөө энэ муу адсаганд хоёр зоосны ч үнэ өхгүй шүү дээ

гэж Нед Ленд бувтнаж байв.

Канадын хаъяат тэртээ тэргүй өөрийнхөө энэ муу арьсыг түүнээс ч бага үнэлж болох ажээ. Бид энэхүү хөвөгч аппарат дотор ямар ч улс байсан даруйхан уулза учрах хэрэгтэй байлаа. Би уул онгоцны гадаргуу дээр дотогш орох ямар нэгэн таг, нүх сү эрлээ. Гэвч ган хуягийн зүйдлийн ирмэг дагуулан ойр ойрхон зэрэглэж хадсан тав хадааснууд бүгд адилхан ажээ.

Сар ч шингэлээ. Бид ч пад харанхуйд үлдлээ. Энэхүү усан доогуур явагч хөлөг онгоцон дотор нэвтрэхийн тулд үүр цайхыг хүлээх хэрэгтэй болжээ.

Ингээд л бидний амь нас тэр чигээрээ хөлгийг жолоодон буй далд залуурчийн олон аашний эрхэнд орсон билээ. Хэрвээ л тэд уснаа шумбахыг завдах аваас бид өнгөрчээ. Хэрэв л ийм явдал эс тохиолдвол бид усан доогуур явагч онгоцны багтай харьцаж болно гэдэгт би эргэлзэхгүй байв. Үнэндээ ч онгоц доторхи хүмүүс өөрснөө л тэндээ хүчилтөрөгч хйи гарган авч амьсгалдаггүй л юм бол, тэд хүчилтөрөгчийнхөө нөөцийг аривтгахаар далайн усан дээр байн байн хөвж гардаг л байх ёстой билээ. Үүнээс авч үзэхэд онгоц дотор агаар орох ямар нэгэн нүх сүв байх ёстой.

Хөлөг онгоц баруун зүгт цагт арван хоёр милийн хир тааруу хурдтай давхилаа. Сэнсний далбаа жигд эргэлтээр ус самарч үе үе агаарт ус цацлан солонгорсон туяа үүсгэнэ.

Өглөөний 4 цагийн үед улам хурдалж довтолоход бид хөлгийн тавцан дээр тогтохын аргагүй боллоо. Аз болоход Нед маань өвч хуяганд бэхлэгдсэн нэгэн том цагираг тэмтрэн олсон тул бид бүгдээрээ түүнээс зууралдсан билээ.

Ашгүй өнөөх эцэс хязгааргүй шөнө маань өнгөрөх шиг болотой. Би тэр шөнө үзэж өнгөрөөсөн үйлийг бүгдий нь санахгүй боловч заримдаа салхи намжиж, далайн долгио нмхорх хэрд миний сонорт ямар нэгэн хөгжим ая дууны мөчлөг хэсэг сонсдох шиг санагддаг байсан тэр нэгэн явдал миний ойлголтанд үлдсэн юм.

Усан доогуур явагч энэ хөлөг ямар нууц хадгална вэ? Ямар аймшигтай амьтад үүн дотор байдаг бол? Ямар муйхар хүчтэй хөдөлгүүр түүнд тийм аймшигт хурд өгнө вэ?

Гэгээ орлоо. Өглөөний манан биднийг хучсан боловч удсанчгүй замхарлаа.

Би түүний усан дээр ил гарсан гүдгэр хэсгийг шинжин судалж эхэлтэл өнөөх маань доошоо сууж эхэллээ.

-Ай шулмууд аа, хүүе! Ад чөтгөрүүд ээ! хэмээн Нед Ленд буй байхаараа дэвслэн байж биднийг оруулаад орхи!.. гэж хашгирлаа.

Гэвч түүний дуу сэнсний хүрчигнэх чих дүлийрэм дуунд дарагдах ажээ.Заяа

дайрахад онгоцдоошоо суухаа болив.

Тэгтэл гэнэтхэн тайлдаж байгаа цуурганы чимээ сэвхийн нээгээд хүний толгой цухуйлаа. Тэр ямар нэгэн юм хашгираад эгшин зуур алга болж одов. Хэдхэн минутын дараагаар найман мундаг, муйхар эр гарч ирээд биднийг үг дуугүй, таавар болсон хачин онгоцондоо дагуулан орлоо.

[Тор](#)

---

## ХӨДӨЛГӨӨН ДОТОРХИ ХӨДӨЛГӨӨН

-Энэ явдал яах ийхийн зуургүй болсон тул бид гурав нэг ч үг солилцож чадсангүй. тийнхүү хөвөгч шоронд аваачиж чихэж байхад манай нөхөд чухам юу бодож байв, бүү мэд. Миний хувьд л бол хамаг бие арзайж хүйт оргиж билээ.

Бид ямар улстай учирч байна? Гарцаагүй далайн ямар нэгэн шинэ хэлбэрийн дээрэмчидтэй л биз.

Бидний хойноос дээр цоорхойн хавхаг таг хаагдахын цацуу бид пад харанхуй зогсож билээ. Өдрийн хурц наранд дасчихсан миний нүд юу ч харахгүй байв. Нед Ленд, консель хоёр мөн л харгалзагчаар цагдуулан намайг дагалаа.

Шатан доорх хаалгаар биднийг оруулмагц л өнөө хаалга бдний ард хав яв хаагдсан билээ.

Гэтэл тэнд бид гурвуулхнаа ажээ. Бид хаана байв? үүнийг хэлэх байтугай төсөөлж ч чадахгүй ажээ.

Тэнд пад харанхуй тул хичнээн удаан байсан ч нүд дасахгүй учир өчүүхэн ч зурвас гэрэл олж харсангүй ээ.

Түүний зэрэгцээ иймэрхүү бүдүүлэг харьцаанд зэвүүцсэн Нед Ленд өөрийн дургүйцлийг зөнд нь тавьж :

-Мянган савдаг! хэмээн бархирч юуны чинь каледон нутгийн зэрлэг, түүнээс долоон доор зэрлэгүүд! Махчин байх нь л ганцхан дутаж! Гэвч намайг үүгээрээ яасан ч айлгахгүй... үхсэн хойноо л би та нарт сайн дураараа идэгдэнэ дээ гэж догширч байлаа.

-Биеэ барь Нед минь, биеэ барь юу юу ч болоогүй байхад уурлахын хэрэг байхгүй. Одоохондоо бид арай л тавган дээр шарагдаагүй байна гэж Консель амгалан байв.

-Зүйтэй, одоохондоо ч бид арай л хайруулын тавган дээр биш байж, харин зууханд байгаа маань ч гарцаагүй л дээ! Ашгүй энд овоо харанхуй байна. аз болоход хутга маань биенд яваа. Түүнийхээ хэргийг би гарахад над их гэрлийн ч хэрэг алга. Над хамгийн түрүүнд халж ойртсон дээрэмчдийг ч би...

-Нед, та бүү их шуугиул, түүнчлэн энэ явдлаараа бидний байдлыг бүү хүндрүүл...яаж мэдэх вэ бидний үгийг чагнаж ч байж. Харин түүнд орвол бид чухам хаана байгаагаа ярилцъя хэмээн би жад шидэгчид хандан өгүүлэв.

Би их л цэнэж хэд гишгээд гөлмөн төмрөөр доторлосон хананд туллаа. Тэгээд хан дагаж тэмтэрсээр хэдэн мухар сандал тойруулсан модон ширээ мөргөв. Бидний шоронгийн шал дээр алхаа зөөлрүүлэхийн тул сийрс дэвсжээ. Нүцгэн хананд би цонх халганы зүйлтэй юм олсонгүй ээ. Хана даган нөгөө тийшээ явсан Консель надтай мөргөлдөж бид өргөөшөө арав, уртаашаа хорин фут жижиг өрөөний гол руу хүрч ирэв. Өрөөний таазны өндрийг бид тохойлдож чадсангүй. Өндөр горзгор Нед Ленд хичнээн сарвайгаад ч адарт нь хүрсэнгүй.

Энд орж ирсээр хагас цаг өнгөрсөн боловч бидний байдал өөрчлөгдсөнгүй ээ. Гэвч бидний шорон гэнэт гэрэлтүүлэгдэв. Гэрлийн хурц тод өнгөөр би усан доогуур явагч тойрон байсан солонгорсон сод туяа, цахилгаан гэрэл мөн гэж танилаа. Анхандаа би гялбаж өөрийн эрхгүй нүдээ тас аньсан билээ. Дараа нь нүдээ нээвэл таазанд бэхлэгдсэн бөмбөгөр цагаан шилнээс гэрэл цацарч байв.

-Ашгүй нэг юм харагдахтай болов шив дээ гэж Нед Ленд өгүүлэв. Тэр, гартаа хутгаа атгаж дайралтыг няцаах гэсэн шиг зогсож байлаа.

-Бидэнтэй чухам юу болох нь л харагдахгүй байгаа нь хайран даа хэмээн би хошигнон хэллээ.

- Эзэн тэсвэрлэж л үзэхийг зөвлөхсөн байна гэж Консель дуун гарав. Гялбам хурц гэрэлд бид шоронгоо ажиж авах бололцоотой ажээ. Түүний тавилга гэхээс нэг ширээ, таван мухар сандал байв. Далд хаалга бин битүү хаагдсан тул зай завсар харагдсангүй. Бидний сонорт ямар ч юм үл дуулдах онгоцон дээрх амьд бүхэн цөм үхсэн мэт ажээ. Би онгоцыг зогсож буй, явж буй, живсэн буюу эсхүл урьдын адил хөвж буй аль алиныг нь хэлж чадахгүй байв.

Хүмүүс ямар ч хэрэггүй байж харанхуй гянданг гэрэлтүүлэхгүйн тул онгоцны багаас хэн нэг нь удахгүй орж ирнэ гэдэгт үл эргэлзэх бөгөөд цахилгаан дэн гэрэлтүүлэгдсэн нь ямар нэгэн зорилготой гэдэг ойлгомжтой буйзаа.

Би эндүүрсэнгүй ээ. Удсан ч үгүй түгжээ тарчигнах чимээ гарч хаалга нээгдмэгц хоёр хүн орж ирлээ.

Тэдгээрийн нэг нь навтгар, булиа, мөр өргөнтэй, данхар толгойтой, арзгар өтгөн хар үстэй, урт сахал, хурц харцтай хүн байв. Түүний төрх байдалд өмнөд газрын хурдан шаламгай, цовоо байдал илрэх нь Францад прованс мужийнхан иймэрхүүгээрээ гайхуулдагтай адил билээ.

Түүний нөгөөх өндөр хүнийг нилээд тодорхой зурвал зохих мэт царай шинжээч агуу их хүмүүс Грасиоле болон Энгель нарын шавь энэ хүний зан авирыг номонд заасан шиг тодорхойлохсон бизээ. Би өчүүхэн ч гуйвсангүй, түүний хамгийн гол зан чанарыг тодорхойллоо. Үүнд: Түүний тэргүүн бардам сэхүүн болж ирээд хар нүдний нь шийдэмгий хурц хүйтэн харц түүнийг өөрийн хүчинд бат итгэдгий нь харуулж, хөрслөг цагаан арьс нь түүний амгалан байдлыг гэрчлэх бөгөөд хөмсөгний нь булчин эгшин зуур агшихыг харвал, түүний эрэмгий болох нь танигдах ба амьдралын асар их нөөцийг агуулсан цээжний амьсгалын хүчирхэг түрэлт, түүний зүрх зоригийг илтгэнэ. Ингээд нэмж хэлэхэд энэ хүн тун ихэмсэг бардам хүн бөгөөд түүний амгалан болж ирээд дальдаршгүй ширүүн харц оюун ухааны нь ариун тунгалаг болохыг тусган, түүний төрх байдал бүхэлдээ агуу их чин шударгын сэтгэгдлийг төрүүлнэ.

Түүний орж ирэхийн чацуу би өөрсдийн хувь заяаны талаар санаа зовох явдалгүй болон түүнтэй учирсан биднийг сайн сайхан төгсөлтэй гэдэгт шууд итгэсэн билээ.

Энэ хүний насыг гучин тав, тавь хоёрын хооронд бол уу гэж бодогдмоор бөгөөд түүний насыг би яг олчихож чадсангүй. Тэр өргөн духтай, шулуун хамар, тод зурвас амтай, бөх сайхан шүд болон цэвэрхэн нарийхан гаралтай хүн байв. Ер нь л надтай тохиолдож агсан эрчүүдийн дотроос эр хүний гуа сайхныг хадгалсан хамгийн цэвэр гуа сайхан эр байлаа. Түүнчлэн, түүний царайны бас нэгэн өвөрмөц гоц чанар бол нэг л тусгалаараа замбуулингийн тэн хагасын тал хэсгийг буйгаар нь багтаан харж чадах, өөр хоорондоо харилцан хол зайтай оршигч хоёр нүд байлаа. Тэрний энэ чанар хурц хараатайгаа хослон Нед Лендээс хол илүү үзмэрч болохыг би сүүлд мэдсэн билээ.

Энэ нэгэн үл танигдагч, хэн нэгний зүг өөрийн харцыг чиглүүлэхэд түүний хөмсөг нь эрчлэн, зовхи нь ойртож, хараа нь нарийсах тул түүний харц цоргих мэт ажээ. Ай бүү үзэгд ямар харц гэж санана! Түүний хараа холыг ойртуулан, уураг тархины хамгийн угт далдлагдсан нууцад нэвтэрч, усны гүнийг шил мэт нэвтлэн, далайн ёроолын амьдралыг номон дээрх мэт уншдаг ажээ.

Тэр хоёр үл танигдагч хоёулаа халиун малгай, нохой загасны арьсан өндөр түрийтэй гутал, миний л мэдэх эдээр хийсэн гоёмсог бөгөөд биедээ тохирсон хувцас

өмсчээ.

Тэдний толгойлогч нь бол уу гэмээр өндөр биетэй нь биднийг маш анхааран ширтсэний дараа дагалдагчдаа над үл мэдэгдэх хэлээр хэдэн үг хэлэв. Энэ нилээд яруу цээлхэн уяхан аялагхан эгшиг авиа элбэгтэй, үе үе уртатган дуудах яриа байлаа.

Нөгөөх нь хариу толгой дохихын хамт мөн л төчнөөн хоёр гурван үл ойлгогдох үг хэлэв.

Тэгтэл ч толгойлогчийн нь харц ямар нэгэн юм хэлэхийг эрсэн мэт над руу хандахад би, цэвэр франц хэлээр түүний эрэлтийг ойлгохгүй байгаагаа харууллаа. Гэвч тэр миний үгийг бас л ойлгосонгүй мэт тул бидний байдал бүр ч төвөгтэй болсон билээ.

- Эзэн өөрийнхөө намтрыг эзэнд ярьж өгвөл эрхбиш эд ямар нэгэн юм ойлгохсон бол уу хэмээн би зөвлөхсөн байнам гэж Консель хэллээ.

Би түүний зөвлөлгөөнийг дагаж өөрсдийн түүхийг нэг ч юм дутаалгүй үг тус бүрийг тод дуудан бүгдийг ярилаа. Би өөрсдийн алдар нэр, албан тушаал бүгдийг тоочсоны эцэст, ёсыг даган өөрийн бие профессор Аронакс, зарц Конселийн хамт болон алдарт жадчин Нед Ленд хэмээн тэдэнд танилцуулав.

Найрсаг бодлогоширсн дулаан харцтай тэр хүн миний яриаг анхааралтай, эелдгээр хүлээн авлаа. Гэвч миний ярианаас ядаж ганц үг ойлгосон янз үгүй түүний царайд ганц ч булчин татавхийсэнгүй ээ.

Тийм учраас англиар ярилцаж болох бас нэг бололцоо үлджээ. Бодвол энэ бараг ч олон улсын дундын хэл болох тул ойлголцох ч магадгүй. Би англи хэлийг немц хүний нэгэн адил толь хэрэглэхгүйгээр уншиж, бичиж сайн мэдэх боловч харилцан ярилцахаар ярианы хэлэнд төдий л сайн биш билээ. Түүний зэрэгцээ, энэ тухайд ярихыг аль болохоор эрмэлзэх хэрэгтэй байлаа.

- Одоо, таны ээлж хэмээн би жад шидэгчид хандан ярь Нед минь! Та өөрийн оюун ухааныг шавхан дайчилж английн хамгийн шилдэг, гоё сайхан үгээр ярьж, надаас илүү амжилт олохыг хичээнэ үү гэж хэллээ.

Нед ч өөрийгөө хоёр дахин гуйлгасангүй, миний ярьсныг англиар давтав. Тэр үнэндээ миний ярианы гол утгыг дамжуулсан боловч хэлбэрийн нь шал өөр болгожээ.

Канад хүн их л ширүүн уулзаж байв. Мань хүн, биднийг ийнхүү хүний ёсноос гадуур хүч түрэмгийлэн буй хэмээн шууд эсэргүүцэж, биднийг чухам ямар хуулиар энэхүү шоронд барьж хорьсныг асуулт болгон тулгаж, эрх чөлөөг маань ийнхүү хязгаарласан тэр этгээдтэй хууль ёсоор заргалдана гэж заналхийлэн, гар занган

хашгачин байснаа эцсийн бүлэгт, турж үхлээ гэсэн тэмдэг дохио өгч хоёр саллаа.

Энэ ч яах аргагүй зөв байсан бөгөөд үүний тухай бид бараг мартжээ.

Жад шидэгч маань өөрийн яриаг, минийхийн нэгэн адил ямар ч ашиг олсонгүйг сая мэдмэгцээ мэл гайхаж, цэл хөхөрчээ. Бидэн дээр орж ирэгсэд ядаж нүд ч ирэмсэнгүй ээ. Бодвол тэд Фарадейн<sup>1</sup> хэлийг Арагогийн<sup>2</sup> хэлээс хэт мэдэж гийгүүлэх юмгүй буйзаа.

Ийнхүү хэл ярианыхаа хамаг нөөцийг шавхаж дуусаад амжилтгүйдээ эвгүйрхэн цаашид би чухам яахаа мэдэхгүй гайхаж атал Консель маань надад хандан:

- Хэрэв эзэн зөвшөөрөхсөн бол би, мөн зүйлийг немцээр хэлээд үзье гэж хэлэв.

- Юу? чи немц хэл мэддэг гэж үү? хэмээн би бархирч билээ.

Ердийн фламанд хүн ярьдагчлан би ч гэсэн нэг муу ярьдаг юмаа. Хэрэв л эзэн татгалзахгүй бол...

- Ярилгүй яахав Консель минь! Бушуухан ярь! Тэгээд л Консель маань өөрийнхөө учрал тохиолыг гурав дахь удаа уужуухан ярьж өглөө. Гэлээ ч гэсэн яригчийн хэл ярианы нарийн итгэгчийн хэллэгийн онцгой барил бүхнийг ч харгалзахгүйгээр немц хэл бас л ашиг болсонгүй.

Ингээд хамгийн сүүлд би арга ядахдаа, хаа байсан сурагч байхынхаа үеийн хэд гурван үгийг хамж цуглуулан мөн яриаг латинаар давтлаа.

Хэрэв миний энэ яриаг Цицерон<sup>3</sup> өөрөө сонссонсон бол хоёр чихээ бөглөн, намайг гал зуухны өрөө рүү үлдэн хөөх агсан боловч би мөн ингэж тэгсээр байж яриагаа дуусгаж билээ.

Гэвч, үүнээс бас л үр дүн гарсангүй ээ.

Сүүлчийн энэхүү оролдсоны дара тэд, үл ойлгогдох хэлээр хэдэн үг сольчихоод, бидэнд ядаж дэлхийн орон бүхэнд, үндэстэн бүхэнд яг л нэг адил байдаг дохиогоор ямар нэгэн тайвшруулах маяг үзүүлсэнгүй гарч одлоо.

Тэдний араас хаалга тас хаагдав.

- Энэ чинь бузар явдал! хэмээн Нед Ленд зэвүүцэн шатаж бараг хорь дахин давтан хашгачиж – Энэ бүдүүлгүүдтэй чинь англи, франц, немц, латин хэлээр ярьж байхад нэг ч үг хариулахгүй байна гэнэ! Аа! Юу гэсэн үг вэ? гэж догширч эхлэв.

- Тайвшир, Нед минь уурлаад бидний хэрэгт тус болохгүй гэж уурсан догширсон жад шидэгчид учирлан сэнхрүүллээ.

<sup>1</sup>Фарадей-Английн алдарт физикч

<sup>2</sup>Араго-Францын алдарт физикч ба одон орныг судлагч

<sup>3</sup>Цицерон –Эртний римийн илтгээч бөгөөд уран зохиолч(106-43он)

- Үгүй ээ, профессор та мэдэж байна уу, ингэхэд, энэ төмөр сав дотор чинь бид турж үхлээ гэж үнэхээр цухалдсан канад хүн үгүүлэв.

- Нн... хэмээн Консель гүн ухаантан хүний нэн амгалан царай гарган бас ч болоогүй ээ гэж татгалзлаа.

- Нөхөд минь дэмий их тачъядахын хэрэг юун бид үүнээс ч доор юм үзлээ. Энэ капитан, түүний онгоцны багийг яаран зэмлэхийн хэрэг алга, бид эдний тухай өөрсдийн дүгнэлтийг хийж амжина гэлээ. Тэхэд Нед Ленд

-Би ч одоо тэднийг дүгнэчихээд л байна л даа. Эд бол ёстой үл бүтэх амьтад! гэж Нед Ленд илэрхийлэн хэлэв.

-За тийм байж, гэвч эд аль газрын улс бол? гэж Консель санаанд ч үгүй асуухад, Нед Ленд :

-Үл бүтэхчүүдийн орон! гэлээ.

-Нед, хонгор минь, тэр орон чинь дэлхийн газрын зураг дээр төдий л тод бус тэмдэглэгдсэн тул эдгээрийн үндэс угсааг тодорхойлоход тун хүнд болох нь ээ. харин эднийг англи, франц, герман улс биш гэж баттай хэлж болно. Миний бодлоор эдгээрийн толгойлогч ба түүнийг дагаж яваа хүн өргөргийн хоногудын доод хувиарт төрсөн болов уу гэмээр тэд гадаад байдлаараа өмнөт орны хүмүүстэй тун ойролцоо санагдана. Гэвч эдний арьсны ялгавар маш далд учраас шууд л Араб, Турк, Испани, Энэтхэг ямар хүн болохыг нь бардаагаар хэлэхийн арга алга. Бас эдний хэл нь надад бүр ч мэдэгдэхгүй байна.

-Хэл бүрийг мэдэхгүй байх нь ямар тусгүй вэ?

Хэрвээ олон улсын дундын ганц хэл байдагсан бол хичнээн сайн байсан билээ! хэмээн Консель өгүүлэв.

- Тэглээ ч гэсэн, ямар ч нэмэр болохгүй биз гэж Нед Ленд эрс татгалзан, манай гянданчид бид мэтийн өлсөж байгаа шударга улсыг цухалдуулахын тул зориут зохиож гаргасан тусгай хэлтэй байгааг та мэдээгүй байна гэж үү? Түүнчлэн амаангайлган шүдээ хавсарч, эрүүгээ хөдөлгөх гэдэг юу болохыг дэлхийн газар бүхэнд андахгүй. Квебек, Париж, Паумот, үгүй ер нь эл дэлхийн аль ч цэгт энэ дохио “Би өлсөж байна, идэх юм аль” гэсэн нэг л адил ойлгогдох дохио шүү дээ!

- Нн... гэвч юм ухаж өгдөггүй улс алийг тэр гэхэв дээ...гэж Консель ажигчгүй хариулав



Яг энэ үед өрөөний үүд нээгдэн онгоцны зарц орж ирлээ. Тэр бидэнд миний үл мэдэх эд бүсээр оёсон хувцас эдлэл авчирч өгөв.

Би даруйхан өмсөж эхэлмэгц миний нөхөд ч мөн намайг дууриан хувцаслаж гарав.

Энэ үеэр, хэлгүй мэт зарц, магад ч үгүй дүлий ч байж ширээн дээр гурван хүний хооллох хэрэгсэл өрж тавив.

- За энэ ч ёстой л мөн дөө. Энэ лав хэрэг бүтэмжтэйнх биз гэж Консель хэлэхэд, өшөөрхсөн Нед Ленд:

- Харж л байж мэдье. Энд ч юугаар цатгахыг нь мэдэж л байна! Нохой загасны элэг, алгана загасны гол мах, далайн хавны хар мах зэрэг л болов уу? гэхэд нь Консель:

- Удахгүй мэднээ гэв.

Мөнгөн тагтай дийзнүүд ширээн дээр цэгцтэй өрөгдсөн байв.

Төдөлгүй бид ширээнд суулаа. Бид нилээд боловсронгуй хүмүүсийн дунд байгаа нь зайлшгүй бөгөөд хэрэв л цахилгаан гэрэлтүүлэггүйсэн бол бид Ливерпулийн Адельфи Парижийн Гранд буудалд тохилог танхимд байна гэж бодож болох ажээ.

Жич, тусгайлан тэмдэглэхэд талх, дарс хоёрын аль нь ч үл үзэгдэнэ.

Ус нь маш цэвэр тунгалаг боловч ус усаараа л үлдэх тул үүнд Нед Ленд тоймгүй их гутарсан билээ.

Бидэнд өгсөн гүнцэг дотор би онц амттай бэлтгэсэн хэд хэдэн загас ялган тавив. Гэвч бусад төрлийн зоогийг би чухам амьтны буюу ургамлын аль ертөнцөд хамааруулахаа мэдсэнгүй тул юу ч хэлж чадсангүй ээ.

Хоолны хэрэгсэл ганган, гоё болохын зэрэгцээ халбага сэрээ, таваг алчуур зэрэг бүгд тус бүрдээ доорхи сийлбэр тэмдэгтэй ажээ.

Хөдөлгөөнт орчинд хөдөлгөөн юм гэсэн үг байлаа. Энэ яриа усан доогуур явагч онгоцонд яг тохирсон уриа ажээ. “Н” үсэг бодвол тэр хачин онгоцны капитаны нэрний түрүүний үсэг буйзаа.

Нед Ленд, Консель хоёр бодох сэтгэхийн үйлээр биеэ зовоосонгүй хомхойрон хооллож эхлэхэд би ч гэсэн тэднийг дууриаж шамдаж идлээ.

Одоо ч би өөрсдийн хувь зохиолд сэтгэл зовохоо болилоо. Биднийг тэд өлсгөлөнгөөр шаналгана гэдэгт би үнэмшихгүй байсан л даа.

Ер нь энэ ертөнц дээр юм бүхэн болж өнгөрөх жамтай учраас арван таван цаг өлссөн бидний өлсгөлөн ч бас л өнгөрөх ёстой бизээ. Идэж цадмагц бид яахын ч аргагүй нойрондоо дарагдан бүхнийг мартлаа. Энэ бол урт удаан шөнийн турш үхэлтэй тэмцсэний дараахи ядаргааны цорын ганцхан тэмдэг байв.

Үнэнийг хэлэхэд би дуртай нойрсохсон гэж Консель хэлэхэд:

Би ч гэсэн унтлаа гэж Нед Ленд хариулав. Миний хоёр дагалдагч шалан дээр дэвссэн сийрсэн дээр сунаж унаад эгшин зуур нам унтчихлаа.

Би тэдний адил амархан унтаж чадсангүй. Миний тархи толгойд дэндүү олон бодол хутгалдаж, үл тайлдсан дэндүү олон асуудал миний сэтгэлийг үймрүүлэн нүдний минь өмнүүр дэндүү олон дүр жирэлзэж байв.

Бид, чухам хаана байна аа? Ямар хачин тохиолдлоор биднийг энд авч ирэв ээ? Би хөлөг онгоцыг ёроолгүй гүн рүү живж байгааг мэдэрлээ, үгүй ээ, мэдрэх мэт боллоо.

Намайг хар дарж байлаа. Далайн тэрхүү нууц таавар болсон аймшигт гүнд уул хөлөгтэй юугаараа ч юм бүү мэд ойр төрөл түүн шиг аварга, түүн шиг хүчирхэг, түүн шиг хурдан миний үл мэдэх амьтан бужигнаж, жирэлзэж эрээлэн байв.

Гэвч тэгсхийгээд л тэдгээр дүр бүдгэрсээр бүдгэрсээр уураг тархи аяндаа манарч эхлэхэд би таг унтчихсан билээ.

[Тор](#)

---

## НЕД ЛЕНД УУРЛАЖ БАЙНА

Би хичнээн ч удаан унтсан юм бүү мэд, бодвол их л унтсан бололтой сэрэхэд минь тархи сэргэж, бие хөнгөрсөн байлаа.

Би бусдаасаа түрүүлж сэргээ. Нөхөд маань бөх гэгч нь нойрссоор байв.

Би өөрийнхөө төдий л зөөлөн бус хэвтрээс тархи минь амарч дахин саруул, нарийн ажиллагаатай болсныг мэдэрсээр босч ирмэгцээ, юуны урьд өөрсдийн өрөөг анхааралтай шинжин судалж эхэллээ.

Бидний унтах завсар энд юу ч өөрчлөгдсөнгүй шорон-шоронгоороо, хоригдол-хоригдлоороо байлаа. Ганцхан л зарц, хоолны үлдэгдлийг ширээн дээрээс цэвэрлэсэн байв. Бидний хувь заяа цаашдаа хэрхэн өөрчлөгдөхийг зөгнөсөн юм

огтхон ч үл мэдэгдэх тул би, энэхүү торхонд бид бүх насаараа арай түгжигдэхгүй байгаа хэмээн өөрөө өөртөө түгшүүрт асуулт тавьж байлаа.

Хэдийгээр миний тархи өчигдрийн хар дарсан олиггүй үзэгдлээс ангижирсан боловч энэ асуудал, түүгээр ч барахгүй маш гунигтай санагдаж, цээжинд ямар нэг юм зангирах мэт болон амьсгалахад хүнд байв. Бөгчим агаар жирийн ажиллагаанд саад болох ажээ.

Үнэндээ хүн зуун метр агаарт байгаа хүчилтөрөгчийг нэг цагт амьсгалдаг юм. Гэтэл амьсгалагдсан агаар нүүрсхүчлийн хийгээр баяжиж дахин амьсгалах хэрэгцээгүй болно.

Ийм учраас манай шоронгийн агаарыг магадгүй бүх онгоцны агаарыг ч шинжлэх хэрэгтэй байв.

Үүний тулд усан доорхи хөлгийн капитан яадаг бол? Хэрэв тэр химийн аргаар Бертолетийн давснаас хүчилтөрөгч гарган авдаг бол, уул давсыг нөөцлөхийн тул хуурай газартай үргэлж холбоо барьдаг байх ёстой биш үү. Аль эсхүл тэр тусгай том саванд хүчилтөрөгч нягтруулж аваад аль хэрэгцээтэй цагтаа зарцуулдаг болов уу? Ингэж ч байж болно. Эсхүл зөвхөн арвилан хэмнэхийн үүднээс хорин дөрвөн цагт нэг удаа усан дээр хөвж гараад шинэ агаар нөөцөлдөг болов уу?

Гэвч тэр эдгээр аргын алины нь ч гэсэн ашигладаг байсан, нэг аргы нь даруйхан хэрэглэх цаг болсон байх ёстой.

Би уушгиндаа шаардагдах хэмжээний агаарыг авахын тул аахилан амьсгаадаж эхэлтэл, гэнэт давс ханхалсан цэнгэг агаар бидний өрөө рүү сад тавилаа.

Би том ангайж амьдруулагч сайхан урсгалыг уушиг дүүрэн хомхой гэгч амьсгалав. Яг тэр минутад онгоц хүчтэй бус боловч мэдэгдэхүйц тэхдээ үл мэдэг далбилзлаа.

Усан доорхи хөлөг өнөө гайхал маань бодвол сэрүүн агаар амьсгалахаар халимын нэгэн адил, усан дээр хөвж гарсан бизээ...

Хөлөг онгоцны агаар сэлгэх арга ийнхүү яг таг нотлогдсон билээ.

Би цэвэр агаар ханатлаа амьсгалмагц агаар оруулж буй салхилах цонх буюу нүхийг эрсээр хаалган дээр байгаа сараалж төмөр олж харав. Тэхэд энэхүү сараалжаар цэвэр агаар дотогш нэвтэрдэг ажээ.

Би энэхүү ажиглалтуудыг хийж дөнгөж амжтал Нед Ленд, Консель хоёр бараг зэрэг сэрэв. Тэд нүдээ нухлан сунисаар босч ирэв.

- Эзэн амгалан нойрсов уу? гэж Консель ерөнхийдөө ёсорхуу байдлаар асуулаа.

- Гойд сайхан унтлаа, хонгор минь гэж би хариулахын далимд Нед та? гэж асуулаа.

- Үхсэн юм шиг унтчихжээ профессор гуай. Хүүш энэ чинь юу билээ? Далайн агаар үнэртэж байх шиг байх чинь гэж тэр үгүүлэв.

Би түүнийг унтаж байхад юу, болсон бүгдийг ярьж өглөө.

- Мөөн, мөн, мөн-хэмээн тэр дуугараад бид “Авраам Линкольн” дээрээс нарвалыг харж байхад л дуулдаад байсан мөөрөх мэт дуун энэ байж шүү гэж хэлэв.

- Таны зөв Нед энэ “амьсгалж” байжээ.

- Эрхэм профессор, одоо хэдэн цаг болж байгааг би нэг л мэдэхгүй байх чинь бид хоол идэх цаг болсон биш үү?

- Хооллох цаг ий? Та бодвол, өглөөний зуушлах цаг асуусан байлгүй дээ. Бид чинь бүтэн өдөр шөнө унтаад байна шүү дээ? Нед минь!

- Тантай маргах юм алга. Харин зарц хоол ч байсан, зууш ч байсан юу л авчирна, би түүнийг гар сарвайлган угтахсан байнам гэж Нед Ленд хариулав.

- Ялангуяа, зарц аль алины нь нэгмөсөн аваад ирвэл гээч! гэж Консель нэмэрлэв.

- Зүйтэй хэмээн канад хүн зөвшөөрөөд бид аль алины нь ч зооглох эрхтэйгээс гадна, би хувьдаа өглөөний зууш, өдрийн хоол хоёрт өөрийн зүгээс өчүүхэн боловч тус хүргэхээс татгалзахгүйсэн билээ гэв.

- За яахав, Нед минь, хүлээж л байя гэж хэлээд, эд, биднийг ямар ч л гэсэн өлсөөж алахгүй улс бололтой. Тийм л бол тэд өчигдөр бидэнд хоол авчирч өхгүй байсан шүү дээ гэлээ.

- Тэгвэл арай биднийг тээрч үхтэл тэжээх гэж байгаа юм биш биз? хэмээн Нед өгүүлэв.

- Нед та шударгыг хичээвэл болно! Та эрхбиш, махчнуудын гарт өөрсдийгөө орчихлоо гэж бодоогүй биз?

Нэг удаа эндүүрэх ч юу ч биш гэж Нед Ленд бүр үнэнээсээ хэлээд хэн, яаж мэдэх вэ, эд чинь шинэ шөл уугаагүй удсан ч байж магадгүй... Тэгвэл эрхэм профессор та, мөн Консель таны шударга зарц болон миний бие мэтийн гурван сайхан тарган данайсан амьтад...

- Боль та, Нед! хэмээн би жад шидэгчийн яриаг шууд таслан авч энэ бодлоо та орхи! Хамгийн гол нь манай эзэнд энэ үгээ бүү дуулга. Энэ чинь бидний байдлыг улам л хүндрүүлэхээс биш сайн болгохгүй гэлээ.

- Ер нь ямар ч л байсан би нохой шиг өлсгөлөн байна. Тэгтэл одоо хоол нь ч

зууш нь ч алга!.. гэж Нед Ленд өгүүлэв.

- Нед, хонгор минь, бид эндхийн дэглэмд захирагдах нь хууль шүү дээ. Миний бодоход бидний ходоод онгоцны тогоочийн цагаас хамаагүй түрүүлэн давхиад байх шиг байна.

- Яахав тэгвэл ходоодныхоо цагийн зүүг буцаагаад жаахан эргүүлчихгүй юу тэгээд л гүйцэх нь тэр хэмээн Консель маань тайвуухан хэлж суув.

-Мэдлээ таныг эрхэм Консель! гэж тэсвэргүй канад хүн хэлээд та дандаа л амгалан байгаарай! За мөн атаархам тайван зантай хүн юм даа! Та ч заргалдсан дорожноо турж үхсэн нь дээр гэх хүн байна даа!

-Заргалдахын хэрэг юу байхав? тэртээ тэргүй тус болохгүй.

Юу тус болохгүй гэж? Заргалдаж гэмээ нь л сая санаа амрахгүй юу? Хэрэв л энэ муусайн дээрэмчид гэж би зөвхөн л ноён профессор эднийг махчин гэж нэрлүүлэхгүй байгаагаас профессорыг хүндэтгэсэндээ тэгж байгаа юм, хэрэв энэ муусайн дээрэмчид намайг өөрсөддөө хэдэн сайхан маань уншиж өгөхгүй, үг дуугүй л энэ муу нүхэнд нь бүтэж үхэх гээд л зүгээр сууж байна гэж бодож байгаа бол дэндүү эндүүрэл болно! Ноён профессор та аан гэж бай, энд биднийг энэ сараалжиндаа ер нь аль хэр удаан хадгална гэж та бодож байна, та шууд л хэлээрэй.

-Шууд л хэлэхэд Нед минь, энэ туай хичнээн л мэдэж байгаа бол би төчнөөн л мэдэж байнаа.

-Тэгээд та ер нь юу гэж бодож байна?

-Миний бодлоор бол бид, онц их нууц юм санамсаргүй мэдчихлээ.

Хэрэв усан доогуур явагч онгоцны баг энэ нууцыг чанд хадгалахыг эрхэмд үзэж, энэ сонирхол нь гурван хүний амь наснаас ч илүү үнэтэй бол бидэнд тун их аюул заналхийлж байна. Хэрэв тийм биш бол биднийг залгисан гайхал анхны бололцоо тохиолдмогц л биднийг, бидний нэгэн адил хүмүүс амьдардаг ертөнцөд буцааж тавих болно.

-Эсхүл биднийг онгоцны багт багтаан авч үлдээнэ...гэж Конселийг нэмэрлэн хэлэхэд :

-Гэж бодвол хэмээн Нед Ленд, түүний яриаг залгуулан авч “Авраам Линкольн”-ноос арай бүтэлтэй хурдан гүйдэлтэй өөр нэгэн хөлөг онгоц энэхүү дээрэмчдийн үүргийг барьж аваад, түүний бичгийг, бидний хамт хамгийн өндөр шургийнхаа орой дээрээс дүүжилчих болно! гэж яриаг дуусгав.

-Зүйтэй санал, Нед гэвч миний мэдэж байгаагаар бол одоо хүртэл энэ хөлгийн багт элсэхийг хэн ч гэсэн бидэнд хэлээгүй шүү дээ. Ийм учраас тэр тухайд хэрхэх

яахаа, одоо ярихыг больё, давтан сануулахад хөдлөх цаг болоход цагийн байдлыг харгалзан хөдлөх тэр болтол ганцхан тэсвэрлэх л хэрэгтэй. Одоохондоо бид яасны ч хэрэггүй, тэртээ тэргүй бидэнд хийх юм ч байх биш дээ гэлээ.

-Үгүй ээ хэмээн бууж өхийг үл хүссэн зөрүүд хүн ямар нэг юм хийх л хэрэгтэй гэв.

-Юу хийх гэж Нед?

-Оргоно!

-Газар дээрх гяндангаас оргох гэдэг чинь маш их хүнд хэрэг, тэгвэл усан доорох гяндангаас оргоно гэвэл бүр ч бүтэшгүй хэрэг хэмээн би хэлэв.

-За Нед, найз минь гээд Консель эзний хэлсний хариуд та юу гэсээр байна? Америкчууд үг эрж гүйдэггүй бэлэн үгтэй улс байдаг гэдгийг би мэднэ л дээ гэв.

Жад шидэгч, сандрахдаа дуу гарсангүй. Үнэндээ ч бидний байдлаар бол оргох гэдэг дэмий хэрэг байв. Гэвч канадын хаъяат нь хагас франц хүн билээ. Түүнийгээ ч Нед Ленд нотолж, зохистой хариулт өгсөн юм.

-Эрхэм профессор та, үмүүс ер нь шоронгоос оргох аргагүй бол чухам яадгийг нь мэдэх үү? хэмээн тэр хэдэн минут бодолхийлсний дараа хэлэв.

-Үгүй ээ, хонгор минь.

-Хийж ядаад байх юм байхгүй! Тэгвэл тэд шорондоо тааламжтай суухын тул аль болохоор төвхнөцгөөдөг юм.

-Яриад яахав! Уёан доорх шоронгийн дор нь буюу дээр нь байхаар, дотор нь байсан дээр гээч гэж Консель хэллээ.

-Гэвч ахмгийн урьдаар тэндээс хуяг хаалгач, харгалзагч нарыг нь авч хаях хэрэгтэй гэж Нед Ленд хэлэв.

-Яалаа гэнээ, Нед? Энэ онгоцыг гартаа авна гэж та нээрээн үнэнээсээ бодож байна уу?

-Яах аргагүй үнэнээсээ гэж Нед хариулав.

-Энэ ч болшгүй хэрэг.

-Яагаад профессор? Хэрэв л аятай нөхцөл тохиолдвол энэ болно. тэр нөхцлийг ашиглахгүй байхын учир юу билээ. Миний бодоход онгоцон дээр хориос илүүгүй хүн байгаа биз. Энэ хэдхэн тооны хүн хоёр франц, нэг канад хүнийг ч айлгаж чадахгүй ээ!

Жад шидэгчтэй маргахын оронд түүний үгийг дуугүй өнгөрөөхөөс сайхан юм үгүй ажээ. Тийм учраас би :

-Бид зохистой нөхцөлийг харж байх болно. Нед минь! Харин тэг болтол тэсэж

үзэхийг л танаас гуйж байна. Ийм төлөвлөгөөг зөвхөн залиар л шийдвэрлэх нь юу юм гэхээс биш таны цочмог уур тийм нөхцөлийг наашлуулахаас цаашлуулах нь халаг биз, тэр минутыг тачвядах юмгүй, тэсвэртэй хүлээхийг надад та амлах хэрэгтэй хэмээн хэлснээр энэ явдлыг дуусгавар болгоход :

-Би танд амлая, ноён профессор гэж Нед Ленд төдий л бардам бус царайлан бидний хоолыг цагт нь, нягт нямбай зөөхгүй байлаа ч гэсэн та үүнээс хойш миний амнаас нэг ч бүдүүлэг үг гарахыг сонсохгүй, миний гар нэг ч удаа ширүүн загнахыг үзэхгүй гэлээ.

-Амласнаа л бүү мартаарай, Нед гэж би канад хүнд анхааруулж билээ. Үүгээрээ яриа дуусвао болж, бид тус бүрдээ бодлогшрон гиюүрэв. Би Нед Лендийн итгүүлэхийг оролдсон бүх оролдлогыг харгалзахгүйгээр ямар нэгэн итгэл найдвараар сэтгэлээ хуурахыг бодсонгүйгээ шударга хүлээх ёстой. Нед Лендийн хэлж агсан завшаантай тохиолдолд би үл итгэж билээ. Усан доогуур явагч онгоцны баг маш олуул гэдэг нь эргэлзээгүй хэрэг бөгөөд тийм учраас тэдэнтэй тэмцэх хэрэг гарвал бид маш хүчирхэг давсантай мөргөлдөх байв.

Гэтэл бас Нед Лендийн төлөвлөгөөг биелүүлэхийн тул юуны өмнө бидэнд эрх чөлөө хэрэгтэй байсан бол бид олзлогдогсод байлаа. Бид энэхүү бин битүү төмөр савнаас хэрхэн яаж мултрахыг л мэдэхгүй байв. Гэтэл энэ усан доогуур явагч хачин хөлгийн хачин капитан ямар нэгэн нууцыг хадгалж буй нь харсаар байтал мэдээжийн хэрг тул биднийг хөлөг онгоцон дотуураа зоргоор маань явуулахгүй нь бас л илхэн байлаа.

Ер нь тэр бидэнтэй цаашдаа яахыг нь урьдчилан хэлэхийн аргагүй бөгөөл тэр эсхүл биднээс бушуухан салахын түүс болж биднийг үгүй хийнэ, аль эсвэл биднийг олон жил хорьж байгаад эцэст нь ямар нэг хүнгүй арал дээр цөлчих бол уу, бид түүний эрхэнд тэр чигээрээ орсон тул миний дээрх сэтгэмжүүд бараг үнэний хувьтай буйзаа. Бид хэрэв иймэрхүү нөхцөлд орох бол эрх чөлөөг балдан олохын тул Нед Ленд мэт баатарлаг зоригтой байх хэрэгтэй билээ. Би Нед Лендийн хоолойд хараал тээглэж гар зангах нь улам л сүртэй болж байгааг ажлаа. Тэр сараалжин дотор буй зэрлэг араатан шиг нааш цаашаа харайлж хөл гараараа хана балбаж байв.

Тэхэд, цаг явсаар л бөгөөд гэдэс хэдий өлсөх боловч зарц ирэх нь харагдахгүй л байлаа. Ийнхүү живж үхэхийн аюулд нэрвэгсдийн зүг анхаарал үл тавих нь сайныг зөгнөсөнгүй ээ.

Нед Ленд өлсөхийн эрхэнд улам бүр догширно. Тэр уураа барихыг хэдий амалсан боловч онгоцны багийнхнаас хэн нэгнийг ирэхэд

тэсвэр алдаж аюултай юм болох бий хэмээн би санаа зовж байв.

Дараагийн хоёр цагт Нед Лендийн хилэн бүр ч дэврэв. Канад хүн хэдий хашгирах, гуугалах боловч хана туурга дүлий мэт ажээ. Би энэхүү хөлгийн дотор өчүүхэн ч гэсэн дуу чимээ сонссонгүй нь энэ онгоц амьгүй мэт санагдаж байлаа. Тэр зогсож байснаас гарцаагүй. Хэрэв л явж агсан бол сэнснийиэргэлтэнд хөлөг онгоц доргих байдал мэдэгдэхсэн бизээ. Усны ёроолгүй гүнд живж орсон тэр газар дэлхийд дахин үл хамарагдаж билээ. Энэхүү авс мэт юман дотор чив чимээгүй байдал маш зэвүүн ажээ.

Энэ төмөр саванд бид хичнээн хоригдох гэж би бодохоосоо л айж билээ. Урьд над төрсөн найдвар онгоцны капитантнй учирснаас хойш улам бүр мохож ирлээ. Түүний элэгсэг харц, нүдэнд дулаан царай, шударга байдал нь миний санаанаас бүрэн арилав. Энэ нэг этгээд амьтан хүнийг өрөвдөх сэтгэлгүй хэрцгий хүн хэмээн бодвол яг онож байгаа буйзаа. Би түүнийг хүн төрөлхтнийг үүрд үзэн ядаж, тэдгээрийн эвлэршгүй дайсан болсон ингүүлсэн үзэхийн сайхан сэтгэл хэзээ ч үл төрөх хүний ёсноос гадуур амьтан гэж дотроо бодож билээ.

Үгүй ээ, нээрэн энэ хүн биднийг өлсгөлөнгийн гашуун зовлонгоор шаналган, энэхүү хавчиг шоронгийнхоомухарт гууриатуулж үхүлэх гэж үү? Энэ аймшигт бдол миний ой ухааныг бүрэн эзэлжээ. Намайг аюулын хар сүүдэр нөмөрлөө.

Энэ үед Консель урьдын адил амгалан ахуйд, Нед Ленд бүр ч галзуурч байв.

Яг энэ үед хананы цаан чимээ гарав. Төмөр шалан дээр хөлийн чимээ сонсдож цурга хоржигнон хаалга нээгдмэгц зарц орж ирлээ.

Намайг яах ийхийн зуургүй Нед Ленд үйлийн үртийг шалан дээр унагаад багалзуурдаж авав. Хөөрхий муу зарц түүний булиа гарт амь тэмцэн байлаа.

Консель тэр мууг, түүний гараас мултлахыг хичээж, би ч гэсэн туслахаар ухасхийтэл :

Нед та тайвширч үз! Та ч гэсэн мөн адил эрхэм профессор! Миний үгийг дуулцгаа! хэмээн францаар хэлсэн хэн нэгний үг биднийг зог тусгав.

[Тор](#)



## ЁРООЛГҮЙ ГҮН ДАЛАЙН ХҮН

Энэ бол хөлөг онгоцны капитан байв.

Нед Ленд эгшин зуур босон харайхад, хөөрхий муу зарц эзнийхээ дохиогоор голтой голгүй юм өрөөнөөс гуйвсаар гарч одлоо. Канадын харьяатын өдүүлсэн хэргийн хариуд үзэн ядахын хорслоор буцалбал буцлах тэр хүн, гарын ганц ч хөдөлгөөнөөр ямар нэгэн хилэгнэлийн тэмдэг үзүүлсэнгүй нь капитаны эрх мэдэл хэр хичнээн болохыг илтгэсэн билээ. Консель бид хоёр энэхүү будлианы төгсгөлийг мэл гайхан хүлээж ахуйд капитан хоёр гараа цээжиндээ зөрүүлэн, биднийг маш анхааралтай ширтэж зогсов. Эсхүл тэр яриа үүсгэхийг төвдсөн болов уу? Аль эсхүл Францаар үг дуугарсандаа харамсаа юу? Энэ ч магад үнэн тал нь буйзаа. Бидний дундаас хэн ч эвдэхийг зүрхлээгүй хэдэн секундын нам гүм байдал шувтарч:

- Эрхмүүд ээ хэмээн капитан сая ам нээж, би франц, англи, немц, латин аль ч хэлээр чөлөөтэй ярьдаг юм. Ингэхээр би та нартай түрүүчийн уулзалтандаа ч ярьж болох байсан гэвч би та нарыг ажиж сайн бодож тунгаахыг чухалчилсан юм. Тэхэд та нар тус тусдаа, янз янзын хэлээр өөрсдийнхөө тухай нэг л адил зүйл ярьсан болохоор чухам л хэн болохоо надад дүүрэн итгүүлж чадсан. Иймээс би ер бусын тохиолдлоор эрдэм шинжилгээний ажилд хилийн цаана явсан байгалийн судлалын тухай түүх, парижийн музейн профессор ноён Пьер Аронакс болон түүний зарц Консель тэрчлэн Америкийн холбооны нэгдсэн улсын тэнгисийн цэргийн хөлгүүдийн бүрэлдэхүүнд багтах нь “Авраам Линкольн” онгоцны жадчин Нед Ленд нартай учирсан болохоо сая мэдлээ гэж хэлэв.

Би зөвшөөрсний тэмдэг болгон мэхийн ёслов. Капитан надаас юм асуусангүй болохоор би хариу хэлэхийн шаардлагагүй буйзаа.

Энэ хүн францаар ямар ч өөгүй маш зөв ярьж байв. Түүний яриа тун цэвэрхэн, үг нь яахын аргагүй яг таг ажээ. Гэлээ ч гэсэн түүнийг би яриагаар нь нэг нутгийн хүн гэж хэлэхгүй билээ.

Тэр яриагаа үргэлжлүүлэн:

- Миний бие хоёрдахь удаагийнхаа уулзалтыг нилээд удаашруулсан болохыг эрхэм ноёд сайн мэдэж байгаа бизээ. Гэвч би, та нарыг хэн болохыг мэдмэгц, эрх биш цаашид хэрхэн яавал зохихыгоо бодож боловсруулах хэрэгтэй байсан. Би нилээд их эргэлзлээ. Та бүхнийг тун харамсалтай үйл лай хүн төрөлхтөнөөс хөндийрөн тасарсан над мэтийн хүнтэй золгуулсан ажээ. Та нар миний аглаг буйд

амгалан байдлыг эвдлээ...

- Өөрийн эрхгүй хэмээн би хэллээ.

- Өөрийн эрхгүй ий? гэж үл танигч хүний дуу өндөрсөж тэгвэл “Авраам Линкольн” миний хойноос бүх далайгаар өөрийн эрхгүй мөрдөж явсан уу? Түүнчлэн та нарт:

Энэхүү онгоцон дээр өөрийн эрхгүй аялан жуулчлах санал төрсөн үү? Бас танай галт бөмбөг миний хөлгийн хуяг дээр өөрийн эрхгүй унасан уу? Тэрчлэн эрхэм Нед Ленд над уруу жад өөрийн эрхгүй шидсэн үү? Хэмээв.

Түүний энэхүү үгэнд би арай ядан барьж байгаа хилгэнэлийг нь олж танилаа.

Гэвч эдгээр зэмлэлд өх зүй ёсны хариу надад бэлэн байв.

- Эрхэм ээ бодвол та Америк, Европ хоёр тивд өөрийн дэгдээсэн их маргааныг өөрөө мэдэхгүй байгаа биз. Түүнчлэн таны хөлөгтэй мөргөлдсөн хэд хэдэн хөлөг онгоцны сүйрлийн улмаас бүтэн хоёр тивийн олон нийтийн санаа сэтгэлийг үймрүүлсэн хэсэг явдлыг та бас мэдэхгүй уул нууцыг тайлах түлхүүр нь ганцхан танд байгаа тэрхүү тааврыг тайлбарлахыг оролдсон тоо томшгүй олон таамаглалыг танд би тоочихыг больё. “Авраам Линкольн” Номхон далайн хамгийн зах хязгаар хүртэл таныг мөрдөн, хөөхдөө далайн ямар нэгэн хүчирхэг гайхал амьтныг мөрдөж байгаа хэмээн бат итгэж явсан болон түүнээс ямар боловч үнээр, тэнгис далайг цэвэрлэх ёстой гэж эрс шийдэж явсан болохыг та бас мэдэх хэрэгтэй гэж би хэлэв.

Капитаны царайд инээдээ барьж ядсан ямар нэгэн үл мэдэг тэмдэг тодров.

Гэвч тэр урьд урьдаас амгалан царайгаар:

- Ноён Аронакс та, тэр онгоц усан доогуур явагч хөлгийг далайн тэр л гайхал шигээ хөөж буудахгүйсэн гэж батлахыг зүрхлэх үү? гэж асуув.

Капитан Фарагут ямар ч л байсан гуйвах юмгүй хөөж буудах хүн тул энэхүү асуулт намайг тэвдүүлж билээ.

Тэр, усан доогуур явагч хөлгийг аварга нарвалын нэгэн адил устгахыг өөрийн үүрэг хэмээн үзэх агсан бизээ. Иймээс би юу ч хариулсангүй ээ.

Капитан цааш нь үргэлжлүүлэн:

- Ингэхээр би та нарыг дайснаа гэж үзэх бүрэн эрхтэй биз?

Би дахин дуугарсангүй, гэвч энэ удаа тэхээс тэх гэж хариу хэлсэнгүй ээ. Таны хамгийн ноттой баталгаа хүчинд автагдах ийм үед иймэрхүү асуудлыг маргахын хэрэггүй билээ.

- Та нарыг хэмээн капитан үргэлжлүүлэн, найрсаг зочломтгой хүлээн авахад намайг юу ч албадаагүй тул би нилээд удаан эргэлзсэн юм. Хэрэв л би та нараас

хагацахын түүс болсон бол би энд дахин эргэж ирэхийн явдалгүй байсан.

Та нарыг би онгоцныхоо орой дээр гаргаж хаячаад л доошоо шумбаж, хэзээ нэгэн цагт амьд байсныг тань таг мартчихсан бол болох л байсан. Тэх эрх надад байгаагүй гэж үү?гэхэд нь

- Энэ ч боловсон хүний ёс бус, зэрлэг хүний л дүр байх байсан даа гэж би хариулав.

- Эрхэм профессор та “боловсон хүний ёс” гэж юуг хэлж байна? Би хүн нийгэмтэй, зөвхөн л би өөрөө зөвтгөх буруутгах эрхтэй, ганцхан л шалтгаанаар түнш тасарсан хүн шүү дээ. Би тэр нийгмийн чинь хуулийг хэрхэвч дагахгүй, тиймээс та миний дэргэд үүнээс хойш түүнийхээ тухай хэзээ ч үл дурсахыг танд сануулья хэмээн эрс эсэргүүцэж билээ.

Үүнийгээ онц ширүүн хэлсэн юм. Үл танигчийн нүд уур хилэн, хорсол жигшлээр бадарч байв. Энэ хүний өнгөрсөн үе ямар нэгэн аймшигт нууцыг хадгалсан бол уу гэсэн бодол миний толгойд зурс хийлээ. Тэр өөрийн биеийг хүн нийгмийн хууль ёсноос дээр тавьж, хүн үл хүрэх орчинд шингэж орсон нь дэмий хэрэг биш буйзаа.

Өөртэйгээ тэмцэлдэх өчүүхэн оролдлогыг усан дээр тийнхүү хялбархан няцааж байгаа юм чинь түүнийг далайн гүнд мөрдөхийг хэн зүрхлэх билээ дээ? усан доогуур явагч моторт завьтай өрсөлдөх ямар хөлөг байна аа? Түүний хөлгийн аймшигт зэвсгийн хурц үзүүрийг ямар бөх ган хуяг ч хариулж чадахгүй.

Далайн энэхүү эзнийг дэлхий дээр хэн ч гэсэн ямар ч хариуцлагад татан зэмлэх сачийгүй буйзаа.

Энэ бүх бодол миний толгойд эгшин зуур жирсхийн өнгөрөөд тэр хачин хүн өөрийн бодолд мөн л автагдан өрөөн дотуур алхалж байв.

Би түүнийг айх гайхах зэрэгцэн ажиглаж билээ.

Капитан нилээд удаан дуугүй байсны дараа :

-Ийнхүү миний бие эргэлзэж байсан хэдий боловч гээд үргэлжлүүж, хүн төрөлхтөн гэдэг хэзээд эдэлбэл зохих эрхийн дагуу холбогдох зүй ёсны нигүүлслэлтэй. Би өөрийн сонирхлыг амтатгасанд миний эцсийн шийдвэр оршижболно. Одоо яая гэхэв, нэгэнтээ л та нар миний онгоцон дээр хаягдсанаас хойш эндээ л байхаас биш. Энд та бүхэн өүгд эрх чөлөөтэй байх болно. Гэвч би та нарт нилээд хүлцэнгүй ганцхан болзол тавьж гэмээнэ эрх чөлөөг тань хангаж болно. Тэрхүү болзлыг дагана гэсэн та бүхний амлалт л над хэрэгтэй.

-Хэл л дээ капитан, миний бодоход таны болзол шударга хүн хүлээж авч болохуйц бизээ гэж найдаж банья хэмээн би хэллээ.

-Яриад яахав! Энэ л байна. Миний бие санаандгүй ямар нэгэн явдлаас та нарыг хэзээ ч магадгүй, хэд хэдэн цагаар, түүгээр ч барахгүй хэд хэдэн хоногоор хорьж хадгалахад хүрч болзошгүй. Тийм болохоор иймэрхүү үед ямар нэгэн хүч түрэмгийлэх явдалд хүрэхгүйн тулд миний бие та нараас уул болзлыг зайлшгүй дагана гэсэн амлалты тань авах хэрэгтэй байна. Үүнийг та бүхний таалалд толилуулж байгаа явдал бол та нарыг саваагүй юманд саатганаж явж санамсаргүй хэрэт орох вий хэмээн сэргийлж байгаа юм шүү. Тэгвэл энэхүү миний болзлыг хүлээн авах уу?

Үүнээс авч үзвэл энэхүү хөлөг онгоцон дээр хүн төрөлхтөний хууль дэглэмтэй хундага хагараагүй хүн мэдэж болохгүйн нууц явдал болдог ажээ? Алс нь намайг отож байсан гэнэтийн явдлууд дотроос, бодвол энэ явдал магадгүй хамгийн аягүй нь ч байж байсан,

-Бид хүлээн авъя аа, харин...капитан ганцхан юм асуухыг зөвшөөрнө үү? гэлээ би,

-Асуу л даа.

-Биднийг өөрийн хөлгөн дээр таавараа бай гэв үү?

-Тийм ээ. Бүрэн чөлөөтэй байх болно.

-Энэ чинь юу гэсэн үг вэ, та ойлгуулж өгнө үү?

-Та нар бүх хөлөг онгоцон дотуур эрх дураараа сэлгүүцэж энд юу болж байгааг зөвхөн ганц нэгээс бусды нь бүгдийг үзэж харж болно. Нэг үгээр хэлэхэд миний өөрийн болон миний хүмүүсийн нэгэн адил эрх эдлэх болно.

Бид харилцан бие биенээ ойлголцсонгүй нь мэдээжийн хэрэг билээ.

-Уучлаарай капитан, энэ эрх чөлөө тань зөвхөн өөрийн хоригдсон өрөөн дотуураа л өөдөө сөөргөө холхих, ялтан хүний эрх чөлөө байна шүү дээ. Бид, үүний тань эдэлж чадашгүй нь ээ гэж би хэллээ.

-Тэглээ ч гэсэн эдлэх л болно доо.

-Үгүй ээ, энэ чинь бид эх орондоо, эхнэр хүүхдэдээ, нөхдөдөө эргэж үүрд очихгүй гэсэн үг үү?

Тийм ээ, хүн нийгмийн хууль дэглэм гэж хүмүүс өрсдөө нэрлээд түүнийгээ эрх чөлөө эдлэж байна хэмээн таг сохроор дагадаг тэрхүү жигшүүрт мөлжлөгөөс салах явдал таны бодож байгаагаас тийм ч зүдгүүртэй биш байхаа.

-Миний хувьд бол ч гээд Нед Ленд би эндээс оргох оролдлого хийхгүй гээ хэзээ ч амлахгүй гэж хэллээ.

-Битгий оргоорой гэж би гуйгаагүй шүү, Недээ! хэмээн капитан хүйтэн царайлж

хариулав.

-Капитан та дэндүү хэтэрч байгаа юм биш биз. Энэ чинь тун хэрцгий хэрэг гэж би биеэ барьж чадсангүй хашгирав.

-Үгүй ээ, эрхмүүд ээ. Энэ бол тун нигүүлсэнгүй сэтгэл! Та нар тулалдааны дараа надад олзлогдсон үлс. Би та нарыг хэдийгээр далайд шидчихэж чадах боловч та нарт амьдарл заяаж байна. Та нар над руу довтолсон биз! Та нар нэг ч хү ннэвтэрч үл болох миний а жамьдралын нууцад нэвтэрсэн. Тэгвэл миний тухай хэн ч эс сэдэвлэвэл зохих байсаар байтал та нарыг би зүгээр тавьчихна гэж санаж байна уу? Хэрхэвч үгүй! Та нарыг усан доогуур явагч өөрийн хөлөг онгоцон дээр байлгах өөрийн сонирхлыг голчлохоос биш та нарынхыг голчлохгүй шүү дээ!

Капитаны дуу улам бүр аягүй шиоүүсч ирсэн болохоор би түүнийг ахин итгүүлэх арга эрэлхийлсэнгүй.

-Тэгвэл капитан та биднийг үхэл, олз хоёрын нэгийг сонго гэж байгаа юм шив дээ?

-Яг тийм.

-За найз минь хэмээн би Консель, Нед Ленд хоёрт хандан, хэрэг нэгэнт ийм болохоор ярихын ч хэрэг алга. Гэвч энэ капитанд би юу ч гэж ам алдаагүй гэдгийг санах хэрэгтэй гэж хэлэв.

-За тэгвэл сайн байна, би нэг хэдэн юм хэлье. Ноён Аронакс би таныг мэднээ. Би танай нөхдийг ч мэдэхгүй байна, харин таныг надтай уулзуулсан энэ завшааныг та эрхбиш харамсахгүй биз. Миний хэрэглэдэг ном судрууд дотор та далайн нууцын тухай өөрийнхөө бүтээлийг ч олж үзэх болно. Би түүнийг үргэлж дахин дахин уншдаг юм.

Та өөрийнхөө тэр номд хуурай газрын шинжлэх ухаан л зөвхөн хүрч чадах хязгаарт хүрсэн юм байна. гэвч таны үзсэн бага болохоор тэр бүхнийг мэдэхгүй. Ингэхлээр энэ онгоцо ндээр өнгөрүүлсэн цагаа та харамсаж амаа барихгүй байх гэдгийг миний зүгээс баттай хэлэхийг зөвшөөрнө биз.

Та ид шидийн оронд жуулчлах болно. Гайхах, сонирхох, хөхөх, баярлах тэр бүхэн таны оюун ухааны ердийн илрэл болох биз таны нүдний өмнө тасралтгүй яралзан байх гайхамшгаас та төдий л амархан уйдаагүй байхаа. Би урьд өмнө хийсэн аяллуудынхаа дүгнэлтийг хийхийн тулд дэлхийг тойрох хамгийн эцсийн ч байж магадгүй аяллыг хийхээр шийдсэн юм. Энэ ажилд та туслалцаж болно. Өнөөдрөөс эхлэн та тэс өөр ертөнцөд орно гэж мэдэх хэрэгтэй. Та намайг болон миний хүмүүсийг тооцохгүйгээр урьд өмнө манай ертөнц сүүлчийнхээ нууцыг задлан

дэлгэх болно! гэж ярьж билээ.

Капитаны энэ яриа над маш их сэтгэгдэл төрүүлсэн гэдгийг би хүлээхгүй байж болшгүй ээ. Тэр миний сэтгэлийн хамгийн эмзэг судсыг хөндсөн тул эдгээр гайхамшиг зүйлсийг дүрслэн бодсон миний бясалгал алдагдсан эрх чөлөөг минь орлож чадахгүй гэдгийг би хэсэг зуур мартжээ.

Гэвч би эрх чөлөөний тухай энэ чухал асуудалд сүүлд дахин эргэж болно гэж үзэж байсан тул :

-Капитан та хэдий хүн төрөлхтөнтэй эв муудсан боловч хүн ёсны сэтгэхүйгээс холдож хөндийрээгүй санжээ. Бид бол далайд сүйдсэн улс, та биднийг өөрийнхөө онгоцон дээр энэрэнгүй сэтгэлээр хүлээн авлаа. Үүний тань миний биен миний нөхөд хэзээ ч мартажгүй, харин шинжлэх ухаанд хүчин зүтгэх энэ бололцоо алдагдсан эрх чөлөөний минь хариуд хэр хэмжээндээ тохирсон шагнал болно гэдгийг би өөрийн хувьд хүлцэнгүй хүлээх байнам гэсэн хариу өгч өөрийн үгийг би хязгаарласан билээ.

Бидний энэ хэлэлцээрийг батжуулахын тул капитан миний зүг гар сунгах байх хэмээн би бодож байсан авч тэр тэгсэнгүй учраас би гол зүрхнээсээ гомдож билээ.

-Бас нэг асуулт байна хэмээн би хачин хүнийг гарахын даваан дээр асуулаа.

-За юу байна, эрхэм профессор?

-Таныг бид хэн гэж нэрлэх ёстой байнам?

-Та нарт би зөвхөн капитан Немо бас таны бие болоод таны дагалдагчид бол надад зөвхөн “Наутилус” онгоцны дээр зорчигчид гэлээ.

Капитан Немо ямар нэг юм хашгирмагц зарц орж ирлээ. Капитан түүнд үл ойлгогдох өнөө л хэлээрээ тушаал өгөөд Консель бас канад хүн хоёрт хандаж :

-Та нар өөрсдийнхөө өрөөнд өглөөнийхөө зууш хүртэх болно. Энэ хүнийг дагаад яв даа гэв.

-Үгүй л гэхгүй хэмээн жадач маань хэллээ.

-Ийнхүү бидний гуч шахам цаг хоригдсон өрөөнөөс Консель тэр хоёр гарч одлоо.

-Харин одоо профессор минь бидний ээлж өглөөний зууш биднийг л хүлээж байгаа. Танд газарчлахыг зөвшөөрнө үү ? гэлээ.

-Таны л мэдэлд байна, капитан гээд би капитан Немо дагалдав. Бид цахигаанаар гэрэлтүүлсэн ердийн гудамж өрөө мэт нарийхан чөлөөнд гарч арваад метр яваад хаалганд тулж очлоо.

Капитан хаалгыг нээгээд над зам тавин дотогш оруулахад би маш тохилог тавлаг суудалтай зооглох өрөөнд орсон билээ. Өрөөний хаалганы эсрэг талд хар зандангаар бүрсэн өндөр тавиур харагдлаа. Түүний дэвсэнгүүд дээр маш их үнэтэй уран нарийн хийц бүхий шаазан ба мөнгөн болор сав суулга солонгорон гялалзаж байв. Өнгө ялгаж тун нямбай будсан хананы будаг адраас буух гялбам хурц гэрлийг зөөлрүүлэх ажээ.

Тасалгааны голд идээ зассан ширээ байна.

Капитан Немл миний суух байрыг гараар дохиж заагаад :

-Суу та хоол зоогло. Та бодвол их өлсөж байгаа биз гэлээ.

Би ч өөрийгөө дахин шаардуулсангүй.

Энэ өглөөний зуушин дээр хэд хэдэн төрлийн загас, миний л үл мэдэх юмаар хийсэн ямар ч юм бэ дээ, амттаны зүйлс өглөө.

Энэ бүхэн нилээд аятайхан санагдавч нэгл хачин амттай байсан, гэвч түүнд амархан дасч болох байв. Миний л бодсоноор бол эдгээр хүнсний зүйлс фосфор ихтэй байсан тул тэднийг тэнгис далайгаас авснаас зайлсангүй ээ.

Капитан Немо надаас нүд салгахгүй байв. Би түүнээс юу ч асуусангүй, гэтэл тэр миний хэл ам татлан байгаа түмэн асуудалд хариулахыг яаравчлан байлаа.

Энэ зоогуудын ихэнхийг та мээхгүй биз, гэлээ ч гэсэн та айх юмгүй ид. Эд бүгдээрээ тэжээлтэй амт шимттэй зүйлс.

Би өөрөө аль эрт хуурай газрын хоол хүнснээс эрс татгалзчихсан хүн. Гэлээ ч гэсэн үүнийг харгалзахгүйгээр би эрүүл мэнд л байна. Түүгээр ч барахгүй яг над шиг л хооллодог манай багийнхан бүгд л атаархам чийрэг эрүүл мэнд улс гээч гэж ярив.

-Тэгвэл энэ амттан бүхэн далайнх болх нь ээ?

-Тиймээ профессор минь. Далай миний бүх л хэрэгцээг хангадаг юм.

Заримдаа би далайд тор хаядаг. Тэхэд миний тор хоосон байсан удаа байгаагүй шүү. Бас заримдаа хүн хүч хүрч үл чадах орчлонд ан гөрөө хийж усан доорхи өөрийн ой шугуйд оршдог ан амьтантай хөөцөлддөг хүн дээ. Миний сүргүүд өвгөн малчин Нейптуны мал сүрэг мэт өргөн дэлгэр тэнгис далайнхаа уудам талд эрх дураараа билчдэг юм. Миний эзэмшил эцэс хязгааргүй уудам, түүнийг би л ганцаараа өвлөдөг.

Би капитан Немо руу гайхан ширтэж :

-Би ойлгож байна, капитан минь таны тор таны тавганд амттай загас авчирдаг юм байна. Харин таны усан доорх өөрийн ой шугуйд ан гөрөө хийдэг гэдгийг чинь ойлгохгүй байна. Та хэдий хичнээн ч бага хэрэглэлээ гэсэн таны ширээн дээр мах хаанаас бий болж байна. Үүний чинь л ойлгохгүй байна гэлээ.

Би хуурай газрын амьтны мах хэзээ ч иддэгүй шүү хэмээн капитан татгалзлаа.

-Тэгвэл энэ юу вэ гэж би таваг дээр байсан хэсэг гол мах руу хуруугараа заав.

-Хуурай газрын амьтны мах гэж эндүүрсэн энэ зоог бол далайн яст

мэлхийний гол мах байгаагаас биш өөр юуных ч биш. Энэ нэг сүмс: үүнийг далайн гахайн элгээр хийсэн юм. Танд бол амтаараа тэжээвэр гахайн рагутай адилхан санагдах байх. Миний тогооч их мэргэжилтэй хүн тул далайн загас ба амьтдаар хоол хүнс хийхдээ хэнийг ч дагуулахгүй. Энэ бол хясаагаар хийсэн консерв, үүнийг ямар ч малай угсаатан ертөнцөд хосгүй хэмээн үзэх бий, бас энэ бол халимын дэлэнгээс гарсан уургаар хийсэн цөцгий, энэ бол ёотон, үүнийг умарт тэнгийсийн замгаар хийсэн юм. Ингээд хамгийн сүүлд энэ бол анаменээр хийсэн чанасан жимс.

Энэ бүхнийг би ховдоглондоо биш ганцхан л капитан Немогийн ярианд гайхан сонирхсондоо бүгдээс нь амталлаа.

-Далай намайг зөвхөн хооллож байгаа ч юм биш бас хувцаслаж байгаа юм. Таны өмссөн энэ хувцсыг нэхсэн эд бол далайн зарим нэг хясаа, шандас байгаа юм. Наадах чинь хүрэн ягаан өнгөөр будагдаж газрын дундад далайн Аплизин гэдэг эртний зөөлөн биетний биеэс гаргаж авсан бодисоор ягаан туяа суулгасан юм. Танд бэлтгэсэн өрөөнд таны ннүрийн заслын ширээн дээр байгаа үнэртэй ус бол далайн зарим ургамлыг хуурай нэрэх замаар гаргасан юм. Таны орны жинтүү бол далайн сайн чанарын өвсөөр нэхсэн. Таны бичих үзгийг халимын сахлаар, бэхийг каракатицын булчирхайны шүүсээр хийсэн юм. Миний хэрэглэж байгаа юм бүхнийг далай өгч байгаа тул энэ бүхэн нэгэн цагт далайдаа эргэж очих болно гэж ярилаа.

-Далайд та дуртай юу капитан аа?

-Эш яриад яахав, дуртайгаар барах уу. Далай гэдэг чинь дэлхий.

Далай бол дэлхийн бөмбөрцгийн аравны долоон хувийг эзэлдэг юм.түүний ууршилт хичнээн сэрүүн, амьдруулах их чадалтайг яана. Түүний асар уудам хязгаарт эргэн тойрны амьдралын энэхүүш бүлээн амьсгалын дунд хүн ганцаардахгүй. Үнэндээ далайд байгаль бодисын гурван ертөнц бий бус уу? Ургамал амьтан, эрдсийн, амьтны аймгийн түг түмэн амьтад, үе хөлтний хоёр анги, зөөлөн биетний тавананги, сээр нуруутны гурван анги, сүүгээр бойжигчид, мөлхөгчид ба загасны гэх мэт үй олон тоонд хүрнэ. Амьтдын энэхүү асар том анги арван гурван мянга гаруй бага дүрс байдаг бол зөвхөн аравны нэг хувь нь цэнгэг уснаа маьдардаг юм. Далай бол байгалийн асар том хөнөг. Дэлхийн бөмбөрцөг дээр амьдрал анх далай дээр бий болсон юм бол далайд л дуусгавар болохыг хэн байг гэдэг юм. Далай тэнгис бол хамгийн энх түвшин нутаг...далай тэнгис дарангуйлан захирагчдад үл хамаарагдана.



Зөвхөн далайн гадаргуу дээр л тэд бие биенийгээ хүйс тэмтэрч, алалдан тулалдан, хуурай газрын амьдралын хамгийн булай бузрыг үзүүлж болно, тэгвэл тэдний эзэмшил гучин футын гүнд л дуусгавар боолдог юм. Ай даа, профессор минь далай тэнгисийн гүнд та амьдраач! Зөвхөн энд л бүрэн дүүрэн эрхчөлөө зөвхөн энд л бүрэн дүүрэн тусгаар тогтнол, зөвхөн энд хэн нь ч хэнийгээ дарлахгүй шүү дээ. ахмад Немо энэхүү халуун үгийг гэнэт таслалаа. Тэр өөрийн ердийн тогтуун зангаа алдсандаа гэмшив үү? Аль эсхүл илүү юм хэлчихлээ гэж айв уу?

Хэдэн минут хир тэр гуанзан дотор нэг л сэтгэл хөдөлсөн аястай алхлаа. Дараа нь тэр өөрийн ердийн хүйтэн сүрлэг царай гаргаж, бие барин тайвширмагц :

-За одоо эрхэм профессор т ахэрэв “Наутилус” хөлгийг сонирхох дуртай агсан бол би таны тусын тул бэлэн байнам хэмээн тэр миний зүг хандаж билээ.

[Тор](#)

---

## “НАУТИЛУС”

-Капитан Немо үүд чиглэхэд би дагалдан одов. Гуанзны голын яшил хаалга нээгдэхэд би зэргэлдээ өрөөнд орсон байлаа. Энэ нь номын сан ажээ. Хэмжээгээрээ гуанзнаас багагүй байв. Таазанд тулсан алт шармал, үнэт модон өндөр шүүгээнүүд адил хавтастай асар олон боть ном дүүрэн хадгалагдаж байв. Шүүгээнүүд тасалгааны бүх хананы дагуу тавигджээ. Хүрэн ширээр ширлэсэн өргөн сайхан зөөлөн сандлууд амарч суухаыг урих мэт байлаа.

Тэдгээрийн дэргэд номын хөнгөхөн зөөвөр тавиур харагдана. Тасалгааны голыг ном овоолсон том ширээ эзэлжээ. Мөн тэнд хуучин сонины хэд хэдэн дугаар байв.

Энэ сайхан танхим таазанд нь шигтгэж тавьсан дөрвөн бөмбөгөр цахилгаан дэнгээр гэрэлтүүлэгджээ.

Би энэхүү өрөөг бахархан харж байв. Энд аргагүй л тохитой үзэмжтэй ажээ.

-Капитан аа, таны энэ номын хадгаламж хуурай газрын ямар ч орд шилтгээнд ховор байх зүйл бус уу? Ийм сайхан номын сан таныг далайн ёроолд

дагалдан явна гэдэг ганцхан бодол намайг бүр донсолгочихлоо гэж би хэллээ.

-Ажиллахад үүнээс тааламж тохиромжтой газар хаанас та олох вэ дээ, профессор минь! хэмээн капитан хэлээд,

-Парижийн музей дахь таны тасалгаа юунд ч үл үйрмэх тийм тааламжтай байдаг гэж үү? Гэж татгалзлаа.

-Үгүй л дээ, мэдээж хэрэг... таны энэ өрөөний дэргэд миний тэр муу тасалгаа ч тун хөөрхий харагдаж байгааг би хүлээх ёстой. Таны энд зургаа, долоон мянгаас доошгүй ном бий дэг ээ?

-Хорин мянга, эрхэм Аронакс. Энэ бол намайг хуурай газартай холбож байгаа цорын ганц зүйл. "Наутилус" хамгийн анхан усанд живж орсон тэр өдөр ертнөц миний хувьд байхгүй болсон юм. Тэр өдөр би хамгийнхаа сүүлчийн ном, хамгийнхаа сүүлчийн сонин сэтгүүлийг худалдан авсан. Тэр цагаас хойш хүн төрөлхтөн миний хувьд бол бодож сэтгэх, бичиж нийтлэхээ зогссон. Энэ номууд бүгд таны эрхэнд байх болно, тэхээр та хэзээ л хэрэгтэй цагтаа ашигла. Таны таалал л мэдэж, эрхэм профессор гэхэд би капитан Немод талархаад номын тавиурт очло. Би тэнд утга зохиол, гүн ухаан, шинжлэх ухааны бүх салбар мөчирт холбогдох номуудыг ямар хэл дээр бичигдсэнийг харгалзахгүйгээр үсэглэлийн дарааллаар байсан сонин зохиол миний нүдэнд шууд туссан бүлгээ. Энэ бол капитан Немо бүх хэл бичиг тэгш мэддэгийг харуулж байлаа.

Энд би Раблегээс Жорж занд, Ксенофонтос Мишле, Гомероос Виктор Гюго хүртэлх яруу найргийн ба үргэлжилсэн үгийн уран утга зохиол, шинжлэх ухааны эртний ба орчин үеийн хүн төрөлхтөний эрдэмтэн мэргэдийн шилдэг бүтээлүүдийг олж үзлээ. Гэвч энэ ноомын санд эрдэм шинжилгээний ботиуд дийлэнх нь байгаагаас механик, баллистик, усан судлал цаг уурын шинжилгээ, газар зүйн, газар судлал гэх мэтчилэн ухааны ботиуд миний бодсоноор Немогийн эрдэм шинжилгээний ажлын гол болсон байгалийн хөгжлийн түүхийн ботиудаас цөөнгүй байлаа. Энд Гумбольдтын бүх боть, Арагогийн бүх боть, Фукогийн бүтээлүүд, Анри Сен-Клер-Девиль Шасль, Секки лам, Мори, Мильн-Эдвардс, Катрфаж, Тиндаль Фараде, Бертелю, Агассиц, академийн "Жил тутмын сэтгүүл" газар зүйн олон нийгэмлэгийн мэдээ гэх мэт номууд тавиур дээх жирийж байлаа. Эдгээрийн зэргэлдээ, энэхүү нэрт нийгэмлэгийн дунд капитан болон хүндэт зочин миний хоёр боть энд буй харагдав. Гэтэл 1865 оны дундуур нийтлэгдэж гарсан гэж миний мэдэх "Одон орны судлалын үндэс" гэдэг Жозеф Бертраныном нэгэн чухал өдөр тогтооход надад тус болсон нь "Наутилус" онгоцыг 1865 оноос арай хойхно усна тавьжээ гэдгийг мэдэхэд оршино.

Иймээс капитан Немо усан доорхи даяанч болсоор гурван жилээс хэтэрсэнгүй ээ!

Хэрэв үүнээс арай шинэ тутам гарсан өөр ном олдох бол энэхүү хөлгийн уснаа шумбаж орсон хугацааг нилээд ойролцоо олохсон гэж би бодлоо. Гэвч надад одоо үүнийг мэдэх өдий төдий зав чөлөө байсан тул “Наутилус”-ын гайхамшигтай танилцахаа хойшлуулахыг би хүссэнгүй билээ.

-Номынхоо санг ашиглах зөвшөөрөл өгсөнд тань баярлалаа, капитан. Энэ тань шинжлэх ухааны ёстой эрдэнийн сансанж. Би ашиглана ч гэлээ.

-Энэ өрөө зөвхөн номын сангаар ч барахгүй, тамхины ч өрөө юм шүү.

-Тамхиных аа? “Наутилус” дээр тамхи татдаг юм гэж үү! хэмээн би би бараг бархирчихлаа.

-Тэгэлгүй яхав.

-Тийм л бол би нэгэн зүйлийн таамаглал хэлэх ёстой. Та Гаваньтай холбоо барьдаг байх нь ээ.

-Ямар ч холбоо байхгүй хэмээн капитан хэлээд та энэ энг янжуур татаад үз л дээ. Энэ хэдийгээр Гаванийх биш ч гэсэн, хэрэв л та тамхины чанар мэддэг бол таны сэтгэлд эрх биш нийцэх л байх гэж хариулав.

Би алтлаг навчаар ороосон, хэлбэрээрээ Гавань нутгийг шилдэг чанарын янжуурархуу, тэрэнд орвол арай цайвар өнгийн янжуур авч том хүрэл тавиур дээр байсан зулнаас асааж бүтэн хоёр хоног тамхиар тасарч зовсон шунахай тамхичин шиг ховдоглон сорж билээ.

-Гойд янжуур санж... гэвч энэ чинь тамхи биш биз?

-Тамхи аа, далайн никотин элбэгтэй нэгэн дүрсийн замаг. Тэгвэл та одоо Гаваний янжуур байхгүйд их харамсаж байна уу?

-Би энэ минутаас хойш жишлээ.

-Тийм бол та чухам ямар гаралтайг нь асуулгүй хичнээн л бол хичнээн тат даа. Энэ тамхинаас тамхины ямар ч монополь гааль түрээс хураагаагүй юм шүү. Тэгвэл, татвар хураагдаагүй гэж тамхины чанар муудахгүй байгаа биз дээ.

-Бяцхан ч муудсангүй ээ.

Энэ минутанд капитан Немо энд номын санд бидний орж ирдэг хаалганы харалдаа өөр нэгэн үүд нээхэд би цэлийтэл сайхан гэрэлтүүлсэн асар том өргөөнд орлоо.

Энэ бол өндрөөшөө тав, өргөөшөө зургаа, уртаашаа арван метр эмжээтэй, мухарласан булангууд бүхий уужим байлаа. Угалзлан хээнцэрлэж чимсэн таазанд нь шигтгэж тавьсан чийдэнгийн гэрэл хурц боловч энэхүү үзэсгэлэнд

хуримтлуулсан гайхамшгуудыг зөөлнөөр гэрэлтүүлж байлаа. Ай даа ёстой л музей гэдэг энэ байв. Энэ байв. Чадварлаг болоод нямбай хүний гар, байгаль ба урлагийн хамаг баялгийг энэхүү үзэсгэлэнд уран зураачийн шилтгээнд байгаа энэ амьд байдлаар нь тун цэгцтэй өрсөн ажээ. Агуу их зураачдын яг ижилхэн гуутай гучин ширхэг хөрөг төв сайхан хээтэй, гоёмсог эдээр бүрсэн ханыг чимэглэн байв. Хөргүүдийн хооронд эр цэргийн бүрэн зэвсэгтэй баатрын хөшөө босгож элгэвч бамбай дээр сэлэм хутга зөрүүлдэн дүүжилжээ.

Би европ газар хувийн болон нийтийн зургийн үзэсгэлэнд л сонирхож асан асар их үнэ цэнэтэй хөргүүд олж үзлээ. Зургийн хуучны мастеруудын бүтээлээс энд : Рафаэлийн “Авхай”, Леонардо Да Винчийн “Дагина”, Корреджогийн “Хэлгүй”, Тицианы “Эмэгтэй”, Веронезийн зураг, Мурильогийн “Аргамжилсан нь” Гольбейн “Хөрөг, Веласкесийн “Лам”, Риберагийн “Зовлон эдлэгч”, Теньрсын “Яармаг”, Робенсын Фламанд нутгийн хоёр байгальч Жерар Доу, Метсу Толь Поттер нарын маягаар гурван жижиг хөрөг, Жерико, Прюдон хоёрын оёр хөрөг, Бакюйзен ба Вене хоёрын тэнгисийн хэд хэдэн байдал зэрэг хөрөг байлаа. Орчин үеийн зураг урлалын бүтээлүүдийн дунд би Делакура, Энгро, Декан, Труа, Мейссонье, Добиньи ба бусад зураачийн гарын үсэгтэй зургууд олж харлаа.

Түүнчлэн энэ музейн булангуудад өндөр өндөр суурин дээр эртний баримлын хэд хэдэн гайхамшиг сайхан гантиг ба хүрэл баримал байх ажээ.

Капитан Немогийн урьдчилан хэлсэн үг хэрэг дээрээ харагдаж “Наутилус”-ыг үзэж эхэлсэн анхны алхмаас эхлээд би гайхаж гөлрөхийн туйлд хүрч билээ.

-Энэ тасалгаанд тун эмх замбараагүй байгаа хэдий боловч таны биеийг ямар ч эрээ цээргүй хүлээн авсан явдалд эрхэм профессор та эрхбиш намайг өршөөх болов уу хэмээн би найдаж байнам гэж хачин хүн хэлэхэд би :

-Капитан та ер нь нилээн сайн жүжигчин юмаа! хэмээн хэллээ.

-Үгүй ээ, би зөвхөн л сонирхогч хүн гэж тэр татгалзан :

-Хүн төрөлхтөний эдгээр бүтээлийг цуглуулах явдал надад маш их бахтай байсан юм. Би эдгээрийг эрэхдээ цуцашгүй, авахдаа шунахай байснаас үнэхээр ч асар их үнэтэй хэд хэдэн ховор зүйл олж авсан юм шүү. Энэ бол миний хувьд үхэж үгүй болсон хуурай газрын сүүлчийн дурсгал болж үлдсэн юм. Миний нүдэнд одоо танай орчин үеийн зураачид ч гэсэн балар эртний мастерууд мэт санагддаг болсон их хүмүүсийн нас тоогүй юм.

-Аа энэ хөгжимчид? хэмээн би үзэсгэлэнгийн нэг талын ханыг бүхлээр нь эзэлсэн бадралт баг бишгүүрийн таг дээр тарааж хаясан Вебер, Россини, Моцарт,

Бетховен, Гайдн, Мейербер, Вагнер, Обер, Гуно ба бусад хөгжимчдийн хөгжмийн зохиолыг хуруугаараа зааж асуув.

Энэ хөгжимчид миний хувьд бол Орфейн үеийнхэн. Цаг үеийн ялгаа үхэгсдийн ой ухаанд байдаггүй юм болохоор профессор гуай одд газарт нойрсож байгаа танай тэр нөхдийн чинь нэгэн адил би талийгаач болсон хүн юм шүү... гэлээ.

Капитан Немо таг дуугүй болж бодлогоширлоо. Би түүний царайг чимээгүй шинжин түүнийг тун их сонирхон харж зогсов. Тэр үнэ цэнтэй нэгэн ширээн дээр тохойлдон зогсож, над руу үл харах нь энд намайг байгаа гэдгийг таг чиг мартчихсан мэт байв. Би түүний бодолд саад хийхгүйг хичээж энэхүү үзэсгэлэнд цуглуулсан гайхамшигуудыг сонирхон орлоо.

Энд урлагийн бүтээлүүдтэй зэрэгцэн байгаль бодисын ховор эрдсүүд мэдэгдэхүйц суурь эзэлсэн ажээ. Эдгээр нь төлөв далайн амьтан ба ургамлын зүйлс болон далайн бусад эрдсүүд байсан нь капитан Немогийн өөрийн нь гараар цуглуулагдсан буйзаа. Өрөөний голд дороос нь цахилгаан гэрэл тусгасан усан оргил дээш годгодож, тридана хэмээх асар том хясааны дун дотор дорогш эргэн бууж байлаа. Тридана гэдэг энэхүү хясаа хөндлөнгөөрөө гурван метр том юмаа. Тэгвэл энэ хясаа нэгдүгээр Ван Францискт Венец улсаас бэлэглэсэн асар том алдарт хясаанаас том ажээ.

Усан оргилын сав аварга хясааг тойрон зэсээр тоногдсон гоё сайхан шилэн авдруудад хэзээ нэгэн цагт байсан ч хүн олж үзэхэд бэрхтэй далайн хамгийн үнэтэй ховор зүйлс тавьсан байв. Эдгээрийг үзмэгц миний хэр зэрэг хөхөж баярласныг дүрслэн бодож болноо.

Энд хөндий хэвэлтний хэсэг болцруу ба өргөс биетнээр бүрэлджээ. Хөндий хэвэлтний дотор дэвүүр хэлбэрт горгонин далайн органикууд, сирийн хөвөн биетэн, молуккийн шүр, альционы гойд нэгэн дүрс, сэтгэл бахдам дэвүүр навчтан, Реюньён арлын глазчатза, мадропорын төрлийн хөндий хэвэлтний бүхэл бүтэн цуглуулга, тэдгээрийн дотроос ялангуяа Антилийн арлын “Далайн вангийн тэрэг” анхаарал их татаж байлаа. Энд мөн ахмгийн олон дүрсийн шүр сувд цуглуулагдсан бөгөөд эдгээрийн далагнал бөөгнөрөн бөөгнөрсөөр бүхэл бүтэн арал хойг ч үүсгэх явдал буй ба зарим тивч тогтоож болно. хурц хурцөргөс зүүгээр хучигдсан, хуягаар өвчилсөн өргөс биетэн далайн од, далайн бортого, далайн зараа, могой сүүлт гэх мэт хэд хэдэн дүрсээс бүрэлджээ.

Энд хэрэв л миний оронд надаас арай л мэдрэл муутай эрдэмтэн Конхиолог байсан бол зөөлөн биетний цуглуулга хадгалагдсан дараах хайрцгийг үзээд муурч

унах байсан буйзаа. Эдгээр дээжүүдийг төдий гэж үнэлэхийн аргагүйгээс гадна тэдгээрийг тодорхойлж бичихэд бүтэн боть ном бичих хэрэгтэй байв. Тиймээс би зөвхөн л хамгийн сонирхолтойгоос нь тооцоод зогсьё. Капитан Немогийн зөвөн биетний энэхүү цуглуулганд Энэтхэгийн гадаад далайд орших жигд цагаан толбо бүхий улаан хүрэн өнгийн гоёмсог загалмай аварга загас, түүнчлэн “Эзэн хааны спондили” хэмээн нэрлэгдэх тод гялбам өнгөтэй нэгэн дүрс зөөлөн биетэн байх бөгөөд үүнийг европын ямар ч музей, хорин мянган франкаар дуугүй авах байлаа. Мөн эрж олоход тун бэрх Австралийн загалмай аварга загас, өчүүхэн үлээх төдий болоход бутран унах үүрмэг тийм эмзэг, цагаан өнгийн, хоёр талаасаа хавтас хуягтай Сингаль нутгийн сердцевик, түүнчлэн сонирхогсод нэн их үнэлэн үзэх үрчгэр ирмэг бүхий шохойлог гуурс хэлбэрийн Ява газрын далайн леек, америк орчны уснаа тохиолдох шар ногоон өнгийн болон шинэ Зеланд арлын эрэг орчим ба Мексикийн буланд орших ваарын дээвэр маягийн дунгаараа бусдаас ялгарах хар хүрэн өнгийн гэдэс ба хөлтэй мөн бас хүхэрлэг төрлийн хэмээгдэх гайхамшигт амьтан цитер ба венусын ховор нэгэн дүрс, тана эрдэнийн толботой гантиг мэт гангамсаг кубарна, цааш нь Энэтхэг нутагт мөнгөний оронд хэрэглэх упсовкийн төрлийн бүх дүрс, бас дорнот Энэтхэгт хамгийн үнэтэй гэгдэх “Далайн алуар” хэмээх дун зэрэг хэвэл хөлтний бүхэл бүтэн аймаг цуглуулагдсанаас гадна башейк, янтин, митр, каск, бачрец, арф, тритон, ттероцер, пателла, гиалеи, клеодар гэх мэтээр эрдэмтэд шилэн сонгож өгсөн сайхан сайхан нэртэй бөх ба хэврэг хуяг бүрхүүлт зөөлөн биетэд байлаа.

Тус тус шилэн авдарт урьд өмнө үзэгдэж харагдаагүй үзэмж төгөлдөр сувд эрдэнийн хэлхээ, цахилгаан гэрэлд солонгорон байхын дунд : Улаан далайн ёроолоос авсан ягаан өнгийн сувд шүүдэс болон бусад бараг бүх далай тэнгист тохиолдох янз бүрийн зөөлөн биетний хясаан дотор торж ургадаг ногоон, шар цэнхэр хар өнгийн эмзэг ур буву сувдууд байлаа.

Эдгээр сувдын зарим нь тагтааны өндөгнөөс том ажээ. Тэдгээр нь жуулчин Таверны Белгийн хаанд гурван саяар худалдсан тэр том сувднаас үнэтэй бөгөөд дэлхий дээр хамгийн гоё хэмээн миний үзэж байсан Маскат хааны сувднаас илүү үзэмжтэй байлаа.

Тийм болохоор энэхүү цуглуулгын үнийг тогтоох аргагүй ажээ. Эдгээрийг худалдаж авъя гэвэл капитан Немо хэд хэдэн саяыг зарцуулах хэрэгтэй байсан буй заа.

Энэхүү дуулдаж сонсогдоогүй их баялгийн эх булаг нь хаана байдаг бол

хэмээн би өөрөө өөртөө асуулт тавьж зогстол капитан Немо гэнэт миний зүг хандан :

-Миний цуглуулгыг үзэж байна уу? профессор гуай? Тэд үнэхээр ч байгальч хүний дур сонирхлыг татах ёстой юмдаг. Миний хувьд бол эдгээрийг өөрийн гараар түүж цуглуулсанд л эдгээрийн үнэ нь байдаг юм. Ер нь энэ үзвэрт байгаа зүйлсийн аль нэгийг надад өгөөгүй далай тэнгис гэж бөмбөрцөг дээр байхгүй гэлээ.

-Ийм их баялгийг нүдээрээ үзээд таны баярлан хөхөгүй байж чадахгүйг би сайн ойлгож байна. капитан минь Европын нэг ч музейд ийм цуглуулга байхгүй. Гэвч би өөрийнхөө хамаг байдаг баяр хөөрийг ганцхан музей үзвэрт л зарцуулчихвал хөлөг онгоцыг үзэхэд надад юу үлдэх билээ? Би таны нууцыг танихын тулд төдий л нэрэлхэхгүйдэг шүү гэхээс гадна миний энэхүү их дур сонирхлыг ийм их хурдтайгаар ямар нэгэн этгээд оньсны хүчээр явдаг “Наутилус” хөлөг өөрөө их өдөөж байгаа юм шүү. Таны энэхүү өргөөний ханан дээр надад үл ойлгогдох хэмжих багажууд дүүжлээстэй байхыг би харж байна. тэгвэл би танаас ингэж асууя... гэтэл капитан миний яриаг тасалж :

-Эрхэм Аронакс таныг би энэхүү онгоцон дээр бүрэн эрх чөлөөтэй байхыг тань дээр хэлсэн тул “Наутилус” онгоцонд таны орж нэвтэрч болохгүй өнцөг булан гэж байхгүй. Хөлөг онгоцыг хичнээн л бол хичнээн сонирхож болно. би таны газарчаар үйлчлэхэд дуртайяа бэлэн байнам гэлээ.

-Мэдэхгүй чухам ахмад минь таныг яаж би талархдаг юм байгаа юм. Таны хайр хандлагыг хөсөрдүүлэхгүйг л хичээе. Физикийн зөвхөн эдгээр багажийн үүрэг юу болохыг л хэлж өгнө үү?

-Яг л ийм багаж миний өрөөнд байгаа. Тэнд ороод би танд хэлж өгье. Харин урвдаар танд зориулж бэлдсэн өрөөнд оръё.

“Наутилус” онгоцон дээр ямар нөхцөлд байхаа та мэдвэл зохих биш үү. Би капитаны хойноос дагалдсаар нарийхан гудамд гарлаа. Онгоцны хошуу хавьд хүрэлцэн очоод капитан Немо намайг нэгэн өрөөнд, үгүй ээ зөөлөн сандал ширээ ор зэргийг тавьж сайхан төхөөрсний нь яана, нэгэн саруул тасалгаанд орууллаа. Би гэдэг баяр талархал болж ахуйд :

-Таны тасалгаа минийхтэй харьцаж минийх саяын бидний байсан танхимтай нийлдэг юм хэмээн капитан Немо үүд нээх зуураа өгүүлэв. Дараа нь бид капитаны тасалгаанд орж очлоо. Энд төмөр ор, ажлын ширээ, хэдэн сандал, нүүр гарын тосгуур, ердөө энэхэн байв. Зөвхөн л гарцаагүй шаардагдах зүйлс л байхаас биш өөр ямар ч тохилог хэрэглэл үгүй ажээ. Өрөөнд бүдэг гэрэлтэй байв.

Капитан Немо :

-Сууна уу та хэмээн надад сандал заалаа.

Би ч суулаа. Тэр жаахан дуугүй байснаа дараа нь яриагаа эхлэв.

[Тор](#)

---

## “БҮГД ЦАХИЛГААН ХҮЧЭЭР”

-Профессор та хар! хэмээн капитан Немо ханан дээр дүүжлээстэй багажуудыг заан яриагаа эхлэж “Наутилус” онгоцыг хөтөлдөг бүх багаж энэ дээ. Энд эдгээр багаж яг л тэр үзэсгэлэнд байгаачлан үргэлж миний нүдний өмнө байж “Наутилус” далайд чухам хаана байгаа ба хаашаа явж байгааг зааж байдаг юм. Эдгээр багажийн заримы нь ч та мэднэ. Энэ бол халуун хүйтний хэмжүүр : “Наутилус” дээрх агаарын дулааныг хэмждэг юм. Энэ бол бромметр, үүгээр агаарын даралтыг хэмжиж, цаг агаарын өөрчлөлтийг урьдчилан тодорхойлдог, энэ бол агаар чийг хэмжигч, үүгээр агаарын чийгийн их багыг тодорхойлно. Энэ бол луужин, үүгээр хөлөг онгоц чиглэлээ авна. Энэ бол өргөдөг хэмжүүр гэдэг багаж, үүгээр нарны хөөрөлтөөр оршиж байгаа орчныхоо өргөргийг гаргана. Энэ бол нарийн цаг гэгч. Үүний тусламжтайгаар бид бөмбөрцгийн уртрагийг олно. Ингээд хамгийн сүүлд өдрийн ба шөнийн дуран. Үүгээр би “Наутилус” усан дээр хөвж гарахад далайн орчныг хардаг юм даа гэлээ.

-Эдгээр багаж ч ихэвчлэн далайн дадмаг ажилд л хэрэглэгддэг багаж даа. Би эдгээрийг сайн мэднэ. Харин энд л нэг надад үл мэдэгдэх багаж байна. бодвол энэ л Наутилусыг хөдөлгөчихдөг онцлогтой болов уу. Энэ нэг зүүтэй тоотой том цагираг чинь даралт хэмжигч үү дээ?

-Тиймээ наадах чинь онгоцны хажуу ханаар дамжиж устай харьцсаны улмаас “Наутилус” живж ороход усны даралтыг заадаг юм.

-Энэ? Халуун хүйтний хэмжүүр үү?

-Тиймээ зөвхөн л шинэ хийцтэй. Энэ бол усны янз бүрийн давхаргын температур заагч халуун хүйтний хэмжүүр.

-Тэгвэл энэ ямар багажууд вэ? Ямар юманд хэрэглэж болохы нь би



мэдэхгүй байна.

-Энд танд, эрхэм профессор жаахан тайлбар үг хэлэхгүй бол горьгүй нь хэмээн капитан Немо хариуллаа.

-Тэр хэсэг зуур дуугүй байсны дараа нь :

-Байгаль дээр эдлэхэд хялбар хөнгөн, хурдан, дуулгавартай нэгэн хүч байдаг юм. Тэр хүч миний онгоцыг гэрэлтүүж, дулаацуулж, хөдөлгөж юм бүхнийг хийж явдаг. Энэ хүч бол цахилгаан гэлээ.

-Цахилгаан гэнэ ээ? хэмээн би дуу алдав.

-Тиймээ.

-Тэгвэл капитан минь таны хөлөг ер бусын хурдтай шүү дээ. Энэ нь цахилгааны тухай бидэнд мэдэгдсэнтэй төдий л нэг уялдахгүй байх чинь юу билээ. Түүний механик хүч одоо хүртэл тун хягаарлалтай биш билүү!

-Харж байна уу, эрхэм профессор! хэмээн капитан Немо хэлээд цахилгаан энергийг ашиглах миний арга нийтийн тогтсон аргаас арай өөр юм шүү. Зөвхөн л энэхүү тайлбараар дуусвар болгохыг эрхбиш зөвшөөрөх биз гэв.

-Хэдийгээр би таны энэхүү мэдэгдэлд тун их сэтгэл хөдөлсөн боловч шалгаахыг байя капитан минь. хэрэв л татун эвгүй гэж үзэхгүй бол ганцхан асуултанд минь хариулж өгнө үү. Энэ гайхамшигт хүчийг гарган авдаг эх булгийн бүх элемент, ялангуяацайр маш хялбархан барагддаг бишсэн билүү. Хэрэв л та газартай харьцдаггүй юм бол ямар аргаар түүний нөөцийг нөхдөг хүн бэ?

-Дуртай хариулъя хэмээн капитан Немо хэлээд юуны өмнө далайн ёроолд цайр, төмөр, алт мөнгөний ба бусад металлын хүдрүүд бишгүй байдаг бөгөөд тэдгээрийг боловсруулан авахад төвөг их ордоггүй гэдгийг мэдэх хэрэгтэй. Гэвч би газрын баялгийг ашигладаггүй. Би хичнээн энерги хэрэгтэй бол төчнөөнийг л далайгаас гарган авдаг хүн дээ гэж хэллээ.

-Далайгаас ий?

-Тиймээ профессор минь далайгаас. Далайн уснаас цахилгаан гүйдэл гарган авах арга олон бий. Жишээлбэл би харилцан адилгүй гүнзгийг оруулсан дамжуулагчдыг тойрч байгаа далайн усны давхаргын температурын ялгавраас цахилгаан гүйдэл гарган авч чадахсан билээ. Гэвч би арай өөр дадлагжсан арга хэрэглэхийг бодсон юм.

-Ямар?

-Та далайн усны найрлагыг мэднэ биз? Далайн усны ерэн зургаан хувийг цэвэр ус эзэлдэг бөшөөд барагцаалбал түүний хоёр ба гуравны хоёр хувьд

натрийн хлорлог давс буюу хоолны ердийн давс ууссан байдаг болон хлорлог магни, хлорлог кальци, бромот магни, хүхэрлэг нелийн магний хүхрийн хүчил, нүүрс кальцын давс зэрэг бага багаар холилдосн байдаг, хлорлог натри далайн усанд их хэмжээгээр холилдсоныг та үзээ биз дээ. за тэгвэл яг л энэ хлорлог натраар чинь би тэжээлээ хийдэг юм даа.

-Хлорлог натраар ий?

-Тиймээ, хлорлог натри чинь мөнгөн устай нэгдэж бунзений тэжээлд цайрыг орлон амальгамыг үүсгэдэг юм даа. Тэгвэл тэжээлийн мөнгөн ус урвалд задардаггүй, задардагаас зөвхөн натри байгаа юм. Натрийг далай надад өгдөг шүү дээ. түүнчлэн натрийн тэжээл бол цайрын тэжээлээс хоёр дахин хүчтэй гэдгийг танд хэлбэл зохино.

-Таны оршиж байгаа орчинд натрийг хэдий ашигтай болохыг капитан минь би ойлгож байна. далайд тэр хичнээн л бол хичнээн, за тэр ч сайн. Гэвч натрийг чинь түүний хлорлог кальциас цэвэрлэх хэрэгтэй шүү дээ. та үүний тул яадаг вэ? жич таны батрейгаар хлорлог натийг шууд задлах шингэн тэжээл хийж болох боловч хэрэв би эндүүрээгүй бол шингэн тэжээл буй болгохын тул зарцуулж байгаа натрийнхэмжээ шинээр гарган авах гэж байгаа натриас хамаагүй их шаардагдана шүү дээ. тиймээс та байхгүй натрийг гарган авахаасаа өмнө байгаа натрийгаа зарцуулж гүйцэх юм биш үү!

-Тийм л болохоор эрхэм профессор минь би натрийг цахилгааны аргаар гаргаж авдаггүй, үүний тул харин чулуун нүүрсний шаталтын энергийг ашигладаг юм шүү дээ.

-Чулуун нүүрсий? Тэхээрээ та яаж ийхийгээд л газартай харьцаатай хүн байх нь ээ?

-Үгүй ээ, харьцаа байхгүй. Хэрэв та хүсвэл далайн чулуун нүүрс гээд нэрлэчихье л дээ.

-Тэгвэл та далайн ёроолын давхаргын чулуун нүүрс гарган авах арга олсон хүн үү?

-Та үүнийг гайгүй нүдээрээ үзэх болно профессор минь. би танаас жаахан тэсвэртэй байхыг хүсэж байна, түүгээр ч барахгүй цаг хугацаа таны тэсвэртэйхэн байхы тань дүүрэн хангажбайгаашүү дээ. би юм бүхнээ ганцхан л далайгаас авдаг гэдгийг бүү март та, Далай надад цахилгаан өгдөг бол цахилгаан "Наутилус"-ыг дулаацуулдаг, гэрэлтүүлдэг, хөдөлгөдөг. Ганц үгээр хэлэхэд амьдруулдаг юм даа.

-Гэвч амьсгалах агаар танд өгддөггүй байх аа?

-Ай хэрэв над хэрэгтэйсэн бол шаардагдах хэмжээнийхээ агаарыг өөрөө гарган авахсан билээ. Гэвч би хэзээ л дуртай цагтаа далай дээр хөвж гардаг болохоор тэгэхийн хэрэг алга. Жич би цахилгааны хүчээр агаарын хүчирхэг шахууруудыг ажиллуулж онгоцныхоо тусгай багтамжуудад хий дүүргээд хэрэгтэй цагтаа удаан хугацаагаар живж ордог юм.

-Капитан таны өмнө би зөвхөн л мэхийн ёслохоос өөр юм алга. Бодвол цахилгаан механикийн аварга хүчийг та бусад хүмүүс нээхээс хамаагүй эрт нээж чадсан бололтой гэж хэллээ.

-Тэд түүнийг хэзээ нэгэн цагт нээх ч юм уу, үгүй ч юм уу, бүү мэд гэж капитан хүйтэн царайлж тэд нээж чадлаа ч гэсэн чадаагүй ч гэсэн энэхүү гайхамшигт хүчийг би юунд хэрэглэснийг та өөрөө мэдлээ шүү дээ. Энэ хүч нь хөлөг онгоцыг тасралтгүй бөгөөд тогтмол гэрэлтүүлж чадаж байна, тэхэд тийм чадал наранд байхгүй шүү дээ. Тэгвэл эдгээр цагийг хар! Эд бүгд цахилгаанаар ажиллаж явцаараа ямар ч нарийн цагаас дутахгүй. Би цагийнхаа нүүрийг итали цаг шиг хорин дөрөв хуваасан юм. Учир нь миний хувьд бол нар сар өдөр шөнө гэж байдаггүй харин би өөрөө далайн хөлгүй гүнд авч ордог тэр хиймэл гэрэл над бий. Одоо хар л даа, өглөөний арван цаг болж байна гэлээ.

-Яг тийм.

-Бас энэ нэг багаж бол цахилгааныг өөрөөр ашигласны нэг баталгаа. Таны нүдий өмнө өглөөтэй байгаа тоотой энэ нэг дэвсгэр бол "Наутилус"-ын хурдыг заадаг юм. Лаг хэмээх хол ойр хурд хэмжих багажийн сэнсийг энэ дэвсгэртэй холбосон утсаар дамжуулж үүний зүү миний онгоц хичнээн хурдтай явааг над хэлдэг юм. За харж байна уу, энэн минутанд бид жигдэрсэн хурдтай, цагт арван таван милль явж байна.

-Тун гайхалтай!Капитан та байгалийн энэ нэгэн хүчийг ашиглаж таны онгоц уурын хүчийг цахилгаанаар сольсон нь тун их хожоотой болж таныг нэн их зөв юм хийснийг тань би одоо харж байна гэж би өгүүллээ.

-Бид онгоцоо үзэж бас л дуусаагүй шүү, профессор гуай! Хэмээн капитан сандлаас босох зуураа өгүүлээд : Хэрэв та ядраагүй бол онгоцны хитэг рүү очъё л доо гэлээ.

Үнэндээ ч би усан доогуур явагч онгоцны хошууны бүх хэсэгтэй танилцсан билээ. Онгоцны тэн голоосхоншоорын мөргүүл хүртэл байх зүйлийг дараалан тоочвол : Уртаашаа таван метр тасалгаатай гуанзан, номын сангаас ус үл нэвтрэх

ханаар тусгаарлагджээ. Мөн уртаашаа таван метр тасалгаатай номын сан, арван метр том үзэсгэлэн, капитаны өрөөнөөс ус үл нэвтрэх хоёр дахь ханаар тусгаарлагджээ. Мөн капитаны уртаашаа таван метр өрөө, миний хоёр метр хагас өрөө хамгийн сүүлд жинхэнэ форштевен хүртэл үргэлжилсэн уртаашаа долоон метр хагас хийн багтаамж сав тус тус байлаа.

Ерөнхийдөө онгоцны энэ хэсгийн урт нь гучин таван метр ажээ. Ус үл нэвтрэх ханануудын бин битүү хаагддаг хаалгуудаар хангагдсан нь онгоцны ямар нэгэн хэсэгт ус орж эхэлбэл “Наутилус”-ыг живэх аюулаас хамгаалах ёстой байлаа.

Би капитан Немог дагалдан гудам өрөөгөөр явсаар онгоцны тэг дунд хүрлээ. Тэнд ус үл нэвтрэх халхавч хоёр хананы хооронд нарийхан худаг байх бөгөөд хананд нь эргэдэж бэхэлсэн төмөр шат тааз өөд одсон байв. Энэхүү худаг чухам ямар хэрэгтэй болохыг би капитанаас асуувал :

-Дээшээ завинд хүрдэг юм гэлээ.

-Юу? та бас завьтай гэж үү? хэмээн гайхаж хоцорсон би магадлан асуухад :

-Тэгэлгүй яахав. Хөнгөн болж ирээд живдэггүй сайхан завь бий. Загас барихад хэрэглэдэг юм.

-Тэгвэл завиа усан дээр тавихын тул таны онгоц хөвж гарах ёстой биз?

-Яасан ч үгүй. Миний завь “Наутилус”-ын их биенд байдаг тусгай хөнөгт далд байдаг юм. Тэр өөртөө бин битүү хаагддаг ус үл нэвтрэх тусгайбөмбөгөр хавхагтайгаас гадна өөрийнхөө хөнөгт боолтоор бэхлэгддэг юм. Энэ шат “Наутилус”-ын дээд тавцанд байдаг жижиг таганд хүргэдэг бол тэр завины ёроолд мөн тагтай жижиг нүх хоорондоо харьцдаг учир би түүгээр дамжиж завиндааорохо миний хойноос “Наутилус”-ын нүхний тагийг хааж би өөрөө завины ёроолын тагийг хаадаг юм. Тэгээд би завиныхаа бэхэлгээ эргийг мулталмагцминий завь дээшээ хар хурдаараа ойж далан дээр гардаг даа. Дараа нь би завиныхаа хураадаг тагийг нь эвхэж аваад шураг босгож далбаа тавих буюу сэлүүр барихгүй юу.

-Тэгээд та яаж онгоцондоо эргэж ирдэг юм бэ?

-Би буцаж ирдэггүй. “Наутилус” миний хойноос ирдэг.

-Таны тушаалаар уу?

-Тиймээ миний тушаалаар, би онгоцтойгоо цахилгаан утсаар холбоотой явдаг, би онгоцондоо буцах гэвэл цахилгаан утас цохичихдог юм.

-Нээрэн үүнээс хялбар юм гэж юу байхав гэж энэ бүх гайхамшигт мангуурчихсан би дуу алдав.

Бид цаашаа онгоцны тавцан дээр гарах шатны орчинг өнгөрөөд өглөөнийхөө амтат зуушаа хоёр завжиндаа бувайтал чихэж байсан Нед Ленд, Консель хоёрын хоёр метр уртөрөөний дэргэдүүр гарлаа. Тэдний өрөөний зэргэлдээ гурван метр урт гал зуухны өрөө байлаа. Мөн тэнд хүнс агуулах нилээд зайтай тасалгаа байв.

Гал зуух нь цахилгаанаар ажилладаг ажээ. Цаган алтан хавтганд цахилгаан утас гагнан залгаж цав цайтал улайтгаад л зууханд шарах, чанах, жигнэх, халуун хүйтнийг тааруулдаг байв. Нэрлэгний цахилгаан аппарат далайн усыг нэрж цэвэр сайхан усаар хөлөг онгоцыг хичнээн л бол хичнээн хангадаг ажээ.

Гал зуухны дэргэд халуун устай байлаа.

Түүнээс цааш онгоцны баг суудаг таван метр урт өрөө үргэлжилнэ. Түүний хаалга түгжээтэй байсан тул би тавилгаар нь “Наутилус”-ыг үйлчлэгч хүмүүсийн тоог мэднэ гэж найдаж байсан боловч мэдэж чадсангүй.

Энд багийнхан суудаг өрөөг машины тасгаас тусгаарласан ус орохгүй дөрөв дэх хана байв. Тэрхүү халхавч хананд буй хаалгаар цааш ормогц бид “Наутилус”-ыг хөдөлгөгч машинуудыг тэргүүн зэргийн инженер капитан Немогийн гараар суурилуулсан их танхимд оров.

Цэлийтэл гэрэлтүүлсэн энэхүү их тасалгаа уртаашаа хориос доошгүй метр байв. Тэр тасалгаа хоёр хэсэгт хуваагдаж нэгд нь цахилгаан энерги гаргагч тэжээл, нөгөөд нь онгоцны сэлүүр сэнсийг эргүүлэгч машин тавьжээ.

Энэ тасалгаанд ханхалжагсан нэгэн хачин үнэр над гайхагдсан бүлгээ.

Капитан Немо ч миний эвгүйрхсэн байдлыг ажжээ.

Энэ бол натийг гарган авахад ялгарагч хийн үнэр. Гэвч энэ ердөө л нэг эвгүй үнэр шүү дээ. Тэгээд ч бид өглөө бүр бүх онгоцондоо сайтар салхи оруулдаг юм гэж тэр ярилаа.

Би “Наутилус”-ын машинуудыг тун их сонирхон үзлээ.

Би Румкорфын тэжээлийг бус бунзейний тэжээлийг ашиглаж буйг та харж байгаа биз дээ хэмээн капитан Немо Румкорфын тэжээл над хэрэгтэй хүч өгч чадахгүй байхсан билүү. Бунзейний батарей ч надад цөөн л дөө. Гэвч тус бүрдээ их хүчтэй юм шүү. Батарейгээс гарч байгаа цахилгаан гүйдэл энэ танхимын нөгөөталд буй аварга цахилгаан моторуудад нөлөөлж тэр моторууд дандаадамжлагын төвөгтэй системээр сэлүүр сэнсийн голд эргэлдэх хөдөлгөөн олгодог юм. Тэр голын бүдүүн нь жаран сантиметр урт нь долоон метр хагас. Гол энэхүү нүсэр байдлыг харгалзахгүйгээр секундэд зуун хоёр эргэдэг юм.

Тэгвэл таны хурд ...хэмээн би хэлэх гэтэл :

Цагт тавин миль хүрдэг юм гэлээ.

Энд ямар нэгэн онцгой нууц байсан боловч би түүнийг тайлбарлаж аль гэж хэлж зүрхэлсэнгүй. Яахаараа цахилгаан ийм асар их энерги өгч чадах вэ? Энэхүү урьд өмнө сонсогдоогүй бараг хэмжээ хязгааргүй их хүч чадлын эх булаг нь хаана байна? энэ өндөр хүчдэл буй болгодог шинэ хэлбэрийн ороомогтоо буюу эсхүл дамжлага системд нь энэхүү нууц байна уу? Үүнийг би мэдэж чадсангүй.

Капитан Немо таны үр бүтээлт ажлын өмнө би сөгдөж, чухам үүнд та яаж хүрсэн болохыг тань ойлгохыг ч оролдохоо больё хэмээн би хэлээд “Наутилус”, “Авраам Линкольн”-ыг тойрон явж байхыг би нүдээрээ үзсэн болохоор ямар их гайхамшигтай хурдалж чадахыг нь ч мэднэ. Гэвч ердөө ганцхан хурдан яваад ч газар авахгүй шүү дээ. тэхээрээ чухам хаашаа явж байгаагаа харах хэрэгтэй биз. Түүнчлэн онгоцоо дээш доош, баруун зүүн тийш нь залах хэрэгтэй. Энэ бүхнийг та далайн гүнд хэд хэдэн зуун атмосферын их даралтанд яаж үйлддэг вэ? Бас далай дээр яаж хөвж гардаг вэ? Ингээд хамгийн эцэст нь өөрийн сонгосон давхаргад та ямар аргаар шулуун шугамын хөдөлгөөнийг баримталдаг вэ? Танд би өдий олон асуулт тавьсан минь эвгүй юм болсон биш биз гэж асуулаа.

-Юуны эвгүй байхав профессор минв хэмээн тэр хсэг зуур эргэлзэн байснаа :

Та энэхүү усан доорххөлөгнөөс хэзээ ч зайлж одохгүй шүү дээ. хоёулаа миний өрөөнд орёё. Тэнд л та “Наутилус”-ын тухай юу л мэдэхийг хүссэнээ мэдэх болно.

[Top](#)

---

## ХЭДЭН ТОО БАРИМТ

Хэдхэн минутын дараа бид үзэсгэлэнгийн өргөөний сандал дээр амандаа янжуур зуучихсан сууцгааж билээ.

Капитан Немо над нэгэн зураг өгсөн нь “Наутилус”-ыг уртааш нь ба хөндлөөш нь зүсэж үзүүлсэн байлаа. Дараа нь тэр тайлбарлаж эхэллээ.

- Энэ дээ ноён Аронакс одоо таны морилж яваа хөлгийн зураг. Энэ хөлөг бол хоёр тийшээ шувтан янзаараа янжууртай адилхан цилиндр хэлбэрийн онгоц байгаа

юм. Жич, янжуур хэлбэрийн хийций чинь Лондонд энэ талын хөлөг үйлдвэрлэгээний шилдэг маягийн хийц гэж үздэг юм шүү. Энэхүү цилиндрийн урт нь нэг үзүүрээсээ нөгөө үзүүрээ хүртэл далан метр, бүдүүн нь тэн голдоо хамгийн их газраа найман метр. Би хурд ихтэй хөлөг онгоц хийхэд нэгийг аравтай харьцуулахын жишээтэй, өргөний нь хийхэд урттай нь харьцуулдаг ердийн заншлыг баримтлаагүй боловч энэхүү өгөгдсөн харьцаанд ч магнай талын эсэргүүцэл тиймх биш гэхээс гадна хөлөг онгоц өөрийн эзэлхүүний хэмжээгээр түрж гаргаж буй ус явцанд саад болдоггүй юм. Тэгвэл энэхүү түрэгдсэн усны хэмжээ “Наутилус”-ын гадаргууны талбай багтаамж хоёрыг бодоход дөхөм болно биз. Тэгвэл түүний гадаргуу мянга арван нэгэн метр шоо дөрвөлжин зай эзэлдэг юм. Тэхээрээ усны тэр гүнд живж орсон цагтаа мянга таван зуун метр шоо дөрвөлжин ус буюу нэг тонн ус түрж гаргадаг юм.

Усан доогуур явахад зарцуулагдсан энэхүү хөлгийн төлөвлөгөөг би хийхдээ түүнийг усанд оруулж тавихад түүний багтаамжийн аравны есөн хувь нь далайд далд орж, аравнынэг хувь нь ил гарч байх зорилго урдаа тавьсан. Иймэрхүү нөхцөлд хөлөг онгоц өөрийнхөө багтаамжийн аравны есөн хувийг буву мянга гурван зуун тавин метр шоо дөрвөлжин ус түрж гаргаад мөн төдийчинээ тонн жинтэй болох ёстой байсан. Тийм болохоорби энэ жингээс хэтрүүлж хүндрүүлэхийн хэрггүй байв. “Наутилус” гадуур ба дотуур гэж хоёр давхар торхтой нь хоорондоо доогуураа залгагдсан дармал “т” үсгийн хэлбэртэй хөндлөн огтлол бүхий төмөр хөндлөөр холбогдсон тул түүний улмаас ер бусын бөх чанарыг олсон юм. Үнэндээ ч “Наутилус” иймэрхүү давхар торхтой хийгдсэн нь нэн их бэхжиж цул цутгамал байхаас ч дутсангүй. Түүний өвч хуяг үл хотойхоос гаднахийсэн материал нэг төрөл бэхэлгээбат учраас далайн ямар ч шуурганд зад үсэрнэ гэж айх явдалгүй. Энэхүү давхар торхыг нимгэн төмрөөр хийсэн юм. Дотоод торхны зузаан нь таван сантиметр орчим гурван зуун ерэн тонн хүнд юм. Түүнчлэн өндрөөшөө тавь, өргөөшөө хорин таван сантиметр гадаад торх килийн хамт жаран тонн, машинууд, бусад тоноглол дотоод халхавч хана тавилга, тулгуур энэ бүхэн бүгд есөн зууг тонн ингээд дотоод торхны гурван зуун ерэн тоннтай хамт нийт бидэнд хэрэгтэй мянга гурван зуун тавин тонн болдог юм. Та ойлгов уу?

-Ойлголоо.

-За тэгвэл “Наутилус” далайн усны гадаргуу дээр хөвж байхдаа аравны нэг хувь нь ил гарч байдаг гэсэн биз. Тэгвэл энэ хөлгөн дээр тэрхүү аравны нэг хувьтай тэнцүү багтаамж сав байгаад түүнийг усаар дүүргэвэл мянга таван зуун метр шоо дөрвөлжин эзэлхүүнийг буюу эсхүл ямар ялгаа байх вэ, мянга таван зуун тонн ус түрж гаргадаг “Наутилус” онгоц маань усанд бүхлээрээ живж, орчих ёстой болох нь

ээ. за тэгвэл яг энэ чинь л хэрэг дээрээ биелж байгаа юм аа. Тэгвэл “Наутилус” дээр түүний доод хэсэгт тусгай багтаамж сав бий. Ганцхан кран эргүүлчихлээр л тэр сав усаар дүүрч “Наутилус” далайн уснаа далд живж ордог юм.

-Аргагүй л агуу байна, капитан минь. гэлээ ч гэсэн минийхээр бол яг энд л хамгийн гол саад учирч байгаа мю биш үү.

-“Наутилус” нэг ч сантиметр цухуйхгүй гээд усанд живж орохыг би ойлголоо. Гэтэл гүнзгийрэх тутам таны хөлөгт хэтэрхий их даралт учирдаггүй гэж үү? Энэхүү даралт таны онгоцыг доороос нь дээш нь усны гучин хоёр фут давхарга тус бүрд барагцаалбал нэг сантиметр атмосфертэй тэнцэх хүчээр буюу өөрөөр хэлбэл нэг сантиметр шоо дөрвөлжин хавтгай дээр энг килограммын хүчээр түлхдэггүй гэж үү.

-Тун зүйтэй эрхэм профессор хэмээн капитан Немо хэлээд статистикийг динамиктэй хутгаж болохгүй, тэгвэл үүний улмаас ноцтой алдаа гарах болно. далайн их гүнзгийд хүрэхийн тул их хүч гаргахын хэрэг ер байхгүй. Тэгвэл та миний яриаг анхааралтай бодож чагна л даа? гэлээ.

-Таны ярьж байгааг би хичээнгүйлэн сонсож байна.

-“Наутилус”-ыг далайн гүнд живүүлэхэд тэрний жинг хэд хичнээн хэмжээгээр ихэсгэх хэрэгтэй вэ гэдгийг олохын тул би далайн янз бүрийн гүнд дээрх давхаргуудын хүндийн жин, даралтын доор далайн ус, эзэлхүүнээ хэд хичнээн багасгадгийг бодож гаргах хэрэгтэй болсон.

-Тэр мэдээжийн хэрэг.

-Гэвч ус нягтардаг чадвартайг нягтрахдаа маш бага хэмжээгээр нягтарч эзэлхүүнээ багасгадгийг үгүйсгэж болохгүй ээ. Үнэндээ ч хамгийн сүүлийн мэдээгээр авч үзвэл далайн ус гучин футын гүнд даралтын хэмжээ нэг атмосферээр өсөхөд өрвөн саяны дөрвөн зуун гучин зургаан хувиар нягтардаг байна. тэгвэл мянган метрийн гүнд живж ороход мянган метр өнөдр усан баганын даралтаас буюу зуун атмосферийн даралтаас далайн усны эзэлхүүн хэд хичнээн багасах нь вэ гэдгийг авч үзэх хэрэгтэй. Тэгвэл тэрхүү эзэлхүүний багасалт нь тэг бүхэл зуун мянганы дөрвөн зуун гучин зургаа болно. Үүний улмаас хөлөг онгоцны жин мянга таван зуун тонн байхаас таван зуун зургаан бүхэл зууны тавин дөрвөн тонн болж өсөх ёстой. Үүнээс авч үзвэл шаардагдах жингийн өсөлт зөвхөн зургаан бүхэл зууны тавин дөрвөн тонн болжээ.

-Ердөөн үү?

-Ердөө л тэр эрхэм Аронакс, үүнийг шалгахад ч хялбархан. Түүний зэрэгцээ надад зуун тоннын багтаамж савууд байдаг юм. Түүний ачаар их хэмжээний



гүнд орж чаддаг юм. Усан дээр хөвж гарахын тул би энэхүү нэгдэл багтаамжуудыг л хоосолчихвол гүйцэх нь тэр. Хэрэв “Наутилус” өөрийн эзэлхүүний аравны нэгэн хувийг усан дээр ил гарган өх хэрэгтэй бол би бүх л усны багтаамж савыг хоослох хэрэгтэй болно.

Эдгээр тоо баримтууд дээр тулгуурласан энэхүү ярианы эсрэг маргах ямар ч тал надад алга байна.

Капитан таны эдгээр тоо баримтыг би хүлээн авах байнам. Нээрээ ч тэдний эргэлзээгүй зөв болох нь өдөр бүр хэрэг дээрээ нотлогдож байгаа юм чинь маргах гэхэд инээдтэй хэрэг болох буйзаа. Гэлээ ч гэсэн надад бас нэг эргэлзэх тал байна гэж би хэлбэл :

-Ямар гэж асуулаа.

-Та мянган метрийн гүнд ороход “Наутилус”-ын их бие зуун атмосферийн даралтыг үздэг биз. Тиймээ, хэрэв та иймэрхүү гүнзгийд багтаамж саваа суллаж онгоцоо хөнгөтгөөд дээшээ хөвж гарахыг бодвол багтаамж савнуудаас үе юүлэх шахуургаар энг сантиметр шоо дөрвөлжин хавтгай тус бүр дээр зуун килограмм нэмэгдэл эсэргүүцлийг давж гэмээ нь саваа суллах хэрэгтэй боло бий. Тэгвэл энэ чинь шахуургаас их чадлыг ...

-Тэр их чадлыг зөвхөн л цахилгаан өгч чадна хэмээн капитан Немо миний үгийг таслан хэллээ.

Миний машины чадал бараг хязгаргүй гэдгийг давтаж хэлвэ, эрхэм профессор. “Наутилус”-ын шахуургууд ер бус чадалтай “Авраам Линкольн”-ны тавцан дээр түүний шахсан усан оргил хүрхрээ мэт нэвсийн бууж байсныг та мэдэх л ёстой. Жич, би цахилгаан тэжээлээ хэт ажиллуулахгүйн тул мянга таван зуугаас хоёр мянган метр хүртэл гүнзгийд живэх үедээ хийннэмэгдэл багажууд хэрэглэдэг. Хэрвээ миний толгойд далайн хамгийн гүн хэсэгт түүний гадаргуугаас наймаас арван мянган метрт жуулчлах дон шүгэлбэл би дээрхээс арай өөр боловч мөн л адил найдвартай өөр арга хэрэглэдэг юм.

-Ямар арга байх билээ, капитан?

-Түүнийг танд сайн ойлгуулахын тул би эхлээд “Наутилус”-ыг хэрхэн жолооддог тухай ярьж өх хэрэгтэй.

- Би дуулах юмсан гэж хорхой хүрээд байна.

-Энэхүү хөлгийг баруун буюу эсхүл зүүн тийш нь өөрөөр хэлбэл хэвтээ хавтгайд эргүүлэхийн тул би хитгэн доор бэхлэгдсэн ердийн залуур хэрэглэдэг юм. Энэ залуурыг тусгай жолоо ба жолоо татуургаар хөдөлгөдөг. Түүнчлэн бас

“Наутилус”-ыг босоо хавтгайд дээрээс нь доош доороос нь дээш нь залж болох ба үүнийг ол шугам дээр хөлөгний хоёр бөөрөнд сул бэхэлсэн хоёр хавтгайн тусламжтай гүйцэтгэнэ. Энэ хоёр хавтгай хөлгийн өрцтэй зэрэгцээ шугаманд байгаа цагт “Наутилус” түвшин шугамаар хөдөлнө. Хэрэв тэдгээрийг хазайлгавал сэнсний эргэлтэнд хөөгдөж буй “Наутилус” хазайлтын өнцгөөс шалтгаалж диагнолоор эсхүл өгсөнө, эсхүл уруудана. Тэхдээ энэхүү диагнолийн урт хичнээн байх нь миний эрх. Хэрэв би эгц өөдөө гаръя гэвэл сэнснийхээ эргэлтийг зогсооход усны доороос түлхэх түлхэлт “Наутилус”-ыг босоошугамаар устөрөгчөөр цэнэглэсэн бөмбөг шиг хөөж гаргадаг юм.

-Догь хэрэгээ, капитан хэмээн би дуун алдаж орхиод усан доор яваа “Наутилус”-ыг сохроор жолооддог байх нь ээ? гэж асуулаа.

-Ердөө ч тийм биш. “Наутилус”-ын урд хэсэгт байгаа бөмбөгөрт жолоо байдаг юм. Тэр бөмбөгөрийн гэггвч хавтгай зузаан шил байдаг.

-Шил тэгээд ийм их даралтыг даана гэж үү?

-Даана аа. Унагахад буюу доргихдоо үйрчихмээр мөртөө болор гэдэг чинь нэн их бөх чанартай байдаг. 1864 онд умарт далайд цахилгаанаар гэрэлтүүлэн загас барих ажил зохиож байх үед долоон миллиметр зузаан хавтгай болор арван зургаан атмосфер даралт дааж байсан юм шүү. Тэгвэл миний хэрэглэж буй шил голдоо хорин нэгэн сантиметр буюу миний саын ярьсан хавтгай болроос гуч дахин зузаан юмдаг.

-Би ойлголоо. Гэвч замаа харахын тул нүдгүй харанхуйг чинь гэрэлтүүлэх хэрэгтэй бол би бодохдоо яаж энэхүү гүнзгий харанхуй дтор чинь... гэхэд капитан миний үгийг тасалж

-Залуурын бөмбөлбгний ард нэн их гайхалтай цахилгаан дэн бий хэмээн хэлээд түүний цацраг урагшаа хагас миль газар ус нэвт гийгүүлдэг юм.

-Гайхалтай юм капитан минв, тун гайхалтай байна. эрэдмтдийг тэгж их төөрөгдүүлсэн, тэрхүү гайхал нарвалын цацаргасан гэрэл цахилган наран чухам ямар учиртай нь одоо л надад ойлгогдлоо. Гэвч дэлхий дахиныг тэгж их шуугиулсан “Наутилус”, “Шотланд” хоёрын мөргөлдөөн ердийннэг тохиолдол уу, үүнийг мэдэхийг хүсвэл болохсон болов уу?

-Ёстой санамсаргүй тохиолдол болсон юм шүү, профессор гуай!  
Мөргөлдөхөөс өмнө би хоёр метрийн гүнд явсан юм, гэвч ямар ч гай болоогүй би тэр даруйхан харсан л даа.

Тийм ээ тийм ямар ч гай болоогүй. “Шотланд” онгоц ч зогсоолдоо мэнд хүрсэн

л дээ. тэгвэл “Авраам Линкольн” –той дайралдсаныг тань юуг эж тайлбарлах вэ?

-Эрхэм профессор, тэр бол америкийн далайн эрэлхэг цэргийн шилдэг хөлөг гэдгийг би аргагүй хүлээх боловч над руу довтолсон шүү дээ. Тиймээс би биеэ хамгаалах хэрэгтэй байсан. Үүний дашрамд хэлэхэд би зөвхөн л түүний над руу дайрах бололцоог нь үгүйсгэснээр л хязгаарласан шүү дээ.Тэхээр тэр хамгийн ойролцоо буй зогсоолд хүрч гэмтлээ засварлахад төдий л их бэрхтэй биш ээ.

-Ай капитан “Наутилус” гэдэг үнэхээр гайхамшиг хөлөг санж хэмээн миний бахархал:

-Тиймээ профессор гэж тэр мэдэгдэхүйц сэтгэл хөдөлсөн байдалтайгаар хэлээд :

-Би түүндээ төрсөн үр шигээ хайртай, хэрэв далай дээгүүр хөвдөг хөлөг онгоцонд мянга мянган аюул заналхийлж ямар нэгэн санамсаргүй гэнэтийн тохиолдол гай болдог юм бол энд, далайнэнэхүү гүнд хүн юунаас ч айх юм алга. Далайн ус бяц дарчихна гэж айх юм алга, тэгвэл энэ хөлгийн их бие төмрөөс ч бөх, үүнд далайн сэгсрэлтээс болж суларчих, ганхчих, төхөөрөмж алга, салхи хуу татаад явчих далбаа алга, тэсэрчинэ гэж айх уурын тогоо алга, онгоцон дээр модон хэсэг байхгүй тул түймэр гарахгүй, түүнчлэн далайн гүнд ганцаар тэнүүчлэх учраас мөргөлдөхийн аюул байхгүй энх амгалан налайж байдаг тул далайн шуурга ч аюултай бус. Тэхээр аргагүй л гойд хөлөг байгаа биз дээ, профессор гуай! Хэрвээл хөлөг онгоц сэдэвлэгч хүн уул онгоцыг хийгч хүнээс өөрийнхөө бүтээлд хол илүү итгэдэг гэдэг үнэн бол түүнчлэн тэрхүү хөлгөндөө мөн илүү итгэдэг болби энэхүү хөлгийг сэдэвлэгч нь ч, хийгч нь ч жолоодогч нь ч болох учраас онгоцондоо “Наутилус”-даа хичнээн хайртай хичнээн гүн итгэдэг болох нь танд аяндаа ойлгогдох буйзаа гэж ярилаа.

Энэ бүхнийг капитан Немо сэтгэл их лхөдөлсөн байртай ярьж байв.

Түүний нүдэнд бадарч байсан гал, түүний биеийн эрс хөдөлгөөн түүнийгшал өөр болгожээ. Тэгээд ч би тэсч чадсангүй. Түүнд :

-Тэхээрээ та инженерийн мэргэжил олсон хүн юмаа? гэсэн арай эвгүйдүүхэн болов уу гэмээр нэг асуулт тавьчихад :

-Тиймээ. Би хуурай газрын оршин суугч байхдаа Лондон, Париж, Нью Йоркт суралцаж байсан гэж хариулав.

-Тэгвэл та энэ усан доогуур явдаг гайхамшиг хөлөг онгоц барих ажлыг яаж нууц байлгасан юм бэ?

-Түүний хэсэг тус бүр нь эрхэм профессор бөмбөрцгийн янз бүрийн

өнцөг буланд, тэхдээ хуурамч зохиол үүрэг зорилготой хийгдсэн юм. “Наутилус”-ын килийг Францад Крезогийн заводод, сэлүүр голыг Лондонгийн Бэн ба К-гийн үйлдвэрт, сэнсий нь Глазгод Сеотын заводод, багтаамж савуудыг Парижид, Кайл ба К-гийн, хөдөлгүүрийг Германы Круппын заводод, мөргүүлийг Шв?йцэд Мотаны фабрикт, шалган хэмжих багажуудыг Нью-Йоркт ах дүү Гарт нарын үйлдвэрт гэх мэтчилэн хийлгэсэн юм даа. Эдгээрийг үйлдвэрлэгчид өөр нэрээр нэрлэсэн миний зургуудыг авч хийсэн.

-Гэлээ ч гэсэн хэсэг хэсгээр нь хийлгэх ч бага хэрэг шүү дээ. тэдгээрийг чинь нийлүүх угсрах хэрэгтэй биз гэж би хэлэв.

-Би далайн дунд орхигдсон нэгэн зэлүүд арал дээр өөртөө хөлөг онгоцны үйлдвэр босгосон юм. Тэнд миний сургасан ажилчид, үнэнч нөхөд, миний хяналтын доор “Наутилус”-ыг угсарсан юм. Хөлөг онгоцны угсралт дууссаны дараа арал дээр байсан бидний мөрийг түймэр аваачсан юм. Миний хүч хүрдэгсэн бол арлы нь ч тэр чигээр нь дэлбэлчих байсан.

-Ердийн төмрөөр хийсэн хөлөг онгоцны тонн тус бүр мянга нэг зуун хорин таван франкийн үнэтэй. Тэгвэл миний “Наутилус” мянга таван зуун тонн жинтэй. Үүнээс үзвэл хэрэв л үүний бүх дотоод тавилга төхөөрөмжийн үнийг оролцуулбал хоёр сая франкаас доошгүй болохоос гадна энд хадгалагдаж байгаа урлагийн үнэт бүтээлүүд, цуглуулгуудыг бодож үзвэл дөрөв таван саяас наашгүй дээ.

-Танд хамгийн сүүлчийн ганц асуулт тавьж болох уу?

-Тэг л дээ профессор

-Та их баян хүн үү?

-Би хэмжээгүй баян, францын арван миллиардын улсын өрийг хоосрол зүдрэлгүй төлчих чадал байна.

Би тэр этгээд хачин хүнийг нүд салгалгүй ширтэж билээ.

Тэр миний итгэмжлэлээр элэг барьж байв уу? Аль яах вэ?

-Гэвч энэ бүхнийг ирээдүй л харуулах болно доо.

[Тор](#)

## “ХАР МӨРӨН”

Дэлхийн бөмбөрцгийн гурван зуун жаран нэгэн сая хавтгай дөрвөлжин метр талбайг ус эзэлнэ. Энэ их усны нийт эзэлхүүн нь нэг мянга гурван зуун далан сая шоо дөрвөлжин метртэй тэнцэнэ. Үүнээс үзвэл дэлхийн бөмбөрцөг дээр байгаа усны хүндийн жин мянга гурван зуун далан квинтиллион тонн хүрдэг байна.

Энэ тоог ойлгох гэвэл нэгжтэй нэг миллиард хэрхэн харьцдагчлан миллиардтай нэг квинтиллион мөн адил харьцдаг гэдгийг мэдэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл нэг миллиардад хичнээн нэгж байдагчлан нэг квинтиллионд төчнөөн миллиард байдаг.

Газар дэлхийн идэр залуу үед гал халуун галав юүлж усан галав залгажээ. Тэнгис далай эхлээд бөмбөрцгийг буйгаар нь хучиж байгаад Силурийн үед уул үүсэх хөдөлгөөн эхэлж бага багаар далай татарсаар тэнгис далайгаар уулсын орой шовойн гарч арал хойгууд нэг ил гаран зарим үе далд орон, сүүлдээ бүхлээрээ тив болон бэхжээд одоогийн бидний харж байгаа хуурай газрын хэлбэрийг олжээ. Ингээд хуурай газар далайгаас зуун дөчин сая зургаан зуун мянга долоон хавтгай дөрвөлжин метр газар булаан авчээ.

Тивүүдийн хэлбэр дэлхийн бөмбөрцгийг таван том хэсэгт хуваах боломжийг өгдөг. Үүнд :

Умарт мөсөн далай

Өмнөт мөсөн далай

Энэтхэгийн гадаад далай

Атлантын гадаад далай

Номхон дөлгөөн гадаад далай эдгээр болно. Номхон дөлгөөн гадаад далай умраас өмнө зүгт туйлын хоёр бүслүүр өрнөөс дорно зүгт Ази, Америк хоёр тивийн хооронд бөмбөрцгийн зуун дөчин таван хуваарийг тууш эзлэн оршино. Энэ бол бүх далайнуудын дундаас хамгийн дөлгөөн тогтуухан өргөн урсгалтай таталт түлхэлт багатай, бороо хур ихтэй тэнгис билээ.

Миний ер бусын жуулчлалаа эхэлсэн тэнгис иймэрхүүсэн билээ.

-Хэрэв та хүсэхсэн бол эрхэм профессор хэмээн капитан Немо надад хэлээд манай шинэ жуулчлалын эхлэх цэгийг одоо бидний байгаа орчин яг олчихъё. Одоо арван хоёрт арван таван минут дутуу байна. Би “Наутилус”-д дээш гарах тушаал өгөөдөхье гэж хэллээ.

Үүнийг хэлэхийн хамт капитан цахилгаан хонхны товрууг гурван удаа дарлаа. Усны шахуургууд багтаамж савуудаас ус юүлэн эхэлж, тэдгээр савын даралтыг хэмжих багажийн зүү даралт улам бүр багасаж буйг заан дээшил дээшилсээр тэг дээр очмогцоо яг зогсов.

-Бид хөвж гарлаа гэж капитан Немл хэлэхэд би гол шат руу одож, төмөр гишгүүрээр нь дамжсаар таг бүхий онгорхойгоор дээш гарч ирвэл “Наутилус”-ын тавцан дээр гарсан байлаа.

“Наутилус”-ын тавцан уснаас наян сантиметрээс илүүгүй цухуйжээ. Түүний ээрүүл хэлбэрийн их бие яах аргагүй янжуур маягтай ажээ. Түүний төмөр өвч хуурай газрын мөлхөгч аварга амьтны арьс мэт болохыг би ажиглалаа. Одоо л надад яагаад бусад онгоц “Наутилус”-ыг амьтан гэж ойлгож эндүүрч байсан нь ойлгогдов.

“Наутилус”-ын их биед хагас далдлагдсан хөнгөн завь хөлгийн тавцангийн дунд хэр их бус овгор үүсгэсэн ажээ. Түүний хоншоор ба хитгэ хоёрт зузаан болроор шиллэсэн гэгээвч бүхий налуу бүхээг нижгээд байв.

Урд талын бүхээгт жолооч байрлах бөгөөд ар талынхад нь замаа гэрэлтүүлэгч нүд гялбам хурц цацралтай цахилгаан дэн байх ажээ.

Далай амгалан, тэнгэр цэлмэг байхын зэрэгцээ тэгисийн хавтгайрсан долгион дунд хөлөг онгоц үл мэдэг халбилзан, дорно зүгийн зөөлөн салхи усны өнгийг бэржилзүүлэн байлаа. Юунд ч үл бүдгэрэх тод ялгаран харагдагч далайн түвшний зурвас шугам ажиглалт хийх дүүрэн бололцоог хангаж өглөө.

Далайд арал, хад, энэ тэр юм юу ч харагдахгүйн зэрэгцээ “Авраам Линкольн” ч үзэгдэхгүй ажээ.

Биднийг эрэг хашлагагүй агуу сүрлэг зэлүүд цөл бүсэлсэн байв.

Капитан Немо жин үд болохыг хүлээж байгаад секстант хэмээх багаж нүдэндээ аван дурандсаар нарны хөөрөлтийн өндрийг тодорхойлсон нь түүнд энэхүү орчны өргөргийг бодож гаргахад хэрэгтэй ажээ.

- Үд болжээ. Профессор та доошоо бууж орохгүй юу? гэж хэллээ.

Би Японы эрэг газар ойртсон болохын баталгаа, шаравтар өнгө орсон далайн ус руу сүүлчийнхээ удаа хараад капитаны араас дагалдан үзэсгэлэнт танхимд орж очлоо.

Капитан Немо тэнд нарийн цагийн тусламжаар тэрхүү орчны уртрагийг бодож олоод, дүнгий нь урьд өмнийн өнцөг хэмжилтийн ажиглалттай тулган шалгаж “Наутилус”-ын байгаа цэгийг зураг дээр тэмдэглэв.

-Эрхэм Аронакс бид одоо уртрагийн 137<sup>0</sup> 15'-талд байна гэж тэр хэлэхэд би,

-Ямар уртрагаас тоолоод тэр билээ? хэмээн түүний хариултаар нь чухам ямар

үндэсний хүн болохы нь мэдэх горьдлоготой асуучихлаа.

-Надад Париж, Гринвич, Вашингтон аль алины нь цагаар тавьсан янз янзын нарийн цаг бий. Гэвч би таны энд морилон байгаад зориулан өнөөдөртөө Парижийн уртрагийг ашиглалаа гэж хариулав.

Энэ хариултаас би юу ч олж авсангүй. Би баярласны тэмдэг болгож зөвхөн л мэхийн ёслов.

-Бид Парижийн меридианаас өрнөт уртрагийн  $137^{\circ} 15'$  умарт өргөргийн  $30^{\circ} 7'$ -нд явж байна. Өөрөөр хэлбэл бид Японы эргээс гурван зуун миль зайтай байна. Ингэхлээр чинь өнөөдөр, арван нэгдүгээр сарын найман, одоо яг үд дунд усан доогуур дэлхий тойрох эрдэм шинжилгээний жуулчлалаа эхэллээ. За тэгээд эрхэм профессор, одоо танд би ажиллахад тань саад хийхийг больё. Би дорнот умарт дорнот зүгт чиглэл авч тавин метрийн гүнд живж орох тушаал өгсөн. Газрын энэ том зураг дээр өдөр тутмын аялсан зам тэмдэглэгдэж байх болно. Үзэсгэлэнгийн танхим таны таалалд бүрмөсөн үлдлээ гэж капитан немо хэлээд мэхийн ёсолсны дараа гарч одов.

Үзэсгэлэнгийн танхимд би өөрийн бодолд “Наутилус”-ын капитан байсхийгээд л орж ирэх ажээ.

Өөртөө эх орон байхгүй гэж бардам загнаж байгаа энэ хүний үндсэн угсааг мэдэх цаг надад байдаг болов уу? Юунаас болж, хэнээс болж энэ хүн төрөлхтөнийг үзэн ядах болов оо? Эсвэл тэр Конселийн хэлдгээр орчин үеийн Галилей буюу эсвэл эх орноосоо хөөгдсөн хувьсгалч эрдэмтэн байгаад эрдэмтэн гэж үзэгдээгүй “Энэ ертөнц гомдоочихсон” тэдгээр эрдэмтдийн нэг байв уу? Үүнийг би тайлбарлаж мэдэхгүй байв.

Хөлөг онгоцныхоо тавцан дээр санамсаргүй шигдчихсэн намайг найрсгаар хүлээн авсан боловч түүний хүйтэн царайлах тэр байдал миний амьдрал түүний гарт гэдгийг мартагдуулахгүй байв. Тэр урдаас нь сунгасан миний гарыг нэг ч удаа атгаагүй бөгөөд гараа над руу нэг ч удаа сунгаагүй билээ.

Энэ хүний сэтгэл догдлуулан буй нууцад нэвтрэн орохыг оролдож бүтэн цагийн турш би бодолд нэрвэгдэж суулаа.

Дараа нь миний хараа ширээн дээр байгаа газрын зураг руу хандаж капитан Немогийн гаргасан уртраг өргөрөг хоёрын огтлолцол дээр би хуруугаар дарав. Тэнгис далай, тивүүдийн нэгэн адил өөрөө урсгал голуудтай байдаг билээ. энэхүү урсгал бусад урсгалаас өнгө болоод халуун хүйтнээрээ ялгаварлагдана. Тэнгисийн хамгийн нэртэй том урсгал бол Гольфстримын дулаан урсгал юм.

Газрын зураг дээр шинжлэх ухаан гол таван урсгал чиглэлийг тэмдэглэсэн юм. Үүнд : Нэгийг нь Атланын далайн умарт хэсэгт, нөгөөг нь өмнөт хэсэгт нь, гуравдахий нь Номхон далайн өмнөт хэсэгт, дөрөв дэхий нь умарт хэсэгт, тавдахий нь Энэтхэгийн далайн өмнөт хэсэгт тус тус тэмдэглэжээ. Эрт дээр үед Арал, Каспийн тэнгис, Азийн том хуурууд хамтдаа усны нэгэн том сав болж Энэтхэгийн тэнгисийн умарт хэсэгт зургаа дахь том урсгал байсан ч юм билүү яаж мэдэхэв.

Газрын зураг дээр цэгээр тэмдэглэсэн “Наутилус”-ын зогсож байсан тэр орчинд тэдгээр урсгалын нэгэн Куро Сиво буюу Япон хэлнээс орчуулбал “хар мөрөн” хэмээх урсгал дайрч өнгөрсөн байв. Энэхүү урсгал халуун орны шатаам халуун нарны эгц тусгалд халж Бенгалийн булангаас гарч, Малаккийн хоолойгоор өнгөрөөд, Ази тивийн эргийг дагаж явсаар Алеутийн арлуудыг хүртэл Номхон далайн умарт хэсэгт дугуйрч ургана.

Энэ урсгал гаврын мод ба халуун орны бусад модны гол, үе гишүү урсган аваачихаас гадна тод цэнхэр өнгө, өндөр температураараа далайн хүйтэн хар ногоон уснаас ялгагдана.

“Наутилус”-ын зам энэ урсгалыг дагах байв. Би урсгалын хойноос зураг дээр хөөн харж зах хязгааргүй тэрхүү орчинд хэрхэн замхран одохыг нь санаандаа дүрслэн бодож, үнэн бодит байдлаас хэтэрхий холдон одсон тул, Нед Ленд, Консель хоёр өрөөнд орж ирэхийг мэдсэнгүй ээ.

Намайг даган яваа хоёр хүн өөрсдийн нүдний өмнө буй эрдэнийн санг хараад бараг хөшилдчихсэн билээ.

-Энэ чинь бид хаана орчих нь энэ вэ? Арай Квебекийн музейд биш байгаа? Хэмээн канадын харъяат дуу алдлаа.

-Эзэн хэрвээ зөвшөөрөхсөн бол би Сомерар буудалд байна хэмээн бодохсон байнам гэж Консель хэллээ.

-Миний найз нараа! Та нар Канадад ч биш, Францад ч биш харин “Наутилус” онгоцон дотор далайн түвшнээс доош тавин метрийн гүнд байна гэж миний хэлэхэд :

-Эзэн хэлж байгаагаас хойш үнэмшихээс биш яахав, гэвч үнэнийг хэлэхэд, энэ музей над мэтийн фламанд хүнийг ч гайхуулж чадах ажээ гэж Консель хариу өчив.

-Миний найз бахаа ханатал гайхаж болно. түүнийхээ зэрэгцээ шилэн гүнгэрвээтэй зүйлийг ч үз. Тэнд чам шиг ангилан хуваарилагч хүнд хийх ажил мундахгүй гэв.

Амьтдын хүрээлэнг ангилан хуваарилахад Конселийг дахин шаардах ч явдалгүй билээ. шилэн гүнгэрваанууд дээрээс тэр тонгойж байгальч хүний хэлээр



анги, отряд, доод отряд, баг, төрөл, дүрс ... гээд шулганаж сонслоо.

Тэр завшаанаар конхиологийн ухаанаар төдий л их оролддоггүй Нед Ленд капитан Немотой миний учирсан тухай шалгааж түүнийг хаанахын хэн болох, хаашаа явж байгаа, бид бүхнийг аль хэр гүнзгий рүү аваачиж буй зэргийг асууж орхилоо.

Канад хүн намайг өчнөөн төчнөөн асуултаар булж ганцад нь хариулах бололцоо өгснгүй ээ.

Түүний дуугүй болсны дараа би өөрөө юу л мэдэж байсан бүхнээ түүнд уламжлаад, мөн энэ хугацаанд тэр юу үзэж юу дуулсныг нь асуув.

-Юу ч үзэж, юу ч дуулсангүй. Түүгээр ч барахгүй би энэ хөлгийн багийнхнаас нэг ч хүн олж харсангүй. Багийнхан нь ч бас цахилгаан хүмүүс байдаг байх аа гэж канад эр хэллээ.

-Цахилгаан?

-Бүр үнэн үг, үүнд итгэж бараг болно шүү... за тэр ч яахав, эрхэм профессорминь хэл, та, энэ онгоцны баг бүгд хэдэн хүн байгаа вэ? арав уу, хорь уу, тавь уу, зуу юу? хэмээн мөн л өнөө үзэлдээ автагдсан Нед Ленд маань асууж билээ.

-Танд би юу ч хэлж чадахгүй нь Недээ "Наутилус"-ыг гартаа оруулах буюу эндээс оргох гэсэн бодлоо та наад толгойноосоо хая. Энэ хөлөг бол одоо үеийн техникийн хамгийн гайхамшиг. Хэрэв би үүнтэй аль болохоор сайн танилцаж чадаагүйсэн бол бүх насандаа гэмшихсэн билээ. та бидний энэ байдалд, ядаж энэхүү гайхамшигуудын дунд жуулчлахын тул олон хүн бидэнд атаархахсан буйзаа. Ингэхэд та номхорч үз, тэгээд бидний эргэн тойрон болж буй энэ бүхнийгажиглая.

-Ажиглая аа? хэмээн жадчин маань хэлээд, үгүй ээ, энэ төмөр гянданд чинь юугаа үзэх юм бэ? Бид чинь таг сохор явж байхад гэж бархирав.

Нед Ленд үгээ дуусаагүй байтал үзэсгэлэн танхим пид харанхуйн дунд шингэлээ. Гэрэлтэж байсан тааз гэв гэнэт унтрахад миний нүд өвдсөн бөгөөд хэрэв би харанхуйд байгаад хурц гэрэл гэнэт харсан бол миний нүд мөн л өвдөх байсан биз.

Бид айх гайхах зэрэгцэн, хөдөлж ч чадахгүй хөшилдөн зогсоцгоож, сайн муу алин болохыг мэдэхгүй байтал "Наутилус"-ын төмөр хуяг гулсах мэт чимээ гарч, сүрчигнэх хөдөлгөөн мэдэгдлээ.

Нед Ленд :

-Өнгөрөх нь тэр ээ гэлээ.

Гэвч үзэсгэлэн гэв гэнэт гэрэлтэв. Гэрэл онгоцны хоёр талын хананд буй зуйван цонхоор гаднаас нэвтэрч байлаа. Усны гүн цахилгаан чийдэнгээр тод гэрэлтүүлэгдсэн ажээ. Эхлээд би энэхүү хэврэг халхавч бяц үсэрнэ гэсэн бодолдоо

дав хийж асан боловч гэгээвчний зузаан зэс жаазыг хараад санаа амарлаа. Тэр жааз гэгээвчинд ер бусын үзэгдэл гэж санана. Усны тунгалаг давхаргыг нэвт туссан цахилгаан цацралын гайхамшиг өнгө гэрлээс сүүдэр рүү бүдгэрсэн зөөлөн хувиралт, бичиж болшгүй баялаг солонгоорол зэргийг хэн зурж чадах билээ.

Далайн ус булгийн хамгийн цэвэр уснаас тунгалаг чанартайг бүгд мэднэ. Далайн усанд хөвсөн ба ууссан давсууд түүний тунгалаг чанарыг улам өсгөдөг юм. Далайн зарим хэсэгт жишээлбэл Антилийн арлуудын дэргэд далайн хэд хэдэн арван метр зузаан усыг нэвт ёроолын элсний ширхэг тус бүр тод харагддаг биш үү.

Далайн гүнд бадарсан цахилгаан гэрэл “Наутилус” тойрон буй шингэн орчинг галын шингэн дөлийн урсгал болгон хувиргасан мэт байв.

Хэрэв усны гүнзгий давхаргууд өөрөө гэрэлтдэг гэсэн Эрэмберийн таамаглалыг зөв гэж үзэх юм бол байгаль гүн уснаа оршин суугчдад үзэгдэж харагдаагүй гоё сайхан үзэгдлийг хүртээсэн ажээ. Би “Наутилус”-ын гэгээвчээр харж усан дотор бүжиглэх гэрлийн наадмыг үзээд үүнд үнэмшиж болох байв.

Үзэсгэлэнгийн хоёр тал руу үл мэдэгдэж, үл шинжлэгдсэн Ертенцийн зүг нижгээд цонх нээгдсэн ажээ. Үзэсгэлэнд хүглийж буй харанхуй гадаахийг гэрэлд тодосгох тул бид аврага том (аквариумын) шил сав нэвт харж буй мэт байв. Энэ хэр “Наутилус” хэдий хурдалж агсан боловч зогсож байгаа юм шиг санагдана. Үүний учир нь юу гэвэл бидний цонхны харалдаа онгоцны явж буйг илтгэх үл хөдлөх, юм байсангүй тул билээ. Гэвч усан доогуур явагчийн хушуугаар ярагдсан усны хөврөл бидний нүдний урдуур асар их хурдтай жирэлзэн өнгөрч байв. Гайхаж гөлөрчихсөн бид гэгээвчний шилэнд наалдан ширтэж өөрсдийн сэтгэгдлийг илэрхийлэх үг эс олсон бүлгээ. Гэтэл Консель ашгүй нэг:

-За найз. Нед Ленд та юм харах гэлүү? За хараад байгаарай! гэж дуун гарлаа.

-Сонин л юм. Сайхан л юм. Энэхүү гайхамшиг орчлонг сонирхох гэж алс холоос ирэхэд ч аргагүй л болох байна! хэмээн Канад хүн маань энэхүү гойд үзэсгэлэнт үзэгдэлд автан оргох бодол, уур хилэнгээ таг мартаж хариу өгүүлэв.

-Капитан Немогийн амьдрал одоо л надад ойлгомжтой боллоо. Тэр өөртөө тэс өөр ертөнцийг бий болгоод түүнийхээ гуа жавхлангаар сэтгэлээ тэжээж яваа хүн санж.

-Үгүй ээ, тэгээд загас хаанаа байнаа. Бид загас олж харахгүй байна гэж канадын харъяат асуулт тавилаа.

-Тэртэй тэргүй та тэднийг мэдэх биш дээ, байсан байгаагүй ямар ялгаа байсан юм? хэмээн Консель хариулахад, Нед Ленд бачимдан:

- Яалаа гэнээ? Нөхөр минь би загасчин хүн шүү гэж хашгарлаа.

Хоёр нөхрийн хооронд маргаан дэгдсэн бөгөөд загасыг тэр хоёр дор дороо өөрийнхөөрөө л мэддэг билээ. Ер загасны аймаг сээр нуруутны хүрээний түрүүчийн анги үүсгэдгийг хэн бүхэн мэднээ. Тэдэнд шинжлэх ухаан “усанд зохицсон заламгайгаар амьсгалдаг, хүйтэн цустай,сээр нуруутан” хэмээн яг тохирсон тодорхойлолт өгсөн ажээ. Загас, хоёр доод анги болон хуваагддагийн нэг нь яслэг эдээс тогтох ба нөгөө нь мөгөөрслөг загас болох бөгөөд эдгээрийн сээр нуруу мөгөөрслөг эдээс бүрэлдэнэ.

Загасыг иймэрхүү хувиарладаг тухай Канад хүн сонссон ч байж магад, харин Консель ч энэ тухай түүнээс аамаагүй илүү мэдэж байсан нь маргаангүй.ээ. Недтэй нөхөрлөөд түүнийг гэгээрүүлэхийг Консель сайн санаанаасаа хүсэж байсан тул:

- Нед, найз минь, та бол аргагүй л загасны аянга, цахилгаан,авхаалж, зоригтой загасчин. Өөрийнхөө насанд та, далайн их бага амьтан бишгүй л барьсан хүн. Гэлээ ч гэсэн тэднийг хэрхэн ангилан хувиарладаг тухай таныг юу ч төсөөлөхгүй гэдэг талаар би тантай ана мана үзэлцсэн ч бэлэн байнам хэмээн хэлэхэд:

-Ердөө ч тийм биш гэж Нед Ленд ер ажрах шинжгүй загасыг иддэг ба иддэггүй гэж хоёр хуваадаг юм гэв.

- Энэ бол хэнхүүдийн ангилалт хэмээн Консель инээд алдаж - За тэгвэл яст ба мөгөөрст загас хоёрын хооронд ямар ялгаатайг мэдэх үү та, хэлдээ?

- Мэдэж болно.

- Тэгвэл эдгээр ангийг хэрхэн хувиарладаг вэ?

-Үгүй ээ, үүнийг ч гадарлахгүй

-За тэгвэл аан гэж бай Нед минь, харин тогтоогоорой. Яст загас зургаан баг болон хувиарлагддаг юм.Нэгдүгээр багт өргөс сэлүүртэн, энд сам хэлбэрийн заламгай бүхий, хөдөлгөөнт, үргэлж дээд эрүүтэй загаснууд багтдаг юм. Энэ баг арван таван язгуур багтаадаг буюу бидэнд мэдэгдсэн бүх загасны гуравны хоёр хувийг хамаардаг юм. Багийн төлөөлөгч нь ердийн алгана.

- Овоо амттай загас даа гэж Нед Ленд нэмэрлэв.

- Хоёрдугаар багт сүв цуухтан эдгээрийн элгэн доорх сэлүүр ястайгаа үргэлж биш, эгэм цээжнийхээ сэлүүрийн ард гэдсэн доороо байна. Энэ багт таван язгуур багтахаас ихэнх нь цэнгэг усны загас хамаарагдана.Төлөөлөгч нь мөрөг цурхай хоёр.

Түй! хэмээн Канад хүн тоомсорлохгүй янзтай цэнгэг усны загасанд миний дургүй гэдэг нь гэв.

Гуравдугаар багт зөөлөн сэлүүртэй, элгэн доорхи сэлүүр нь эгэм ястайгаа

шууд үргэлжилж цээжний сэлүүр доороо байна. Энэ багт дөрвөн язгуур багтана.Төлөөлөгч нь хальпий загас.

- Айдаа, энэ ч сайхан загас даа! хэмээн жадчин маань загасыг уушинд бэлтгэх онолын үүднээс дүгнэх үзлээ баримтлан өгүүлэв.

- Дөрөвдүгээр багт хэмээн Консель түүний үгийг анзааралгүй, могой загасны ганцхан язгуур байдаг юм. Нялцгар нягт хайрстай, гэдэсний сэлүүргүй, урт шувтан бие бүхий амьтан,

-Амтгүй дээ гэж жадчин нэмэрлэв.

-Тав дугаар багт багц заламгайтан; энд заламгайны нумын дагуу хос хосоороо байрласан багц заламгай бүхий хөдөлгөөнт, үргэлж эрүүтэй загас багтана. Энэ багт өргөс амтны ганцхан язгуур хамаарагдана. Төлөөлөгч нь далайн морь гэхэд, Нед :

-Түй! Ойгоргүй амьтан гэлээ.

-Сүүлчийн зургаадугаар багт үргэлж эрүүтэн, энд хамаарагдах загасны эрууний яс, эрүү хоорондын ястай бат холболдож тагнайн доод хонхор ясны гавал ястайгаа авцалдан байдаг .Энэ багт хатуу арьстан ба салаа шүдтэний хоёр язгуур багтана.Төлөөлөгч нь саран загас.

Энэ цагаан сав л балиартуулж чадна даа гэж Нед өгүүлэв.

-За,найз тэгээд миний хэлснийг ойлгов уу? хэмээн эрдэмтэн Консель асуухад:

-Юу ч ойлгосонгүй гэж жадчин хариулаад, гэвч та цааш нь ярь л даа, таны яриа маш сонин байна гэв.

-За тэгвэл мөгөрст загасны доод анги өөртөө дөнгөж гурван баг багтаадаг юм гэж Консель ажиг ч үгүй үргэлжлүүлэн ярихад :

-Хичнээн л цөөн бол төчнөөн сайн гэв.

-Нэгдүгээрх нь дугуй амтан; эдгээрийн эрүү нь нэгэн цагираг болон нийлж, заламгай нь, самалдаг мэт байна. Энэ баг бол дөнгөж нэг язгууртай. Төлөөлөгч нь Миного.

- Муу ч загас бишээ гэж Нед Ленд хэлэв.

- Хоёрдугаар багт аврага загас ба скат багтана.Эдгээрийн заламгай нь дугуй амтнуудынх шиг мөртлөө доод эрүү нь хөдөлгөөнтэй юм гэхэд :

-Юу? Аврага загас ба скат хоёр нэг багт багтана гэж үү ? Үгүй ээ, нөхөр минь, Консель та хэрвээ л хөөрхий скатуудыг хөнөөж дуусгах гээгүй юм бол аврага загастай нэг багт багтаасны хэрэггүй байх аа хэмээн Нед Ленд

бархирав.

Гуравдугаар баг гэж Консель ажиг ч үгүй үргэлжлүүлж хилэм загасны баг.

Эдгээрийн заламгай нэгэн нарийхан завсар болон нээгдэж тусгай таглаагаар хаагдана. Энэ баг дөрвөн язгууртай. Төлөөлөгч нь хилэм.

-Консель та, хамгийн сайн загасыг нь сүүлд нь хэлэх гээд л хадгалаад байжээ. Та гүйцэв үү?

-Гүйцлээ, Нед. Гэлээ ч гэсэн энэ бүхнийг дуулснаараа та төдий л их дуулсан болохгүй. Учир нь баг чинь цаашаа доод баг язгуур доод язгуур, төрөл, дүрс, бага дүрс...гэх мэтчилэн жижиглэн хуваагдана гээч.

-За тэр, Консель ёстой л нэг хэдэн төрөл хөвж явна даа хэмээн Нед Ленд цонх руу хандан өгүүлэхэд Консель :

-Ай даа, аргагүй л нэг загас байна даа. Бид ёстой загас үржүүлдэг шилэн саван дотор байгаа мэт юм биш үү гэлээ.

-Үгүй ээ, хэмээн би татгалзаж шилэн сав гэдэг чинь мөн л тор шүү дээ. Тэгвэл энэ загас гэдэг амьтад шувуу агаарт ямаршуу л зоргоороо байдаг вэ, яг тэрүүн шиг л чөлөөтэй амьтан гэв.

-Алив хө Консель энэ ямар гэгч загаснууд вэ? хэлээд орхиоч над гэж Нед Ленд гуйв.

-Энэ ч миний мэддэг дангийн жаа биш дэг ээ, Эзнээс асуу гэлээ.

Үнэндээ ч энэ ангилахын өвчин болсон хүн, байгальч биш байсан болохоор ердийн нэг тунцааг пузанкаас ялгаж чадав гэж үү, бүү мэдээ? Тэр энэ талаар, ямар нэгэн загасыг нэг хараад л нэрлэдэг, дадлага ажииллагаан дээр мэргэжсэн канад хүнээс шал өөр байлаа.

-Энэ бол эвэр нуруут гэж би хэлэв.

-Хятадын эвэр нуруут гэгч гэж Нед Ленд нэмэрлэлээ.

-Эвэр нуруутны төрөл,хатуу арьстны язгуур, үргэлж эрүүтний баг хэмээн Консель шивнэв.

Нээрээч Нед Ленд, Консель хоёрыг нэгтгэчихвэл нэг сайн байгальч болохсон билээ.

Канад хүн сая эндүүрсэнгүй ээ. Учир нь сүүлэндээ байгаа дөрвөн эгнээ өргөсөө арвагануулан, нуруун дээрээ хурц хурц эвэр шивүүр бүхий сэлүүр,ширүүн барзгар хайрстай хавчиг зууван биелсэн олон тооны эвэр нуруут “Наутилус”-ыг тойрон бүжиглэж байлаа.

Элэг цээж нь цагаан мөртлөө, нуруу нь бор, үүнээс гуа сайхан хосолсон жигд

өнгө бодож олоход ч хэцүү бизээ. Эвэр нуруутны дэргэдүүр цахилгаан скатууд салхинд хийсч яваа эд мэт далбайсан, далбайсан юмс хөвж явав. Тэдгээрийн дунд би нүднийхээ дээхнэ гурван сэвэлзүүртэй зөөлөн ягаан гэдэс, шаравтар нуруу бүхий хятад скат байхыг харлаа. Энэ бол маш ховор тохиолддог нэгэн бага дүрс билээ.

Хятад скат байгаад Ласепед ерөөсөө үнэмшээгүй бөгөөд түүнийг японы нэгэн зураг дээр л олж үзсэн билээ.

Хоёр цагийн турш “Наутилус”-ыг усан доор оршигчдын бүхэл бүтэн арми дагалдлаа. Энэхүү өөр хоорондоо өнгө зүс, хурдан шаламгайгаараа өрсөлдөж буй загасан дунд би ар голоороо хоёр хар судалтай сонивтор загас, хөх бие, мөнгөн толгойтой японы макрель, ганц зөвхөн нэр нь л зөндөө их намтар болох цэнхэр ногоон хоёр туяа хослон солонгорсон сэлүүр бүхий судалт спар, сүүлээ тойрсон хар цагирагтай спар, мөн зургаан бүслүүрт спар зарим нэг нь уртаараа метр хүрэх бекас загас, нэг ам сэргэлэн нүдтэй, зургаан фут урт Мурей зэргийг ялгаж танилаа.

Бид бахдан баясч ханахгүй л байлаа. Загаснуудыг Нед Ленд нэрлээд л, Консель тэр даруйхан ангилаад л, би тэдгээрийн гол хэлбэр, хурдан хөдөлгөөнийг харж хөөрч байв. Би амьд загасыг байгаль орчинд нь хэзээ ч олж үзээгүй билээ.

Хятад, Японы далайн энэхүү амьд цуглуулга бидний нүдний өмнүүр жирэлзэн өнгөрч байсан бүх дүрсийг бүгдийг тоочихыг больё. Тэд бодвол цахилгаан дэнгийн гэрэлд татагдаж “Наутилус” руу сүрэг сүргээрээ цувж байсан буйзаа.

Гэтэл үзэсгэлэн танхим гэв гэнэт гэрэлтлээ. Гэгээвчийн төмөр халхавчууд хаагдаж, дур булаасан тэр бүх үзэгдэл алга болсон боловч би өөрийн бодолд бас л их удаан автагдан суулаа.

Үзэсгэлэнгийн хананд дүүжлээстэй багажуудыг би харахад луужингийн зүү мөн л дорно умар дорно зүгийг заасаар бөгөөд даралт хэмжүүр таван метрийн гүнд харгалзах таван атмосфер, хурдны цахилгаан хэмжүүр цагт арван таван милийн хурдыг зааж байв.

Би капитан Немог хүлээж авсан боловч тэр орж ирсэнгүй. Хананы цагаар өдрийн тав болж байв.

Нед Ленд, Консель хоёр өөрсдийнхөө өрөөнд явж одлоо. Би ч гэсэн бас л тасалгаа руугаа явав. Миний өдрийн хоол ширээн дээр минь хүлээж ахуйг үзвэл яст мэлхийн шөл, соновтор загасны тусгайлан бэлдсэн халуухан элэг байсан нь тун ч хосгүй амттай бөгөөд яргай загасны зөөлөн махтай бондгор толгойт загасны гол мах байв. Үдшийн цагийг би ном уншиж өнгөрөөв. Намайг нойр дийлж орондоо орж нам унтаж өгсөн үед “Наутилус” онгоц \*Хар мөрний” урсгалыг даган хөвж байлаа.

## УРИЛГА БИЧИГ

Би дараагийн нь өдөр, арван нэг дүгээр сарын есөнд бүтэн арван хоёр цаг унтаад сэрлээ. Консель ердийнхөө заншлаар "Эзэн хэрхэн нойрссон" тухай лавлаж өөрийнхөө зүтгэлийг үзүүлэхээр хүрч ирлээ. Тэр бүх насаараа унтахаас өөр юу ч хийдэггүй юм шиг л хухирчихсан өөрийн Канад найзыг унтаагаар нь орхичоод иржээ.

Би, өөрийнхөө сайн зарцад хичнээн л бол төчнөөн донгосох бүрэн эрхий нь олгож, асуултанд нь хайш яайш, заримдаа ч буруу зөрүү хариулж байв. Өчигдрийн тэр сонин юм болоход капитан Немо байгаагүй явдал намайг эвгүйр хүүлж байсан бөгөөд түүнтэй би өнөөдөр уулзана байх гэж горьдож байлаа.

Би шандаслаг эдээр хийсэн өөрийнхөө шинэ хувцсыг өмсөв. Энэ хувцасны янзыг Консель хэд хэдэн талаар нь өөлөв. Зарим нэгэн дун хорхой хад чулуунд биеэ барьж бэхэлдэг торгомсог мяндас эдээс энэхүү эдийг нэхсэн юм гэж би түүнд хэлэв. Энэхүү шандсаар маш дулаан зөөлөн сайхан эд хийж болно. Иймээс "Наутилус" хөлгийн багийг далай өөрөө хувцасладаг учраас тэрхүү онгоц ямар нэгэн хөвөн эд хонины ноос, торгоны хорхой зэргийг хэрэглэдэггүй ажээ.

Би хувцаслаад үзэсгэлэнт танхимд орж очвол тэнд хэн ч алгаа.

Би шилэн савнуудад цуглуулсан үнэт зүйлийг үзэж эхэллээ. Би хатааж хавчуулсан хэдий боловч ер бусын өнгө үзэмжээ алдаагүй хадгалагдаж байгаа далайн хамгийн олон төрлийн ургамлаар дүүрэн ургамлын цуглуулга олж үзлээ. Иймэрхүүгээр бүтэн өдөр өнгөрлөө. Капитан Немо байдаггүй ээ. Гэгээвчний төмөр халхавч нээгдсэн ч үгүй. Тэрхүү гайхамшиг зүйлийг үзэж ханачихна гэж биднээс хямгадсан ч байж болно.

"Наутилус" мөн л түрүүчийнхээрээ дорно умар дорно чигийг барьж, тавь жаран метрийн гүнд цагт арван хоёр милийн хурдтай явж байв.

Дараагийн өдөр, арван нэгдүгээр сарын арван, мөн л иймэрхүү ганцаардмал байдлаар өнгөрлөө. Би "Наутилус"-ын багаас нэг ч хүн олж харсангүй. Нед Ленд, Консель ;хоёр өдрийн ихэнхийг надтай хамт өнгөрөөлөө. Капитан үгүй байгаа

явдлыг эд надаас ч илүү гайхаж байв. Тэр хачин хүн өвдчихөө юу? Эсвэл бидэнтэй харьцах шийдвэрээ өөрчилчихөө юу?

Эцсийн эцэст Конселийн хэлснээр, бид ямар ч талаар гомдол гаргах хэрэггүй байв. Биднийг сайн хооллож байсан болохоор гэдэс цатгалан, бас эрх чөлөө дүүрэн. Манай эзэн гэрээнийхээ болзлуудыг хатуу баримталж байв. Түүнчлэн бидний тэрхүү ер бусын байдал бидэнд иймэрхүү сэтгэл хангамжтай явдалд хүргэсэн болохоор бид хувь заяандаа гомдох талгүй бүлгээ.

Энэ өдрөөс эхлэн би болж өнгөрсөн явдлуудын тухай тусгай тэмдэглэл хөтлөх болсон минь тэр бүхнийг одоо яг үнэнээр нь нарийвчлан тоочих боломж өгч байгаа билээ. Сонирхолтой зүйл гэвэл би өдрийнхөө тэмдэглэлийг далайн замгаар хийсэн цаасан дээр эхэлж бичлээ...

Арван нэгдүгээр сарын арван нэгэнд өглөө эрт, цэвэр агаар сэнгэнэн орж ирсэн нь бид хүчилтөрөгчийнхөө нөөцийг нөхөхөөр далайн мандал дээр хөвж гарчээ. Би шат руу очиж “Наутилус”-ын тавцан дээр гарлаа.

Өглөөний зургаан цаг болж, цаг агаар бүүдгэр. Далай бүрзийх боловч амгалан. Түүний өнгөн дээгүүр хөнгөн атриа бэржийж байв.

Капитан Немо дээшээ гарч ирэх нь үү, үгүй юу? гэдэг асуудал надаас салахгүй байлаа. Одоохондоо тавцан дээр, жолоодлогынхоо бөмбөгөр дотор харагдаж буй залуурчаас өөр хэн ч үл үзэгдэнэ.

Онгоцны их биенд нуусан завийн ёроолд овойсон товгор дээр сууж би давс нэвширсэн далайн агаар салхи хомхой амьсгалж байв.

Нарны гэрэлд далай дээрх манан бага багаар замхарч эхлэв. Бадралт наран алс дорно зүгээс алгуур мандаж, да-лайн уудам хязгаар түүний туяанд дарь тэсрэх мэт цацран гэрэлтлээ. Салхит өдрийн шинжийг илтгэсэн салбагар уулс этгээд гоёмсог зөөлөн өнгөөр туяаран харагдав.

Ямар ч догшин шуурганаас айдаггүй “Наутилус”-т салхитай өдөр ер юу болох вэ дээ?

Миний ард хөлийн чимээ гарах хүртэл нарны энэхүү баясгалант мандалтыг би сонирхон зогслоо. Хэн нэгэн, онгоцны тавцан өөд гарч байх шиг санагдав.

Би капитан Немод мэхийн ёслохоор зэхэж байтал харин түүний туслагч гарч ирлээ. Түүнийг би капитантай анх уулзсан тэр үед харсан билээ. Тэр намайг хараагүй юм шиг гарч ирээд, нүдэндээ хүчит дуран авай ойртуулж орчин тойрныг асар анхааралтай дурандаж байв. Дурандаж гүйцсэнийхээ дараа нээлттэй Люкэнд ойртож очоод... *Nautron respoc orui virch!* гэж хэллээ. Сүүлд иймэрхүү юм болоход



тэгж хэлж байхыг нь олон удаа дуулсан учир би энэ үгийг яг тогтоож авсан юм. Гэвч, энэ нь юу гэсэн үг болохыг бүү мэд. Энэ үгийг хэлчихээд туслагч, шатаар бууж одлоо. Би “Наутилус”-ыг одоо доошоо живж орох гэж байгаа юм байх гэж бодоод яаран буулаа.

Иймэрхүүгээр, ямар ч өөрчлөлт гарсангүй, таван хоног өнгөрлөө. Өглөө бүхэн би, тавцан дээр гардагсан. Тэхэд, өнөө хүн өнөө л үгээ давтаж хэлдэг байв. Гэвч капитан Немо үзэгдсэнгүй ээ.

Арван нэгдүгээр сарын 16-нд Консель, Нед Ленд хоёрым хамт өрөөндөө орж ирээд өөртөө хаягласан захидал ширээн дээр байхыг үзэх хүртэл би түүнтэй дахин уулзахгүй нь юм байх гэж бодож байлаа.

Би дугтуйг яаран задалж үзтэл францаар тод сайхан бичсэн бичиг байсан бөгөөд бичгийн хэлбэр нь немц үсгийн шовгор хэлбэртэй төсөөтэй ажээ. Энэ захидлын агуулга нь...

*“Наутилус” хөлгөн дээр морилон*

*буй эрхэм профессор*

*АРОНАКС танаа*

*1867 оны 11-р сарын 16.*

*Капитан Немо эрхэм профессор Аронакс таны биеийг маргааш өглөө Кресло арлын ойд хийх ан авд өөрийн биеэр орролцохыг урьж байна. Энэхүү жуулчлалд эрхэм профессор таныг дагалдагсад оролцохыг таалахсан бол капитан Немо би нэн их баярлахсан байнам*

*“Наутилус” онгоцны капитан Немо гэжээ.*

- Ан хийх ий! хэмээн Нед дуу алдав.

-Тэхдээ Кресло арлын ойд гээч! гэж Консель өгүүлэв.

-Тэгвэл энэ хүн зарим хуурай газраар гардаг байх нь ээ? хэмээн Нед асуулаа.

-Бодвол, захидлаас ойлгомжтой биш үү гэж би захидлыг дахин уншаад хариулав.

-За яахав, хэрэг тийм болсон бол энэ урилгыг хүлээн авах хэрэгтэй хэмээн Канад хүн өгүүлээд хуурай газар гараад бид, цаг үеийн байдлыг харгалзаж, цаашид хөдлөх төлөвлөгөө боловсруулъя. Түүнээс гадна би үмх шинэ мах идчихээсээ буцахгүйсэн байнам гэлээ.

Капитан Немо арал буюу тив дээр гарахаас жигшдэг тухай үг болон ойд ан хийх энэхүү урилга хоёрын хоорондох этгээд зөрчлийг би эвлэрүүлэхийг оролдолгүйгээр:

- Аль вэ, эхлээд Кресло арал гэдэг юу болохыг зураг дээр үзчихье гэсэн хариултаар өөрсдийн маргааныг төгсгөл болгов.

Би зураг дээр эрж байгаад энэхүү арлыг умарт өргөргийн 32 хоног 40хувь, өрнөт уртрагийн 167 хоног 50хувь дээр оллоо. Тэр арлыг 1801 онд капитан Креспо нээсэн юм. Испаны хуучин зураг дээр туунийг Рекка де ла Пиат гэж нэрлэдэг нь орчуулбал:

“Мөнгөн хад” гэсэн уг. Энэ арал бидний анх хөдөлсөн газраас барагцаалбал мянга найман зуун миль зайтай байлаа. Үүгээр бол «Наутилус» анхныхаа чиглэлийг өөрчилж, одоо өмнө дорно зүгийг барьж явав.

Би Номхон далайн умарт хэсгийн уудам хязгаарт төөрөлдсөн тэрхүү бяцхан цэгийг зураг дээр өөрийн нөхдөд зааж өглөө.

- Хэрэв капитан Немо заримдаа, хуурай газар гарах бол хүн амьтангуй эл хуль арал Сайгон авдаг нь ойлгомжтой боллоо.

Нед Ленд хариу дуугарсангуй толгой сэгсрээд, Консель тэр хоёр гарч одов.

Хэлгүй мэт санагдах, онгоцны хэнэггүй зарцын авчирсан оройн зоогийг идээд би, нилээд сэтгэл хөдлөнгүй хэвтэртээ орлоо.

Маргааш өглөө нь арван нэгдүгээр сарын 17-нд би нойрноос сэрвэл “Наутилус” хөдлөхгүй зогсож байхыг мэдлээ. Би яаралгүй хувцаслаад үзэсгэлэнт танхимд орж очтол тэнд капитан Немо байлаа.

Тэр намайг угтан босч ирээд мэхийн ёсолж мэндлэлцсэний дараа би түүнийг дагалдах эсэхийг лавлан асуув.

Тэр өөрийнхөө найм хоногийн эзгүйдлийг тайлбарлах ямар нэгэн сэдэв мэдэгдээгүй болохоор би тэртухай нь ч асуухыг зүрхэлсэнгүй зөвхөн л миний бие болон миний нөхөд түүнийг дагалдахад бэлэн байгааг уламжлаад:

- Капитан танаас юм асууж болох уу? хэмээн нэмж өгүүлбэл :

- Асуу л даа та, хариулж л чадах бол би хариулъя гэж тэр хэллээ.

- Хуурай газартай та ямар нэгэн талын харьцаагаа тасалчихсан хэр нь Креспо арал дээр өөрийн эдлэн газар, ой модтой байдаг тань яаж таарч байна даа, ингэхэд? гэж би асууж орхилоо.

- Эрхэм профессор та хэмээн капитан надад хэлээд, мэдэж байна уу, үгүй юу. Миний мэдэлд байдаг тэр ой мод нарнаас илч, гэрэл авах явдал байдаггүй юм. Тэнд арслан, бар, ирвэс, ер нь дөрвөн хөлт амьтан байхгүй. Тийм ой тэнд байдгийг ганцхан би л мэднэ. Тэдгээр мод ганцхан миний тулд л ургаж байдаг юм. Энэ бол газар дээрх ой биш усан доорхи ой гэж хариуллаа.

- Усан доорхи ий!? хэмээн би хашгарчихад ;
- Тиймээ, профессор гуай гэлээ.
- Та тэгээд намайг тийшээ явъя гэж байгаа юм уу?
- Яг, зүйтэй.
- Явган уу?
- Гутлаач норгохгүй гээч. Тэгээд бас ан хийнэ гэнэ ээ?
- Тиймээ, ан хийнэ.
- Буутай юу?
- Буутай гэв.

Би капитан руу бахархсан нүдээр харсан боловч миний харц зусардсан шинж байгаагүй билээ.

“Энэ хүн ер нь хийтэй байх аа. Мань хүний тэр өвчин сая найм хоног үргэлжилсэн дэг ээ; магадгүй ер нь одоо ч гэсэн үргэлжилсээр байж. Хайран хүн дээ! Энэ хүнийг би, солиотой байхаасаа этгээд хачин хүн байсан бол дээрсэн гэж үзэхсэн” хэмээн дотроо бодлоо.

Миний энэхүү бодлыг царайн дээрээс минь магад амархан мэдэж болох байсан даг. Капитан Немо надад юу ч хэлсэнгүй, зөвхөн өөрийн хойноос дагалдах дохио өгөхөд би, түүний хойноос ер нь ямар нэгэн аягүй юм болоход хүлцэн хүлээх хүний байртай дагаж явав.

Би гуанзанд орж очвол өглөөний хоол бэлэн болсон байлаа.

- Эрхэм Аронакс та сууж айлд хэмээн капитан хэлээд, ганцхан нэрлэхэлгүй шиг л зооглоорой. Би танд усан доорхи ресторан амлаагүй боловч усан доорхи зугаалаг амласан. Тийм учраас, би танд нилээд сайн идэж явахыг зөвлөх байнам. Бид зөвхөн үдэш орой болсон хойно хоол иднэ шүү гэлээ.

Би тэрхүү зөвлөлгөөг нь дуулгавартай хүлээн авч өглөөний зууш хэр чинээгээрээ л идэв. Өглөөний зуушийг далайн замгаар амт оруулж янз бүрийн загасаар хийжээ. Идсэн зуушаа бид, цэвэр усаар даруулсан бөгөөд би түүн дээр капитаныг дууриаж «Хальслаг родомений» хэмээх замгийн эсгэсэн ханд хэд хэдэн дусал нэмэрлэлээ.

Капитан Немо эхлээд уг дуугүй зуушилж байснаа:

- Би бодвол, эрхэм профессор. Кресло арлын ойд ан хийх урилга аваад намайг та туйлбаргүй амьтан гэж үзсэн. Дараа нь таны биеийг усан доорхи ойд би урьсан тухай мэдмэгцээ, намайг ухаан солиорсон гэж бодсон. Ноён профессор, ер ий хүмүүсийг хэзээ ч тэгж гэж өнгөцхөн дүгнэж болохгүй шүү дээ!

- Үгүй капитан минь та итгэж...

- Хэрвээ хүн өөртөө хүрэлцэхүйц хэмжээний амьсгалах агаар аваад усан доогуур орвол удаан хугацаагаар тэнд байж чаддаг гэдгийг та надаас дутуугүй мэдэж байгаа байх. Усан доор ажилладаг ажилчид ус үл нэвтрэх хувцас, тол-гой хамгаалагч төмөр дуулгатай доошоо орж тусгайлан зориулагдсан урт хоолойгоор агаар авч амьсгалдаг биз.

Тиймээ тэр хувцсыг скафандр гэдэг юм.

-Зүйтэй. Гэвч тийм баг өмсчихсөн ажилчин хүн чөлөөтэй хөдөлж чаддаггүй юм. Түүнийг тусгай шахуургаар амьсгалах агаар дамждаг урт хоолой аргамжаатай байдаг. Тэр ёстой л газартай нь хадчихсан гинж мэт яршигтай.

Хэрэв бид “Наутилус”-тай тийм хоолойгоор холбогдох юм бол явж гавихгүйсэн билээ.

- Тэгвэл энэ явдлыг яаж үгүйсгэх вэ? гэж би асуув.

- Руквейроль-Денейрузийн багажийг хэрэглэдэг юм. Энэ багажийг, эрхэм профессор тантай нэг нутгийн хоёр хүн хийсэн. Харин би цааш нь улам сайжруулж ашигласан тул та өөрийн эрүүл мэндэд өчүүхэн ч гэм учруулахгүйгээр, физиологийн шал өөр нөхцөл бүхий орчинд, усан доогуур хэрэглэж болно. Энэ бол агаар тавин атмосферийн даралттайгаар шахаж оруулсан зузаан хавтгай төмөр сав хэлбэрийн аппарат юм. Уул савыг усан доор орогчийн нуруунд яг л цэрэг хүний үүрэвч шиг бэхэлдэг. Доторхи агаарын даралтыг жирийн байдалд хүргэж, тусгай клапанаар цааш нь уушгинд дамжуулдаг төмөрчний хөөрөг шиг нэг тийм хэсэг түүний дээд талд байдаг. Руквейроль-Денейруз хоёрын ердийн багажинд, усанд шумбагч хүний хамар ам хоёр дээр тавигддаг хийн савтай залгаатай хоёр резин хоолой бий, нэг нь агаар амьсгалахад, нөгөө нь амьсгалсан агаар гаргахад зориулагдаж байсан. Түүнийг өмссөн хүн амьсгалаа авах буюу гаргахад шалтгаалж уул хоёр гуурсны нүхийг хэлээрээ таглах буюу нээдэг байв. Тэгвэл би усны дээд давхаргуудын даралтыг далайн тэр гүнд давахын тул дээрх багажийн резин багийг зэс дуулгаар сольж түүнд сая агаар амьсгалах, гарах гуурсаа бэхэлсэн юм даа.

- Их сайн байна, капитан. Гэвч таны өөртөө авч явсан агаар дуусч, түүний хүчилтөрөгчийн найрлага арван таван хувиас доош орвол тэр амьсгалах аргагүй болно шүү дээ.

- Тэр үнээн, профессор. Гэсэн ч би « Наутилус » онгонцны шахуурга тэр саванд агаар хий асар их даралттай шахдаг гэж хэлсэн биз дээ. Тэгвэл энэхүү шахаж оруулсан амьсгалах агаар есөөс арван цаг аажуу уужуу хүрэлцдэг юм.

- Дахиад надад эргэлзэх юм алга даа хэмээн би хэлээд далайн гүнд та өөрийн замыг хэрхэн гэрэлтүүлдгийг капитанаас асуучихвал болох уу? Бодвол тэнд нүдгүй, пад харанхуй буйзаа гэв.

- Румкорфын аппаратаар гэрэлтүүлдэг юм, профессор Шахсан агаартай амьсгалах саваа ар нуруундаа үүрдэг бол үүнийг бүсэндээ зүүчихдэг юм. Тэр аппарат Бунзений элементээс бүрддэг. Түүнийг би ердийн аппаратын нэгэн адил калий хлорын давхар ислээр цэнэглээгүй, харин натриар цэнэглэсэн. Аппаратын нөлөөлөх ороомог цахилгаан гүйдэл хуралдуулсан байж цааш нь тусгай хийцтэй чийдэнд дамжуулна. Энэ чийдэн бол нүүрс хүчлийн хийгээр дүүргэгдсэн могой хэлбэрийн хөндий гуурс байдаг юм. Аппарат цахилгаан гүйдэл гаргахад уул хий цайвар өнгөөр хурц гэрэлтдэг юм. Ингэж л би усан доорхи замаа харж амьсгалж явдаг хүн дээ.

-Капитан та, миний тавьсан асуулт бүрд ийм хангалттай хариу өгсөн газар надад одоо эргэлзэх зүйл өчүүхэн ч алга, Руквейроль, Румкорф хоёрын аппаратын талаар дийлдсэн гэж би өөрийгөө хүлээж байна. Гэвч усан доогуур ан хийхэд биднийг та буугаар зэвсэглэнэ гэсэнд тань маргаан үүсгэвэл өчүүхэн боловч зүйл хожно гэж би итгэж байна.

- Тэгвэл миний буу дариар цэнэглэдэг, галт зэвсэг биш гэж капитан хэллээ.

- Таны буу тэгвэл шахсан хийгээр ажилладаг байх нь ээ?

- Тэгэлгүй яахав. Үгүй та, өөрөө бод л доо, хүхэр, шүү, нүүрс зэргийн аль аль нь ч байхгүй, “Наутилус” онгоцны дээр байгаа би яаж даринь тухай дурсах вэ дээ.

- Тэдний зэрэгцээ агаараас мянга найман зуун тавь дахин нягт орчинд, усан дотор буудахад чинь сум гэдэг асар их эсэргүүцэл туулах хэрэгтэй болно.

- Энэ миний бууны буудалтанд саад болохгүй. Жич хэлэхэд Фультоны дараа Филипп Кольс, Берлей гэдэг хоёр анчин хүн, фурси гэгч Франц хүн, Ланди гэгч Итали хүнд тус тус сайжруулж хийсэн мөн иймэрхүү нөхцөлд буудах буу бий шүү. Ингээд давтан хэлэхэд би хэдийгээр дарьгүй боловч хийгээр цэнэглэсэн буутай гэдгийг анхааруулахаас гадна миний бууны цэнэг шахсан хийн нөөц “Наутилус”-ын цахилгаан шахуургын агаар хязгааргүй юмдаг гэдгийг сонсох ёстой.

- Гэвч цэнэгийнхээ нөөцийг буудах бүрдээ нөхөх хэрэгтэй биз?

-Тэгээд яагаа вэ. Бууг дахин цэнэглэхэд, миний ард үүрээстэй байгаа Руквейролийн сав ямар хэрэгтэй билээ? Үүний тул ганцхан кран мушгих л хэрэгтэй. Гэсэн ч эрхэм профессор та, усан доогуур ан хийхэд шахсан хий, сум хоёр ялихгүй шаардагддагийг өөрөө үзэж болно.

-Тэглээ ч гэсэн далайн ёроолын тэр бүрэг бараг гэрэлтүүлэгдсэн харанхуйд тийм нягтрал ихтэй шингэн орчинд буудаад; буудаад хол тусахгүй, оноод оноод алж чадахгүй мэт л санагдах юм даа.

- Тийм бишээ, профессор. Миний бууны буудалт тус бүр заавал алж тусдаг юм. Хэрвээ л миний бууны сум хүрсэн байвал түүгээр ч барахгүй ядаж дөнгөж шүргэсэн л байвал аянга ниргэсэн мэт унадаг гээч.

-Яагаад?

-

Яагаад гэвэл, миний буу жирийн сумаар бууддаггүй харин Австри улсын химич Лёнибрек бий болгосон тусгай цэнэгээр бууддаг юм. Энэ бол дотроо хар тугалган цом бүхий ган бүрхүүлтэй маш жижигхэн шилэн үрлүүд байдаг юм.

Үнэн хэрэг дээрээ энэхүү Лёнибрекийн сум гэгч бол өөртөө тун өндөр хүчдэл бүхий цахилгаан гүйдэл хадгалсан Лейдений өчүүхэн сав байгаа юм. Тэр сав үл мэдэг хөндөгдмөгц л цэнэгээ задалж, хүрсэн амьтнаа ямар ч том биетэй байсан хөнөөдөг юм. Ингээд нэмж хэлэхэд энэ шилэн үрлүүд, дөрвөн номерийн үрэл сумнаас ялихгүй том, бууны хүхээ хайрцагт арваас доошгүй сум ордог юм даа.

-- Бууж егье хэмээн би хэлээд,

--Та миний бүх л талын эргэлзээг бүр мөсөн няцаалаа. Иймээс би зөвхөн тэр буугий тань аваад л таны хаа хүрсэн газар хүртэл дагалдахаас өөр арга алгаа гэлээ.

-Капитан Немо намайг “Наутилус”-ын хитгэ рүү дагуулан орж Нед Ленд, Консоль хоёрын өрөөний дэргэдүүр гарахдаа тэднийг мөн дуудахад тэд ч мөн эгшин зуур бид хоёртой нийлэн цаашиллаа.

-Бид машины танхимын цаадтай байх нэгэн багахан өрөөнд орвол, энд усан доогуур зугаалахад өмсдөг өнөөх скафандр гэдэг өмсгөлий нь өмсөх хэрэгтэй болжээ.

[Тор](#)

---

## ТЭНГИСИЙН ЁРООЛООР ЗУГААЛСАН НЬ

Энэхүү өрөө “Наутилус” онгоцонд зэвсгийн болон хувцасны өрөө аль аль нь

болдог ажээ. Арав гаруй өмсгөл анчдыг хүлээж хананд өлгөөстэй байв.

Нед Ленд уул өмсгөлүүдийг үзмэгц дур гутсан янзтай ярвайж байсан нь бодвол, энэхүү нүсэр хүнд хувцсанд чихэлдэж орох гэдэг тэр эрд төдий л таалагдсангүй буйзаа.

- Эрхэм Нед та хэмээн би канадын эрэлхэг эрд зориуд анхааруулан Креспо арлын ой гэдэг усан доорхи ой шүү! гэж хэлмэгц үмх шинэ мах олж үмхэнэ хэмээн найдаж байсан түүний хүсэл талаар болсонд гол нь горойсон канад хүн :

- За мөндөө! хэмээн дуу алдаж тэгвэл эрхэм профессор та энэ хударганд чихэлдэж орохоор завдан байна уу? гэж надаас асуулаа.

-Яриад яахав, хонгор минь.

-Юу сайхан, дур сайхан. Хэрэв л намайг үүнд хүч түрэмгийлж чихэхгүй бол би ч ордоггүй дээ! гэж Нед Ленд мөрөө хавчив.

-Таныг хэн ч албадахгүй эрхэм ээ гэж капитан Немо, Нед Лендэд хүйтнээр хариулахад, Нед :

-Консель чи яах вэ? гэв.

-Консель эзнийхээ хойноос зөвхөн усанд битгий хэл галд ч орно! гэж Консель хариу өчив.

Капитаны тушаалаар хоёр далайчин хүрэлцэн ирж, энэхүү үргэлж резинээр хийсэн ус үл нэвтрэх хүнд хувцас өмсөхөд бидэнд туслалцлаа. Усны их даралтанд тохируулан хийсэн энэхүү хүнд өмсгөлүүд гадаад байдлаараа дундат зууны үеийн баатрын өвч хуяг шиг харагдах боловч түүнээс уян хатнаа- раа ялгагдаж байв.

Уул хувцас үргэлж хийцтэй өмд, цамц, гутал гурваас бүрэлдэх бөгөөд гутлы нь хар тугалгаар улласан байлаа. Цамцны эдийг зэс цагирганд тэлж угласан тул цээжин биеийг усны даралтаас хамгаалж, амьсгалахад чөлөөтэй болгожээ. Цамцны ханцуйд гарын хурууны хөдөлгөөнд саад үл болох резин бээлий залгасан байлаа.

Капитан Немо бодвол асар их чадалтай боловуу гэмээр, гадаад байдлаараа ёстой Геркулес мэт сүрлэг нэгэн далайчин Консель бид дөрөв уул өмсгөлийг даруйхан өмсч бэлэн болоход зөвхөн толгойгоо л төмөр дуулганд шургуулах ажил үлдсэн байлаа.

Гэвч би үүнийг өмсөхөөсөө өмнө өөртөө зориулагдсан буутай танилцах зөвшөөрөл капитанаас авахад тэнд байсан далайчдын нэг нь надад ердийн л нэг буу шиг буу авч өгснийг үзвэл : мөрлөгч нь энгийн бууныхаас арай том болуу гэмээр, гангаар хийсэн хөндий голтой байв. Тэхнээ нь мөрлөгч нь шахсан агаар хуралдуулах сав болж өгдөг бөгөөд гох дарахаар уул савнаас шахсан хий тусгай клапанаар

дамжиж гол төмөртөө очдог ажээ. Хүхээ хайрцганд хорь орчим цахилгаан сум байсан нь тусгай автомат пүршээр гол руугаа гүйдэг байлаа. Бууны амнаас нэгэн сум үсрэн гармагц л түүний оронд дараачийн сум орж бэлэн болсон байдаг ажээ.

- Энэ мөн сайхан зэвсэг юмаа хэмээн би магтаад, тэхдээ бас тун хялбар хийцтэй юм байна. Би ч ер нь доошоо буух хүртэл тэсэхгүй нь шиг байна. Гэтэл бид яаж ёроол руу ордог билээ? гэж асуувал :

-“Наутилус” одоо арван метрийн гүнд ёроолын элсэн дээр зогсож байна. Бид явахад бэлэн болжээ, профессор.

- Үгүй, бид онгоцноосоо яаж гарах билээ?

- Одоо үзнэ ээ, та.

Тэгтэл ч капитан Немо зэс дуулгаа өмслөө. Консель бид хоёр түүнийг мөн дуурайн үйлдсэн бөгөөд Нед Ленд салахын өмнө бидэнд анд сайн явахын ерөөл тавьж үгээр үдсэн билээ. Цамцны зах дотроо эрэгтэй зэс цагираг бүхий тул зэс дуулгаа түүнд эрэгдэж суулгадаг ажээ. Дуулганы зузаан шил бүхий гурван цонхоор толгойгоо эргүүлэн урагшаа буюу хажуу тийшээ харж болох байлаа.

Би Руквейролийн аппаратын краныг нээгээд, Румкорфын дэнг бүсэндээ дүүжлээд гартаа буугаа барилаа. Өмсгөл хүнд хувцас, ялангуяа хар тугалагаар улласан гутал намайг бараг шалтай хадаж байлаа. Би нэг ч алхаж үл чадах мэт санаж байв.

Гэвч энэ ч зүйн хэрэг байсан юм байлгүй. Намайг хувцасны өлгүүрийн дэргэдэх бяцхан бүхээг дотор чирч аваачлаа. Миний бусад нөхдийг ч мөн л миний нэгэн адил араас түлхлэн оруулчихдаг байна шүү. Бидний араас хаалга хэрхэн хаагдсан чимээг би үл мэдэг сонссон бөгөөд энэ хэр пад харанхуй байлаа.

Хэдэн минутын дараа миний чихэнд юм шуугих дуулдахад би, ямар нэгэн хүйтэн юм дороос дээшээ, цээж өөд өгсөөд байхыг мэдэрлээ. Бодвол машины танхимд нэг кран нээчихсэн бололтой. Тэгээд л бидний зогсож буй бүхээгийг далайн усаар дүүргэж байгаа байлгүй, Ус уул бүхээгийг бүрмөсөн дүүргэсний дараа «Наутилус» онгоцонд хоёр дахь хаалга нээгдэж, бид бүдэг цайвар гэрэл олж үзлээ. Ингээд л секундйн дараахан бид далайн ёроолоор алхаж гарав.

Далайн ёроолоор зугаалсан сэтгэгдлээ би одоо ер нь яасхийгээд бичижхэе дээ? Би өөрийн үзсэн гайхамшгийг тэр байтугай уран зураачийн бийр урлаж үл чадах усан доорхи тэр сайхан өнгө үзэсгэлэнг яавал үгээр дамжуулж чадах вэ?

Энэ үед капитан Немо түрүүнд, бидэнтэй явсан далайч сүүл барьж явлаа. Консель бид хоёр дунд нь төмөр дуулга нэвт ярьж болох шиг бас зэрэгцэн алхаж



билээ. Би өнөө хүнд емсгөл шахсан хий цахилгаан цэнэг бүхий сав, тугалаган ултай гутал, самрын ясан доторхи идээ шиг, саяын бөндгөр багана дотор бөндөгнөж явсан толгой дээрээ байгаа төмөр дуулга зэргийн хүндийн жинг мэдрэхгүй байв. Миний энэхүү хэрэглэж явсан эдлэлүүд усан дотор орохдоо, хэд хичнээн хэмжээний ус түрж гаргасан бол тэрхүү түрсэн усныхаа жингээр хүнд нь хорогдсон бүлгээ. Аль хаа байсан тэр дээр үед Архимед анх нээж олсон физикийн энэхүү хууль надад хөдлөх бүрэн бололцоо өгсөн тул би уул хуулийг магтаж мандуулахад бэлэн байлаа.

Гучин фут зузаан усыг харгалзахгүйгээр далайн ёроолд гялбам хурц гэрэлтэй байсан нь намайг тун их гайхуулж билээ. Усны энэхүү зузаан давхаргыг нарны туяа саадгүй нэвт тусч, далайн ёроолыг гэрэлтүүлсэн тул би хэдэн зуун метрийн цаадах өчүүхэн жижиг зүйлсийг ялган таньж байв. Нүдэнд харагдах газраас цааш гэрэл бүдэгрэн, бүдэг нь өтгөрөн харласаар, яваа яваандаа үл мэдэгдэм өнгөөр хөх цэнхэртэн замхарч харагдлаа. Намайг тойрон буй орчин мөн л өнөө агаар мэт санагдсан бөгөөд зөвхөн хуурай газрын агаараас нилээд нягт балов уу гэмээр тэхдээ түүнээс ч багагүй тунгалаг байв. Миний чанх дээр далайн төвшин налайж байхыг би харлаа.

Бид далайн эрэг орчны элстэй адил үрчлээ атриагүй тов толигор, нарийн ширхэгтэй торгон элсэн дээгүүр явж байв. Энэхүү нүд гялбам хурц өнгөтэй торгомсог хивс ёстой л нарны тусгал толь болсон ажээ. Хэсэг тус бүр нь гэрэл туяагаар цацарч агсан усны давхарга чухам яагаад тийнхүү хурц гэрэлтэж агсан учир нь энэ байв. Хэрэв би, усан дотор гучин фут гүнд, яг л усны гадаа, нартай өдөр мэт тийм цэлмэг. Тунгалаг байсан гэж хэлбэл хүмүүс надад үнэмших болов уу?

Арван таван минутын турш бид хэнд ч мэдэгдэшгүй тийм бяцхан амьтад буюу хэд хэдэн миллиард хясааны тоосонд дарагдсан элсэн хивсэн дээгүүр туучин явав. “Наутилус”-ын бараа бүдгэр бүдгэрсээр аяндаа үгүй боллоо. Түүний алсаас харагдах хүчирхэг цахилгаан чийдэн өөрийн хурц гэрлээр шөнө биднийг эргэж ирэхэд тус болох ёстой байв.

Бид хэдий яваад л байвч, асар өргөн элсэн цөл зах хязгааргүй мэт ажээ. Би өөрийн өмнөх шингэн хөшгийг гараар ярж хаяхад, тэр миний ард эгшин зуур дахин хаагдаж элсэн дээр гарсан бидний мөр дээрх усны давхаргын даралтын хүчинд дахин тэгшлэгдэж байлаа.

Ийнхүү явтал ашгүй нэг алс тэртээ ямар нэгэн харлах бараа харагдаж билээ. Түүнд ойртон очоод ажиглавал ургаа амьтнаар өтгөн хучигдсан усан доорхи хадан цохио ажээ. Тэнд л би шингэн орчинд, этгээд онцгой гэрлийн гоёмсог цацралыг олж

үзээд нүд дальдарч бүлгээ.

Энэ хэр өглөөний арван цаг билээ. Нарны гэрэл хурц өнгөөр ташуу тусч, гурвалжин призмийн дундуур гарч задрахын нэгэн адил хугарч ургамал, амьтан, хад, бут зэргийг гэрэлтүүлэн долоон өнгөөр солонгорч байлаа. Уран зураачийн будаг нийлэх модон дээр нялсан өнгө өнгийн будаг мэт усан доторхи ягаан, цэнхэр, хөх, ногоон, шар улбар, улаан өнгөө тод ялгаран туяарах гэдэг ёстой л нүдэнд чимэгтэй ажээ.

Миний сэтгэлийг донсолгон байсан тэрхүү баяр хөөрийг би Консельтойгоо хуваалцаж чадахгүй байсан маань юутай харамсалтай билээ? Бас капитан Немо өөрийнхөө усан цэрэгтэй ярилцаж байсан тэрхүү дохио тэмдгүүдийг мэдэхгүй минь юутай хайран бэ! Дуугуй байхын аргагүйн улмаас би, өөрөө өөртэйгөө ярьж, амьсгалах эрхэм агаараа ямар ч хэрэггүй дэмий үрэгдүүлэн, заримдаа ямар нэгэн юм хашгачиж явлаа.

Консель мөн л миний нэгэн адил энэхүү гайхамшиг сайхан үзэгдэлд сэтгэл уярсны улмаас зог туслаа.

Үнэнийг хэлэхэд энэ бэрх хөвүүн тэрхүү ургаа амьтан, хөндий хэвэлтэн зэргийг хармагцаа л ангилан ялгаж эхлэх мэт санагдаж билээ.

Тэдгээр амьтад далайн ёроолоор дүүрэн хөглөрч байв. Энд : Изид, корнулярий “цагаан шүр” өндгөн мөөг мэт бөндийж ганц нэгээрээ буюу бөөнөөрөө орших хөндий хэвэлтнүүд байх бөгөөд амаа тойрсон туг тэмтрүүл бүхий актиний хэмээх ургаа амьтад бүхэл баг цэцгийн хүрээлэн үүсгэсэн байв.

Далайн ёроолын тэрхүү цэцэрлэгт хамгийн гоё чимэглэл нь цагаан цэнхэр өнгийн цацагласан тэмтрүүл, сэрсгэр захтай портит хэмээх хөндий биетэн, элсэн дээр од мичид мэт үсэрхийлэн түгсэн далайн одод, салаалсан мушгиа цацраг бүхий далайн офиур хэмээх өргөс биетэнгүүд байв.

Далайн ёроолоор мянга мянгаар дэвсэгдсэн : Молоток, донаци дэвхрэг сам хорхой “Гребешен” трохус, стромбус аплизин хэмээх далайн туулай, далайн барагдашгүй баялаг бусад амьтдыг улан дороо няц няц гишиглэн явахдаа үнэн голоосоо би харамсан хайрлаж билээ. Гэвч бид урагшаа явах нь зайлшгүй биш үү. Бидний толгой дээгүүр тэнгэрийн өнгөт тэмтрүүл бүхий физалийн баг,захаараа ягаан шаргал судлаар хүрээлэгдсэн, зөөлөн ягаан буюу хүрэн ягаан бүрхэвчтэй медузууд алгуурхнаа хөвж байв. Бид пелагей хэмээх медузтай дайралдсан бөгөөд хэрвээ л шөнийн цаг агсан бол Фосфорын гэрэл цацарган бидний замыг гэрэлтүүлэхсэн билээ.

Эдгээр бүх гайхамшигийг би дөнгөж милийн хагасын хагас хэр газраас явуут харсан бүлгээ. Учир нь нэг ч зогсож өхгүй, үргэлж урагшаа алхлан байгаа капитан Немогоос хоцрох аргагүй байв.

Удсан ч үгүй газрын хөрсний байдал хувирч элсэн хив-сэн дэвсгэр, америкчууд “Лаг” гэж нэрлэдэг нялцгар шавраар солигдлоо. Энэхүү лаг шавар ихэвчлэн цахиурлаг болон шохойлог шүр биетнээс тогтоно. Дараа нь бид замаг ургасан талбараар алхаллаа. Өтгөн ургасан өвс ургамлаар хучигдсан усан доорхи, нуга зүлэг, уран хүн нэхсэн сахлаг сайхан хивс мэт хөл доор сэвсийж байв.

Ургамал зөвхөн бидний хөл доор гишгэгдсэнээр ч барахгүй, мөн бидний толгой дээрээс ч салмайх ажээ. Бид бараг замгаар дээвэрлэгдсэн гудамжилсан зэрэглээ шугуй дундуур явж байв. Тэнд урт гэгч нь тууз мэт навчит фукус, бөөрөнхийвтөр болон гуурс хэлбэрийн лауренци, нарийн навчит кладостефууд, дэвүүр маягийн кактустай адилхан өргөн навчит родомени гэх зэрэг ургамал байгаа харагдлаа.

Ногоон замаг далайн гадаргууд нилээд ойр, улаан нь дунд хэр гүнзгийд хүрэн болон хар өнгийн замгууд далайн хамгийн гүн давхаргуудад бүхэл бүтэн цэцэрлэг ой шугуй үүсгэн ургасныг би ажиглалав.

Замаг гэдэг байгалийн ёстой гайхамшиг нь ажээ. Ургамлын энэхүү язгуурт, хамгийн бяцханаас нь аваад хамгийн аврагыг нь хүртэл бүгд хоёр мянга орчим дүрсийн замаг багтдаг юм Тэгвэл тавхан миллиметр шоо дөрвөлжин талбай дээр дөчин мянган ширхэг багтах тийм хомсхон замгаас аваад уртаашаа таван зуун метр тийм том замаг бас байдаг гээч.

“Наутилус”-ыг бид орхиж гарсаар наг хагас өнгөрлөө. Үд болох ойртжээ. Үүнийг би юугаар мэдэв гэвэл нарны гэрэл бараг эгц дээрээс тусаж усан дотор ороод хугарахгүй байна. Өнгө будгийн үзэмжит орчин яваа яваандаа бүдгэрсээр бидний толгой дээрх усан хурмастын оюу номин өнгө аажимдаа алга боллоо.

Бид урагшаа жигдхэн алхахад бидний хөлийн чимээ ер бус тод сонсдож байв. Газар дээр дуулж яваагүй тийм өчүүхэн чимээ л тун түргэн зуур тархах ажээ. Нээрээ ч ус гэдэг орчинд дуу чимээ агаараас хол илуу дамждаг тул ямар нэгэн чимээ усны гаднахаас дөрөв дахин хурдан дуулдаг учиртай.

Энэ үед далайн ёроол нэг тийшээ мэдэгдэхүйц хэвийж ирлээ. Ингэхэд бид зуун метрийн гүнд, арван атмосферийн даралт доор байгаа санжээ. Бодвол миний өмсгөл хувцас иймэрхүү нөхцөлд тохируулагдсан байснаас би даралт ихэссэний улмаас ямар нэгэн зүдэргээ үзээгүй билээ.

Ганцхан л миний хурууны үеүдэд ямар нэгэн ул ойлгогдох ба дайрах байдал

мэдэгдсэн боловч энэ явдал төдөлгүй мартагдсанбайлаа. Би хэдийгээр өөрийн тэрхүү өмсөж зүүсэндээ дасаагүй боловч урт удаан хугацаагаар явган явж сураагүй болохоор энэ хооронд бүтэн хоёр цаг явахад надад ядрах шинж ердөө ч мэдэгдсэнгүй ээ. Харин би усаар дэмжигдэж ер бус хөнгөн хөдөлгөөнтэй алхалж бүлгээ.

Энд гурван зуун метрийн гүнд би нарны гэрлийг бас л харсаар байв. Гэвч дөнгөж бүрэг бараг харагдсан билээ. Өдрийн хурц гэрэл үдшийн улаавтар бор гэрлээр буюу өдөр шөнө хоёрын дундаж өнгөөр солигдов. Гэсэн ч бид замаа нилээд сайн харж явсан тул Румкорфынхоо дэнлүүг ажиллагаанд оруулах арай л болоогүй байлаа.

Гэтэл капитан Немо гэнэт зог тусаж, намайг гүйцэж очмогц гараа урагш сунган бүрэнхийн дунд биднээс хол бус бүдэгхэн харагдаж буй ямар нэгэн бөөн хар юм руу заалаа.

“Креспо арлын ой энэ байх нь ээ” гэж би бодсон минь эндүүрсэнгүй ээ.

[Тор](#)

---

## ДАЛАЙ ДОТОРХ ОЙ

Ийнхүү бид ойн захад ашгүй нэг гарч ирлээ. Бодвол энэ нь капитан Немогийн зах хязгааргүй арвин эдлэнгийн гоц сайхан газрын нэгэн буйзаа. Газар дэлхийг өмчилж байсан анхны өдрүүдэд хүмүүс өөртөө эдэлдэг байсан эрхийн нэгэн адил энэхүү ойг тэр өөрийн өмч гэж тооцож байв.

Креспо арлын ой асар том модлог ургамлаас бүрэлдэж агсан бөгөөд бид тэдгээрийн ханагар мөчир доор явж ормогцоо би тэндхийн моддын мөчир гишүүдийн онцлог нэгэн байдлыг үзэж мэл гайхлаа. Би ер нь хүн болж хүзүү толгой зүүсээр тийм юм үзээгүй билээ.

Доогуур хивс мэт дэвсгэрлэн буй өвс, ногоо моддын хажуугаас салаалж салбарласан мөчрөөс бүгд нугарна, тахийна гэж байдаггүй, харин бүгд дээшээ шугам мэт тэгш боссон байв. Хамгийн нарийхан нахиа төмөр саваа шиг дээшээ хөвчлөн татагджээ.

Фухусууд ба бусад замгууд тойрох орчныхоо нягтаас шалтгаалж, далайнхаа дээд төвшинд, яг эгц босоо ургажээ. Хэрэв би эдгээр ургамлыг гараараа хажуу тийш нь зайлуулаад тавивал дахин босоо байдалдаа шилжиж байв.

Төдөлгүй би энэхүү этгээд хачин босоогийн ертөнцөд биднийг хүрээлэн буй харанхуйд дассаныхаа адил хялбархан даслаа. Ойд газрын хөрс чулуу ихтэй байв. Түүний зэрэгцээ усан доорхи ургамлын төрөл анги маш баялаг мэт санагдлаа.

Би амьтан, ургамал хоёрыг хооронд нь хольж хутган төдий л хялбархан ялгаж таньсангүй. Би ургаа амьтанг, усны ургамалтай буюу аль эсвэл усны ургамлыг ургаа амьтантай эндүүрч байв. Хэн ч гэлээ дээ, ер нь яаж эндүүрэхгүй байх вэ? Энэхүү усан доорхи ертенцийн чинь ургамал амьтан хоёр холь- цолдсон гэдэг нь цадиггүй! Эндхийн бүх ургамал газартай зөвхөн наалдсанаас биш тэндээс ургасан биш гэдгийг би ажиглалаа. Үүнд гайхах явдалгүй. Тэнд үндэсгүй юм чинь газраас шим тэжээл авах гэж газарт нааллдаг юм биш зөвхөн л тулгуур олох гэж авцалддаг юм шүү дээ. Тийм ч учраас тэд элсэн дээр ч шавар дээрч, хаа ч хамаагүй нүүж суудаг юм. Эдгээр ургамал тэднийг хүрээлж байгаа усаар амьсгалж хооллож амьдарч байдаг юм. Тэдгээрийн ихэнх нь навчны оронд этгээд хэлбэртэй бяцхан нимгэн хальснууд соёолуулдаг юм.

Энэ хальснуудын өнгө : Ягаан, улаан, ногоон, хүрэн, бор, бор хүрэн янз байдаг. Би энд “Наутилус”-ын ургамлын цуглуулгын хавтсанд хатаасан байдлаар бус харин бүр амьдрал төгс байдлаар нь дэлгэмэл дэвүүр мэт падин-павлин, тод, улаан өнгө церами, нахиагаа соёолуулж буй ламинар утас маягийн арван таван метр өндөр нероцестей, дээшлэх тусмаа гол нь бүдүүрэх ацетабулярийн баглаа болон далийн бусад олон төрлийн цэцэглэдэггүй ургамлуудыг олж харлаа. Амьтан нь цэцэглээд ургамал нь цэцэглэдэггүй ямар этгээд хачин ертенц вэ? хэмээн нэгэн байгальч хүн усан доорхи ертенцийг дүгнэж хэлсэн юм гэдэг. Хуурай газрын сэрүүн бус орчны моддоос хэмжээгээрээ дутахгүй олон янзын ургамлын нөмөрт амьд цэцгийн бут мэт, ургаа амьтдын бүхэл бүтэн чуулга харагдаж ахуйд тэдний дээр махирласан тууш тууш ховил бүхий меандринууд тунгалаг ганган тэмтрүүлтэй кариофилим хэмээх од хэлбэрийн шаргал өнгөтэй шүүр биетэн сагсайж багсайтал цэцэглэн, энэ бүгдийн дээгүүр хуурай газрын. цэцэрлэгийн гуа үзэмжийг туйлжуулан адилтгах гэсэн мэт калибр шувуухайн үеийн олон бяцхан ялаа загас цэцэгнээс цэцэг дамжих шиг, бидний хэл дороос шар өнгийн леписакантууд, нисдэг тахиа болон моноцентрууд бекас шувуудын сүрэг мэт дээр хий дэгдэж байв. Өдрийн нэг цагийн үед капитан Немо амрах дохио өглөө.

Бид уртын урт орой нь тоть маягийн сүмийн ганжир мэт дээшээ тэнгэр сүлбэсэн алару модны хажууд тэрийж унав.

Энэ амралтын нэн тааламжтай агсныг яана. Ганцхан л хэрэгтэй хэрэггүй юм ярих боломжгүй ажээ. Өмсгөл багтай тул ярьж ч сонсож ч болдоггүй ээ. Би өөрийн асар том зэс толгойгоо Конселийн мөн тийм толгойд ойртуулан өөрийн сайн нөхрийн хөхөж баярласандаа цогшиж гэрэлтсэн хоёр нүдийг харснаар сэтгэлээ хангаж билээ.

Тэр ч гэсэн сэтгэл ханамжтайн тэмдэг болгож ясан толгойгоо төмөр дуулган дотроо инээдэмтэйхэн эргэлдүүлсэн бүлгээ.

Бүтэн дөрвөн цаг зугаалга хийж явсан авч гэдэс өлсөхгүй байгаад би гайхаж билээ. Яахаараа ходоод тийм өлсөж байсныг бүү мэд. Гэвч би усан доор ордог хүмүүсийн нэгэн адил үхтлээ унтмаар байв. Миний нүдний зовхи зузаан шилний цаана аяндаа анилдаж эхэллээ. Би зүүрмэглэж эхэлсэн бөгөөд тэр их нойр ч ганцхан явган яваагийн эрхэнд л баригдаж байсан билээ. Гэвч капитан Немо аврага усаэ цэрэг хоёр аятайхан жишээ үзүүлсэн тул би элсэн дэвсгэр дээр тэр дороо нам унтчихлаа.

Би хичнээн ч унтсан юм бүү мэд. Миний сэрэхэд л капитан Немо босчихсон байсан. Би таатай нь аргагүй суниаж атлаа гэнэтхэн ерөөсөө хэдхэн алхам газар, метр өндөр далайн асар том аалз олж харав. Тэр өөрийнхөө хялар нүдээр цоргих мэт ширтэж байх нь бодвол довтлох гэсэн бололтой. Миний өмсгөл баг түүний шүднээс намайг хамгаалж чадахаар зузаан боловч би айхгүй байж чадсангүй. Яг энэ минутанд өнөө далайчин, Консель хоёр сэрлээ.

Капитан Немо тэр далайчинд нөгөө жигшүүрт муухай амьтныг зааж өхөд тэр бууныхаа мөрлөгчөөр даруйхан цохиж алав.

Тэр асар том үе хөлтөнтэй учирсан явдал далайн энэхүү хөлгүй харанхуй хар цүнхэлд түүнээс ч аюултай, өөр амьтантай учирч болох болон, түүний эсрэг миний энэ өмсгөл хувцас ч хамгаалалт болж үл чадах нэгэн бодлыг надад төрүүлж билээ.

Би болгоомжтойхон явахаар шийдлээ. Би тэрхүү амрал- тыг бидний өнөөдрийн зугаалгын төгсгөл гэж бодсон минь эндүүрэл болж капитан Немо харин «Наутилус» руугаа эргэхийн оронд мөн л урагшлан явдаг байна шүү.

Далайн ёроол улам л хэвгий болж байсан тул бид улам л гүнзгий руу орж байв. Бидний зуун тавин метрийн гүнд хоёр өндөр хадан цохионы хоорондох нарийхан нугад хүрч ирэхэд өдрийн гурван цаг орчим байсан болов уу. Бидний өмсгөл хувцасны ид шидийн ачаар усан дор ороход хүнд байгалиас заяасан хэр хэмжээнээс бид ерэн метр илүү дор оржээ.

Бидэнд хэдийгээр шалган хэмжих нарийн багаж байгаагүй боловч би өөрсдийгөө зуун метрийн гүнд оржээ гэж бодож гаргалаа. Учир нь ерөөсөө ямар ч тунгалаг усанд нарны гэрэл үүнээс гүнд нэвтэрч чаддаг билээ. Тэгвэл бидний байсан тэр гүнд пад харанхуй дүнсийж байв. Гэтэл бидний өмнө гэнэтхэн нилээд хурц гэрэл бадрав.

Энэ нь капитан Немо өөрийнхөө цахилгаан чийдэнг асаасных ажээ. Тэхээр нь Консель бид нар ч гэсэн тус бүрийнхээ чийдэнгийн унтраалга товчийг нэгэнтээ эргүүлбэл тусгай хийгээр дүүргэмэл тахир гуурс цахилгаан гүйдлийн нөлөөгөөр тэрхэн зуур гэрэлтлээ.

Бидний дөрвөн дэнгийн гэрэл далайн усыг эргэн тойрон хорин таван метрийн зайтай гэрэлтүүлэв.

Капитан Немо харанхуй шугуй руу гүнзгийрч орлоо. Мод шингэрч эхэллээ. Энд ургамал нь амьтдаасаа хурдан ховордож байхыг би ажиглав. Бид хэрэв энд далайн ургамлыг олж харахаа бараг больсон бол ургаа амьтан, үе хөлтөн, зөөлөн биетэн, элдэв янзын загас мөн л түрүүчийн хэвээр биднийг тойрон бужигнаж байв.

Миний бодсоноор бол өнөө цахилгаан чийдэн бол далайн амьтдын анхаарлыг татах ёстой билээ. Гэтэл хэрэв л тэд бидэнд ойртож ирвэл, авлахад боломжгүй, нилээд хол зайнд язалзаж байв.

Капитан Немо зог тусаж буугаа онилж байхыг би хэд хэдэн удаа харсан боловч тэр буудалгүй буугаа буцааж хурааж байлаа.

Эцсийн бүлэгт өдрийн дөрвөн цаг орчимд бид ашгүй нэг зугаалгынхаа цаад захад хүрч, ирэх гэсэн газраа хүрч ирэв бололтой. Гэв гэнэтхэн бидний халз өмнө, мангар том боржин цохио бий болсон нь нүх сүв агуй болсон эгц чавчим элгэн улаан хад байв. Энэ нь Креспо арлын бэл, эх газар ажээ.

Капитан Немо зогсов. Тэр бидэнд мөн зогсох дохио өгсөн тул би энэхүү хадан ханыг гэтлэн гарахыг хичнээн хүслээ ч гэсэн зогсохос өөр арга байсангүй. Энд капитан Немогийн эдлэн газрын шувтарга болсон байлаа. Тийм ч учраас тэр хүний хилийг алхахыг хүссэнгүй ээ.

Тэрхэн зурвас газрын цаана, түүний үзэн яддаг өөр ертөнц байгаа бүлгээ!

Ингээд бид буцах замдаа орж, капитан Немо ч мөн бяцхан отрядынхоо манлайд гарч “Наутилус” онгоцны зүг биднийг хөтлөн одлоо. Бид “Наутилус” онгоцондоо өөр замаар буцах мэт санагдаж байв.

Энэ шинэ зам нэн хэц тул тун ядаргаатай, гэлээ ч гэсэн биднийг далайн гадаргууд маш хурдан ойртуулж байв.

Хэдий тийм боловч даралт гэнэт өөрчлөгдөх явдал, хүний биеэс азот их ялгаж цус хөөрүүлдгийн улмаас, бие махбодод муугаар нөлөөлөх аягүй явдлаас болгоомжилж бид усны дээд давхрагад төдий л хурдан гарахыг хичээсэнгүй ээ.

Энэ аюул их гүнзгийгээс дээшээ цочир гарч ирдэг болгоомжгүй улсад усан доор ажилладаг хүмүүст их тохиолддог бүлгээ.

Удсан ч үгүй бид усны гэрэлтэй давхаргад дахин орж ирэв. Энэ хэр нар нилээд доор орж ташуу тусаж байсан тул гэрэл нь усан дотор нэвтрэхдээ хугарч ургамал амьтны биенд солонгорч байв.

Бид арван метрийн гүнд янз бүрийн загас жараахайгаар хүрээлэгдэн алхалж байв. Гэвч одоо болтол бууны дуу нэг гаргачихмаар далайн томхон амьтан олж үзээгүй билээ.

-Гэтэл капитан Немо буугаа дахин мөрөндөө авч бутанд шурган хөдөлж буй ямар нэгэн амьтан руу шагайж байхыг би харав. Тэр гохоо дарлаа. Чихэнд юм исгэрэх сулхан чимээ сонсогдож, биднээс тавхан алхмын зайд ямар нэгэн амьтан унаж ойчих харагдлаа.

Тэр бол далайд оршигч цор ганцхан дөрвөн хөлт амьтан далайн минж байв. Энэ амьтан гэдсээрээ мөнгөлөг цагаан, нуруугаараа хар хүрэн сортой, уртаараа метр хагас арьс орос, хятад газар тун их үнэд хүрдэг. Урт гонзгор бие, богино пагдгар хөл, хавтгай толгой. мухар хоншоор, хулгар чих, урт хавтгай сүүлтэй хуруун завсраа зузаан бөх хальс бүхий тэр амьтныг би их сонирхлоо.

Тэрхуу үнэт амьтан, түүний хойноос загасчид улайран хөөцөлдсөний улмаас сүүлийн жилүүдэд тун ховор болсон юм. Тэр одоо номхон далайн умарт хэсгээр тохиолдох боловч бүр мөсөн үгүй болох цаг нь бодвол холгүй буйзаа.

Өнөө далайчин алагдсан минжийг мөрөн дээрээ авч хаяхад бид цаашаа хөдөллөө.

Бид элсэн хотгор дундуур бүтэн цаг явлаа. Заримдаа тэр дээшээ овойж усны гадаргууд ойртовч, хоёр метр хэр очоод л уруудаж байв. Усны гадаргууд ойртох яг тэр үед л би бидний дээр яг л бидэн шиг улс явж, бидний л яасан бүхнийг дуурайж байхыг нь харж байсан бөгөөд тэд, зөвхөн толгойгоороо уруугаа хөлөөрөө өөдөө харчихсан байв.

Анхаарал татсан өөр нэгэн үзэгдэл гэвэл бидний тархин дээр нарны гэрлийг үүлс хэсэгхэн зуур хөшиглөн өнгөрч хэсэг хэсгээрээ тасралтгүй хөвж байлаа. Энэхүү хачин үзэгдлийн учрыг би бодолхийлж байж сая ухаарвал бидний дээгүүр хөвсөлзөж байсан усны давхаргын зузаан нимгэнээс шалтгаалж ус долгионтсоны учир тэдгээр



үүлс хөвөлзөж агсан ажээ. Би сайн ажиглаж хараад тэнгисийн гадаргуу дээр ус хөөсрөн бургилгаж буйг үзэж билээ Ус маш тунгалаг байсан тул би бүр, бидний дээгүүр түргэн зуур нисэн өнгөрч буй шувуудын сүүдэр дайрч өнгөрөхийг ч ажигласан бүлгээ.

Тэхэд л би, анчин хүн ер нь хэзээ нэгэн цагт олж үзэхэд бэрх нэгэн мэргэн буудалтын гэрч нь болсон юм даа. Ямар нэгэн том шувуу далавчаа өргөн дэлгэн хальсаар ус руу ойртож ирсэн тэр цагт, уул шувуу тод сайхан харагдаж байсан тул түүнийг усанд хэдхэн метр зайтай бяйхад далайчин буугаа мөрөндөө авч буудсан билээ. Ус руу өнөө шувуу чулуу мэг унаж ирэхдээ тун их эрчтэй унасны улмаас усны эсэргүүцлийг давж, мэргэч буучийн гарт бараг өөрөө орж ирсэн бүлгээ. Энэ бол тэнгисийн шувуудын нэг сайхан төлөөлөгч асар том хэмжээний альбятрос байж билээ.

Бид бүтэн хоёр цагийн турш туулахад бэрх замаг ургасан нуга газар, элсэрхэг хотгороор явлаа. Биднээс хагас миль хэртэй газар ямар нэгэн бүдэг гэрэл ёлтойж харагдах үед би эцсийнхаа хүчийг шавхан зүтгэж явснаа үнэхээр хүлээх ёстой. Тэр бол “Наутилус”-ын чийдэн ажээ. Бид хорин минутаас хэтрэхгүй хугацаанд “Наутилус”-д хүрч очих учиртай. Би тэнл дахин цээж дүүрэн амьсгална хэмээн дүүрэн итгэж явсан нь хийн савнаас хоолойгоор дамжиж, миний дуулган дор орж буй амьсгалах агаар дуусч байгаа мэт санаж явав. Гэтэл биднийг хэсэг зуур саатуулсан нэгэн тохиолдлыг би урьдчилан мэдсэнгүй. Би капитанаас хориод алхмын хойно алхаж явтал тэр гэнэт эргэж над руу чиглэн ирлээ. Тэр төмөр мэт хатуу гараараа намайг газарт наалдуулан дарж авахад, өнөө усан цэрэг ч мөн Конселийг тэгж даржээ.

Эхлээд би, ийнхүү бидний зүг гэнэт довтолсон тэр учры нь чухам юу гэж үзэхээ мэдэхгүй гайхаж байтлаа, капитан миний дэргэд мөн адил хөдлөхгүй зэрэгцэн хэвтэхэд нь сая учрыг олж тайвширч билээ.

Би замгийн бутан доор эргэн тойрон чухам юу болж буйг мэдэхгүй хэвтэж атлаа, толгойгоо өргөн дээш харвал бидний дээгүүр гэрэл сацаргасан ямар нэгэн асар том голигор голигор амьтад хөвж өнгөрөхийг харлаа. Энэ аврагуу- дыг би аврага загас буюу акул мөн хэмээн танилаа. Энэ аймшигт амьтан хүчирхэг сүүл, хүнийг ганц үмхэхдээ л хоёр хэсэг болгочих ган мэт хурц шүд, шил мэт гөлийсөн нүдтэй билээ.

Тэр амьтныг Консель ангилан ялгасан эсэхийг ч бүү мэд, харин өөрөө түүний мөнгөлөг цагаан гэдэс, арзайсан олон хурц шүд бүхий ам зэргий нь харчихаад

байгаль шинжээч эрдэмтэн байхаасаа барьц алдсан золиодос амьтан мэт харж хэвтлээ.

Бидний асар их аз болоход тэдгээр аймшигт араатны нүдний хараа төдий л сайн биш билээ. Тэд бидний яг толгой дээгүүр юу ч үзсэнгүй хөвж өнгөрөв. Бид балар харанхуй модонд барстай дайралдахаас ч аюултай аюулаас азтай ангижирч бүлгээ.

Хагас цагийн дараа бид тод цагаан гэрэл нь бидэнд зам зааж агсан “Наутилус” онгоцондоо хүрч очив. Гадаа хаалга нь бидний явсны! дараа хаагдсангүй нээлттэй хэвээрээ үлджээ. Бид өнөөх бяцхан бүхээгт явж очмогц капитан Немо гадаа хаалгаа хаачихав. Тэр дараа нь нэгэн товч мушгимагц онгоцон дотор ажиллаж эхэлсэн шахуурганы шуугих дууг би сонсож өөрийгөө тойрч байсан ус доошилж байхыг мэдэрлээ. Хэдхэн минутын дараа бүхээг дотроос ус бүр мөсөн юүлэгдлээ. Тэр үед дотор хаалга нээгдэж бид хувцасны өрөөнд орж очив.

Надаас өмсгөл багий минь тайлж авахад би үхтлээ ядарчихсан амьтан, ядаргаа нойр хоёртоо бараг савж унахаа дөхөж байсан боловч усан доогуурхи энэхүү гайхамшигт сайхан зугаалгаараа сэтгэл хэмжээгүй ханасан хүн, өөрийн- хөө өрөө руу явж одлоо.

[Тор](#)

---

## **НОМХОН ДӨЛГӨӨН ГАДААД ДАЛАЙ ДООГУУР 4000 БЭЭР АЯЛСАН НЬ**

Маргааш нь арван нэгдүгээр сарын 18-нд би бие амарч, хөл хөнгөрөн босч ирээд, “Наутилус” онгоцны тавцан дээр гарч ирэхэд капитаны туслагч мөн л өнөөх хэлдэг үгээ яг хэлж байв.

Гэнэт миний толгойд энэ үг “Юу ч харагдахгүй байна аа” гэсэн үг байх нь ээ гэсэн бодол төрлөө.

Нээрээ ч тэнгис хов хоосон байв. Далай дээр ганц ч далбаа үл харагдана. Креспо арлын уулс бодвол шөнө үгүй болсон байлгүй. Гэрлийн задаргааны цэнхэр өнгөөс бусад өнгийг шингээн авах тэнгис ганцхан л тэр цэнхэр өнгөө ца- царгаж

харагдав.

Тавцан дээр капитан Немо өөрөө гарч ирэх хүртэл би тэнгисийн өглөөний сайхан. энгийг сониурхан зогсож билээ. Тэр намайг хараагүй юм шиг дүр үзүүлж одон орны шинжилгээний ажиглалтуудаа хийж эхэллээ. Түүнийгээ дуус- гаад тэр жолоодлогын бөмбөгөр тийш очиж, түүнийг тохойлдон далай руу ширтэн зогсов.

Тэр үед онгоцны тавцан дээр хорь орчим далайчин гарч ирснийг ажвал бүгд эрүүл чийрэг, булиа эрс байлаа. Тэд далайд урьд шөнө хаясан тороо татаж эхлэв. Эд олон янзын ястан ажээ. Би тэдний дунд хэд хэдэн ирланд, франц, славян хүн нэг грек, кристо арлын нэгэн иргэн байхыг ялгаж танилаа. Тэд бүгд дуу цөөнтэй, өнөө л миний үүсэл гарлы нь ухааж мэддэггүй үл мэдэгдэх хачин хэл дээр ярьцгааж байв.

Тэд тороо тавцан дээр татаж гаргалаа. Тэр тор нь норманди маягийн болж ирээд доод гогцоонд нь оруулсан мод гинжний тусламжаар нүх нь усан дотор онгорхой үлддэг, том шуудай хэлбэртэй ажээ. Энэ шуудай нь онгоцны хитэгт ган аргамжаар уягдаж, далайн ёроолоор чирэгдэхдээ замдаа тохиолдсон юм бүхнийг хамдаг байв.

Энэ өдөр торонд далайн сонирхолтой амьтад орж баригдсанаас дурдвал: Ер бусын ховдог болохоос гадна, тун этгээд хачин хөдөлдөг, өөрийнхөө муухайд “далайн четгер” гэж хочлогдсон нэг байрнаас нөгөө байранд өөрийн гар сэлүүрээрээ тулж үсрэн явах загасчин загас, энгийн цагт зүгээр нэг гэдэстэн боловч дайсан ойртохыг мэдмэгц гэдсээ хийлэн цүндийлгэж арьсныхаа хуниасыг тэнийлгээд, аймшигт хурц өргөс, арзайсан гэдэстэй болон хувирч, тэр гэдсээрээ дайсныг угтан авах цоохор өнгийн өргөс гэдэстэн зэрэг загас баригдсан байв. Түүнчлэн “Наутилус”-ын тавцан дээр сэгсрэгдсэн торноос хэд хэдэн шаравтар зүсний миног, урт бие нь сүүлийн сэлүүрээр бус утас маягийн урт хялгасаар дуусах хоёрын зэрэг мөнгөлөг саарал хялгасан сүүлт, биений нь доод хэсэг урт шулуун сэлүүрээр эмжигдсэн хэд хэдэн тооны хайрслалг шулуун сэлүүрт, хүрэн толботой шаравтар бор треск, олон терлийн быгки, хамгийн эцэст хэдий их хурдан ч гэсэн асар том торноос зайлж чадаагүй хэд хэдэн ширхэг гойд сайхан тунцууд асгарч байв.

Торонд орсон загас мянган фунтээс доошгүй буйзаа. Энэ нь азтай боловч төдий л гайхалтай бус шүүрдэлт байжээ.

Үнэндээ уул тор онгоцны араас олон цаг чирэгдэж замдаа тохиолдсон бүгдийг шүүрдсэн билээ.

Барьсан бүх загасыг усан цэргүүд зооринд оруулсан бөгөөд тэдгээрийн хагаыг шинэ дээр нь идэж дуусгах, бусды нь өөр талаар эдлэх ёстой байв.

Загас шүүрдэлтийн ажил дуусаж буй тул би онгоц одоохон доошоо живж орно хэмээн бодож өөрийнхөө өрөө руу явахаар завдтал капитан Немо надад ойртон ирж өгүүлэх нь :

- Тэнгис өөд хараач, профессор! Энэ чинь тэхэд танд заримдаа догшин, заримдаа амгалан амьд амьтан биш гэж үү? Тэр өчигдөр бидний нэгэн адил л нойрсож өгсөн бол өнөөдөр, өглөө мөн л нойр сайн ханаж сайхан зантай нь аргагүй сэрсэн ажээ гэлээ.

“Амар мэнд, баяртай маяртай ч үгүй. Хажуугаас нь харсан хүн биднийг дээр эхэлсэн яриагаа л үргэлжлүүлж байгаа юм байлгүй гэж санамаар” хэмээн би дотроо бодлоо.

- Хар л даа, та хэмээн капитан үргэлжлүүлж :

-Нар хүртэл найртай нь аргагүй дэгдэж өдрийнхөө ердийн амьдралаар амьдарч эхлэв бусуу. Энэ далай тэнгисийн биемахбодын амьдрах их чадлыг ажихад ямар сонин бэ! Үүнд бүр зүрх ч бий, судас ч бий гээч. Далайд амьтны цусны эргэлттэй яг адилхан хөдөлгөөн бий гэж тэмдэглэсэн эрдэмтэн Моорийн үгийг би дүүрэн зөвшөөрнө гэлээ.

Калитки Немо надаас энэ үгэндээ хариулт авахыг төдий л их хүсэхгүй байгаа нь харсаар байтал ойлгомжтой тул би түүний үгэнд ямар ч нэмэргүй “мөн тийм” “Таны зөв” (тэгэлгүй яахав) гэсэн хариулт өхөөс өөрийн биеийг чөлөөлж дуугарсангүй.

Капитан Немо ердөө л үгнүүдийнхээ хооронд урт урт зогсолт хийж өөрөө өөртэйгөө ярьж байлаа. Энэ бол хоёр хүний сэтгэмж байв.

Тийм ээ хэмээн тэр үргэлжлүүлэн ;

Далайд халуун хүйтний өөрчлөлт, давс шүүний найрлага нүдэнд үл үзэгдэх бяцхан амьтдын хольцоос шалтгаалж үргэлжийн эргэлт болж байдаг юм. Халуун хүйтний өөрчлөлтөөс усны нягтрал янз бүр болж үүний эцэст урсгал, эсрэг урсгал бий болдог биш үү.

Туйлын бүсүүдэд тун өчүүхэн боловч экваторын орчинд нэн их хэмжээний байдаг усны ууршилт халуун ба сэрүүн орны хооронд усны солилцлыг бас бий болгодог билээ. Түүнээс гадна тэнгисийн ус дээрээсээ доош орж, дороосоо дээш гарч үргэлж хутгалдаж байдгийг би бас ажигласан юм даг. Далайн усны энэ хөдөлгөөн бол далай амьсгалж буй жинхэнэ тэмдэг юм. Нарны илчинд халсан далайн нэгэн дусал гадаргуугаас ёроолд орж, тэгээс дээш хоёр градусын температурт өөрийн хүндрэлийн дээд хэмжээнд хүрч хөрөөд дахин дээшээ дэгддэг

билээ. Энэ үзэгдлийн үр дүнг та хойт туйлын тэнд ажиж мэдээд. ус яагаад дээрээсээ өрөмтөж хөлддөгийн учрыг ойлгох болно гэж ярилаа.

Капитан Немо өөрийн энэхүү яриаг дуусгах хооронд “Мөсөн туйл гэнэ ээ? Энэ зоригт эр биднийг арай тийш нь аваачих гээгүй байгаа?” гэж би бодож амжив.

Тэр хооронд капитан Немо дуугүй болж, түүний хараа тэнгис тийш хандсан бөгөөд тэр усны энэхүү их арвин санг мэрийлттэй; дур сонирхолтой, тасралтгүй судалдаг ажээ. Тэр хэсэг зуур дуугүй зогссоноо, үргэлжлүүлэн;

-Далай өөртөө хичнээн их давс уусгадаг гэж санана.

Хэрэв далайн усанд ууссан тэр их давсыг шүүж тунгааж авах юм бол хааш хаашаа дөрөв аравны таван миль хэмжээний шоо дөрвөлжин болохсон билээ. Хэрэв та, эрхэм профессор, тэрхүү давсыг дэлхийн бөмбөрцөг дээгүүр жигд тараахыг хүсэхсэн бол дэлхийг арав гаруй метр зузаан давс бүрхэхсэн бизээ. Гэвч, та далайн усанд ууссан тэр их давс, байгаль бодисын ямар нэгэн гажууд зангаас шалтгаалсан гэж бүү бодоорой. Тиймээ! давс далайн усны ууршилтыг багасгасны улмаас усны уур салхинд туугдан одохгүй тул манай ертөнцийн сэрүүн бүсүүдийн хур борооноос хамгаалдаг учиртай.

Энэ бол дэлхийн бөмбөрцөг дээр байгалийн их хүчийг тэнцэтгэх агуу их хүндэт үүрэг биш үү гэв.

Капитан Немо дахин дуугүй болж, тавцан дээгүүр хойш урагшаа хэд алхсанаа

:

Тэгвэл, нэгэн дусал усанд хэд хэдэн саяараа байдаг буюу наян мянган ширхэг нь дөнгөж ганцхан миллиграмм жинтэй тэдгээр бактер хэмээх тэр өчүүхэн бяцхан амьтдын гүйцэтгэх үүрэг тийм ч бага бишээ. Тэд далайн усанд буй давсыг өөртөө шингээн авч, далайн усанд уусмал байдалтай байгаа хатуу чанарын бодисуудыг биедээ хураан авдаг билээ. Тэнд, усны гүнд ургаа амьтад шүр биетний болон хөндий хэвэлтний бөөгнөрлүүдийг үүсгэж бүхэл бүтэн арап хойгууд, тивүүдийг тогтоодог юм. Тэхэд ус тогтмол нэгэн байдалд байхгүй дээрээсээ доошоо болон дороосоо дээшээ, цааш наашаа үргэлждийн хөдөлгөөнд оршиж тэдгээр амьд биесийг тэжээлээр хангадаг билээ. Усны энэхүү дээшлэх доошлох цаг үргэлждийн урсгал, цаг үргэлждийн хөдөлгөөн далайд мөнхийн амьдралыг бий болгодог юм. Тийм учраас эх газар, хуурай газраас үлэмж илүү хүчтэй; нэн илүү үр шимтэй, далайн хэсэг бүхэнд үргэлж цэцэглэн байх, үхэж мөхөшгүй, төгс амьдрал энд буцлан байх нь ихэнх хүмүүст амьгүй хоосон мэт боловч энд оршигч тоо томшгүй амьтад болон надад амьдруулах нэгэн орчин болжээ.

Эдгээр үүргийг капитан Немо ярьж байх үед царай нь айхтар хувирч, түүний тэр яриа надад асар их сэтгэгдэл төрүүлж билээ.

- Тиймээ, амьдрал! хэмээн тэр залгуулан авч жинхэнэ амьдрал зөвхөн л энд байгаа юм. Ирээдүйд “Наутилус” шиг өглөө бүхэн цэвэр агаараар амьсгалах гэж дээшээ гардаг орд харш, байшин барилга босгон, хэнд үл ч хамаарах, эрх чөлөөт хотууд усан доор сүндэрлэнэ гэдэгт би хувьдаа бат итгэж байна... Хэн яаж мэдэх вэ. хэрэв ямар нэгэн эзэрхий этгээд... гэж хэлэх гэснээ яриагаа дуусгаж чадсангүй аймшигтайгаар нудрага зангидлаа.

Дараагаар нь ямар нэгэн харамсалт хар бодлоос хагацахыг оролдох мэт царай гарган, шууд над руу хандан:

- Далайн гүн чухам хэд хичнээн болохыг эрхэм профессор та мэдэх үү? гэж асуулаа.

- Би зөвхөн л хамгийн сүүлчийн хэмжилтүүдээр тодорхойлогдсон тэр хэдэн тоог л мэднэ.

- Та тэрнийгээ надад хэлчихвэл болохуу? хэмээн капитан маань надаас асуухад би :

- Дуртай зөвшөөрнө хэмээн эхэлж,

- Би танд юу л санаж буй бүхнийгээ л хэлье. Хэрэв би эндүүрээгүй бол тэнгисийн дундаж гүн Атлантын гадаад далайн умарт хэсэгт гурван мянга есөн зуун метр, Газрын Дундад далайд мянга хоёр зуу, харин Атлантын гадаад далайн өмнөт хэсэгт барагцаалбал өргөргийн гучин тавдугаар хоногт, тэнгисийн хамгийн гүн газрыг хэмжсэн байсан. Тэдгээрийн эцэст нэг газарт арван хоёр мянган метр, нөгөө нэг газарт арван дөрвөн мянга ерэн нэгэн метр, бас нэг газарт арван таван мянга нэг зуун дөчин есөн метр тус тус гүнзгий байжээ. Эрдэмтдийн бодож байгаагаар бол хэрвээ, далайн ёроолыг тэгшитгэж хэмжих аваас түүний гүн, дэлхийн бөмбөрцгийн хаана ч тэр, гурван мянга найман зуун метр байхсан гэж үзэж байгаа юм билээ гэв. Тун сайн, эрхэм профессор хэмээн капитан Немо залгуулан авч,

- Бидэнд арай дээр бол уу гэмээр нэгэн мэдээ сонсогхсондог оо хэмээн найдаж байна. Хэрэв та, Номхон далайн энэхэн хэсгийн гүнзгийг сонирхож буй бол би танд гуравхан мянгаас хэтрэхгүйсэн гэж хэлэхсэн билээ гэв.

Ингэж хэлчихээд капитан Немо нээлттэй байгаа нүхээр орж, төмөр шатаар дамжин доошоо буухад би түүнийг дагалдан одож үзэсгэлэн танхимд орж очив. Яг тэр минутанд сэлүүр сэнс эргэлдэн эхэлж, хурдны хэмжүүр хорин миль заав.

Дараагийн өдрүүдэд, түүгээр ч барахгүй бүтэн долоо хоног капитан Немо

миний нүдэнд тун цөөхөн үзэгдэж билээ. Би түүнтэй их л удаж байж уулздаг байв. Капитаны туслах өглөө бүр өөрийн ажиглалтыг нэн нямбай үйлдэж түүнийгээ газрын зураг дээр тэмдэглэжээ.

Консель, Нед Ленд хоёр надтай өдөр бүр, олон цагаар хамт байлцахад Консель, бидний өнөөх усан доогуурхи жуулчлалын гайхамшгийг ярьж жадчин маань тэр зугаалгад оролцоогүйгээ үнэнээсээ харамсан, хар бууж байв.

Гэвч би далай доорхи ойд жуулчлах бололцоо дахин олдох байлгүй хэмээн түүнийг тайтгаруулж билээ. Үзэсгэлэн танхимын цонхны халхавч бараг өдөр бүр удаан цагаар сөхөгддөг тул бид усан доорхи ертөнцийн гуа сайхныг үзэж бахдаж үл ханах билээ.

Энэ үед “Наутилус” өмнө дорно зүгийг барьж, зуугаас зуун тавин метрийн гүнд явж байв. Гэвч наг удаа капитан Немогийн илүү зан нь хөдөлж, онгоц маань залуурын доош орох мушгилтанд автан далайн ёроол руу хоёр мянган метрийн гүнд орж явчихлаа.

Зуун градусын хувиартай термометр, далайн бусад бүх өргөрөгт нэгэн адил харгалзах мэт тэрхүү гүнзгийг харгалзах температур ( - ) тэгээс дээш дөрөв дөрөвний нэгэн градус халууныг зааж байв.

Арван нэгдүгээр сарын хорин зургааны өглөөний гурван цагт “Наутилус” уртрагийн 172 хоногт мэлхийн халуун бүсийг огтлон, хорин долооноо Сандвичийн арлуудыг өнгөрлөө. Эдгээр арлын орчинд 1779 оны 2дугаар сарын 14-нөө алдарт далайчин капитан Кук амь үрэгдсэн бүлгээ.

Дэлхийг тойрох манай жуулчлал эхэлснээс хойш бид дөрвөн мянга найман зуун жаран бээр газар явжээ.

Би 29-ний өглөө онгоцны тавцан дээр гарч ирвэл, Гавайн олтригийг үүсгэх долоон арлын хамгийн том Гавайн арлыг онгоцноос хоёр миль орчим зайнд салхин доор талаас нь олж үзлээ. Би тариалангийн талбай, уулсын бэл, далайн эрэгтэй зэрэгцэн одсон уулсын хяр, галт уулсууд болон тэдгээрийн дунд далайн төвшнөөс дээш таван мянган метрийн өндөрт дүнхийж буй Мун-Реагийн оргил зэргийг тод ялгаж харав.

“Наутилус” өмнө дорно зүгийг чиглэсэн хэвээрээ явав. Тэр арван хоёрдугаар сарын нэгэнд, уртрагийн 142 хоногт экваторыг огтолж, арван хоёрдугаар сарын 4-нд онгоцны тэмдэглэлт явдал болоогуй түргэн зуурын аяллын эцэст бид, Маркизын бүлэг аралд тулж ирлээ.

Би, өрнөт уртрагийн 39 хоног 32 хувь өмнөт өргөргийн 8 хоног 67хувьд орших

Маркизын арлуудын хамгийн томуудын нэгэн болох Пука-Хивийн арал дээр Мартини оргилыг олж үзлээ. Гэвч, капитан Немо газарт ойртон очих нэн дургүй тул би, уулсыг хучсан өтгөн ойгоос өөр, юуч харж чадсангүй билээ.

Эндхийн уснаа орхисон тор, ер бусын амттай бөгөөд зөөлөн махтай, амтлаг шаргал болж ирээд хөх цэнхэр туяа цацаргасан хэд хэдэн ширхэг макрель, мөнгөлөг өнгөөр солонгорох хөхөвтөр ногоон сарган загас шүүж авчирсан байв. Эдгээр загас идээний ширээнд хүндэт байр эзэлдэг бүлгээ.

Дээр нь Франц улсын далбаа намирч агсан тэдгээр сайхан аралтай салахын ёсыг гүйцэтгээд, арван хоёрдугаар сарын 4-нөөс 11-нийг хүртэл “Наутилус” дахиад хоёр мянга шахам миль давхилаа. Энэхүү жуулчлал толгой хөлтний ангийн хос заламгайтны доод ангид багтах кальмар хэмээх маш соньхон зөөлөн биетний асар их сүрэгтэй тохиолдсоноороо онцгой билээ. Энэ доод ангид сепи болон аргонавтууд мөн хамаарагдана. Эдгээр зөөлөн биетэн яагаад ч юм дээ, эртний байгальчдын анхаарлыг онцгой татаж, эртний илтгэгч- дийн судар бичигт эрхэм суурийг эзэлдэг учраас баячуудын идээ будааны ширээн дээр бага бус хүндлэгддэг байв. Юу ч л гэсэн алдар цуут Галений өмнөхөн амьдарч агсан эртний грекийн эмч Атенс ингэж нотолдог бүлгээ.

“Наутилус” арван хоёрдугаар сарын 9-ний шөнө тэрхүү кальмарын их сүрэгтэй учирсан билээ. Тэдгээр олон сая зөөлөн биетэн май загас ба сардины нэгэн адил сэрүүн бүслүүрээс нилээд дулаан бүсэнд нүүдэг ажээ.

Бид тэдгээрийг зузаан болор цонхны цаанаас ширтэж байхад хөл нь тархин дээрээ байхаар байгалиас заяагдсан тэдгээр кальмарчууд толгой дээрх арван мөчөө зогсоо зайгүй арвалзуулан бөгсөөрөө урагшаа түрэн давхиж харагдав.

“Наутилус” хэдий асар их хурдан давхих боловч олон цагийн турш тэдгээр кальмараар хүрээлэгдэн явсан билээ. Бид усанд тор хаясан нь тэдгээр зөөлөн биентээс нэн олныг барьсан билээ.

Далай биднийг уйтгарлуулсангүй, бидний нүдний өмнө цаг минут тутамд тайз чимэглэлээ өөрчлөн жүжиг үзэгдэл дэлгэн үзүүлж байв. Далай зөвхөн бидний зугаа гаргаад зогсоогүй өөрийн эрдэнийн сангийн нууцад нэвтрэх болол- цоо өгч билээ.

Арван нэгдүгээр сарын 11-нд би үзэсгэлэн танхимд капитан Немогийн номын сангаас ном авч уншин суух үед Нед Ленд, Консель, хоёр гялбам хурц гэрэлтүүлэгдсэн далайг болор цонхны араас нэвт сонирхон байлаа. “Наутилус” энэ үед хөдөлгөөнгүй яг зогсож билээ. “Наутилус” өөрийн усны тусгай багтаамжуудыг усаар дүүргэсэн тул мянган метрийн гүнд байсан бөгөөд усны энэхүү гүн хэсэгт ямар



ч амьтан оршдоггүй билээ. Энд зөвхөн асар том загаснууд л хааяа нэг явдаг ажээ.

Энэ үед би Жак Масэгийн “Ходоодны зуучууд” гэдэг маш сонин ном уншиж агсан тул зохиогчийн хурц оюун өгүүлшгүй сайхан бичлэгийг бахдан баясаж сууж билээ. Гэтэл Консель намайг гэнэт :

- Эзэн хэрэв таалахсан бол цонхонд ойртон ирэхийг хүсэхсэн хэмээн ямар нэгэн хачин этгээд хоолойгоор дуун гарахад ;

- Юу болоо вэ, Консель оо? гэж би асуув.

- Эзэн өөрөө үз л дээ!

Би номоо хойш нь тавьчихаад цонхонд наалдан ус руу харав.

Тэгвэл, цахилгаан дэнгээр гэрэлтүүлэгдсэн шингэн орчинд ямар нэгэн үл хөдлөх асар том бөөн хар юм харагдав. Би тэрхүү аврага амьтныг танихыг хичээнгүйлэн нүд салгалгүй ширтэн ажвал миний толгойд нэгэн бодол аянга мэт гялсхийн орж ирэх мэт болоход би :

- Онгоц! хэмээн бархирав.

- Мөөн...энэ чинь живсэн онгоц байна-гэж Канад хүн хариулав.

Нээрээ ч Нед Ленд эндүүрсэнгүй ээ. Бидний өмнө яах ч аргагүй живсэн хөлөг онгоц байв. Түүний их бие шинээрээ шахам байхыг бодвол аюул учраад хэдхэн цаг болсон мэт ажээ. Тэрхүү онгоцны тавцан дээр гурван тооны шонгийн богино уг байхыг харвал уул онгоц амь гарахын тул шураг модоо тас цавчиж үзсэн бололтой. Гэвч тэр нь тус болсонгүй ээ...

Живсэн тэрхүү онгоцны сэг юутай харамсалтай сэтгэгдэл төрүүлсэн гэж санана!

Гэвч түүнээс ч хэт харамсал төрүүлсэн нь хэд хэдэн хүний хүүр гулдайн хэвтэж харагдах түүний тавцан байлаа. Миний тоолсноор бол зургаан хүний хүүр байсан бөгөөд дөрөв нь эр хүний, нэг нь онгоцны залуурчаас зууралдан зогсоогоороо үхсэн байхаас гадна нэгэн эмэгтэй, хүүхдээ тэвэрсээр жижиг цонхны ирмэг дээр тэгнэж үхсэн байв.

Тэрхүү эмэгтэй нэн залуу ажээ. Чийдэнгийн хурц гэрэлд гэрхүү эмэгтэйн гутаж муудаагүй нуур царайг би ажиг амжив. Бодвол тэр эмэгтэй сүүлчийнхээ тэнхээ шавхан хүүхдээ дээш нь өргөсөн бололтой хөөрхий бяцхан үр нь эхийн- хээ хүзүүгээр тэвэрсэн хэвээрээ тэр чигтээ үхжээ.

Бусад гурван усан цэрэг жирийн бус байдлаар хөшилдсөнийг харвал тэд өөрсдийнхөө биеийг онгоцонд барьж хүлсэн аргамжийг тайлах гэж оролдсоор үхсэн бололтой. Дөрөвдөх хүн, ердийн амгалан бөгөөд зоримог царайтай залуурч босоо чигээрээ, хоёр гараа залуур хүрдэн дээр тавьсан хэвээрээ үхсэн байлаа.

Хөөрхий хөгшин залуурч живж орсон гурван шурагт хөлөг онгоцоо далайн ёроол хүртэл, сүүлчийнх нь замд жолоодсон хэвээрээ байх мэт санагдлаа.

Юун аймшигт үзэгдэл вэ! Бид аюул сүйрлийн тэрхүү аймшигт зурагнаас нүд салгаж чадахгүй байж билээ...

Би асар том аврага загасны сүрэг хүний махны үнэрээр айсуй явааг мөн олж харав.

“Наутилус живсэн хөлгийг бүтэн нэг тойроход би тэрхүү онгоцны их бие дээр:

гэж бичсэн уул онгоцны нэрийг олж уншсан бүлгээ.

[Тор](#)

---

## ВАНИКОРО

Энэхүү эмгэнэлт нэгэн учрал бол дараачийн иймэрхүү олон тохиолдлын хамгийн эхнийх байлаа. Үүнээс хойш бид усны ёроолд ялзарч гүйцэж буй живсэн онгоцны сэгийг “Наутилус”-ын цонхоор байн байн олж үздэг болов. Далайн гүнд зэвэнд идэгдсэн их буу, сум, гинж, занга болон бусад өдий төдий төмөр эллэл байхыг бид олж үздэг байлаа.

Арван хоёрдугаар сарын 11-нд бид Памумотугийн ольтригт ойртон ирсэн бөгөөд эдгээр ольтригт Бугенвиль (цаг үедээ “Аймшигт бүлэг арлууд” гэж нэр өгсөн) ажээ. Энэхүү ольтригийн арлууд өмнөт өргөргийн 13 хоног Зхувь 20дахь хоног 50 хувь болон өрнөд уртрагийн 125 дугаар хоног, 30 хувь хүртэлх хувиаруудын хооронд дорно-өмнө, дорноос өрнө, умар өрнийг чиглэн хоёр мянга илүү километр газар цувран тогтсон ажээ. Эдгээрийн хамгийн зүүн захын бүлэг арлыг Дюгийн арлууд гэх ба баруун захын хэсэг арлыг Лазаревийн арлууд хэмээн нэрлэдэг юм.

Энэхүү ольтриг нийт гурван зуун далан хавтгай дөрвөлжин бээр талбайг эзлэн жаран тооны бүлэг арлыг багтаан тогтсоны дотор Франц улсад харъяалагдах Гамбьейн бүлэг арал орно. Эдгээр арал бүгд шүрэн арал билээ. Хөндий биетнүүдийн удаан боловч цөхрөлтгүй үйлчилгийн эцэст тэдгээр арлыг усан дээр ил гаргаж, эрт орой

хэзээ нэгэн цагт хооронд нь холбох юм. Дараа нь эдгээр шинэ арал зэргэлдээ ольтригтой нийлэхэд нэг талаас шинэ Зеланди, шинэ Коледони хоёр нөгөө талаас : Маркизын арлууд нэгэн бүтэн шинэ тив үүс- гэх болноо.

Би нэгэн өдөр энэхүү онолыг капитан Немод хэлэхэд капитан надад хүйтнээр хариу хэлсэн нь;

-Хуурай газар шинэ тивээр дутаагүй, харин шинэ хүмүүсээр дутаж байгаа юм шүү! Гэж хариулж билээ.

“Наутилус”-ын явах чиглэл ольтригуудын дотроос хамгийн сонирхолтой арал болох Клермон-Тоннер арлын дэргэдүүр санамсаргүй өнгөрөв. Тэр санамсаргүй тохиолдол Номхон далайн энэхэн хэсэгт байгаа арлууд тасарч тогтсон, шүрийн төрлийн маш сонирхолтой хөндий биет амьтнуудын чуулганыг судлах их завшаан над өглөө. Эдгээр шүр биет амьтад шохойлог бүрхүүл бүхий амьд бие махбод ажээ. Тэдгээрийн бие цогцсын хэлбэржлийн ялгаа миний алдарт багш Мильн-Эдвардст тэдгээрийг нийт таван хэсэг болгон хуваах боломжийг өгчээ. Эдгээр түм түмэн маш бяцхан амьтад нийт нэгэн цуваа болон бөөгнөрч шрийн төрлийн хөндий биетний бие махбодыг үүсгэдэг ажээ. Тэдгээрийн ялгаж гаргасан шохойлог бодисоос хад цохио, арал хойг тогтдог байв. Энэхэн орчинд бол тэд, далайтай усам доорхи нарийхан ангал завсраар харилцдаг өчүүхэн нуур буюу гүехэн тохойг хүрээлсэн шохойлог цагираг үүсгэжээ. Тэнд усан доор тэдгээр бяцхан амьтад шинэ Кальдоны эргийг тойрсон буюу Паумотугийн бүхэл бүтэн ольтригийг тогтоосон хад цохионы нэгэн ижил хадан цохио хана хэрэм босгон байдаг ажээ. Өөр газар, жишээлбэл, Маврикийн арлууд дээр тэдгээр амьтад хажуу ёроол дороо хэр хэмжээгүй гүн гүнзгий усан эргүүлгийг үүсгэн эгц цавчим, маш өндөр арсгар хана болон боссон байдаг.

Бид, Клермон-Тоннер арлаас хэдхэн кабельтийн газар явахад би тэдгээр хомсхон барилгачдын хийж бүтээсэн нүсэр их ажлыг бахдаж барахгүй явлаа.

Ийм хана бүтээж босгоход тэр амьтад хэд хичнээн хугацаа хэрэгтэй бол хэмээн Консель надаас асуухад би эрдэмтдийн бодож гаргаснаар бол зуун жил болоход энэ хадан хана өндрөөшөө нэг дүймыг найм хуваасны нэгийн хэртэй ургана гаж хариулбал тэр мэл гайхаж байна.

-Тэгвэл энэхү хадан хана гурван зуун метр өндөр болох юм гэхэд...

-Зуун ерэн хоёр мянган жил хэрэгтэй дээ, хонгор минь! Тэгвэл шашны судар бичиг газар дэлхийн насыг дэндүү багасгажээ. Түүнчлэн галба юүлэхийн өмнө байсан ой мод, чулуу нүүрс болон хувирах болтол хичнээн их хугацаа хэ- рэгтэй байсныг авч үзвэл тэр судар бичгийн нотолгоо төдий л баттай биш болох билээ.

“Наутилус” далай дээр хөвж гарах үед би уснаас дөнгөж бултайн өтгөн ойгоор хучигдсан Клермон-Тоннер арлын гадаад байдлыг нарийвчлан судаллаа. Түүний шохойлог хөрс шороо үер шуурганд далайн давслаг усаар бордогдсон буйзаа.

Тэр нэгэн сайхан өдөр зэргэлдээ хуурай газар дээрээс салхинд хийссэн ямар нэгэн үр далайн замаг, загасны ялзармал үлдэгдлээр тэжээгдсэн эндхийн хөрсөн дээр унаж ургасан бизээ. Дараа нь мянга мянган миль зайтай газар ургаж агсан наргилын самар далайгаар урсч ирээд долгиогоор эндхийн эрэг дээр шидэгдсэн ч байж магад; хийсч ирсэн жимс үр хөврөлийг олж мод болон ургахад, модод хур чийгийн ууршлыг биедээ татаж, булаг ундрал, өвс ургамал битүү бүрхсэн бизээ. Тэрчлэн бас зэргэлдээх хуурай газар дээрээс моддын хамт хаягдсан ямар нэгэн өт хорхой, шавьж тэргүүтэн энэхүү арлын хамгийн анхны оршин суугч болсон буйзаа. Гэтэл бас яст мэлхий эргийн элсэнд өндгөө булж, залуу моддын мөчир дээр шувуу үүрээ зассан болов уу. Ийнхүү амьтдын хүрээлэн аажимдаа олшрон түгсэн байх. Ингээд хамгийн эцэст залуу ургамал, баялаг амьтдын чуулганд татагдсан хүн ирж суурьшсан бизээ.

Эдгээр арал дээр нэн бяцхан амьтдын хүч хөдөлмөрөөр амьдрал ийнхүү бий болжээ.

Орой тийшээ Клермон-Тоннер арлын бараа далд орж “Нау тилус” чигээ өөрчиллөө. Уртрагийн 135 дугаарт хөлөг матрын халуун бүс хүрмэгц усан доогуур явагч хөлөг өрнө-умар-өрнө зүг чиг авч халуун бүснээс гарсангүй цаашлан явлаа. Халуун орны нарны илч тэсэхийн эрхгүй төөнөх авч бид халуунд ядарсангүй бөгөөд гуч дөчин метрийн гүнд усны температур арав, арван хоёр градусууд хэтэрсэнгүй ээ.

Арван хоёрдугаар сарын арван таванд Номхон далайн сувд эрдэнэ болсон Таити арлаас буруухнаар өнгөрлөө. Өглөө нь би салхины доод тал руу онгоцноос хэд хэдэн миль зайд тэрхүү арлын уулсын өндөр оргилыг олж харсан билээ. Түүний орчны уснаас бид далайн могойны нэгэн дүрс өнгийн пеламид, тунец, макрель зэргийн хэд хэдэн төрлийн агуу сайхан загас барьсан бүлгээ.

“Наутилус” найман мянга нэгэн зуун миль яваад байв. Бид “Арго” “Дюк-оф-Портленд” хоёр хөлгийн баг сөнөсөн Тонга-Табу хэмээх ольтригийн дэргэдүүр явж өнгөрөхөд “Наутилус”-ын хурдын хэмжүүр явсан газрын есөн мянга долоон зуун хорь дахь милийг зааж байв. Дараахнаар нь бид Фиджи арлыг тойрлоо. Энд “Юнион” онгоцны багийнхныг, “Эрхэмсэг Жозефина” онгоцны ахмад Бюрог зэрлэг хүмүүс алсан юм. Энэхүү ольтриг өрнөд уртрагийн 174-179, өмнөд өргөргийн 62° дугаар хоногуудын хооронд баруунаасаа зүүнээ гурван зуун жар, хойноосоо урагшаа дөрвөн зуун кило-

метр үргэлжилнэ.

Тэр хэдэн арван том жижиг арал, хад хясаануудаас тогтсоны хамгийн том нь Вити-Леву, Банда-Леву, Кандубон зэрэг арал болно.

Эдгээр арлыг Торчелл анх бораметр бий болгосон жил буюу 1643 онд Тасман нээж одсон бөгөөд мөн тэр жил XIV Людовг Францын хаан ширээнд суусан бүлгээ. 18 дугаар зууны хоёрдугаар хагаст тэр арлууд дээр Кук очиж, да-раа нь Д. Антракосто айлчлаад, хамгийн суулд 1827 онд Дю-мон-Дюрвиль газар зүйн энэ бүх ээдрээ гаргажээ.

Лаперузын хөлгүүдийн сүйрлийн нууцыг анх тайлсан капитан Диллоны зүрх шимшрэм учралтай нэр уялдсанаараа дурсгалтай Вагелетой тохойд “Наутилус” ойртлоо.

Бид энэ тохойн ёроолд хэд хэдэн удаа тор хаяж олон тооны эмгэн хумс гаргаж тэдгээрийг ширээнийхээ ард тэр доор нь хомхойрон идэж билээ. Вагелеа тохой эмгэн хумсны хаялга хэмжээгээрээ асар том ажээ.

Эмгэн хумс тус бүр хоёр сая орчим өндөг гаргадаг тул хэрвээ л тэдгээрийг цөлбөдөг үй олон дайсан байгаад, тэдгээрт үржих бололцоо өгдөггүйсэн бол энэхүү тохой төдөлгүй эмгэн хумсаар дүүрэх байв.

Мань Ленд өөрийнхөө хомхойролд сүүлд нь гэмшиж дуу тавиагүй нь эмгэн хумс гэдэг амьтны махыг хүний ходоод боловсруулж чадахгүй байх ёсгүй, цор ганцхан зууш болох тул болой. Үнэндээ ч насанд хүрсэн хүний нэг өдрийн хоолонд байвал зохих гурван зуун арван таван грамм азотлог бодисыг хүртэхийн тул энэхүү толгойгүй зөөлөн биетэй эмгэн хумсыг зуун ерэн хоёроос доошгүй залгих хэрэгтэй бол уу.

Арван хоёрдугаар сарын хорин таванд “Наутилус” 1606 онд Квирос нээж, 1768 онд Бугенвил судлан шинжлээд, 1773 онд Кук одоогийнх нь нэрийг өгсөн Шинэ-Гебридийн ольтриг дунд хөвж байв. Энэ хэр бид Арру аралд нилээд ойрхон явав. Үд дундын ажиглалтын үед би онгоцны тавцан дээр гарч ирэхдээ энэхүү арлыг олж харлаа. Тэр арал нэн өтгөн ойгоор битүү хучигдаж, өндөр уулын шовх шовх оргилоор чимэгджээ.

Би капитан Немог найм дахь өдрөө олж үзсэнгүй. Тэр арван хоёрдугаар сарын 27-ны өглөө онгоцны үзэсгэлэн танхимд орж ирээд толгой дохих нь тав хүрэхгүй минутын өмнө гараад орж ирсэн хүний байртай харагдлаа. Тэр үед би зураг дээр “Наутилус”-ын замыг мөрдөж суув.

Капитан ширээнд ойртон ирж зураг дээр хуруугаараа хатгахын хамт:

- Ваникоро хэмээн дөнгөж ганцхан үг хэллээ.

Тэр үг нь миний чихэнд буун дуу мэт тод сонсдож билээ. Учир нь Лаперузын хөлгүүд сөнөсөн тэр арлын нэр тийм байсан юм.

-“Наутилус” Ваникорог чиглэн явна уу? гэж би босон харайвал :

-Тиймээ, профессор минь гэлээ. Би ”Буссоль” “Астроляби” хоёр бут үсэрсэн тэрхүү алдарт арлыг нүдээрээ үзэх нь ээ! Бид удахгүй Ваникоро хүрэх үү?

- Бид хүрчихээд байна аа, профессор гуай.

Би капитаныг дагалдан онгоцны тавцан дээр гарч орчин тойрныг шунахай нь аргагүй эрэгцуулэн харвал зүүн хойт зүгт дөчин миль орчим үргэлжилсэн урт шүр далангаар хүрээлэгдсэн яах ч аргагүй л галт уулын оргилтоос гарал үү- сэлтэй хоёр арал бүртийн үзэгдлээ.

“Наутилус” шүр далан дотор нарийхан зурвас судгаар шурган орвол далайн усны түрлэгийн шугамын цаадтай тавиас жаран метр гүн зогсоолд орсон байв. Өндөрр өндөр дал моддын сүүдэр дор, бидний ойртож буйг нэн их анхааран ширтэж буй хэд хэдэн зэрлэг хүн байхыг би олж харвал тэд “Наутилус”-ын ээрүүл хэлбэрийн хав хар их биеийг асар том халим хэмээн эндүүрсэн буйзаа.

Капитан Немо надаас Лаперузын сүйрлийн тухай чухам юу мэдэх вэ гэж асуухад би ;

Нийтэд л юу мэдэгдсэн бол тэрний нь л би мэднэ гэж хариулав.

-Маш сайн. Гэлээ ч гэсэн та тэр нийтэд мэдэгдсэн зүйлээ надад хэлчихэж болох уу?

-Тун дуртай ярьчихъя хэмээн би Дюмон-Дюрвилнийн мэдээлсэн бүхнийг сонсголоо.

-Тэдгээр баримтат зүйлийн агуулга нь гэвэл : Лаперузаг, түүний туслах Ланглийн хамт 1785 онд XVI Людвиг “Буссоль” , “Астроляби” хэмээх хоёр жижиг хөлөгтэй дэлхийг тойрох аянд явуулсан юм.

Францын засгийн газар Лаперузын хөлгүүдийг удаан хугацаагаар үгүй болчиход нь сэтгэл түгшин 1791 онд аврах экспедицийг Бруно Д. Антракастогийн удирдлагын доор төхөөрөн, “Итгэл” “Хайгуул” гэсэн нэртэй хоёр том хөлгийг Брестээс есдүгээр сарын 28-нд хөдөлгөсөн ажээ. Түүнээс хоёр сарын дараагаар Францын засгийн газар “Эльбермель” хэмээх онгоцны капитан Боуэн гэгчээс өмнөт Георгийн эрэг орчинд ямар нэгэн эвдрэл сүйрлийн үлдэгдэл байна гэсэн мэдээ авсан боловч энэ мэдээг жич хэлэхэд төдий л тодорхой мэдээг авч чадаагүй. Д. Антракasto, капитан Гунтерийн илтгэлд дурьдсанаар Лаперузын хөлгүүдийн сүйрэл болсон адмиралтействын арлуудыг чиглэн өөрийн аянг үргэлжлүүлсээр байжээ.

Д.Антрамастогийн эрэл ямар ч амжилт олсонгүй ээ. “Итгэл”, “Хайгуул” хоёр Ваникоро

арлын дэргэд зогсолгүй өнгөрчээ. Тэрхүү аян нэн азгүй төгсч Д.Антракasto өөрөө, хоёр туслах ба хэд хэдэн далайчныхаа хамт амь сүйджээ.

Лаперузын хөлгүүдийн сүйрлийн маргаангүй мөр дээр далайн хөгшин чоно капитан Дильон анх орчихсон байлаа. 1824 оны 5 дугаар сарын 15-наа “Ариун Патрик” хэмээх онгоц шинэ Гебридийн арлын нэгэн болох Тикопиа арлын дэргэд зогссон гэнээ. Тэнд нэгэн улаан арьстан капитан Дильонд бариул дээр нь ямар нэгэн бичиг сийлсэн сийлмэлийн иш худалдсан байжээ. Тэр улаан арьстан түүнээс зургаан жилийн өмнө Ваникоро арлын дэргэдэх уснаас цухуйсан хад мөргөж сөнөсөн онгоцон дээр явсан хоёр Европ хүнийг уул арал дээр олж харсан гэжээ.

Тэр даруй л Дильон дэлхий нийтээрээ сэтгэл түгшиж байсан Лаперузын хөлгүүдийн сүйрлийн тухай ярьж буйг таамаглажээ. Тиймээс тэр улаан арьстнуудын хэлснээр сүйрлийн ул мөр элбэг үлдсэн Ваникоро арал хүрэхээр шийджээ. Гэтэл тэр шийдвэрээ хэрэгжүүлэхэд нь далайн урсгал, салхи хоёр саад одсон байв.

Дильон тэндээс Калькутт хүрч өөрийн нээлтээрээ тэнгисийн тээврийн Азийн нийгэмлэг, Ост-Дорнот-Энэтхэгийн компани зэргийг гайхуулж чадаад мөн “Хайгуул” гэсэн нэртэй өөр нэгэн хөлөг онгоц авч 1827 оны нэгдүгээр сарын 28-наа Францын засгийн төлөөлөгчийг онгоцондоо авч, Калькуттаас хөвөн оджээ.

Номхон далайн хэд хэдэн хэсэгт зогсож, ажиж дөхсөөр явж 1827 оны 7 дугаар сарын 7-нд “Хайгуул” онгоц одоо “Наутилус” зогсож буй Вану хэмээх тэр зогсоолд зангаа хаясан гэнэ ээ.

Тэнд Дильон сүйрлийн нэн олон сэг олсны дотор хөлөг онгоцны занга, элдэв төрлийн багаж, ачаа өргөх хэрэгсэл, чулуу дүүгүүрдэгч зэвсэг, арван найман футын ном, одон орны судлалын эвдэрхий багажууд байсан бөгөөд эдгээрийн хамгийн эцэст “Намайг Базен цутгав” гэсэн бичиг, “1785 онд Брестийн зэвсгийн үйлдвэр цутгасан тамгатай хүрэл хонх олжээ. Иймд одоо эргэлзэх явдалгүй болжээ.

Дильон иш баримттай зүйл их цуглуулахын тул 1827 оны аравдугаар сар хүртэл Ваникоро арал дээр байжээ. Дараа нь зангаа өргөж Шинэ Зеландаар дайран Калькутт орж, тэндээс Францад очиход түүнийг нэн их найрсаг хүлээн авчээ.

Яг тэр үеэр сураггүй алга болсон Лаперузын алдарт зориулан нэрлэсэн “Астроляби” онгоцны капитан Дюмон-Дюрвиль. Дильоны нээлтийн тухай юу ч мэдсэнгүй сүйрлийн ул мөрийг шал өөр зүгт эрж явжээ. Нэгэн халимын ангуучаас Лузиад ба Шинэ Каледоны зэрлэг хүмүүст умарт Людовигийн одон ба медаль байгаа сураг дуулжээ.

Дильон, Ваникоро арлыг орхиж одсоноос хоёр сарын дараа Люмен-Дюрвиль,

Гобарт-Тоуны арлын дэргэд зангаа хаясан ажээ. Зөвхөн энд л тэр Дильоны бүтэмжийг олж сонссон байв. Гэтэл бас мөн тэндээ Калькуттаас яваа "Юнион" хөлөгний капитаны туслах Джемс Гоббс гэгчээс өөр нэгэн тодорхой баримтат зүйл дуулжээ. Түүний нотолсноор бол тэр өмнөт өргөргийн 8 дахь хоног 18 дахь хувь, дорнод уртрагийн 15 дахь хоног 30 дахь хувь хоёрын хооронд буй арал дээр зогсоход тэндхийн зэрлэгүүдэд төмрийн гонзгой хэсэг болон улаан эдийн тасархай байхыг олж үзсэн гэжээ.

Дюмон-Дюрвиль тэдгээр эсрэг тэсрэг хоёр нотолгооны алинд нь үнэмшихээ мэдэхгүй гайхаж атлаа юу ч гэсэн капитан Дильон өөрөө явахыг шийджээ.

1828 оны хоёрдугаар сарын 10-нд "Астроляби" онгоц Тикопиа аралд хүрэлцэн ирж, тэнд байсан цагаан арьстан нэгэн усан цэргийг онгоцондоо боцманы тушаалд элсүүлэн аваад Ваникоро арлыг чиглэжээ. Тэр аралд хоёрдугаар сарын 12-ноо хүрэлцэн ирээд "Астроляби" хөлөг уул арлын шүрэн цагирагийн гадна талд ес хоног хүлээсний эцэст хоёрдугаар сарын 10-нд Вану зогсоолд орсон ажээ.

"Астроляби" онгоцны цэргүүд арлыг тойрч эрэлхийсний эцэст, 23-ны өдөр, эвдрэл сүйрлийн баримт болоход тэдний л хэрэг болохгүй хэмхэрхий үлдэгдэл хэдхэнийг авчирчээ. Нутгийн зэрлэгүүд онгоц сүйдсэн газрыг зааж өхөөс татгал- заж хэл мэдэхгүй буюу ойлгохгүй байгаа маяг үзүүлсний зэрэгцээ зэрлэгүүдийн байдал сэжиглэлтэй болж сүйрэлд учирсан хүмүүстэй тэд муу харьцсан болов уу гэсэн бодол төрүүлж билээ. Үнэхээр ч Люмен-Дюрвилийг зэрлэгүүд, Лапе- руз ба түүнийг дагалдсан хөөрхийгийн өшөөг авахаар ирсэн болов уу гэж айсан ч байж магад билээ. Ингэтэл хоёрдугаар сарын 26-нд элдэв төрлийн бэлэг санд болон амлалт баталгаа зэрэгт сэтгэл татагдсан улаан арьстнууд өш хонзонгийн аюул тэдэнд заналхийлж буй биш гэдгийг ойлгомгоц капитаны туслах Жакинод онгоц сүйдсэн газрыг зааж өгчээ.

Тэнд дөрөв таван метрийн гүнд Паку, Вану хоёр хадны хооронд шохойлог бүрхүүлээр хогжруутсан занга, их буу, төмөр ба тугалган хулдац зэрэг зүйлс хэвтжээ. "Астроляби" онгоцноос тусгай завь очиж тэнд байсан манга найман зуун фунт хүнд занга болон найман фунтийн сумаар бууддаг их буу, хоёр чулуу шидэгч нэгэн гонзгой тугалган цул зэргийг арай ядан татаж гаргасан ажээ.

Дюмен-Дюрвиль улаан арьстнуудыг сайтар байцаан асуусны эцэст, Лаперуз тэрхүү арлын дэргэд хоёр хөлгөө хоёулыг алдсаны эцэст, тэдгээрийн сэгээр гурав дахь бяцхан онгоцоо барьж задгай их далайд үл мэдэгдэх зүг гарч өгчээ... Чухам хаашаа явсныг хэн ч үл мэднэ.

Иймд "Астроляби" онгоцны дарга мангифер модны дэргэд зоригт далайч Лаперуз ба



түүний нөхдийн дурсгалт хөшөө барихыг тушааж, шүр гантиг суурьтай жижиг дөрвөлжин суврага босгохдоо, зэрлэгүүд эвдлэн сүйтгэхээс болгоомжилж уул хөшөөндөө хэсэгхэн ч төмрийн зүйлтэй юм оруулсангүй ээ.

Түүний дараа Дюмен-Дюрвиль шалавхан зангаа өргөн авч одохыг завдсан боловч “Астроляби” хөлгийн баг энэ газар ширүүсч байсан халуун ханиад өвчинд нэрвэгдэж капитан өөрөө ч гэсэн хүнд өвчтэй агсан тул зөвхөн гуравдугаар сарын 17-ноо эргэх замдаа оржээ.

Түүний зэрэгцээ Францын засгийн газар Дюмен-Дюрвиль, түрүүчийн ярьсан Дильоны тухай юу ч мэдэхгүй байх бий хэмээн болгоомжилж Ваникоро арлын зүг Легоарна ДеТромеленоор толгойлуулан “Байонезку” хэмээх жижиг хөлөг явуулжээ.

“Байонезку” хөлөг, “Астроляби” онгоцыг Ваникороос явснаас хэдэн сарын дараагаар тэнд хүрэлцэн очиж ямар ч шинэ сонин зүйл олсонгүй боловч зэрлэгүүд Лаперузын хөшөөг хөндөөгүй байгааг үзэж иржээ.

За тэгвэл капитан Немод миний уламжилж чадах зүйл энэ л байлаа.

- Тэгвэл хэмээн тэр надад тэрхүү арал дээр эвдэрсэн хоёр хөлгийн сэгээр барьсан гуравдахь онгоц чухам хаана, хэрхэн сөнөснийг одоо хүртэл хэн ч мэдэхгүй байх нь ээ? гэвэл :

- Тиймээ, хэн ч үл мэднэ гэж би хэллээ. Капитан надад юу ч хэлсэнгүй, харин өөрийн хойноос дагалдах дохио өгөөд үзэсгэлэн танхимд явж орлоо. “Наутилус” хэд хэдэн метрийн гүнд доошоо живж ороход, түүний хажуугийн хоёр гэгээвчний төмөр халхавч сөхөгдлөө.

Би гэгээвчинд духаа наалдуулан харвал далайн ёроолым шохойлог тогтоц, ургаа ба суугаа амьтад, замаг урагш хойшоо сүлжилдэх үй слон загасны дунд Дюмон-Дюрвилийн экспедицийнхэн гаргаж авч чадаагүй сүйрлийн үлдэгдэл.занга, их буу, шураг мод, гинж, ном зэрэг юмс байлаа. Эдгээр сэгийг би харж харамсан байсан тэр цагт капитан Немогийн хоолой чичирхийлэн байж өгүүлэх нь :

- Лаперузын экспедицийн францын эргээс 1785 оны арван хоёрдугаар сарын долоонд “Буссоль” “Астроляби” гэдэг хоёр хөлөгтэй гарсан билээ. Тэд эхлээд шинэ Каледони дээр Ботани-Бей хүрч, тэндээсээ Санта-Круцийг чиглээд Гавайн бүлэг аралд хамаарагдах Намук аралд ирж зогссон юм. Ингээд Лапе- рузын хөлгүүд Ваникорын үл мэдэгдэх хаддын ойролцоо хүрэлцэн ирэхэд түрүүлж явсан “Буссоль” өмнөт эргийн нь тэнд усан доор байсан хад мөргөсөн тул түүнд туслахаар яаравчилсан “Астроляби” мөн хад руу мөргөчихжээ. Түрүүчийн нь хөлөг бараг нүд ирмэхийн зуур сөнөж үгүй болсон боловч салхины нь доохно хадан дээр мордчихсон

хоёрдахь онгоц хэд хоног тэсчээ Аюул суурэлд учрагчдыг нутгийн улаан арьстнууд нилээд сайхан хүлээн авсан тул Лаперуз уул арал дээр суурьшиж сөнөсөн хоёр онгоцныхоо үлдэгдлээр гурав- дахь жижиг онгоцоо барьж эхэлсэн юм. Хэд хэдэн усанцэрэг Ваникоро арал дээр сайн дураараа үлдэж хүнд ажил, өвчин хоёрт эцэж туйлдсан бусад хэсэг нь Лаперузын хамт цаашаа Соломоны арлуудын зүг явсан боловч тэдгээр арлын хамгийн гол, том арлын дэргэд ханамж, гутамж хэмээх хоёр хадан хушууны хооронд онгоцтойгоо бүгд үхэж үгүй болсон бүлгээ хэмээв.

- Та хаанаас энэ бүхнийг мэдсэн юм бэ?-гэж би хашгарч архивол:

- Тэдний сөнөсөн сүүлчийн газраас үүнийг л би олсон юм даа гэж капитан Немо таг дээрээ францын сүлдтэй төмөр хайрцаг надад үзүүллээ. Тэрхүү хайрцагт давстай усанд зэвэрчихсэн хуйлаастай, баримт бичиг байхыг үзлээ.

Энэ нь нүүрэн дээрээ XVI Людвигийн жинхэнэ өөрийнх нь тэмдэгтэй, тэнгисийн сайдын заавар бичиг байв.

-Далайчин хүний үзэл ийм л байх ёстой?-хэмээн капитан Немо хэлээд, тэр одоо далайн ёроолын шүрэн булшинд амгалан нойрсч буй миний болоод миний нөхдийн булш ийм л байвал би нэн их баярлахсандаа гэлээ.

[Тор](#)

---

## ТОРРЕСЫНХООЛОЙ

Арван хоёрдугаар сарын 27 – 28-ны шөнө “Наутилус” Ваникор арлыг орхиж баруун өмнө зүгийг барин маш их хурдтай явж одлоо. Ваникорог шинэ Гвинейн зүүн өмнөт хэсгээс тусгаарлаж буй зай буюу гурван мянга илүү километр газрыг гуравхан хоногт туулав.

1863 оны нэгдүгээр сарын нэгний өглөө “Наутилус” онгоцны тавцан дээр Консель надтай дайралдаж :

-Шинэ жилийн мэндийг хүргэж, сайн сайхныг ерөөхийг эзэн зөвшөөрөхсөн балов уу? гэж түүний асуухад би :

-Тэгэлгүй яахав, тэгэлгүй яахав Консель минь чинийхээ ерөөл, мэндчилгийг би, бид Париждаа, цэцэрлэгтээ, миний ажлын тасалгаанд байгаа шигээ л дуртай хүлээн авах байнам.

Чинийхээ ерөөл мэндчилгээнд баярлалаа. Түүнчлэн бас чамдаа баяр хүргэе. Ганцхан л чиний тэр энэ нэгэн шинэ жилийн сайн сайхан гэдэг үгий чинь юу гэж ойлгож болох вэ? Чиний тэр сайн сайхан гэдэг чинь бидний энэхүү олз-логдсон бэйдал дуусвар болоход оршино уу, аль эсхүл энэхүү агуу сайхан жуулчлал үргэлжлэхэд оршино уу?

- Үнэндээ би эзэндээ чухам юу гэж хариулахыг үл мэднэм. Яах аргагүй л бид нэн сонирхолтой юм үзэж, энд өнгөрөөсөн хоёр сард уйдаг зав олдсонгүй. Сүүлийн үед эндхийн байдал нэн гайхамшигтай болж, хэрэв л энэ бүхэн бүр сайхан болох юм бол чухам бид юундаа хүрэхийг хэлэхэд ч хэцүү л байна даа! Миний бодлоор бол ч бидэнд хэзээ ч ийм завшаан тохиолдохгүй л дээ...

- Мөн! Хэзээ ч тохиолдохгүй. Чиний зөв... Консель минь

-Тэрнээс гадна капитан Немо өөрийн “хэн ч биш” гэсэн латин нэрнийхээ эзэн нь болж чадаж байна шүү. Капитан биднийг өчүүхэн ч хавчиж хясахгүй байгаа нь ерөөсөө тэр энэ ертенц дээр байхгүй байгаатай л адил байна!

- Зүйтэй :

-Тэхлээр энд юу л байна, тэр бүхнийг бүгдий нь үзэж гүйцсэн тэр жилийг сайн сайхан жил гэж хувьдаа үзэхийг эзэнд уламжлахыг би өөрөө мэдчихье!

-Бүгдий нь үзнэ гэв үү, Консель чи? Хэтэрхий шунаж буй биш биз. Гэвч энэ талаар Нед юу бодож байгаа бол?

-Нед Ленд ч яг л эсрэг юм бодож буй. Энэ ч жирийн хар ухаантай, жигтэйхэн зоргоороо ходоодтой хүн л дээ. Дандаа загас идээд л, загас хараад л байхаасаа тэр уйдаа биз. Өдөр бүр л шахам хоол идэж, дарс ууж сурсан хүнд архи мах, талх дутагдана гэдэг айхавтар зовлонтой байгаа байхаа.

- Энэ ч миний хувьд бол бага хэрэг. Би “Наутилус”-ын дэглэмд жигтэйхэн дасчиж гэж хэлэв.

- Би ч адилхан. Тиймээс Нед Ленд эндээс оргох хичнээн л дуртай бол би эндээ үлдэх төчнөөн л дуртай. Тэхлээр ирж буй энэ шинэ жил над азгүй муу жил байлаа ч гэсэн түүнд маань сайн сайхан жил байх буюу эсхүл түүнд муу, над сайн жил болох болно. Учир иймээс бид хэдийн хэн нэгт нь хувь заяа буян хишигтэй жил байх ёстой. Эзний хувьд бол тэр, өөрөө юу л хусч байгаа бол би түүнд, тэрний нь л хүсэхсэн байнам гэв.

- Баярлалаа, Консель! Ганцхан чамаас гуйхад л чи шинэ жилийнхээ бэлэг сэлтийг сүүлд болоорой. Харин одоохондоо зөвхөн л гар барьчих. Өөр би чамд юу ч сонгож чадашгүй.

- Эзэн хэзээ ч үүнээс хэт нигүүлсэнгүй байсангүй билээ гэж Консель өчив.

Нэгдүгээр сарын хоёронд хурдны хэмжүүр Япон далайгаас анх бид гарсан цагаас хойш бүгд арван нэгэн мянга гурван зуун дөчин миль явсныг зааж байв.

“Наутилус”-ын өмнө, Австралийн зуун хойт эрэг орчныг угааж байдаг далай шүр арлын аюулт бүс дайралдах байв.

Манай хөлөг 1770 оны зургаадугаар сарын 10-нд капитан Кукийн онгоцыг золтой л хөнөөчихөөгүй усан дотор далд орших муухай шүр арлаас хэдхэн милийн зайд явлаа. Кук өөрөө сууж явсан хөлөг онгоц хад мөргөсөн боловч онгоцны нь ёроолд гарсан онгорхой хаднаас ховхорсон хад бөглөчихсөн учраас түүний онгоц живээгүй бүлгээ.

Гурван зуун бээр урт үргэлжилсэн усан доорхи тэрхүү далд саадыг би очиж мөргөхдөө тэнгэрийн дуу мэт нижигнэн байдаг усан доорхи тэрхүү далд саадыг би нүдээрээ үзэхийг нэн их хүсч билээ.

Гэтэл энэ үед “Наутилус” онгоцны залуур биднийг усны гүн рүү авч орсон тул би тэрхүү шүрэн ханыг үзэж чадсангүй. Тиймээс зөвхөн л миний торонд орсон загас тэндхийн амьтны аймагтай л танилцахаас өөр зам олдсонгүй ээ.

Загасны жишүүд олон дүрсийн дотор би мөнгөлөг цайвар биедээ, үхсэнийхээ дараа устаж үгүй болчихдог эрээн цоохор цагиргуудаар бүслэгдсэн нилээд балмад загас байхыг олж харлаа. Эдгээр балмад хэмээх загас бүхэл бүтэн сүргээрээ бидний бараа болж бидэнд ховор тохиолдох амтлаг хүнс болж билээ. Түүнчлэн манай торонд маш амтлаг боловч уртаараа таван сантиметр хэтрэхгүй спар нэн олон орж, ёстой л тэнгис далайдаа алтан хараацай болсон триглү баригджээ. Торонд зоо фитууд ба зөөлөн биетний дотор альционарийн, Лужанок живородящик, байдарок, молоток зэргийн олон дүрс байхыг би олж харав.

Шүрэн аралд далайг огтолсноос хоёр өдрийн дараа нэгдүгээр сарын 4-нд бид шинэ Гвинейн арлуудын эргийн барааг харах болов. Капитан Немо надтай уулзахдаа нэгэн удаа Энэтхэгийн гадаад далайд Торресын хоолойгоор шургаж орно гэж мэдэгдэж бүлгээ. Тэр түүнээс өөр юу ч хэлсэнгүй боловч Нед Лендэд зөвхөн энэ л нэг тохиол хэрэгтэй байв. Түүний сэтгэл хангамжтай байдлаар бол бид Европын эрэгт ойртсон ажээ.

Торресын хоолой өөрийн аймшигт бартаат шургац, тэнд амьдрагч омгуудын зэрлэг догшноос болж нэн бүтэлгүй нэр хүндтэй тэр хоолой Австрали тивийг шинэ Гвинейгээс тусгаарлана.

Үд дундын хэрд капитаны туслах секстант хэмээх багажаар нарны хөөрөлтийн

өндрийг хэмжиж буй үеэр би, шар мэт хурц өндөр өндөр аргал, шатны гишгүүр шиг үелэн харагдах хажуу энгэр бүхий Арфальксын уулсын оройг харав.

“Наутилус” онгоц аюултайгаараа дэлхий дээр алдаршсан түүний аман дээр хамгийн зоригт далайчид боловч бодлогошрон зогсдог, тэрхүү аюулт хоолойн амсар дээр ирэв. Энэ хоолойг Лун Бац де Торрес өмнөт далайнуудын Меланезей руу буцах замдаа анх нээсэн бөгөөд 1840 онд Дюмон Дюрвилийн онгоц золтой л хад мөргөж сөнөөгүй бүлгээ. Гэвч хайрдах хад мөргөхийг юманд эс бодох “Наутилус” онгоц боловч эндхийн шүр арлаас болгоомжлох хэрэгтэй байв.

Торресын хоолой барагцаалбал зуун гучин тав – зуун дөчин километр өргөн боловч тоо томшгүй олон их бага арал усан доорхи ил далд хад цохио бүхий тул нэвтэрч бараг болшгүй билээ.

Энэ бүхнийг харгалзан капитан Немо аль л болох талын арга хэмжээ авчээ. “Наутилус” усан дээр тэн хагасаа хүртэл ил гаран, нэн яльгүй хурдтай хөвж байв.

Түүний сэлүүрийн далбаа, ядарсан халимын сүүл адил ус алгадан байв. Үүнийг ашиглан би өөрийн хоёр нөхрийн хамт цаг үргэлж хов хоосон байдаг тавцан дээр авиран гарч жолоодлогын бүхээгний ард зогсов. Капитан Немо өөрийн гараар онгоцоо залж жолоодох байрандаа байлаа.

Миний нүдний өмнө Торресын хоолойн дэлгэрэнгүй зураг дэлгээстэй байв. Усан судлалын инженер Винцен дон Дюмулон дэлхийг тойрох Дюмон-Дюрвилийн сүүлчийн жуулчлалд гар бие оролцож явсан тэнгисийн албаны мичман сүүлдээ адмирал болсон Купван -Дюбуа нар тэр зургийг гаргажээ. Энэ зураг, түүнчлэн капитан Хингийн гаргасан өөр нэг зураг хоёр Торресын хоолойн толгой эргэм олон годриог сүлжин өнгөрч болох шилдэг зургууд байв. Би тэдгээр зургийг нэн их анхааралтай ажиглан бүлгээ.

Тэнгис “Наутилус”-ыг тойрон ууртай нургилж, цагт хоёр хагас милийн хурдтайгаар зүүн өмнөөс баруун хойшоо эрчилж буй тэнгис түүний давалгаа уснаас бараг алхам тутам цухуйж байгаа үхэр чулуунууд мөргөн бут үсэрч байв.

- Аймшигтай л газар байна! хэмээн Нед Ленд өгүүлэхэд би :

Нээрээ ч үүнээс ч доор газар буй гэж санахын ч арга алга. Тэр байтугай хаа сайгүй явдаг “Наутилус” боловч тэвдэх л газар байна гэлээ.

-Энэ муу хар капитан өөрийнхөө замыг сайн мэддэгээс ер зайлсангүй. Миний харж байгаагаар бол ч цаашлах тутам энэ шүр арлууд бүр хар барагцаалчихлаа. Хэрэв л “Наутилус” тэдний нэгийг шүргээд л авбал зомгол болно доо.

Үнэндээ ч байдал тун хурцаджээ. Гэвч “Наутилус” ид шидтэй юм шиг аймшигт нүсэр

хаддын хоорондуур эсэн мэнд шурган шурган өнгөрч байв. Тэр Дюмон-Дюрвилийн хөлгүүд золтой л сөнөж одоогүй “Астроляби”, “Зүтгэлт” хоёр хөлгийн явж гарсан замыг дагасангүй ээ. Манай шумбагч хөлөг нилээд хойгуур чиглэл авч Меррей арлын хадан хушуу ороомогцоо, баруун өмнө тийшээ, кумберлендийн шургац руу эгц эргэлээ. Капитан Немо “Наутилус”-ыг шууд л энэ гарцаар шургуулна бий хэмээн би бодохыг завдтал, мань хүн онгоцоо гэнэт баруун хойт зуг залж, Таунда ба Аюулт сувгийн зүг эргүүлээд олон их бага арлын хоорондуур ийш тийшээ сүлжин орлоо.

Дюмон-Дюрвилийн хоёр онгоц хоёулаа хайрдсан энэ аюулт сувагт капитан Немо явж орох, тийм болгоомжгүй гэж үү хэмээн би гав гайхсандаа өөрөө өөрөөсөө асуусан бүлгээ. Гэтэл яг энэ уед “Наутилус” дахин чиглэлээ эрс өөр- чилж халз баруун зүгийг барин Гвебороар арлыг чиглэн явлаа.

Өдрийн гурван цаг орчим байсан билээ. Далайн түрлэг дээд хэмжээндээ хүрч давалгаа намдсан байв. “Наутилус” Гвебороар аралд ойртон очлоо. Бид дал мод ургасан гуа үзэмжит эргээс дөнгөж хоёр милийн зайд байв.

Гэтэл, гэв гэнэт хүчит донсолгоо намайг онгоцны тавцан дээр бөмбөрүүлчихэв. Тэхнээ нь “Наутилус” маань шүр арал мөргөн мордоод баруун тийшээ яльгүй хавиргалан хэвтсэн ажээ.

Би хөл дээрээ босож ирвэл капитан Немо өөрийн туслахын хамт онгоцны тавцан дээр гарч ирээд нөгөө миний мэдэхгүй хэлээр ярилцан хөлөг онгоцоо шалган үзэхэд гурван үг солилцож байхыг олж харлаа.

Бидний байдал ямар байсан гээч. Онгоцны тэвшийн цаадтай Гвебороар арал умраас өмнө зүг рүү хүний аврага том бар мэт хөндөлсөж харагдав. Зүүн зүгт далайн татлаганы улмаас уснаас цухуйн ирж буй шүр арлуудын толгой нүцгэрч үзэгдэнэ.

Бид гүехэн газар хайрдаж суурьтай нь аргагүй суужээ. Түүгээр ч барахгүй далайн түрлэг боллоо гээд энд ус их нэмэгддэггүй ажээ. Гэвч хөлөг онгоцны бие нэн бөх тул хад мөргөсний улмаас өчүүхэн ч гэмтсэнгүй ээ. Гэтэл “Наутилус” эндээс ховхорч чадахгүй бол эдгээр хаданд нэг насаараа хадагдан үлдэж, капитан Немогийн онгоц төгсгөл болох буйзаа хэмээн би хэзээд амгалан бөгөөд үл ажрах хэв заншил бүхий капитан Немо над ойртон ирэх үед би бодож билээ. Түүний царайнд бачимдсан буюу сэтгэл түгшсэн шинж огтхон ч үгүй ажээ.

- Сүйрч гүйцэв ээ? гэж би түүнээс асуувал :

- Үгүй ээ, ялимгүй саад учирлаа гэж тэр хариулав.

- Ямар ч л гэсэн энэ нэгэн тохиодол таныг, тэр зугатааж гарсан эх газрын тань иргэн дахин болгож тараах нь ээ?

Капитан Немо над руу нэг л аягүй хачин харчихаад ондооцож толгойгоо сэгсэрлээ. Бодвол тэр, хэн ч, хэзээ ч, юу ч түүнийг хуурай газар дээр эргүүлэн үл аваачна гэдгийг над ойлгуулах гэсэн буйзаа. Тэгээд дараа нь тэр :

-Яагаа вэ та, ноён профессор! “Наутилус”-ын байдал төдий л найдвартай биш байна уу. Миний хөлөг танд тэнгис далайн гайхамшгийг бас л үзүүлэх болно. Бидний жуулчлал зөвхөн эхэлж байгаа болохоор би тийн бараа бологч болж явах аз завшаанаа тийм ч түргэн алдахыг хүсээгүй л байна гэлээ.

-Тэгвэл, капитан аа: хэмээн би түүний хэлсэн үгэнд өгөх маягтай аялгууг үл мэдсэн царай гаргаж “Наутилус” далайн түрлэгийн ид дунд хайрдсан шүү дээ. Номхон далайн түрлэг ерөөсөө их биш, тэхээр та хэрвээ л “Наутилус”-ыг хөнгөтгөх ямар нэгэн арга оллоо ч гэсэн өөрийнхөө онгоцыг усан дээр чухам яасхийгээд дахин хөвүүлэхий тань би бодож олохгүй байнам.

- Профессор таны зөв гэж капитан Немо хэлээд Номхон далайн түрлэг хэзээд их биш, гэвч Торресын хоолойд усны өндөр нам төвшин метр хагасын ялгаатай байдаг юм. Өнөөдөр нэгдүгээр сарын дөрвөн, тэгвэл хоногийн дараа сар шинэлнэ. Тэхээр бөмбөрцгийн тэрхүү үнэнч дагуул шинийн сар хэрвээ л над энэхүү яльгүй бяцхан тус хүргэхийн тул тэнгисийн усыг над хэрэгцээт өндөрт өргөж өхгүй бол би нэн их гайхах болно гэж хариулаад өөрийнхөө туслахын хамт “Наутилус” дотроо орж явчихав.

Хөндий биет амьтдын биеэс ялгардаг мэт бат бэх бодисоор хад чулуунд яг гагнагдсан шиг усан доогуур шумбагч онгоц хайрдсан газраа ургаа хад мэт хөдөлгөөнгүй зогсож байв.

- За юу болов эрхэм профессор хэмээн капитаныг я в- маги над руу .ойртожирсэн Нед Ленд асуулаа.

- Бид нэгдүгээр сарын ёстой өдрийн түрлэгийг л хүлээх болжээ. Тэгээд биднийг тэргэл саран хайрдсан газраас минь ховхолж хайрлах болно. Ийм л байна даа найз минь.

- Ердөө л үү?

- Ердөө л

-Тэгвэл капитан маань зангаа хурааж, урагш ухасхийн хайрдсан газраасаа хөндийрч явөхгүй санаатай байх шив дээ?

Яах юм, тэртэй тэргүй биднийг түрлэг ховх татах юм чинь? гэж Консель өгүүлэв.

Канадын харъяат дургүйцсэн маягтай Консель руу харснаа мөрөө хавчив. Түүний царайнд зоригт далайчийн золбоот мэдрэхүй доромжлогдсон байдал илэрхий байлаа.

- Миний үгийг та санаж байна уу, ноён профессор хэмээн тэр миний зүг хандан энэ муу төмөр тэвш үүнээс хойш усан доор ч тэр, дээр ч тэр, хэзээ ч дахиад хөвөхгүй. Энэ мууг одоо зөвхөн л хог дээр хаявал таарна. Миний бодлоор бол бид одоо капитан Немог өөрсдийн дундаас тусгаарлавал зохино гэж хэллээ.

- Аан гэж бай, эрхэм Нед. Энэхүү гайхамшиг онгоцны ирээдүйг танаас өөр хэн ч ингэж муу үзээгүй байна. Дөрөвхөн өдөр тэсэж үз. Номхон далайн түрлэгийн хүч ямар болохыг бид нэг үзчихье. Жич хэлэхэд эндээс оргох таны саналыг Английн буюу Прованы эргийг харагдсан цагт л авч хэлэлцвэл зүйд нийцнэ. Харин Шинэ Гвинейн эрэг орчимд үүнийг яарахын хэрэг ор үгүй. Хэрэв л “Наутилус” хайрдлагаас ховхорч чадахгүй бол энэ нэгэн мухардсан аргыг хэ- рэглэхэд хэзээ ч хожимдохгүй гэж би хариуллаа.

- Ядаж тэгвэл энэ нэгэн хэсэг хуурай газар дээр шингэж болохгүй гэж үү? хэмээн тэр нилээд гутарсан янзтай, энэ арал байна. Тэнд мод ургадаг. Модонд хуурай газрын амьтад амьд зууш котлет, ростбир, бифштексүүд явж байна шүү дээ. Би нэгэн үмх мах ямар их дуртай идэхсэн билээ гэв.

-Энэ ч Недийн зөв. Би түүний саналыг дуртай хүлээн авахсан байнам. Ядаж бид хуурай газраар явах, алхаж гишгэх дадлаа мартчихгүйн тул үгүйдээ энэхэн эрэг дээр гарчихаад ирэх зөвшөөрөл эзэнтэн өөрийнхөөтэр түншээс аваад ирж чадахгүйсэн бол уу? гэж Консель өгүүллээ.

-Би асууж өгье л дөө. Гэвч тэр татгалзана гээдэгт би эргэлзэхгүй байна.

-Яахав эзэн үзээд алд, ядахдаа бид капитан Немогийн найрсаг зангийн хэр хэмжээг мэдээд авахгүй юу гэж Консель хэллээ.

Харин тэхнээ капитан Немо, миний хүсэлтэд тун их дуртай хариу өгч, хүсэлт ёсоор минь зөвшөөрөл өгснөөр барахгүй онгоцондоо эргэж ирэх ам тангарагий маань ч авсангүй нь нэн гайхалтай. Тэхэд шинэ Гвинейн арлуудаар жуулчлах гэдэг нэн аюултай зүйлийн нэг бөгөөд түүгээр хэсүүчил л гэж би Нед Лендэд зөвлөхгүйсэн билээ. Учир нь тэндхийн арьстан папуасуудын гарт орсноос “Наутилус” дээрээ олзлогдсоноороо олзлогдож үлдвэл дээр байв.

Капитан Немо биднийг дагалдах эсэхийг би асууж зүрхэлсэнгүй. Түүнчлэн бас бидэнтэй нэг ч усан цэргээ явуулахгүй. Нед Ленд завиа ганцаараа залах болно гэдэгт би дүүрэн итгэж бүлгээ. Гэвч хуурай газар биднээс хоёрхон миль зайтай бөгөөд канадын харъяат, гарамгай далайчин тэр том том онгоцонд нэн аюултай хадаас дэндүү бяцхан хөнгөхөн завиа зовох юмгүй гаргаж чадах байв.

Маргааш нь нэгдүгээр сарын 5-нд бяцхан завийг байрнаас нь гаргаж усанд тавив.



Энэ ажлыг хоёрхон усан цэрэг хялбархан хийж байв. Сэлүүрүүд завийн ёроолд бэлэн буй тул зөвхөн бид л орж байраа эзлэн суух явдал үлджээ.

Бид буу сүх зэргээр бүрэн зэвсэглэн өглөөний найман цагт “Наутилус”- аас салж одов.

Далай овоо намдуу байв. Эрэг зүгээс сэрүү татан, яльгүй салхилж байлаа. Консель бид хоёр сэлүүр дээр сууж хүчлэн татахад Нед Ленд шүр арлуудын хоорондох нарийхан завсраар завиа залж явав.

Завь маань ч залууртаа сайхан захирагдаж сум мэт нисч билээ.

Энэ үед Нед Ленд өөрийн сэтгэлийг нуусангуй бөгөөд оргож гарсан хоригдол мэт баяртай явахдаа одоо удахгүй л өнөө шөнөдөө эргэж ирнэ гэдгээ таг мартжээ.

- Удахгүй бид мах иднэ! хэмээн тэр бараг дуулах шахаж, чухам ямар мах гэж санана! Хиймэл хуурамч бус ёстой жинхэнэ ангийн мах иднэ гээч! Талх л байхгүй дээ... Загас муу хоол гэж би хэлээгүй байна, үгүй ээ, энэ чинь дандаа загасны хойноос загас цохиод л байна гэсэн чинь юу гэсэн үг вэ, өөрснөө бодоод үз л дээ! Цог дээр шарсан үмх шинэ мах гэдэг уйдсан цагт хичнээн таатай вэ?

- Ээ хар хэнхэг? Чиний зөвхөн л дан ганц ярианаас чинь болж миний хорхой хүрчихлээ... гэж Консель өгүүлэв.

- Энэ хавь антай эсэхийг мэдэх хэрэг үлджээ. Хэрэв антай юм бол, чухам хэр хэмжээний том амьтан юм бол? Анчин маань ангийнхаа ан болчихвол ямар сайн байх билээ дээ? гэж би нэмэрлэн өгүүлбэл :

- Бага хэрэг, эрхэм профессор хэмээн хангинуур сүхний ир шиг хурц шүдээ яралзуулан байж Нед Ленд, хэрэв л энэ арал дээр өөр амьтан байхгүй бол би шарсан барын зэгсэн бөөн мах, амьд бар боловч барьж идэхэд бэлэн байнам гэлээ.

- Нед Ленд намайг бүр айлгалаа гэж Консель хэлэв.

- Бидэнтэй золгох амьтан өдгүй дөрвөн хөлтөн байна уу? өдтэй хоёр хөлтөн байна уу? ямар ч амьтан байсан би түүнийг нэг л мэргэн буудалтаар мэндлэхэд бэлхэн!

-Ухай? Нед Ленд дахиад л галзуурч эхэллээ! хэмээн миний өгүүлэхэд

-Санаа бүү зов, профессор минь. Зоригтойхон сэл? Хагас цаг ч өнгөрөхгүй би танд хамгийн шилдэг жороор бэлдсэн дийз зоог баримз гэлээ.

Найман цаг хагаст “Наутилус”-ын жижиг завь Гвебор арлыг хүрээлсэн шүрэн бүслүүрийг эсэн мэнд гэтлэн элсэрхэг хаялгад хүрч ирлээ.

---

## ХУУРАЙ ГАЗАР ХЭД ХОНОСОН НЬ

Хуурай газар гишгэсэн анхны тэр тохиол над нилээд их сэтгэгдэл төрүүлснийг би санаж байна. Нед Ленд чухамдаа газар хөрсний бат бэхийг шалгах гэсэн шиг хөлөөрөө урьдаар газар дэвсэж үзсэн билээ. Гэтэл бид капитан Немогийн хэлснээр “Наутилус” онгоцноо жуулчлагчид болсоор буюу биднийхээр бол олзлогдсон бодсоор хоёр бүтэн сар ч болоогүй байлаа.

Онгоцноос гарснаас хойш хэдэн минутын дараа бид далайн эрэгт буун сум тусах газар ойртож иржээ. Эндхийн хөрс ихэвчлэн хөндий биетний шохойлог чулуулгаас тогтсон боловч үхэр боржин чулуу хаа сайгүй бутарсан ширэгсэн голын хуурай сайры нь авч үзвэл уг арлыг галт уулын гаралтай гэж дүгнэж болох байв.

Бүх арал гуа үзэмжит ойгоор битүү хучигджээ. Зөөлөн салхи сэвэлзэн бүр найгалзан байх асар өндөр моддын зарим нь хоёр зуун фут хүрэх бөгөөд ёстой л байгалийн жинхэнэ гамакууд, мөлхөгч ургамал сахлаг мань торлогдон ба-рилцалдсан ажээ.

Тэнд мимозууд, финцсууд, гибисв молод, дал молод байхаас гадна моддын дэргэд тэдгээрийн хүнхэр ногоон оройд саравчлагдсан асар том цахирмын цэцэг цэцэглэн байв.

Гэвч өлтэй өөдтэйгийн бодолд нэрвэгдэн явсан канадын харъяат, Гвинейн арлуудын гойд ургамлын гайхамшиг өнгөтэй таатайгийн зүг анхаарал үл тавьж билээ. Тэр бидний самрын мод олоод хэд хэдэн самар чулуугаар цохин унагаж бид хоёрт барилаа. Бид сүү ууж амтлаг зөөлний нь амтар-хан зооглохдоо “Наутилус”-ын зоогны ердийн зарчимд жөтөөрхөхдөө тийнхүү ховдоглосон гэж үзэж хэрхэн болох билээ.

- За мөн гоё доо! хэмээн Нед Ленд над өгүүлбэл :

- Яриад яахав! гэж Консель дэмжиж байв.

- Бидний эдгээр самраас жаахан нөөц “Наутилус” дээр авч гарахыг капитан Немо үнэхээр зөвшөөрөхгүй гэж үү, та нар юу гэж бодож байна? хэмээн Канад хун асуухад би :

- Арай ч үгүй биз. Гэвч өөрөө гар хүргэхгүй нь ч лавтай даа гэлээ.

- Хохь нь л биз! гэж Консель өгүүлмэгц :

- Бидэнд л сайн гэж Нед Ленд батлав.

- Жаахан анзаараарай Нед минь хэмээн би үр жимсний хоёр дахь мод руу дайрахыг завдан буй канад хүнд хандаж ,

- Бидний самар агуу сайхан эд боловч түүгээр бяцхан завиа язартал нь дүүргэхээс өмнө өөр ямар нэгэн илүү амттай үр жимс энэ арал дээр буй эсэхийг үзвэл дээр биш үү. “Наутилус” онгоцон дээр шим шүүслэг, шинэ сэргэг үр жимс бидэнд нэн их хэрэг болно гэж би бодож байна шүү гэлээ.

Эзний зөв, миний бодлоор бол завиа бид гурав хувааж: нэгдүгээр хэсэгт нь үр жимс, хоёрдугаарт идэшний ногоо, гуравдугаарт нь одоохондоо бид олж үзээгүй л байгаа ангийнхаа ганзага хийвэл зүгээр бус уу гэж Консель өгүүллээ.

Консель та сэтгэл түгшсэний хэрэггүй хэмээн канадын харъяат хэлэв.

- За ингээд бидний зугаалгыг цаашлуулан үргэлжлүүлэхдээ зөвхөн л мэдээтэй байх хэрэгтэй. Энэ арал эзгүй мэт боловч юу ч гэсэн идэш тэжээл сонгохдоо биднээс төдий л дээргүй амьтан энд оршдог байж юу магад...

- Ээ, ээ... харла гэж! гэж Нед Ленд миний сануулгыг сонсчихоод шүдээ хавиран байж бархирахад, Консель :

- Нед та яаж байна? хэмээн асуулаа.

- Аа цус гэж, үнэхээр би тэр хүний мах зооглох зарчмын чинь гайхамшгийг сая л ойлгож эхлэв гэж канад хүн хэлэв.

- Юу! юу? Нед та юу хэлэв? Та чинь махчин байсан санжээ? Тэгвэл би тантай нэг өрөөнд байхдаа үргэлж л над аюул заналхийлж байжээ?. Тэгвэл би нэг өглөө сэрэхэд миний тэн хагасыг идчихсэн байх нь ээ?

- Найз минь би чамд нэн хайртай болохоор онцын их шаардлагагүй бол таныг идчихгүй байлгүй.

- Аа бүү мэд хэмээн Консель хэлж алив ангаа бушуухан хийе. Энэ нэг идэмхийд чинь бушуухан л нэг бөөн мах үмхүүлчихгүй бол ойрын нэгэн сайхан өдөр эзэнтэн өөрийнхөө хуучин зарцын зөвхөн өчүүхэн хэсгий нь олж авч магадгүй гэлээ.

Нед Ленд, Консель тийнхүү хошигнолцох зуур бид ойн цоорхойд явж хүрлээ. Бид моддын өтгөн сагсгар мөчир доогуур бүтэн хоёр цаг явж аанай цоорхойн цаад талд тойрч гарлаа.

Азтай тохиолоор бид халуун бүсний хамгийн ашигтай ургамлын нэгэн болох нэг модтой тулгарсан нь “Наутилус” дээр үгүйлэн уйтгарлаж байсан хүнсээр биднийг цаашид хангаж билээ.

Гвебороар арал дээр элбэг ургадаг талхны модны тухай би ярьж байгаа юм. Бид, тэр даруйхандаа манай хүмүүсийн дунд “рима” хэмээн нэрлэгдсэн, түүний үргүй дүрсийг

оллоо.

Талхны мод орчныхоо моддоос дөчин футын өндөр шув шулуухан голтойгоороо ялгагдаж байв. Байгальч хүний нүдэнд түүний олон салаа том ногоон навчсаар бүрхсэн гоёмсог бөмбөгөр орой шууд танигдах ажээ. Түүний багсгар бөөн навчис дундаас барзгар олон зургаан өнцөгтөөр бүрхэгдсэн нэг дициметр хэр том бөөрөнхий жимс бөндийж байв. Нэн ашигтай энэ мод гадны ямар ч арчилгаа, асрамжгүйгээр жилд найман сар дараалан үр жимс өгдөг билээ. Тэдгээрийн үр жимсийг Нед Ленд сайн мэдэх ажээ. Тэр өөрийн олон удаагийн аянд тэдгээрийг идэж үзсэн тул түүнийг хэрхэн яаж ажиллахыг мэддэг байв.

-Ноён профессор, хэрэв л би энэхүү модны доторхи зөөлнийг амтлахгүй бол ер тэсэх арга үгүй мэт байнам хэмээн түүнийг хэлэхэд би :

- Тэг! Тэг! Тэг. Тэх л гэж ямар нэгэн туршлага хийх л гэж бид ирсэн биш үү зовох юмгүй, тэг гэвэл :

- Удах юм үгүй, одоохон хэмээн тэр галт шилээр зэвсэглэн байж түргэн зуур түүдэг гал ноцоов. Задгай гал хөгжилтэй нь аргагүй дүрэлзэж эхэллээ. Тэр далимаар Консель бид хоёр талхны аятай мод сонгон оллоо.

Түүний зарим нэгэн үр гүйцэд боловсроогүй тул түүний зузаан хальс цагаанаараа ажээ. Гэвч өөр нэг хэсэг цэвцгэр шаргал үр нь зөвхөн л унагааж авахыг хүлээх мэт байв. Ийм нэг нь нэн олон ажээ.

Консель арваад ширхгийг Недэд авчирч өгвөл канад хүн түүнийг хавтгай хавтгайгаар нь хэсэглэн зүсч цог дээр тавилаа. Талхны модны үр жимс дотроо ямар ч яс үс байдаггүй бүлгээ. Тэх хоорондоо Нед :

- Энэ хэдий чинээн амттай талх болохыг профессор та эрх биш үзэх бий! хэмээн үргэлж бувтнаж суув.

- Ялангуяа бүтэн хоёр сар талхны бараа хараагүй улсад уу, бүр ч амттай гээч гэж Консель нэмэрлэнэ.

- Энэ зөвхөн талхаар ч барахгүй, бүр амтлаг боов гэж л мэд. Та үүнийг хэзээ ч амталж үзээгүй юу профессор гуай?

- Үгүй ээ Нед минь.

- Тэгвэл та тэнгэрийн орны тамшаалалд бэлд дээ. Хэрвээ л таныг нэгийг идчихээд дахиад нэгийг нэхэхгүй юм бол би, жад шидэгчдийн эзэн хаан цолноосоо огцоръё! гэлээ.

Хэдхэн минутын дараа цог дээр тавьсан талх нь борлож ирлээ. Түүний зүсэм бүрийн голд амтлаг зөөлөн хэсэг нь цайран харагдаж артишокын үнэр мэт аятай үнэр

ханхлан авай.

Үнэхээр ч тун амттай талх байсныг шудрагаар хүлээх хэрэгтэй бөгөөд би нэн их дуртай идэж бүлгээ.

- Бодвол үүний амтлаг зөөлөн гол нь юун л энэ хэвээрээ удав гэж дээ. Тэхээр үүнийг онгоцон дээрээ аваачсаны хэрэггүй биз дээ гэж би хэлбэл, Нед :

-Яалаа гэж эрхэм профессор хэмээн уурсах маягтай хэлж та бол байгальч-онолч хүн харин би бол хэрэг дээр нь туршсан талх баригч хүн, Консель чи эдгээр жимснээс нилээнийг базаагаад орхи, буцах замдаа авъя гэлээ.

- Дараа та яаж төхөөрөх юм?

- Гол зөөлний нь гурил шиг зуураад, исгэчихэд хутгахгүй их удна гээч. Талх барихын тул тэр зуурмагаасаа “Наутилус”-ын гал зууханд аваачиж хайрахгүй юу. Тэгээд жаахан гашуувтар болох боловч бэлэн болсон цагт нь та шүлсээ залгих бий гэлээ.

-Таны талх аргагүй л дээд зэрэгтээ хүрсэн санж. Үүнээс хэт хүсэх юм бидэнд алга..

-Тийм бишээ, профессор гуай гэж канад хун эрс татгалзаж, бас л идэшний ногоо, амтлаг жимс эрэх хэрэгтэй гэлээ.

- За яахав, явъя, эрье.

Талхны модны жимс түүж базаасны дараа бид манай “хуурай газрын” зоогонд өөр шинэ зууш эрэхээр дахин цаашлан явлаа.

Бид үд дундын хэрд гадил жимсний хүрэлцэхүйц үр жимс цуглуулсан тул бидний эрэл тийм ч урагшгүй тгссөнгүй билээ. Халуун орны энэхүү гайхамшиг амтлаг жимс бүтэн жилийн турш боловсордог ажээ. Тэднийг түүхийгээр иддэг юм.

Гадилаас гадна бид хэд хэдэн том мөөг ба ананс олж авлаа. Эдгээрийг түүх гэж бид их цаг гарзадсан боловч түүндээ харамссан ч үгүй.

-Консель, Нед Лендийг дагалдан явж түүнээс нүд үл салгана. Тэр бидний урьд алхаж, бут модны дэргэдүүр өнгөрөхдөө үр жимсний хамгийн сайны нь мулт татан явлаа.

- За хэмээн Консель эцэст дуун гарч эрхэм Нед таны сэтгэл одоо ханасан биз гэж би найднам та юу хүссэнийгээ одоо базаагаа биз?

-Чи. . .хэмээн Нед хүнгэнэв.

- Юу? та бас л ханаагүй байна уу?

- Эдгээр хэдэн ногоо ч зөвхөн л хоолонд холих хачир л лаа. Исгэлэн амтлаг л зүйл тэгвэл өнөө шөл халуухан нь хаа байна?

-Нээрээ, тийм, тийм Нед минь өнөө биднийг котлетоор хооллоно гэснээ бүү мартаарай! Таны тэр хайран, шарсан, халуухан котлет тань л үзэгдэхгүй байна шүү.

-Эрхэм профессор та ойлгож буй биз. Бид ангаа зөвхөн дуусгах байтугай ер нь эхлээгүй байна шүү. Тэсэж үз! Эрт орой алин боловч, энд эс бол өөртэй, бид хоёр далавчтан биш байсан ч дөрвөн мөчтөнтэй уулзах л байх.

- Хэрэв л өнөөдөр биш бол хэзээ нэгэн цагт хэмээн канад хүний ярианы өнгийг дагуулан Консель залгуулан авч, гэвч ойн гүнд хэтэрхий хол очихын хэрэггүй биз. Би л хувьдаа завиндаа эргэж очихыг зөвлөхсөн байнам гэлээ.

- Юу? Одоо юу? гэж Нед хашгарав.

- Бид харанхуй болохоос өмнө онгоцондоо эргэн очих ёстой гэж би хэллээ.

- Одоо тэгвэл хэдэн цаг болж байна вэ? гэж гомдолтойгоор канад хүн асуувал :

- Өдрийн хоёр цаг өнгөрөөд байна гэж Консель өчив.

- Хуурай газар дээр цаг юутай хурдан явчихна вэ? хэмээн Нед Ленд гүн санаа алдаж билээ.

Буцах замдаа бид ойгоор явлаа. Бид зам зуураа өөрсдийн хүнсний нөөцийг байцааны дал модны навчсаар арвижуулсан бөгөөд тэднийг түүх гэж ендер модны шовх оройд мацах хэрэгтэй болов. Түүнчлэн бид бас малотчууд “абру” гэж нэрлэдэг ногоон буурцаг, сайн чанарын ямсом зэргийг түүлээ.

- Бид завиндаа ойртон очих үед ядарсандаа бүр туйлджээ. Гэтэл, бид бас л хүнс базааж гавьсангүй гэж Нед Ленд үглэсээр байв. Гэвч түүний аз гозойж агсан бол уу. Бид завиндаа дөнгөж суумагц өндрөөшөө хорин таваас гучин фут, саагийн хэд хэдэн мод гэнэтхэн олж харчихлаа.

Эдгээр модод талхны моддын нэгэн адил нэн ашигтай бөгөөд шудрагаар халахад тэдгээр нь меланезийн үнэт тэжээлүүдийн нэг бүлгээ.

Тэр моддыг хэрхэн ашиглахыг Нед Ленд мэддэг байв. Тэр сүх барин очиж, хэдхэн минутын дотор тэдгээрээс хоёр гурвыг нь цавчиж унагаав.

Канад хүний хөдөлмөрлөхийг би өлсгөлөн хүний сонирхлын үүднээс биш байгальч хүний сонирхлын үүднээс ажиглаж байв. Тэр, моддын гол тус бүрээс хуруун чинаа зузаан холтос ховхлон авч байхыг харвал, учир нь олдохгүй ээдрэн зангирсан шөрвөслөг эд цухуйж буйн дунд наалданги цагаан юм үзэгдэж байв. Энэ л гурил мэт цагаан зүйл бол полеланезийнхны гол хоол болдог зүйл бүлгээ.

Ингээд өдрийн таван цагт хүнс нөөцөлж ачаалсан бидний зяцхан завь уул арлын эргийг орхин одож хагас цагийн дараагаар “Наутилус” онгоцныхоо бөөрөнд тулж очлоо.

Биднийг хэн ч гарч угтсангүй. Асар том төмөр сав эзэнгүй мэт байв.

Бид үүргээ авч тавьчихаад өрөөндөө орвол оройн хоол ширээн дээр минь бэлэн

байсан тул би идэж уугаад унтахаар хэвтлээ.

Дараачийн нь өдөр, нэгдүгээр сарын 6-нд онцын сонин юм болсонгүй. Онгоцон дотор өчүүхэн төдий ч дуу чимээгүй, ер нь амьдралын өчүүхэн ч шинж тэмдэг үгүй ажээ. Бидний бяцхан завь, мөн л өнөө орхигдсон газартаа халбалзаж байв. Бид Гвебороар аралдаа буцаж очихоор шийдлээ.

Энэ удаа бидний ан урьдынхаас нилээд олз омогтой байх бизээ гэж Нед Ленд найдаж билээ. Түүнээс гадна бид тэрхүү арлын ойн нөгөө хэсгийг хэрж хэсэхээр ярьж тогтлоо.

Нар гарахтай зэрэг бид аян замдаа ороход эрэг орчны давалгаанд хамагдсан бяцхай завь маань арал руу нэн хурдан хөвж одлоо.

Бид эрэг дээр буумагц Нед Лендийнхээ төрөлхийнхөө соргог чадалд нь итгэмжлэн дагалдан одоход урт хөллөсөн тэр амьтан биднээс хэтэрхий холдож одохыг нь зөвхөн л хянан шүүмжилж явав.

Нед Ленд биднийг арлын баруун хэсгийн гүнд авч оржээ. Бид хэд хэдэн жижиг горхи гатлан гарч нэг талаасаа ойгоор зааглагдсан гоёмсог хавцгайд ирлээ. Горхины эрэг орчинд хэд хэдэн зимродок дайралдсан боловч өөртөө буун сум хүрэх газар ойртуулсангүй ээ.

Тэдгээр шувуудын байдлаар бол тэд, хоёр хөлт амьтантай анх удаа учирч байгаа бус бөгөөд хүн гэдэг чухам яаж ч болох амбан гэдгийг мэддэг байх нь ээ гэсэн бодол надад төрүүллээ. Үүнээс үндэслэж би, тэр арал хэдийгээр одоо хэр эзгүй байлаа ч гэсэн тэнд хүн саяхан ирээд оджээ гэсэн дүгнэлт хийв.

Бид тэрхүү өргөн хавцгайг хөндлөн гарч олон шувуу дуугарах чимээ сонсдон байгаа өчүүхэн төгөлд хүрч ирлээ.

- Эд ч одоохондоо шувуунаас цаашлашгүй ээ гэж Конселийг өгүүлэхэд, Нед ,
- Гэвч, тэдний дунд иддэг нэг хэсэг бий шүү хэмээв.
- Дэний л байх аа даа, найз минь. Миний бодлоор бол эд чинь тоть л байна гэж Консель мөн л мөчөөгөө өгөхгүй хэлэхэд ,
- Идэх юм юу ч үгүй улсад тоть гэдэг чинь мах шүү дээ, найз минь хэмээн канадын харъяат догирхон хэлбэл би :
- Аятайхан аялуулсан тоть гэдэг чинь нилээд амттай зоог гэж мэдээрэй хэмээн хувийн зүгээс нотлох байнам гэлээ.

Үнэхээр ч моддын өтгөн навчис дунд хэрэв л хэн нэгэн хүн тэднийг хүмүүжүүлэх ажлаар оролдсон бол хүний хэлээр шууд ярихад бэлхэн буй тотидын бүтэн ертенц үүрлэсэн ажээ.

Үүнийг л хүсэн хүлээхийн эрхэнд тэд өөрийн өнгө ягаарам эм тотитойгоо шулганалдаж мөчрөөс мөчир, модноом мод дамжиж дэвхрэлцэж байв.

Тэнд тотийн багийн бүх дүрс цугларсны доор, гүн ухааны ямар нэгэн тулгамдах асуудлыг шийдвэрлэн бодолхийлж буй мэт ихэмсэг., залхуу какаду нисэлтэн дундаа салхинд хийсч яваа эрээн даавуу мэт харагдах тод эрээн зүсний арарууд, хүний хэлийг бусдаас хурдан сурдаг жако хэмээх ухаалаг тоть ба бусад олон дүрсийн гангамсаг боловч хоолонд нэмэргүй жигүүртнүүд бужигнаж байв.

Шувуудын тэрхүү байгалийн цуглуулганд нэгэн төрлийн жигүүртэн дутагдаж байсан нь Шинэ Гвинейн ба Аррубгийн арлуудаас өөр хаана ч үл тохиолдох, зөвхөн л энэ орчинд дайралдсан шувуу бөгөөд миний аз болоход тэр шувууг олж сонирхох хувь заяа надад тохиожээ.

Бид армаг тармаг моддын дундуур гарч бут бургас ургасан нэгэн сайхан нуга газар хүрч ирлээ. Бидний алхах чимээгээр ямар нэгэн үл таних хоёр шувуу үргэж нисэхийг би ажвал тэдгээрийн өд зөвхөн салхи сөрж нисэхээр бай- галиасаа заяагдсан ажээ. Тэдгээрийн хөвөлзсөн нисэлт, агаарт эргэлдээн үүсгэж буй маягтай хосолсон хөдөлгөөн тэдгээр өд сөдтэй бахдаж бичиж болшгүй үзэмж тэр бүхэн нь өөрийн эрхгүй нүдний харц булааж, сэтгэл хөдөлгөж билээ. Тэднийг би зовох юмгүй таньж :

- Диваажингийн шувуу байна хэмээн хашгирчихав.

-Хянга цээжтэний анги, болжмор хэлбэртний баг, диваажингийн шувуудын язгуур гэж Консель маань шууд ангиллаа.

- Ногтрууны язгуур арай биш биз? хэмээн Нед Ленд асуувал :

- Бишээ, анд минь биш хэмээн би, эдгээр нь хэдийгээр ногтрууны төрөл биш байлаа ч гэсэн хэрэв та өөрийнхөө хурдан шаламгай авъяасаа шавхан дайчилж халуун орны эдгээр гайхамшиг шувуудын нэгийг барихад надад ту- салбал, би мөн нэн их баярлахсан байнам гэлээ.

- Би хэдийгээр буу буудахаасаа, жад шидэхэд илүү дассан боловч үзээд л алдъя л даа.Ноён профессор минь.

Тэдгээр шувуудыныг наймаалдаг манай нутгийнхан олон янзын аргаар тэднийг барих бөгөөд гай болоход тэр аргуудынх нь нэгийг ч бид ашиглах боломжгүй байв. Тэд уул шувуудын үүрлэх дуртай өндөр моддын оройд тор тавих буюу эсхүл наалданги тусгай цавуурхаг бодисыг ашигладаг, түүнчлэн ундалдаг усыг нь хордуулдаг ажээ.

Бидний хувьд би зөвхөн л нисэлтэн дунд нь буудахаас өөр аргагүй байв. Үүнээс ч юу их ашиг гарна гэж дээ. Нээрээ ч бид арвин хэмжээний сум гарзадсан



боловч тэдгээрээс нэгий нь ч алсангүй.

Өглөөний арван нэгэн цагийн хэрд арлын гүн дэх анхны хэлхээ толгодыг өнгөрчээ. Гэвч бид нэг ч амьтантай дайралдсангүй ээ. Бид өлсгөлөнд автагдлаа. Ан олз омогтой болно гэж найдсандаа замын хүнс авч яваагүйг хэлэх үү, үүндээ мөн их гэмшиж билээ.

Гэвч, бидний аз дайрахад болон Конселийн өөрийнх нь мэнгэ голлоход тэр дараалан хоёр сумаар цагаан тагтаа, вяхрь хоёрыг буудаж унагаав. Тэдгээрийг бид бушуухан мулзлаад шоронд хатгаж хуурай мөчрийн задгай гал дээр шарж гарлаа.

Конселийн хяналт дор бидний зоог шараглаж байх үед Нед Ленд талхны модны үр жимсээр зууш бэлтгэж байв.

Тэгтэл удсан ч үгүй цагаан тагтаа маань вяхрийнхаа хамт номын ёсоор далд.орж яс үс ль үлдэв.

Тэр шувууны хооллодог задийн самар тэдгээрийн маханд онцгой амтыг олгож бидний шарсан тэр халуун зоог үнэхээр тамшаалмаар болсон билээ.

- Эд трофелляр тэжээгдсэн пулярка мэт амттай ажээ гэж Консель өгүүлэн

- За, Нед гуай танд бас одоо өөр юу дутаж байна? хэмээн би асуувал :

- Дөрвөн мөчтөний нь мах, эрхэм профессор гуай. Эдгээр шувуу зөвхөн л зууш болсноос биш хоол болж гавьсангүй, тиймээс би махаер нь жинхэнэ таташ хийж болмоор ёстой дөрвөн хөлтөн алахаас нааш ер тайвширшгүй гэлээ.

Би бол тэр сайхан шувууг барихаас нааш ер тайвшрахгүй гэж би хэлэв.

- За ингээд ангаа хийе ээ. Зөвхөн л эргэж далайдаа ойртох, бид бүр уулын тагт гарчлаа.

Миний бодлоор бол мод руу нэвтэрхий хол очихгүй байвал муу юм болохгүй буйзаа гэж Консель хэлэв.

Конселийн хэлдэг зөв байсан тул бид түүний зөвлөлгөөнөөр боллоо. Бүтэн нэгс цаг явсны дараа бид ихэвчлэн саагийн мод бүхий ойд орж ирлээ. Бидний хөл дороос хэд дахин могой год хийж гарсан боловч хоргүй могойнууд байв. Өнөө диваажингийн шувууд буун сум хүрэхгүй газраас үргэж нисчээд байсан тул би тэдгээрийг найдвараа алдчаад гайхаж явтал бидний урьд явж очсон Консель гэнэт бөхөсхийж нэгэн юм шүүрэн аваад намайг дуудаж, бархирч байхыг харвал тэр нөгөө шувууны нэгэн сайхан амьтныг гартаа барьсан ажээ.

- Сайн хүү бол Консель минь! гэж миний хашгарахад

- Эзэн хэтэрхий элгэмсэг байна хэмээн Консель хариулав.

-Тэгэлгүй яахав, тэгэлгүй яахав найз минь. Чи ёстой гайхамшигийг үйлдэв.

Диваажингийн шувууг амьд тэр мөртөө нүцгэн гараараа барих гэдэг чинь тун их гайхамшиг!

Эзэн хэрэв ойртож ирвэл, сайн ажиж хайрлахсан бол миний гавъяа төдий их бус гэдгийг ойлгох болно.

- Яагаад тэр вэ?

- Энэ шувуу чинь шал согтуу байна!

- Согтуу уу?

- Тиймээ, согтуу байна. Энэ чинь задийн модны ёроолд задийн самар жамьж байгаад шал согтсон тул би түүнийг барихад, их төвөг орсонгүй. Нед та сайн хар даа! тэсвэргүй зөн гэдэг чинь ямар хартай гэдгийг, харваас илэрхий баримт нь энэ дээ!

- За боль доо, найз минь. Сүүлчийн хоёр сард миний балгасан архины хэмжээгээр намайг сургах ч танд нүгэл л болохоос өөр юмгүй гэж канад хүн хариулав.

Тэр хооронд би шувууг үзлээ. Консель намайг хуурсангүй ээ, тэр шувуу задийн самрын мансууруулах шүүсэнд үнэхээр согтож ямар ч арчаагүй болжээ. Тэр зөвхөн нисч чадахгүйгээр ч барахгүй, явж чадахгүй байв.

Конселийн барьсан тэр шувуу шинэ Гвиней ба түүний зэргэлдээ арлууд дээр байдаг диваажингийн шувуудын нийт найман дүрийн дотросс хамгийн гоё нь байлаа. Энэ дүрс “изумруд” гэж нэрлэгддэг хамгийн ховор дүрс болой. Үүний урт нь гучин сантиметр, толгой нь жижигхэн, хушуутайгаа шууд зэрэглэн байдаг хоёр нүд нь мөн бас нэн бяцхан ажээ.

Түүний шар хушуу, хар хүрэн тавхай, хумс, хүрэн ягаанаар эмжээрлэгдсэн бор хүрэн далавч, цасан цагаан сэвлэг гүн ногоон хүзүү, ягаан шаргал цээж, гэдэс зэрэг нь сэтгэл хөдлөм гуа үзэмж ажээ. Түүний сүүлийг ер бусын гоёмсог зөөлөн, нумласан хоёр сэвсгэр өд чимэглэж байлаа. Ерөнхийдөө л тэр шувуу нэн гуа, үзэмж төгөлдөр тул улаан арьстнуудын өгсөн нарны “шувуу” хэмээсэн нэрэндээ зохицож байв.

Тэдгээр ховор шувуунаас нэгийн зэргийг амьдаар нь Париждаа аваачиж амьтны үзэсгэлэнд бэлэглэх хүсэл минь бадран байсан бөгөөд тэнд нэг ч амьд диваажингийн шувуу байхгүй бүлгээ.

Энэ үнэхээр тийм ховор шувуу гэж үү гэж Нед Ленд махы нь иддэггүй бол ямар ч хэрэггүй гэсэн анчны хэнэггүй царай гаргаж асуувал:

- Үнэхээр тийм ээ Нед минь. Тэрнээс гадна диваажингийн шувууг амьдаар нь барих гэдэг тун хүнд хэрэг билээ. Эдгээр шувуудын амьд нь байтугай үхсэн нь нэн их үнэд хүрдэг бүлгээ. Тийм ч учраас Европ газар алмас эрдэнэ, сувд зэргийг дуурайлган,

хуурамчаар хийдэг шиг эндхийн улаан арьстнууд эдгээрийг мөн дуурайлган үйлддэг юм.

- Юу! Диваажингийн шувууг тэд хуурамчаар хийдэг гэж үү? гэж Консель дуун алдав.

- Тиймээ, Консель минь.

- Яаж хийдгийг нь эзэн мэдэх үү?

-Мэднээ. Консель минь. Эдгээр шувууд зуны тэрсүү сялхилалтын үед өөрийнхөө сүүлийн сайхан өдөө гээдэг юм. Шувуу хуурамчаар үйлдэгсэд тэдгээрийн өд сөдийг түүж аваад ямар нэгэн гай нь дайрсан тотины сүүлэнд наах буюу эсхүл аятайхан оёчдог юм. Дараа нь тэд оёдол заадлы нь будаж шунхдаад хушуу хурууг нь “маажиндчаад” өөрсдийн тэрхүү өвөрмөц урлагийг Европ руу музейн үзмэрийн газарт юм уу, дурлагчдад нь хүргүүлдэг юм.

- Тэгээд яагаа вэ? хэмээн Нед Ленд нэмэрлэн, тэд ямар юмандаа гонгинодог юм, тэртэй тэргүй махы нь ямар идэх юм биш, хамгийн гол нь тэр хэрэгтэй гол сайхан өдөө л авбал барж гэлээ.

Диваажингийн шувуу барьж авах миний хүсэл иймэрхүүгээр хангагдсан боловч халуун котлет хайрч шамирах Нед Лендийн хүсэл биелтлээ хол байлаа.

Тэглээ ч гэсэн өдрийн хоёр цагийн үед канадын харъяат улаан арьстнууд “баританг” гэж нэрлэсэн тэндэх үүлдрийн бодон гахай нэгийг буудаж унагаах аз дайрав.

Бидэнд жинхэнэ халуун бүлээн юм олж идэх бололцоо өгсөн Недийн тэр мэргэн буудалтыг хөгжөөнтэйгээр угтлаа.

Өөрийн олз омгонд Нед Ленд сэхүүн нь аргагүй байв. Цахилгаан сум дөнгөж шүргэхийн төдий ч бодон гахай байсан газраа үхэдхийн унажээ. Канад газрын хүн бодонг яах ийхийн зуургүй төхөөрч оройн хоолонд зориулан нилээд жинтэйхэн хэсгийг огтлон авлаа. Үүний дараа ан гөрөө ахин үргэлжлэн Нед Ленд, Консель хоёрын аль аль нь мэргэн цэцнээ гайхуулах бололцоо гарч бүлгээ.

Нээрээ ч найз нар шигүү ургасан бутан дундуур шургаж орсон нь нэгэн хэсэг кенгеругийн сүргийг үргээв. Тэд өөрсдийн урт уян хөл дээрээ дээр дээр дэгдэн, тун хурдан зугатсан боловч бидний цахилгаан сум тэднээс хурдан ажээ.

- Айдаа ноён профессор минь хэмээн олз омогтойдоо мансуурсан Нед Ленд чарлах шахам, юутай сайхан амьтан бэ, ялангуяа жуузгалсан цагт уу! Хүнсэнд маань хичнээн их нөөц гээч? Нэг хоёр, гурав, дөрвөн кенгеру. Энэ уул хяр шиг их махыг чинь бид л зөвхөн иднэ гэж бод л доо. Тэр муу сайн илжигнүүд үнэрлэх ч үгүй л дээ гэлээ.

Миний бодлоор бол канад хүн хөхөж баярласандаа олон юм донгосч байгаагүйсэн

бол тэр сүргийг ч хүйс тэмтэрчих байсан л даа. Гэвч одоо тэр Конселийн ангилснаар хос уутны анги кенгеругийн язгуурт багтах нэн сонирхолтой эдгээр арваад тооны сүүгээр бойжигч доор сэтгэлээ ханга- хаас өөр юм үлдсэнгүй ээ.

Алагдсан кенгерунууд хэмжээгээр том биш туулай хэлбэрийн кенгерунд харъяалагдсан ажээ.Тэд бол өдөр нь унтдаг шөнийн амьтад билээ. Тэр дүрсийн кенгеру тун хурднаасаа гадна маш шаламгаараа гайхуулдаг бүлгээ. Тэд хэдий бие багатай боловч арьс нь их үнэтэй юм.

Бид өөрсдийн ан олзтойд сэтгэл нэн их ханамжтай байв. Сэтгэл хөөрсөн Нед дараачийн нь өдөр тэрхүү гайхамшиг арал дээр дахин ирж тэнд байгаа идэж л болдог дөрвөн хлт бүхнийг хүйс тэмтэрнэ гэж боджээ. Гэвч тэр үйл яв- дал өөрөөр эргэнэ гэдгийг урьдаас мэдсэнгүй ээ.

Оройн зургаан цагийн хэрд бид далай тийш гарч ирлээ. Бидний завь тавьсан газартаа байх бөгөөд биднээс хоёр миль хэр зайтай газар “Наутилус” уснаас бүртийн харагдах далаи мэт барайж байв.

Нед Ленд тэр даруйхан л өдрийн зоог бэлггэх ажилд орлоо. Тэр ч тогоо барихдаа эрлэг нь байв. Тэрний шарсан “бари-утангийн мах” котлет төдөлгүй ойр хавьд хорхой хүргэж үнэртсэн билээ...

Гэтэл харин би шарсан бөөн махнаас хөхиж баярласандаа, яг л канад нутгийн тэр хүн шиг болчихсон байснаа гэнэт мэдэрч билээ.

Тэгээд л хоол маань амттай болсон гэдэг ч яах аргагүй. Хоол дээр бас хоёр вяхрь саагийн зуурмаг, талхны ба мангогийн модны хэд хэдэн жимс,тав зургаан ананс бидний самрын иссэн сүмс зэрэг нэмэрлэж урам зоригийг хөгжөө- лөө. Миний сайн нөхдийн ба миний гэсэн ч гэдэс цатгалан зоогондоо хүндэрсэн болоход ,

- Хэрэв бид “Наутилус”таа өнөөдөр буцаж очихгүй бол ер нь яадаг юм? гэж Консель асуухад :

- Өнөө ч, маргааш ч, ер нь хэзээ ч эргэж очихгүй хэмээн Нед Ленд хэлтэл бидний хөл дор том чулуу пидхийн уналаа.

[Тор](#)

---

## КАПИТАН НЕМОГИЙН АЯНГА

Бид суудлаасаа босолгүй ой руу эргэн харцгаав. Миний гар амандаа хүрч чадсангүй замдаа яг хөшчихөв.

- Тэнгэрээс чулуу хар аяндаа унадаггүй шиг билээ. Энэ чинь хэмээн Консель хэлээд

- Тэгж унасан чулууг аэролит гэж нэрлэдэгсэн биш билүү гэлээ.

- Тэгтэл нилээд оньчтой шидсэн хоёрдох чулуу шуугин ирж түүний саяын ярьсныг нь нотлох гэсэн шиг барьж байсан махы нь цохиод уначихав.

Бид гурав тэр даруй харайн босож буугаа мөрлөөд ямар ч довтолгоог устгахад бэлэн болоход :

- Үгүй ээ, энэ чинь сармагчингууд шидлээ гэж үү? хэмээн Нед Ленд өгүүлбэл :

- Бараг л энэ чинь зэрлэг хүмүүс шидэж байна гэж Консель хариулав.

- Завиндаа! хэмээн би захирангуут, далай тийш хөдөлцгөөлөө.

Үнэндээ ч биднийг нэг талаас маань халхалж байсан төгөл модон дотор, биднээс зуугаад алхам газар том, том хавчаахай муна зэргээр зэвсэглэсэн хориод зэрлэг хүн гарч ирсэн тул учрахаас өөр аргагүй болжээ. Бидний завь биднээс хориод метр зайтай байв. Зэрлэгүүд яаралгүй ойртох боловч харваас дайсагнах төлөвтэй ажээ. Сум чулуу хоёр мөрөн дээр мөндөр мэт бууж байв.

Гэтэл Нед Ленд цуглуулсан хүнсээ орхихыг хүссэнгүй тул заналхийлж байсан аюулыг харгалзахгүйгээр алагдсан кенгеру ба бодонгийн гулуузыг завь руугаа чирч байв.

Хоёрхон минутад бид зэвсгээ бэлтгэн хүнсээ завиндаа авчраад завиа ус руу түлхэнгүүт сэлүүрээ сууринд нь бэхлэн авч сэлүүрдэж гарлаа.

Биднийг эргээс хоёр кабельт холдож амжаагүй байтал хашгарч, цовхчисон хэдэн арван зэрлэгүүд, бүслэхээ хүртэл далай руу орж бахиралдаж байв. Тэдний хашгаралдаан “Наутилус”-ын багийнхны анхаарлыг татах бий гэж бодож явсан маань эндүүрэл болж усан доогуур явагч онгоцны тавцан эзэнгүй хов хоосон харагдсаар байв.

Хорин минутын дараа бид “Наутилус-даа хүрэлцэн ирэв.

Онгоцны дээд таг дэлгээстэй тул бид завиа аргамжаад онгоцон дотроо явж орлоо.

Би үзэсгэлэн танхимд явж орвол тэнд бадралт баг бишгүүр хөгжмийн дуу гарч байсан нь капитан Немо хөгжимдөж буй аялгуундаа нэвтэрхий автагдсан тул миний орж ирэхийг мэдсэнгүй ээ.

- Капитан! гэж би дуун гарвал тэр дуулсангүй учир түүний мөрөнд гар хүрч :

- Капитан аа хэмээн дахин дуудлаа. Тэр дав хийгээд түргэн зуур эргэж харлаа,

- Аа, та юу эрхэм профессор. За ан олзтой юу? Ямар ургамал олж сонирхов?

- Ан тун олзтой. Танд баярлалаа. Гэвч бид хойноосоо хоёр хөлт амьтны сүрэг дагуулж ирснээ нуугаад яахав. Тэдэнтэй ойролцоо байх явдал надад аюулгүй биш мэт санагдана.

- Хоёр хөлтөн гэнэ ээ.

- Тиймээ, зэрлэгүүдийг.

- Зэрлэгүүд ий? хэмээн капитан дооглох маягтай унжруулан хэлээд – та манай энэ ертенцийн хуурай газрын нэгэн дээр гишгэгчээд зэрлэгүүдтэй тулгарчихсандаа юунд нь тэгж их гайхаа вэ? Зэрлэгүүдгүй гэж ер нь хаана байна!

Түүнчлэн таны тэр зэрлэгүүд гэж нэрлэж буй эдгээр хүмүүс бусдаас юугаараа дор юм?

- Гэвч капитан минь..,

- Капитан минь. Капитан минь над ямар хүртээлтэй юм? миний хувьд бол би зэрлэгүүдтэй хаа сайгүй л учирсан.

- Ямар ч гэсэн хэмээн би хэлээд хэрвээ л та энэ бөөн бүлэг юмыг “Наутилус” руу довтлуулахыг хүсээгүй юм бол урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг би танд зөвлөх байнам гэлээ.

- Санаа бүү зов. Та энэ талаар нэг л их сүйд болоод байх юм байхгүй.

- Үгүй ээ, эд чинь тун олон юм байна?

- Хичнээн?

- Зуугаас доошгүй!

- Аронакс та аан гэж бай! хэмээн хуруугаа дахин хөгжмийнхөө даралтан дээр тавингуутаа Шинэ Гвинейн бүх улаан арьстан бүгдээрээ далайн энэ хаялга дээр цугларах юм гэхэд ч “Наутилус”- т заналхийлэх юм алга гэлээ.

Капитаны хуруу зөвхөн л хөгжмийн даралтан дээгүүр жирэлзлээ. Түүний хуруу зөвхөн л хөгжмийн даралтны хар ясан дээгүүр гүйж байгаагаар түүний дарж буй аялгуу минорын өнгөтэйг нь ялгаж танив.

Төдөлгүй түүний сэтгэхүй дарж буй хөгжимдөө тэр чигээрээ эзлэгдэж, дэргэдээ буй намайг таг мартлаа. Дахин би түүнд саад хийхээсээ айж сэмхэн гарч одов.

Би дээшээ онгоцны тавцан дээр гарч ирвэл шөнийн тэнгэр жам ёсоор дүнсийн нөмөрч буй нь энэхү доод өргөргүүдэд үдшийн гэгээ тасарч гүйцээгүй байхад өөнийн харанхуй шууд нөмөрдөг билээ. Гвөбороар арал харанхуйн дунд дөнгөн дөнгөн бүртийж, эрэг дээр задгай түлсэн тоо томшгүй түүдэг яралзан буйг харвал арлын зэрлэгүүд уул арлыг орхин одохыг хүсээгүй байгаагийн баримт ажээ.

Онгоцны тавцан дээр би гав ганцаар олон цаг зогссон: нэг бол тэдгээр улаан

арьстны тухай капитан Немо хэнэггүй байдлаараа тэдгээрт сэжиглэх явдалгүйг надад итгүүлсэн тул тэднээс би айж сүрдсэнгүй. Тэр төдөлгүй дэргэдээ байгаа намайг таг мартаж бодвол халуун бүсийн тэрхүү сайхан шө- нийн амьсгалд нэрвэгдэн бүлгээ. Дараа миний эх орны орой дээрээс өнгийх тэнгэрийн умарт хэсэгт мяралзах тэр оддыг ширтэн миний хамаг сэтгэл зүрх Франц нутгийн зүг одож билээ. Сар хөөрөх тутмаа оддыг бүдгэрүүлнэ. Дэлхийн энэхүү үнэнч дагуул хоёрхон өдрийн дараа "Наутилус"-ыг хайрдсан шүрэн хэвтрээс нь ховхлох гэж мөн л энэ замаараа дэгдэнэ дээ гэж би бодолхийлж байв.

Шөнө дөл хэрд сагсгар модод сүүдэрт нам гүн нойрсож буй эргийн нэгэн адил, тэнгисийн налайн харласан тэр төвшин мөн л амгалан гэдэгт би санаа амарч эцэст өөрийн өрөөнд хүрэлцэн ирмэгц хэвтэртээ ороод нам унтчихав.

Шөнө тайван өнгөрлөө. Бодвол, зэрлэгүүд усан дээр голийж буй гайхлын барааг нэг хараад л айсан буйзаа. Гэтэл түүний дээрх нээлттэй тагаар "Наутилус"-ын дотор чөлөөтэй нэвтэрч болох байв.

Нэгдүгээр сарын 8-ны өглөөний 6 цагт би тавцан дээр дахин гарлаа. Үүрийн гэгээ шөнийн харанхуйг дөнгөж л үлдэн хөөж байв.

Удсан ч үгүй салбайсан цагаан манан дундуур эхлээд эргийн хаялга, дараа моддын орой харагдан харагдсаар арал бүхлээрээ тодорч ирлээ.

Эрэг дээр улаан арьстнууд мөн л хэвээр байсан бөгөөд энэ удаа улам олон болжээ. Барагцаалбал тэд тав-зургаан зуугаас илүү бололтой.

Усны татлагыг ашиглан тэдний зарим хэсэг нь уснаас цухуйсан хаддыг дамжин "Наутилус"-т хоёр кабельтаас холгүй газар ойртон иржээ.

Тэдний царайг би энгийн нүдээр сайн үзэж байв Тэд нэн чийрэг болж ирээд асар өндөр биетэй гэц хонхор духтай өргөн бодовч хавтгай бус хамартай, нүд гялбам цав цагаан шүдтэй, улаан арьстны папуас хэмээх омгийнхон бөгөөд тэдний час улаанаар будсан бужгар үс тос даасан хар арьсан дээрээ эрс ялгарч бүлгээ. Түүнчлэн хоёр салаа болгож огтолсон чихний нь омогт ясан эрх дүүжлээстэй ажээ.

Ихэнх эрчүүд нь чармай нүцгэн, хэд хэдэн бүсгүйчүүд бүсэлхийгээрээ чөдөр өвсөөр уяж тогтоосон, өвс сулжмэл банзал өвдгөө хүртэл унжуулжээ. Заримы нь бодвол удирдагчды нь хүзүүнд, улаан, цагаан шилэрхүү өнгөлөг гялалзсан юмаар хийсэн тал дугуй буюу дугуй чимэг байх харагдав.

Зэрлэгүүд бүгдээр нум сум, бамбай, жадаар ээвсэглэжээ. Олонхийнх нь ар нуруунд торон савтай дүүгүүрийн бөөрөнхий чулуу бөндөгнөж явав. Тэд дүүгүүр эдэмшихдээ агуу чадалтай ажээ.

Тэдний удирдагчдын нэг нь “Наутилус”-г бусдаас ойртон ирж их л анхааралтай ширтэж байв. Тэр гадиль модны навчаар хийсэн орхимж нөмөрсний нь харвал нилээд том толгой байлгүй.

Надад нэн ойрхон зогсож буй тэр зэрлэгийг би, тун хийлгэчихэд хялбар байсан боловч тэрнийг ямар нэгэн дайсагнах ааш гаргахаас нааш хүлээзнэхээр шийдлээ.

Далайн татлага болж байсан тэр үед зэрлэгүүд “Наутилус”-ыг үргэлж тойрон бужигнаж байв. Гэвч тэд ямар ч дайсагнах янз гаргасангүй.

Тэд байн байн “ассе” хэмээн ганц үг давтан хашгаралдаж гар даллан байснаар намайг эрэг дээр гарна уу гэсэн урилга мөн гэж ойлголоо. Тэгэвч би тэрхүү урилгыг нь няцаавал дээр гэж санав.

Хүнснийхээ нөөцийг арвижуулахыг хүссэн Нед Лендийн заяа харлахад энэ өдөр бидний бяцхан завь “Наутилус”-аас хөдөлсөнгүй нь мэдээж хэрэг билээ.

Канадын харъяат хэзээний их гарын эр болох тул аль болохоор өдөр өнгөрөөхийг хичээж Гвебороар арлаас авчирсан мах; талхаа даршлах ажил хийв.

Өглөөний арван нэгийн орчим, далайн түрлэг уснаас цухуйсан хаддын оройг далдалж эхэлмэгц зэрлэгүүд эрэг тийш буцлаа.

Эрэг дээрх хүмүүс улам олширч буй нь “Наутилус” мэнд ирсэн мэдээ ойр хавийн арлууд дээгүүр түгж, Гвебороар арлын өнцөг бүрээс улаан арьстнууд цувж буй гэдгийг гэрчилж бүлгээ. Харин гэхэд нэгхэн ч завьхан үл үзэгдэх ажээ.

Бодвол богинохон байлтай хугацаа, гэвч өнгөрч өхгүй, өдөр байж сууж ядахдаа би цаг өнгөрөөхийн тул далайн ёроолыг маажуураар малтахаар шийдэв. Би далайн ёроолд тунгалаг уснаа олон төрлийн ургамал амьтан байхыг нэвт харж байв. Жич хэлэхэд энэ өдөр хэрэв л Немо андуураагүй бол шинэ Гвинейн эргийн дэргэдэх бидний зочлолтын эцсийн өдрийн өмнөх өдөр тул тэр орчны ургамал амьтантай танилцах явдлыг хойшлуулах хэрэггүй бүлгээ.

Консель энгийн муусайн эмгэн хумс шүүрддэг шүүрийн нэгэн адил хөнгөхөн малтуур нэгийг надад авчирч өгөв.

Зэрлэгүүд ер нь ямар шүү байртай улс байна? Хэрэв эзэн зөвшөөрөхсөн бол тэд надад, тийм ч догшин биш бололтой улс мэт сэтгэгдэл төрүүллээ гэж Конселийг ярихад би ;

- Тэглээч гэсэн л махчингууд шүү дээ! гэв.

- Махчин л бол заавал булай новш? байх нь алба уу? хэмээн Консель мэтгэж төлөв томоотой хүн байсан мөртөө бузар идэмхий ч байж бас болох биш үү. Аль аль нь ямар ялгаа байна гэлээ.



- За яахав. Консель минь. Эд чинь олзлогдогсдоо бүхэл номын нь ёсоор шарж иддэг махчин боловч шудрага улс гэж би чамд өчүүхэн буулт хийе. Гэсэн ч шудрага улсын хоол болохыг өчүүхэн ч хүсэхгүй тул “Наутилус”-н капитан урьдчилан болгоомжлох арга хэмжээ авахгүй байх тутам нь мэдээтэй байх болно. За одоо ажилдаа гэлээ.

Бид хоёр цагийн турш далайн ёроол шүүрдсэн боловч онцын сонин юм олоогүй болохоор бидний торонд дүүрсэн: “миндалын чих” гэж нэрлэгддэг хавчаахай, миний л олж үзсэнд орвол сонирхолтой, гоёмсог арфууд, молотокуюдыг үзэж сэтгэлээ хангалаа. Түүнчлэн бид хар далайн хэд хэдэн бортого, сувд, агуулагч хясаа барьснаас гадна арав гаруй тооны жижиг яст мэлхий барьсныгаа гал зууханд шилжүүлэхээр шийдлээ. Гэтэл яг тэр минутад би санаанд ер ороогүй нэгэн хачин гайхал амьтан олж үзэв. Үнэндээ ч түүнийг ер бус ховор тохиолдох зэрэмдэг амьтан гэж нэрлэж болох билээ. Консель тороо усанд дөнгөж хаяж орхимогц дүүрэн хясаатий татаж гаргахад нь торы нь би гэнэт угз татан аваачиж тэдний дундаас нэгий нь шүүрэн авч хашгарсан нь ёстой л далайн хясаа хавчаахайны дун хуяг судлагч эрдэмтний хоолойноос буюу хэзээ нэгэн цагт хүн гэдэг амьтны хоолойноос гарч байсан дуунаас хамаагүй чанга хашгарахыг үзэж тэр мэл гайхаж билээ.

- Эзэнтэн юу болов? хэмээн тэр гайхан сууж эзнийг ямар нэгэн амьтан хазчаагүй биз? гэв.

- Үгүй ээ, найз минь.. Гэвч би энэ олзны төлөө эрхий хуруугаа ч дуртай өгчихсөн байнам.

- Ямар олз?

- Энэ дунг хэлж байна! гэж би хөхүүн гэдэг нь өгүүлбэл,

- Үгүй ээ, энэ чинь зөөлөн биетний хүрээ, гэдэс хөлтний анги, сам заламгайтны баг, оливын дүрсэд хамаарагдах ердийн нэг дун байна шүү дээ..

- Тун зүйтэй. Гэвч Консель минь үүний чинь дунгийн эргүүлэг баруун тийшээ эргэхийн оронд зүүн тийшээ эргэлдсэн байна.

- Нээрээ юү?

- Нээрээ, хонгор минь. Үүний чинь солгой дун гэдэг юм?

- Солгой дун гэнэ ээ? хэмээн Консейин хоолой нь чичигнэн дуугарав.

- Үгүй чи, эргүүлгий нь хар л даа.

- Үнэхээр миний сэтгэл хэзээ ч ингэж хөдөлж байгаагүй гэдэгт эзэн бүрэн итгэж болно гэж Консель тэр дунг гартаа энхрийлэн авч хэлэв.

Үнэндээ ч сэтгэл хөдлөхөөс өөр замгүй сайхан юм олсон бүлгээ. Ер нь байгаль дээрх хөдөлгөөн ихэвчлэн баруунаас зүүнээ буюу нар зөв байдгийг хэн бүхэн мэднэ. Одод

өөрсдийн дагуулуудын хамт баруунаас зүүнээ эргэдэг тэгвэл хүний баруун гар зүүнээс дадамгай. Тийм учраас түүний хэрэглэдэг, багаж бүхэн баруунаас зүүнээ хэрэглэхээр хийгдсэн байдаг. Байгаль ч гэсэн мөн л энэ хуулийг баримталдаг бөгөөд хэрвээ л үүний хууль гэж хэлж болох юм бол зөөлөн биетний дунгийн мушгиа мөн л баруунаас зүүнээ эргэдэг тул солгой дун мэтийн этгээд ховор зүйл тохиолдох тэр эгзэгтэй цагт, сонирхогсод хамаагүй их үнэ өгдөг бүлгээ.

Консель бид хоёр өөрсдийн тэр үнэгуй ховор эрдэнийг үзэж сонирхон байв. Би тэр дунгаа байгалийн хөгжлийн түүхийн Парижийн музейд хэрхэн бэлтгэхээ төлөвлөн бодож байтал Конселийн гарт байсан өнөө үнэтэй дунг маань зэрлэгүүдийн шидсэн чулуу хага цохичив.

Би бачимдсандаа нэг муухай бархиран хоцроход Консель миний буу руу үсрэн очиж, биднээс арваад метр зайтай зогсон дүүгүүр даллан буй зэрлэг рүү шагаймагц нь би түүнийг хориглохыг завдсан боловч амжсангүй ээ.

Сум тэр зэрлэгийн гарын шуунд байсан бугуйвчийг нь тас татав.

- Консель! Хүүе чи яаж байна! гэж би сандран хашгарвал:

- Яагаа вэ? Энэ муу махчин эхлээд бидэнд халдсаныг эзэн та хараагүй гэж үү?

- Хүний амьтай тэнцэх үнэтэй дун гэж ер үгүй, Консель минь.

-Ээ муу, үл бүтэх амьтан...Миний марийг малт цохичихсон бол дээрсэн! хэмээн Консель үглэв.

Үүнийг Консель үнэн голоосоо хэлж байсан боловч би тэрний нь зөв гэж үзсэнгүй ээ.

Гэтэл бид малгай-дунгийн гайхамшгийг сонирхон байх завсар байдал өөр болсон байв. Улаан арьстнуудын хориод жижиг завь “Наутилус”-ыг хүрээлжээ. Тэдгээр завийг модны гол ухаж, урт нарийхан, хөнгөн хийсэн тул хурдан ява- хад тохирсноос гадна усан дээр холбилзуулахгүйн тул завины хажуу хоёр ирмэгт хулсан хоёр хөвүүр бэхэлжээ.

Харваас ч папуасууд европ хүмүсийг урьд өмнө үзэж, тэдний хөлөг онгоцтой тулгарч байсан нь илэрхий. Гэвч тэд уснаас дөнгөн цухуйж буй шураг мод, яндан юу юу ч үгүй янжуур маягийн энэхуу төмөр савыг ер нь юу гэж бодсон бол? Бодвол сайн юм санаагүй дээ. Тэд онгоцноос нилээд зайтай удаан зогсоцгоолоо. Харин тэд аажимдаа бидний зүгээс түрэмгийлэх янзгүйг мэдмэгц “Наутилус”-тай яваа яваандаа дасч зориг орсондоо танилцахын тул ойртохоор шийджээ. Тэгвэл энэ л танилцах эрмэлзэлд нь саад хийх хэрэгтэй байв.

Дуугүй буудаг бидний буу зөвхөн аянга мэт ниргэдэг галт зэвсгийг хүндэтгэж сурсан тэр зэрлэгүүдэд төдийл их айх сэтгэгдэл тэрүүлэхгүй байлаа. Энэ нь дуугүй буудаг

аянга хүмүүсийг айлгахгүйтэй л яг адил ажээ. Гэвч дуу нь аюултай биш аянга нь аюултай бүлгээ.

Энэ минутын дотор хэд хэдэн завь “Наутилус”-ыг бүслэн авч онгоцны тавцан дээр нумын зэв уул мэт харанхуйлан буув.

- Чөтгөр аваачиг! Мөндөр бууж байхчив! Сумаа харуулчихсан ч юм билүү, яаж мэдээ вэ... гэж Консель өгүүлбэл, би :

- Капитам Немог анхааруулах хэрэгтэй гээд онгоцны дотогш нэвтрэх нүх рүү явав.

Би үзэсгэлэн танхнмд явж орвол тэнд хэн ч байсангүй. Тэхээр нь би капитаны өрөөний үүдийг тогшиж үзвэл:

- За гэх дуу сонсдов.

Капитан Немог би нэг л их тоо бодож байхад нь орж очжээ. Түүний өмнө тооны тэмдгүүдээр эрээчсэн цаас навсайлдаж байв.

- Би танд саад хийчихэв үү? хэмээн би ёсорхон асуувал,

-Тэглээ, эрхэм профессор, гэвч ийнхүү саад хийх ямар нэгэн чухал шалтгаан бий биз гэж би бодож байнам гэлээ.

Онц чухал хэрэг байна. Биднийг улаан арьстны завь хүрээлчлээ, бодвол хэдхэн минутын дараа олон зуун зэрлэг хүн биднийг дайрах нь шиг болтой.

- Ухай хэмээн капитан ер санаа зовсон шинжгүй амарлингүй царайлж тэд завьтай ирлээ гэнээ? гэлээ.

- Тиймээ капитан.

Тэгвэл дээд тагаа л хаячихвал болох нь тэр.

Яг л тэгмээр юм гэж би танд хэлэх гэсэн юм.

- Түүнээс хялбар юм гэж ер үгүй-хэмээмэгцээ капитан Немо дэргэдэх нэг цахилгаан товруу дарчаад, онгоцны багийнхны өрөөнд зохих зааврыг нь өглөө.

- Ингээд л гүйцлээ гэж тэр, минут хэр дуугуй байснаа сүүлд над руу хандан-онгоцны завь байрандаа тавигдаж, дээд таг хаагдсан байхад “Авраам Линкольн”-ны бөмбөг цөм цохиж чадаагүй, миний онгоцны бөөрийг зэрлэгүүд цөм цохиод орж ирэх бий гэж та эрхбиш айхгүй биз? гэлээ.

- Үгүй ээ, айхгүй. Гэвч өөр нэг аюул байна. Капитан аа.

- Ямар аюул?

- Маргааш өдий үед дээд тагаа агаар оруулах гэж дахин нээх хэрэгтэй шүү дээ.

- Зүйтэй, тун зүйтэй, эрхэм профессор миний хөлөг яг л халим шиг амьсгалдаг юм.

- Хэрэв л тэр үед папуасууд онгоцны тавцан дээр байсаар байх юм бол та хэрхэн яаж түүнийгээ нээх юм бэ?

- Тэгвэл та, эрхэм профессор, миний онгоц өөд тэднийг авирна гэж бодож байна уу?

- Тэгэлгүй яахав.

- За яахав.

За яахав, авирч л байг... Авирахад нь саад хийгээд байхын ч хэрэг алга. Эд чинь ердөө л хөөрхий, зэрлэг амьтад шүү дээ. Тэхээр Гвебароар арал дээр ч “Наутилус” хүрч ирсэн явдал эдгээр хөөрхийнүүдийн нэгний нь боловч амь насанд аюул учруулахыг би яасан ч хүсэхгүй гэв.

Би түүнд мэхийн ёслоод явахыг завдтал капитан Немо намайг хориглон, дэргэдээ зэрэгцэн суухыг урилаа. Тэр бидний аялал, ан гөрөөний тухай надаас сонирхон асууж, канадын харъяат яахаараа тэгж их махассан болохыг ойл-гохгүй байгаа мэт царай гаргаж байлаа.

Дараа нь яриа өөр тийшээ хандахад капитан Немо төдий л их аман дээр байгаагүй ч гэсэн нилээд сонин зүйл сонгож билээ.

Жич хэлэхэд Дюмон-Дюрвилийн хөлгууд арай л сөнөчөөгүй тэр хоолойд “Наутилус” маань хайрдчихсан болохоор бидний яриа түүнийг хамарсан юм. Энэ талаар капитан Немо ярьсан нь:

- Дюмон Дюрвиль бол францын хамгийн боловсролтой хүмүүсийн нэг нь байсан болон алдар нэрт агуу далайчдын мөн нэг нь байлаа. Францын Кук хэмээх хөөрхий тэр эрдэмтэн өмнөт туйлын мөс, өргөн тэнгисийн хад, номхон тэнгисийн арлуудын зэрлэгүүдтэй тулж, ялж дийлсээр ирсэн тэр баатарлаг хүн очиж очиж хот орчны төмөр замын галт тэрэгний нэгэн сүйрэлд амь үрэгдэх ч гэж дээ! Энэ баатарлаг хүн амьдралынхаа минутанд, тэгж үхнэ гэдэг талаараа бодох бололцоо олсондоо тэрний сэтгэл юутай их тарчилсан гэж та бодож байна!

Үүнийг ярихдаа капитан Немо сэтгэл нэн зовсон шинжтэй байв. Тэр шинж нь түүний нэр хүндийг өргөж байсан юм.

Бид францын тэр агуу их далайчны аялсан замын нь зураг дээр мөрдөж, дэлхий тойрсон түүний аян амжилтгүй төгссөн боловч Адели ба Луифилиппийн арлуудыг нээсэн, өмнөт туйлыг нээх гэсэн хоёр удаагийн оролдлого зэргийг нь мөрдлөө.

Хамгийн эцэст бид номхон далайн гол гол арлын орчинд үйлдсэн түүний гидрографийн шинжилгээний тухай дурсаж ярилаа.

- Далайн гадаргуу дээр Дюмон-Дюрвиль юу хийсэн бүхнийг би далайн гүнд давтаж хийх санаатай, гэвч миний шинжилгээ бол дүүрэн хангалттай, нягт нарийн болохоос гадна их хүч хөдөлмөр орохгүй юм. Далайн салхи шуурганд үргэлж нүдүүлж явсан Дюрвилийн “Астроляби”, “Эрэмгий” хоёр хөлгийг амгалан тасалгаанд нь ажиллаж

суухад юу ч саад болохгүй ёстой л усан доорхи жинхэнэ байшинтай ялгаагүй “Наутилус”-тай зүйрлүүлж яахин болох.

- Гэвч “Наутилус”-ын нэг талын хувь хүртээл нь “Астроляби”, “Эрэмгий” хоёрын хувь хүртээлтэй адил юм даа, капитан аа-хэмээн би хэлж орхивол.

- Юу билээ, профессор гуай? гэлээ.

-“Наутилус” яг тэдэнтэй ав адил, яг л тэдний сууж байсан газар хайрдчихсан шив дээ.

- “Наутилус” хайрдсан юм бишээ хэмээн капитан хүйтэн царайлян “Наутилус” зөвхөн л далайн ёроолд хэвтэж амсхийж байгаа нь энэ. Түүнчлэн өөрийнхөө онгоцыг хөдөлгөх гэж би Дюрвилийн хөдөлсөнтэй адил тэгж их махран зүтгэх ч үгүй. “Астроляби”, “Эрэмгий” хоёр золтой л сөнөчөөгүй, тэгвэл “Наутилус-т заналхийлэх аюул ердөө ч алга. Маргааш яг л миний тогтоосон өдөр, яг л миний тогтоосон цагт далайн түрлэг миний онгоцыг зөөлхөн өргөмөгц л миний онгоц өөрийнхөө жуулчлалыг үргэлжлүүлэх болно.

- Капитан аа хэмээн би-эргэлзэх юм ч надад...

- Маргааш хэмээн миний үгийг тасалж, сандлаасаа бо- сонгуутаа өдрийн хоёр цагт “Наутилус” хайрдлагаасаа хөндийрч, ямар ч гэмтэлгүйгээр Торресын хоолойгоор гарч одно! гэлээ.

Үүнийг капитан Немо тасалданга тод өгүүлээд, яльгүй мэхэсхийн ёслов. Энэ нь яриа дууссан гэсэн тэмдэг ажээ. Би зөвхөн л гарч одохоос өөр замгүй тул тэр ёсоор болгон гарч одлоо.

Би өөрийн өрөөнд эргэж ирвэл капитантай ярьсан миний яриаг сонсохыг сонирхож агсан Консель маань тэнд байв.

- Улаан арьстнууд “Наутилус”-ыг заналхийлж байна гэсэн миний үгийг сонсоод капитан надаар наад барьж байна даа, найз минь тэгвэл капитанд дүүрэн итгэж болно. Явж амгалан нойрсдоо гэж би хэлбэл, Консель:

- Эзэнд одоо миний хэрэг үгүй юу? гэлээ.

- Үгүй ээ\* хонгор минь, их баярлалаа. Нед Ленд юу хийж байна?

- Эзэн хэрэв зөвшөөрөхсөн бол Нед Ленд одоо кенгеругийн махаар, ёстой л шүлс залгихаас өөр аргагүй таташ хийж байна гэж хэлэх байнам гэв.

Өрөөндөө би ганцаар үлдээд, хэвтэртээ орсон боловч маш муу унтаж билээ.

Зэрлэгүүд миний толгой хавьд онгоцны төмөр тавцан дээгүүр тэл, тап туучиж үргэлж хашгаралдаж байв.

Шөнө тайван өнгөрлөө. “Наутилус”-ын багийнхан бахь байдгаараа үзэгдэх ч үгүй сонсдох ч үгүй байв. Цэргийн боомтын нүхэн гэр дээгүүр гүйлдсэн шоргоолж цэргүүдийн сэтгэлийг өчүүхэн ч үл зовоодогтой нэгэн адил тэдний сэтгэлийг зэрлэгүүд өчүүхэн ч үл зовоох ажээ.

Би өглөө зургаад бослоо. Онгоцны дээд таг нээгдээгүй л байв. Тиймээс онгоцны доторхи агаар өчигдрөөс хойш солигдоогүй ажээ. Энэ байдал үл мэдэгдэх учир нь гэвэл усан доогуур явагч хөлөгний хийн бэлтгэл багтаамжууд онгоцны бохирдсон агаарт байсхийгээд л хэд хэдэн метр шоо дөрвөлжин цэвэр агаар өх учраас болой.

Би өөрийнхөө өрөөнд үд хүртэл ажилласан тул капитан Немогийн барааг ч харсангүй билээ. Хөлөг онгоц хөвөлтөнд бэлтгэж байх янз ч алга даа.

Би нилээд хэдэн минут хүлээгээд үзэсгэлэн танхимд явж орлоо Цаг харвал хоёр хагас болжээ. Тэгвэл арван минутын дараа далайн түрлэг дээд цэгтээ хүрэх ёстой бөгөөд хэрвээ л капитан Немо алдаж тооцоогүй бол “Наутилус” усан дээр хөвж гарах ёстой билээ. Хэрэв л энэ бүхэн өнгөрчих юм бол бидний онгоц өөрийн шүрэн хэвтрээс ховхрох хүртэл олон сар хүлээх хэрэгтэй байв.

Гэтэл удсан ч үгүй онгоцны их бие доргиж эхлэв. Онгоцны төмөр хуяг шүрэн ёроолд шүргэж хэрхэн хяхтнаж буйг би сонсож байлаа.

Хоёр цаг гучин таван минутанд капитан Немо үзэсгэлэн танхимд орж ирэв.

- Одоо бид хөдөллө-гэв.

- Аа-гэж би дуугарвал капитан Би дээд таг нээчих гэсэн,

- Папуасууд яасан бэ?

- Папуасууд ий? гэж мөрөө хавчив.

- Тиймээ. Үгүй ээ. Тэд чинь ороод ирнэ шүү дээ.

- Хаагуур?

- Таны нээ гэсэн тагаар!

-Эрхэм ноён Аронакс хэмээн капитан хэнэг ч үгүй “Наутилус”-ын дээд тагаар хэдий нээлттэй байлаач гэсэн тэр болгон орж болдоггүй юм шүү гэв. Би гайхсандаа түүн рүү гөлөрчихвөл;

- Та ойлгохгүй байна уу? гэж асуув.

- Тиймээ.

- За тэгвэл нааш ир. Та өөрөө үз л дээ гэлээ ? Бид дээд таг өөд гардаг шатанд ойртон очив. Тэнд Консель Нед Ленд хоёр онгоцны тавцан дээрээс галзуурсан мэт бахиралдаж, чарлалдаж буй зэрлэгүүдийн орлилдоон дунд дээд талын тагийг нээж байгаа хэд хэдэн усан цэргийн ажлыг нэн их сонирхон зогсож байв.

Дээд таг пүршний хүчинд гэдрэг шидмэгц түүний нүхээр хориод тооны улайрсан муухай амьтны дүрс харагдлаа.

Тэгтэл эдгээр зэрлэгийн хамгийн түрүүчийнх нь шатны хашлага дээр гараа тавимагцаа яагаад ч юм бүү мэд ямар нэгэн их хүчээр ар гэдэргээ шидэгдэж үхэр дуун гарган дэгдсээр зугтаж одсон билээ.

Түүний нөхөр арван хүн түүний жишээгээр дараалан оролдлого хийж мөн л тийм үр дүнтэй буцацгаалаа. Консель нэн их хөхиж баярлалаа. Өөрийн хэзээ язааны эрэлхэг дайчин эр зоргиндоо өөрийн эрхгүй хөтлөгдсөн Нед Ленд ухарч буй дайсныг мөрдөхийг завдан ухасхийж шатанд мөн өнөө хашлаганаас барьж авч амжсан тул бас л арагшаа хаягдсан бүлгээ.

- Ээ харал аа! хэмээн тэр бахирч, намайг цахилгаан цохилоц! гэхэд нь би хамаг учрыг мэдэж авлаа.

- Тэхнээ нь шатны хашлага төмрийг өндөр хүчдлийн гүйдэл дамжуулагч болгосон ажээ. Түүнд гар хүрсэн хэн боловч арагшаа айхавтар хүчтэй цохигдож байв. Хэрэв л капитан Немо өөрийн байдаг бүх гүйдэл үүсгэгчээс гарсан гүйдлийг түүгээр дамжуулсан сан бол тэр цохилт амь насанд аюултай байж болох байлаа. Гэвч тэр аюул багатай гүйдэл дамжуулагчаар зөвхөн хязгаарлаж довтолгоонд ба онгоцон доторхи хүмүүсийн хооронд нэвтэршгүй саад бий болгожээ.

Энэ завсар айсандаа сүнс нь зайлсан Папуасууд хурдавчлан ухарч байв. Бид инээдээ нуун галзуурсан мэт хараал тавьж агсан Нед Лендийг аргадан тайтгаруулж бүлгээ.

Энэ минутанд далайн түрлэгийн давалгаагаар өргөгдсөн «Наутилус»-ын хайрдсан газраасаа хөндийрч байв. Өдрийн яг хоёр цаг дөчин минут буюу капитан Немогийн тогтоосон цаг болжээ.

Онгоцны сэлүүр сэнс ус аажуухан алгад алгадсаар яваандаа эргэлт нь түргэсэж “Наутилус” далайн гадрага дээгүүр хөвж эхлээд торессын аймшигт хоолойгоос ямар ч гэмтэл хохиролгүй гарч одов.

[Тор](#)

---

## ДАХИАД Л ШОРОНД

Дараачийн нь өдөр, нэгдүгээр сарын аравнаа “Наутилус” задгай тэнгист дахин гарч

довтолголоо. Энэ удаа цагт гучин таван миль хурдалж байсан нь хийсэх мэт ажээ Түүний сэнс маш түргэн эргэлдэж буй тул би түүнийг ажиж минутанд хэд эргэж байгааг нь тоолж чадахгүй байна.

Цахилгаан гэдэг тэр гайхамшиг хүч «Наутилус»-ыг зөвхөн хөдөлгөж байгаагаар барахгүй мөн гэрэлтүүлж дулаацуулж, цахилгаан цохиулж л амиа алдахаасаа л айхгүй бол хэн ч гаднаас нэвтэрч үл чадах саадыг бий болгож хамгаалж буй тэр их цахилгаан хүч энэ бүхнийг би санахад хичнээн бахдаж биширсэн гэдэг хязгааргүй билээ. Тэр ч яахав харин энэ бүхнийг өөрийн гараар бүтээсэн тэр хүн миний баяр бахдлыг бүр ч илуу төрүүлж бүлгээ.

Бид энэ хэр, шууд баруун зүгийг барьж явав. Нэгдүгээр сарын 11-нд бид уртрагийн 135 ба умарт өргөргийг 10 хоногт Карбентарийн буланд орох амыг цагдан орших весеелийн хушууг тойрлоо. Энд хэдийгээр усан доорхи хад олон боловч өөр хоорондоо их зайтайгаас гадна зураг дээр нарийн тэмдэглэгджээ. «Наутилус» бидний явах замын дагуу орших мөн дээрх аравдугаар өргөрөг, уртрагийн 130 хоногт баруунаас Викторин зүүнээс Моне хоёр цохионы хоорондуур хялбархан өнгөрлөө.

Нэгдүгээр сарын арван гурванд бид Тиморын далайн уснаас мөн тэр нэрээр нэрлэгдсэн арлын дэргэдүүр уртрагийн 122 хоногт явж орлоо. Мянга зургаан зуун хорин таван шоо дөрвөлжин бээр дэвсгэр бүхий энэ арлыг Энэтхэгийн хэд хэдэн хаан хувааж захирдаг ажээ. Тэр арлыг захираад өөрсдийгөө гумбараа матарын хөвүүд хэмээн нэрлэдэг нь хорвоо дээр оршигч хамаг л амьтдын дотроос хамгийн хувьтай дээд төрөлтөн гэж үздэгийн учир тэр байжээ. Тэр хаадын зэрлэг “өвгөд” уул арлын голын уснаа үй олноороо байдаг нь тэндхийн олон лам нартай садан сүлбээтэйгийн хүчинд тэр нутгийн хүн амын зүгээс бишрэн сөгдөхийн гүн сүсэглэлээр хүрээлэгдсэн билээ. Түүнчлэн тэдний хойноос санаа тавьдаг, тэдэнд зусарддаг, тэдийн зоогонд залуу хүүхнүд барьдаг бөгөөд тэр нэгэн сэтэрт гүрвэл өөд нь гар далайсан харь газрын хүн сайнаа үзэхгүй нь зайлшгүй бүлгээ.

Гэвч «Наутилус» тэдгээр муухай амьтадтай ноололдож байхын хэрэггүй байв. Капитаны туслах ээлжит ажиглалтаа үйлдэж байхад буюу үд дундын үед Тимор арлыг бид хэдхэн минут ажиглаад явсан билээ. Мөн тэдгээр бүлэг аралд хамаарагдах Роттн хэмээх жижиг арлыг би бас л түргэн зуур хараад өнгөрөв. Энэ арлын бүсгүйчүүд гуа сайхнаараа цуутай бөгөөд боолчуудыг худалдаалах меланезийн зээл дээр өндөр үнэлэгддэг ажээ.

Эндээс «Наутилус» баруун өмнө зүгийг чиглэн огцом эргэн Энэтхэгийн гадаад далайг зорьж одлоо.



Капитан Немогийн өндөр ааш биднийг хааш аваачих нь вэ? Азийн эрэг өөд үү? аль эсхүл Европ тив рүү юу? Эдгээр таамаглалыг хүн амьтантай хуурай газрыг үзэн ядах капитаны цаг үргэлжийн хилэгнэлтэй холбон тайлбарлахад хүнд байв.

Тэгвэл бид арай урдуур орох нь ээ? Магад ч үгүй “Наутилус” маань Сайн итгэлтийн ба Горнын хушууг тойрч өмнө туйл руу одож байж? дараа нь бид, усан доогуур явагч онгоц дураар туулах уудам хязгаар бүхий номхон тэнгистээ яасхийгээд л явж ирэх вэ?

Энэ бүх асуулганд зөвхөн ирээдүй л хариулт өгч чадах байв.

Далайн дайсагнал шуурганы эрхэнд алс хаягдсан, хуурай газрын эцсийн хаш- лага саад Карьте-Гиберни, Серинтататам ба Скоттын далд шүр арлуудын дэргэдүүр өнгөрч нэгдүгээр сарын14-нөө бид хуурай газраас алс хол задгай далайд гарч ирлээ. “Наутилус”-ын хурд жигдэрлээ. Олон ааштай янзын онгоц нэг бал далайн их гүнд очоод, нэг бол удаан хугацаагаар түүнний гадаргууг үл орхиж билээ.

Энэ аяллын үед капитан Немо далайн янз бүрийн гүнд усны халуун хүйтнийг хэмжих сонирхолтой ажиглалтуудыг үйлдээ. Ердийн нөхцөлд тэдгээр ажиглалтыг нилээд төвөгтэй багажуудын тусламжтайгаар үйлдэх бөгөөд түүнийг далайн гүнзгийг хэмжих термометрчилсэн багажаар буюу янз бүрийн төмөрлөг цахилгаан харилцан адилгүй дамжуулах явдал дээр үндэслэсэн аппаратаар хэмждэг билээ. Гэвч тэдгээр багажийн заалтанд тэр болгон итгэж болохгүйгээс гадна тэдгээрийн шилэн хэрэгсэл далайн их гүнд усны өндөр даралтыг тэсвэрлэж чаддаггүй ажээ. Тэрчлэн уул туршла- гыг давтан үйлдэх явдал нэн төвөгтэй тул нэг удаагийнхаа ажиглалтанд тэр болгон итгэхэд бэрх болно.

Тэгвэл капитан Немо дуртай гүнзгйдээ өөрийн биеэр орж ажиллахуйц усны янз бүрийн давхрагад оруулсан термометр ямарч маргаангүй яг таг хэмждэг ажээ.

Тиймэрхүүгээр нэг бол ус дүүргэсэн тусгай багтаамжуудын тусламжтайгаар, нэг бол “Наутилус»-ын залуурыг далайн ёроол руу хазайлгасны үрээр капитан Немо далайн гадрагаас доош гурав, дөрөв, тав, долоо, ес, арван мянган метрийн гүнд дараалан орж хэмжээд, усны халуун хүйтэн мянган метрээс доош бөмбөрцгийн бүх л өргөргүүдэд, цельсийн дөрөв аравны таван градус тогтмол байдаг гэдэг дүгнэлтэд иржээ.

Би тэдгээр шинжилгээг маш сонирхон ашиглаж эрдэм шинжилгээний тэдгээр ажиглалт капитан Немод ямар хэрэгтэй юм бол? гэж өөрөө өөрөөсөө асуудаг байв, үнэхээр тэр хүн төрөлхтний ашиг тусын тул гэж үү?

Тэгвэл тэр ч найдвар багатай буйзаа. Учир нь түүний тэрхүү бүх хөдөлмөр өөртэй нь

хамт ямар нэгэн алсалсан тэнгисийн ёроолгүй гүнд булшлагдах ёстой байв.

Гэвч яаж мэдэх вэ, тэр надаар дамжуулан өөрийн эрдэм шинжилгээний их бүтээлийг ертөнцөд бэлэглэх ч гэж байж, тэгвэл эрт орой алин боловч хэзээ нэгэн цагт усан доогуур явагч өөрийн онгоцноос намайг суллан тавьж, хуурай газар хүмүүсийн дунд эргэн ирэх бололцоог над өгнө гэж үү?

Тэгвэл үүнд одоохондоо итгэж найдах ямар ч үндэсгүй бизээ...

Гэлээ ч гэсэн капитан Немо нэг удаа дэмий бөмбөрцгийн гол гол далайнуудад үйлдсэн усны нягтралыг шинжилсэн шинжилгээнийхээ үр дүнгийн тухай надтай сэтгэгдлээ хуваалцлаа. Жич хэлэхэд түүний хэлснээр эрдэм шинжилгээний асар их сонирхлыг төруулж буй гэгдэх нэгэн мэдэгдлээс авч үзвэл миний зүгээс хийсэн дүгнэлтээр тэр нь шинжлэх ухаантай ямар ч уялдаа авцалдаагүй боловч миний хувьд л нэн их чухал зүйл байлаа.

Энэ хэрэг нэгдүгээр сарын 15-ны өглөө болж билээ. Би капитан Немогийн хамт “Наутилус”-ын тавцан дээгүүр нааш цааш сэлүүцэн явтал далайн усны нягтрал энд тэнд харилцан адилгүй гэдгийг та мэдэх үү гэж надаас тэр гэнэт асууж бүлгээ. Би мэдэхгүй хэмээн хариулаад, энэ асуудлын талаар шинжлэх ухаанд хэрэг дээр нь жинхэнэ шалгасан баримт нотолгоо байхгүй гэж нэмэн хэлэв.

- Би өөрөө үүний чинь шинжилсэн хэмээн капитан Немо над хэлээд би түүний зөв гэдгийг хаана ч батална гэлээ.

- Маш сайн байна гэж би хэлээд-гэвч “Наутилус” ч онцгойдоо тусгаар ертөнц учраас түүн дээр яваа эрдэмтний их нээлт газрын бөмбөрцөг дээр оршигчдын сонорт хэзээ ч хүрэхгүй нь харамсалтай юм гэв.

- Таны зөв профессор гэж жаахан бодолхийлсний дараа капитан Немо нээрээ ч “Наутилус” бол биеэ дайсан тусгаар ертөнц, миний энэ онгоц бол газар дэлхийгээс өөртэй нь хамт нарыг тойрч буй бусад ертөнцийн нэгэн адил хол юм. Яг л түүнчлэн Ангараг ба санчир хоёр ертөнцийн эрдэмтдийн бүтээлийг газар дэлхий хэзээ ч мэдэж чадахгүй шиг “Наутилус”-ын эрдэмтдийн ажил хэзээ ч мэдэгдэлгүй үлдэх юм. Зуурдын тохиолдлоор таны хувь заяа “Наутилус”-ын хувь заяатай холбогдсон болохоор би танд өөрийн ажиглалтын тухай аар саар зүйл мэдэгдэж болох байнам гэв.

- Би таны үгийг хичээнгүйлэн сонсьё капитан минь.

- Далайн ус ердийн цэнгэг уснаас хамаагүй их нягтралтай гэдгийг та эрхбиш мэдэж байгаа, гэвч тэр нягтрал газар бүр адилгүй. Нээрээ ч үнэндээ хэрэв цэвэр цэнгэг усны нягтралыг нэгж болгон авч үзвэл Атлантын тэнгисийн усны нягтрал-нэг бүхэл

мянганы хорин найм, номхон тэнгисийнх нэг бүхэл мянганы хорин зургаа, газрын дунд далайнх... “Ухай тэхээрээ мань Газрын дунд далайд очдог байх нь байна шүү! гэж би бодов”

-... Нэг бүхэл мянганы гучин нэг, Ионийн далайн усных нэг бүхэл мянганы арван найм, Адратикийнх-нэг бүхэл мянганы хорин наймтай тус тус тэнцэнэ.

Түүнээс үзвэл “Наутилус” дэлхийн бөмбөрцгийн хамгийн хөл хөдөлгөөнтэй далайн усыг ч тойрдоггүй нь тодорхой байв. Түүнээс үндэслэж би түүнийг хэзээ нэгэн цагт, магадгүй удах ч үгүй нилээд хөгжсөн орнуудын эрэгт ойртох төстэй гэдэг дүгнэлт хийлээ.

Энэ шинэ мэдээ Нед Лендийг баярлуулах ёстой байв.

Дараачийн хэдэн өдрийн турш бид шинжилгээний хэд хэдэн ажил хамтдаа хийв. Үүнд: Далайн усны янз бүрийн гүнд ууссан давсны хэмжээ, цахилгаан дамжуулах чанар, өнгө, тунгалаг зэргийг тодорхойлсон билээ. Энэ бүх хугацаанд капитан Немогийн гарын гайхамшигт ур, бүтээлч авъяас чадвар намайг нэн их гайхуулан бишрүүлсэн бөгөөд түүний тэр чанар зөвхөн л намайг урьдчилан анхааруулах зантай нь л өрсөлдөж чадах байв. Гэвч тэдгээр туршлага дуусмагц л дахин сураггүй алга болох тул би “Наутилус” онгоцноо аанай л ганцаараа үлддэг бүлгээ.

Нэгдүгээр сарын арван зургаанаа “Наутилус” онгоц нэгэн удаа далайн төвшнөөс хэдхэн метрийн гүнд нам унтчих мэт болсон билээ. Онгоцны цахилгаан хөдөлгүүрүүд зогсож, сэлүүр сэнс эргэлдэхээ больсон тул усан доогуур явагч онгоцыг далайн урсгалын эрхэнд зөнд нь тавьсан бүлгээ. Дөнгөж саяхан аль хол газар нэн их хурдлан давхиснаас шалтгаалан жижиг засвар хийхээр машинуудаа зогсоох мэт надад санагдлаа.

Гэтэл энэ өдөр би, өөрийн нөхдийн хамт сонирхолтой нэгэн үзэгдлийн гэрч болсон юм. Үзэсгэлэн танхимын гэгээвчтэй хавтас аажим нээгдсэн боловч “Наутилус”-ын гадаах цахилгаан чийдан асаагүй байгаа тул тэнгэр бүрхсэн үерийн хар үүлс усны гүнд гэрэл муу оруулж, бидний эргэн тойронд бүрэнхий ажээ.

Би тэнгисийн усны хачин өнгийг сонирхон байтал “Наутилус” гэв гэнэт нүд гялбам хурц гэрлийн цацралд дайрагдав. Түүнийг би эхлээд манай онгоцны гэрэл асч давхаргыг гэрэлтүүлээ гэж бодсон боловч андуурал болжээ. Тэгж эндүүрснээ би орчныг сайтар ажиглаж харсны дараа сая мэдсэн бүлгээ.

Тэхнээ нь “Наутилус” далайн усны урсгалд хөв хөвсөөр фосфороор гэрэлтүүлэгдсэн давхаргад орсон тул түүний гэрэлтэх хүч, хүрээлж буй харанхуйтай харьцуулбал гялбам хурц санагджээ. Тэрхүү гэрэл үй олон тооны маш бяцхан амьтдын биеэс

цацрах бөгөөд тэр амьтдын бие онгоцны төмөр ёроолтой хавирснаас улам их гэрэлтэж билээ. Гэтэл би бас гэрэлтэж буй тэрхүү далайн дунд, улайдсан зуухнаас урсаж байгаа хайлсан тугалга мэт унжирсан гэрэл бүр ч илүү хурц дүрсхийхийг ажсан нь түүний дэргэд далайн зэргэлтэж буй бусад давхаргад харанхуй болох мэт сэтгэгдэл төрж бүлгээ. Тэр хурц гэрэл манай цахилгаан чийдэнгийн зөөлөн сацралтай өчүүхэн ч адилгүй байв.

Тэр гэрэл хөдөлгөөнтэй болоод биетэй мэт санагдлаа. Үүгээрч барахгүй уул гэрэл амьтай болодыг шууд ажиг болох байв.

Тэрхүү гэрэл туяа бадарсан уснаа “Наутилус” олон цаг аяллаа. Тэрхүү гал гэрэл дунд гүрвэл мэт тонгочиж буй далайн том амьтдыг хараад бидний бахархал бүр ч их боллоо. Тэрхүү гэрлийн хүйтэн сацралын дунд далайн тамирчид далайн гахай, сэлмэн хамартууд сэлж харагдсан бөгөөд сэлмэн хамартын гурван метр урт аврага том эвэр сэлэм, гэгээвчний болор шилэнд хэд хэд хавирсан бүлгээ. Дараа нь эвэр нуруут, макрель мэтийн бусад жижиг загас бий боллоо.

Тэрхүү гайхамшиг үзэгдэлд дур татах ямар нэгэн хачин чадал бий ажээ Тэд өдрийн цаг агаарын байдал усны тэрхүү гэрэлтлийн хүчийг ихэсгэсэн ч байж болох юм. Тэгвэл далайн гадаргуу дээр үер бууж байсан бол уу? Гэвч, “Наутилус” хөвж явсан тэрхүү хэдхэн метрийн гүнд тэнгэрийн байдал ямар ч чөлөөгүй тул бид усны амгалан урсгалд таатайхан халбилзан байв.

Тиймэрхүүгээр бид улам л шинэ шинэ гайхамшгийн дунд үл мэдэг урагшилж байлаа. Консель маань нүдээ байдгаараа бүлтийлгэн харж аль л тохиолдсон үе хөлтөн, зөөлөн биетэн загас, ургамал амьтдыг зогсоо зайгүй ангилан байв.

Өдөр хоног нэн түргэн өнгөрөх болж, тэдгээрийг би тоолохоо ч болилоо. Нед Ленд маань тогтсон заншлаа баримтлан өөрсдийн хоолыг аль болохоор олон төрөл болгохыг хичээж явав.

Бид яг л эмгэн хумс дун бүрхүүлээ үл орхих мэт амьдрах болов. Би өөрийн туршлагаас авч үзвэл эмгэн хумс байх төдий төвөгтэй бус байлаа.

Энэ хэлбэрийн амьдралд бид бүр дадчихаад түүний тааламжтай, хөнгөнд амтархан байсаар дэлхий дээрх амьдрал байдал шал өөр болж байгааг таг мартжээ.

Гэтэл нэгэн удаагийн санамсаргүй тохиолдол бидэнд бодит байдлыг ухамсарлан сэхээ оруулан бүлгээ.

Нэгдүгээр сарын арван наймнаа <<Наутилус>> уртрагийн 105, өмнөт өргөргийн 15 хоногт явж байлаа. Цаг агаарын байдал ширүүн, далай дээгүүр өндөр өндөр давалгаа цалгилж билээ. Салхи дорно зүгээс асар их хүчтэй шуурч байв. Хэд хэдэн

өдрийн турш үргэлж цаашилж байсан барометр догшин үер ойртож буйг зөгнөж бүлгээ.

Капитаны туслах ажиглалтаа хийж байх үед би онгоцны тавцан дээр гарч ирэв.Тэр ердийнхөө заншлаар өнөө л хэлдэг үгээ л хэлэх болно хэмээн би бодож байтал, энэ өдөр тэр урьдынхаасаа шал өөр, мөн л үл ойлгогдох үг хэллээ.Тэгтэл ч капитан Немо онгоцны тавцан дээр гарч ирээд дуран авч алсыг дурандаж гарлаа.

Далайн төвшин дээр байгаа ямар нэгэн цэгээс дурангаа ул салган, капитан хэдэн минут хөдөлгөөнгүй зогссоноо, дурангаа хурааж өнөөх надад үл ойлгогдох хэлээрээ туслахтайгаа хэдэн үг солив.

Ажвал тэр хүний сэтгэл ямар нэгэн юманд үймэрсэн бол уу гэмээр бөгөөд өөрийн хөдөлсөн сэтгэлийг арайхийж барьж байх харагдлаа.Тэгж капитан Немо биеэ сайн барьж амгалан байдлаа хадгалан чадаж байв. Мнний таамагласнаар бол капитан Немо, туслахдаа ямар нэгэн санамж өгч, тэр нь хариу амлаж буй буюу өөртөө итгэж болохыг хичээнгүйлэн баталж буй мэт байв.

Үгүй дээ л тэдгээрийн дууны өнгөөр тиймэрхүү сэтгэгдэл надад төрж билээ.

Саяхан капитан Немо, түүний туслах хоёр дурандаж байсан тэр зүг би нэн их анхааран ширтсэн боловч юу ч олж үзсэнгүй. Тэртээ тийшээ тэнгэр ус хоёр нэгэн шугаманд зааглан харагдаж тэрхүү шугамын тэгш шулуун зурвас юунд ч үл өртөж билээ.

Тэр хооронд капитан Немо намайг харахгүйгээр, магад ч үгүй миний байгааг мэдэх ч үгүй байсан байж онгоцны тавцан дээгүүр нааш цаашаа холхилж байв. Түүний алхаа, мөн л жирийн яаралгүй хэвээрээ жигд боловч ердийнхөөсөө жаахан удаахан байсан ч байж магадгүй.

Хааяа тэр зогсож, хоёр гараа элгэндээ зөрүүлээд далай өөд ширтэж байв.

Усны тэрхүү уудам цөлд тэр юу харсан бол? “Наутилус” хамгийн ойр байгаа хуурай газраас хэд хэдэн арван миль зайтай байв.

Капитаны туслах дурангаа дахин нүдэндээ авав. Дараа нь тэр тавцан дээгүүр нааш цааш харайж, заримдаа зог тусан, дэвслэн, тэгснээ дахин гүйх шахам болж байв. Тэр одоо өөрийнхөө түгшсэн сэтгэлийг нуухыг оролдсонгүй ээ.

Тэр явдлын нууц бодвол удахгүй л задрах ёстой болсон бөгөөд учир нь капитан Немогийн тушаалаар онгоцны бүх машин хамаг байдгаараа ажиллаж эхлэв.

Энэ минутанд капитаны туслах өөрийн капитаныг дахин дуудлаа-Тэр тавцан дээгүүр холхихоо больж дуран авч далайн алс төвшин руу дурандаж одов.Тэр дурангаа нүднээсээ мөд салгасангүй. Эдгээр ер бус амгалан улсын хачин загнахыг харж

сонирхсон би үзэсгэлэн танхимд бууж очоод өөрийн үргэлж ашиглан байдаг агуу сайхан яндан дуран авч тавцан дээр эргэж ирээд далайг дурандахаар нүдэндээ авч алсыг онож харж амжаагүй байтал минь миний гараас хэн нэгэн хүн мулт татан авчлаа.

Би түргэн зуур эргэн хартал миний өмнө капитан Немо зогсож байсан боловч би түүнийг таньсангүй ээ. Түүний царай нь муухай хувирч нүдэнд нь хилэнт гал бадарч байв. Тэр шүдээ шазайлган, ам нь дутуу ангайжээ. Түүний хураасан бие, зангидсан нудрага, мөрөндөө шигдсэн хүзүү зэрэг нь түүний бие үзэн ядах асар их үзэл, уур хилэнгээр нэвширсэн болохыг илтгэж байв.

Тэр ядаж өчүүхэн ч хөдөлсөнгүй. Түүний надаас булааж авсан дуран тавцан дээр хэвтэв.

Үнэхээр тэр надаас болж их хилгэнэв гэж үү? Эсхүл тэр үл ойлгогдох хүн "Наутилус онгоцонд олзлогдсон хүн мэдэж болохгүй ямар нэгэн чухал нууцыг намайг мэдчихлээ гэж санав уу?

Гэвч, түүний тэр их үзэн ядах үзлийн эх үүсвэр нь би биш ажээ. Тэр ядаж намайг тоож харсан ч үгүй. Түүний нүүд алсад бүртийж буй тэр нэгэн цэг дээр тулж тогтсон байв.

Тэгтэл ч капитан Немо сая сэхээ орлоо. Түүний хувирсан зүс, ердийнхөөрөө амгалан, хүйтэн байдалтай болов. Тэр өнөө хэлээрээ туслахдаа хэдэн үг хэлчээд дараа нь над руу хандаж :

- Эрхэм Аронакс танаас хэмээн тэр захирангуй хоолойгоор - бидний хооронд хийсэн хэлэлцээрийн нэгэн зүйлийг даруй дагах явдлыг би шаардах хэрэгтэй боллоо гэв.

- Чухам ямар зүйл билээ, капитан аа?

- Таны бие болоод таныг дагалдагсад та бүхнийг суллах тушаал намайг өх хүртэл түгжээтэй суух хэрэгтэй болж дээ.

- Таны тушаалыг би зайлшгүй дагах минь болжээ хэмээн би хэлээд, түүнээс нүд салгалгүй ширтэн байж гэвч танаас нэг юм асууж болох уу?

- Үгүй ээ, болохгүй!

Хэрэг нэгэнтээ тийм болсон тул маргахын хэрэггүй бөгөөд, түүнтэй тэмцэлдэх хүчин чадал надад үгүй бүлгээ. Тиймээс, түүнийг дагахаас өөр аргагүй болжээ. Би Нед Ленд, Консель хоёрын өрөөнд орж очоод капитаны тушаалыг тэдэнд сонсголоо.

Миний сонгосон мэдээ канадын харъяатад чухам ямар сэтгэгдэл төрүүлснийг тааварлах боломж уншигчдад олгоё. Тэхэд олон юм ярихын зав бидэнд байсангүй.

Энэ үед дөрвөн далайчин биднийг босгон дээр маань хүлээн зогсоож байгаад анх

биднийг “Наутилус”-т орж ирэхэд аваачиж түгжсэн өнөөх тасалгаанд хүргэв.

Нед Ленд тэмцэлдээд үзэхийг завдсан боловч хаалга түүний яг хамры нь өмнө яв хийтэл хаагдав.

-Энэ чухам юу болж байгаа нь энэ билээ. Эзэн бидэнд хэлээд өхгүйсэн болов уу? гэж Консель асуулаа.

Би өөрийн нөхдөд онгоцны тавцан дээр болсон бүхнийг ярьж өгөв. Тэд мөн л миний нэгэн адил гав гайхсан боловч бид бүхнийг хүрээлж байсан тэр нууц тодорхой болсонгүй ээ.

Би нэн их бодолд орлоо. Капитань царайны хачин хувиралт миний толгойноос гарахгүй байв. Би ядаж хоёр янзын бодлыг холбон дүгнэж чадахгүй, ямар ч хэрэггүй таавар, сэжиглэлүүдийн дунд төөрөлдөн мангуурч байтал:

-Хүүе ширээн дээр хоол байна гэсэн Нед Лендийн дуу миний бодлыг сарниалаа.

Үнэхээр ч ширээ дүүрэн аяга таваг өржээ. Бодвол тэнд ингэж юм бэлтгэх тушаалаа капитан Немо “Наутилус”-ын гүйдлийг хурдасгах тушаалтайгаа нэгэн зэрэг өгсөн буйзаа.

-Өөртөө нэгэн сайхан зөвлөлг өхийг эзэн зөвшөөрөхсөн болов уу? хэмээн надаас Консель асуухад, би :

-Зөвшөөрөлгүй яахав, хонгор минь гэв.

-За тэгвэл эзэн өглөөнийхөө зуушийг сайн идчих. Үүнийг цаашдын болгоомж, цаг үе шаардаж байна. Бүү мэд шүү дээ ер нь цаашид юу болох нь Консель минь, чиний зөв.

-Аяа... хэмээн Нед Ленд санаа алдаж бидэнд зөвхөн л загас өгч шүү дээ. Бидний нөөцнөөс юу ч алга...

-Бод л доо Нед минь. Үгүй ээ, энэ чинь ерөөсөө бидэнд юу ч өгөөгүй бол чи яах юм? Энэ үг Канад нутгийн хүнийг номхотгов. Бид ширээний ард сууцгааж чив чимээгүй зуушлав. Би бага идлээ. Консель өнөө болгоомжлолдоо автаж албаар их идэв. Харин Нед Ленд л өөрийнхөө эхний дургүйцлийг харгалзахгүйгээр нэг ч үмх хүнс сул орхисонгүй гөрчихлөө.

Өглөөний зуушны дараа бид тус бүрдээ нэг нэг булан эзлэн сууж авав.

Яг энэ минутанд бидний тэрхүү хавчиг өрөөг гэрэлтүүлж байсан таазны хагас бөмбөгөр чийдэн унтарсан тул бид пад харанхуйд үлдлээ. Нед Ленд ч тачигнатал хурхирч эхлэв. Харин Консель түүнийг дууриан хурхирч ороход би гайхаж байв. Миний нөхдийг яагаад тийнхүү амархан зүүд нойр авч одов хэмээн би өөрөөсөө асууж суутал миний ч нойр хүрч дийлдэхийн аргагүй болж билээ.

Би нүдээ нээлттэй байлгахаар хэдий хичээсэн боловч миний дураар болсонгүй хоёр нүдний минь зовхи өөрөө бууж орж ирээд байв. Би нэн их шаналгаатай байдалд орж унтах унтахгүйн хооронд бүр зовчив. Бодвол бидэнд өгсөн хоолонд нойрны эм хольсон бололтой.

Тэхлээрээ биднийг харанхуй гянданд хорьсон нь капитан Немод бас багадаж өөрийнхөө цаашид үйлдэх ажлаа нуухын тул биднийг мөн унтуулах хэрэгтэй байжээ? Хагас дутуу унтаж, зүүрмэглэх зуураа би онгоцны дээд таг хаагдаж буй чимээ муухан сонслоо. Усны гадаргуу дээр хөвж байснаас шалтгаалж үл мэдэг халбилзаж агсан онгоц хөдлөхөө ч больчив. Бодвол “Наутилус” тэнгисийн мөнхийн амгалан гүнд живж байсан буйзаа.

Би энэ завсар мөн л нойртойгоо үзэлцсээр байв. Гэвч энэ бүтдэггүй хэрэг ажээ. Миний амьсгаа суларч, үе мөчний үзүүрээс зүрхэнд минь хүртэл үхлийн хүйт дааварлаж байхыг би мэдэрч байлаа. Тугалга цутгасан мэт хүнд зовхио өргөхийн арга алга. Муу юм үзэгдсэн муухай зүүд зүүдлэгдэж хүндээс хүнд нойр намайг дарж авлаа. Дараа нь зүүд үзэгдэхээ боль больсоор би ухаан алдсан билээ.

[Тор](#)

---

## ХӨНДИЙ БИЕТНИЙ ЕРТӨНЦ

Би маргааш өглөө нь сэргэл толгой минь аймшигтай дүнсийж байв. Би харин нэн их гайхалд өөрийнхөө өрөөнд байж байлаа. Бодвол миний нөхрийг нойрон дунд нь мөн л тэгж өрөөнд нь аваачсан байлгүй. Учир иймээс миний нөхөд өнгөрсөн шөнийн явдлыг надаас илүүгүй мэдэж байсан тул тэрхүү нууц хэргийн хөшгийг зөвхөн л ирээдүй л ямар нэгэн аргаар сөхнө гэдэгт найдахаас өөр арга надад байсангүй.

Би өрөөнөөсөө гармаар дур хүрлээ. Гэвч би суларсан юм бол уу, аль эсхүл түрүүчийн адил түгжээтэй юу? Тэхнээ нь би бүрэн чөлөөтэй болчихсон ажээ. Тэгээд хаалгаа нээж, гудамж өрөөгөөр дамжин тавцан өөд гаргах шат руу явлаа. Өмнөхөн нь хав яв хаачихсан дээд таглааг цэлийтэл нээжээ. Би онгоцны тавцан дээр гарч ирэв. Тэнд намайг Нед Ленд, Консель хоёр хүлээж байлаа, би тэднийг байцааж эхэлсэн боловч тэд юу ч мэдсэнгүй. Өчигдөр тэд нам унтчихаад өнөө өглөө мөн л өрөөндөө сэргээсэн байлаа.

“Наутилус” мөн л урьдын адил амгалан, мөн л урьдын адил сэжиглэлтэй ажээ. Тэр жигдхэн хурдаар далай дээр ил хөвж явлаа. Түүн дээр юу ч болоогүй, түүний юу ч



хувираагүй мэт санагдлаа.

Нед Ленд далайн төвшинг ажиж зогсоход канад газрын харъяатын соргог нүд алсад хөлөг онгоцны янданг ч далбааг ч, газар орны бараа ч олж үзсэнгүй -далай цөл мэт хов хоосон байв.

Баруунаас салхилах хүчит салхи далай дээр сүрлэг давалгаа эвхрүүлж байв.

“Наутилус” нилээд аягүй сэгсэрч бүлгээ. Амьсгалах агаарынхаа нөөцийг нөхөн авмагц “Наутилус” далайн гүнд арван тав орчим метр живж орсон нь бодвол ямар нэгэн хэрэг гарвал түргэн зуур дээшээ хөвж гарах гэж тиймэрхүү яльгүй гүнд орсон буйзаа. Ердийн заншлын эсрэг энэ нэг маяг нэгдүгээр сарын арван есний өдөр хэд хэд дахин давтагдсан бүлгээ. Тийнхүү хөвж гарах тутам капитаны туслах онгоцны тавцан дээр гарч ирэн тэндээс өнөөх л хэлдэг үгээ дотогш дамжуулж байв.

Гэвч капитан өөрөө үзэгдсэнгүй ээ. Онгоцны багийнхнаас би ердөө л амарлингуй зант зарцын биеийг олж үзсэн бөгөөд тэр миний хоол ундыг зөөж тун нямбай үйлчилдэг билээ.

Ингэж байтал өдрийн хоёр цагийн үед би өөрийн тэмдэглэлийг цэгцэлж суутал капитан Немо үзэсгэлэн танхимд над дээр орж ирэв. Би түүнд мэхийн ёслохуй дор тэр надад үл мэдэг толгой дохиж нэг ч үг хариу дуугарсангүй ээ. Би оролдож буй зүйлээ дахин үргэлжлүүлж өчигдрийн явдлын тухай тэр ямар нэгэн юм ярих байх хэмээн шийдсэн боловч , тэгсэнгүй ээ.

Би түүнийг хулгай нүдээр сэмхэн харлаа. Түүний нойр хомсдосноос болсон мэт улайсан нүд ядарсан хүний шинжтэй бөгөөд царайнд нь нэн их уйтгар түүгээр ч барахгүй, уй гашуу тодорч байв.

Тэрээр танхим дотуур алхлан, зөөлөн сандал дээр нэг сууснаа дахин босож гартаа дайралдсан номыг нэг барьж авснаа тэр дор нь шидчихээд, шалган хэмжих багажуудын дэргэд очиж харж зогссоноо ердийн байдлаар тэдний заалтыг тэмдэглэсэн ч үгүй нэг л хачин ажээ. Тэр нэг секунд боловч нэг байранд зүгээр сууж чадахгүй мэт харагдлаа. Тэг тэгсээр хамгийн эцэст над руу хүрч ирээд;

- Та эмч биш биз, эрхэм Аронакс? гэлээ. Гэнэт тийнхүү шууд тавьсан асуултанд нь би төдий л зохих хариу бэлтгээгүй байсан тул тулгамдахдаа хэсэг зуур түүнийг гөлрөн уг дуугүй суув.

- Таныг би эмч биш биз гэж асууж байна. Таны зиндааныхны олонхи нь байгалийг судлагчид, хүн эмнэлгийн боловсролтойсон биш билүү...

- Тиймээ би эмч байсан, музейд алба хаахаасаа өмнө эмнэлгийн газар олон жил ординатор хийсэн хэмээн хариуллаа.

- Тун сайн байна гэж капитан хэлсний нь бодвол миний хариулсан хариулт түүнийг баярлуулсан байх аа. Гэвч би тэр надаар чухам яах гэж буйг мэдэхгүй байсан тул дахин юу асуухыг нь хүлээж түүнд нь хэргийн учир байдлыг харгалзан зохих хариултыг өхөд бэлэн байв.

- Эрхэм профессор та миний усан цэргүүдийн нэгэнд эмнэлгийн тусламж үзүүлэхийг зөвшөөрөхсөн бол уу? гэлээ.

- Хүн өвдөө юу?

- Тиймээ

- Би таныг дагалдахад бэлэн байна.

- Тэгвэл явъя.

Миний зүрх их дэлссэн үнэнээ би шудрагаар хүлээх ёстой. Яагаад ч юм бүү мэд, тэрхүү өвчтэй усан цэрэг, өчигдөр шөнийн явдал хоёрын хооронд ямар нэгэн учир бий гэсэн бодол миний толгойд орсон нь тэр нэг нууц миний сэтгэлийг, нөгөө усан цэргээс илүү донсолгож билээ.

Капитан Немо намайг онгоцны хойт руу дагуулан явж багийнхны өрөөний дэргэдээс жижиг тасалгааны үүд татлаа. Тасалгаанд жинхэнэ англо сакса ястан, гүжирмэг царайны дөч орчим настай хүн хэвтэж байв. Би түүний дээрээс тонгойн харвал тэр өвдсөн хүн биш шархадсан хүн ажээ. Цусанд будагдсан цагаан эдээр боосон толгойд нь зөөлөн дэр дэрлүүлсэн байв.

Намайг боолты нь авахад шархадсан хүн над руу том нүдээр яг ширтэж, боолты нь авахад саад хийсэнгүйгээр барахгүй нэг ч удаа ёолсонгүй ээ.

Тэрний шарх аймаар ажээ. Ямар нэгэн мохоо зэвсгээр цохиулсан гавлын нь ясны цаана тархи нь харагдаж байв. Тархины нь эд эс хөндөгдсөн болох нь харваас илэрхий байлаа. Тархины нь боровтор хөрсөм дээр байгаа цус, ширээний бүтээлэг дээр туссан улаан архины толботой адил харагдав. Тиймээс тэр хүний тархи хөдөлсний дээр цус харавсан ажээ.

Хөөрхий тэрний амьсгаа давхцаж царай нь байн байн татвалзаж бүлгээ. Миний өмнө тархины өвчлөл хөдөлгөөнт эрхтний мэдрэлийн төвийн саагийн гэм хоёр хавсрах тохиолдол яг дүрээрээ байв.

Шархлагчийн судасны цохилт тасалдсаар, дөрвөн мөч нь хөрж эхлэхэд үхэл улам бүр ойртон түүнийг хэрхэвч буцаах аргагүй гэдгийг би харж байв. Би шархыг дахин боогоод капитан Немо руу эргэж:

- Энэ хүн чухам яасхийж шархадсан юм гэж асуувал:

- Тэр нь гол гэж үү? хэмээн тэр булзааруулан хариулаад “Наутилус” ёврогдсоны

улмаас машины араа мултарч энэ хүнийг цохисон юм. Гэвч та үүний тухай юу гэж бодож байна? гэж асуув. Би үг хэлэхээсээ эргэлзлээ.

- Ярь, ярь та. Энэ хун франц хэл мэдэхгүй гэв. Шархадсан хүн рүү би дахин нэг хараад:

- Энэ хүн хоёр цагаас хэтрэхгүй.

- Үүнийг аврах арга алга уу?

- Юу ч алга.

Капитан Немо арга ядсандаа нударгаа зангидав. Түүний нүднээс нулимс хэлхээ тасран бөнжигнөж ирлээ.

Хэдэн минутын турш би үхэж буй тэр хүнээс нүд салгаж чадсангүй ээ. Түүний амь нас тонилон одож буй нь харваас илэрхий. Чийдэнгийн зэвүүн цайвар гэрэл түүний цонхигор царайг бүр ч цайлгаж байв.

Зайлшгүй хүнд хүчир амьдрал, үгүйрэл хоосролын улмаас яагаа ч үгүй эрт үрчлээтсэн, түүний ухаалаг царайг би ажиг зогслоо.

Унтарч буй тэр амьдралын нууцыг хөрж буй уруулын нь сүүлчийн нь үгнээс олж мэдэхийг би хичээлээ. Гэтэл капитан Немо надад:

- Таныг би одоо энд барих явдалгүй. Явж болно, эрхэм профессор гэв.

Тэхээр нь явахаас өөр арга олдсонгүй билээ. Капитаныг би талийж буй хүний дэвсгэрийн дэргэд үлдээж, үзэж харсан бүхэндээ сэтгэл ихэд өвдөн өрөөндөө эргэж ирэв.

Өдрнйн турш миний санаанд муу юм бодогдоод амар заяа үзүүлсэнгүй, шөнө нь ч би муу унтлаа. Зүүдэн дунд минь холоо гэгч нь гинших дуун сонсогдож бас гашуудлын аялгуу уянгадах ч шиг боллоо.

Маргааш өглөө нь би үүрээр онгоцны тавцан дээр гарав. Тэр өдөр капитан Немо надаас урьтсан тул тэр тэнд байлаа. Тэгээд тэр над руу ойртон ирээд:

- Эрхэм профессор та өнөөдөр усан доогуур хийх жуулчлалд оролцохыг хүсч байна уу? хэмээн асуухад нь би;

- Миний нөхөд түүнд чинь оролцож болох уу? гэж асуув.

- Хэрэв л тэд дуртай бол бололгүй яахав.

- Таны үгийг баяртай хүлээн авах байнам.

- За тийм бол явж баг өмсдөө гэлээ. Тэр өнөө нас барсан хүний тухай нэг ч үг дуугарсангүй. Би Нед Ленд, Консель хоёр дээр орж капитаны урилгыг тэдэнд дамжуулбал Консель дуртай зөвшөөрч, харин канад хүн энэ удаа татгалзсангүй ээ.

Өглөөний найман цаг болоогүй байв. Найм хагасын үед бид өмсгөлдөө чихэлдэн орж

цахилгаан дэнлүү авч Руквейролийн савууд үүрлээ.

Хоёр хаалга дараагаараа нээгдэж, капитан Немо ба арван хоёр усан цэргийн хамт бид “Наутилус” амарч хэвтсэн далайн чулуулаг ёроолд арван метрийн гүнд буулаа.

Эхлээд төдий л хэвгий бус ёроолын хөрс биднийг доошоо гучаад метр уруудах нилээд гэгц газар хүргэлээ. Бид нэгэн их хонхорт орж очсон нь номхон далайд бидний анхны зугаалга хийсэн ёроолоос эрс ялгавартай байв. Энд далайн доорхи ой, нуга газар, зөөлөн шаргал элс аль аль нь ч байсангүй ээ. Капитан Немо биднийг дагуулан яваа газрын онцлог байдал миний нүдэнд шууд бууж байв. Энэ бол хөндий биетний ертөнц ажээ.

Ургаа амьтдын ангид альционарийн доод анги гэж буй бөгөөд энэ ангид гаргонийн баг гэж байдаг бүлгээ. Энэ багт байгалийн нэн сонирхолтой нэгэн бүтээл, үнэт хөндий биетнүүд багтдагийг эрдэмтэд амьтан, ургамал эрдсийн гурван ертөнцөд дараалан хамааруулж үзсэн билээ. Энэхүү эрт дээр үеийн эмийн зүйл, эдүүгээ манай үеийн эмэгтэйчүүдийн үнэт эдлэлийг зөвхөн 1744 онд Тремблей гэгч Англи хүн амьтны аймагт багтаасан бүлгээ.

Хөндий биетэн буюу шүр биетэн гэдэг бол маш жижиг амьтдын бөөгнөрөл бөгөөд бутрамтгай чулуужсан хөндий бие үүсгэн хуралддаг учиртай. Эдгээр хөндий биетэн үржлийн үүсвэр ор ганц жижиг амьтнаас хуваагдаж үржих замаар цаашдаа олширч бөөгнөрдөг ажээ. Тэдний бөөгнөрөл нийт нэгэн доор нэгэн амиар амьдрах боловч, амьтан тус бүр хувьдаа хувийн амьдралтай бүлгээ.

Би эдгээр сонирхолтой ургаа амьтдын тухай сүүлчийн бүтээлүүдийг уншсан тул далайн гүнд байгаль өөрөө ургуулан, чулуужсан шүрэн моддын ойд явах гэдэг надад нэн сонин байж билээ.

Бид гар чийдэнгээ асааж, тэдгээр шүрэн биет амьтдын босгож буй үе улирах тутам, ирээдүйд Энэтхэгийн гадаад далай Номхон дөлгөөн гадаад далай хоёрыг тусгаарлах хадан хананы дэргэдүүр явав. Зам зуураа бид байсхийгээд л шүрэн моддын шугуйг тойрох хэрэгтэй болдог байв. Тэдгээр мод маягийн ургамал хуурай газрын моддоос зөвхөн хаданд барилдан наалдаж оройгоороо руугаа харснаараа л ялгаварлагдах ажээ.

Тэдгээрийн өнгө булаалдан тодрох мөчүүд дээр тусч буй бидний гар чийдэнгийн гэрэл гайхамшиг сайхан солонгорон сацарч байв. Тэдгээр чулуужсан амьтан усны хөдөлгөөнд надад заримдаа ганхан савлаж буй мэт санагдах бөгөөд заримдаа надад тэдний дөнгөж дэлбэрч эхэлж буй буюу эсхүл сэвсийтэл цэцэглэн алаглаж буй эмзэг нарийхан дохиур, тэмтрүүл бүхий шинэхэн цэцгийг тасдаж авмаар бодогддог

байлаа. Гэтэл баригдашгүй хурдан, бяцхан жараахай, шувуун сүрэг мэт тэдний дэргэдүүр тэдгээрийг хөндөхтэй үгүйтэй, сум шиг шуугин өнгөрөх ажээ. Харин би тэр амьд цэцгүүдийн зүг гараа дөнгөж сарваймагц тэд буй бүх орвонгоороо хөвөлзөн хөдөлдөг бүлгээ. Тэдний цагаан цэцгээс хоромхон зуур хумхин улаан дэлбэндээ нуугдан харсаар байтал өнгө нь гандаж, саяхан цэцэглэн байсан амьд бут чулуужин хатаж хоцордог байв.

Завшаант тэр нэгэн тохиолдол зоофитуудийн хамгийн ховор дүрсийн бөөн дээр оруулчихсан бүлгээ. Тэнд ургасан шүрэн биетний шугуй гуа үзэмжээрээ Африк, Франц, Итали болон газрын дундат далайн эрэг орчноос авч ашигладаг шүрэн биетнээс хол илүү ажээ.

Ховор тохиолдох үнэт шүрэн биетний өнгө үзэмж нь “ГАл улаан цэцэгс”, “Ал улаан хеес» гэсэн гоёмсог нэрэндээ зохицож байв.

Төдөлгүй шүрэн биетний бут олширч. модод нь өндөрсөж эхэллээ. Уран барилгын зөн билэг болсон гудамжилсан нарийхан зурвас бидний өмнө зурайлаа. Капитан Немо үл мэдэг урагш тонгойсон туурга бүхий харанхуй хөндий рүү гүнзгийрэн ороод, бид түүгээр урагшилсаар гүн тийшээ зуун метр явав.

Шүр моддын дунд би бусдаас бага бус сонирхолтой нэгэн дүрс хөндий биетэн, бие махбод нь гүйцэ шохойжсоныг харгалзахгүйгээр, гадаад байдлаараа далайн жинхэнэ замгийг дууриан, шүр биетний ногоон улаан бут хэд хэдийг олж үзлээ. Гэлээ ч гэсэн нэгэн сэтгэгч “шүр биетэн гэдэг” бол хад чулуу мэт унжсан бөх нойроосоо сая сэрж эхлээд арай л хөдөлгөөнөө олж амжаагүй амьдралын тэр хязгаар нь байж магадгүй гэжээ.

Ингээд хоёр цаг илүү явсны дараа бид шүр биетний амьдралын эцсийн гүн буюу барагцаалбал гурван зуун метрийн гүнд орлоо. Энд шүр биетний бөөн цөөн бүлэг мод ургасангүй, харин чулуужсан аврага том моддын бүхэл бүтэн балар шугуй хүглийж байх нь бүх л төрлийн өнгө солонгоруулан, далайн олон өвс плюмарийн гоёмсог гинжүүдээр тордогдсон ажээ. Бид гүн усны зузаан харанхуй өөд сүндэрлэн алга болсон тэдгээрийн өндөр ороодсон доогуур тонгойх зовлонгүй явж ахуйд бидний хөл доор тубилор, астрей, меандрин, фунгий, кариофилийн гоёмсог зөөлөн хивс цэцэглэн байв.

Ямар гоёхон үзэгдэл бэ! Бид өөрсдийн сэтгэгдлийг солилцож болохгүй нь юутай харамсалтай вэ? Тиймэрхүү мартаж хэрхэвч үл болох сайхан цагт чиний толгой шил төмөр, хоёроор хийсэн тэр дуулганд баригдан байх нь ямар гомдолтой вэ! Яахаараа бид, тэрхүү бидний дэргэдүүр сум шиг шунгинан өнгөрч буй загаснуудын нэгэн адил

усанд амьдарч эс чадна вэ? Эсхүл ядахдаа газар ус хоёрын алинд нь ч болбой нь урт удаан цагаар явж чадах хоёр нутагтан шиг биш байна вэ?

Тэгтэл капитан Немо зог тусав. Би ч гэсэн, миний нөхөд ч гэсэн мөн зогслоо.

“Наутилус” -ын далайчид капитаныхаа ард дугуйран зогсохыг би ажиглав.

Би сайтар анхааран харвал тэдгээрийн дөрөв нь ямар нэгэн урт гонзгор юм мөрөн дээрээ авч явахыг сая үзлээ.

Бид тал бүрээсээ шүр моддын ойгоор хүрээлэгдсэн уужим хэмжээний нуга газрын голд зогсоцгоож байв. Бидний барьж явсан гар чийдэн сулхан бүдэг цайвар гэрэл тусгах тул бидний сүүдэр асар томрон доёлзох ажээ.

Тэрхэн нуга газрын захаар бид харанхуй бөгөөд хаа нэгэн газар хааяа хааяа цус мэт улаан гал гялс гээд алга болох нь бидний чийдэнгийн гэрэл ойролцоо байгаа шүр модны голоос ойсон нь тэр ажээ.

Консель, Нед Ленд хоёр миний дэргэд байлаа. Усан доогуурхи бидний тэрхүү жуулчлал ямар нэгэн зорилготой болох нь сая л бидний толгойд орж билээ.

Тэр орчны газрыг шинжин үзвэл далайн ёроол энд тэндгүй л овгор товгор болохыг би олж үзэв. Тэдгээр овгор нэн цэгцтэй зөв хэлбэртэй зохицон байрласан нь хүний гараар хийгдсэн гэдгийг гэрчилж байв.

Тэгтэл ч капитан Немогийн дохиогоор усан цэргүүдийн нэг нь урагшаа гарч бүснээс жоотуугаа тайлан аваад далайн ёроолын хөрсөнд нүх ухаж эхлэв. Тэхэд нь би сая бүхнийг ухааран бүлгээ.

Тэхнээ нь тэр нэгэн нуга бол хүүр оршуулдаг газар, тэнд ухаж буй нүх нь булш, тэдгээрийн үүрч ирсэн гонзгор юм бол өнгөрөгч шөнө нас барсан усан цэргийн хүүр ажээ.

Капитан Немо би түүний нөхөд тэнгисийн тэрхүү ёроолгүй гүнд, ах дүүсийн тэр нэгэн хүүр оршуулах газар өөрсдийнхөө тэр нэгэн нөхрийн ариун шарилыг нутаглуулахаар энд хүрэлцэн иржээ.

Үүнаас урьд өмнө би хэзээ ч тэгж их сэтгэл түгшиж үзээгүй билээ. Миний алаг зүрхийг хэзээ ч, юу ч тэгж их эмгэнүүлээгүй билээ.

Миний нүдний өмнө болж буй тэр бүхнийг би харахыг хэдий үл хүсэвч миний нүд тэр нэгэн эмгэнэлт зүйлээс секунд хэр ч салж чадахгүй байлаа.

Тэр завиар булшны нүх тэнгисийн ёроолд улам бүр л гүнзгийрч бүлгээ. Зээтүүний дохилтонд цочсон загаснууд тал бүр тийшээ бут үсрэн зайлж байв.

Зээтүүний ган үзүүр ёроолын хөрсөнд далд буй чулуунд хангинаж буй бүдэг чимээ надад сонсогдож байв.

Нүх уртаашаа ахиж, өргөөшөө уужирсаар эцсийн эцэст хүн элбэг багтахаар том болов.

Тэгтэл ч шарил авч явсан улс ойртон ирлээ. Цагаан бөсөөр ороосон хүүр ус дүүрэн байсан өнөө нүх рүү гулсан орж явчив.

Капитан Немо, далайчид уул нүхийг хүрээлэн зогсч хоёр гараа алгандаа зөрүүлэн тавьжээ. Тэр нэгэн үйл явдалд гүнээ эмгэнэн, сэтгэл зовсон бид гурав, тэдний ёслолд саад хийхгүйг бодож нэг алхам хойш ухарч билээ.

Дараа нь нүхийг шүр биетний чулуужсан хэсгүүдээр дарж шороог нь дөрвөлжин заслаа.

Тэр бүхнийг гүйцсэний сүүлд капитан Немо ба түүний нөхөд нэг өвдөг дээрээ сөхрөн сууж, нэг гараа гозойлгон ёслоод салахын ёсыг гүйцэтгэв.

Ингээд гашуудлын цуваа “Наутилус”-ын зүг буцах замдаа орох нь тэрээ.

Бид шүр моддын шугуй дотуур дахин алхсаар шүрэн цохионы ёроолд хүрч ирэв. Эндээс ердөө, эгц газар өөд өгссөөр цаг илүү хүнд зам туулсны эцэст “Наутилус” -ын гал алсад гялалзаж харагдав.

Бид түүнийг шууд чиглэн явсаар өдрийн хоёр цагт онгоцондоо эргэн ирлээ.

Саяхан шаналж өнгөрөөсөн эмгэнэлт ёслолын үед төрсөн уйтгарт бодлын эрхэнд би хувцсаа дөнгөж солимогц л онгоцны тавцан дээр бушуухан гарахыг яаравчлав.

Тэгтэл ч капитан Немо над дээр хүрч ирэв.

- Тэр хүн хөөрхий, миний хэлснээр урьд шөнө л нас барчив аа даа?

- Тэгсээн эрхэм профессор минь.

- Тэхээрээ тэр одоо усан доорхи хүүр оршуулах газар, өөрийн олон нөхдийн хамт сэршгүй бөх нойроор амгалан нойрсож байгаа нь тэр үү?

- Тиймээ, тэр тэнд биднээс бусдад таг мартагдан нам унтжээ гэж капитан Немо хэлчихээд хоёр гараараа нүүрээ даран, уйлахгүйг оролдсон боловч тус болсонгүй ээ.

Тэгээд тэр нилээд дуугүй байснаа:

- Тэнд усны ёроолгүй гүнд, бидний нутаглах газар байдаг юм даа гэв.

- Тэнд танай талийгаач бологсод аврага загасны амнаас хол, амгалан нойрсдог байх нь ээ?

- Тиймээ, аврага загас ч тэр, хүн ч тэр аль алин нь ч хүрч тэнд үл чадна гэж капитан Немо бүдэг хоолойгоор хариулж бүлгээ.

---

## ЭНЭТХЭГИЙН ГАДААД ДАЛАЙ

Усан доогуурхи манай жуулчлалын хоёрдугаар хэсэг эндээс эхэлнэ. Бидний аяллын эхний хэсэг миний сэтгэлийг тэгж их хөдөлгөж надад төдий их хүчтэй сэтгэгдэл төрүүлсэн тэр нэг зүрх догдлом зүйлээр төгсгөл болсон билээ.

Капитан Немогийн бүх амьдрал зах хязгааргүй тэр уудам тэнгис далайн хязгаарт тиймэрхүүгээр л өнгөрч байснаар барахгүй тэрхүү их тэнгис далайнуудынхаа хамгийн далд эрдэнийн санд өөрөө өөртөө булш зэхсэн ажээ.

Тэнд, далайн тэрхүү хөлгүй гүнд этгээд сонин капитаны амь насаараа үүрд бат уялдсан найз нөхөд буюу “Наутилус” онгоцондоо амьдрагсдын хамгийн эцсийн амгаланг далайн ямар ч гайхал амьтан хөндөж үл чаднаа. Капитан Немогийн хэлснээр тэд тэнд далайн гайхлууд болон “хүмүүс” хүрч үл чадах гүнд нойрсож буй ажээ.

Үргэлж л тэнд хүн нийгэмд үл итгэж, хувиршгүй гөжүүд зуршил ноёрхоно!

Энэ хэр Конселийн маань хөгжөөсөн таамаглал миний сэтгэлд нийцэхийг больжээ.

Энэхүү бэрх хөвүүний нотолноор бол капитан Немо өөрийн зүг анхаарал хандлага олоогүйн улмаас үзэн ядах үзлийн хороор ертөнцийн ачийг хариулж буй эрдэмтэн байлаа. “Наутилус” онгоцны капитан бол эрдэмтдийн элэг доог болсон агуу их эрдэмтэн хүн бөгөөд нийгмийн амарлингуй мохоо мөчид байдалтай тэнцэж ядаад, арга барахдаа хүмүүс хүрч үл чадах далайн тэрхүү орчинд эрх дураар амьдрахаар үүрд шингэсэн хүн гэж заримдаа Консель дүгнэдэг байв. Гэвч миний бодлоор бол Конселийн тэр таамаглал капитан Немогийгн чухам үнэн байдлыг харуулж чадахгүй байлаа.

Үнэндээ ч биднийг шоронд хорьсон, бидний хоолонд нойрны эм хольсон, бас капитан Немо намайг алсын бараа харчихаас өмнө миний гараас дурангаа яаравчлан булааж авсан түүнчлэн “Наутилус” ямар нэгэн юмтай мөргөлдсөний улмаас л шалтгаалж түүний усан цэргийн нэг нь үхлийн шарх олсон зэрэг тэр нэгэн шөнийн этгээд нууц явдал мань Конселийн дээрх тааврыг няцааж байв. Үгүй ээ капитан Немо хүмүүсийн дундаас зөвхөн зугтсан явдлаар энэ бүхэн тайл- барлагдахгүй ээ. Түүний агуу бүтээл-усан доогуур явагч хөлөг онгоц капитан эрх чөлөөг юу ч үл боогдуулах далайн энэ орчинд зөвхөн түүний толгой хоргодох орон болсноор зогсоогүй, магад ч үгүй аймшигт өс хонзонгийн зэвсэг ч болдог байж.



Гэвч би энэхүү таамаглалынхаа зөв бурууг батлах ямар нэгэн баримтгүй байв. Энэ таамаглал зөвхөн л намайг хүрээлэн буй учир нь үл ойлгогдох над харанхуйн дунд миний баримжаалах од болон ёлтойж байлаа. Тийм ч учраас энэ талаар ярихыг түр зогсож, ганцхан л хэрэв үйл явдлын явцын дагуу гэж хэлж болбол замынхаа тэмдэглэлийг үргэлжлүүлэн хөтөлье.

Жич хэлэхэд капитан Немо бид нар уулзаагүй удлаа. Биднийг “Наутилус” дээрээс оргож чадахгүйг тэр мэдэж байв. Тийм ч учраас тэр онгоцон дээрээс оргож болохгүй гэсэн бидний амлалтыг аваагүй билээ. Гэвч биднийг хавчиж хяссан зүйл үгүй бүлгээ. Бид аргагүй л найр тавихын эрхэнд зочид хэмээн нэрлэгдсэн жирийн нэгэн олзлогдогсод байв. Нед Ленд энэ хэр эрх чөлөөгөө олж авах итгэл найдвараа мөн л орхихгүй байлаа. Тэр эндээс хамгийн анхны завшааныг ашиглан оргож чадна гэдэгтээ бат итгэж бүлгээ. Бодвол би ч гэсэн түүний хойноос дагалдах даг аа. Гэлээ ч гэсэн би капитан Немогийн сайхан санааны буянгаар танилцах боломжийг олсон усан доорхи ертөнцийн гайхамшгаас сэтгэл гуниггүйгээр салж чадахгүй буйзаа.

Тэр хүн ингэхэд ер нь яргачин уу, аль эсхүл бусдын золиос болсон хүн үү, би түүнийг үзэн ядвал зохих уу, эсхүл түүний өмнө бишрэн сөгдвөл таарах уу, одоо хүртэл надад энэ бүхий ойлгогдохгүй байв. Үнэнийг хэлэхэд би “Наутилус”-аас нэгмөсөн салахаасаа өмнө, гайхамшигтай сайхан эхэлсэн дэлхий тойрох энэ аяллыг дуусгахыг хүсэхсэн бүлгээ.

Тэнгисийн гүн ёроолд нуугдаж байгаа бүх гайхамшигийг бүгдийг би үзэх юмсан. Надаас өмнө нэг ч хүн амьтан үзэж хараагүй тэр бүхнийг үзэх миний ханашгүй их хүсэл амь насанд минь хамаатай ч байлаа гэсэн хамаагүй. Би эдүүгээ хүртэл юу гэж үзэж мэдээв. Бид Номхон далайгаар дөнгөж зургаан мянган бээр явсан учир би юу ч үзээгүй буюу бараг юу ч үзээгүй байна.

Түүний зэрэгцээгээр “Наутилус” маань хүн амьтан оршин суудаг газарт ойртон ирж байлаа. Хэрвээ бидэнд оргох зайлах ямар нэгэн бололцоо алдах юм бол би тэр бүхнийг мэдэх үзэх амин хувийнхаа хүслийг хангахын тул хань нөхрийнхөө сонирхлоос уравсан бузар хэрэг болох бөгөөд тэр явдалдаа би өөрөө өөрийгөө хэзээ ч өршөөхгүйсэн гэдгийг их сайн мэдэж байлаа. Би тэднийг дагах ёстой, магадгүй тэднийг дагуулах ч байж болох юм. Үгүй ер нь хэзээ нэгэн цагт оргох бололцоо гарах бол уу? Бусдын хүчээр эрх чөлөөгүй болсон энгийн нэг хүн бол үүнийг хүсэн мөрөөдөх боловч, ингэж оргож зайлах бололцоо олдох бий гэхээс эрдэмтэн хүн айх ажээ.

Энэ өдөр, нэгдүгээр сарын 22-т үд дундын хэрд капитаны туслах ердийнхөө

заншлаар ажиглалт хийхээр онгоцны тавцан дээр гарч ирэв. Би ч гэсэн мөн дээшээ гарч сигар уугиулан зогсохдоо түүнийг ажиглан байлаа. Энэ хүн францаар ярьдаггүй гэдэгт би үл эргэлзэж билээ. Учир нь миний үгийг ойлгосны ямар нэгэн гэнэн тэмдэг тэрнээс гаргуулчихыг оролдож, би түүнийг дандаа л франц үгээр өдөж шүүмжилж байдагсаан. Гэвч тэр үргэлж л ажрах ч шинжгүй, таг дуугүй байх ажээ.

Түүнийг нүдэндээ секстант барьж нарны хазайлтын өндрийг олж байх үед “Наутилус» Креспо арлын ойд ав хийхэд биднийг даргалж явсан өнөө мангар далайч онгоцны тавцан дээр гарч ирээд цахилгаан гэрэлтүүлгийл шил арчиж эхлэв.

Гэрлийн нь хүчин сэвэг сармай маягийн цагирагласан шилний хүчээр, нэгэн багц болон цацран, хэдэн зуу дахин өсдөг тэрхүү гэрэлтүүлэгч багажыг нэн сонирхон үзлээ. Түүний гэрэлд үүсгэх хүч хамгийн дээд хэмжээндээ хүрч гийхээр зохиогдсон ажээ. Тэр багажийн цахилгаан хөвч агааргүй хоосон орчинд бадрах тул цахилгаан хөвчийг бий болгож буй балын хурц үзүүрт арвитайгаас гадна, жигд улайсах чанартай ажээ. Тэрхүү багажийн цахилгаан хөвч үүсгэгч хоёр туйлын бал чулууг арвилах гэдэг капитан Немод нэн чухал зүйл бөгөөд тэр чулууг шинээр нөхөн олно гэдэг тийм ч амар биш хэрэг буйзаа. Тэгтэл агааргүй хоосон орчинд тэрхүү бал чулууны хурц үзүүр нэн удаан шатаж барагддаг учиртай.

“Наутилус” живж орохоор бэлдэх үед, ой үзэсгэлэн танхимд эргэж ирлээ. Онгоцны доод таг ч хаагдлаа. Бид зуун метр гүнд шумбан орж шууд баруун зүгийг барин одов. Ингээд бид таван зуун тавин сая гектар хавтгай дөрвөлжин, асар өргөн талбайг эзлэн буй Энэтхэгийн гадаад далайд зорчин орлоо. Энэ далайн ус нэн тунгалаг учир онгоцны тавцан дээрээс уруугаа харахад дорой биетэй хүний толгой эргэх ажээ.

“Наутилус” хэвийн байдлаар зуугаас хоёр зуун метрийн гүнд явж байв. Иймэрхүү байдалтай хэд хонолоо. Надаас өөр хэн нэгэн хүн ийнхүү аялж агсан бол энэхүү жуулчлалын уйтгартай бөгөөд нэг янзтайд янгуучлахсан буйзаа. Гэвч онгоцны тавцан дээр гарч өглөө бүр давс шүү амтагдсан сэрүүн салхинд зугаалах зугаалга, үзэсгэлэнгийн гэгээвчээр үзэх далайн ёроолын гайхамшиг, капитаны номын арвин санд ном унших уншлага өдөр бүр үйлдэх тэмдэглэл энэ бүхэн миний хамаг цагийг эзэлж нэг ч минут залхуу хүргэдэггүй, уйтгарлуулдаггүйсэн билээ.

Нед Ленд, Консель бид гурвын бие эв эрүүл байлаа. “Наутилус”-ын хооллох зарчим ерөнхийдөө бидний сэтгэлд нийцэх боловч канадын харъяатыг гомтгохоос би айж түүний ямар нэгэн аргаар олж хоолны хольцонд нэмэрлэн буй эх газрын элдэв төрлийн хүнснээс татгалзах дургүй агсан.

Түүнчлэн бид бүхнийг хүрээлэн буй халуун хүйтний тогтмол нэг хэвийн байдалд ядаж

хамрын ханиад хүрэх учиргүй бөгөөд хэрвээ хүрдэг юм гэхэд “Наутилус”-ын эмийн санд ханиад томууг тун сайн анагааж чаддаг “Правансэ” хэмээх газар “далайн ...” гэж нэрлэгдсэн мод маягийн шүр биетнээр бэлдсэн нунтаг эмийн нөөц бишгүй л бий бүлгээ.

Би хэд хэдэн өдөр өглөөгүүр онгоцны тавцан дээр гарч усчин шувууд олныг үзэж гайхаж бахадсаны дотроос ялангуяа цахлай, поморник хоёроос олныг үзэж хөхив. “Наутилус”-ын баг тэдгээрийг агнаж авчран, зохих ёсоор эдэлснийг үзвэл тэдгээр усчин шувууд амттай болохыг сая мэдлээ. Эрэг газраас алслан нисч, далайн давалгаан дээр сууж бие амрах том шувуудын дотроос гуурс хамартны багт харъяалагдах гуалиг сайхан альбатросууд анхаарал татаж байв Усан дээр ойрхон явсан ялаа барьж иддэг хурдан жигүүрт фрегатууд ба тагтаан чинээ биетэй олон тооны фаэтонууд, далавчаа дөнгөж эмжсэн ягаан судалтайдаа бүр тас хар мэт үзэгдэх цагаан плюмаж зэргээр эндхийн сэлүүр хөлөгний язгуур бүрэлдсэн ажээ.

“Наутилус”-ын орхисон торонд өдөр бүр л улам шинэ дүрсийн яст мэлхий орж ирэхийг үзвэл худалдахад өндөр үнэ хүрдэг, бөмбөгөр, тал дугуй эвэр хуяг бүхий бессу буюу сүйх тэрэг хэмээн алдаршсан сонирхолтой яст мэлхий нэгийг тэмдэглэж болно. Эдгээр яст мэлхий хамрынхаа нүх сүвгийг махлаг тагаар бөглөж орхиод усан доор маш удаан байж чадах ажээ. Эдгээр зөөлөн биетний зарим нь далайн араатнаас биеэ хамгаалсан хуягандаа нуугдан унтаж байх завсраа баригдсан бүлгээ. Эдгээр амьтны мах нь гутамшиг боловч өндөг нь олдошгүй амтат зууш больюу.

Үзэсгэлэнт танхимын гэгээвчээр биднийг харахад хэзээд бидний сэтгэлийг хөхөөн байдаг загасны талаар ч хэлэх юм алга. Энд би урьд өмнө хэзээ ч олж үзээгүй хэд хэдэн дүрсийн загасыг олж үзлээ.

Юуны өмнө Улаан далайд ихэвчлэн байдаг, ялангуяа Улаан далайд, Энэтхэгийн гадаад далай, төв Америкийн эрэг орчимд орших тэвшин загасыг дурьдчихъя. Эдгээр загас далайн зараа, хавч, хавч хэлбэртэн яст мэлхийнүүд шиг шохойлог буюу цахиурлаг хуягаар хамгаалагдаагүй, харин нэг нэгтэйгээ харилцан үргэлж. яслас бөх бүрхүүлтэй юм. Тэвшин хэлбэрт загасны бие уян хатан бус, хатуу ирмэгт, гурав дөрөв буюу таван талт хайрцаг маягийн хуягтай байна. Бидэнтэй, мах нь нэн амттай ясжсан хуяг бүхий болон том хар нүдэн дээрээ эвэр маягийн урт өргөс ёрдойлгосон, үүний улмаас эвэрт загас хэмээн нэрлэгдэх дөрвөлжилсэн хуягт тэвшин хэлбэрт загаснууд тохиолдож байлаа.

Түүнээс гадна хурц өргөс бүхий уртаас урт ташуур мэт сүүлтэй өргөслөг скатуудыг

нэрлэж болно. Тэр сүүлээрээ хүний амь насанд ч аюул учруулж болохоор гуялдаг юм.

Конселийн хөтөлж байсан тэмдэглэлд бас хэд хэдэн дүрсийн загас тэмдэглэгдсэнийг үзвэл: Номхон далайд бид олж үзсэн өргөс гэдэстэн, урт хоншоорт скатууд, өргөс хайрсгүй цахилгаан скатууд, өргөөшөө нэг метр уртаашаа метр хагас, нуруундаа гантигийн өнгөт тунгалаг толботой хүрэвтэр өнгийн цахилгаан скатууд зэрэг байв.

Өөр дүрсийн загаснаас өндөг маягийн сүүлгүй загас, хамаг бие нь буйгаараа арзайсан өргөс бүхий хий дүүрсэн бөмбөг мэт түнхийдэг цагаан хосолсон бүрэг хүрнээс бараг хар өнгөтэй судалтай, аалзтай төстэй хоёр шүдэт загас, бусад тэнгисүүдэд байдгийн нэгэн адил дүрсийн марин загас, цээжиндээ далайч мэт өргөн хавтгай сэлүүртэй болж ирээд урагшаа шонтойж унжирсан нилээд урт хоншоортой пегас хамээх бяцхан загас гүн цэнхэр толбо ба судас бүхий шар өнгийн лир загас болон бусад олон загасыг тэмдэглэж болно. Тэдгээрийн мах нь цэвцгэр цагаан, нэн амттай билээ.

Бид бас хар хөх далбаат загастай учирсан бөгөөд тэр загас өөрийнхөө нүсэр том сэлүүрийг салхинаа дэлгэх хөлгийн далбаа мэт хэрэглэж чаддаг билээ. Түүнчлэн нэн урт нарийхаи биетэй, эр нь мөнгөлөг цагаан өнгө бүхий ердийн хялгас сүүлийн тэр байтугай Ремингтон болон зэвсэг үйлдвэрлэгч фабрикийн бусад эзэн бодож олоогүй, усны дуслаар цэнглэж хорхой шавьж нэн цэцэн буудаж алдаг этгээд буугаар зэвсэглэсэн ялаа нядлягч хэмээх загас олж үзлээ.

“Наутилус” нэгдүгээр сарын 21-23 хүртэл хоногт тавин дөрвөн миль давхив. Өөрөөр хэлбэл цагт бид хорин хоёр хагас миль явж байжээ. Бид зөвхөн л манай цахилгаан дэнгийн гэрэлд автагдаж, биднээс үл холдохыг эрмэлзэж хурдлагч загасыг л харж амжиж байв. Гэвч тэдгээрийн ихэнх нь тэр даруйхандаа хол хаягдах тул тэдний цөөн хэсэг нь бидэнтэй зуузай холбохыг оролдож байлаа.

Хорин дөрөвний өглөө бол уртрагийн 94 хоног 33 хувь, өмнөт өргөргийн 12 хоног 5 хувьд орших киллинга арлын бараа харав. Тэр шүрэн арал самрын дал модоор хучигджээ. Дээр үед тэр арап дээр Чарльз Дарвин, капитан Фиц - Рой нар очиж байжээ. Тэрхүү хүнгүй арлын эргийн дэргэдэх нуур “Наутилус” явж өнгөрлөө. Бидний тор олон янзын хөндий, биетэн, мөн түүнчлэн хэд хэдэн бяцхан далайн гахай, шүрдсэнээс сонирхолтой хэд нь капитан Немогийн цуглуулганд байраа одлсон билээ.

Төдөлгүй Килинга арал далд орж “Наутилус” Энэтхэгийн хагас арлын хамгийн урьд үзүүрийг чиглэн баруун хойшоо хөвж одлоо.

- Бид боловсронгуй орнуудад ойртож байх шив хэмээн Нед Ленд энэ өдөр надад хэлээд энэ ч ан гөрөөс байхаасаа зэрлэгүүд байх нь их шинэ Гвинейн арлуудаас арай дээрсэн. Энэтхэгт чинь Англи, Франц, Энэтхэгийн засмал, төмөр, элдэв зам, хот тосгон бишгүй л бий биш үү эрхэм профессор гуай. Тэнд ч алхам бүрдээ л нутгийнхаа хүнтэй учирч болно. Капитан Немотой салахын ёсыг гүйцэтгэх цаг ирсэн юм биш биз, та юу гэж бодож байна? гэж асуулаа.

- Болоогүй ээ! Болоогүй! хэмээн би эрс татгалзан хариулаад, - “Наутилус” ч хүнтэй газар руу ойртож л байна. Тэр байтугай Европ орж явна биш үү. Яахав биднийг Европ хүргээд орхиг. Тэр цагт л бид оргох тухайгаа бодож болно. Жич хэлэхэд капитан Немо биднийг Гвебороар арап дээр явуулсан шигээ л малабьярын буюу короманделийн эрэгт ан хийлгэхээр тийм ч дуртай зөвшөөрөхгүйдэг ээ гэж би бодож байнам гэв.

- Тэгвэл, түүнээс зөвшөөрөл авахгүй явчих гэж нэг сайхан юм байхгүй юу гэж канад хүн хэлэхэд би түүнд хариу дуугарсангүй. Тэдэнтэй би маргалдах дур хүрсэнгүй билээ.

Гэвч намайг усан доогуур явагч хөлөг онгоцон дээр хаясан зуурдын тохиолдлыг аль болохоор үртэй ашиглах бололцоог хангах бүх л боломжийг эцэст нь хүртэл шавхахаар цаанаа би эрс шийдэж байж билээ.

Килинга арлыг өнгөрмөгц “Наутилус” нэн их удааширч ирлээ. Бид байсхийгээд л далайн маш их гүнд шумбаж орох болов. Бид, хоёр буюу заримдаа гурван километрийн гүнд орох боловч Энэтхэгийн далайн эцсийн гүнийг хэмжсэнгүй бөгөөд далайн гүнийг хэмжих баганыг арван гурван километр доор оруулсан ч ёроолд нь хүрдэггүй бүлгээ.

Эндхийн усны доорхи давхаргуудын халуун хүйтэн Номхон тэнгисийнхтэй нэгэн адил тэгээс дээш дөрвөн градус заах ажээ. Би зөвхөн л гүехэн газрын ус гүнзгий газрынхаас үргэлж бага байхыг ажиж авав.

Нэгдүгээр сарын 25 - нд тэнгисийн гадаргуу эл хуль, хов хоосон байж, “Наутилус” түүний толь мэт өнгөн дээгүүр гулгах мэт хөвж, өөрийн хүчирхэг сэнсээр усыг хутга мэт зүсэн, усан оргил сацруулын өндөрт хөвж явлаа. “Наутилус”- ыг алсаас харсан онгоц, асар том аврага халим гэж эндүүрдэг нь гайхалтай бишээ.

Би энэ өдрийг онгоцны тавцан дээр алсыг ширтэн зогсож өнгөрлөө. Зөвхөн, өдрийн дөрвөн цагийн үед л баруун тийшээ явж байсан усан онгоц алсад харагдав. Түүний шураг мод далайн төвшин дээр хэдэн минут хэр тод ялгаран харагдсан боловч уснаас дөнгөж цухуйж буй “Наутилус”-ыг тэр онгоцон дээрээс харахын аргагүй байв.

Би тэр онгоцыг галт онгоцны хагас арлын ба дорнот нийгэмлэгт харъяалагддаг Мельбурн болон Георг хааны хушууг дайран Цейлон -Сиднейн замд явдаг тээврийн онгоц гэж бодлоо.

Өдрийн таван цагийн үед, халуун орны ахар богино үдшийн бүрий буухаас арай өмнөхөн, Консель бид хоёр гайхамшигт нэгэн үзэгдлийн гэрч болсон билээ.

Ингэхэд зөөлөн биет, гайхамшиг нэгэн амьтан байдаг бүлгээ. Эртний домог яриагаар бол түүнтэй учрах гэдэг сайн сайхны бэлэг тэмдэг билээ. Аристотель, Антей, Плиний нар түүний авир зан, төрх байдал, амт зэргийг судалж эртний Грек Римийн шилдэг шүлэгчид түүнийг аялан дуулахад хүч хөдөлмөр хайрлаагүй юм. Тэд түүнийг “Наутилус” буюу “Помтилус” хэмээн нэрлэжээ. Орчин үеийн шинжлэх ухаанд бол тэр нэгэн зөөлөн биетэн “Аргонавт” гэсэн нэрээр алдаршсан бүлгээ.

Бид, далайн уснаа ил хөвж буй тэдгээр аргонавтын бүхэл сүрэгтэй дайралдсан билээ. Тэд хэдэн зуугаараа байв. Тэдгээр эвлэгхэн биетэй зөөлөн биет амьтан амьсгалахдаа биедээ дотогш татаж авсан усаа тусгай сүвээр гадагш тургиж бөгсөөрөө урагшаа явдаг ажээ. Түүний бүгд найман – тэмтрүүл урт нарийхан хөлний зургаа нь усан дээр ил хөвж, үлдсэн хоёр “гектокотили” хэмээн нэрлэгдэх нумлаж хөвчилсөн, сарьслаг хөл нь хөлгийн далбаа мэт салхинаа тавигдсан байдаг юм.

Дээр үед тэр нэгэн цагт, Кювье бяцхан гоёмсог хөлөгтэй зөв зүйрлэн дүрсэлсэн, түүний мушгиа хэлбэртэй хөөрхөн дунг усан дотор би олж ил харав. Үнэндээ ч тэр дун бяцхан завьтай тун адилхан ажээ. Шохойн давслаг тундсаар аргонавт өөрөө “шавж хийсэн” тэр нэгэн бяцхан завинд уул зөөлөн биетэн ургаж барьцалдаагүй ч гэсэн, тэр завь түүнийг хаяж гээгдүүлэхгүйгээр үргэлж тээдэг байна.

- Аргонавт хэзээ бол хэзээ, энэ завиа хаячихаж болох боловч тэгдэггүй гээч гэж би Консельд хэлэв:

- Яг капитан Немо шиг гээч хэмээн Консель хэлээд- Тэхлээр капитан өөрийнхөө хөлгийг капитан “Аргонавт” гэж нэрлэвэл таарах байсан юм гэв.

Бараг бүтэн цагийн турш тэдгээр аргонавт, «Наутилус» бараа болж явтал гэв гэнэт хаанаас юм бүү мэд тэд сандралдлаа. Тэд бүгд нэг л командаар юм шиг далбаагаа нэгэн зэрэг хумхиж, урагш тавьсан тэмтрүүлүүдээ татаж аваад, биеэ цомтгон, завинуудад хүндийнхээ төвийг шилжүүлмэгц нүд ирмэхийн зуур усан доогуур бүгд алга болж одов.

Далайн цэргийн олон хөлөг онгоц иймэрхүү хэцүү дадлагыг хэзээ ч ингэж жигд нэгэн зэрэг үйлдэж байгаагүй бизээ. Энэ хэр нар шннгэж, бараг л яг тэр минутанд шөнө боллоо. Зөөлөн салхинд эржийсэн долгио “Наутилус”-ыг аяархан халбилзуулан байв.

Маргааш өдөр нь нэгдүгээр сарын 26-нд бид наян хоёр дахь уртраг тушаа, экваторыг хөндлөн огтолж дэлхийн бөмбөрцгийн умарт хагасын уснаа хөвж орлоо.

Энэ өдөр биднийг аврага загасны их сүрэг дагалдсан билээ. Эдгээр нь арван нэгэн давхар эгнээ шүдтэй, цагаан гэдэс, хүрэн нуруу бүхий болон хүзүүндээ нүдтэй адилхан гадуураа цагаан цагирагтай том хар толбо бүхий гөлгөр биет хар цоохор, мохоо хоншоор бүхий өргөс сэлүүрт аврага загаснууд байв.

Тэдгээр аврага араатан үзэсгэлэн танхимын гэгээвч рүү хэдэн удаа аймшигтай улайран дайрав. Тийм минутанд Нед Ленд уурсан догширч учраа алдаж байв. Тэр эдгээр гайхлыг усны гадаргуу дээр байж, ялангуяа цонхны шил руу салахгүй дайрч буй таван метр урт бар хэмээх аврага загасыг агная гэхээс байж ядаж билээ.

Гэтэл төдөлгүй, “Наутилус” хурдаа нэмэн хамгийн хурдан аврага загасыг боловч хараа бараагүй хол хаялаа.

Нэгдүгээр сарын хорин долоонд бид Бенгалийн буланд орох үед усан дээр хөвж яваа хэд хэдэн хүний хүүртэй дайралдав. Юун булай юм бэ? Тэр бол үхэгсдийн хүүрийг үгүй хийж идэж дуусгадаг элээ сэглэж арай дуусаагүй, Энэтхэг газрын оршин суугчдын хүүр байв. Ганга мөрний урсгал, тэднийг задгай далайд урсган аваачиж, элээ тоншиж дуусаагүй үлдсэн сэгий нь аврага загас идэж бардаг ажээ.

Оройн долоон цагийн орчимд «Наутилус» усан дээр хөвөн ил гарч сүү мэт цав цагаан долгион дээгүүр гулсаж байв.

Сарны гэрлээс болж, тийнхүү цайсан юм болов уу? үгүй ээ, тийм байх ёсгүй. Шинэлээд дөнгөж хоёрхон хонож буй идэрхэн сар энэ хэр арай гараагүй, харин дөнгөж сая жаргасан нарны туяа тэнгэрийн хаяанд харваж, сүү шиг цагаан далайн дэргэд сүүдэр шиг бараантан харагдаж билээ.

Тэр нэгэн нүд булаам сонихон үзэгдлийг өөрийн нүдээр харсан Консель гав гайхаж үзсэндээ үл итгэх ажээ.

Тэр, чухам юу болж байгааг тайлбарлахыг хүсч над руу хандав. Аз дайрахад би түүний сонирхлыг татах хүслий нь хангаж чадах байлаа.

- Энэ бал сүүн далай гээч байгаа юм хэмээн би түүнд өгүүлж – иймэрхүү асар том хэмжээний цав цагаан толбо, далай дээр тусах явдал, Энэтхэгийн эрэг хавьд ч ховор хэрэг биш гэлээ.

- Тэгвэл, далай чухам яахаараа иймэрхүү сүү мэт цав цайдгийг эзэнтэн над хэлчихгүй юу? Далайн ус арай сүү болчоогүй л байлтай даа? гэж Консель асуув.

- Үгүй байлгүй яахав хонгор минь. Чамайг ийнхүү гайхуулж буй усны сүү шиг цагаан өнгө бол уртаараа миллиметрийн тавны нэг хэр хэмжээтэй. Ус үс мэт нарийн

өнгөгүй тунгалаг, гялалзаж цайрах маш бяцхан бүдүүлэг нялцгай амьтдаас болсон хэрэг. Тэдгээр бяцхан бүдүүлэг амьтад хоормог мэт холилдон, заримдаа олон олон километр хол үргэлжлэн их талбар эзэлдэг юм.

- Олон олон километр ий? гэж Консель дуун алдав.

- Тиймээ, найз минь. Хичнээн километр болдгий нь хэмжих гэж л бүү оролдоорой. Тэртэй тэргүй чи давахгүй хэрэг. Хэрэв би эндүүрээгүй бол зарим далайчдын яриагаар, сүүн далайгаар тэд дөчөөс тавь хүртэл миль газар аялж байсан гэдэг!

Гэвч, миний үгийг харгалзахгүйгээр Консель тэрхүү үснээс бүдүүнгүй, өчүүхэн амьтан дөчин миль шоо дөрвөлжинд хэд хичнээн багтахыг нь чээжээрээ бодох гэж мунгинан оролдов.

Хэд хэдэн цагийн турш "Наутилус" сүүн далайн цайвар усыг хурц хушуугаараа зүсэн зүсэн урагшлахад нь би савангийн өтгөн хөөсөн дундуур гулгах мэт ямар ч чимээгүй явахыг нь ажиж билээ.

Шөнө дөлийн үед далайн ус жирийнхээ өнгийг олж бараантан харласан боловч хойно үлдсэн сүүн далайн цайвар ус тэнгэрийн мандалд харваж туяаран байх нь умарт туйлын туяа адил гэрэл сацарсан байв,

[Тор](#)

---

## КАПИТАН НЕМОГИЙН БАС НЭГ САНАЛ

Нэгдүгээр сарын хорин наймнаа үд дундын хэрд "Наутилус" умарт өргөргийн 9 дэх хоног 4 хувьд усан дээр хөвж гарвал биднээс баруунтай найман миль газар ямар нэгэн хуурай газар харагдлаа. Миний нүдэнд юуны өмнө жигтэй сонихон овооролдон тогтсон хадтай нилээд өндөр уул үзэгдсэний зарим нь далайн төвшнээс дээш хоёр мянга илүү фут өндөр ажээ. Үд дундын ажиглалт хийгдсэний дараа би үзэсгэлэн танхимд бууж очоод зураг дээр тэмдэглэснийг нь үзвэл бид сувд эрдэнийн орон болсон Энэтхэг газрын "Сингааль" арлын эрэг орчимд байгаа юм санжээ. Тэр даруй би тэрхүү үржил шимт хөрс бүхий арлын тухай ном эрэхээр номын санд орж Х. К. Сиррагийн бүтээл "Сингааль" орон ба "сингаальчууд" гэдэг ном олж авав. Энэ үеэр капитан Немо туслахын хамт орж ирлээ. Капитан хэсэг зуур зураг дээр харж байгаад дараа нь над руу эргэж:



-Сингааль арлынхан сувд шүүрддэгээрээ цуутай юм шүү. Эрхэм профессор та сувд түүдэг тэр газар очихыг хүсэх үү? гэлээ.

-Дуртайяа очихсон байнам.

Их сайн. Түүнээс хялбархан юм гэж юу байхав. Гагцхүү бид сувд түүдэг газры нь үзэхээс биш, сувд түүдэг улсы нь үзэхгүй шүү. Одоо сувд түүх улирал нь арай болоогүй. Гэвч тэр сонин биш, одоохон би манаарын булан чиглэх тушаал өгөөд орхиё. Бид тэнд зөвхөн шөнөдөө л явж хүрэх бий гэв .

Капитан өнөө үл мэдэгдэх хэлээрээ туслахдаа хэдэн үг хэлмэгц, тэр үзэсгэлэн тянхимаас яаравчлан гарч одлоо. Мөн тэрхэн даруй "Наутилус"-ын даралт хэмжих багажны заалтыг харж байвал гучин футийн гүнд живж оров.

Би газрын зургийг гартаа авч манаарын буланг эрж эхэлбэл тэр булан мөн өөртэйгөө нэгэн адил нэртэй жижигхэн арлын дэргэд, умарт өргөргийн 9 дэх хоног; Сингааль тивийн баруун хойт эрэгт байв. Капитан Немо дахин цааш ярьсан нь:

- Эрхам Аронакс минь хэмээн тэр эхлэн хэлээд сувд эрдэний? Бенгалийн булан, Энэтхэг хятадын далай, Америкийн урд эргийг угааж буй ус, Панамын ба Камифорын булангаас түүдаг юм. Бидний аз дутахад бид энд арай эрт ирчихэж. Сувд түүгчид энэ манаарын буланд гуравдугаар сарын дунд хэрээс оройтохгүй ирдэг тул тэр үеэр энд гурван зуугаас доошгүй хөлөг онгоц цугларч тэрхүү нэн их ашиг олз бүхий зүйлийг эрж гучин хоногийн турш ажилладаг билээ. Тэр үед онгоц тус бүр арав, арван сэлүүрчтэй, арав арван шумбагчтай байдаг. Далайн гүнд тэр арван хүн хоёр баг болж усанд ээлжлэн ордог юм. Тэд хөлийнхөө хооронд хүнд чулуу хавчиж доош орж хүрэх гэсэн гүнדהа хүрмэгц чулуугаа орхидог билээ. Дараа нь өөртөө оосортой өнөө чулууг нь сэлүүрчид дээш нь татаж гаргах ажээ.

- Тэгтэл тэр бүдүүлэг арга нь одоо хүртэл хэвээрээ байх нь ээ?

- Хэвээрээ. Энд өөрчлөгдсөн юм ер үгүй хэмээн капитан Немо хариулахдаа- Сувд эрдэнийн энэ их сан хэдийгээр алсын гэгээгээр, аль хаа байсан 1802 оноос эхлэн дэлхий дээр хүнд үйлдвэрийн хамгийн тэргүүний орой болох Английн өмч болж эхэлсэн боловч сувд авах арга туршлага нь яг л хуучин янзаараа гээч гэж хэлэв.

- Миний бодлоор бол ямар ч гэсэн, таны тэр өмсгөл шиг тийм нэг баг, энэ ажиллагаанд тун их ашиг болохсон байнам.

- Тэгэлгүй яахав. Үгүй ээ. Энэ чинь тэр хөөрхий шумбагчдын усан доор байх хугацаа нэн хязгаартай гэдэг нь мэдээж хэрэг шүү дээ. Жишээлбэл, Персиваль гэгч Англи хүн, өөрийнхөө тэмдэглэлд бичихдээ: Нэгэн Сингааль газрын хүн усан доор

бүхэл бүтэн таван минут явж чадна гэсэнд нь би үргэлж эргэлзэж ирлээ. Усан доор бараг бүтэн минут- тавин долоон секунд байж чаддаг сайн усчин улс буйг би мэднэ. Зарим нь бүр хамгийн сайн усчин хүн наян долоон секунд тийм- бүтэн хагас минут байж чаддаг нь ч бас бий. Гэвч тийм улс тун цөөхөн, тэрчлэн тэдгээр хөөрхийсийг усан дээр эргэж гарч ирэхэд чихнээс нь цустай ус гардаг миний санахад бол усчин хүн усан доор байх дундаж хугацаа гучин секундээс хэтрэхгүйдэг. Тэрхэн ахар хугацаанд тэр хүн сувдтай хясаа эрж олоод, түүж цуглуулж уутлах хэрэгтэй. Тиймээс сувд түүх ахмад, бүр мэрэгжсэн усчин улс дунд хэр наслах нь ч ховор, тэдгээрийн ихэнх нь цэл залуугаараа үхчихдэг юм. Тэдний нүдний хараа түргэн зуур муудаж, дараа нь нүд нь идээлж бээрлээд. хамаг бие нь ой гутам муухай яр шарх болчихдог. Ихэвчлэн тэдний үнхэлцэг нь хагарч усан доор гэнэт үхдэг юм.

- Ай харла, энэ ч мөн хүнд мэрэгжил юм даа гэж өгүүлээд үгүй ээ, ер муусайн хүүхнүүдийн аяыг дагаж өдий олон хүний амь нас гарздаж, ажил үрж байх ч гэж дээ. Тэгвэл капитан аа, нэгэн хөлөг өдөрт хэд хичнээн хясаа түүлгэж байгаа юм? хэмээн асуув.

- Ажлын нэгэн өдөрт дөчөөс тавин мянган ширхгийг... Английн засгийн газар 1814 онд улс төрдөө сувд түүх ажил зохиоход сувд түүгчид хорь хоногийн дотор далан зургаан сая хясаа түүсэн гэж ярьдаг. .

- Ядахдаа, сувд түүгчийн хөлс мөнгө их байдаг юм байгаа биздээ?

- Харин ч үгүй гээч. Хумсын төдийхэн. Панамд тэд нэгэн долоон хоногт бүтэн доллар хүрэхгүй хөлс авдаг юм. Ихэвчлэн тэд сувдтай хясаа тус бүрдээ, хоёр улаан мөнгөтэй тэнцэх зэс зоос нэгийг авдаг. Тэгвэл тэдний түүсэн хясааны хэд нь сувдгүй, хоосон байдаг гэж санана!

- Эзэн хүнд тэдний их орлого оруулж байгаа нэг сувдад ердөө ганцхан зэс зоос өгнө гэж үү? Дэндүү хэрцгий хэрэг гэж би хэллээ.

- Ингэхэд ноён профессорын бие болоод таныг дагалдагсад манаарын булангийн сувдат ёроолыг үзэх завшаангүй санжээ. Хэрэв энэ үеэр таны аз дайрч сувд түүгч ямар нэгэн усчин хүн тэнд байх бол та, тэрний ажлын арга маягтай ч танилцах болно гэж капитан Немо хэлэв.

- Тэгвэл бүр ч соньхон байхсан.

- Жич хэлэхэд, профессор та. аврага загаснаас айдаггүй биз?

- Аврага загас ий? Түүний тэгж асуусан нь надад үнэнийг хэлэхэд дэмий мэт санагдлаа. Тэгээд айдаг уу, үгүй юу? гэж капитан Немо шалгаж эхлэхэд:

- Үнэнийг хэлэхэд, капитан минь тэдгээр загасанд тань би төдий л их дасаагүй

хүн дээ гэв.

- Тэгвэл, бид тэдэнтэй нэн их дасаж, заримдаа мэдэхгүй өнгөрөөчих ч удаа байдаг. Та ч гэсэн удахгүй л бидний нэгэн адил дасах болно хэмээн капитан хариулаад - Бид сайн зэвсэглэнэ. Хэрэв болж өгвөл, ямар нэгэн аврага загас буудаж унагаахыг бодъё за тэгээд, профессор минь баяртай, маргааш уулзъя. Бид өглөө эрт явцгаана шүү гэж хамгийн гэмгүй янзтай өгүүлээд, үзэсгэлэн танхимаас гарч одов.

- Хэрэв таныг Швейцарын ууланд баавгай агная гэвэл эрхбиш та: “Их сайн маргааш явж тэр баавгайг чинь агная” гэх бий. Хэрэв танаас “Атлантын тэгш газар арслан агнах уу? эсвэл Энэтхэгийн балар шугуйд бар агнах уу?” гэж асуувал та “Үгүй ээ, яахав арслан ч бай, бар ч бай агнаад л үзье. Тэр тун сонин зүйл байх ёстой” гэж бодох бий. Гэтэл таныг аврага загас агнахдаа хөлөг онгоцны дээрээс биш эдгээрийн орших орчинд нь усан дотор агная гэвэл та, тийм урилга хүлээж авахаасаа өмнө нилээд сайн бодож болохдог оо.

Үнэнийг хэлэхэд капитан Немог гарч одоход би, духандаа бурзайж чийхарсан хөлсийг арчихаас өөр аргагүй болж билээ.

“Сайн бод, яарах хэрэггүй. Кресто арлын доорхи шугуйд минж агнах ч нэг хэрэг. Тэр ч зөвхөн л цаг аятай өнгөрүүлэх л арга. Тэгвэл одоо юу юугүй аврага загастай учирна хэмээн мэдсээр мөртөө далайн ёроолоор тэнэх гэдэг шал өөр хэрэг. Зарим оронд жишээлбэл: Андаманы арлуудын орчинд негрууд нэг гартаа хутга, нөгөө гартаа гогцоо бариад аврага загас руу дайрахаасаа айдаггүйг би мэднэ. Гэвч тэрхүү аврага араатантай хүч үзэлцсэн тэдгээр зүрх зоригтнуудын дундаас амьд буцаж ирэх нь ховор гэдгийг би бас мэднэ. Түүнээс гадна би негр хүн биш, мөн ч байлаа гэсэн миний тэр эргэлзээ зарим талаараа зүйтэй ч байж болох юм” гэж би өөрөө өөртөө ярьж билээ.

Миний сэтгэхүйн урдуур аврага загасны бөөн сүрэг явж өнгөрөх мэт болоход би, бүхэл бүтэн хүнийг тэг дундуур нь тас хазчих чадал бүхний, хэд хэдэн эгнээ хурц шүдтэй аврага загасны асар том амы нь харах шиг болохын зэрэгцээ, тэдгээрийн шүд миний хажуу хавирга руу шигдах мэт болох бүлгээ.

Түүнээс гадна, капитан Немо тиймэрхүү тоомсоргүй янзтай энэ тухай над ярьсны нь учрыг би ойлгож ядлаа. Тэр ой модонд гарч ямар нэгэн гэм хоргүй үнэг элдье гэж намайг уриалж байгаа мат санагдаж байв.

Бодвол Консель татгалзах л байх. Тэгвэл ч бүр сайн. Капитан Немогийн урилгыг хүлээж үл авахын минь гол шалтаг болно гэж би бодов.

Нед Лендийн хувьд бол ч бүү мэдээ. Би түүнийг хүн шиг бодлоготой, буурьтай юм

хийнэ гэж итгэхгүй байв. Тэрхүү дайчин эрд, хөнөөл хичнээн л их байвал, төчнөөн л их нөлөөлж дур сэтгэлийг нь, татдаг бүлгээ.

Би уншиж байсан номоо дахин үргэлжлүүлсэн боловч түүний хуудсыг дэмий л хий эргүүлэхээс өөр ашиг олсонгүй ээ. Тэр номын хуудсан дээрээс халз өөдөөс минь аврага загасны аймаар том ам ангайх ажээ.

Энэ үед Нед Ленд, Консель хоёр үзэсгэлэн танхимд орж иржээ. Тэд хоёул хөгжөөнтэй бөгөөд урам зоригтой байв. Тэд өөрсдий нь чухам ямар зүйл хүлээж буйг мэдэхгүй байлаа. Нед Ленд миний зуг хандаж:

- Танай тэр капитаныг чинь чөтгөр аваач! Нээрээ шүү. Би бүр үнэнээсээ хэлж байна. Сайхан тэр бидэнд овоо аятайхан юм хэлж байх чинь... хэмээн эхлэхэд нь би:

- Аа, та нар мэдчээ юу? гэв.

- Эзэн хэрэв зөвшөөрвөл, “Наутилус” хөлгийн дарга саяхан биднийг Манаарын буланд, сувд эрдэнэ түүх газар очиж үзэхийг урьсан тухай хэлэхийг би хүснэ. Тэр бидэнтэй тун эелдэг харьцаж ёстой л эр хүн шиг байсан гэж Консель хэллээ.

- Өөр юм та нарт тэр хэлээгүй юу?

- Юу ч хэлээгүй хэмээн Канад хүн хариулаад усан доогуур зохиох энэхүү өчүүхэн жуулчлалд таныг ч бас урьсан гэж л хэлснийг нь эс тооцвол өөр юм хэлээгүй ээ гэв.

- Тэр үнээн. Харин та нарт өөр сонин зүйл... гээд би ярих гэтэл,

- Өөр юу ч хэлээгүй ээ эрхэм профессор. Харин та бидэнтэй хамт явна биз? гэж асуув.

- Би юу? Явалгүй яахав. Нед та, усан доогуурхи жуулчлалын амтанд орсон болтой над санагдах чинь.

- Тиймээ, тун сонин юм байдаг. Сониноор ч барахгүй гээч.

- Гэвч, аюултай юм биш үү? хэмээн би санаандгүй мэт асуучвал:

- Сувдын хаялга дээр жирийн нэг зугаалга хийхэд ямар юм нь аюултай байдаг юм? гэж Нед Ленд эрс татгалзлаа.

Капитан Немо аврага загасны тухай ярьж миний нөхдийг айлгахын хэрэггүй гэж бодсон нь надад ойлгомжтой болов. Тэд хэдийнээ аль нэгэн үе мөчнөөсөө ангижирсан юм шиг би нөхдийнхөө зүг сэтгэл түгшин харж байв.

Заналхийлж буй аюулын тухай би нөхөддөө анхааруулах явдал байна уу? Байлгүй яахав. Гэвч би тэдэнд чухам яасхийж анхааруулах аргаа мэдэхгүй байв.

- Сувд түүх тухай эзэн ямар нэгэн юм бидэнд ярьж өхийг зөвшөөрөхгүйсэн бол уу? гэж Консель асуув.

Жинхэнэ сувд түүх тухай юу, эсвэл түүнтэй уялдсан аюулын тухай юу? хэмээн би

энэ асуудлын далимаар өөрийнхөө ярианд хэрэгтэй чиглэлээ олж болох талыг нь ашиглаж асуухад канадын харъяат:

Сувд түүх тухай гэв- Ер нь хэн ч тэр явах гэж буй замаа сайн мэдэж гэмээ нь явдаг биш үү.

- За тэгвэл, миний найз нар наашаа ойрхон шиг сууцгаа. Би та нарт сувд түүх тухай Сирын номноос өөрөө юу мэдэж авснаа бүгдийг нь ярьж өгье.

Нед, Консель хоёр зөөлөн сандал дээр надтай зэрэгцэн суулаа.

- Яруу найрагч хүнд бол, миний найз Нед чи сонс, сувд гэдэг чинь далайн нулимс, авхай нарт бол хуруу туруу чих мэхнээсээ дүүжилдэг үнэт бэлцгэр чулуу, химич хүнд бол Фосфорын хүчлийн давс, нүүрсхүчлийн кальц хоёрын нэгдэл, хамгийн эцэст байгальч хүнд бол зарим нэгэн хоёр хавтаст хясаан дотор ургадаг зөвхөн л нэг муу эмзэг ур... гэхэд.

- Зөөлөн биетний хүрээ, хальслаг заламгайтны ангид багтах хясаануудад ургадаг шиг билээ гэж Консель залгуулан өгүүлэв.

Тун зөв, миний эрдэмт найз. Өөрөөсөө цэнхэр, цэнхэр хөх, ягаан цагаан бодис буюу тана ялган гаргаж хавтсаа доторлодог бүх төрлийн зөөлөн биетэн сувд гаргадаг юм.

- Тийм хавчаахайг хүн иддэг юм уу гэж Канад эр асуув.

- Тиймээ, иддэг ч бас бий шүү. Жишээлбэл: Шотланд, Уэльс, Ирланд, Саксони, Богемы, Франц зэрэг орны зарим их усанд байдаг юм.

- За, үүнийг чинь л мэдэж авъя. Хэзээ нэгэн цагт хэрэг болох юу магад! гэж өнөөх Канад нутгийн хүн хэлж билээ.

- Гэвч сувд өгдөг хясаа маань сувдан хясаа юм шуу. Сувд гэдэг бол бөөрөнхий хэлбэрт олон танан ур байгаа юм. Сувд эсхүл хясааны хавтсанд наалдсан байдаг, эсхүл зөөлөн биетний биений хуниас завсар байдаг. Сувд хясааныхаа хананд наалдсан байна уу, үгүй бол хясаан дотроо сул байнауу, түүнээс хамаарахгүй, дотроо заавал бөөм, цөмтэй байдаг нь түүнийг нь тойрч жилээс жилд нимгэн хальслаг танан бүрхүүл давхарлан ургаж байдаг юм. Сувдын голд ямар нэгэн хатуу гүтүү юм, жишээ нь элсний нэг жижиг ширхэг орчихвол бөөм нь болдог ёстой.

- Нэг хясаан дотор хэд хэдэн сувд байж болох уу? гэж Консель асуув.

- Байдаг удаа бий зарим хясаанд хүзүүний бараг бүтэн хэлхээ сувд ч ургах явдал байдаг. Тэр ч байтугай зарим хясаан дотор, гэвч би үүнд төдий л лав итгэдэггүйл дээ, зуун тавиас доошгүй аврага загас ч байх ёс бий.

- Зуун тавин аврага загас ий? хэмээн Нед Ленд бархирчихав.

- Би аврага загас гэгчхэв уу? хэмээн би зовсхийж асуугаад сувд гэж хэлэх гээд л солиорчихож. Юуны чинь аврага загас байдаг юм, энэ бол шал дэмий үг! гэв.

- Тэгэлгүй дээ гэж Консель өгүүлээд - Гэвч, сувдыг хясаанаас нь яаж салган авдгийг эзэн хэлчихгүй юу гэлээ.

- Олон янзын арга бий заримдаа, хэрэв сувд хавтсандаа зүгээр наалдсан бол энгийн хямсаагаар авдаг юм. Гэвч ихэвчлэн түүсэн хясаагаа мөн тэрхэн орчинд эрэг дээр сийрсэн дэвсгэр дээгүүр тарааж хаяад, арваад хоногийн дараа буюу хатаж ялзрах үед нь далайн устай том саванд хийж хясаануудынхаа хавтсыг сөхөж дэлгэмэгц усанд тунгааж угаадаг юм. Энэ үед зэрэг дугаараар нь ялгагч хүмүүс ажилдаа орж, хавтсандаа наалдаж ургасан сувдыг худалдаанд тусгайдаа гардаг танан хананаас нь ховхлон авч цуглуулсны дараа, зөөлөн биетний нялцгай махбодийг урсаж үгүй болтол нь буцалгаад, тунаж үлдсэн сувдыг хамгийн бяцхан нь хүртэл түүж авдаг юм.

- Сувд эрдэний үнэ түүний зөвхөн хэмжээнээс л шалтгаална уу? гэж Консель асуув.

Үгүй ээ, хэмжээнээсээ ч ганцхан болохгүй шүү гээд хариу өгүүлрүүн: -Бас хэлбэрээсээ ч бэлцгэрээсээ ч өөрөөр хэлбэл нүдэнд харагдах солонгорсон тэр өнгө, гялгараасаа болдог юм. Хамгийн том сувд зөөлөн биений хуниасанд үүсдэг юм. Тэд цагаан, ихэвчлэн бөлбөгөр боловч онц номин өнгөтэй, мөн дийлэнхдээ бөөрөнхий хэлбэртэй эсхүл нимбэг мэт хэлбэртэй байх нь ч бий. Бөв бөөрөнхий сувдаар бугуйвч, гонзгой зуувнаар нь ээмэг зээмэг хийдэг юм. Эдгээрийн алийг нь ч ширхэгчлэн худалддаг. Хясааныхаа хавтас хананд наалдаж ургасан сувд нь нөгөөгөөсөө хэлбэр муутай учраас хямд. Тиймээсээ тэдгээрийг жигнэж зардаг юм. Ингээд хамгийн эцэст нь гуравдугаар зэргийн сувд гэж бий. Тэр бол будаа шиг бутархай, жижиг сувд байдаг юм. Тийм сувдыг тусгай хэмжүүр саваар хутгаж худалддаг. Эдгээрийг голчлон гоёлын зүйлд шигтгээ болгон хэрэглэх боловч сүм хийдэд ямбаны хувцас чимэхэд бас хэрэглэдэг юм.

- Сувд ялгах гэдэг бодвол их новширсон удаан, хүнд хөдөлмөр дэг ээ? гэж Канад хүн асуув.

Үгүй ээ хонгор минь, энэ бол тийм ч хүнд ажил биш. Энэ ажлыг арван нэгэн давхар тор, шигшүүрийн тусламжаар гүйцэтгэдэг юм. Хориос наян тооны нүхтэй шигшүүрт үлддэг сувдыг нэгдүгээр зэрэг, зуугаас найман зуун нүхтэй шигшүүр дээр үлддэг сувдыг хоёрдугаар зэрэг, найман зуугаас мянган тооны нүхтэй шигшүүрээр шигшигдсэн сувдыг гуравдугаар зэрэг гэж ялгадаг юм.

- Үгүй ээ мөн, айхтар аа хэмээн Консель өгүүлээд миний бодоход сувд ялгагчдын ажил ч механикчлагдсан л юм байна... Сувд эрдэнийн аж ахуй ямар шүү орлоготой болохыг бидэнд эзэнтэн хэлчихгүйсэн бол уу? гэв.

- Хэрэв Сиррагийн мэдээлсэнд үнэмших юм бол гээд хариуд нь -Сувд эрдэний Сингааль орны баялаг ёроолыг жилд гурван сая аврага загасаар хөлсөлдөг юм билээ гэлээ.

- Франкаар! гэж намайг Консель залруулж өгөв.

- Аа тийм франкаар! Гурван сая франкаар шүү гэж би давтан өгүүлээд - Гэвч энэ орчин одоо урьдынхтайгаа адил тийм их орлого өгдөггүй мэт надад санагдана. Америкийнх ч бас ялгаагүй. Америкийн сувдны хаялга V Карлын үед жилд дөрвөн сан Франкийн сувд өгдөг байсан бол одоо тэр бүтээгдэхүүн нь гуравны хоёр дахин хорогджээ. Бүх дэлхийн сувд эрдэнийн сан жилд ерөнхийдөө есөн сая франкийн сувд өгч байгаа юм.

- Тэгвэл би, зарим нэгэн сувд асар их үнэ хүрдэг гэж дуулсан юм гэж Консель асуув.

- Тиймээ, миний найз, Юлий Цезарь одоогийн манай ханшаар зуун хорин мянган франкийн сувдыг Сервиллид бэлэглэсэн гэж түүх нотолж байгаа юм.

Эрт дээр үед, хэн нь ч юм дээ, нэг авхай цуунд сувд уусгачхаад уучихсан юм гэнэлээ гэж би бас дуулсан хэмээн Канад хүн хэллээ.

- Тэр чинь Клеопатра! гэж Консель өгүүлэв.

- Юу ч амттай л байв гэж дээ хэмээн Нед Лендийг хэлэхэд, Консель:

- Тун муухай амттай байлгүй яахав, Нед минь хэмээн хариулж-үгүй ээ чи бодоод үз л дээ, тэр нэгэн аяга цуу нь тавин мянган франкийн үнэтэй байсан юм чинь гашуун байлгүй яахав гэв.

Тэр муу эхнэр миний авгай байгаагүй нь л болж гэж Канад хүн өгүүлээд, лантгар том нударгаа харж суулаа.

- Нед Ленд тэгээд бас Клеопатрын нөхөр байх! хэмээн Консель тачигнатлаа хөхөрлөө.

- Үнэхээр би гэрлэхээр шийдэх удаа нэг бий юм шүү. Консель минь гэж мань эр ажиг ч үгүй хэлээд - хэрэв одоо хэргийн байдал пад харласан бол миний буруу ч биш л дээ. Би өөрийнхөө гэргий болгох гэж агсан Кэт Тендертээ хүзүүний сувдан чимэг авсан юм. Гэтэл яагаад ч юм тэр маань өөр хүнтэй суучихсан л даа. Харин миний тэр худалдаж авсан хүзүүний сувдан чимэг дөнгөж бүтэн хагас долларын үнэтэй байсан боловч эрхэм профессор та миний үгэнд нээрээ итгээрэй, тэр чимэгний минь нэгхэн

ч ширхэг сувд нь хорихон тооны нүхтэй шигшүүрийн нүхээр багтахгүй... билээ.

- Эшш муу найз минь, Нед минь! хэмээн би инээмсэглэж тэр хүзүүний чинь чимгийг хиймэл сувдаар хийчсэн юм байхгүй юу - Тэр нь сувдын ааг шингэсэн ердийн л нэг бөөрөнхий шил байхгүй юу гэв.

- Ямар ч гэсэн хэмээн Канад эр маргалдаж тэр ааг гэдэг чинь хямд л байх ёсгүй гэлээ.

- Тэрэнд ямар ч үнэ байхгүй. Тэр бол азотын хүчилд уусгасан уклеик гэдэг жараахайны хайрс байгаа юм. Түүнд ёстой сохор зоосны үнэ алгаа.

- За тэгвэл Кэт Тендер яагаад өөр хүнтэй суусны учрыг одоо л би мэдлээ хэмээн Нед Ленд их сэтгэгчийн дүр үзүүлж амарлингуй нь аргагүй хэлж билээ.

- За одоо өнөөх сувдынхаа тухай ярианд дахин орцгооё гэж би хэлээд-газар дээр байгаа нэг ч баян феодалд капитан Немод одоо байгаа шиг тийм үнэтэй сувд нэгхэн ч байхгүй гэдэгт би дүүрэн итгэж байна гэв.

- Энэнтэй адилхан уу?-хэмээн Консель үзвэрийн шилэн гуун дотор хар хилэн дэвсгэр дээр байгаа сувдыг хуруугаар зааж асуув.

- Тиймээ, тэрэнтэй чинь адилхан. Түүнд чинь би хоёр сая...

- Франк, франкийн хэмээн Канад Консельд яаравчлан сануулахад, би:

- Аа тийм, хоёр сая франкийн үнэ өгвөл арайч эндэхгүй биз гэж бодож байнам. Тэр сувдыг ч олж авахад капитан Немод зөвхөн л нэг удаа бөхийх төвөг гарсан байх даа... гэв.

- За харж л байгаарай хэмээн Нед Ленд гэнэт дуу тавьж хэн яаж мэдэхвэ, маргаашийн зугаалгаар бид яг тийм сувд олоод авч юу магад гэлээ.

- Ги... хэмээн Консель дуун гарав. Яагаад болдоггүй юм?

- “Наутилус” онгоцон дээр байсан цагт бидэнд тэр олон сая янчааны хэрэг юу байна аа?

- Тиймээ. Тэрэнтэй чинь адилхан. Түүнд чинь би хоёр сая франкийн үнэ өгвөл арай эндэхгүй биз гэж бодож байнам...

Энд ч хэрэггүй л дээ... Гэвч өөр газар... ?

- Өөр газар гэнэ шүү! хэмээн Консель толгойгоо сэгсрэв.

- Нед Лендийн зөв гэж би өгүүлээд -хэрэв бид европ уу, эсхүл Америкт хэд хэдэн сая франкийн сувд эрдэнэ аваачих юм бол бидний усан доогуур хийсэн аялал, адал явдлын тухай өгүүлэлд нэн их тус нэмэр болж, хүмүүсийн сэтгэлд ихээхэн итгэл төрүүлэхсэн билээ гэв.

- Яах аргагүй тийм! гэж Канад хүн зөвшөөрөв.



- Тэгвэл та хэл л дээ хэмээн ашиг сонирхлыг нь харахаасаа ач тусыг нь шинжлэх ухааны үүднээс харахсан гэж сонирхож байсан Консель сувд түүхэд учрах ямар нэгэн талын аюул хөнөөл байна уу гэж асуулаа.

- Байхгүй ээ хэмээн би эрс хариулж - ялангуяа, хэрэв л нэгэн талын болгоомжлолыг урдаас анхаарваас ямар ч аюул байхгүй гэлээ.

- Үүнд чинь ямар аюул байж болох билээ? хэмээн Нед Ленд асуугаад - Хэрэв л ус залгиж хахаж цацахгүй л бол гэв.

- Хамаг учир ч зөвхөн тэрэнд биш дэг шүү. Недээ, гэвч, жич хэлэхэд аврага загаснаас та айдаггүй биз? гэж би яг л капитан Немо шиг ажиггүй байдал гаргахыг оролдон нэмж асуув.

- Би юу? Одоо би юу дээ? хэмээн Нед Ленд өгүүлээд бүр ясны жадчин, тэгээд бас аврага загаснаас айх гэнээ! гэлээ.

Аврага загасыг дэгээдэж тавцан дээр гаргаад, сүүлий нь сүхээр тас цавчиж гэдсий нь хутгаар хуу татаж, зүрхий нь сугалаад, сэгий нь далайд шидчих талаар яриагүй байна шүү...

- Тэгвэл та асуухдаа, аврага загастай ...

- Ай даа яг л тэрний чинь тухай!

- Усан дотор уу?

- Усан дотроо!

- Тэгвэл биедээ сайнаас сайн жад авч явбал яасан юм?... Ингэхэд ер нь аврага загас гэдэг чинь ч нилээн булиа амьтан юм шүү дээ, профессор гуай. Таныг тэд шамирахын тул юуны өмнө урьдаар нуруугаараа эргэж байж гэмээ нь сая довтлох болно. Тэр завсар нь та жадаа түүний зүрхэнд хийж хэзээ ч амжина гээч.

Нед Ленд ярихдаа дандаа “Шамирах” гэдэг үгийг хэрэглэдэг заншилтай бөгөөд тэр үгий нь би дуулахаас нуруу руу хүйт оргих шиг болдог билээ.

- Ингэхэд Консель чи, аврага загасны талаар юу бодож байна? гэж би асуув.

Би эзэнд бүр илэн далангүй хэлэхэд гээд түүнийг яриагаа эхлэхэд нь би “санасан ёсоор боллоо” гэж бодож суув.

- Хэрэв аврага загаснаас эзэн л айхгүй бол түүний үнэнч зарц би, юундаа тэднээс айх билээ? гэж бүлгээ.

[Top](#)

---

## АРВАН САЯ ФРАНКИЙН ҮНЭТЭЙ СУВД

Шөнө боллоо. Би хөнжилдөө орсон боловч муу унтлаа. Дандаа л аврага загас зүүдэнд минь орж, нэг бус удаа цочиж сэрэхэд, хүйтэн хөлс цутгачихсан байдаг байв.

Маргааш нь өглөөний дөрвөн цагт капитан Немо надад үйлчлүүлэхээр тавьсан зарц орж ирээд намайг сэрээв. Би бушуухан босож хувцаслаад үзэсгэлэн танхимд орж очив. Капитан Немо намайг тэнд хүлээж байв.

- Эрхэм Аронакс та бэлэн үү! гэж тэр асуув.

- Бэлнээр барах уу, капитан.

- Тийм бол намайг дагалдахыг хүсье.

- Бид баг өмсөх үү?

- Одоохондоо үгүй ээ. “Наутилус” эрэгт ойр очиж чадахгүй болохоор би түүнийг Манаарын сувдат булангаас холоос хол зогсоосон. Тийм болохоор бидэнд завь төхөөрөхийг би тушаасан. Тэр биднийг дэмий их ядраахгүй сувдат буланд шууд хүргэж өгнө. Харин баг маань завин дотор бий болохоор бид усанд яг орохоосоо өмнө өмсчихөмз гэлээ.

Бид тавцан дээр явж гарвал Нед Ленд, Консель хоёр маань биднийг тэнд хүлээж бүлгээ.

Усанд буулгаж “Наутилуса”-аас аргамжсан завинд таван усан цэрэг сэлүүрдэхээр сууж байв.

Энэ хэр ч ороогүй тул шөнө гэдэг нүдгүй харанхуй ажээ. Тэнгэр бүрхсэн, өтгөн хар үүлсийн цоорхойгоор хааяа нэг од анивалзаж байв.

Би хуурай газар тийш харсан боловч далайн төвшний дөрөвний гурван хувийг хөшиглөсөн үл мэдэгдэх үргэлжилсэн хав харанхуй хүглийн байхыг үзлээ.

Сингааль арлын баруун эргийг барьж шөнөдөө явсан “Наутилус” одоо булан орох хоолойн аман дээр буюу эсхүл, Манаарын арлууд ба Сингаалийн эрэг хооронд үүссэн өргөн тохойд байгаа бололтой далайн усны пад харлан буй төвшин доор бараг хорин миль газар тасралтгүй үргэлжлэх сувд эрдэнийн дэлхий дээрх хамгийн том хаялгын нэгэн буюу эрдэнийн уудалж баршгүй их сан оршиж бүлгээ.

Капитан Немо, Консель, Нед Ленд бид дөрөв завины бөгсөнд байр эзлэв. Усан цэргүүдийн нэг нь залуур дээр суухад нь сэлүүрээс авцгааж, хамаг ажил шувтрахын хамт бид аян замдаа гарлаа.

Завь өмнө зүгийг барив. Сэлүүрчид яарахгүй байв. Тэд яг л далайн цэргийн сургуулийнхан дадлага хийсэн шиг арван секунд болоод л сэлүүрээ усанд нэг тавьж байхыг нь би ажив.

Завь хурдалсан хүчиндээ өөрөө урагшаа гулгах үед дээш нь өргөсөн сэлүүрүүдээс доошоо усан дээр гоожиж байгаа усан дуслууд пол пол хийх дуун аяархан дуулдаж байв. Эргийн зүгээс ирж буй усны сулавтархан атриа бидний завийг үл мэдэг халбилзуулан, долгионы мушгирсан сэрвээ хоншоорт шалчигнаж бүлгээ.

Бид дуугүй явав. Тэхэд капитан Немо юу гэж бодож явсан бол? Энэ нэгэн хуурай газрын тухай түүнд бидний ойртож яваа тухай ч бодож байж юу магад билээ?

Бодвол Нед Ленд ч бас хуурай газрын тухай бодож явсан биз. Гэвч түүний бодлоор бол бид хуурай газраас хэтэрхий хол явсан буйзаа.

Конселийн хувьд бол ч тэр юуны тухай эс бодсон билээ. Тэр зөвхөн капитаны амласан тэр сайхан зугааг байж ядаж хүлээсэн биз.

Таван цаг хагаст үүрийн анхны туяа далайн төвшин дээрх алсын уулсын зурвас барааг тодотгон гийгүүлж билээ. Дорно хэсэгтээ нам доор мөртөө өмнө талаараа уулархаг тэр нэгэн арлаас бид одоо тавхан милийн зайтай явав. Тэр арал бидний завь хоёрын хооронд далай эзгүй ажээ. Ганцхан ч хөлөг үл үзэгдэж нэг ч гэсэн шумбагч хүн харагдахгүй байв.

Энд бид дэндүү эрт ирсэн гэдэг нь үнэн тул капитан Немогийн зөв байлаа.

Өглөөний зургаан цагт гэв гэнэтхэн өдөр болж ирсэн нь үдшийн бүрий, үүрийн гэгээ гэж ер мэддэггүй тэдгээр халуун орны гэм биш зан, гэнэт биш хууч бүлгээ. Нарны туяа гэрэлтүүлж, өдрийн дэнлүү тэнгэрийн мандалд тэрхэн даруй хөөрөн гарав.

Одоо би хуурай газрыг ил харахаар барахгүй эрэг дээр ургасан зарим моддыг харах болов.

Бидний завь эргийн нь шугам урагшаа тахийж одсон Манаар арлын зүг эргэв. Капитан Немо суудлаасаа босож далайг ажиглан зогслоо.

Түүний дохиогоор завь зогсож, усанд зангаа орхив. Гэвч энэхэн орчинд далайн сувдат ёроол нэн ойрхон агсан тул занганы гинжийг нэгэн метрээс илуугүй хөвөх хэрэг гарсангүйээ.

Далайн татлага бидний завийг задгай далай тийш занганы гинжний боломжоор, эгшин зуур урсгаж аваачив.

- Бид хүрээд ирэх нь энэ дээ эрхэм профессор! хэмээн капитан Немо өгүүлээд:

- Та энэ битүү тохойг харж байна уу? Энд ганцхан сарын дараагаар хэд хэдэн зуун хөлөг цугларч, хэд хэдэн мянган зоригт усчин шумбан орно гээч. Энэ тохой сувд түүхэд мөн тохиромжтой нь салхинаас уулсаар халхлагдаж, ус ширүүн давалгаалах нь хэзээ ч байдаггүй. Энэ хоёр бол сувд түүгч усчин улсын ажилд онц чухал шаардагдах нөхцөл болдог юм. Одоо бид багаа өмсөцгөөж зугаалгандаа орох болно.

Би юу ч хариу дуугарсангүй бөгөөд зөвхөн л энэ орчны аймшигтай уснаас нүд үл салган ширтэх зуур далайчдын нэг нь нүсэр хүнд баг өмсөхөд минь надад туслалцав. Капитан Немо, миний хоёр найз мөн л багаа өмсөцгөөж гарав. Тэхнээ нь тэр булангийн ёроолоор явах зугаалганд далайчдын нэг нь ч оролцохгүй юмсанжээ.

Бид төдөлгөйхэн хаймар өмсгөлд хүзүүгээ хүртэл чихэлдэж, шахсан хийтэй саваа нуруундаа үүрлээ. Румкорфын аппарат, цахилгаан чийдэн завин дотор байсангүй ээ. Энэ тухай би, бидний толгойд төмөр дуулга углахаас өмнө капитан Немод сануулж хэлбэл:

- Чийдэнгийн хэрэг бидэнд байхгүй. Бид их гүнзгийд орохын хэрэггүй болохоор гүехэн усан дотор нарны гэрэл л боллоо. Түүнээс гадна аюултай араатдын анхаарлыг татаж болох тул эдгээр усанд чийдэнгийн гэрлийг ёлтойтол асаах явдал өршөөж болшгүй гэнэн хэрэг болох биш үү гэлээ.

Энэ үгийг капитан Немо хэлэх завсар би Нед Ленд, Консель хоёр руу харав. Гэвч салшгүй хоёр найз маань төмөр малгайгаар толгойгоо аль хэдийнээ бумбадчихсан тул юуч сонсохгүй боллоо.

Тиймээс би капитан Немод зөвхөн л сүүлчийнхээ асуултыг тавихаас өөр замгүй боллоо.

- Тэгвэл буу хаа байна? Бид үнэхээр зэвсэглэхгүй явна гэж үү? хэмээн миний асуухад:

- Буу юу? Буугаар яах юм? хэмээн капитан Немо үгнээс зөрж-Уулынхан баавгайд явахдаа буутай явдаг гэж үү? Том хутга сайн гар ямар ч сумнаас хол илүү гээч. Май энэ онцгой гойд мэс. Бүсэндээ хавчуулчих. За тэгээд явъя гэлээ.

Би өөрийн хань нөхдийн зүг харав. Тэдэнд мөн л капитан бид хоёрынхтой яг адил зэвсэг байхаас гадна Нед Лендийн гарт “Наутилус” дээрээс авч гарсан том жад байх харагдлаа.

Тиймээс би зөвхөн л толгой дээрээ нүсэр хүнд төмөр дуулга хөмрүүлж эргэлдүүлээд, шахсан хийтэй савныхаа хийн хаалтыг нээлгэхээс өөр аргагүй болжээ.

Нэг минутын дараагаар биднийг усан цэргүүд нэг нэгээр маань завины хажуу руу

буулгаж өхөд метр хагасаас хэтрэхгүй гүнд хөл газарт хүрч туяарч дагтаршсан торгон шар элсэн дээр гишгэлээ.

Бидэнд капитан Немо гар занган дохио өгмөгц бид түүний хойноос дагалдан хэвийн ташуу газар уруудан усны гүн тийш бууж одлоо.

Миний бодож сэтгэхүйг эзлэн намайг зовоож агсан муу юм гэнэт сарнин одож, би усан доорхи амьдралын хамаг гайхамшигт тэр чигээрээ татагдан орж миний сэтгэл санаа гүнээ тайвширч бүлгээ.

Нарны гэрэл далайн ёроолыг сайхан гэрэлтүүлж байв. Түүгээр ч барахгүй тун бяцхан юмс ч тод харагдаж байлаа. Бид арван минут хэр явсны дараа таван метрийн гүнд орж очиход далайн ёроол хавтгайран тэгширч ирлээ.

Бид ганцхан сүүлнээсээ өөр сэлүүргүй дан сэлүүртний багийн хэд хэдэн сүрэг жараахай үргээчихлээ. Тэдгээрийн дотор би хятадын могой толгойтоос хэмжээ болоод нилээд цайвар өнгөөрөө л зөвхөн ялгагдах, шаравтар бор нуруу ба гэдэстэй метр шахам урт, алаг эрээн зүсний могой толгойтой загас байхыг олж харав. Цааш нь бидэнтэй сэрвээндээ босоо зах мэт сэлүүртэй, хурц тод өнгийн дэрвүүлт загас дайралдав. Идшинд орох энэ загасни хачирлаж борцолсон мах нутгийн хүмүүсийн хамгийн амтат хүнс болдог ажээ. Түүнчлэн бас уртаараа гучин сантиметрээс хэтэрдэггүй дээрээсээ цэнхэрдүү бор, дороосоо мөнгөлөг, маш жижигхэн өнгөлөг хайрсаар битүү бүрхэгдмэл ставрид хэмээх харангын язгуурт хамаарагдах- загас явахыг Консельд дохиогоор мэдэгдэв.

Энэ завсар улам хөөрч бий нар усны гүнийг бүр л тодоос тод гийгүүлж бүлгээ. Усны ёроолын байдал бага багаар хувирч эхлэв. Нягтарч тагтаршсан торгом элс, зарим талаараа, засаж тэгшилсэн замтай адилхан мөлгөр хад чулуу дэвсгэрлэсэн хөрсөөр солигдож ирсэн нь зөөлөн биетэн хөндий хэвэлтнээр хивс мэт битүү хучигдсан байв.

Энд би зөвхөн гагцхүү устрицын язгуурт хамаарагдах улаан далай ба Энэтхэгийн тэнгист үрждэг хэв муутай нимгэн хавтас бүхий плацын дув дуугүй дун бүрхүүлтэй улаан ягаан люпин, «Наутилус»-ыг сайхан будгаар хангагч персийн хэд хэдэн пурпурниц мөн бас Индостаны зээл дээр худалдагддаг анатин гэдэг идшинд ордог дун болон хамгийн эцэст үзэмж төгөлдөр дэвүүр нь далайн бүх амьтны хамгийн гоёмсог акулий зэргийг олж үзэв.

Энэ далайн ёроолоор дүүрэн үе хөлтний анги өөд уруугүй зорчилдон байхын дотор бөөрөнхийвтөр бие нь нэг талаасаа эвэр хушуу, нөгөө талаасаа долоон хос хөлтэй бүдүүн гэдэс бүхий олон үет хорхой, мөн амны өмнөх мөч нь алга болсон,

бараг үхэж мөхөж байгаа палеострак гэдэг бүлэг амьтан, Чарльз Дарвин өөрийн нүдээр олж үзсэн аврага хавч зэрэг амьтан үй олноороо байв. Асар их хүчтэй заяагд- сан аврага хавч бол байгалиасаа эрэг орчны мод өөд авиран гарч тэдний самрыг аван бяц шидэлж, дараа нь аймшигт чадалтай хумсаараа хага хага татан иддэг бүлгээ. Хадан завсраар арай ядан мөлхдөг малабар орны хавчны дэр- гэд эндэх нутгийн хавчнууд тод сайн гэрэлтүүлэгдсэн усанд айхтар хурдан гүйдэг ажээ. Дотор нь сувд ургадаг, сувд эрдэнийн хясааны хацар хавтас гаднаасаа бэржгэрдүү зузаан нь хаанаа л бол хаанаа бараг адилхан, дугариг шахам ирмэгтэй бүлгээ.

Тэдгээрийн заримыг нь урд ирмэгээс зүг бүр тийшээ сацарсан ногоовтор судал тууш тууш татагдсан байв. Тэд бол залуу хясаа ажээ. Бусад арав буюу арваас дээш настай хөгширсөн хясаа өргөнөөрөө бараг арван таван сантиметр хүрч харавтар буюу бараг пад хар өнгөтэй байлаа.

Тиймэрхүү хясаа түг түмээрээ овооролдсон байхыг капитан Немо надад заасны дараа энэ их баялаг үнэхээр барагдашгүй бөгөөд байгалийн бүтээх нь хүний сүйтгэхээс ямар ч гэсэн хэзээд давуу байдгийг би сая л ойлгож билээ.

Хүмүүсийн цөлбөн сүйтгэх авир зан төрөлх заншил нь болсон Нед Ленд хажуудаа зүүлттэй явсан уутыг хамгийн шилдэг хясаагаар дүүргэж авахыг яаравчлав.

Гэвч бид зогсож саатаж болохгүй байлаа. Хэзээний танил замаараа урагшилж гуйвалтгүй алхалж бий капитан Немог бас хоцрохын хэрэггүй билээ. Гараа дээш нь өргөвөөс усан дээр ил гарч байсан гүехэн газар бидэнтэй хэд хэдэн удаа дайралдав. Гэвч ус тархан доороо л гүнзгийрдэг байв.

Бид дандаа л өндөр газар хадан хясаа тойрох хэрэгтэй болдог билээ. Тэдгээрийн ангал, ан цавуудад том том хавч хэлбэртэн үүрлэсэн ажээ. Цэрэг дайны ямар нэгэн аймшигт хачин машин мэт тэд өндөр дүүжгэр хөл дээрээ дүүжиг- нэн зогсож бидэн рүү салахгүй ширтэж байв.

Тийнхүү бид яван явсаар далайн ургамлын хамгийн үзэсгэлэнт төлөөлөгчдөөр битүү бүрхсэн жигтэй хачин хэлбэр бүхий гуа сайхан хадан хананд онгойж ёнхойн харагдаж бий агуйн аман дээр хүрч очив. Эхлээд надад нарны гэрэл тэр агуйн аман дээр эцэс болж агуй дотор нэвтэлшгүй пад харанхуй ноёлж бий мэт санагдсан боловч нарны гэрэл шингэсэн, учир нь олодохгүй нэг л саруул туяа агуйг дүүргэсэн усан дотор гэрэлтэх мэт харагдлаа.

Капитан Немо агуйд явж оров. Бид ч түүний хойноос дагалдлаа.

Төдөлгөхөн миний нүд агуйд бүүдийж буй бүрэг бараг гэрэлд дасаж ирэв.

Тосканы уран барилгын том багануудтай адилхан, доогуураа боржин чулуун өргөн суурь дээр лүглийж бий байгалийн хадан баганаар зарим хэсэгтээ тулгуурласан дээвэр байхыг би ялгаж харав.

Бидний хачин газарч тэр хүн усан доорхи энэхүү агуйн гүнд биднийг дагуулж ирэхийн хэрэг нь юу билээ? Үүний учрыг би төдөлгүй мэдлээ. Бид нилээд хэц ташуу руу уруудсаар нэгэн гүн хонхрын ёроолд бууж ирлээ. Тэнд капитан Немо зогсож, анхандаа бид ерөөсөө ажаагүй байсан, бөөн хар юм руу гараар заалаа.

Тэр бол аврага том тридакна байсан нь өргөөшөө хоёр метрээр ч барахгүй “Наутилус”-ын үзэсгэлэн танхимынханд байдгаас ч хэмжээгээр том ажээ.

Би тэр гайхамшиг сайхан зөөлөн биетэнд ойртож очив. Тэр, энэ нэгэн агуйн амгалан уснаа цор ганцаар амьдарч, доороо байгаа боржин чулуун сууринд бөх наалджээ.

Би түүний хүндийг гурван зуун килограмм гэж тодорхойллоо. Тийм хавч дор хаяж арван таван килограмм махтай байх ёстой билээ.

Капитан Немо бодвол, тэрхүү тридакны энд оршдогийг эртнээс мэдэх бизээ. Түүнийг тэр нэг бус удаа эргэж байгаа бөгөөд байгалийн тэр нэгэн гайхамшигийг бидэнд үзүүлэх гэж энд авчирчээ гаж би бодлоо.

Гэвч энэ нь миний эндүүрэл болжээ. Тэхнээ нь капитан Немо маань уул зөөлөн биетний байдлыг өөрийн биеэр шалгах хэрэгтэй юм санжээ.

Тэр хясааны асар том хавтас дутуу хаалттай байв. Капитан Немо хавтсыг нь хамхиулахгүйн тул хутгаараа тэвхэдчихлээ. Дараа нь тэр уул зөөлөн биетний арсгар мантийг гараараа өөд нь сөхөж ирэв.

Тэхэд нь би уул зөөлөн биетний нялцгай биетний атриан завсар хушган чинээ том, сул ургаж бий сувд байхыг олж харав, Түүний гайхамшиг бөв бөөрөнхий хэлбэр, агуу цэвэр тунгалаг өнгө, үгээр хэлж болшгүй солонгорсон сайхан туяа зэрэг нь түүнийг хаана ч ямар ч үнэ хэлцэхийн аргагүй үнэхээр ховор үнэт эрдэнэ болгон хувиргажээ.

Сониурхож гайхсандаа сэтгэл хөдөлсөн би, түүнийг гартаа авч нүдэндээ ойртуулан, хүнд хөнгөний нь жигнэж үзэх хэмээн сарвайтал капитан Немо миний гарыг хойшлуулж, тэвхэдсэн хутгаа түргэн зуур суга татан авахын хамт түүний хоёр хавтас хав хийтэл хамхигдав.

Тэр сувдыг уул хясааны манти доор үлдээсний үрээр түүнийг аянд нь томсгон ургуулж бий капитаны санааг би ойлголоо. Уул хясаа жил бүр өөрийн биеэс ялган гаргаж байгаа нялцгай бодис тэр сувданд шинэ шинэ бүрхүүл болон нэмэгдэж бий

ажээ. Тэр сайхан эрдэнэ дэлбэрч байгаа энэ агуйг тэр хүн ганцаараа мэдэж байв. Түүнийг энэ хүн нэгэн сайхан өдөр музейдээ аваачихаар өсгөж байгаа юм.

Танан эрдэнээр яваа яваандаа нэгмөсөн бүрэгдэх бөөрөнхий төмөр буюу эсхүл шүр мүр тэр хясааны хавтсан дотор хийчээд, энэхүү сувд ургах нөхцөлийг нь өөрөө ч өдөөсөн байж болох юм.

Тэгсэн ч тэгээгүй ч тэрхүү сувдыг өөрийнхөө сонссонтой ч, “Наутилус”-ын үзвэрт хадгалагдаж байгаатай ч харьцуулж үзсэн түүнийг дор хаяж арван сая франкийн үнэтэй гэж би үнэллээ, түүгээр ч барахгүй энэ бол зөвхөн үнэт эдлэл байхаасаа, юуны өмнө гойд ховор эрдэнэ байсан бөгөөд тийм хүнд том ээмэг даах чихтэй эрхэмсэг авхай энэ дэлхийд үгүй билээ.

Гайхамшигт тридакныг үзэж дуусав. Капитан Немо агуйгаас явж гарахад бид нөгөө ташууг даган өөдөө өгсөж сувд эрдэнийн хаялга дээр гарч ирэв.

Бид тэгш талаар зугаацах мэт тал бүр тийшээ салж явцгаалаа. Хэн хаа дуртай газраа саатан зогсож нэг нэгээсээ их хоцорч явав.

Урьд өмнө нь миний сэтгэлийг зовоож агсан усан доорхи энэхүү зугаалганд тохиолдож болох аюулын тухай би таг мартчихсанаа хэлэх хэрэгтэй.

Одоо далайн ёроол улам л дээшилсээр эцэст нь нэг метрээс хэтрэхгүй гүехэн газар хүрч ирэхэд миний толгой усан дээр ил гарлаа. Тэр үед Консель намайг гүйцэн ирж өөрийн дуулганы шилэн цонхыг миний дуулганы цонхонд наалдуулан надад нөхөр журмын мэндийг хүргэсэн дохио өгөв. Гэвч тэрхэн гүехэн газар хэдхэн арван метр яваад гүнзгийрч эхэлсэн тул бид өөрсдийн төрөлх орчиндоо дахин шингэж орлоо. Тэнгисийг тийнхүү төрөлх орчиндоо хэмээн нэрлэх нь надад зүйн хэрэг мэт санагдана.

Тиймэрхүү янзтайгаар дахиад арваад минут өнгөрөв. Гэтэл капитан Немо гэв гэнэт зог тусав. Миний бодоход тэр замаасаа төөрчих шиг санагдав. Гэтэл үгүй ээ: тэр биднийг ойртон ирэх дохио өгөхөд бид хүрэлцэн очвол гараа урагш сунган нэгэн бөөн хар юм руу заав. Би нэн анхааралтай ажиглаж эхлэв.. Тэгтэл ч надаас таван метр хэртэй газар ямар нэгэн сүүдэр дүрсхийв. Аврага загасны тухай түгшүүрт бодол миний ухаанд орж ирэв. Тэгтэл би дэмий сэтгэл түгшсэн ажээ. Энэ удаа хамаг хэрэг шал өөр талаар эргэв.

Тэр бол хүн, хүн хүндээ Энэтхэг газрын загасчин амьд хүн ажээ. Бодвол тэр сувдат хясааны хойноос шумбаж байсан буйзаа. Би түүний толгой дээр өөрөөс нь холгүй, усан дээр хөвж байгаа түүний завины ёроолыг харав. Тэр шумбан орж ирмэгцээ төдий л удалгүй буцаад гарчихаж байв. Усанд орохдоо тэр завиныхаа



бөгснөөс олсоор оосорлочихсон том чулуу салтаандаа хавчин орж байв. Тэр чулууны хүчээр усны ёроолд түргэн зуур бууж ирж байлаа. Барагцаалбал таван метрийн гүнд орж ирээд чулуугаа орхин дөрвөн хөллөхийн сацуу барьж яваа тороо л гар дороо дайралдсан хясаагаар дүүргэхийг оролдож бүлгээ. Дараа нь дээшээ гарч торон доторхи юмаа завиндаа хоосолсны сүүлд мөн чулуугаа дээш нь татан авч, түрүүчийнхээ хийснийг дахин давтаж байв. Усан доор орж ирэх бүрдээ гучин секундээс илүүгүй удаж байлаа.

Бидний тэнд байхыг усанд шумбагч ажиггүй ажээ. Түүнээс биднийг хадны сүүдэр халхалж байв.

Ер нь ч өөртэй нь адилхан хүн гэдэг амьтан, усан доор хажууханд нь зогсож өөрийнх нь хөдлөх бүрийг ажиг байна гэсэн бодол хөөрхий загасчны толгойд хэрхэн орж болох билээ.

Тэр хүн олон удаа шумбаж, олон удаа буцаж бүлгээ. Шумбах бүрдээ арваас хэтрэхгүй хясаа түүж уутлах бөгөөд уул хясааг бас авцалдаат бат бэхлэгдсэн сууринаас нь ховхлох хэрэгтэй байв. Тийнхүү амь насаа даатган байж авсан хясааны нь хэд нь хоосон байдаг гэж санана!

Би шумбагчийн хойноос тун их анхааралтай ажиг байв. Тэр тогтмол нэгэн хугацаанд шумбан орж буцаж гарах ажээ. Түүний ажилд хагас цагийн турш юу ч саад болсонгүй ээ.

Амь зуух сонирхолтой ажлын хойноос ширтэн ширтсээр тэр хөөрхийд заналхийлж болох аюулыг би таг мартан, гөлөрчихсөн байтал тэр хөөрхий гэв гэнэт айж хөл дээрээ үсрэн босч, хөвж гарахын тул усны ёроолоос огло, үсрэн дүүлэхийг харав.

Түүний айсны учрыг би сая мэдвэл хөөрхий тэр муу усчны толгой дээр аврага том амьтны сүүдэр жирэлзсэн байв.

Тэр бол түүний өмнөөс нүдээ гялалзуулан, амаа ангайж ирж явсан асар их биет аврага загас байлаа.

Би айж сүрдсэндээ өчүүхэн ч хөдлөх тэнхээгүй, мод мэт хөшилдчихөв.

Хомхой араатан хөөрхий муу загасчин руу шууд дайран орлоо. Нөгөөтөх нь хажуу тийшээ бултаж ангайсан амнаас нь зайлж чадсан боловч цээжин дундуураа гуядсан бүдүүн сүүлнийх нь аймшигт дэлсэлтээс зайлж чадсангүй учир эгшин зуур онхолдож явчихлаа.

Энэ бүхэн хэдхэн секундийн дотор болж өнгөрлөө. Аврага загас ар нуруугаараа эргэж, индус хүнийг нэг уухаж хоёр хуваахаар дайран иртэл миний хажууд зогсож агсан капитан Немо гартаа хутга авч, гайхлыг угтан эрс шийдэмгий алхахыг би гэнэт

харав.

Одоо ч гэсэн би тэрхүү аймшигт тулалдааныг нэгд нэгэнгүй бүгдий нь сайн санаж байна. Тэхэд капитан Немо газар зоогдсон мэт бат зогсож, аврага загасны ойртон ирэхийг гайхмаар тайван сэтгэл амгалан хүлээж билээ. Нөгөөдөхийгээ довтлон орж ирмэгц тэр хажуу тийшээ ер бусын хөдөлгөөнөөр нэн шаламгай огло харайн зайлж хутгаа ишинд нь тултал гэдсэнд нь шааж орхив.

Тэгэвч энэ бүхэн үүгээр төгсгөл болсонгүй ээ. Зөвхөн л үүгээр л тулалдаан дөнгөж эхэлж байсан юмсанжээ.

Аврага загас манай хэлээр бол дүрсэлж ярихад, ёстой л аймшигтай түрхэрч билээ. Түүний шархнаас цус сад тавилаа. Ус бидний эргэн тойронд тунгалаг бус улаан өнгөөр өтгөрч будагдсан тул би цаашид юу болсныг харахыг байлаа.

Зөвхөн хэдхэн эгшин өнгөрсний дараа ус жаахан шингэрч ирэхэд зоригт капитан аврага загасны сэлүүрээс зуугаад, түүнтэй ач тач үзэлцэж гэдэс гүзээгүй хутгалж байхыг би үзсэн бөгөөд тэр зөвхөн л сүүлчийнхээ шийдвэрлэх цохилтыг буюу зүрхэнд нь хутгалчих амжилтыг олохгүй байв. Аврага загас амь тавин гулилзаж, усыг тэр чигээр нь тээрэмдэж агсан тул би арай чуу л гэж хөл дээрээ тогтож байв.

Би капитанд туслахаар ухас хийхийг завдсан боловч айсандаа болж зогссон газраа хадагдчихсан хүн шиг нэг ч алхам урагшаа хөдөлж чадсангүй.

Тулалдагчдын байдал өөр болж буйг би харж сэтгэл өвдөн хайрлаж зогсов.

Капитан өөр рүүгээ түрж ирсэн аврага загасны асар том биенд дарагдаж газар ойчлоо. Аврага загасны аймшигт том ам ангайж ирэхэд хэрэв л энэ хэрэгт Нед Ленд өөрийн биеэр оролцож хутгалдаагүйсэн бол нэгхэн секундийн дараа капитан Немо амь настайгаа буй бүх тооцоогоо хийж, нэгмөсөн дуусвар болох байсан билээ.

Канад хүн хүний бодол, сэтгэхүй мэт хурц хурдан хөдөлгөөнөөр аврага загас руу дайран орж, өөрийн жадны ташуу хурц үзүүрээр түүнд аймшигт цохилт өглөө.

Цусны шинэ урсгалд ус дахин булингартаж аврага загасны сүүлийн амь тэмцсэн дэлсэлтэнд улаанаар эргэлдэж явчихав. Гэвч Нед Ленд алдаж жадалсангүй ээ. Түүний жад уул араатны гол зүрхэнд тусчээ.

Энэхэн хэсэг бол үхэж буй амьтны эцсийн туйлалт байв. Тэр гайхлын татваганах хөдөлгөөнд дэгдсэн долгио нэн ширүүн агсан тул Консель бид хоёрыг ташиж унагасан бүлгээ.

Энэ үед Нед Ленд капитаны босоход туслалцаж байв. Тулалдаанд нэг ч шалбархай олоогүй тэр хүн хөл дээрээ босмогц, тэнд хэвтэж буй индус руу гүйн очиж, хөлд нь уяатай агсан чулууны оосрыг тас огтлоод, түүний мэдрэлгүй болсон

биеийг тэврэн авч, ёроолын хөрс рүү нэгэнтээ тийрмэгц далайн дээр хөвөн гарч явчихлаа.

Бид гурав ч гэсэн түүний хойноос дагалдан дээшээ хөөрч хэдхэн секундйн дараа бүгдээр загасчны завин дээр авиран гарсан бүлгээ.

Капитан Немогийн анхны сувилгаа бол хөөрхий түүнд ухаан оруулах арчилгаа байв. Аврага загастай тулалдсан тулалдаан дөнгөж хэдхэн секунд үргэлжилсэн тул тэр индус усан доор төдий л удаан байгаагүйгээс түүнд үзүүлэх тусламжийг оройтоогүй гэж үзэж болох байв. Гэтэл нөгөө талаар авч үзвэл түүнийг аврага загас сүүлээрээ нам цохисон байж болох юм.

Аз болоход, тийм хэрэг болсонгүй тул Консель, капитан Немо хоёр шуурхайлан илсний үрээр живсэн хүний ухаан аажимдаа наашилж бүлгээ.

Тэр өөрийнхөө халз дээрээс тонгойж буй асар том дөрвөн зэс толгой үзчихээд түүний гайхсан ба түүгээр ч барахгүй айсан нь хэдий хэр байсан бол!

Капитан Немо бүснээсээ өөрийн ууттай сувдаа тайлан авч амь аврагдагчид сарвайв. Усны хүний тэрхүү сайхан бэлгийг Сингааль орны хөөрхий тэр муу ядуу индус чичирч салганасан гараараа айж мэгдсээр хүлээн авлаа. Тэнгэрээс гэнэт унасан тэр их баялгийн хариуд, тэхэд бас амь насы нь аварсан ямар сүрхий тэнгэр дээдэст, чухам хэнд хожим хойно ачлахаа мэдэхгүй айсан, гайхсандаа аль ч учраа алдчихсан байдал түүний царайнд үг хэлэхийн хэрэггүй танигдаж байв.

Капитан Немогийн дохиогоор бид завинаас бууж далайн сувдат ёроолд эргэн ирээд хагас цаг явсны дараа “Наутилус”-ын завь аргамжаатай байсан занганд ойртон ирлээ. Бид онгоцон дотроо ормогц далайчдын туслалцаатайгаар хүнд төмөр дуулганаасаа суллагдацгаав. Капитан Немо:

- Баярлалаа танд, Нед гуай? хэмээн хамгийн түрүүнд Нед Лендэд хандаж билээ.

- Зүгээр, капитан минь-хэмээн Канад эр хариу өгүүлээд зөвхөн л би танд ачий тань хариулсан минь тэр дээ гэлээ.

Тэхэд капитан Немогийн царайнд муухан инээмсэглэл гүйлэгнэсхийж, хамаг хэрэг түүгээр дууслаа.

- “Наутилус” руу хэмээн тэр захирлаа. Завь ч давалгаан дээгүүр сум шиг хурдлан одой. Хэдхэн минутын дараа бид аврага загасны хөвж яваа хүүрийн дэргэдүүр өнгөрлөө. Түүний шонтгор шовх хоншоор бараг нурууныхаа сэлүүрт хүрэхээ шахсан цээжний нь хадуур маягийн урт сэлүүр, гэдэсний нь цагаан, нурууны нь үнсэн саарал өнгөөр би, жинхэнэ аврага загасни язгуурын хамгийн аюултай дүрсийн нэгэн болох цэнхэр аврага загас мөн гэж танилаа.

Алагдсан араатныг Консель, жинхэнэ шинжээч хүний нүдээр шохоорхон харж байсан болохоор, энэ минутанд тэр, уул аврага загасыг мөгөөрст загасны доод анги, жинхэнэ аврага загасны язгуур, цэнхэр аврага загасны дүрсэнд өөрөө санаандаа хамааруулж байгаад би итгэж байв. Үнэхээр ч тийм болохоор түүний зөв буйзаа.

Хөвж яваа тэр үхдэлийг би сонирхон харж байх зуур түүний төрлийн зургаан тооны хомхой махчид завины дэргэд гэнэт буй болохыг олж үзлээ. Тэд. биднийг өчүүхэн ч юманд бодсонгүй харин өнөө цэнхэр аврагын хүүр рүү довтлон орж, хугачин тасчиж бие биеэсээ булаацалдан байв. Найман цаг хагаст бид, “Наутилус”-таа эргэж ирэв. Би өрөөндөө орж ирээд өнөөдрийн болж өнгөрсөн бүх явдлыг санаандаа сэргээхээр оролдлоо. Тэдгээрээс хоёр янзын дүгнэлт хийж болох байв. Үүнд: Нэгдүгээрт: Эр зоригийн талаар капитан Немотой мөр зэрэгцэх хүн гэж байсангүй ээ, Хоёрдугаарт: - Тэр үзэн ядах өөрийн үзэл, хүн төрөлхтнөөс зугатан далайн ёроолд ороод тэдгээрийн үзэн ядах өөрийн үзлийг харгалзахгүйгээр хамгийн түрүүнд дайралдсан ядуу зүдүү хүний төлөө амь насаа өхөд ч бэлэн ажээ.

Энэ нэгэн хачин хүн аман дээрээ юу ч гэж ярьж байсан энэрэх нигүүлсэнгүй чанараа, өөрөө өөрийгөө нэгмөсөн үгүйсгэж чадсангүй ээ. Тэр тухайн нь би түүнд хэлэхэд капитан надад:

- Тэр бол, профессор минь, дарлагдсан орны нэг муу иргэн байлаа шүү дээ. Би өөрийнхөө эцсийн амьсгалаа хүртэл дарлагдагсдын талд байх болно. Дарлагдаж зовсон хэн бүхэн миний ах дүүс байсан ч юм, байгаа ч юм, байх ч юм гэж сэтгэл нь мэдэгдэхүйц хөдөлсөн байдалтай хариулж билээ.

[Тор](#)

---

## УЛААН ДАЛАЙ

Нэгдүгээр сарын хорин есөнд өдрөөр Сингааль тив нүднээс далд орж, “Наутилус” Мальдивийн арлуудыг Лаккадивийн арлуудаас тусгаарлаж буй хоолойнуудын толгой эргэм олон голдрил дунд нэн их хурдтай давхин одов. Бид Киттан хэмээх шүрэн арлын дэргэдүүр явж өнгөрсөн бөгөөд энэ арлыг 1499 онд Васко да Гама нээжээ. Энэ арал умарт өргөргийн 10 хоног О хувь, 14 хоног 30 хувь ба дорнот уртрагийн 69 хоног О хувь, 50 хоног 72 хувьд орших Лаккадивийн ольтригийн арван есөн том арлын нэгэн нь бүлгээ.

Энэ хэр усан доогуур явагч манай хөлөг анх Япон далайгаас хөдөлсөн цагаасаа хойш арван зургаан мянга хоёр зуун хорин миль явжээ.

Дараачийн нь өдөр, нэгдүгээр сарын гучнаа, "Наутилус" далайн дээр хөвөн гарахад хуурай газар хэдийнээ үзэгдэхгүй болжээ.

Одоо манай хөлөг умар-өрнө-умар зүгийг барьж, Персийн буланд явж орох аман дээр нь байгаа Арабын ба Энэтхэгийн хагас арлын хооронд орших Оманы буланг чиг- лэж явав.

Капитан Немо биднийг хааш нь аваачна вэ? Энэ асуултанд би энэ тухай надаас үргэлж шалгаагаад байгаа Нед Лендэд хариулж үл чадсанаар үл барам өөрөө өөртөө хариулж ч чадахгүй байв.

- Найз минь бид, капитан Немо хаашаа л харна тийшээ л явж байна гэж би түүнд хариу өгч билээ.

- Энэ ч бидэнд төдий л сайн юм болохгүй биз гэж би зовж байнам хэмээн Канад хүн өгүүлж-Персийн булан ганц л орцтой бөгөөд тэр орц нь мөн гарц болдог тул хэрэв л бид тийшээ орж очвол эргээд л түүгээрээ гарахаас өөр замгүй болно гэв.

- Яахав тэгвэл эргээд л түүгээрээ гарчихна биз. Хэрэв Персийн булангийн дараа наптан Немо Улаан далайд орохыг хүсвэл Баб-эль -Мандебийн хоолой түүний онгоцыг оруулахад хэзээд бэлхэн байна.

- Эрхэм профессор надаас дооргүй мэдэж байгаа. Улаан далай гэдэг чинь яг л Персийн булан шиг усны битүү хаалттай сав шүү дээ хэмээн Нед Ленд татгалзаж-Тэгвэл Суэцкий суваг чинь ухагдаж арай дуусаагүй болохоороо, "Наутилус" мэтийн хөлөг онгоц, түүний нрээдүйн усны боомтын хоосон тогоонуудыг дамжиж нэвтэрч ер чадахгүй. Үүнээс үзвэл Улаан далай биднийг Европт хэрхэвч ойртуулж чадаагүй дэг гэв.

-Бид Европт ойртож байна гэж би танд хэлээгүй шүү дээ.

- Тэгээд та юу гэх гээ вэ?

- Миний бодлоор бол "Наутилус" Араб, Египетийн эрэг орчныг угааж буй усыг тойрч үзээд Энэтхэгийн гадаад далайд дахин хөвж одох буйзаа. Тэгээд эсхүл Мозамбикийн хоолойгоор эсхүл, Маскаренскийн арлуудын дэргэдүүр гарч Сайн итгэлтийн хушуу хүрэх бизээ.

- За яахав, тэгж гэж бодъё хэмээн Нед Ленд бас л цааш нь үргэлжлүүлэн шалгааж-Сайн итгэлтийг хүрдэг л байж, тэгээд цааш нь хаачих вэ? гэв.

- "Наутилус" тэр хушуу тойрмогц бид өдий хүртэл очиж үзээгүй Атлантын гадаад далайд л орно биз. Нед найз минь чи ингэхэд ер нь үнэнээ хэлчих. Үнэхээр таныг

усам доорхи ертөнцийн энэхүү эцэс хяэгааргүй агуу гайхамшиг залхаачихлаа гэж үү? Миний хувьд бол энэ сайхан жуулчлалын эцсийн цэг ирэх юм гэхэд үнэндээ би гүнээ сэтгэл гажих болно. Үүнийг бушуухан дуусаасай гэж нэг ч хүн хүсэхгүйдэг шүү.

- Үгүй ээ, эрхэм профессор минь та, энэ нэгэн усан доогуур явагч хөлөг онгоцонд бид олзлогдоод даруй бүтэн гурван сар болж байгааг мартчихлаа гэж үү?

- Түүнийг би санахгүй байна, Нед мнн. Санахыг ч хүсэхгүй “Наутилус” дээр өнгөрч буй нэг хоногийг ч би тоолохгүй байна шүү.

- Тэгээд энэ чинь юу болж төгсөх юм бэ?

- Дуусах цаг нэг л ирнэ! Тэхэд бид дуусах тэр цагий нь түргэтгэж чадахгүй байж хий дэмий л мэтгэлзэх юм. Тэрэнд орвол мнний зоригт найз Нед минь, та над дээр хүрч ирээд: “Оргох завшаан одоо л нэг гарлаа” гэж хэлбэл тэр зантай дуртай зөвлөн аврагдах аргаа эрхсэн билээ. Гэтэл тийм аятай завшаан одоохондоо алга. Ний нуугүй хэлэхэд капитан Немо хэзээ нэгэн цагт Европ орчны далайд явж орохыг зориглоно гэдэгт би төдий л итгэхгүй байна.

Эдгээр товч ярианаас авч үзвэл би “Наутилус” ба түүний хачин капитан хоёрыг бишрэн шүтэгч, зөн билгийн эзэн болжээ. Нед Лендийн хувьд бол тэр:

- Энэ бүхэн ч үнэн л дээ, гэлээ ч гэсэн минийхээр бол хаана албадлага хавчилга байна, тэнд амар заяагаа үзэхгүй нь лав буйзаа гэж уул яриагаа дуусгалаа.

Дараачийн дөрвөн өдрийн турш, нэгдүгээр сарын гуравныг хүртэл “Наутилус” Оманы буланг хөндлөн гулдгүй хэрж янз бүрийн хурдтайгаар, янз бүрийн гүнд орж гаран явлаа.

Тэр явах жинхэнэ замаа олж аваагүй хар таамгаар л явж байх мэт боловч Ракагийн халуун бүсийг эдгээр өдрүүдэд нэг удаа ч хөндлөн огтолсонгүй ээ.

Энэ далайг орхиж одохын өмнө бид Оманы гол хот Маскатын барааг хэдэн минут хэр харж билээ. Би тэр хотын цав цагаан байшингийн цаана байгаа падан хар дэвсгэр дээр тодорч буй бэхлэлт зэрэг үнэхээр чухаг тохиолдох үзэсгэлэн төгөлдөр зүйлүүдийг үзэж сэтгэл уярч бүлгээ.

Би тэндхийн сүмүүдийн бөмбөгөр орой, гозгор ганжир нялх ногоо битүү бүрхсэн довжоолсон ташуу энгэр газар зэргийг харж нэн сонирхлоо.

Гэвч, тэр сайхан зүйлс удсан ч үгүй алга болсон нь “Наутилус” эргэлдсэн хар усны гүнд живж орсон билээ.

Дараа нь манай хөлөг хуурай газраас зургаан миль зайтай хөвж Арабын эргийн дэргэдүүр, Гадрамаутын хажуугаар мөн эрт дээр үеийн балгаснууд хаа нэг харагдах намхан уулсын хөвөлзсөн энгэр орчны ойролцоо давхин өнгөрөв.

Ингээд бид хоёрдугаар сарын таванд Энэтхэгийн гадаад далайн ус Улаан далай руу юүлэн ордог, Баб-Эль-Мандебийн хоолойд яг л цорго мэт лав суусан Адены буланд явж орлоо.

Хоёрдугаар сарын зургаанаа “Наутилус” далай дээр хөвж гарахад эх газартайгаа нарийхан хүзүүвчээр залгагдсан Адены хушуун дээр байдаг Аден хотын бараа харагдав.

Байгалийнхаа гадаад байдлаараа ёстой л Арабын Гибралтар болсон Аденыг анх 1839 онд англичууд эзлэн авч одоо хэрхэвч нэвтэршгүй бат бэхлэлт болгон хувиргажээ. Би алс холоос тэр хотын сүмийн найман талт оройг үзсэн бөгөөд түүхч Эдридийн үгээр, энэ хот хэзээ нэгэн цагт тэр хавийнхаа эрэг орчинд хамгийн баян, хамгийн их хөл хөөртэй болсон худалдааны том төв байжээ.

Адены тэндээс капитан Немо “Наутилус”-ыг шууд гэдрэг эргүүлнэ гэж би бат итгэсэн минь эндүүрэл болжээ.

Тэхнээ маргааш өдөр нь хоёрдугаар сарын долоонд бид Баб-Эль-Мандебийн хоолой руу орж явчихав. Тэр хоолойн нэр Араб хэлээр “Нулимсын үүд” гэсэн үг ажээ. Хоолойн урт нь дөнгөж тавин хоёр километр бөгөөд хар хурдаараа довтолж буй “Наутилус” түүнийг цаг хүрэхгүй хугацаанд явж өнгөрлөө. Гэвч далайн дээрэм Адены ноёрхлыг батжуулах зорилгоор англичууд эзлэн авсан Пермийн арлуудын эргийг би ядаж үзэж чадсангүй ээ. Суэцийн хүзүүвчийг бамбай, Калькутта, Мельбурн, Ариун Маврикийн арлуудтай холбодог Англи, Францын дэндүү олон онгоц уул хоолойн усыг хэрэн хэсүүчлэх тул “Наутилус” далайн дээр ил гарч болохгүй байв. Тиймээс бид цаг үргэлж далай доогуур хөвж билээ.

Ингээд бид үд дундын хэрд Улаан далайн уснаа сая нэг орж очлоо.

Улаан далай! Түүний гадаргуу дээр уулс хэзээ ч үл хуралдаж, дусал ч ус үл унагана! Түүний гүн цэнхэр тэнгэр хэзээ ч хэрхэвч үл бүрхэнэ! Нэгхэн ч томхон гол түүнд үл цутгана! Галдам халуун наран, түүний гадаргуу дээрээс жил тутам метр хагас зузаан ус ууршуулан авч одно.

Хэрэв л энэ нэг хачин тохой тэнгисээс холдон тасарч нуур болон хувирсансан бол хэдийн хатчихсан байхсан.

Улаан далай хоёр зуун дөчин километр өргөн хоёр мянга зургаан зуун жаран километр урт юмаа. Птоломейн хаад ба Римийн эзэнт улсын үед Улаан далай дэлхий дахины худалдааны гол судас болж байв.

Суэцийн сувгийг тавих явдал энэ далайд урьдынх нь алдрыг эргүүлж өх болно.

Капитан Немогийн ямар зан нь хөдлөхөөрөө түүнийг энд хөвж ирснийг би

мэдэхийг ч оролдсонгүй бүлгээ. Гэвч “Наутилус” энд хүрч ирсэн явдалд би хэмжээгүй баярлаж байв.

Бид одоо урьдаас ирж яваа онгоцтой зөрөхийн тул заримдаа ил гарч, заримдаа далд орон жигдэрсэн хурдтайгаар явсан бөгөөд тийм ч учраас би энэ усны сонирхолтой савтай ойр дотно танилцах бололцоог олсон юм.

Хоёрдугаар сарын наймны өглөөний нарнаар бид өмхөрч өгөршсөн хана туургаа зөвхөн л буун дуунаар нурж унах болчихсон Мекка хэмээх хуучирсан хотын эвдэрхий балгас байхыг олж харав. Эвдэрсэн хэмхэрхий хана хэрмийн дунд финикийн дал молод үндэслэн, сайхан цэцэглэж байлаа. Дээр үед тэр нэгэн цагт Мекка хот зургаан том зах зээлтэй, хорин зургаан дуган сүмтэй, хотоо гурван километр холуур тойрч бүсэлсэн арван дөрвөн усан буудалтай байжээ.

“Наутилус” Африк тивийн эрэгт ойртон ирэхэд далай энэ орчинд гүнзгийрч байв. Тэнд усны гүнд шумбан орж, усан доорхи хаддыг битүү бүрхсэн замгийн сахлаг ногоон хивс, фуклууд, ув улаан шүрэн биетний сэтгэл булаам үзэмжит бут зэргийг үзэж сонирхоцгоов. Ливийн эрэг орчинд ойролцоо буй усан доорхи шүрэн биетэн ба арлууд ямар сайхан гойд үзэсгэлэнтэй вэ? Гэвч усан доорхи байгалийн үзэмжний гойд сайхан нь болон олон төрөл нь “Наутилус” төдөлгүйхэн ойртож агсан дорнод эрэг орчинд байж билээ. Тихамын дэргэд ургаа амьтад зөвхөн усан доор байгаад зогссонгүй, харин өөрсдийн үзэсгэлэн төгс сайхан сүлжилддэг далайн усан дээр хэд хэлэн метр өндөрт ил гаргасан байв. Үнэндээ усан дээр ил гарсан зоофитуудийн өнгө усан доорхиосоо муухан байж билээ.

Үзэсгэлэн танхимын гэгээвчний дэргэд би сууж хичнээн ч олон мартагдашгүй сайхан цаг өнгөрөөсөн гэж санана: Түүнчлэн бас цахилгаан чийдэнгийн гэрэлд би усан доорхи ургамал амьтны хичнээн олон шинэ шинэ төрлийг олж харсан гэж санана. Үүнд: Аппендикуляр сальп, аспидийн өнгөт актинийн бүлэг бүлгээрээ ургасан тоо томшгүй олон хясаа, бас одоо хүртэл би анги төрлий нь хаана ч олж үзээгүй мянга мянган дүрсийн хөвөн биетэн зэргийг олж үзсэн бүлгээ.

Хөвөн биетэн бол ургамал бишээ. Тэдгээрийг зарим байгальчид одоо хүртэл ургамал хэмээн үзэж иржээ. Гэтэл энэ бол хөндий биетэн буюу өөрөөр хэлбэл шүрэн биетнээс доорд шатанд ангилагдах бүдүүлэг амьтан бүлгээ.

Хөвөн биетнийг амьтны аймагт хамааруулан үзэх нь нэн зүйтэй бөгөөд эртний зарим эрдэмтдийн жишээгээр тэдгээрийг ургамал ба амьтны аймгийн хоорондын ямар нэгэн ертөнцөд хамааруулан үздэг талаар ярихын ч хэрэггүй билээ.

Байгальчид одоо хүртэл хөвөн биетний биений зохион байгуулалтын талаар



нэгдсэн нэг санаа үгүй гэдгийг би бас дурдах ёстой.

Заримынх нь саналаар бол эдгээр нь нэн бяцхан үй олон амьтдын нэг дор бөөгнөрсөн бөөгнөрөл гэжээ. Би нөгөө хэсгийн нь санал мөн түүнчлэн Мильн-Эдвардсын саналаар бол хөвөн биетэн тус бүрийг бие даасан тусдаа амьтан гэж үзнээ.

Хөвөн биетний анги хэд хэдэн мянган дүрсийг багтаана. Хөвөн биетэн бүх тэнгист мөн зарим нэгэн гол мөрөн, нууруудад оршдоог. Тэд ихэвчлэн Газрын дундад ба Грекийн далайн Сирийн эрэг орчинд болон Улаан далайд элбэг байна. Энэ орчинд голчлон Сирийн тунгалаг бор өнгийн, эмзэг зөөлөн болон нэг ширхэг нь бүтэн хагас франк хүрдэг триполитаны хөвөн биетэн тохиолдоно.

Бид бүхнийг Суэцийн хүзүүвч ойр дорнотоос тусгаарлаж байсан тул тэнд дахин очиж тэндхийн хөвөн биетэнтэй танилцах найдваргүй болсон учраас би Улаан далайн хөвөн биетэнг ч судлах ажлыг нэн шуурхай хийлээ.

“Наутилус” найм, мөн есөн мянган метрийн гүнд, хад цохио болсон дорнот эргийн дагуу аажимхан хөвж байх үед би Конселийг дуудан ирүүлж бид хоёр онгоцны гэгээвчийн дэргэд зэрэгцэн суулаа.

Тэнд модны гол маягийн, навч маягийн, бөмбөг хэлбэрийн, савар маягийн гэх мэтчилэн бүх төрлийн хөвөн биетэн цэцэглэж байв. Тэдгээрийн гадаад хэлбэр ёстой л өөрсдийнхөө нэр хочинд яг зохицож сагс шиг, хундага шиг, ээрүүл шиг, арслангийн савар шиг, тогосны өд шиг, Нептуны савар шиг хэлбэртэй байх нь тэдгээрт шинжлэх ухааны үүднээс тийнхүү нэр өгсөн биш, харин нилээд шог шүлэгч нэг нь дамшигласан мэт ажээ.

Хөвөн биетний мяндаслаг нялцгай биед гэвшрэн унжирсан шингэн бодис амьдралыг хадгалж буй эс тус бүрийг дор дор нь нарийхан зурвас шүүслэг эдээр тасралтгүй хооллоноо. Эс нь тэжээл авмагц өөртөө байсан илүүдэл усыг түлхэн гаргадаг байна. Тэрхүү унжирсан бодис уул амьтны үхсэний дараа үгүй болж задрахдаа намгийн хий буюу аммиак ялган гаргах бөгөөд уул амьтнаас зөвхөн л нар салхинд шарлан ганддаг шөрвөслөг эд үлдэж бат бэх, уян хатан, ус үл нэвтрүүлэх зэрэг чанараасаа хамаарагдаж янз бүрийн зүйлд ашиглагдана.

Хөвөн биетэн хад чулуунд зөөлөн биетний дун бүрхүүлд түүгээр ч барахгүй ургаа амьтдын биенд наалдан ургадаг юм.

Тэд яг л шүр биетний нэгэн адил хад чулууны өчүүхэн боловч завсар заалхайг бөглөж хаданд буй хонхор тус бүрийг дүүргэн өргөөшөө хавтайж, өндрөөшөө шовойж доошоо дүүжилж янз бүрээр ургана.

Эдгээр хөвөн биетнийг хүмүүс шүүрдэх буюу гараар түүх замаар цуглуулж авдаг хэмээн би Консельд ярьсан бөгөөд тэдгээрийг гараар ургасан сууринаас нь ховхолж авах нь сайн арга хэмээн үзэцгээдэг гэлээ. Усанд шумбагчид тэдгээрийн эд эсийг гэмтээхгүйгээр нэн болгоомжтой нямбай түүдэг ажээ. Тэгвэл тусгай багажаар шүүрдэж авах нь ашиг муутай ажээ.

Хөвөн биетнийг тойрон бужигнаж буй бусад төрлийн зоофитуудийн дотрсос медуз “далайн мөөг” байсан нь маш гоёмсог өнгө хэлбэрээрээ онцгой байв Энд зөөлөн биетний дотроос кальмарууд, мөлхөгчдийн дотроос яст мэлхий байх нь бид мөн тэр өдөртөө махы нь амтархан идсэн шөлний буюу яст ногоон мэлхмий байж бүлгээ.

Эндхийн загас гэдэг тоймгүй олон ажээ. Эдгээр өдрүүдэд “Наутилус”-н торонд. ердийн нэгэн шүүлтээр, скатууд орсон байсны дотроос жигнэвэл арван хоёр орчим килограмм болдог метр хагас өргөн далбагар хэмжээтэй далайн бүргэд буюу бүргэдэн скат, нүдэн дээрээ эвэр мэт урт өргөстэй дөрвөн талт ясан хуяг бүхий эвэрт кузовка, урдуураа тод шар. хойгуураа хүрэвтэр, дээгүүрээ бараан хар гантиг мэт маш хээнцэр гуа өнгөтэй бие бүхний могой загасны язгуурын мурен хэмээх араатан загас, хар ба хүрэн цагираг бүслүүртэй шар өнгийн карат загасны язгуурт багтах эвэрт занкууд, хар бараан судал бүхий тод улаан өнгөтэй колбинещукийн язгуурт хамаарагдах присоскууд болон бусад олон төрлийн загас баригдсан ажээ. Энэхүү сүүлчийн присоскууд ур маягийн мөгөөрслөг сөрөх аппаратаар хангагдсан нь тэд хад чулуу болон амьтны дун бүрхүүлд түүнийхээ хүчээр маш бөх бумбадан тогтож дайснаас биеэ хамгаалах буюу бусдыг дайран довтлохын тул биеэ хураадаг байна. Торонд орсон бусад олон загасыг бид өөр далайнууд дээр үзсэн билээ.

Хоёрдугаар сарын еснөө “Наутилус” баруунаа Суакин, зуунээ Йемен хоёрын хооронд, Улаан далайн хамгийн өргөн хэсэгт хөвж явлаа.

Үд дундын хэр капитаны туслах ажиглалтаа хийж гүйцсэний дараа капитан Немо онгоцны тавцан дээр байсан над дээр ирж хамт зогслоо.

“Наутилус”ыг тэр чухам хааш нь авч явааг хэлүүлэхээс нааш түүнийг би тавихгүйгээр шийдэв.

Гэтэл капитан Немо намайг хармагцаа над руу шууд хүрэлцэн ирж янжуураар зочлоод:

- Улаан далай таны сэтгэлд нийцэв үү, профессор гуай? Бодвол та түүний загас, хөвөн биетэн, шүр биетэнгийн битүү шугуй зэргийг харж ханаа бизээ? Бас түүний эргийн дагуу байх хотуудыг хараа биз дээ? гэж асуулаа.

- Харлаа капитан, тун их баярлалаа. Энэ бүх бололцоог “Наутилус” л над олголоо

шүү. Юутай нарийн ухаантай хийсэн онгоц вэ!

- Тиймээ профессор минь, ухаантай ч, зоригтой ч, учиртай ч хийсэн гээч? Миний онгоц Улаан далайн аймшигт шуурга, хүчит урсгал, далд хаддаас хэзээ ч айхгүй!

- Үнэндээ ч энэ далай хамгийн аюултай далайнуудын нэг гэгддэг юм шүү. Хэрэв би эндүүрээгүй бол эрт үеэс авахуулаад муу нэртэй байсандаг аа гэж би хэлэв.

- Нээрээ ч эрт дээр үеэс эхлээд бузар муу нэртэй байсан юм. Грекийн түүхчид, тэгээд ч бас Римийнхэн ч гэсэн үүний тухай муу юм ярьдаг юм. Страбоны хэлснээр бол энд хур бороотой болон умартын салхи ихтэй цагт тун зочломтгой бус гэдэг.

Арабын түүхч Эдриди, үүнийг Кользумын булан гэж нэрлээд, энд үүний элсэн хаялга дээр хөлөг үй олноороо сөнөдөг шөнийн цагт үүгээр хэн ч аялахаас айдаг гэж ярьдаг. Түүний хэлснээр “энэ далай нэн догшин аймшигт шуургатайгаараа цуутай, түүнчлэн ааш муутай арал хойг олонтой. Усан дээрээ ч гэсэн дороо ч гэсэн дур сонирхлыг татахаар юм юу ч үгүй” гэдэг. Түүний сэтгэгдлийг Арриан, Агатархид Артемидор бас зөвшөөрдөг юм...

- Тэдгээр эрдэмтэн, түүхчин “Наутилус” дээр хөвөх хувьгүй байгаад л тэр байхгүй юу хэмээн би хэлчихэв.

- Таны түмэн зөв гээд капитан Немо инээмсэглэв. Гэвч энэ талаар яривал, орчин үеийн түүхчдийн байдал ч эртний түүхчдийнхээс төдий л сайнгүйдэг ээ. Тэгвэл ууранд байгаа механикийн хүчийг нээж олох хүртэл олон зуун жил шаардагдсан. Тиймээс хамаг ертөнцөд одоо дахиад нэг зуун жил болоход хоёрдугаар “Наутилус”-ыг үзэх эсэхийг хэн мэдэх юм бэ? Дэвшилт гэдэг, эрхэм профессор минь хэтэрхий удааширч байгаа юм бишүү гэв.

- Тэр үнээн, таны хөлөг бүтэн зууныг, за бүхэл бүтэн зууныг биш юм гэхэд өөрийнхөө эрин үеэс хол түрүүлж оджээ. Үүний тань нууц, зохиогчийнхоо хамт үүрд мөхөж одох гэдэг ямар азгүй вэ! гэж би хэлэв. Капитан Немо надад хариу дуугарсангүй ээ. Хэдэн минут таг дуугүй байснаа тэр дахин ярихдаа:

- Улаан далайгаар хөвөхөд хэр зэрэг аюултай болох талаар эртний түүхчдийн сэтгэгдлийг бид шүүмжлэн хэлэлцэж байсан байх аа?

- Тиймээ, тэдний болгоомжлолыг хэтэрхий даваадуулчихаж гэж та бодож байна уу? гэлээ би.

- Тийм ч үгүй ч эрхэм профессор хэмээн Улаан далайг бодвол орвонгоор нь судалчихсан капитан Немо надад хариулаад өөрийнхөө чиг замыг өөрийн дур зоргоор хэрэглэн чадах уурын хүчээр чөлөөтэй сонгон авч, сайн тоноглогдож бөх

баригдсан орчин үеийн хөлөг онгоцонд өчүүхэн ч бэрхшээлийг үл үзүүлэх тэр бүхэн эртний далайчдын хөлөг онгоцонд гэнэтийн санамсаргүй аюул хөнөөл учруулж байлаа. Далайн гахайн өөх, давирхай зэргээр нялагдсан дал модны олсоор үдэж бөхөлсөн тэдгээр банз модон хөлгүүдийг дүрслэн бодох хэрэгтэй! Тэдгээр баримжаалах ямар ч багаж хэрэгсэл байсангүй тул тэд далайн үл мэдэх урсгал дунд хар таамгаараа хөвж байв. Иймэрхүү нөхцөлд онгоцны сүйрэл гарахгүй байхын учиргүй бөгөөд энэ нь жирийн явдал болжээ. Гэвч манай энэ өдрүүдэд өмнөт тэнгисүүд Суэцийн суваг хоёрын хооронд явж буй онгоцнуудад Улаан далайн догшин шуурга, өөдөөс сөрөх халуун салхи ямар ч аюулгүй болжээ. Эдгээр онгоцоор жуулчлагчид болон мөн тэдний цэрэг дарга нар алсын аянд гарахын өмнө амь сүнсээ даатган өргөл барьц өргөхийн хэрэггүй болсон буюу эргэж ирснийхээ дараа ойр хавийн сүмд бараалхаж өршөөл нигүүлслэлийг хүртээсэн бурхан тэнгэрт бахдан бишрэхийн хэрэггүй болсон юм.

- Ай даа, далайчдын гол зүрхэн дэх бахдал бишрэл ч онгоцны ууртай хамт ууршин одож дээ хэмээн би хошигнож:

- Тэхэд, капитан та, энэ далайн намтрыг нэвтэрхий судалсан бололтой хүн тул чухам яачихаад үүнийг Улаан далай гэж нэрлэсэн тухай над хэлж өхгүй юу? гэв.

- Эртний хүмүүс, үүний зарим хэсэгт жигтэй улаан өнгөтэй тул тийнхүү нэрлэжээ гэж капитан хариулав.

Тэгвэл бид одоо хүртэл ямар ч будмал өнгөгүй зөвхөн л тув тунгалаг устайг үзэж байгаа биш билүү.

- Тэр үнээн. Гэвч, бид энэ булангийн мухар хэрд очиход ус нь улаавтар туяатай болохыг та үзэж үнэмших болно. Би санаж байна. Бид нэгэн удаа Тор гэдэг тохойд ус нь бүхэл бүтэн цусан нуур мэт харагдаж, час улайсан байхыг үзсэн.

- Яахаараа тэгж будагддаг юм бол? Маш бяцхан замгууд тийнхүү улайлгадаг юм бол уу?

- Тиймээ. Энэ час улаан өнгө бол нэгэн миллиметр шоо дөрвөлжин дотор дөчин мянган ширхэг нь багтдаг триходесмий хэмээх өчүүхэн ургамлаас шүүрдэг нялцгар шингэн бодис юм.

Бид, Торын тохойд очиход, та энэ нэгэн сонин зүйлийг нүдээр ч үзэж байж магад.

- Тэхээрээ та “Наутилус”-аараа Улаан далайгаар анх удаа явж байгаа нь энэ биш байх нь ээ?

- Анх удаа бишээ. Би Суэцийн сувгийг ухах ажил анх ахлахад энд ирсэн юм.

- Энэ суваг “Наутилус” мэтийн ийм хөлөг онгоцонд ямар ч ашиггүй л даа гэж би

хэпэв.

- Тэгэвч, дэлхий дахинд хэрэгтэй л дээ хэмээн капитан Немо хариулаад. Түүгээр ч барахгүй Улаан далай, Газрын дундат далай хоёр хоорондоо шууд харилцаатайг худалдааны хэрэгт асар их ач холбогдолтой гэдгийг эртнийхэн ч сайн мэдэж байсан юм шүү гэв. Гэвч, тэд далайгаас далай хүртэл зөвхөн л нэг суваг ухчихвал болох талаар ер бодсонгүй, харин Нил мөрний урсгалыг Улаан далайтай холбох хол тойруу зам сонгожээ. Тэрхүү Нилийн сувгийг барих ажил, зарим нэгэн мэдээгээр авч үзвэл Сезострисе хааны үеэс эхэлсэн юмдаг шүү. Юу ч л гэсэн, манай тооллоос өмнө 615 онд Нехо хаан, Нил мөрний усаар долгиолох сувгийн барилгыг Арабын зүг хандсан Египетийн нам дор газрыг дайруулан зохиож эхэлсэн нь магадтай юмдаг. Нил мөрнөөс Улаан далай хүртэл аялах энэ зам хөлөг онгоцнуудад дөрөв хоногийн газар байсан бөгөөд түүний өргөн нь зөвхөн хоёр хөлөг зэрэгцэн явах боломжтой байжээ. Уул сувгийн барилга Гистапе хааны хүү Дарийн үед үргэлжилж, бодвол II Птолемейн үед зөвхөн дууссан болов уу. Страбон хаан уул сувгийн ашиглагдаж байхыг нүдээр үзжээ. Гэвч сувгийн ус төдий л гүнзгий бус учраас Нил мөрний гүйхэд хальсан хаврын саруудад л түүгээр хөлөг онгоц явах бололцоотой байжээ. Тэр суваг Антотинуудын үед өөрийн үүргийг гүйцэтгэж байгаад, дараагаар нь элс шавар дарж хэрэгцээгүй болсон юм. Гэвч Халиф хаан Омарын зарлигаар дахин сэргээгдсэн боловч манай тооллоос өмнө 761 буюу эсхүл 762 оны урд өөрийн эсрэг босч тэмцсэн Мохаммед бей Абдуллахын цэргийн хүнс хоолыг тасалдуулахын тул Халиф хаан Аль-Манзор бүрмөсөн булж устгажээ. Бас Бонапарт генерал Египетийн эсрэг үйлдсэн аян дайныхаа үед тэрхүү сувгийн ор мөрийг Суэцийн дэргэдэх элсэн цөлд эрж олоод мөрний усны их түрэлтэнд автагдаж арай чамай амьд мэнд үлдсэн билээ.

- За яахав капитан минь. Кадиксаас Энэтхэг хүрэх замыг есөн мянган километрээр богиносгож, хоёр далайг холбох ажлыг эртнийхэн хийж чадаагүй юм бол одоо Лессепс хийчихнээ... Тэр хамгийн ахар богино хугацаанд Африк тивийг Азиас Суэцийн сувгаар тусгаарлаж асар том арал болгон хувиргах биз.

- Ганцхан л би танд Суэцийн сувгийг үзүүлж чадахгүй минь хайран байна. Гэвч бид Газрын дундат далайд явж ороход Порт Саидын урт эргийг та нөгөөдөр үзэх болно гэв.

- Газрын дундат далайд ий?

- Тиймээ, эрхэм профессор, юунд та тэгтлээ их гайхаа вэ?

- Нөгөөдөр бид тэнд байна гэж хэлсэн таны тэр үг намайг гайхуулчихав.

- Нээрээ юу?

- Нээрээ капитан минь. “Наутилус” дээр байгаа энэ явдал хэдийгээр юунд ч үл гайхах занг надад сургах ёстой мэт боловч үнэхээр гайхаж байна.

- Гэлээ ч энэ явдал яагаад таныг тэгж их гайхуулав?

- Нөгөөдөр биднийг Газрын дундат далайд хүргэж чадах “Наутилус” тэр, асар их хурд! үгүй ээ, энэ чинь манай онгоц Сайн итгэлтийн хушууг дайрч, Африк тивийг бүтэн нэг тойрох хэрэгтэй болж байна шүү дээ!

- “Наутилус” Африк тивийг бүтэн тойрно гэж танд хэн хэлээд орхивоо? Түүнийг Сайн итгэлтийн хушууны тэрүүгээр гарна гэж хэн хэлэв?

--Тэгвэл... хэрэв л “Наутилус” хуурай газар дээгүүр л гулгадаггүй юм бол, эсхүл Суэцийн хүзүүвч дээгүүр агаараар дэгддэггүй юм бол...

- Яагаад тэрэн доогуур чинь гарчиж болдоггүй юм эрхэм профессор гуай?

- Хүзүүвч доогуур уу?

- Тэгэлгүй яахав хэмээн капитан Немо тайван хариулаад – хүмүүс газар дээр тийм их хүч хөдөлмөр гаргаж байж хийж үйлдэж байгаа юмсыг, байгаль газар доор аль хэдийнээ хийчихээд байгаа юм гэлээ. Юу? Тэнд, тэр доогуур тэгээд нүхтэй юм гэж уу?

- Тиймээ, Арабын тоннель гэж миний нэрлэсэн нарийхан сүв байгаа юм. Суэцийн хүзүүвч доороос тэр эхлээд Порт Саидын дэргэд төгсч байгаа юм.

- Гэвч Суэцийн хүзүүвч чинь үүрмэг элснээс тогтдогсон биш шүү?

- Тэгэвч хязгаартай шүү. Тавин метрийн гүнд ганхашгүй бат боржин хана байдаг юм.

- Тэхээрээ энэ тоннелийг та санамсаргүй нээж олсон байх нь ээ?

- Нэг талаар ч санамсаргүй, нагаа талаар ч зориут нээсэн юм. Жич хэлэхэд энэ нээлтийн санамсартай нь санамсаргүйгээсээ илүү юм шүү.

- Би таны яриаг хичээнгүйлэн сонсьё капитан минь. Гэвч миний сэтгэхүй, чихэндээ нэг л итгэхгүй чинь юу билээ.

- Ай профессор та, юу хэлнэ. Чихтэй байгаад сонсох дургүй байх нь ч шинэ хуучин аль ч цагт адилхан шүү дээ! Тэр нэг нүх зөвхөн байгаа нь бодитойгоор барахгүй, би түүнийг хэд хэд ашигласан юм. Хэрэв тэр байгаагүйсэн бол би Улаан далайн энэ нэг мухарт орж ирэхгүйсэн шүү!

- Хэрэв би танаас тэр нүхийг хэрхэн нээсэн тухай тань асуучихвал миний зүгээс төлөв бус юм болохгүй биз?

- Эндээс хэзээ ч хагацан үл одох учраас нуугаад байх юм ч юу байх вэ дээ гэж капитан Немог хэлэхэд би энэ үгэнд нь чухам ямар учир бий болохы нь ойлгоогүй

царай үзүүлж капитаны яриаг сонсохоор чих тавилаа.

- Энд тоннель бий гэдэг бодлыг надад зөвхөн байгальч хүний сониуч зан, өрдийнхөө нэг зүй ёсны сэтгэмж л төрүүлсэн юм. Түүнчлэн Улаан ба Газрын дундат далай хоёрт нисдэг загас, алгана, судалт щетинозубы болон бусад төрлийн олон олон яг адилхан загас оршдогийг нь би ажсан. Тиймээ би энэ бүхэн хоёр далай хоорондоо харьцаатайг гэрчилж буй юм биш биз гэж өөрөө өөртөө асуулт тавьсан билээ. Хэрэв л тийм харьцах нүх сүв үнэхээр бий юм бол газар доорхи урсгал Улаан далайгаас, Газрын далай руу урсах ёстой. Учир нь Улаан далайн усны төвшин, Газрын дундат далайнхаас дээр байдаг юм. Энэ асуудлыг тайлбарлахын тул би Суэц, орчноос хэд хэдэн загас барьж суулэнд нь зэсэн горхи уяад буцааж тавьсан. Тэгтэл хэдэн сарын дараагаар Сирийн эрэг хавиас би өөрийн таних тэмдэг бүхий хэд хэдэн загас барьсан юм. Тийм болохоор хоёр далайн хооронд газар доогуур харьцах нүх зайлшгүй байгаа нь надад эргэлзээгүй болсон. Би тэр нүхийг нь өөрийн “Наутилус”-аар эрж эрсээр одсон бөгөөд дараа нь түүн руу онгоцтойгоо орж явчихыг зүрхэлсэн юм даг. Иймд ноён профессор та, хоёрхон хоногийн дараа Арабын минь тоннельтэй танилцах болно доо гэлээ.

[Тор](#)

---

## АРАБЫН ТОННЕЛЬ

Мөн тэр өдөртөө би Консель, Ленд хоёрт капитан Немотой ярилцсан ярианаасаа тэдэнд шууд хамаарах сонирхолт хэсгийг нь ярьж өгөв.

Тэдэнд би, хоёрхон өдрийн дараагаар бид Газрын дундат далайн усыг туулах болно хэмээн хэлбэл Консель алга ташин баясахуйд Нед Ленд харин зөвхөн л дал мөрөө хавчиж билээ.

- Усан доорхи тоннель ий? хэмээн тэр дуу алдаж - хоёр далай хоорондоо харьцлаа гэж үү? Ийм юм ерөөсөө хэзээ ч, хэнд ч дуулдаагүй! гэв.

- Нед найз аа? гэж Консель хариуд нь хэлээд - үүнээс өмнө хэзээ нэгэн цагт та “Наутилус”-ын тухай ер нь дуулсан уу? Дуулаагүй ээ! Тэгсэн ч гэсэн “Наутилус” гэдэг онгоц байсан л юм байна даа. Тэгвэл та дуулаагүй гэдэг үгээр түрээ барьж үнэн юмыг үгүйсгэж дал мөрөө хавчих хэрэг алга! гэв.

- Хэний маань зөв болохыг харж л байя хэмээн Нед Ленд толгой сэжлэн өгүүлээд-Тийм тоннель байгаа юм бол ядаж би Газрын дундат далайд бушуухан орохсон гэж баярлах байнам! гэв.

Далай дээр ил хөвж явсан “Наутилус” тэр оройдоо умарт өргөргийн 21 хоног 30 хувьд Арабын тоннельд ойртон ирлээ. Би Энэтхэг, Египет, Турк, Сиритэй наймаацалддаг худалдааны чухал төв Джедду хэмээх хотыг алсаас харлаа. Бидний хөвж явсан энэ орчноос би тэр хотын барилга, далайн эрэгт зогсож буй хөлгүүдийг нилээд сайн ялган харсан бөгөөд тэдгээрийн зарим нь ачаа хүндтэй тул усанд лав сууж эрэгт ойрхон очиж чадахгүй байв.

Шингэхийг завдан буй наран хотын цагаан цагаан байшинг гэрэлтүүлэн байхад тэд нүд гялбам өнгөөр яралзан байв.

Хотоос зайдуу суурин, тариачдын хулсан ба модон овоохойнууд байх ажээ.

Гэвч удсан ч үгүй Джедда хот оройн бүрийд далд орж, “Наутилус” үл мэдэг туяаран гэрэлтэх уснаа живж орлоо.

Маргааш өдөр нь хоёрдугаар сарын 10-наа бид далай дээр хөвж ил гартал, биднээс хол бус олон хөлөг онгоц байхыг үзэж “Наутилус” яаравчлан буцаж живж одлоо. Гэвч, үд дундын хэрд, ердийн ажиглалт хийдэг цагаар далай зэлүүд байсан тул “Наутилус” усан дээр дахин хөвж гарав.

Би Консель, Нед хоёрыг дагуулан онгоцны тавцан дээр гарлаа.

Алс зүүн зүгт буданцар манан дунд намхан эргийн зурвас бараа үзэгдэнэ.

Бид онгоцны хойт бэхлээстэй завины ёроолд хэвтэж элдэв шалдвыг чалчиж атал Нед Ленд гэнэт өндийж далай дээр бүртийж буй бяцхан юмны зүг гар сунган зааж:

- Та тэнд юм харахгүй байна уу, эрхэм профессор гуай? гэж надаас асуув.

- Үгүй ээ хэмээж би хариулаад -Би, тань шиг нүд сайтай биш гэдгийг та мэднэ шүү дээ гэлээ.

- Та хар л даа сайн гэж Нед Ленд намайг шалгаан - тэнд, штирбортын чигт урагшаа, ямар нэгэн том юм хөдлөөд байхыг харахгүй байна гэж уу? гэв.

- Нээрээ тийм байна хэмээн би сайтар ажигласны дараа - ямар нэгэн гонзгор хар юм усан дээр хөдлөөд байна.

- Бас нэг “Наутилус” гараад ирэх нь тэр үү? гэж Консель асуухад:

- Үгүй ээ хэмээн Канад хүн хариулаад хэрэв би одоо үүнийг далайн ямар нэгэн амьтан гэж хэлбэл арай ч эндүүрэхгүй байхаа гэв.

- Улаан далай халимтай гэж үү? хэмээн Консель асуухад би:

- Ховорхон байдаг юм гэв.



Үнэхээр ч урт, гонзгор хар юм биднээс миль хүрэхгүй газар байх харагдав. Тэрний байдлыг холоос харвал уснаас бултаж буй хад мэт санагдах байв. Гэвч тэр чухам юу болохыг би тэрхэн үедээ таньж чадсангүй ээ.

- Үгүй ээ, энэ чинь халим биш хэмээн тэр амьтнаас эгшин зуур ч атугай нүд үл салган ширтэж байсан Нед Ленд хэлээд,

- Халим бол миний хуучин танил би тэдний аашийг ер андахгүй гэв.

- Жаахан хүлээзнэе хэмээн Консель хэлээд, “Наутилус” яг л түүнийг чиглэн явж байна, хэдэн секундийн дараа би түүний юу болохыг мэднэ гэлээ.

- Ухай! Хөдөлж байна.. Живж байна! гээд Нед Ленд бачимдаж - Ээ хар чөтгөр! Ямар амьтан байгаа? Сүүл нь ердийн халимынх буюу шүдэт халимынх шиг салаа биш юм байхчив. Харин сүүлний нь сэлүүр тас чавчигдсан юм шиг мухар юм гээч! гэв.

- Гэвч... гээд би ярих гэтэл,

- Хараач хөөе гэдсээ дээш нь харуулж нуруугаараа дээшээ эргэлдэж байна гэж Канад хүн хэлэхэд Консель

- Тийм байна. Энэ бодвол ямар нэгэн скрека обольтительниц бололтой! Гэж хэлээд Консель инээмсэглэв.

Конселийн хэлсэн уг над санаа авахуулж билээ. Ардын дунд хүүхэн загас хэмээн алдаршиж домог болсон сиренийн багт хамаарагдах амьтан байгааг би сая ухаарч мэдлээ.

- Үгүй ээ, энэ сирен биш, харин яг тэр багт хамаарагдах өөр нэг ховор амьтан байна. Үүнийг дюгонь гэдэг юм гэж Консель хэлэв.

Тэр завсар Нед Ленд уул амьтныг ширтсээр байв. Түүний нүд хомхойрон гялалзаж байх нь тэр амьтан тийш довтолохоор ус руу үсрэн орох эгзэгтэй цагийг хүлээх мэт байлаа.

- Ай эрхэм профессор минь, би хэзээ ч иймэрхүү амьтан агнаж үзээгүй билээ! гэж сэтгэл зүрх нь оволзсондоо чичирсэн хоолойгоор тэр дуун гарав.

Тэдгээр үгэнд нь Нед Лендийн байдаг зан чанар илэрч байлаа.

Гэтэл капитан Немо гарч ирэв. Тэр, далайд тонгочиж буй дюгонжийг олж хараад, дараа нь Канадын харъяатын зүг ширэв татаж түүний байж ядаж байхыг тааж мэдээд Нед Ленд руу хандаж:

- Эрхэм Нед таны гарт хэрэв одоо жад байгаа сан бол таны алгыг хорсгохсон бол уу? гэж асуув.

- Яах аргагүй тэгнэ шүү, капитан

- Тэгвэл та жадчиныхаа мэрэгжилд нэг өдөр боловч эргэн орж, өөрийн агнуурын амжилтны бүртгэлийг нэг боловч баатарлаг явдлаар нэмэгдүүлэхийг хүсч байна уу?

- Дуртай тэгэхсэн байнам!

- Тэгвэл яая гэхэв, үзээд алд!

- Баярлалаа, капитан гэж Нед Ленд өгүүлэхэд түүний нүдэнд цог бадрах мэт ажээ.

- Танд зөвхөн нэг л болзол тавих байнам. Үүнд та алдалгүй л шийдээрэй! Энэ бол таны тусын тулд хэлж байгаа юм шүү.

- Дюгонь тийм аюултай амьтан юм уу? гэж миний асуухад Канад хүн анзаарах шинжгүй мөрөө хавчвал, капитан:

- Аюултай амьтан, экэ амьтан анчид руу дайрч завий нь онхолдуулдаг ч удаа бий. Гэвч эрхэм Недэд энэ явдал аюултай биш. Нед эрхмийн нүд хурц, гар мэргэн, би эрхэм Недэд санамж өхдөө аюултайд нь болгоомжлох гэсэн юм биш харин дюгонийн мах тун амттай зууш болох тул алдаж үгүй болгохоос нь болгоомжилсон юм. Тэгвэл Нед гуай ч, миний мэдсэнээр бол маханд нилээд овоо гэж байгаа биз гэхэд нь Нед Ленд:

- Аа, тийм бий! Энэ амьтан чинь бас яг ч үгүй амттай байх нь ээ гэв.

- Амттай даа Нед гуай. Түүний махыг үхрийн махнаас ялгах юм байхгүй. Меланез оронд хааны зоогонд хүртэл тавьдаг юм. Сүүлчийн жилүүдэд дюгонийг хамаагүй улайран хядаж буй болохоор бодвол түүний нэгэн төрөл ламантин гэдэг амьтны нэгэн адил даруй устаж үгүй болно бизээ.

- Тийм бол капитан минь, түүнийг хөнөөхийн хэрэггүй юм биш биз? хэмээн Консель үнэн голоосоо өгүүлээд - хэрэв энэ хамгийн сүүлчийн ганц амьтан байвал яана? Тийм бол шинжлэх ухааны тусын тулд амьд үлдээх нь зүй юм биш үү гэхэд:

- Тийм ч байж болох юм хэмээн Нед Ленд хэлээд – гэлээ ч гэсэн гэдэс цатгах тусын тул агнах л хэрэгтэй гэв.

- Үзээд алд даа, эрхэм Нед гэж капитан Немо давтан хэллээ.

Энэ минутанд “Наутилуса”-ын багийнхнаас долоон хүн тавцан дээр гарч ирлээ. Тэд, бахь байдгаараа л дуу чимээ ч үгүй л амгалан ажээ. Тэдгээрийн нэг нь халимын ангуучин хөлгөн дээр хэрэглэдэг жад оосрын нь хамт авч ирлээ.

Бяцхан завь усанд буулган, сэлүүрийн ард зургаан хүн, нэг хүн залуур дээр тус тус суулаа. Нед Ленд, Консель бид завины хоншоор хэсэгт байрлав.

- Бидэнтэй капитан та явахгүй гэж үү? гэж би асуувал:

- Үгүй ээ, профессор минь явахгүй. Харин та нар олз омогтой яваарай гэж хариулав.

Бидний завь зургаан сэлүүрчийн хүчинд онгоцны хажуу бөөрнөөс тэр даруй холдон “Наутилус” аас хоёр миль газар харагдаж буй дюгонь тийш хөвж одлоо.

Түүнд хэдхэн кабельт зайтай ойртон очмогц сэлүүрчид хурдаа удаасгаж, сэлүүрээ усанд аяархан тавив.

- Нед Ленд жадаар зэвсэглэн завины урд хамар дээр босч зогсов.

Халимын жад ихэвчлэн асар урт, бөх оосроор завинд аргамжигддаг бөгөөд шархадсан амьтан зугатан зүтгэх үед хялбархан задрахаар эвхэгдсэн байдаг бүлгээ. Гэтэл энэ нэгэн удаа бидний авч яваа жадны оосор хэтэрхий богинохон дөнгөж хорин метр урт бөгөөд түүний үзүүрийг хоосон модон торхонд барьж уясан байв. Тэрхүү модон торх шархадсан амьтан хаашаа давхиж буйг мэдэгдэх үүрэгтэй ажээ.

Энэ үед би ч гэсэн босч зогсоод, Канад хүний араас дюгонийг харуулдаж байв. Тэр дюгонь далайн ламантин хэмээх амьтантай нэн адил ажээ. Түүний гонзгор шувтан бие урт сүүл болон шувтрах бөгөөд хажуугийн нь сэлүүрүүд ёстой хуруу адил байдаг билээ. Дюгонь дээд эрүүндээ ёстой мөргүүл эвэр мэт урт болсон хурц соёотойгоороо ламантинаас ялгаварлагддаг юм.

Нед Лендийн гэтэж байсан тэр дюгонь нүсэр том амьтан бөгөөд усны дээр нам унтах мэт үл хөдөлж бүлгээ. Тэр нэгэн завшаан Канад хүнд сайн юм болж түүний амжилтыг хялбарчилж билээ.

Бидний завь нэн сэрэмжтэй явж уул амьтанд тав зургаан метр ойртов. Сэлүүрчид сэлүүрээ өөд ид, хийд өргөв.

Энэ хооронд Нед Ленд гэдгэсхийн жадаа даллангуут шидэж орхилоо.

Агаарт исгэрэх дуун гарч, дюгонь алга болж одов. Бодвол түүний хар тэнхээгээрээ шидсэн жад зөвхөн л ус долоосон буйзаа.

- Ээ хар чөтгөр? хэмээн Канад хүн хашгирч

- Би алдаж шидлээ гэж үү? гэв.

- Үгүй ээ, алдаагүй гэж би хариулаад, шархадчихсан. Энэ хар л даа, цусан зам татуулж байна. Гэвч жад тань. ус руу ойчлоо гэж хэлэв.

- Жад минь яав! Жад минь! хэмээн Нед Ленд дуу тавив.

Сэлүүрчид дахин сэлүүрдэж эхлэн залуурч завиа усан дээр хөвж буй торх руу заллла. Бид жадаа олж аваад, шархадсан амьтанг хөөж гүйцэхээр хурдаллаа. Тэр амьтан агаар амьсгалахаар байн байн усан дээр ил гарч ирнэ. Бодвол шарх нь түүнийг тамирдуулахгүй байгаа бололтой. Тэр нилээд их хурдтай гүйж байв. Арван хоёр бадриун гарын хүчинд урагшилж байгаа завь явах биш нисч байлаа. Манай завь түүнийг олон дахин гүйцэн очиж, Нед Ленд ч жадаа хоёрдох удаагаа шидэхийг

завдсан боловч өнөө амьтан тэр болгонд нь бултан зугатаж усанд шумбан орж тухай бүрийн аюулаас зайлан одож байв.

Нед Лендийн тэр үеийн бачимдал хилэгнэл хоёрыг дүрслэн бодож болно. Шархадсан тэр муу амьтныг английн ямар ч муу үг, хараал мэддэг бол бүгдээр нь харааж зүхэж байв. Түүгээр ч барахгүй тэр амьтан бидний бүх төлөвлөгөөг хөсөрдүүлж байсан тул над хүртэл гомдолтой санагдав.

Тиймэрхүүгээр бид дюгонийг бүтэн цаг мөрдөж атал, өнөө амьтан гэнэтхэн бидэн руу довтлон орохоор завь руу маань чиглэн, мөрдсөний маань хариуд биднийг устгахаар шийдэн эргэн ирэхэд би олз омгийнхоо бүтэмжинд үл итгэж сэтгэл түгшиж эхлэв. Дюгонийн тэр аашийг Канад хүн даруй мэдэж:

- Анхаар! гэж хашгирлаа.

Залуурч өөрийн этгээд хэлэн дээр хэдэн юм хэлсэн нь, бодвол сэлүүрчдийг анхаар гэсэн бололтой.

Дюгонь завинд хоринь метр ойртож ирэнгүүт зог тусч, хоншоорынхоо доод талд нь биш харин дээд талд нь байх хамрынхаа нүхээр агаар салхи хүчтэй татаж аваад бидэн руу дайран орж ирлээ.

Бид түүний дайралтаас бултаж амжсангүй. Гэвч залуурчийн чадмаг залалтын ачаар халз тулгарах аюулаас мултарч, бидний завь зөвхөн халбисхийгээд нэг буюу эсхүл хоёр тонн хэр ус хутгасны нь сүүлд нь шавхаж асгах хэрэг гарав.

Завины хоншоор дээр зогсч байсан Нед африк газрын арслан гөрөөс зуух гэж байгаа мэт завины ирмэгээс үмхчээд эргэхийг завдаж буй дюгонийг жадаар хэд дахин бүлж орхив.

Тэрхэн зуур бид бие биес дээгуур дамналдан унаж, дээр дороо орцгоосон бөгөөд хэрвээ л уурсаж хилгэнэсэн Канад хүн самбаачилж тэр нэгэн амьтны гол зүрхэнд жадаа шааж амжаагүй бол энэ хэрэг юугаар төгсөх байсныг бүү мэдээ.

Дюгонь завины бөөрийг мэрээд авах чимээ гарч дараа нь тэр амьтан торхтой жадтайгаа хамт живж одлоо.

Гэвч удсан ч үгүй хоосон торх усан дээр хөвөн ил гарч ирэхэд, түүнтэй хамт өөхий нь өөдөө харсан дюгонийн хүүр мөн хөвж гарлаа. Түүнийг бид оосроос нь чирсээр “Наутилус” руу авч одов.

Дюгонийн биеийг өргөх багаж хэрэглэн арай чуу хийж “Наутилус”-ын тавцан дээр татаж гаргавал, тэр таван мянган килограммаас багагүй хүнд ажээ.

Тэрхүү амьтныг өвчих ажлыг Нед Лендийн шууд удирдлагын доор гүйцэтгэсэн бөгөөд энэ үүргийг тэр хэнд ч итгэмжлэн шилжүүлэхийг үл хүсч билээ.

Тэр өдрийн орой онгоцны тогооч гараа гаргаж бэлдсэн амтлаг сайхан хоол миний зарц над авчирч өгсөн нь өнөө дүгөнийн мах байв. Түүний мах миний сэтгэлд үхрийн махнаас хол илүү нийцсэн билээ.

Маргааш өдөр нь хоёрдугаар сарын 11-нд “Наутилус”-ын хүнсний зоорь ангийн махны шинэ нөөцөөр баяжив. Тэр өдөр онгоцны тавцан дээр алтан хараацайн сүрэг нисч буулаа. Тэдгээр нь зөвхөн л Египетэд дайралддаг, нэгэн дүрс хар хушуутай шовгор толгойтой нүдий нь цагаан толбо тойрсон, нуруу, сүүл, далавч зэрэг нь бор цагаан цээж ба гэдэстэй, улаан сарвуу бүхий Нил мөрний хараацай байв. Тэднээс гадна бид хүзүү ба толгойгоороо хар цоохор, Нил мөрний зэрлэг галуу хэдэн арвыг барилаа. Тэдгээр шувууны мах нэн амттай ажээ.

Тэр өдөр “Наутилус” жигдхэн зөөлөн хурдтай явж байв. Энэ байдлаараа тэр хаашаа ч үл яарах мэт ажээ. Суэцийн буланд ойртох тутам Улаан далайн усны давс улам бүр багасч байгааг би ажиг мэдэв.

Өдрийн таван цагийн үед бид Арабын ба Акабын булан хоёрын хооронд орших, Арабын чулуурхаг газрын төгсгөл болох Рас-Мохаммедийн хушууг умар зүгт олж харав.

Ийнхүү “Наутилус” Суэцийн буланд явж оров. Рас-Мохаммедийн хушуун дээр би нэгэн өндөр уул байхыг ялган харсан нь Ореб хэмээх уул ажээ.

Оройн зургаан цагт “Наутилус” уснаас нэг ил гарч усанд нэг далд орж явсаар далайн нэгэн тохойд орж очсон нь Тор хэмээх тохой байв. Тэр тохойн ус, капитаны хэлснээр үнэхээр улаавтар туяатай ажээ.

Зөвхөн л пеликануудын хашгаралдаан, хил мөргөж буй давалгааны шуугиан, далайн галт онгоцнуудын хааяа нэг орлих яндангийн дуунд сэрдхийн цочиж буй нүсэр харанхуй дунд гүн шөнө гэнэт нөмөрсөн байв.

Оройн найм есөн цагийн хооронд “Наутилус” усны гүнд хэд хэдэн метрийн доор живж орлоо. Миний бодлоор бол бид Суэцэд нилээд ойрхон байх ёстой билээ.

Гэгээвчийн шилний цаана би цахилгаан чийдэнгийн гэрэлд хурц гэрэлтүүлэгдсэн эрэг орчны хаддын уг ёроолыг харж байв. Тэрхүү хоолой цаашлах тутам улам нарийсч байх мэт над санагдаж билээ.

Гэтэл 9 цаг 15 минутанд манай онгоц усан дээр дахин ил гарч ирэв.

Би капитан Немогийн нэрлэсэн Арабын тоннелийг үзэхсэн гэхээс байж ядаж байв. Аргаа барахдаа би онгоцны тавцан дээр салхинд гарлаа.

Удсан ч үгүй, биднээс миль хагасын газар оройн мананд торолзож буй бүдэг гэрэл сүүмэлзэж харагдав.

- Тэр харагдагч, хөвөгч цамхаг байна гэж миний дэргэд дуун гарахад би ер санаандгүй зогсож байсан тул давхийн цочиж эргэн харвал капитан Немо өөрийн биеэр дэргэд минь ирснийг танилаа.

- Тэр бол Суэцийн хөвөгч цамхаг гэж тэр хэлээд - бид одоо удахгүй тоннелийн амсарт хүрч очлоо гэв.

- Тэрлүү ороход тийм ч амаргүй биз? хэмээн миний асуухад капитан:

Тиймээ, энэ орчин ч нэн осолтой л газар. Тийм ч учраас би тоннельд орохын өмнө жолоодох бүхээгт өөрөө орж, онгоцоо өөрийн гараар жолоодох явдлыг ёс болгосон юм. За тэгээд эрхэм профессор та доошоо бууж дотогшоо орно байгаа аа.

“Наутилус” одоо нэгэнтээ шумбан орвол, дахин хөвж ил гарахдаа зөвхөн л Арабын тоннелийг гэтэлж Газрын дундат далайд ил гарсан байх болно гэв.

Би капитан Немог дагалдан явлаа. Онгоцны дээд таг хаагдаж, усны том багтаамжууд усаар дүүргэгдэхэд бидний хөлөг арван метрийн гүнд дахин живж оров. Би өөрийнхөө өрөөнд явж одохыг завдан байсан тэр минутад капитан Немо намайг зогсоож:

- Ноён профессор та надтай хамт жолоодлогын бүхээгт цуг дежурлэхийг хүсэх үү? гэж асуухад нь би:

- Энэ тухай би танаас гуйх гээд зүрхлээгүй юм гэлээ.

- За тэгвэл явъя. Тэхэд та усан доогуур буюу эсхүл газар доогуур жуулчлан явахад чухам юу юу олж үзэж болох бол, тэр бүхнийг олж үзэх болно.

Бид тавцан дээр гаргадаг шатаар дамжиж дунд хэрд нь хүрэв. Тэнд капитан Немо нэгэн жижиг хаалга нээхэд бид намхан таазтай нарийхан гудамж өрөөнд гарч ирлээ. Тэрхүү өрөөний мухарт хөлөг онгоцны урд хамарт, жолоодлогын бүхээг бөмбийж байв.

Тэр нь Гудзон ба Миссипээр хөвдөг галт онгоцнуудын жирийн өрөө шиг яг тийм хэмжээтэй, хааш хаашаа зургаан фут жижиг өрөө байлаа. Түүний тэг дунд жолоодох хүрд байрлаж, онгоцны бөгсөнд байх залуур далбаат ган татуургаар холбогдсон ажээ. Түүнчлэн тэр өрөөний дөрвөн хананд дөрвөн дугариг шилэн гэгээвч байх тул жолоо баригч хүн тал бүр тийшээ харах бололцоотой байв.

Тэнд харанхуй байсан боловч удсан ч үгүй миний нүд харанхуйд дасч, жолоодох хүрдээс хоёр гараараа барин зогсч буй залуурчийг олж харлаа.

- За, одоо тоннель руу орох нүхийг эрж олъё хэмээн капитан Немо хэлэв.

Жолоодох байрыг, машины тасагт цахилгаан гүйдлийн утаснууд холбож ахуй тул капитан Немо залуур хүрднээс холдолгүйгээр тусгай таних тэмдэг дохиогоор

хөлгийн хурдыг хурдасгах ба удаасгах тушаал өгч чадах ажээ.

Капитан Немо нэгэн товч дармагц яг л тэр минутанд сэлүүр сэнс эргэлтээ багасгав.

Бидний онгоц бүтэн цагийн турш ёроолы нь даган хэдхэн метрийн зайтай хөвж байхад эгц цавчим боржин ханыг би дув дуугүй ширтэн явлаа.

Энэ үед капитан луужингаас нүд үл салгалгүй ширтэх бөгөөд түүний заавраар, жолоо баригч хүн, онюцны чиглэлийг цаг үргэлж өөрчлөн залуур хүрдээ мушгиж байв.

10 цаг 15 минутанд капитан Немо өөрөө залуурын ард загсов.

Бидний халз өмнө өргөн цэлгэр болж ирээд, гүн харанхуй гудамжилсан хар нүх онгойн харагдлаа.

Түүн рүү “Наутилус” шуудхан явж оров. Хөлгийн төмөр хуяг ер бусаар хүнгэнэн дуугарч эхлэв. Тэр нь Газрын дундат далай руу энэхүү хэвгий газраар ташуу бууж байгаа Улаан далайн усны дуу ажээ. Усны урсгал “Наутилус”-ыг, хэдий түүний сэнс эсрэг зүгтээ аль байхаараа эргэлдэн, тооромсоглож байгаа ч гэсэн зомгол адил хийсгэн хөөж байв.

Тэрхүү их, нүд эрээлжлэм хурдан давхилт дунд уул тоннелийн ханан дээр цахилгаан чийдэнгийн зурвас гэрэл арайчуу ялгарч харагдахын төдий гялалзан өнгөрч билээ. Миний зүрх галзуурсан мэт цохин, би түүнийгээ намхруулах хэмээн гараар дарж зогссон бүлгээ. 10 цаг 35 минутанд капитан Немо залуур хүрдээ жолоо баригчид шилжүүлэн өгч, дараа нь над руу хандан:

- Бид Газрын дундат далайд орж ирлээ гэв. Газар доорхи усны шируун урсгалд хөөгдөж “Наутилус” хорин минут хүрэхгүй өчүүхэн хугацаанд Суэцийн хүзүүвчин доогуур давхиж гарах нь энэ ажээ...

[Тор](#)

---

## ГРЕКИЙН ОЛЬТРИГ

Дараачийн нь өдрийн өглөө, үүрээр хоёрдугаар сарын 12-нд “Наутилус” усан дээр гарлаа. Би ч ердийнхөөрөө тавцан дээр гарахыг яаравчлав.

Биднээс өмнө зүгт гурван миль зайтай өглөөний манан дунд эртний Пелузиумийн

эрэг бүдэг бадаг зурайн харагдлаа.

Довтлох мэт ширүүн урсгал биднийг нэг далайгаас нөгөө далайд нүд ирмэхийн зуур авчиржээ. Харин нэн хялбархан бууж орж ирэх тэр тоннелиор Газрын дундат далайгаас Улаан далайд буцаж нэвтэрч болохгүй буйзаа.

Өглөөний 7 цагийн үед Нед Ленд, Консель хоёр надтай ирж хамтарлаа. Тэдгээр салшгүй найз нөхөд бүтэн шөнөжингөө “Наутилус”-ын баатарлаг үйл явдлыг өчүүхэн ч сонирхсонгүй нам унтчихжээ.

- Зэ, эрхэм профессор хэмээн Нед Ленд ёжих байдалтай хэлээд өнөө ам гарсан Газрын дундат далай тань хаана байна? гэж асуухад би:

- Бид, түүний чинь л гадаргуу дээгүүр хөвж явна даа, хонгор минь гэв.

- Юу хэмээн Консель дуу алдаж.

- Тэхээрээ, урд шөнө л?...гэж асуух гэтэл нь:

- Тиймээ. Яг урьд шөнө л өнөө нэвтэршгүй хүзүүвчий чинь хорьхон минутанд нэвт цохиод л гарчихсан даа гэвэл Нед Ленд:

- Худлаа гэв.

- Нээрэн Нед минь. Энэхэн урд зүгт харагдаж байгаа намхан эрэг бол Египетийн эрэг гэж би хариулав.

- Намайгаа ч арай тэгж дөнгөхгүй байх аа, эрхэм профессор хэмээн өнөө зөрүүд хүн маргаж эхлэв.

- Нэгэнт л эзэн хэлсэн хойно, гүйцэх нь тэр: гэж Консель хэллээ.

- Жич хэлэхэд Нед минь-хэмээн би үргэлжлүүлж, капитан Немо өөрийн тоннелийг, өөрийн биеэр надад танилцуулсан. Түүнийг би нарийхан явцуу нүхэн дундуур “Наутилус”-аа залж байхад нь түүнтэй зэрэгцэн зогсч байсан гээч гэв.

- Дуулав уу. Нед? гэж Консель хэлэв.

- Таны нүд сайн хардаг хэмээн би нэмэрлэж - Тиймээс та миний хуурч байгаа эсэхийг нэг хараад л мэднэ. Хар л даа та, тэнд Порт Саидын онгонцы зогсоол харагдах ёстой гэхэд Канад хүн заасан зүг хичээнгүйлэн ширтэв.

- Нээрээ тийм байна, таны зөв байх нь эрхэм профессор. Түүнчлэн таны тэр капитан чиг хийсэн хэргийнхээ эзэн юм байна. Бид Газрын дундат далайд байгаа ажээ, сайн л биз. За алив өөрсдийн ажил хэргийн талаар ярья. Харин бидний үгийг хэн нэгэн хүн сэм сонсчих бий.

Канад хүн чухам юу ярих гэсний нь би сайн мэдэж байв.

Ямар ч гэсэн, нэгэнтээ л Нед Ленд шалгаагаад байгаа юм болохоор тэр талаар ярихгүй бол болохгүй гэж би бодлоо.



Тэгээд гурвуулаа цахилгаан чийдэн суулгасан бөмбөгөр бүхээг руу ойртон очиж сууцгаалаа.

- За одоо таны үгийг сонсьё. Та бидэнд юу гэх гэсэн юм? гэж би асуувал, Канад хүн үгүүлрүүн:

- Миний хэлэх юм товчхон. Бид одоо Европт ойртон ирлээ. Тэхээрээ умарт далайн болон аль нэгэн тэнгисийн ёроол руу биднийг дахин авч арилах бодол капитаны бөндгөрт орохоос өмнө “Наутилус”-тай үүрд хагацахын ёс үйлдэхийг би та нарт толилуулах гэсэн юм.

Энэ талаар Канад хүнтэй маргалдан тэмцэх явдал тун бэрх байсан гэдгээ би хүлээх ёстой. Нэг талаар би өөрийн нөхдийн эрх чөлөөг ямар нэгэн хэмжээгээр боогдуулах ямар ч хүсэл байгаагүй, гэвч нөгөө талаар капитан Немогоос тийнхүү яагаа ч үгүй эрт салж одохыг би бодоогүй билээ. Түүний ач, гайхамшигтай онгоцны ачаар өөрийн мэдцийг би өдөр бүр нэмэгдүүлж, далайн ёроолын амьдралын тухай номоо, тэрхүү амьдралын яг амьд голд нь байж байгаад дахин шинээр бичиж авсан бүлгээ. Далай тэнгисийн гайхамшигийг тэгж дүүрэн судлах бололцоо би дахиад хаанаас ч яаж олно? Хаанаас ч олохгүй ээ! Тийм учраас ч би усан доогуур явагч хөлгийг орхин одохыг, дэлхийг бүтэн нэг тойрсон эрдэм шинжилгээний бүтээлт жуулчлал болохоос нааш үл хүсч билээ.

- Миний найз Нед чи үнэхээр энэ онгоцон дээр уйдаж байна гэж үү? Нуулгүй хэлчих. Үнэхээр та өөрийн биеийг энд авчирч хаясан хувь заяагаа хараан зүхэж байна гэж үү?

Канад хүн шууд хариу өгсөнгүй. Хоёр гараа тэр цээжиндээ зөрүүлэн тавьж нилээд зогссоноо:

- Үнэнийг хэлчхэд би энэ нэгэн усан доогуурхи жуулчлалд гар бие оролцсондоо харамсах юм алга. Үүний тухай би хэзээ нэгэн цагт дуртай нь аргагүй дурсан ярих болно. Тэгвэл бид энэ сайхан жуулчлалынхаа тухай дурсан санаж, дурьдан ярихын тул юуны өмнө бидний энэ эцэс хязгааргүй золбирлыг дуусгах хэрэгтэй. Энэ талаар миний бодож байгаа юм энэ дээ! гэв.

- Нед минь энэ аян дуусахдаа л дуусна.

- Хаана? Хэзээ?

- Хаана ий? Бүү мэд. Хэзээ гэнээ? Энэ тухай танд яг таг хариулчихаж чадахгүй. Гэвч тэнгис далай бидний өмнө эцсийнхээ нууцыг задалж тавьсны дараа л дуусах бий гэж бодож байна. Энэ ертөнц дээр тохиолдох ямар нэгэн юмны эх үүсвэрт эрт орой хэзээ боловч нэгэн эцэс хязгаар гэж байдаг л ёстой.

- Би эзэнтэй яг санаа нийлнэ хэмээн Консель хажуугаас оролцож - миний бодлоор бол капитан Немо, бидэнтэй хамт бүх далай тэнгисийг дамжиж тэнэчихээд, хамгийн эцэст нь биднийг зүгээр л далайн ёроол руу хаячихаад явчихаж мэднэ гэв.

- Хаячихаад явчихна аа? хэмээн Канад хүн гоморхож, биднийг тэр зүгээр л хаячихаад явчихна гэж та хэлэв уу? гэв.

- Үгийн өө эрсний хэрэггүй, Нед Ленд минь гэж би тэдний ярианд оролцож, Консельтой энэ талаар би санал үл нийцнэ. Бид капитанаас айх явдал ер байхгүй. Гэвч нөгөө талаас нь авч үзэхэд капитан биднийг сайн дураараа л суллаад тавьчихгүй нь магад. Бид “Наутилус”-ын хамаг нууцыг мэдэх болохоор түүнийгээ дэвэн дэлхийгээр түгээчихийг хүсэв гэж үү дээ гэлээ.

- Тэгвэл та ямар юмандаа найдаж байгаа хүн бэ? гэж Канад хүн асуувал, би:

- Бид эрт орой боловч эгзэг нь таарсан цаг ашиглан чадах тэр нэгэн завшаанд л найдаж байна. Тэр завшаан мөн одоогийн нэгэн адил зургаан сарын дараа дахин тохиолдож болох юм гэв.

- Би байгалийг судлагч, эрхэм ноён та, зургаан сарын дараа бид чухам хаана байхыг одоо урьдчилан хэлчихэж чадах бол айлтган соёрхоно уу? гэж Нед Ленд хэлэв.

- Дахиад энд ирж ч магадгүй, эсхүл Хятадад ч байж магадгүй. “Наутилус” гайхамшигт хурдан хөлөг гэдгийг та мэднэ. Энэ хөлөг усан догуур агаараар нисдэг хараацай, аль эсхүл газраар явах буухиа тэрэг шиг хурдан давхидаг биш билүү. Энэ бас хөл хөдөлгөөнтэй далай тэнгисээс айдаггүйг бид нүдээр үзлээ.

Зургаан сарын дараа энэ хөлөг Франци буюу Английн эрэгт дахин хөвж ирж оргох нөхцөл байдал өнөөдрийнхөөс илүү тохиромжтой болохыг хэн байг гэх юм?

- Эрхэм профессор таны нотолгоонууд ямар ч үндэс алга хэмээн Канад хүн маргалдаж,

- Бид энд байна, бид тэнд байна гээд л та үргэлж ирээдүй цаг дээр ярьж байна. Тэгвэл би “Бид энд байна - үүнийгээ л ашиглах ёстой” гэж одоо цаг дээр ярьчихъя гэлээ.

Нед Лендийн тэр зүй ёсны сэтгэмжийн эсрэг би хэлэх үггүй тул тэрхүү маргаанд би ялагдсанаа мэдлээ. Би өөрийн сонирхлыг дахин хамгаалах ямар ч барьцаа алга болжээ.

- Ноён профессороо! хэмээн Нед Ленд үргэлжлүүлж За яахав болохгүй юмыг болгоод нэг үзье. Капитан Немо өөрөө бидэнд эрх чөлөө тавьж өгье гэж боддог, тэгвэл та яах вэ? гэхэд нь би\*

- Ай бүү мэд гэв.

- Хэрвээ үгээ, капитан Немо нэг насандаа ахиад хэрхэвч давтахгүй гэвэл та яах вэ? Би дуугүй байв.

- Энэ тухай Консель найз юу бодож байна? гэж Канад хүн Конселиос асуув.

- Консель найз чинь энэ тухай хэлэх юм ёстой юу ч алга хэмээн фламанд эр тайвуухан хариулж:

- Тэр энэ асуудлыг чухам ямраар шийдэхийг ер сонирхсонгүй байнам. Тэр яг л өөрийнхөө эзэн шиг, бас яг л найз Нед Ленд шиг эхнэр хүүхэд байхгүй. Тиймээ түүнийг ар талд нь хүлээсэн садан төрөл, үр хүүхэд, гэргий аль аль нь байхгүй. Тэр өөрийн эзний дэргэд хүчин зүтгэж буй тул тэрхүү үүрэгт ажлаа орхин одохыг завдсан юм ер алга. Энэ асуултыг шийдвэрлэж санал хураах хэрэгт гар бие оролцож, өөрийн саналаар аль нэгэн талын нь байдлыг хүндрүүлэхийг үл хүсэж байгааг гашуудалтайгаар уламжлах л байна. Дуэлд хоёр хүн л оролцож байна: Нэг талаас эзэн, нөгөө талаас Нед Ленд, дараа нь Консель миний бие дуугүй олж минут тоолохоос өөр явдалгүй гэлээ.

Конселийн тэр яриаг сонсоод би инээдээ барьж чадсангүй ээ. Конселийг өөрийн эсрэг үл хандахад Канад хүн цаанаа л нэг бах нь ханаж байсан бизээ.

- Консель нэгэнтээ бидний маргаанд оролцохгүй болохоор хэмээн тэр надад хэлээд - энэ асуултыг та бид хоёр л дундаа шийдвэрлэх хэрэг. Би ч хэлдгийгээ хэлчихсэн. Та ч гэсэн миний үгийг сонссон. Тэгвэл та надад юу гэж хариулмаар байна? гэв.

Үнэндээ энэ хэргийг нэг тийш болгох нь хэрэгтэй болов. Бөөрөнхийлэх, булхайлах явдал надад жигшүүртэй муухай санагдлаа. Тиймээс би эрс шийдэж:

- За Нед найз минь, миний хэлэх үг ийм л байна хэмээн түүнд өгүүлрүүн - энэ маргаанд маргаад та намайг дийлжээ. Тийм нотолгооны эсрэг тавих ямар нэгэн айттар татгалзалгаа над л алга.

Капитан Немо биднийг аяндаа суллан тавина гэдэгт найдахын хэрэг ердөө үгүй. Хамгийн өчүүхэн сэрэмжлэл, түүнийг тийм явдалд хүргэхгүй. Гэтэл мөн яг л тийм сэрэмжлэл анхны завшааныг ашиглан “Наутилус”-аас оргож одохыг биднээс шаардаж байна.

- Нэн сайн байна эрхэм профессор! Одоо л та нэг овоо ухаарч байх шиг!

- Гэвч над бас нэг өөлөх тал байна гэж би маргаж эхлэв.

- Энэ нэгэн завшаан нэн тохиромжтой байх ёстой. Манай анхны оролдлого заавал үр дүнтэй төгсөх ёстой. Хэрэв энэ явлал бүтэхгүй бол бидэнд хэзээ ч дахин аятай

завшаантай цаг тохиолдохгүй. Тэрчлэн капитан Немо бидний энэхүү орголтыг хэрхэвч, хэзээ ч уучлахгүй гэв.

- Тэр зүйтэй хэмээн Нед Ленд хэлээд - гэвч таны энэ эрж буй өнөөдрийн энэ орголттой ч тэр, хоёр жилийн дараа оргохоор оролдох оролдлоготой ч тэр адилхан л хамаарагдана. Энэ бүхнээс оргоход зөвхөн л бололцоотой, аятай завшаан гармагц л түүнийг даруйхан ашиглах хэрэгтэй гэсэн нэг л дүгнэлт гарах юм гэв.

- За зөвшөөрье, Нед та эрхэм “Аятай завшаан” гэж чухам юугаа хэлээд байна даа, хэлчих л дээ, тэгвэл одоо?

- “Наутилус” Европ газрын ямар нэгэн эрэгт ойртох харанхуй шөнийг л хэлж байна.

- Та, тэгвэл сэлээд гарчихна гэж бодоо юу? - Тиймээ, хэрэв л “Наутилус” ямар нэгэн эрэг орчинд ойрхон, усан дээр ил явбал. Хэрэв бидний хөлөг эрэг газраас хол, тэгээд усан доор явбал...

- Тэгвэл яах вэ?

- Тэгвэл “Наутилус”-ын жижиг завийг өөрийн болгочихгүй юу. Түүнийг бэхлээнээс нь яаж мултлахыг мэднэ. Бид түүн дотор сэмхэн орж очоод, бэхлээ эргийг нь тайлчихвал завь эгшин зуур хөвж далай дээр гарах бөгөөд биднийг тийнхүү оргож буйг, түүгээр ч барах үгүй жолоодлогын бүхээгт байгаа залуурч хүртэл, мэдэх ч үгүй өнгөрөөчихнө.

- За яахав Нед чи аятай цаг отож л бай. Бүтэлгүй юм болбол биднийг хөөднө гэдгийг ганцхан бүү март!

- Мартахгүй ээ, эрхэм профессор!

- За тэгээд, бид нэгэнтээ бүх талаар ярилцаж тохирсон болохоор, эрхэм Нед Ленд та, таны тэр төлөвлөгөөний талаар би чухам юу бодож буйг минь мэдэхийг хүсч байнаау?

- Хүсэлгүй яахав, эрхэм профессор.

Миний бодлоор, миний бодлоор бол шүү, тэрнээс биш би үүнд итгэж байгаа юм биш, тэр нэг аятай завшаан бидэнд тийм ч түргэн тохиолдохгүй биз.

- Яагаад?

- Яагаад гэвэл, капитан Немо, бид бүхнийг эрх чөлөөгөө эргүүлэн олох гэсэн бодлоосоо эс татгалзана гэдгийг, бодвол сайн мэдэж байгаа болохорор Европын эрэг орчинд хөвөн явах үед тэр цаг ямагт сэрэмжлэн байх биз.

- Харж л байя, тэгээд л мэдье хэмээн Нед Ленд мөн л зөрүүд царайлан толгой сэгсрэв.

- Сайн, тун сайн. Одоо больё! Үүний тухай одоо дахин ярихын хэрэггүй. Оргохоор шийдсэн яг тэр дороо л та бидэнд хэлчихээрэй. Бид танаас юу ч асуухгүйгээр таныг шууд дагалдах болно. Бид ч танд сохор итгэж байна шүү дээ, Нед минь гэж би хэлэв.

Онц чухал үр дүнтэй төгсгөх ёстой бидний тэр яриа ингэж дууслаа.

Илэн далангүй шууд хэлэхэд Канад эрийн заяа нь харьсан азгүй юм болж, цаашид өрнөсөн үйл явдал миний таамаглал зөв болохыг баталж билээ. Эдгээр хөл хөдөлгөөн ихтэй далайд капитан Немо бидэнд итгээгүй учраас ч юм уу, эсхүл Газрын дундат далайн усанд өөдөө сөөргөө зорчин буй ястан бүрийн олон тооны хөлөг онгоцтой учрахаасаа зугатаасан ч юм уу, бид эрэг орчноос алсалсан хол газар бараг цаг үргэлж усан доор явж бүлгээ. “Наутилус” эсхүл жолоодлогынхоо бүхээгийг уснаас дөнгөж цухуйлган ил гарах буюу эсхүл тэр усны их гүнд шумбан орж. байв. Жич хэлэхэд, Грекийн ольтриг ба бага Ази хоёрын хооронд бид, хоёр мянган метрийн гүнд, далайн ёроолд хүрч чадаагүй бүлгээ.

Додеканезийн бүлэг аралд хамаарагдах Карпафос арлын дэргэдүүр бид явж өнгөрсөн тухай би түүний орших газрыг зураг дээр зааж байсан капитан Немоогоос сүүлд сонссон билээ.

Дараачийн нь өдөр, хоёрдугаар сарын 14-нд Грекийн ольтриг орчны загасыг судлах ажилд би хэдэн цаг зориулахаар шийдлээ. Гэтэл надад үл мэдэгдэх шалтгаанаар, гэгээвчний халхавч бүхэл өдөртөө бин битүү хаалттай байв.

“Наутилус”-ын замыг би зураг дээр мөрдөн хөөж Крит арал руу явж буйг нь мэдлээ. Би хамгийн анхан “Авраам Линкольн” онгоцон дээр гарч байх тэр үед энэ арал Туркийн харгислалын эсрэг бссч тэмцэж байсан юм. Босч тэмцсэн тариачдад ямар хувь хүртээл ноогдсон болохыг би мэдэхгүй байсан бөгөөд хуурай газартай аль нэгэн талын харьцаагаа тасалсан капитан Немо очиж очиж над тэр талаар ямар нэгэн юм сэнхрүүлэв гэж үү дээ.

Энэ талаар би орой капитан Немотой үзэсгэлэн танхимд дайралдахдаа ямар нэгэн сэдэв мэдэгдээгүй билээ. Тэр үед капитаны байдал надад нэг л хачин санагдаж, ямар нэгэн юманд их л сэтгэл зовсон янзтай, баргар царайтай байсныг хэлэх хэрэгтэй. Тэр ердийн хэв заншлаа эвдэж хоёр талын гэгээвчний халхавчийг нээх тушаал гэнэт өгч, нэг цонхноос нөгөө цонх руу шилжин холхиж, ус руу нүд салгахгүй ширтэж байв. Тэр ямар юмаа харах гэсэн юм бол уу? Би түүнийг тааварлаж ялаад нүднийхээ урьдуур жирэлзэн өнгөрч буй загаснуудыг шинжиж эхлэв.

Олон төрлийн загасны дунд би жирийн хар хэлэнд далайн бухандай гэж

нэрлэгддэг колбнийг олж харсан нь эдгээр загас Нил мөрний адаг орчны шорвог усанд үргэлж элбэг тохиолддог билээ.

Цааш нь би спаруудын язгуурын загас буюу ердөө далайн карась хэмээн нэрлэгддэг өөрөө биеэсээ гэрэл цацарган явах пагра гэдэг загас олж үзэв. Египет хүмүүс эдгээр загасыг тахидаг тул Нил мөрний усанд тэдгээрийг орж ирсэн цагт голын ус элбэг бууж ургац их авахын зөн хэмээн шашны их баяр ёслол болдог ажээ,

Түүнчлэн бас бидний дэргэдүүр хеилин хэмээх ясархаг загасны сүрэг нүүгэлтэн өнгөрлөө. Тэдгээрийн бас гучин сантиметрийн урт, хөхөвтөр өнгийн тунгалаг хайрстай, зарим газраараа улаан улаан толботой билээ. Эдгээр загас зөвхөн далайн замгаар хооллодог тул тэдгээрийн мах нэн зөөлөн амттайхан бүлгээ. Хеилин бүр дээр үед, эртний Римд нэн нандин зоог хэмээн тооцогдож ихэс дээдсийн ширээнд мурены сүү, тогосын тархи, хараацайн хэл зэргээр хачирлан тавьдаг байжээ.

Эдгээр далайд оршигч өөр бас нэг амьтан эртний Римийн балар цагийг миний санаанд орууллаа. Энэ нь лоцман хэмээх бяцхан загас бөгөөд тэр, цаг үргэлж аврага загас дагах бүлгээ. Эрт дээр үеийнхэн сүсэг бишрэлээр тэрхүү бяцхан загас хөлөг онгоцны хитэгт шигдэн зүүгдвэл түүнийг зогсоож чадна гэдэг байжээ.

Би бас эртний Грекийнхэн шүтэж байсан anthias хэмээх дур булаам, гуа сайхан загас олж озсэн нь энэ загас өөрийн оршин суурьшиж буй газар үүрлэж бугшсан ад чөтгөрийг үлдэн хөөж чаддаг гэж грекчүүд сүжиглэдэг байлаа. Тэдгээр загасыг anthias хэмээн нэрлэсэн нь “цэцэг” гэсэн үг ажээ. Үнэхээр ч тэд, тэр нэрэндээ тохирч, цайвар ягаанаас авахуулаад хүрэн улаан хүртэл, бүх л төрлийн өнгөөр солонгорон туяарах ажээ.

Далайн тэрхүү гайхамшгаас би нүдээ салган ядаж байтал минь намайг гэнэт нэгэн үл санасан сонин явдал цочоож билээ. Тэр нь бүсэлхийндээ арьсан цүнх зүүсэн нүцгэн хүн усан доор шумбан орж ирсэн хэрэг бүлгээ. Энэ бол яах аргагүй амьд хүн байв. Тэр хэд дахин дээшээ самардан гарч, дахин доошоо шумбан орж ирж харагдав.

Би сандрахдаа капитан Немо руу эргэн хандаж, сэтгэл түгшим өгүүлрүүн:

- Хүн живж байна! Түүнийг ямар ч гэсэн аврах хэрэгтэй!

Капитан Немо надад юу ч хариу дуугарсангүй харин цонх руу яаравчлан ойртов.

Шумбагч хүн дахин доошоо сэлж ирээд цонхны шилэнд наалдан бидэн луу харж байв.

Харин тэгтэл капитан Немо тэр хүнд ямар нэгэн дохио өхөд миний гайхаж хоцорсон гэдэг хэмжээгүй. Шумбагч хүн хариуд нь толгой дохиж орхиод тэр

даруйдаа дээшээ самардан алга боллоо. Тэр дахиад үзэгдсэнгүй.

- Түүний төлөө санаа бүү зов хэмээн капитан Немо надад хэлээд.

- Тэр бол Матапан хушууны хүн. “Загас” гэдэг хочтой Николай гэгч. Түүнийг Грекийн ольтригийн бүх арал дээр андахгүй. Агуу усчин хүн дээ! Ус гэдэг түүний төрөлх нутаг. Тэр, хуурай газар дээр байхаасаа, усан дотор байх нь илүү дэг. Тэр, арал дамжин зогсоо зайгүй хэсүүчилж самран явдаг, заримдаа Крит дээр очдог удаа бий.

- Та түүнийг таних уу, капитан?

- Таньж болохгүй тал нь юу билээ. Ноён Аронакс? Тэгж хэлчихээд капитан үзэсгэлэн танхимын хананд далд хийсэн шүүгээ руу ойртон очлоо. Тэрний зэргэлдээ төмрөөр тоноглон жижиг модон авдар байх нь халиван дээрээ “хөдөлгөөн доторхи хөдөлгөөн” гэж сийлээд капитаны нэрийн “Н” гэсэн эхний үсгийг цохиж гаргасан “Наутилус”-ын тэмдэг хавтгай зэс хадаастай байв.

Капитан Немо над руу дахин анхаарсангүй тэр шүүгээг нээмэгц үнэт металлын цутгамлаар бараг дүүрэн байв. Тэдгээр нь бүгд алтан ембүү ажээ. “Асар их хэмжээний тэр металл! “Наутилус” дээр хаанаас тэгж хуримтлав аа? Капитан Немо хаанаас тэгж, тэр их алт авч, түүнийгээ одоо яах гэж байгаа юм бол оо?”

Би амнаасаа нэг ч уг унагасангүй дув дуугүй ширтэн зогслоо.

Капитан Немо уул шүүгээнээсээ алтан ембүүнүүд нэг нэгээр нь гарган, нөгөө жижиг авдранд хийж дүүргээд орхив.

Миний бодож гаргаснаар бол тэр авдарт мянгаас доошгүй килограмм алт хийсэн нь бараг таван сая франкийн хөрөнгө болов шиг болтой.

Дараа нь капитан авдрын халивыг хааж дээр нь явуулах хаягийг нь бодвол шинэ Грек хэл дээр бичих шиг бололтой.

Тэр бүхнийгээ дуусгасны дараа тэр, онгоцны багийнхны өрөө руу оруулсан цахилгаан хонхны товчийг дарав. Тэр даруйхан найман хүн ирж өнөө авдрыг арай ядан үзэсгэлэн танхимаас авч гарлаа.

Тэр авдрыг тавцан дээр гаргахын тул шат өөд ачаа өргөх багажийн тусламжтайгаар хэрхэн татаж байхыг нь би дараа нь сонссон юм. Тэр минутанд капитан Немо над руу эргэж,

- За тэгээд, та юу гэж ярилаа, ноён профессор? хэмээн асуухад нь би:

- Би юу ч гэж яриагүй ээ гэв.

- Тийм бол танд амгалан нойрсохыг хүсье гэж хэлчихээд үзэсгэлэн танхимаас гарч одов.

Түүний дараа би тэр бүхнийг нэн их сонирхон, сэтгэл хөдөлж өөрийнхөө өрөөнд хүрч ирэв.

Би унтахыг хэдий их хичээсэн боловч дэмий оролдлого болжээ. Алтан ембүүтэй авдар, усчин хүн хоёрын хоорондох зохилдох холбоог бодоод бодоод олж чадахгүй байгаа болхи миний сэтгэхүй амар заяаг минь үзүүлэхгүй байв.

Удсан ч үгүй онгоц үл мэдэг халбилзан эхэлснээр “Наутилус” усан дээр ил гарч ирснийг би таамаглалаа.

Дараа нь би тавцан дээгүүр явах хөлийн чимээ олж сонссон бөгөөд тэр чимээгээр завийг байрнаас нь гаргаж усан дээр тавьж байгаагий нь мэдлээ. Усан дээр байгаа завь “Наутилус”-ын бөөр руу нэг мөргөх шиг болсноо дараа нь чимээ бүр тасрав.

Түүнээс хоёр цагийн дараа чимээ дахин гарч завийг буцаан татаж, байранд нь бэхэлж буй бололтой. Дараа нь “Наутилус” дахин усанд шумбан орлоо.

Үүнээс авч үзвэл, олон сая төгрөгийн хөрөнгө хаяг ёсоор хүргэгдсэн буйзаа. Гэвч, хаана хэнд хүргэгдэв ээ? Капитан Немогийн холбоо баригч нь хэн юм бол?

Дараачийн нь өдөр, шөнийн явдлыг Нед Ленд, Консель хоёрт би ярилаа.

Өнгөрсөн бүхнийг сонссон миний нөхөд надаас хэт гайхаж билээ.

- Хаанаас тэр, тэдгээр хар мянгыг олно вэ? гэж Нед Ленд асуусан юмдаг.

Тэр асуултанд нь би хариу өгч чадсангүй. Өглөөний хоолны дараа би үзэсгэлэн танхимд орж ажиллахаар суув.

Тэгээд би өдрийн тав хүртэл өдрийнхөө тэмдэглэлийг бичлээ. Гэтэл санаандгүй гэв гэнэт их халуун болов.

Тэхээр нь хүрмээ тайлчихлаа. Тэгэвч тус болсонгүй. Амьсгалах гэдэг минут тутамд бүр хэцүү болоод байдаг.

Түүний учрыг тайлбарлахын арга алга. Бид халуун орноос алс хол явлаа, тэр тусмаа усан дотор явсан “Наутилус” гадна агаарын температурын нөлөөг үзэх ёсгүй. Би даралт хэмжих багажны зүүг харвал бид жаран футийн гүнд байв.

Би ажлаа үргэлжлүүлэхээр оролдсон боловч халуун улам дэндэж, сууж байж болохын эцэсгүй боллоо.

“Үгүй ээ, энэ чинь онгоцон дээр “түймэр гарчихаа юу?” гэж би бодлоо.

Би сандрахдаа үзэсгэлэн танхимаас гүйж гарах гэтэл капитан Немо урьдаас ороод ирлээ. Тэр шууд термометрийн зүг очиж мөнгөн усны баганы нь хөөрөлтийг хараад, дараа нь над руу эргэж:

- Дөчин хоёр градус! гэв.

- Түүнийг ч би мэдэрч байлаа. Капитан хэмээгээд би - хэрэв л түүнээс хэтэрвэл,



бидэнд муу юм болохдог шүү гэлээ.

- Ай даа, эрхэм профессор хэрэв бид хүсэх л юм бол температурыг түүнээс ч дээш болгож болно.

- Та, тэхээрээ эндэх температурыг өөрийнхөө дураар ихэсгэж юм уу, эсхүл багасгаж чаддаг байх нь ээ?

- Үгүй ээ, гэвч би температурыг ихэсгэж байгаа гал голомтонд ойртох юм уу, холдож чадна.

- Тэгвэл, тэр голомт тань “Наутилус”-аас тусгаар, хол байгаа юм байх нь ээ?

- Тэгэлгүй яахав, бид буцалж буй усан дотор явж байна.

- Та нээрээ хэлж байна уу? гэж би дуун алдвал капитан:

- Өөрөө бодоод үз л дээ гэв.

Энэ үед цонхны хаалт халхавчнууд сөхөгдөхөд би “Наутилус”-ыг тойрон цав цагаан ус байхыг үзэв. Тогоон дотор буцалж буй мэт усанд хүхэрлэг уур хөшилдөн хавтгайрч байлаа. Цонхны шилэнд хуруугаа хүргэж үзвэл, тэр маш их халсан тул би арга буюу гараа угз татан авч билээ.

- Бид хаана байгаа нь энэ вэ? хэмээн би асуувал, капитан:

- Санторин арлын дэргэд байна, эрхэм профессор минь хэмээгээд - Хэрэв яг мэдэхийг хүсвэл Неа-Камменийг Палеа-Каммениас тусгаарласан хоолойд байнам. Усан доорхи галт уулын оргилолт энэхүү үзэгдлийг би танд үзүүлэх гэсэн юм гэлээ.

- Арал шинээр тогтох явдал аль хэдийнээ зогссон гэж би бодож байсан юм шүү гэж би нэмэрлэн хэлэхэд, капитан Немо ярьсан нь:

- Галт уулын оргилолт зогсоогүй цагт, газар хөрс тогтолтын нэг ч процессыг туйлдаа хүрсэн гэж үзэж болохгүй. Үгүй ээ, энэ чинь газрын бөмбөрцгийн дотоод гал халуун хүч хуучин хэвээрээ л байна шүү дээ. Хэрэв түүхчин Кассиодор, Плиний хоёрт итгэх юм бол манай энэ эрингийн арван есдөх жил эдгээр арал дөнгөж саяхан үүсч тогтсон яг энэ орчинд, Теия арал шив шинээр үүсч тогтжээ. Дараагаар нь тэр жаран есөн онд усан дороос дахин шинээр цухуйн гарч, бүр сүүлдээ бүрмөсөн алга болж одохын тулд тэр нэгэн цагт далайн давалгаан доогуур шургаж далд орсон юм. Тэр цагаас хойш манай энэ өдрийг хүртэл галт уулын ажиллагаа энэ орчинд унтарсан юм. Гэтэл харин 1866 сны хоёрдугаар сарын гурванд Неа-Каммены арлын дэргэд уул мэт хөглөрч агсан хүхэрлэг уур манан дундаас гэв гэнэтхэн цоо шинэ арал урган гарч ирсэн ажээ. Түүнийг Георг арал гэж нэрлэсэн. Тэгтэл тэр маань хоёрдугаар сарын зургаанд харин, Неа-Каммены аралтай нэг болчихсон ажээ. Гэтэл түүнээс долоо хоногийн дараа хоёрдугаар сарын арван гурванд Неа-Каммени арлаас аравхан метр

өргөн хоолойгоор тусгаарлагдсан Афроэс гэдэг бас нэг шинэ арал бий болжээ. Энэхүү нэн ховор явдал болж байх үеэр би энэ орчинд санамсаргүй хүрч ирсэн тул арал үүсэлтийн бүх үе шатыг ажигласан юм. Афроэс гэгч бяцхян арал хэлбэрээрээ бараг дугуй, хөндлөөшөө гурван зуу, өндрөөшөө гучин фут байсан юм. Арлын чулуулаг дотроо хээрийн жоншны хэлтэрхий шигтгээ толбо бүхий шил маягийн хайлмаг хар лагаас тогтсон байсан. Тэгтэл хамгийн сүүлд, гуравдугаар сарын арванд Неа-Каммени арлын дэргэдээс, бусдаас бүр бага Рэк гэдэг гурав дахь жаахан арал, далайгаас шомбойн гарч ирээд, гурван арал гурвуулаа нэгдэж нэг болсон юм.

- Бидний одоо байгаа энэ хоолой ямар хоолой гээч вэ? гэж би асуув.

- Энэ байна хэмээн капитан Немо, Грекийн ольтригийн зураг дээр түүнийг зааж, харж байгаа биз дээ, шинэ арлуудыг би газрын зураг дээр тэмдэглэчихсэн байхыг гэв.

- Энэ хоолойн ёроол, бас л хэзээ нэгэн цагт, өргөгдөх байх даа?

- Яаж ч мэднэ эрхэм профессор минь. Яагаад гэвэл 1866 оноос хойш Палеа-Каммени арал дээр, Ариун Николай гэдэг боомтын халз өмнө, найман шинэ арал бий болоод байгаа юм. Үүнээс авч үзвэл төдий л их удахгүй Неа-Каммени, Палеа-Каммени хоёр нэгдэж нэг арал болох нь тодорхой хэрэг. Номхон дөлгөөн далайд шинэ арал үүсэх явдал бол шүр биетний л хийдэг ажил. Харин эдгээр усанд бол шинэ арлууд буй болж байгаа баян хишгийг галт уулын ажиллагаанд л хүртээвэл зохино. Харж байгаа биз дээ, эрхэм ноён профессор та усан доорхи амьдрал гэдэг өчүүхэн зуурч амсхийхгүйгээр үргэлж буцалж байгаагий нь!

Би цонхонд дахин ойртож очив. “Наутилус” үл хөдөлж билээ. Халуун гэдэг тэсэхийн эрхгүй боллоо. Цагаан байсан ус, төмрийн ямар нэгэн давс холилдсоноос ч юм уу улаан болчихжээ.

Гэгээвчийн шил хүрээндээ хэдийгээр нягт бөглүү суулгагдсан ч гэсэн үзэсгэлэн танхимд хүхэрлэг хийн өмхий үнэр орж байв. Усан дотор би улаан гэрлийн ундрага, нүд гялбам хурц улаан дөл олж харсан нь манай хөлгийн цахилгаан чийдэнгийн тод гэрэл түүний дэргэд бүдэг ажээ.

Миний хөлс цутгаж, би амьсгаадаж эхлэв. Ахиад л хэдэн минут болог, тэгвэл ч би амьдаараа болчих байснаа мэдэрч билээ!

- Энэхүү буцлам халуун усанд удаан байх гэж бодохын ч хэрэг алга гэж би капитанд хэлбэл тэр:

- Тиймээ, тэгвэл ч тун болгоомжгүй хэрэг болохсон биз хэмээн ажиг ч үгүй хариулж байв.

Тэгээд тэр ямар учиртай юм нэг товч дарлаа. “Наутилус” аян замдаа ахин хөдөлж, удаахан байсан бол бидэнд үхлээр заналхийлж агсан тэр тамын ёроолос хурданчлан холдож одов. Түүнээс арван таван минутын дараа бид далай дээр ил гарч цэвэр агаар хомхойрон амьсгалж билээ.

Хэрэв л Нед Ленд оргож зайлах газраа энд сонгож авсан бол бид амьдаараа болох байсан гэдэг бодол миний толгойд орж бүлгээ.

Маргааш нь хоёрдугаар сарын 16-наа “Наутилус” Матапан хушууг тойрч, Грекийн ольтриг орчноос холдож одлоо.

[Тор](#)

---

## ГАЗРЫН ДУНДАТ ТЭНГИСИЙГ ДӨЧИН

### НАЙМАН ЦАГТ

Эртний Еврейчууд бол “Их тэнгис” эртний Грекчүүдэд бол зүгээр “тэнгис” эртний Римчүүдэд бол “Манай тэнгис” гэгддэг гүн цэнхэр Газрын дундат далай бол өндөр өндөр уулсаар хүрээлэгдэн далайн нарс, алоэ, кактус, зүржийн моддын өтгөн цэцэрлэгээр бүслэгдэж, цэвэр тунгалаг агаартайгаараа алдаршин, мөнх ногоон цэцэрлэгийн анхилам үнэрийг түгээж ус гал хоёрын унтаршгүй тэмцлийн талбар болж ирлээ. Нептун, Плутон хоёр энд ертөнцийн ноёрхлын төлөө үүрд тэмцэлдлээ. “Газрын дундат далайн эрэг дээр, уур амьсгалын энэхүү шилдэг ертөнцөд хүн, хүчин чадал, эрүүл мэндийг дахин шинээр хүртыюү” хэмээн Мишле бичжээ. Гэвч хоёр сая нэг зуун мянган километр цоо дөрвөлжин талбайг эзэлсэн, гуа жавхлангаараа олноо алдаршсан усны энэхүү их савыг би зөвхөн явуут үзэж өнгөрөөлөө.

Тэгтэл бас Газрын дундат далайг гаталсан тэр бүх хугацаанд ганц боловч удаа нүдэнд үл үзэгдсэн тэр хачин хүн капитан Немогоос би элдэв нэгийг асууж, гайхаж биширсэн өчүүхэн сэтгэлээ баяжуулах завшаан надад тохиолдсонгүй ээ. Үүний ташрамд бас хэлэхэд бид маш их хурдтай явсан тул “Наутилус” онгоц хоёрхон хоногийн дотор, усан доогуур хоёр мянга дөрвөн зуун километр аялсан бүлгээ. Бид хоёрдугаар сарын 16-нд Грекийн ольтригоос гараад хоёрдугаар сарын 18-наа үүрээр Гибралтарын хоолойг өнгөрч явлаа.

Тал бүрээсээ хуурай газраар хүрээлэгдсэн энэ далайд капитан Немо дургүй тул тэрнээс зугатааж буй нь надад ойлгомжтой байв. Энэ далайн давалгаа ч юм уу,

эсхүл салхи нь ч юм уу, санаваас харамсалтай дурсамж хийсгэн авчирч байгаа ч юм билүү, үгүй бол бүр тэрнээс долоон доор юм, буцалтгүй алдагдсан зүйлийн тухай хайрлалтай бодол төрүүлж байгаа ч юм билүү, яаж мэдэх вэ? Эсхүл бусад далайнуудад чөлөөтэй зорчигчдын нэгэн адил, тийм чөлөөтэйгээр, энэ далайд зорчиж үл болох явцуу байдал түүний уурыг бадраасны улмаас Африк, Европ хоёрын эдгээр ойролцоо эрэг хооронд “Наутилус” ердөө л давчуу байсан болов уу?

Ямар ч л гэсэн бид цагт арван хоёр бээр буюу дөчин найман километрийн хурдтай явж байв. Оргож зугатаах Нед Лендийн бодол түүнд хэдий хөөрхийлэлтэй байлаа ч гэсэн тэр тухай санахын ч хэрэггүй гэдэг нь мэдээж хэрэг билээ. Секундэнд арван хоёр, гурван метр газар нисэх мэт довтолж буй цагт завийг хэрхэн тэр ашиглаж чадах билээ. Тэр бол мөн тиймэрхүү хурдтай давхиж яваа галт тэрэгнээс дэвхрэх гэсэнтэй адил үг бөгөөд тэгж дэвхрэхийг зориглосон хүн сайнаа үзэхгүй нь лавтай биздээ. Түүний зэрэгцээгээр “Наутилус” агаар солихоор, зөвхөн гүн шөнийн харанхуйд усан дээр ил гарч ирээд бусад бүх хугацаанд луужин ба хурдны хэмжүүр хоёрын заалтаар баримжаалан давхиж байв.

Тийм учраас би ч гэсэн буухиа галт тэргэнд яваа хүн алс холын зурвас бараа хараад л нүднийхээ урдуур цахилгаан мэт жирэлзэж байгаа замын ойр орчны зүйлсийг харж үл чаддаг шиг Газрын дундат далайд юу ч базааж олж хараагүй билээ.

Гэлээ ч гэсэн Консель бид хоёр сэлүүрийнхээ эр чадалтайд “Наутилус”-тай хэсэг зуур хурдлан өрсөлдөж чадах Газрын дундат далайн хэд хэдэн загас олж харж амжсан бүлгээ.

Бид үзэсгэлэн танхимын цонхны дэргэд бүхэл бүтэн цагаар зогсон байхад миний тэмдгэлэж авсан өчүүхэн зүйл энэ хавийн уснаа орших загасны аймгийн ерөнхий байдлыг бүдүүвчлэн зурах бололцоог надад өгч байгаа юм.

Газрын дундат далайд орших олон тооны загасны дотроос зарим хэсгий нь нилээд удаан ажиглаж авсан боловч заримы нь дөнгөж харахын төдий л өнгөрөөсөн болон зарим хэсгийг нь маш хурдан явсны улмаас ерөөсөө ч олж үзээгүй бүлгээ.

Тэдгээрийг би зөвхөн зөн билэгчлэн ангилж зурах зөвшөөрлийг өөрийн биед өх бөгөөд энэ нь үнэндээ, миний түргэн зуурын өчүүхэн сэтгэгдлийг та бүхэнд уламжлах болно.

Цахилгаан чийдэнгийн гэрэлд тод гэрэлтсэн усны зузаан давхаргад бараг бүх далайд тохиолдох гулзгар нарийхан биетэй, метр хэр урт миногууд мурилзан тахилзан явж харагдлаа. Түүнээс гадна усны урсгалд нэвсийтэл хөвж яваа майхан

шиг, багавтар нь хурц нарийхан, том нь хурц бүдүүн бүдүүн өргөс арзайлгасан бэржгэр арьстай, таван фут өргөн хэмжээний өргөслөг скатууд далбаганаж явав Ска- тын өөр дүрсүүд бидний нүдний урдуур гялалзаж өнгөрөх нь тун хурдан тул эртний Грекчүүдийн өгсөн “далайн бүргэд” гэсэн цол буюу эсхүл одоогийн далайчдын өгсөн зараа, харх, илбэнх гэх мэт хогнууд тэдэнд таарсан эсэхийг нь би шалган дүгнэж чадахгүй байв.

Далайн гахайн төрлийн аврага загасны язгуурт хамаарагдах сельдийн төрлийн ялангуяа загасчдад нэн аюултай аврага загас бидэнтэй уралдаж байв. Түүнчлэн бид аврага загасны хүрээ, селяхийн багт багтах, уртаараа найм ба наймаас ч илүү фут далайн үнэг гэдэг загас олж үзсэн билээ. Далайн энэ нэг амьтан тун сүрхий үнэрч авъяастай, нуруу бөөр нь хар хөх, биений доод тал, хэнхдэг чь толболог цайвар байв.

Цааш нь спарын язгуурын загасан дотроос дорадууд бидэнтэй дайралдлаа. Тэдгээрийн зарим нь зуун гуч хүртэл сантиметр урт байсан бөгөөд мөнгөлөг ягаан өнгөт хайрс нь сэлүүрүүдийнхээ тод шар өнгөнөөс бүр ч тод тунгалаг гялалзаж байлаа.

Бас хоёр гурван метр том агуу сайхан осетрууд үзэсгэлэн танхимын цонхоор шагайх боловч бидэнтэй зуузай холбох чадал мөхөс тул тэр даруйдаа жижиг хүрэн толбо бүхий сунагар хөх нуруугаа харуулан хол хаягдаж байв. Осетрууд биений хэлбэрээр аврага загастай адил боловч чадлаараа тэднийг гүйцэхгүй ээ. Тэд өөрийн амьдралын ихэнх хэсгийг далайд өнгөрөөж, Ижил, Дунай, По, Рейн, Луар, Одер зэрэг мөрнүүдийн урсгалын эсрэг тэмцэлдэн явж хаврын цагт үрээ цацдаг бөгөөд селдь, макрель мэтийн жижиг загасаар хооллодог юм.

Газрын дундат далайд оршигчдын дотроос би хамгийн сайн танилцсан минь тунцууд бөгөөд тэдгээрийн нуруу нь хар хөх, цээжний нь хуяг цэнхэр, хажуу хавирга, гэдэс зэрэг нь мөнгөлөг цагаан толботой боровтор өнгөтэй ажээ. Тэднийг далайд яваа хөлөг онгоцны сүүдэрт хоргодон дагаж халуун орны галдам халуун нарнаас бие халхалдаг гэж ярьдаг нь худлаа ч биш бөгөөд тэд хэзээ нэгэн цагт Лаперузын онгоцны сүүдэрт хоргодон явсан шигээ “Наутилус”-ын сүүдэр талд нэг ч сантиметр хоцрохгүйгээр урт удаан хугацаагаар дагалдан явсан билээ.

Байгалиас хурдан гүйдлийн өрсөлдөөнд зориут оролцуулж байхаар төрүүлсэн мэт эдгээр загасыг би харан харсаар мэл гайхсан байв. Тэд жижигхэн шовгор толгойтой гурав буюу бүр дөрвөн ч метр урт, ээрүүл маягийн гонзгор биетэй, нэн хүчирхэг цээжний ба сүүлний сэлүүртэй билээ. Тунцууд зарим нэгэн нүүдлийн

шувууд шиг хажуут гурвалжин үүсгэн хурдалж байв. Тэдний энэхүү жагсаалаас иш татаж эртнийхэн тунцуудийг хэмжих ухааны ба стратегийн зарим мэдэгдэхүүнүүдийг мэддэг гэж нотолж байжээ.

Гэлээ ч гэсэн тэдний “Их эрдэм” өөрсдий нь хөдөөгийн нутгийн загасчдын торноос авардаггүй ажээ.

Тунцуудийг хөдөөнийхөн эртний Пропонтид ба Испанийхны нэгэн адил өндрөөр үнэлж үзнэ. Эдгээр гайхамшиг сайхан загас сохор мэт мөргөж тэмтчин явсаар жил бүр хэдэн зуун мянгаараа Марсель газрын урхинд орж баригддаг байна.

Хэрэв би эвэр нуруутыг ч, далайн морийг ч, саран загасыг ч, тэвшин загасыг ч, сельдийг ч, бухандайг ч, далайн зарааг ч, уруул загасыг ч, сэлмэн хоншоортыг ч, феринкийг ч, өргөс загасыг ч, анчоусыг ч, тэрчлэн Газрын дундат далайд орших бусад олон төрлийн загасыг олж үзээгүй бол түүний бурууг надад хүлээлгэх нь бус, харин энэ орчноор давхисан “Наутилус”-ын нүд эрэлжлэм хурдыг буруушаах хэрэгтэй.

Тэр орчны сүүгээр бойжигчдын хувьд бол биднийг Адриатикийн далай өнгөрч явах үед надад шүдэт халим, хоёрын зэрэг харагдах шиг болсон бөгөөд бас далайн хэд хэдэн гахай, сүүлт лам гэдэг хочтой ню, үнэндээ ч доминикан ламтай яг адилхан арваад хав загас олж харсан билээ. Төдөлгүй Консель маань зургаан фут өргөн, аврага том яст мэлхий үзсэн нь хуяган дээрээ тууш долоон гүвгэр судал буюу товгор байв. Тэр яст мэлхийг би үзээгүйдээ тун харамссан бөгөөд дүрслэн ярьж байгаагаар бол яст мэлхийн төрөлтнөөс хамгийн ховор дүрс-арьст мэлхий байсан буйзаа. Хөндий хэвэлт дотроос хэдхэн секундийн турш үзэсгэлэн танхимын цонхны шилэнд наалдан байсан галеолярийн нэгэн гойд дүрсийг олж үзэв. Энэ бол бүх фландри даяар нэг ч уран нэхмэлчин сүлжиж үл чадах гайхалтай нарийн сүлжилдэн тогтсон салаалсан сиймхий мяндас байв. Миний аз дутахад энэхүү гойд нэгэн амьтныг барьж авч чадаагүй бүл- гээ.

Хэрвээ хоёрдугаар сарын 16-нд орой тийшээ “Наутилус” гүйдлээ удаашруулаагүйсэн бол би Газрын дундат далайд дахиад нэгхэн ч ширхэг хөндий хэвэлтэн олж үзэхгүйсэн билээ.

Энэ явдал ямаршуу байдалд болов оо гэвэл: Бид Сицилл арап, Тунис хлёрын хоорондуур гарч явав. Энэ нэг нарийхан зурвас газар далайн ёроол гэв гэнэт дээшээ эгц өргөгдсөн байдаг билээ. Энэ орчинд усан доорхи уулын хяр хянгалан хамарлаж байх тул усны гүн энэ хэсэгт дөнгөж арван долоохон метр хүрдэг бөгөөд тэгвэл тэрхүү хянгалсан хярын хоёр хажуу руу барагцаалбал далан метр хүрнэ. Тиймээс

“Наутилус” энэхүү усан доорхи саадыг мөр- гөчихгүйн тул болгоомжтой явах хэрэгтэй байжээ.

Усан доорхи тэр нэг хамарласан хад байгаа газрыг би зураг дээр Консельд зааж өгвөл:

- Эзэн хэрэв зөвшөөрвөл би энэхүү нурууг Европ Африк хоёрыг холбосон хүзүүвч мөн хэмээн хэлэх байнам гэлээ.

- Чиний зөв, хонгор минь хэмээн өгүүлээд-Сициллийн хоолойг тэр бүхлээрээ хаасан юм. Смитий шинжилснээр бол эдгээр хоёр тив, Аддар ба Марсал хоёр хушууны хооронд, хэзээ нэгэн цагт хуурай газраар холбогдож байсан юм гэв.

- Үүнд дуртай итгэх байнам.

- Би бас нэмж хэлэхэд Гибралтар, Сеут хоёрын хооронд мөн иймэрхүү хүзүүвч байдаг юм. Тэр хүзүүвч геологийн балар эртний эрингийн үед Газрын дундат далайг таг хааж байжээ.

- Хэрэв нэг сайхан өдөр галт уулын түрэлт тэр хүзүүвчийг уснаас түлхээд ил гаргачихвал..

- Тэр ч итгэхэд бэрх дээ гэж би түүний яриаг таслан авбал, Консель:

- Эзэн хэрэв зөвшөөрвөл би өөрийнхөө бодлыг хэлчихье. Ямар ч гэсэн хэрэв тийм юм болбол Суэцийн хүзүүвчийг сэтлэх гэж тэгж их хүч гаргасан хөөрхий Лессепсийн хөдөлмөр надад мөн хайрэн байна! гэлээ.

- Тэгэлгүй -дээ, Консель минь. Гэвч чи сэтгэл их зовсны хэрэггүй, тийм юм болохгүй нь лав! Газар доорхи гал халуун хүч аяндаа багасч байна. Газар дэлхийг анх тогтож байхад байсан тэр олон галт уулс нэг нэгээрээ сөнөж байна. Газар доорхи температур үеэс үед улам л багасан, азгүй юм болоход манай дэлхийн амьдралын эх булаг болсон тэр илчхарьж буй... ..

- Тэгэвч нар...

- Ганц нар юу шалих вэ, Консель минь. Тэр нар гэдэг чинь үхсэн хүүрэнд илч өгч чадах юм уу?

- Миний мэдэж байгаагаар бол ч үгүй дэг ээ.

- За тэгвэл, хонгор минь, нэг л харласан хар өдөр, дэлхий гэдэг чинь хөрчихсөн хүүр болчих юм шүү дээ. Тэхэд, газар дэлхий гэдэг яг л сар шиг амьд амьтангүй, амьдралынхаа дулаан илчийг аль дээр алдчихсан, тийм нэг сөнөсөн ертөнц болчих юм.

- Хэдэн зууны дараа энэ бүхэн болох ёстой юм? гэж Консель асуув.

- Тэд хэдэн зуун мянган жилийн дараа хэмээн би хариуллаа.

- Тэгвэл бид ч тэр үед, хэрвээ л Нед Ленд маань ч саад болчихгүй бол, энэхүү усан доорхи сайхан жуулчлалаа дуусгаж амжих юм шив дээ.

Газар дэлхийн ирээдүйн тухай сонсож сая нэг санаа нь амарсан Консель “Наутилу” одоо хэр тааруу хурдтай явааг ашиглан усан доорхи амьдралыг дахин ажиглаж эхлэв.

Тэнд галт уулын чулуулгаас гаралтай хад чулуун дээр Бугенбилийн медуз, далайн бортого, далайн хэмх зэрэг амьтад элдэв өнгөөр солонгорон харагдаж, биений нь хүрэн улаан өнгө орчныхоо усанд улаан туяа цацарган яваа метр хэр өргөн, аялан даялагч каматулууд урт урт голтой гидроактиний, хоолонд ордог мидийн олон олон дүрс, отгон, шар ногоон бут мэт тэмтрүүлдээ хучигдсан таваг бүхий, бор хөлтэй ногоон актини зэрэг амьтад мөн үзэгдэв.

Дараа нь Консель зөөлөн биетнийг шинжин ажиж эхлэхэд нэг нэгэн дээрээ овооролдсон пектуккулюс-спондили хэмээх сам хэлбэрийн хавчаахайн олон дүрс, далайн эрвээхээ хэмээсэн нэрэндээ яг зохицсон тунгалаг өнгийн сэлүүрүүдтэй шаль, эмгэн хумс, далайн туулай хэмээн алдаршсан аплизни, хоолонд ордог махлаг зүрхэн хясаа дун нь дотуураа үнэт танаар хучигдмал далайн чих, Лангедокт мах нь устричийнхээс амттай хэмээн таалагддиг мидий, гурвалжин донацийн далайн финик золил, мод талхигчид, катушек, цинерари ба бусад олон төрлийн зөөлөн биетэн байв. Гэвч Консель маань мэрийн ажиглалтыг хийж дуусаагүй байтал “Наутилус” Сициллийн хоолойн саадыг гэтэлмэгц урьдынхаа хурдаар давхиж одлоо.

Зөөлөн биетнүүд, хөндий хэвэлтнүүд, үе хөлтнүүд минь баяртай! гээд үзэсгэлэн танхимын цонхоор одоо бидний дэргэдүүр сүүдэр мэт нүүгэлтэн өнгөрсөн хэдэн том загаснаас өөр юу ч ялгаж танихын аргагүй боллоо.

Хоёрдугаар сарын 16-17-ны шөнө бид Газрын дундат далайн усны сан газар хоёрдох хонхор дээр хүрч ирвэл түүний усны гүн гурван мянган метрээс хэтрэхгүй ажээ. Яг энэ орчинд “Наутилус” гэв гэнэт доошоо живж орлоо.

Гэтэл байгаль дэлхийн гайхамшигт үзэсгэлэн биднийг энд угтаж байсан бус харин зүрх сэтгэл шимшрэм, харамсалт нэгэн үзэгдэл хүлээж байсан байжээ. Тэхнээ нь бид энэ хэр Газрын дундат далайд хөлөг онгоцнууд буснин сүйдэж аюул сүйрэл гарсан тэр орчинд иржээ. Алжир, Прованс хоёрын хооронд хичнээн хөлөг сураг чимээгүй алга болж, хэдэн онгоц сөнөснийг хэн мэдэх билээ.

Газрын дундат далай нүд алдам уудам Номхон далайн дэргэд өчүүхэн жаахан нуурын төдий бүлгээ. Гэвч нуур гэлээ гээд ааш муутай, бас дурандаа загнах дуртай, түүний ус нь тогтмол бус хуурамч, өнөөдөр тэр цэв цэнхэр толь мэт усан дээгүүрээ



хөвж буй хэврэгхэн хөлгийг бүүвэйлж энэрэх мэт боловч, маргааш болоход хамгийн том бөх онгоцыг болбой нь өөрийн давалгааны огцом цохилтоор, дараа дараалан балбаж зомгол болтол нүдэхдээ догшин ч, хэрцгий ч.

Энэхэн хурдан гүйлтийн дундуур уснгүзун давхрагын ёроолд хичнээн ч олон сөнөсөн онгоц миний нүдний өмнө жирэлзэн өнгөрсөн гээч. Далайн ёроолд удаан хугацаагаар хэвтсэн зарим нэг нь шохойлог бодисоор өнгөртөж сайхан сүйрээд удаагүй зарим хэсэг нь зэвэрсэн байв.

Бидний замын турш занга, их буу, сэнсийн гол, машины эвдэрхий хагархай цилиндр, дэлбэрсэн тогоо зэрэг зүйлс далайн ёроолоор нэг хөглөрч, зарим газраар ёроолоороо өөдөө уруугаа харсан хөлгийн бүхэл бүтэн их бие новшрон байв.

Эдгээр хөлгийн зарим нь хоорондоо мөргөлдөн сөнөж, зарим нь хад мөргөж сүйрчээ. Түүнчлэн далайн ёроолд ямар ч гэмтэлгүй шураг мод, тоног төхөөрөмжтэйгээ тэр чигээрээ, босоогоороо буучихсан хөлөг байхыг би олж үзсэн би- лээ. Тэд миний саналд алсын аянд мордохоор тушаал хүлээж далайн задгай татаалд занган дээрээ зогсох мэт байв.

Тэдний хажуугаар “Наутилус” явж өнгөрөх үед манай хөлгийн цахилгаан чийдэн тэдэн дээр тусахад угтан очиж буй манай онгоцыг мэндлэн хүндэггэж, аян замд сайн явахыг бидэнд ерөөхөөр тэдний урт хушуунд дээрх тугийн нь өндөр шон дээрх бяцхан дарцаг юу юугүй хийсэх гэж буй мэт санагдав. Гэгэл хийсч хөөрсөн дарцаг байсангүй ээ. Далайн тэдгээр хөлгүүдийн сэг хөглөрөн буй энэ газар хаа сайгүй нам гүм ажээ.

“Наутилус” Гибралтарын хоолойд дөтлөх тутам тэдгээр хөлгийн гунигт үлдэгдэл бүр олшрон, далайн ёроолоор дүүрэн хэвтэхийг би ажив. Ази, Африк хоорондын арлууд хоорондоо хичнээн л ойртож шахцалдах бүр хөлгүүд төчнөөн л олон мөргөлдсөн ажээ. Хөлгүүдийн төмөр их бие, ямар нэгэн этгээд хачин амьтантай адилхан зэрэмдэглэгдсэн үлдэгдэл сэгүүд ёрдойж хажуу бөөрөөрөө сарвайн хэвтэхийг энэ орчинд би олж үзлээ. Ялангуяа энд нэгэн сэлүүр хүрдэт галт онгоц хэвтсэн нь тун аймаар хүнд сэггэгдэл төрүүлсэн бөгөөд түүний бөөр нь хүү татсан мэт өм үсэрч, яндангууд нь тахийгаад сэлүүр, хүрднээс нь зөвхөн нарийхан төмөр бие нь үлдэж, залуур хүрд нь ор сууринаасаа булга үсрэн төмөр гинжиндээ санжигнаж бүх бие нь тэр чигээрээ зэвэнд идигдсэн ажээ. Түүнд явсан хэдэн хүн үхсэн бол? Тэр аймшигт сүйрлийг дараа нь ологд ярих хэдэн хүн амь гарсан бол? Аль эсхүл догшин долгио өөрийнхөө нууцыг, хэн нэгэн хүн бусдад ярьчих бий гэсэн шиг хардаж хувьдаа хадгална уу?..

Хориод жилийн өмнө жигтэй шалтгаанаар таг сураггүй алга болчихоод дэлхий дахины сэтгэлийг түгшээсэн «Атлас» гэдэг тэр онгоц энэ мөн гэсэн бодол миний толгойд орж ирлээ. Тэр их баялаг булагдаж, тийм олон хүн эцсийнхээ тайтгарлыг олсон далайн тэрхүү асар уудам булшны газар, Газрын дундат далайн нууцын тухай ямар аймшигт ном бичиж болно гэж санана?

.Тэр хооронд орчин тойрондоо нэн амарлингуй. “Наутилус” усан доорхи өөрийн гүйдлийг үргэлжлүүлсээр бүлгээ. Хоёрдугаар сарын 18-ны шөнийн гурван цагийн үед манай хөлөг Гибралтарын хоолойн аман дээр гарч ирэв.

Тэнд далайн хоёр урсгал байхаас нэг нь аль эрт дээр үеэс эхлэн олноороо мэдэх-Атлантын гадаад далайн усыг Газрын дундат далайд юүлэх дээд урсгал бөгөөд нөгөө нь түүний урдаас угтаж урссан доорд урсгал бүлгээ. Түүний байгааг байгалийн хууль зүйн дагуу нотолжээ.

Үнэхээр ч Атлантын далайгаас орж ирж буй ус болоод түүнд цутгаж байгаа гол мөрний усаар авч үзвэл Газрын дундат далайн усны төвшин жилээс жил улам бүр дээшлэх ёстой бөгөөд хоёр далайн усны төвшинг тэнцэтгэхэд ганцхан өнгөн талын ууршилт юу ч болохгүй гэдгийг баталжээ. Тэгвэл тэр далайн усны төвшин нэмэгддэггүй тул Газрын дундат далайн илүүдэл усыг Атлантын далайд урсгаж аваачдаг, яг Гибралтарын хоолой доогуур гарсан хоёрдогч урсгал байгаа гэдгийг зөвшөөрөх хэрэгтэй байв.

Нээрээ ч тэр урсгал үнэн хэрэг дээрээ байгаа ажээ. Тэрхүү замын чиг дагуу урсгалыг “Наутилус” ашиглаж, нарийхан хоолойгоор нисэх мэт давхин өнгөрлөө.

Геркулесын гайхамшиг сайхан сүмийн эвдэршгүй балгас миний нүдний урдуур секундийн дотор жирэлзэн өнгөрсөн нь Плингийн хэлснээр: Тэр сүм баригдсан аралтайгаа хамт далайн ёроолд сууж орсон ажээ Тэгээд минутын дараа бид Атлантын Гадаад далайн уснаа хөвж ил гарлаа.

[Тор](#)

---

### *ВИГО ХЭМЭЭХ ТОХОЙ*

Атлантын гадаад далай! Энэ бол хорин таван сая миль шоо дөрвөлжин км асар уудам талбайд хавтгайран цалгилах усны агуу их сан бөгөөд өргөөшөө дунджаар хоёр мянга, долоон зуу, уртаашаа бараг есөн мянга миль газар үргэлжилдэг бүлгээ!

Энэ асар уудам тэнгисийг эртнийхэн бараг мэддэггүй байв. Зөвхөн карфагенчууд буюу тэдгээр эртний голландчууд өөрсдийн арилжааны хэргээр л Африк ба Европын баруун эргээр тойрдог байсан байж болох юм;

Энэ тэнгисийн тахирласан эрэг асар хол газар мурилзан одож умарт Лавренти, Миссип, Амазонка, Ла-Платы, Ориноко, Нигер, Эльба, Лаур, Рейн зэрэг дэлхий дээрх асар том мөрнүүдийн адаг цутгаланд ихэд идэгдэн сүйдсэн ажээ.

Дэлхий дээрх хамгийн боловсон, гэтэл бас хамгийн бүдүүлэг газар орны нутаг дэвсгэрийг усжуулан ундлах тэдгээр гол мөрөн өөрсдийн арвин их урсгалыг аанай тэнгист цутгадаг билээ.

Тэнгис далайг туулагчдын сүр сүлдийг зайлуулах Горнын ба Шуургын хоёр хушуугаар төгсгөл болдог усны тэрхүү арвин их санг орон бүгдийн, үндэстэн бүгдийн хөлгүүд зүг бүр тийш нь хөндлөн гулдгүй хэрэн хэсэх ажээ.

“Наутилус” бүтэн гурван сар хагасын дотор бараг арван мянган бээр орчим газрыг буюу газрын бөмбөрцгийн гол бүслүүр шугамын урт хэртэй тэнцэх газрыг туулсны дараагаар өөрийн форштевнийн хурц үзүүрээр Атлантын гадаад далайн усыг зүсч явав. Одоо тэр аль зүгийг зорино вэ? Ирээдүйд биднийг бас чухам юу хүлээж буй бол?

Гибралтарын хоолойгоос гармагц «Наутилус» маань задгай тэнгисийг чиглэн одож билээ. Тэр усны гадаргуу дээр дахин эргэж ил гарах болсон тул бид өглөө бүр сэрүүн агаарт сэлүүцэх боломжтой боллоо.

Усан дээр тэрнийг хамгийн анх удаа ил гарч ирмэгц л би Нед Ленд, Консель хоёрынхоо хамт дээшээ гарахыг яаравчилсан билээ.

Биднээс хорин миль орчим зайтай, баруун урьд талаараа Испанийн хойгтой залгах, Ариун Виннентийн хушуу харагдаж байв.

Өмнөтийн нилээд хүчтэй салхи найрсаг бус далайн дээр том давалгаа босгож байлаа. “Наутилус” сүрхий сэгсрэгдэж бүлгээ. Байсхийгээд л далайн давстай ус навсайн бууж байгаа түүний тавцан дээр удаан зогсохын аргагүй байв.

Бид цэвэр агаар жаахан амьсгалчихаад, онгоцондоо яаравчлан орлоо.

Би өөрийнхөө оронд эргэж ирэхэд Консель ч мөн тасалгаа руугаа явсан бөгөөд харин нэгэн юманд санаа нь үймэрсэн Нед Ленд намайг дагалдав. Газрын дундат далайгаар тийнхүү хурдан явж гарсан нь төлөвлөгөөгөө биелүүлэх бололцоо түүнд өгсөнгүй бөгөөд тэр ч өөрийн өшиж гомдсоныг нуусангүй ээ.

Намайг өрөөнийхөө хаалгыг хаахтай зэрэг тэр сандал дээр суугаад, над руу чимээгүй харж байв.

- Таны байдлыг ойлгож байна, найз минь хэмээн би түүнд хэлээд, тайвшир та, танд өөрөө өөрийгөө зэмлэх ямар ч тал байхгүй. Энэхүү саяын жуулчлалын үе дэх нөхцөл шиг тийм нөхцөлд оргоно гэж бодвол галзуурсан хэрэг болно! гэв.

Нед Ленд хариу дуугарсангүй ээ. Түүний зангидсан хөмсөг, зуусан хөмхий тэр ямар нэгэн хүнд бодолд дарагдан буйг гэрчилж байв.

- Та аан гэж бай, хэмээн би цааш нь та гайгүй учир байдлыг ойлго л доо: Ердөө алдсан юм алга! Бид одоо Португалийн эргийн дагуу улам хойшлох, дээшлэх болно. Бид Англи, Францын ойролцоо гарна. Тэнд бас л хялбархан шингэж болно шүү дээ. Аа харин «Наутилус» хэрэв л Газрын дундат далайгаас мултармагц л хуурай газар гэж бараг байхгүй өмнө зүг рүү чиглэж одсон бол би ч гэсэн таны уй гашууг хуваалцах сан. Тэгвэл би! одоо капитан Немо хол хөдөлгөөнтэй далайгаас тойрч оддоггүйг мэднэ. Тэхээр та тиймэрхүү нөхцөл байдлын дунд хэдхэн хоногийн дараа өчүүхэн ч аюулгүй оргож гарах бэлтгэл хийж амжина даа гэж яриллаа.

Нед Ленд над руу бүр ч төвлөрөн ширтэж байгаад хамгийн эцэст хамхисан уруулаа сая нэг салгаж:

- Бид өнөө орой оргоно! гэж дуун гарав. Би хар эрээн могойд хатгуулсан мэт босон харайв. Үнэнийг хэлэхэд би түүнийг ийм юм хэлнэ гэж бодоогүй байж билээ.

Би түүнд эрс татгалзахыг хүссэн боловч хэлэх үгээ олсонгүй.

- Бид оргож гарах аятай нөхцөлийг хүлээхээр хэлэлцэж тогтсон хэмээн Нед Ленд цааш нь үргэлжлүүлж-Тэр аятай нөхцөл маань бүрэлджээ. Өнөө орой бид, Испанийн эргээс дөнгөж хэдхэн милийн зайд байх болно. Тэгвэл одоо шөнө саргүй харанхуй, салхи шуурга гэвэл мундахгүй л их байна. Та надад өөрөө амласан шүү дээ профессор минь, тиймээс би танд л найдаж байна гэлээ. Би таг дуугүй байв.

- Өнөө орой яг есөн цагт!-хэмээн тэр хэлээд-Би Консельд ч анхааруулсан. Яг тэр цагаар капитан Немо өрөөндөө ороод л түгжиж авна биз. Эсвэл магад ч үгүй унтаад өгч байж. Биднийг механик нь ч, усан цэргүүд ч, хэн ч харахгүй Консель бид хоёр тавцан өөд гардаг шатан доор нуугдчихамз. Ноён профессор та номын санд сууж миний өх дохиог хүлээх болно. Сэлүүр шураг мод, далбаа зэрэг завин дотор бий. Түүнчлэн тийш нь жаахан хүнсний юм ч авааччих зав гарсан. Би бас завиныхаа “Наутилус”-ын их биетэй бэхлээтэй байгаа эргийг мултлах англи түлхүүр олж авсан, тиймээс юм бүхэн бэлэн болжээ. Баяртай, орой уулзъя! гээд босох гэхэд нь би:

- Далай дэндүү догшин байна шүү дээ гэвэл:

- Таны энэ үгийг зөвшөөрнө. Гэвч үүнийг юманд бодохын зав алга. Жаахан зүрхэлбэл л эрх чөлөө бэлэн байна. Гэхэд “Наутилус”-ын завь ч бөх л дөө. Замын

салхины дагуу хэдхэн миль явах гэдэг ч, цаг агаар муу байлаа ч гэсэн бага хэрэг. Бид маргааш хуурай газрын эрэгт зуугаадхан миль очоод байхыг хэн мэдэх юм? Хэрэв хэргийн байдал бүтээмжтэй болбол шөнийн арав, арван нэгэн цагийн хооронд бид Испанийн эрэг орчны ямар нэгэн хэсэгт гарчихаж болно. Хэрэв л тийм биш бол тэр үеэр бид амьд байхгүй. Ингээд орой уулзъя! Баяртай! гээд канад хүн миний сэтгэлийг бүрмөсөн түйвээчихээд өрөөнөөс гарч одлоо.

Яагаад ч юм бүү мэд, оргох цаг яг болохоор л хамаг хэргээ Нед Лендтэй сайтар зөвлөж маргаж байгаад л болчихно гэж би бодож бүлгээ. Гэтэл тэс зөрүүд өнөө канад хүн харин надаар нэг ч үг хэлүүлдэггүй байна шүү. Гэсэн ч би түүнтэй юу ч гэж маргах юм билээ дээ? Нед Лендийн түмэн зөв. Энэ ч аргагүй л харьцангуй аятай нөхцөл тул тэр ашиглахаар шийдлээ...

Ингэхэд ер нь би нөхдийнхөө хувь заяаг гаргуунд нь гаргаж зөвхөн л өөрийнхөө ашиг сонирхлыг эрхэмлэж, хэлсэн үгээ няцаах эрх надад байв уу? Маргааш болоход капитан Немо биднийг аль нэгэн газар орноос алсалсан хол зүгт усан цөлд ахиад аваад явчихгүй гэж үү?

Яг энэ үеэр хүчтэй исгэрэх чимээ гарлаа “Наутилус” өөрийн хоосон багтаамжуудыг усаар дүүргэж тэнгисийн гүнд орж буйг би мэдэв.

Усан доогуур дэлхийг тойрох өөрийн жуулчлалыг дуусгалгүйгээр энэхүү гайхамшиг хөлөгнөөс арга буюу салан одох бодол, түүнчлэн эрх чөлөөг өөртөө ахин олж авах их хүсэл хоёрын дунд эргэлзэж ямар зовлонтой өдрийг би өнгөрөөсөн гэж санана!

Энэ тэнгисийг би өөрөө өөртөө нэрлэснээр “Миний Атлантик”-ийг Номхон далай, Энэтхэгийн далай хоёрын нэгэн адилаар бүх нууцы нь мэдэлгүйгээр тэгж гэнэтхэн орхин одох гэдэг чинь юу гэсэн үг вэ! Ертөнцөд ховор, дур сэтгэл булаам тэр сайхан номын хоёрхон ботийг нь уншчихаад, бусды нь уншихаас сайн дураараа татгалзах гэж үү?

Би өөрийнхөө өрөөнд ямар уйтгартай минууудыг өнгөрөөсөн гэж санана! Би нөхдийнхөө дунд хуурай газрын тунгалаг агаар шиг сэлүүн эрх чөлөөтэй байна гэж бодон сэтгэлээ хуурахыг оролдсон боловч харин тэрнийхээ эсрэг юу юунаас өмнө, ямар нэгэн үл санасан үйл явдал, Нед Лендийг төлөвлөгөөгөө биелүүлэхэд нь саад болоосой гэж хүсч билээ!

“Наутилус” хуурай газар өөд үү эсвэл түүний эсрэг чигт үү, чухам хаашаа чиглэж явааг нь, шалгахын тул үзэсгэлэн танхимд би хоёр дахин орж луужингийн заалтыг харлаа.

Гэвч байдаггүй ээ! “Наутилуо” дандаа л Португалийн эргийн ойролцоо явж байв. Түүний зам тэр эргийн дагуу шууд умартыг чиглэжээ.

Яахын ч арга алга. Оргоход л бэлтгэх хэрэгтэй боллоо. Миний авч явах юм ч юухан байхав. Дандаа л миний тэмдэглэл байв. Хэрэв Нед Ленд өөрийнхөө солирсон төлөвлөгөөгөө биелүүлчихэж чадвал капитан Немо юу гэж бодох бол оо? хэмээн би өөрөөсөө асууж билээ. Хэрэв бидний орголт бүтэмжгүй болбол тэр хачин хүн яах бол?

Би түүнд аль нэг талаар гомдох үндэсгүй гэдэг нь ямар ч эргэлзээгүй юмаа. Харин баярлавал зохино! Үүнээс хэт зочломтгой, найрсаг дотно, нөхөрсөг дулаан, хүлээн авалт бий гэхэд хэцүү бизээ. Гэтэл, нөгөө талаар авч үзэхэд, миний тийнхүү оргон зайлсан явдлыг тэр зэмлэн шүүмжлэх газаргүй юм. Оргохгүй гэж би түүнд амлаагүй ээ. Хөлгөн дээр биднийг түгждэггүй байсан бол, тэр нь “Наутилус”-аас оргож чадахгүй гэж капитан Немо, дүүрэн итгэснийх бөгөөд тийм болохоор л бид ам тангаргаа өгч онгоцон дээр эрх чөлөөтэй үлдсэн олзлогдогсод биш байлаа. Түүнээс гадна бид түүний хөлгийг нэг насаараа орхин үл одно хэмээн капитан Немо нэг бус удаа хэлсэн нь бидний оргон зайлах бүх талын оролдлогыг зөвтгөж байв

Би капитан Немотой Санатории арлын эргийн ойролцоо явах үед уг хэлэлцсэнээс хойш дахиж дайралдаагүй бүлгээ. Зүй тохиол биднийг нээрэн намайг оргохоос өмнө уулзуулчихна гэж үү. Би түүнтэй уулзахыг хүсэхийн хажуугаар түүнээс айж эвгүйрхэж байв.

Тэр миний зэргэлдээ өрөөнд байх тул би түүний алхааг чагнаж билээ. Гэвч, хананы цаанаас өчүүхэн ч чимээ үл сонсдоно. Бодвол тэр өрөөнд хэн ч байсангүй бизээ.

Тэр хачин хүн “Наутилус” онгоцон дээрээ ер нь байгаа бол уу хэмээн би өөрөө өөрөөсөө асууж суув. “Наутилус”-ын завь ямар нэгэн нууц даалгавар биелүүлж, онгоцыг орхиж одсон тэр нэг шөнөөс хойш би капитан Немог нэг л өөрөөр үзэх болсон бүлгээ. Тэрний өөрийн нь олон талын баталгааг харгалзахгүйгээр тэрнийг би хуурай газартай ямар нэгэн талын сүлбээтэй гэдэг дүгнэлтэнд хүрсэн юм. «Наутилус»- ыг тэр хэзээ ч орхиж одоогүй гэдэг яг үнэн үү? Би түүнийг бүхэл бүтэн долоо хоногоор олж үздэггүй цаг ч байсан шүү дээ. Тэр үеэр мань эр юу хийж яасан хүн юм? Эртхэндээ би түүнийг хүн төрөлхтнийг үзэн ядах гэнэтийн өвчинд нэр вэгдсэн хүн юм гэж боддог байсан бол одоо тэр хуурай газар дээр гарч, ямар нэгэн албан үүрэг гүйцэтгэдэг юм байнка гэсэн бодол миний толгойд орох болсон бөгөөд чухам ямар үүрэг гүйцэтгэж явдгий нь би өчүүхэн ч ойлгосонгүй. Энэ нэг бодол, бас

өөр мянга мянган таамаглал намайг зовоож миний амар заяаг үзүүлэхээ болилоо. Бидний оршиж агсан тэрхүү хачин байдлын дунд хамгийн янз бүрийн ямар ч иш үндэсгүй бодол сэтгэгдэл төрж болох байв.

Би тэсч байж чадахыг больж тэр байдал надад эцэс хязгааргүй мэт санагдав. Цаг гэдэг байж болшгүй удаан өнгөрөх ажээ.

Миний хоолыг, урьдын адил өрөөнд минь авчирч байв. Болохыг завдан буй их хэрэгт сэтгэл тогтворгүй болсон тул би бага идлээ. Би ширээний араас долоон цагт бослоо. Намайг Нед Лендтэй уулзах тэр цаг хуртэл зуун хорин минут л “би минут бүрийг тоолж байсан юм” үлджээ.

Миний сэтгэл улам бүр түгшин би нэг байрандаа сууж чадахаа байлаа. Түгшсэн сэтгэлээ тайтгаруулахыг горилон өрөөн дотуураа нааш цаашаа холхин алхлав. Оргох гэсэн энэ нэгэн этгээд оролдлогоос болж бид үхнэ гэдэг бодол ч миний сэтгэлийг төдий л их зовоосонгүй бөгөөд харин “Наутилус”-ыг бид орхин одохоос урьд бидний төлөвлөгөө нурж, энэ явдал баригдвал, түүнчлэн тэрхүү нүүргүй муухай урвалтынхаа уршгаар галзуурсан мэт хилэгнэсэн буюу эсхүл ямар сайн байхав, тэр явдлын улмаас бидэнд гомдож урам зориг ий хугарсан капитан Немогийн өмнө зогсоно гэдэг аюул л намайг хэмлэн, гол зүрхий минь пал пал хийлгэж байв.

Сүүлчийн удаа би үзэсгэлэн танхимд орж үзмээр санагдав. Тэгээд би нарийхан гудамж өргөөгөөр дамжин тэр олон тавтай болоод ашигтай цаг өнгөрөөсөн гайхамшиг сайхан музейд явж орлоо. Тэнд цуглуулж тавьсан эрдэнэсийн зүйлийг би удахгүй ингээд явж одохыг мэдэж байгаа дахинд энд эргэж ер ирэхгүй хөөгдмөл хүн шиг ширтэн ширтэн зогсов. Үнэн хэрэг дээрээ ч миний амьдралын сүүлчийн хэдэн сар дунд нь өнгөрсөн урлагийн тэдгээр агуу бүтээл, байгалийн тэдгээр гайхамшиг зүйлийг би нэгмөсөн орхин одох ёстой бүлгээ. Түүнчлэн би бас Атлантын далайн усыг үзэсгэлэн танхимын гэгээвчний шилний цаанаас сүүлчийн удаа хараад авахыг бодсон боловч цонхны халхавчууд бин битүү хаалттай тул онгоцны их биений ган хуяг тэндхийн нууцыг миний нүднээс халхалж байв.

Тасалгаан дотуур би алхлан байтлаа капитан Немогийн өрөө рүү ордог хаалганаа ойртон очив. Гэтэл тэр хаалга дутуу хаалттай байхыг би харж гайхаж барсангүй билээ. Хэрэв л капитан Немо өрөөндөө байгаа л бол намайг харчихаж болох байлаа. Тиймээс би ухарч эхэллээ. Гэвч нэг ч чимээ үл сонсдох тул би дахин ойртож очив. Тэхнээ нь тэнд хэн ч алга ажээ.

Би үүдийг татаж орж очлоо. Тэнд өөрчлөгдсөн юм нэгхэн ч үгүй. Тавилга мөн л хуучин янзандаа нямбай, цэгцтэй ажээ.

Хананд өлгөөтэй байсан хэд хэдэн сийлбэр хөрөг миний анхаарлыг татлаа. Өнгөрсөн удаа энэ тасалгаанд би байхдаа тэдгээрийг анзаарсангүй ажээ.

Тэдгээр бол бүх насаа, ямар нэгэн агуу их хэрэгт зориулсан түүхийн том зүтгэлтнүүдийн хөрөг байв.Тэнд ; Польшийн эрх чөлөөний тэмцлийн баатар Костюшко, одоогийн Грекийн Леонид буюу Боцарис, Ирландын тусгаар тогтнолын төлөө тэмцсэн Коннель, умарт Америкийн холбоог үндэслэгч Георг Вашингтон, боол эзэмших-өвчин болсон хүний суманд амь үрэгдсэн Линкольн, негрүүдийг боолчлолоос чөлөөлөх хэрэгт зүтгэж яваад сүүлд нь дүүжлэгдсэн Джон Браун болон хамгийн эцэст Виктор Гюгогийн өөрийн гараар зурагдсан аймаар муухай болж ирээд этгээд хачин харандааны ноорог зураг зэрэг байв.

Тэдгээр хөргийг капитан Немо унталгынхаа өрөөнд яагаад дүүжилсэн юм бол? Тэдгээр баатар ба тэрний хооронд ямар хамаа буй юм бод? Хөргүүдийн тэр цуглуулга түүний амьдралын нууцыг тааварлахад надад тус болох юм бол уу? Эсхүл тэр дарлагдсан түмний удирдагч нь байж, сүүлчийн үеийн ямар нэгэн улс төрийн буюу социалист хөдөлгөөнд оролцсон байж магадгүй еэ? Тэрчлэн тэр Америкийн умарт ба өмнө холбоонуудын хоорондын үүрт мартагдашгүй иргэний цуст дайнд оролцогч нь ч байж яаж мэдэх вэ? Цаг гэнэт найм цохилоо.

Цагны харанганы анхны цохилт миний бүх л бодол төөрөгдлийг үлдэн хөөжээ.

Миний бодол сэтгэхүйн нууцыг ямар нэгэн далдын хараа үзчих шиг болж би давхийн цочход, капитаны өрөөнөөс гүйн гарлаа.

Үзэсгэлэн танхимд орж ирэнгүүт би юуны өмнө луужин өөд харав. Түүний зүү, биднийг умарт зүг рүү гуйвмтгүй довтолгон буйг зааж байлаа. Хурдны хэмжүүр ч хэр тааруу хурдыг заах бөгөөд даралт хэмжүүр барагцаалбал 60 метрийн гүнийг зааж байв.

Тийм учраас, Нед Лендийн төлөвлөгөө хэрэг дээрээ биелэхэд юу юунаас тааламжтай нөхцөл төгс бүрэлджээ.

Дараа нь би өөрийн тасалгаанд эргэн ирж дулаахан хувцаслав. Үүнд далайн урт түрийтэй савхи, арьсан малгай, хав загасын арьсаар доторлосон дулаан хүрэм зэргээ өмслөө. Одоо би бэлэн болжээ. Ганцхан хүлээх л үлдсэн билээ.

“Наутилус” дээр дүнсийж буй нам гүм байдлыг зөвхөн сэлүүр сэнсний нь эргэлт л эвдэж бүлгээ. Нед Лендийг гэмт хэргийн төлөвлөгөөгөө биелүүлэхийг завдан байхад нь хүмүүс газар дээр нь илрүүлж дуун шуугиан болох бий хэмээн айсандаа би, хаалганы дэргэд юм бүхнийг хичээнгүйлэн чагнаж зогслоо. Барьж болохын аргагүй түгшүүртэй байдалд би оржээ..Би аль болохоор амгалан байхыг оролдовч болсонгүй



ээ.

Есен цагт хэдэн минут дутуу байхад би миний өрөөг капитаны өрөөнөөс тусгаарласан хананд чихээ наалдуулан чагнав. Тэндээс юу ч дуулдсангүй. Би өрөөнөөсөө гарч үзэсгэлэн танхимд явж орлоо. Тэнд хэн ч байсангүй бүдэг бараг гэрэлтэй байв.

Би цаашаа номын сан руу дамжиж орох үүдийг нээв. Тэнд мөн л хэн ч үгүй, бүдэг байдаг ажээ.

Тэгээд би Нед Лендийн өх дохиог хүлээхийн тул шат руу гарах хаалга өөд явав.

Яг энэ үед сэлүүр сэнсний эргэлт нэн цөөрч, чимээ нь намд намдсаар бүр таг болчихов. “Наутилус” яагаад зогсчихов со? Энэ явдал Нед Лендийн төлөвлөгөөг биелүүлэхэд сайн юм болов уу, эсхүл муу юм болов уу, бүү мэд.

Одоо орчин тойрны нам гүмийг зөвхөн миний зүрхний цохилт донсолгож байв.

Тэгтэл онгоц маань гэнэт яг хийтэл доргив. Тэхнээ нь “Наутилус” далайн ёроолд сууж байсан юмсанжээ. Миний сэтгэл бүр ч их догдолж эхлэв. Канад хүн дохиогоо өхгүй л байв. Би Нед Ленд дээр очиж, оргох хэргээ хойшлуулахыг гуймаар байв. Энэ нэг орой бидний жуулчлал ер бусын нөхцөл байдалд өнгөрөхийг нь би зөгнөж билээ.

Энэ үеэр номын сангийн босгон дээр капитан Немо гарч ирлээ. Тэр намайг харангуут, мэндэлцсэнгүй ч гэсэн, нэн эелдэг зөөлөн дуугаар:

- За, ноён профессор та энд байна уу, таныг би эрээд та Испанийн түүхийг мэдэх үү? гэв.

Хэрэв л тэр надаас, намайг эх орныхоо түүхийг мэдэх үү гэж асуусан бол, энэхүү түгшүүр болоод эвгүйрхэж зовсон эдүүгээгийн энэ байдалд би түүнд юу ч хариулж чадахгүйсэн билээ.

- Та миний асуултыг дуулав уу? хэмээн капитан Немо асуугаад-Испанийн түүхийг та мэдэх үү? гэж давтан асуулаа.

- Маш муу мэднэ гэж би хариулах сэхээ дөнгөж сая л орсон билээ.

- Ээ дээ энэ эрдэмтэд үү! хэмээн капитан хэлээд-өөрсдийнхөө мэрэгжлээс өөр юу ч мэдэхгүй улс! Суу та, энэ түүхээс би танд нэг сонихон зүйл ярьж өгье гэлээ.

Тэгээд капитан зөөлөн сандал дээр тавтайхан сууж авлаа. Би арай гэрэл муутайхан газар сонгон авч түүний нэг адил суув.

- Ноён профессор та миний үгийг анхааралтайхан сонс, миний энэ яриа таны сонирхлыг яах аргагүй татах болно. Учир нь та өөрөө өөртөө тавиад өдий болтол хариулж чадаагүй байгаа нэгэн асуудалдаа шууд хариулт олох болно гэв.

- Таны үгийг би сонсьё оо, капитан аа! гэж би хариулсан боловч энэхүү хэлсэн

урьдатгал үгэнд нь миний дотор сэрд хийв.

Капитан чухам юу гэх гэж байгаа нь тэр болохыг би ойлгосонгүй бөгөөд түүний яриа оргох гэсэн бидний бүтэлгүй оролдлоготой холбоотой юм биш байгаа гэж би өөрөө өөрөөсөө асууж билээ

- Хэрэв эрхэм ноён профессор та зөвшөөрвөл хэмээн капитан Немо үргэлжлүүлж, бид 1702 оноос яриагаа эхлэх болно. Тэр үед зөвхөн ганц хуруугаа хөдөлгөвөл Пиренеин хагас арлыг тэр чигээр нь газар руу хийчихэж чадна хэмээн биеэ тоож агсан Францын XIV Людовик Испаний хаан ширээнд өөрийнхөө ач хүү Анжуиский ванг суулгасныг та санаж ч байж магадгүй.

Тэрхүү V Филипп хэмээсэн нэрийн доор хаанчилж агсан хаан суухын хишиг буянгүй хунтайз гаднын хүчирхэг дайсантай тулгарах хэрэгтэй болжээ.

Үнэндээ ч тэрнээс нэг жилийн өмнө, 1701 онд Голланд, Австри, Английн хаад V Филиппийн толгойноос Испаний хааны алтан малгайг хуу татаж, урьдаас өөрснөө Ш Карл гэж нэрлэсэн нэгэн хаан хүүд өмсгөх зорилгоор Гааг хотноо холбоо байгуулжээ.

Тэгвэл Испани улс тэрхүүү бүлэглэлийн эсрэг тэмцэх хэрэгтэй боллоо. Гэтэл Испанид хуурай ба усан замын цэрэг байсангүй ээ. Гэсэн ч мөнгө ихтэй байлаа. Тэхдээ Америкийн алт ачсан хөнгөн хөлгүүд түүний онгоц татаалд саадгүй хүрч ирсэн цагт л мөнгөлөг байж болох байжээ.

Яг 1702 сны сүүлчээр адмирал Шато-Ренын командалсан Францын хорин гурван онгоцоор хамгаалуулсан тээврийн баян хөлөг Америкаас хүрч ирэхийг Испани хүлээж бүлгээ. Испанийн дайснуудын далайн цэргийн олон хөлөг Атлантын гадаад далайгаар хөндлөн гулдгүй шиншилж явсан учраас тэр хамгаалалт зайлшгүй хэрэгтэй байжээ.

Уул хөлөг Кадиксийг зорьж явсан боловч Кадикс орчны уснаа Английн бүлэг хөлөг сүлжилдэж буйг адмирал Шато-Рено мэдмэгцээ, Францын аль нэгэн боомтод орж зогсохоор шийдсэн байв

Харин тэгтэл тийм шийдвэрийг Испанийн капитанууд эсэргүүцэж, Испанийн ямар нэгэн боомтонд орж очихыг шаардсан бөгөөд Кадикст орж хэдийгээр болохгүй ч гэсэн Англичууд отож хориглоогүй Виго хэмээх тохойд орж зогсох санал тавьжээ

Адмирал Шато-Рено зориг муутай хүн байсан тул тэр шаардлагыг нь зөвшөөрч Виго тохойд орж очжээ

Азгүй юм болоход тэр тохой далай тийшээ задгай тул түүний амы нь хааж хориглолт тавьж болохгүй байв. Учир иймээс дайсны талын хөлгүүд ирэхээс өмнө хөлөгнүүдийнхээ ачааг даруйхан буулгах хэрэгтэй болжээ. Энэ явдалд цаг хугацаа

элбэг хүрэлцжүйц байсан гэвч ашиг болсонгүй ээ. Хэрэв л ёс зарчмыг эвдэнэ гэсэн хэн нэгэн тэнэг асуудал гэнэт гарч ирээгүйсэн бол хамаг хэрэг бүтэмжгүй болохсон билээ...

- Та миний яриаг анхаарч байгаа биз? хэмээн капитан Немо яриагаа тасдаж надаас асуувал би:

- Тун их анхаарч байнам гэж хариулаад, ямар зорилготой мань капитан түүхийн энэ нэг хичээл надад уншаад байгаа билээ гэж гайхлаа.

- За тэгээд би цааш нь, үргэлжлүүлье. Тэгээд цааш нь юу болсон гээч. Тэр үед Америк гэж нэрлэж байсан, Дорнот Энэтхэгээс тээж ирсэн ачааг заавал Кадикст буулгах ёстой юм гэсэн тийм нэг баримталсан зарчим Кадиксын ху- далдаачдын дунд байсан юм. Тэхлээр нь, уул хөсөг ачиж ирсэн алтан ембүүнүүдийг Виго тохойд буулгах явдал бол тэдний ёс зарчмыг эвдэнэ гэсэн үг байлаа. Худалдаачид Мадрид хүртэл заргалдаж Кадиксаас холбоотон далайн хөлгүүдээ татан буулгах хүртэл Виго тохойд уул хөсгийг тас- хорино гэсэн зар бичиг үхээнц дорой хаан хуу V Филиппээс олж авчээ.

Мадридад энэ шийдвэр гарч байх завсар 1702 оны аравдугаар сарын хорин хоёрноо Виго тохойд английн хөлгууд нэвтрэн оржээ. Адмирал Шито-Рено дайсны талын давуу хүчийг харгалзахгүй эрэлхэг зоригтой тулалдлаа. Гэвч, алт тээсэн хөлгөө дайсны гарт орох нь зайлшгүй гэдгийг мэдмэгцээ адмирал Шато-Рено бүх хөлөг онгоцоо ачаа сэлттэй нь шатааж далайн ёроолд живүүлжээ.

Капитан Немо дуугүй боллоо. Энэ нэг түүх надад юугаараа сайхны нь би ойлгоогүй байснаа шудрагаар хүлээвэл зохино.

- Тэгээд цааш нь? гэж би асуув.

- Цааш нь уу? Цааш нь юу вэ гэвэл бидэнд одоо Виго тохойн ёроолд байгаа явдал л залгана даа. Тэхээр түүний нууцад нэвтрэх эрх зөвхөн л бидний гарт байна гэв.

Капитан босч ирээд намайг өөрийн хойноос дагалдахыг урилаа.

Саяхан би эвгүйхэн байснаа энэ хэр мартсан тул шаардуулах юмгүй түүнийг дагаж одов.

Үзэсгэлэн танхимд хав харанхуй байлаа. Нээлттэй цонхоор тэнгисийн цаадтай цэнхэрлэн мяралзаж буй ус харагдана. Би цонхонд ойртож очлоо.

Онгоцны цахилгаан чийдэн усыг хааш хаашаа хагас миль газар хурцаас хурц гэрэлтүүлж байв. Түүний гэрэл тун хурц тул далайн ёроолын элсний ширхэг тус бүрийг үзэж болох ажээ. “Наутилус”-ын өмсгөх баг өмссөн усан цэргүүд дутуу

ялзарсан торх, эвдэрхий хайрцаг зэргийг бусад новшин дундаас онгилон гаргаж байв. Тэдгээр хайрцаг, торхон дотроос алт, мөнгөн эрдэнийн зүйлс асгарч харагдлаа. Далайн ёроолын элс тэдгээрт хучигджээ.

Усан цэргүүд тэдгээр авдар сав, торх зэргийг нуруун дээрээ үүрч онгоц руу авчран нэг доор хураагаад, эрдэнийн тэрхүү барагдашгүй сангаас дахин авахаар буцаж явах нь харагдав.

Одоо л би учры нь олов. Энэ бол далайн цэргийн тулалдааны талбар ажээ. Энд Испаний хаанд алт ачиж явсан хөлгүүд 1702 оны аравдугаар сарын хорин хоёронд живжээ. Алтны энэхүү сангаас капитан Немо хэрэгтэй цагтаа алт авдаг ажээ. Эдгээр торх, эдгээр авдар, ганцхан түүний л эрхэнд байжээ. Тэрхүү сая сая алтан төгрөгийг үе залгамжилсан, цор ганц эзэн нь капитан Немо байжээ.

- Далай гэдэг ийм их баян гэдгийг та мэдэх уу? гэж капитан инээмсэглэн асуув.

- Далайн усанд би, зөвхөн хоёр сая орчим тонн мөнгө л ууссан байдгийг мэднэ.

- Тэр үнээн. Гэвч мөнгий чинь уснаас нь ялган авахын тул зарах зарлага нь орлогоосоо дэндэх шүү дээ. Тэгвэл, энд хүмүүсийн хаясан тэр зүйлийг газраас бид нь татаж авахын тулд зөвхөн л бөхийх хэрэгтэй биш үү. Зөвхөн Виго тохой ч надад эрдэнийн ганц сан болдог биш усан доорхи миний зураг дээр тэмдэглэгдсэн үүнээс ч ялгаагүй өөр мянга мянган газар бий. Миний баялаг миллиардаар л хэмжигдэнэ гэдгийг та одоо л ойлгов уу?

- Их сайн ойлголоо, капитан. Ганцхан л зүйлийг хэлэхийг та зөвшөөрнө үү? Виго тохойгоос алт хутган авахдаа та өөртэйгөө өрсөлдөж элбэг чадах худалдааны ганцхан нийгэмлэгээс амжиж түрүүлсэн байна шүү.

- Ямар нийгэмлэг?

- Живсэн хөлгүүдийг эрж олох ажлыг зохиох талаар Испаний засгийн газраас эрх олсон нийгэмлэг. Энэ компанид хувь нийлүүлэгчид тэдгээр таван зуун сая төгрөгийн алтыг зүүдэндээ л зөвхөн үздэг юм. Тэрхүү живсэн хөлгүүд ачиж явсан ачааг барагцаагаар тэгж үнэлсэн дэг.

- Таван зуун сая ий? хэмээн капитан Немо давтан өгүүлээд - Тэр таван зуун сая ч байсан л даа харин одоо байхгүй болсон гэлээ.

- Мэдэж байна, капитан минь гэж би хэлээд - тийм учраас энэ хэрэгт гар бие оролцогсдод ганц нэг үг хэлэхэд илүүдэхгүй л байх. Гэвч, тэд тэр үгийг хэрхэн хүлээн авахыг хэн мэдэх вэ дээ? Мөрийцөгсөд мөнгө алдахад харамсахаасаа мөрий алдахад харамсах нь их байдгийг та мэднэ шүү дээ. Тэр муусайн панзчингууд ч надад ямар хамаа байхав! Ганцхан л би, мянга мянга ч ядуучуудын зовлонг

хөнгөтгөх тэр их мөнгө хэзээ ч тэдний гарт орохгүй гэдэг л надад нэн хайран байна...

Би яриагаа дуусаагүй байгаад, миний үг капитан Немог дайрч доромжилсон болохыг ойлголоо.

- Хэзээ ч тэдний гарт орохгүй ий? хэмээн капитан Немо өгүүлээд, тэдгээр мөнгийг нэгэнт л би авсан болохоор тэгээд л тэр чигээрээ дүүрлээ гэж та бодож байна уу? Нээрээ эдгээр эрдэнийг би хар аминдаа хураадаг гэж бодоо юу? Тэдгээрийн хүчээр би, бусдад хэрэгтэй юм хийдэггүй гэж хэн танд хэлээ вэ? Газар дээр дарлагдаж зүдэрсэн ард түмэн, давж гэтэлшгүй гаслан, туслахыг горилсон зовлонт, өслөхийг зорьсон хилэнт байдлыг би мэднэ...

- Тэгснээ капитан Немо гэнэт дуугүй боллоо. Магадгүй тэр сэтгэл нь үймэрч тачаадсандаа илүү юм ярьчихсандаа гэмшсэн ч байж.

Тэгсэн ч би бүгдийг ойлгож авлаа. Түүний усан доор орж бусдаас хөндийрөхийн шалтгаан ямарч байлаа гэсэн хамгийн гол нь тэр, хэн хүн хэвээрээ л үлджээ. Хүн төрөлхтний зүдрэлийн улмаас түүний зүрх цусаар шүүрч, дарлагдсан ард түмэнд тэр өглөгч гараараа харамгүй тусалдаг ажээ.

Тэр нэгэн өдөр, бослогын галд оволзож агсан Крит арлын дэргэд, “Наутилус” онгоц явж байх үед капитан Немо гадагш нь гаргасан тэдгээр сая сая төгрөгийн алт мөнгө хэнд зориулагдсан нь надад одоо ойлгомжтой боллоо.

[Тор](#)

---

## АЛСЛАГДСАН ЭХ ГАЗАР

Дараачийн нь өглөө, хоёрдугаар сарын 19-нд над дээр Канадын харъяат орж ирлээ. Нед Лендийн царай муухай байв.

- За юу гэж хэлмээр байна даа, ноён профессор? хэмээн тэр эхэллээ.

- Юу ч гэх вэдээ, Нед ээ? гэж би хариулаад, азгүй нь л тэгж таарлаа гэв.

- Тиймээ...биднийг оргохоор бүр яг завдан байсан тэр минутанд энэ муу хар капитан хөлгөө зогсоочих ч гэж дээ.

- Яая ч гэхэв дээ Нед минь, тэр өөрийнхөө банкны эзэнтэй учрах хэрэгтэй байсан юм чинь.

- Банкны эзэн гэнээ? Нед хоёр нүдээ бултийлгэв.

- Чухамдаа өөрийнхөө банкны мөнгөний кассанд орох хэрэгтэй байжээ. Арвин баялаг эрдэнэс, аль нэгэн улсын хадгаламжинд хадгалагдахаас илүү найдвартай хадгалагддаг, далайн ёроолын тухай би ярьж байна.

Нед Лендэд би өнгөрсөн үдшийн явдлыг ширхэг дараалан ярьж, миний яриа түүнийг номготгож, оргож зугатах бодлоос нь холдуулах бол уу гэж би далдуур итгэв.

Гэвч, энэ ярианы ганцхан үр дүн нь юу вэ гэвэл: Вигогийн тулалдааны талбарт Нед Ленд өөрийн биеэр зугаацан явж чадаагүйдээ харамссан гүн харамсал болжээ.

- Тэгэвч хэмээн тэр өөрийнхөө төөрөгдөж буй бодолд дахин эргэж - горьдлого тасарсан юм алга. Өчигдөр болж бүтэхгүй юмыг, өнөөдөр бүтээж яагаад болоогүй юм...гэж ярихад нь яриаг тасдан авч:

- “Наутилус” хаашаа явж байна? гэж асуув.

- Мэдэхгүй ээ.

- Үд болохоор зураг дээр үзье. Дараа нь Нед Ленд, Консель руугаа явж одоход би хувцаслаж үзэсгэлэн танхимд яаравчлан орлоо.

Тэнд би хананы луужин харвал “Наутилус” баруун урагшаа явж буй урамгүй чиглэл олж харав. Бид Европ тийш нуруугаараа харсан ажээ.

Би ажигласан даруй үд дундын ажиглалтыг тэсч ядан хүлээлээ. Ажиглалтын дүнг ажигласан даруй зураг дээр тэмдэглэдэг заншилтай бүлгээ.

Арван нэг хагасын үед усны шахуургууд багтаамжуудыг хоосолсон тул “Наутилус” далай дээр ил гарч ирэв.

Би тавцан өөд ухасхийсэн боловч Нед Ленд надаас түрүүлжээ.

Ойр тойрон газар харагдах шинж алга. Гацнхан л нүд алдам тэнгис цэлийх ажээ. Гэвч алсад далбаат хэд хэдэн жижиг онгоц бүртэлзэж байв. Тэнгэр үүлээр битүү бүрхэгджээ. Бодвол тэнгисийн их шуургыг зөгнөсөн бололтой.

Гуныж гутсан Нед Ленд, манант алсад хүслэнт газраа олж үзэхийг горилхийлон, үүлэн хөшгийг нэвт ширтэхийг оролдож байв.

Үд дундын хэр нар түр зуур гараад далд орлоо. Капитаны туслах тэр байдлыг ашиглан ажиглалтаа хийж амжив. Тэгтэл ч тэнгис догшрон, давалгаа хуйларч “Наутилус” тэр дороо шумбаж орлоо.

Цагийн дараа хөлөг онгоц яваа газрыг зураг дээр тэмдэглэснийг би олж үзвэл бид, уртрагийн 16 дахь хоног 17 дахь хувь, өргөргийн 33 дахь хоног 22 дахь хувьд, хуурай газраас зургаан зуун километр зайтай явлаа. Тиймэрхүү нөхцөлд оргоно гэж бодохын ч хэрэг алга аа.

Тэр мэдээг сонсоод Канад хүн хичнээн их хүнд бодолд орсныг төсөөлөн бодоход

хялбар билээ.

Миний хувьд бол ч төдий л их гуньсангүй ээ. Харин би өөрийнхөө ажилд асар тааламжтай эргэн орсон нь миний мөрөн дээрээс нэг л их ачаа авч хаясан мэт байж билээ.

Үдэш орой болсон хойно, шөнийн арван нэгэн цагийн орчим капитан Немо над дээр гэнэт орж ирлээ. Тэр надаас өчигдөр шөнө орой болтол сууж ядраагүй биз хэмээн нэн их найрсаг асууж лавлав. Би өчүүхэн ч ядарсангүй гэж хариуллаа.

- Тийм бол, эрхэм ноён профессор таныг би, нэгэн онц сонирхолтой зугаалганд оролцохыг урих байнам гэж тэр хэллээ.

- Тэгэлгүй яхав, капитан минь.

- Зугаалга нэн их ядаргаатай гэдгийг танд анхааруулъя. Их явна, уул өөд авирна. Явах зам энэ орчинд тун олиггүй гэдэг нь танд мэдээж хэрэг.

- Та, ёстой бүр, миний хорхой хөдөлгөчихлөө, капитан би таныг дагалдахад бэлхэн байнам.

- Тийм бол хувцасны өрөөнд очъё. Багаа өмсөх хэрэгтэй гэлээ.

Хувцасны өрөөнд, энэ зугаалганд бидэнтэй хамт явахаар хүн нэг ч үгүй болохыг би харлаа. Миний нөхөд ч явахгүй нь онгоцны цэргүүдээс ч явахгүй нь, түүгээр ч барахгүй капитан Немо, намайг Нед Ленд Консель хоёрыг урых талаар нэг ч үг хэлсэнгүй.

Бид түргэн зуур баг өмсгөлөө өмсчихлөө. Бидний нуруундаа нөөц агаар ихтэй амьсгалах сав үүрлээ. Харин бид Румкорфын аппарат цахилгаан чийдэн биедээ авсангүй ээ. Энэ тухай би капитан Немод сануулж хэлэхэд:

- Тэр бидэнд хэрэггүй ээ гэлээ. Түүний хариулсныг би дутуу дуулсан шиг санасан боловч капитан Немо толгойгоо бөмбөгөр дуулганд углачихсан болохоор дахиад түүнээс асууж чадсангүй. Тэгээд би түүнийг дууриаж дуулгаа ч өмсчихлөө. Тэгтэл ч миний гарт төмрөөр бүрсэн урт мод бариулж, хэдхэн минутын дараа усан доор ордог ердийн ажиллагааг үйлдмэгц, бид гурван зуун метрийн гүнд Атлантын тэнгисийн ёроолыг гишгэсэн бүлгээ.

Шөнө дөл ойртож байв. Усан доор пад харанхуй байсан боловч капитан Немо надад “Наутилус”-аас хоёр миль зайтай түүдэг гал мэт сүүмэлзэж байсан ямар нэгэн улаан цэг руу заав. Тэр юун гал болохыг, юу түүнийг тэтгэж усан дотор яагаад тэгж ноцохыг би өөртөө тайлбарлаж чадсангүй ээ. Ямар ч байсан тэр бидний замыг зааж байв. Би капитантай зэрэгцэн тэр гал руу яг халз чиглэн явлаа. Далайн эхлээд тэгшхэн байсан ёроол одоо л өгсүү болж ирлээ.

Бил модоо тулж хол алхлавч, хөл маань шаварт шигдэх тул газар авч гавихгүй байв.

Замын турш миний толгой дээр ямар нэгэн юм шажигнаад л байлаа. Тэр шажигнаан заримдаа хэнгэрэг дэлдэж буй мэт ширүүсэх ажээ. Удалгүй би тэр чимээний учрыг олов. Тэхнээ нь далай дээр бороо орж байсан тул борооны ширүүн үер далайн ус шавхуурдахаараа тийнхүү их чимээ гарч байсан юм байжээ.

Эхлээд би норчих нь гэж айсан боловч дараа нь инээд алдчихсан билээ. Тэр бодол юутай тэнэг вэ! Усан доор байж байгаад уснаас айна гэдэг чинь юу гэсэн үг вэ! Гэвч баг өмсгөл дотор яваа хүн орчин тойрноо агаараас нягт гэж мэдрэхээс биш усан дотор байна гэдгээ мэдэрдэггүйд л хамаг хэрэг байдаг билээ.

Хагас цаг яваад газар хатуурч ирлээ. Медузууд болон маш бяцхан хэлбэртнүүд фосфорчлах сул туяагаараа муухан гэрэлтүүлж байв.

Зарим нэгэн чулуун дээр хөндий хэвэлтэн шавааралдаж, зарим нь замгаар хучигджээ.

Би нялцгай шавар хивсэн дээр хэд хэд хальтарсан бөгөөд хэрэв л надад тулах мод байгаагүй бол нэг бус удаа ойчих байсан мань эргэлзээгүй ээ. Миний эргэн харахад “Наутилус”-ын чийдэнгийн бүдгэрч буй цагаан гэрэл алсад цайрч харагдлаа.

Тэнгисийн ёроолд овооролдсон хад чулуу хар аяндаа эмх замбараагүй хөглөрсөнгүй, харин тун цэгцтэй хураасан мэт байхын учрыг би олж ядлаа...

Түүнчлэн ямар нэгэн асар том гуу буюу ангал харанхуйн дунд ангайж харлан алсад оджээ. Тэрнээс гадна, бас ямар нэгэн хачин юмнууд энд харагдах боловч учры нь би олсонгүй. Миний тугалган ултай нүсэр хүнд шаахай ясан дээр гишгэж яс шад пад хийн хэмхэрч байх шиг санагдав.

Бидний явж байсан тэр уудам хөндий ямар хачин газар байв аа.

Би капитанаас юм асуухыг хүсэвч, тэр нэгэн удаа усан доогуурхи жуулчлалд явахад түүнийг дагалдан явсан усан цэргүүдтэй өөрий нь солилцож байсан дохио тэмдгийг би мэдэхгүй тул яаж ч чадсангүй ээ.

Тэр хооронд бидний баримжаалж агсан улаан гал улам л тодорч, одоо бүр орчин тойрныг гэрэлтүүлж байв. Усан доор ноцож ассан тэр гал миний сонирхлыг татсан нь хэмжээгүй билээ. Тэр юу бол? Цахилгаан цацрал уу? Эсхүл, эрдэмтдэд мэдэгдээгүй ямар нэгэн этгээд сонин зүйл үү? Аль үгүй бол хүн тэтгэн өрдөж буй гал уу? гэсэн бодол ч миний толгойд орж байв. Магад ч үгүй би энд усны гүнд, яг л капитан Немо шиг этгээд хачин амьдрал хөөцөлдсөн түүнтэй санаа нэгт хүмүүсийг ч олж үзэж байж? Нээрээ би тэнд, хүн нийгмийн шудрага бус зан заншлаас уйдаж зугатсан,



тэгээд далайн ёроолд өөрсөддөө тусгаар тогтнол, амар заяаг олж санаа амарсан, хавчигдмал хөөгдмөл хүмүүсийн бүхэл бүтэн омогтой нүүр учирна гэж уу?

Энэхүү ямар ч утга учиргүй, солиорсон бодол замын турш намайг гижигдлээ. Гэвч түүнд гайхах юмгүй ээ. Сэтгэл тэгж их хөөрсөн цагт, түүнчлэн улам бүр шинэ шинэ гайхамшигт зүйл намайг үргэлж донсолгож байсан үед, капитан Немо өөрөө хүртэл хүсэл мөрөөдөл болж агсан далай доорхи хотуудын нэгэн дээр орчихсон ч би гайхахгүйсэн билээ.

Бидний зам улам л тод гэрэлтүүлэгдсэн байв. Тэрхүү гэрлийг тэтгэгч эх булаг, далайн ёроолоос дээш найман зуугаад фут өндөрт дүнсийсэн уулын оргилын цаана нэгэн газар байгаа бололтой. Намайг тойрон байгаа гэрэл бол зөвхөн л тэрхүү гэрэл бадраагчийн усанд хугарсан туяа бөгөөд чухам өөрөө урьдын адил үзэгдэхгүй л байв.

Капитан Немо ёроолын чулуун гондоруудын дундуур өчүүхэн ч тээнэгэлзэхгүй урагшлан байлаа. Тэр энэхүү харанхуй замыг сайн мэдэх ажээ. Тэр замаасаа гарчих бий гэж айхгүй алхлахыг нь бодвол үүгээр үргэлж явдаг буйзаа. Би капитаны хойноос итгэл төгс дагалдаж байв. Тэр миний санаанд байгалийн ямар нэгэн ид шидтэн усан доорхи увьдас шиг санагдаж, түүний өндөр нуруу усны тунгалаг дэвсгэр дээр тод ялгарах хар дүрс зэргийг нь би харж бахархан явав.

Шөнийн нэг цагийн орчим байв. Бид уулын хормойд хүрч ирлээ. Гэвч тэр уулын халз урдаас авирчгарахын аргагуйтул бид етген молон дотуур егссен нарийхан жимээр дээшилж эхлэв.

Тиймээ энэ бол ой байлаа. Яахав, далайн давстай усанд өмхөрч, навч цэцэггүй болсон үхсэн модод ч бай ямар ч л гэсэн ой байв. Тэнд заримтайгаа асар өндөр нарс лүглийж байлаа.

Энэ бол арай л давхраатаж хэвшээгүй усанд идэгдсэн хөрснөөс үхсэн үндсээрээ бөх зуурсан эгц босоогоороо байгаа чулуун нүүрс ажээ. Чулуужсан моддын мөчир тал бүр тийшээ сэрвийж, гэрэлтүүлэгдсэн уснаас харлан сэрзийж, тодрон харагдана.

Нарийн зөрөг замууд замгуудаар дүүрч түүн дотор мянган мянган хавч хэлбэртэн шивээлсэн ажээ.

Би хаданд авиран эрт дээр үед үер усанд автаж өмхөрч унасан моддыг дамжин үсэрч, зам хөндлөн ширэлдсэн далайн өлөн өвсний торыг тасчин явж, мөчрөөс мөчир дамжин жиргэж буй шувууд мэт хөөрхөн загас жараахайг үргээж байв.

Тэр бүхэнд би сэтгэл татагдсан тул ядарснаа ч мэдсэнгүй, түүнчлэн бас ядаргаагаа тоохгүй яваа газарчаасаа ч хоцорсонгүй ээ.

Ямар мартагдашгүй сайхан үзэгдэл бэ! Түүнийг үгээр яаж дамжуулах вэ? Усан дотор буй хад модыг, тэдний харлаж бараантах уг, улайрч хүрэлтэх орой зэрэг нь гэрлийн хугарсан туяа, сарнисан гэрэлд яаж солонгорон гялалзаж, өнгө ялгаран буйг ямар өнгийн будгаар зурах вэ?

Бид хаднаас хад дамжин үсэрч явахад, бидний хөлөөр ховхорсон сул хадад нишигнэсэн битүүлэг чимээ гарган доошоо нурж байв.

Биднээс баруун, зүүн тийш зээглэсэн моддын гудамжилсан харанхуй хар зурвас зай тэртээ тийшээ харлан харанхуйлж одсон нь нүдний хараа үл хүрэм ажээ. Бидний өмнөхөн нилээд уудам нуга газар буй болсон нь хүний гараар додомдож цэвэрлэсэн мэт бөгөөд хэрвээ л бидний урьдаас энэхүү усан доорхи орны улсын нэг нь гэв гэнэтхэн гараад ирвэл яах билээ хэмээн би өөрөө өөрөөсөө асууж бүлгээ.

Капитан Немо урагшилсаар л байв. Би түүнээс хоцрохгүйг хичээж зориглон явлаа. Барьж явсан мод маань л аргагүй тус болж билээ. Нэг л алдаж гишгэвэл тэрхүү ёроолгүй гүн нарийхан ангалуудын амсар дээгүүр өнгөрч агсан зөрөг зам дээрээс хальж үхэх аюул заналхийлж байв. Гэвч миний толгой өчүүхэн ч эргэсэнгүй, би эрс шийдэмгий алхаж байв.

Хуурай газрын мөстмөл хэсэгт бол ч намайг ухрааж л таарах, хадны тийм гүнзгий ангал дээгүүр ч гэсэн зоригтой харайж бүлгээ. Би өөрийнхөө урьд замыг ч харах үгүй, намайг хүрээлэн буй байгалийн тэр ер бусын агуу гоёмсгийг ч анзаарахгүйгээр ёроолгүй тал, хадны ангал дээгүүр дамналдуулан тавьсан гулзганасан модон дээгүүр зоригтой дамжин явлаа. Этгээд хачин суурин дээрээсээ элэглэн өнгийсөн нүсэр сүрлэг хадан цохионууд тэнцвэрийн бүх хуулийг үгүйсгэсэн мэт санагдлаа. Хажуугийн чулуун хананд хүнхийж орсон хонхор дээрээс жим зам руу тонгойж дүнсийж байгаа хадан хясаад, дэлхийн таталтын бүх хуулийг мөн зөржчээ.

Би ч гэсэн өөрийн биеийг хүрээлэн буй усны нөлөөг биедээ мэдэрч байлаа. Би хүнд хувцас, зэс дуулган гуталтай боловч бараг эгц цавчим хад өөд гөрөөс мэт дүүлэн байв.

Миний ярианы энэхэн нэг хэсэг үнэнээс юутай хол болохыг би өөрөө ойлгож байна. Гэвч анх эхлээд хэнд ч са- нашгүй, болшгүй мэт санагдах авч жинхэнэ хэрэг дээрээ үнэхээр байдаг зүйлсийг би бичих үүрэгтэй билээ. би донтсон юм ч биш, хий хоосон мөрөөдсөн ч юм биш энэ бүхнийг би өөрөө үзэж биеэрээ амссан бүлгээ!

“Наутилус”-ыг орхиж гарснаас хойш хоёр цагийн дараагаар бид ойт бүслүүрийн шугамаас дээш гарчихсан бөгөөд энэ хэр уулын орой хүртэл зөвхөн зуугаадхан фут үлджээ.

Энд нэг л хачин авцалдаж барьцалдсан бутнуудын ширэнгэ мэр сэр харагдах боллоо. Хөл дороос загас жараахай, өтгөн өвсөн дундаас үргэсэн шувууд шиг бөөн бөөнөөрөө бутран зугатаж байв.

Хадан цохио нэвтэршгүй өргөн ангал цав, хөндий ханхай агуй, ёроолгүй гүн там зэрэгт идэгдэж онгойж ёнхойн байх нь тэнд аймшигт муухай зүйлс орогнох шиг надад санагдаж билээ. Бидний ойртон очих үед яг урьд маань аймаар том базуур, асар муухай тэмтрүүл хавч, явхийн гэнэт хамхигдаж зам хаахад хамаг цус нөж минь зүрхэнд юүлэх мэт болж байв. Харанхуйн дунд мянга мянган гэрэл гал цог мэт ёлтойж байлаа. Тэхнээ нь хэвтэртээ бүгшиж хэвтсэн аврага том наймалз хавч, сарвуугаа арвагануулан байгаа аврага аалз, тэмтрүүлүүдээ амьд могой мэт атрилдуулж байгаа бузар муухай найман хөлт зэргийн нүдэд тийнхуу гялалзаж агсан ажээ.

Энэ бол урьд өмнө миний олж үзээгүй гайхлуудын ертөнц дээр байв. Тэдгээр хадад хоёрдугаар хуяг нь болсон тэрхүү үе хөлтнүүд ямар дүрсэд хамаарагдах бол? Тийм амьтад оршиж буй нууцыг байгаль яаж хадгалж ирэв ээ? Тэнгисийн энэ гүнд тэд хэд хичнээн зуун үе улиран амьдарч байгаа бол?

Тэгэвч надад тэднийг сайн ажиглах зав гарсангүй. Тэр аймшигт амьтад аль эртнээс дассан капитан Немо, тэднийг анзаарах шинжгүй, дэргэдүүр нь явж өнгөрөх ажээ. Бид уулын түрүүчийн тавцан дээр гарч ирвэл тэнд намайг бас нэг шинэ сонин зүйл хүлээж агсан билээ. Тэр бол хүний гараар хэзээ нэгэн цагт бүтээгдсэн орд харш, байшин, сум дуган зэрэг байсныг тааж болох овооролдсон чулуу байв. Энэ бүхэн одоо хөндий хэвэлтний амьд цэцэрлэгээр бүрхэгдэж далайн замгийн ногоон хулдцаар хучигджээ.

Тэгвэл тэнд, хуурай газрын ямар нэг хэсэг байж байгаад, ямар аюул түүнийг тэнгисийн ёроолд хийчихсэн юм бол оо? Би чухам хаана байна аа? капитан Немогийн өвчин хаана намайг аваад ирэв ээ?

Энэ бүхнийг би түүнээс асуухыг хүсэвч дуун гараад хэрэггүй болохоор гараас нь бариад авав. Гэвч дуулган дотроо тэр толгойгоо дохичихоод уулын орой өөд гар зангасан нь:

- Яв! Бүр цаашаа яв гэсэн юм шиг санагдлаа. Би эцсийнхээ байдаг хүчийг шавхан түүний хойноос дагасаар, түрүүчийн хадан цохионоос дээшээ хориод метр өндөрт байгаа уулын ноён оргил дээр хар гүйхээрээ гарлаа. Би өөрсдийнхөө авирч гарсан энгэр руу эргэн харвал тэр уул энэ талаасаа долоо, найман зуун футаас хэтрэхгүй өндөр ажээ. Гэвч эсрэг талын нь энгэр доор хаяж л бүтэн хагас мянган фут эгц

цавчим байлаа.

Тэнд асар уудам, тод гэрэлтүүлэгдсэн өргөн хөндий гайхаж гөлөрсөн нүдний минь өмнө цэлийж харагдлаа. Биднээс тавиад метрийн доор галт уулын оргилох өргөн цооног үзэгдэв. Түүний энгэр хажууг даган халуун хайлмаг бодис гал халуун хүрхрээ болон цутгаж байв. Тэрхүү галт уул доорхи хөндий нүдний хараа хүрэхүйц газар аврага том бамбар мэт тод гэрэлтүүлэх ажээ.

Галт уулаас халуун хайлмаг шингэн бодис асгарахаас биш гал дөл үл оргилж билээ. Дөл гарахад агаараас хүчилтөрөгч хэрэгтэй бөгөөд усан дотор гал үл ноцдог биш билүү. Гэлээ ч гэсэн усан дотор цутгаж буй улаан зуурмаг болтлоо халсан шингэн бодис, өөрөө хөрч хүйтрах хүртлээ, усыг уур болгон хувиргаж, устай ана мана тэмцэлдэж чадах бүлгээ. Халуун хүйтний эрс ялгавраас шалтгаалсан усны хурдан урсгал усны уурыг агшин зуур урсган холдуулж, гал халуун шингэн бодисын урсгал уулын хормой хүртэл чөлөөтэй буух ажээ.

Миний нүдний өмнө цөмөрсөн дээвэр, нурсан хана, хэмхрэн унаж хажуулдан зэрэглэсэн асар хаалга зэрэг балгас мэт овооролдож хэвтлээ. Тэдгээр барилга тосгон маягтай адил урлагтай баригджээ.

Алс хөндийд ус дамжуулах асар том барилгын эвдэрхий балгас сүглийн харагдана. Уулын хормой орчинд афины Парфенонтой аль нэгэн талаараа адилхан агуу их цайз хэрмийн үлдэгдлээд үзэгдэв. Тэртээ тэнд цэргийн гурван давхар сэлүүрт онгоц ба худалдааны хөлгүүдийн зогсоол болж байсан эртний усан буудлын өнцөг булан, эрэг орчны эвдэрхий хэсгүүд хадгалагдаж, тэрнээс цаашаа хуучин гудамжнуудын оронцог нурсан ханадын урт овгор шороо харагдаж байв.

Тэр бол капитан Немо нүдний минь өмнө харсаар байтал товойлгон илчилж буй шинэ Помпей байлаа.

Би тэхэд ер нь хаана байв аа? Үүнийг би ямар ч л гэсэн мэдэхийг хүсч билээ. Миний толгойг олзолж авсан зэс дуулгыг мулт татаж аваад ч гэсэн энэ тухай би капитан Немогоос асуухыг бодож бүлгээ.

Гэтэл капитан Немо над руу ойртон ирэв. Тэр тонгойж хэсэг цэрд газраас аваад, хүрмэн хадан хана руу ойртон очиж:

“”АТЛАНТИДА” гэсэн ганцхан үг биччихэв.

Тэр үг миний тархинд цахилгаан мэт нэвт харавлаа. Атлантида! Платоны Атлантидыг Ориген, Порфири, Д, Анвиль Мальтбрэн, Гумбольт нар эрс маргаж, энэ нэгэн алга болж одсон тив бол гоё сайхан домог болохоос цаашгүй хэмээн үздэг билээ! Тэгвэл Плиний, Амиа-Марделлин, Тертуллиан, Энгель, Шерер, Турнефор,

Бюффон, Д. Аvezак нар үнэхээр байсан хэмээн үзэж агсан тэр Атлантида өөртөө учирсан аюул сүйрлийн ул мөрийг хадгалсаар нүдний минь өмнө харагдаж байв.

Тэхнээ нь Ази, Европ, Африкийн аль алинаас нь алс зайдуу Геркулесийн багануудын цаадтай байсны нь л одоо зөвхөн мэдэж буй эрт дээр цагт Атлант хэмээх хүчирхэг омогтон амьдарч тэдгээрийн эсрэг эртний грекчууд анхныхаа аян дайныг зохиож агсан одоо энэ үед бол усан доогуур орж алга болсон тэр тив энд л байсан ажээ.

Платоны он тооллын бичигт тэр эрэлхэг цагийн агуу агуу үйл явдлыг тоочин бичсэн нь хадгалагдаж иржээ. Тимей, Критиас хоёр Атлантидын тухай ингэж бичжээ.

Солон нэг едер Саис хотын хэдэн мэргэдтэй ярьж суужээ. Тэр хотын насыг найман зуун жил гэх бөгөөд тэрнийг нь түүний өндөр сүмийн ариун ханан дээр сийлсэн сийлбэр бичиг гэрчлэх бүлгээ. Тэдгээр мэргэдийн нэг санжаас урт настай өөр нэгэн эртний хотын тухай ярьжээ. Есөн зуун зууны турш байсан тэр хотыг атлантууд бараг эзлэн авч эвдэн сүйтгэсэн байжээ.

Түүний ярьснаар бол атлантуудын ноёрхол бүр Египэт улс хүртэл түгсэн юм гэнээ. Тэд түүнчлэн өөртөө Элладыг сөгтгөхийг бодсон боловч эртний Грекчуудийн “Элладуудын” зориг төгс эсэргүүцлийн өмнө ухрах хэрэгтэй болжээ. Гэтэл газар хөдлөх үер бууж аюул сүйрэл гарлаа. Тиймээс ганцхан өдөр, ганцхан шөнийн дотор Атлантидыг газрын хөрснөөс арчиж, түүний зөвхөн хамгийн өндөр оргилууд Мадера, Азорын ба Канарын арлууд, мөн Ногоон хушууны арлууд далай дээр бүтэн үлджээ... Капитан Немогийн бичсэн тэр үг миний тархинд түүхийн ийм л дурьдатгалуудыг сэдэвлэн сэргээсэн юм даа.

Ингэхэд хувь заяа минь намайг өнөөдөр, алга болж одсон тэр тивийн оргилуудын нэгний нь орой дээр авчирч, мянга мянган жил тэнд хэвтсэн барилгуудын балгасанд гар хүрэх боломжийг өгсөн билээ.

Би газар дээр хамгийн анх түрүүн гарч ирсэн амьтад гишгэж явсан хөрсөн дээгүүр алхлан явав! Мянга мянган жил хүр чулуу мэт бөх нойрсож буй моддын сүүдэрт үлгэр домог гэхээр тийм эрт дээр цагт амьдарч агсан амьтдын яс миний тугалган ултай гутлын улан доор шажигнаж байлаа.

Ай харла, завтай ч болоосой доо би! Тиймсэн бол ч би уулын энгэр рүү бууж очоод тэр нэгэн цагт Африк, Америк хоёрыг холбож байсан бололтой, энэхүү асар том тивийг захаас нь захы нь хүртэл тойрохсон билээ. Тиймсэн бол би усан галба юүлэхээс өмнө танд байсан бүх хоты нь явж үзэхсэн бөгөөд тэр үеийн эртэн чадалтангуудын барьж өдий олон зуун жил цуцалтгүй зогсож, усны эвдэж сүйтгэх их

хүчийг олон мянган жил эсэргүүцэн тэсч буй тийм аврага их чадалтай барилгуудыг сонирхсон бүлгээ.

Далайн ёроолд булшлагдсан тар балгасыг магад ч үгүй, хэзээ нэгэн цагт газрын хөрсний тавцан галтуулын дэлбэрэлт зэрэг дахиад л гаргачих өдөр ирж ч байж юу магад.

Тэнгисийн энэ орчинд одоо ч гэсэн оргилж буй галт уул тун олон билээ. Эдгээр долгилсон цүнхэг дээгүүр хөвж явсан галт онгоцыг дороос нь хүчтэй ёворч байсныг далайчид нэг биш удаа тэмдэглэсэн бүлгээ. Тэдгээрийн нэг хэсэг нь догширсон тэмцлийн бүдэгхэн чимээ усан доор нуржигнан байхыг сонсч нөгөө хэсэг нь галт уулын чандруу усан дээр хөвж явахыг үзжээ. Дэлхийн бөмбөрцгийн энэ нэг хэсэг, дэлхийн гол бүслүүр экватор хүртэл тэр чигээрээ галт уулсын оргилолтын үхэж мөхөшгүй муж билээ. Үнэхээр ч алс ирээдүйд, дэлбэрэлт бүрийн дараагаар давхраатан үелж царцаж байгаа халуун хайлмаг бодис тэдгээр галаар аахилагч уулсын оройг далайн төвшин дээр ил гаргачих ч юм билүү яаж мэдэх вэ?

Байгалийн тэрхүү асар гуалиг үзэмжийг би санаандаа буулгаж авахыг оролдон, хүсэл мөрөөдөлдөө бүрмөсөн автагдаж гөлрөх зуур мань капитан Немо; замаг шавж ургасан мод тохойлдон хөшөө мэт хөдөлгөөнгүй зогсч байв. Хүмүүсийн үрэгдэж үгүй болсон үр хүүхдийн тухай бодоо бол уу тэр? Хүмүүсийн үе залгамжлах ирээдүйн залуу үеийнхний хувь заяа чухам ямар байхыг тэр өөрөөсөө асуугаа бол уу? Эсхүл энэ нэг орчин үеийнхнийг үзэж чаддаггүй этгээд хачин хүн элэнц хуланцынхны амьдралаар амьдрах гэж энд ирсэн юм болов уу? Түүний бодлыг зөвхөн таахын тул би юугаан эс өх байсан бол доо!

Бид бүтэн цагийн турш нар мэт хурц тунгалаг гэрэл цацаргаж буй гал халуун хайлмаг бодисын туяанд гийгүүлэгдсэн уудам хөндийг ухаан санаандаа тунгаан авахаар ширтэн зогслоо.

Ууулын энгэр хажуу халуун хайлмаг бодис дотор нь байгаа улмаас доргин донсолж байв. Ус дамжин чихэнд ирж буй хүрчигнэсэн дуу сүрлэг болоод догшин ажээ.

Тэр минутанд сарны туяа усны давхаргыг нэвт гэрэлтүүлэн хэдэн минутын турш живж орсон тивийг гэрэлтүүллээ. Тэрхүү үзэгдлийн сэтгэл догдлом тэр сайхан үзэмжийг үгээр нэвтрүүлэхийн арга алга!

Капитан Немо тушиж зогссон модноосоо гэнэт холдон одож, хязгааргүй уудам хөндий тийш сүүлчийн удаа харцаа хандуулаад, өөрийгөө дагалдах дохио надад өглөө.

Бид уулнаас эгшин зуур бууж очжээ. Биднийг нүүрсэн ойгоос гарч ирэхийн хамт

«Наутилус»-ын гэрэл алсад од мэт гялалзан харагдав.

Капитан яг түүнийг чиглэж алхлав. Бид өглөөний түрүүчийн туяа далай дээгүүр цацран байхад онгоцондоо эргэж ирлээ.

[Тор](#)

---

## УСАН ДООРХИ УУРХАЙ

Маргааш өдөр нь хоёрдугаар сарын 20-нд өглөөе би тун орой сэрлээ. Шөнийнхөө зугаалганд би тэгж их ядарсан тул арван нэгэн цаг хүртэл унтчихжээ.

Босонгуут би бушуухан хувцаслаж салонд явж оров. “Наутилус” ч чухам хаана явж байгааг мэдэхийг хүсч тэсч ядсан билээ.

Хэмжих багажуудын заалтаар тэр мөн л өмнө зүгийг барьж зуун метрийн гүнд, цагт хорин милийн хурдтай явж байв.

Тэгтэл ч Консель орж ирэв. Түүнд би, бидний шөнийн зугаалгын тухай ярьж өх завсар цонхны халхавч төмөр сөхөгдөж сөнөж мөхсөн нөгөө тивийн зарим хэсгийг тэр үзэж авлаа.

“Наутилус” онгоц Атлантын далайн ёроолоос дээш арваадхан метрт шумбаж явав. Тэр, салхинд хийсэх, хий дүүргэсэн хальсан бөмбөг шиг довтолж бүлгээ. Гэвч бидний мэдрэхүйг буухиа галт тэргээр зорчигсод цонхны цаагуур жирэлзэн өнгөрч буй байдлыг ажиглахтай жишиж үзвэл зохихсон билээ.

Бидний нүдний өмнүүр этгээд хачин дүрст хадад, амьтны ертөнцөөс эрдсийн ертөнцөд шилжиж буй ой, шугуй, бут мод асцидий, анемон хэмээх урт босоо замгуудаар хучигдсан байшин барилга, асга хаддын овооролдсон хэмхэрхий, мөн түүнчлэн газрын гүн дэх галт ажиллагааны хэлгүй гэрч болсон халуун хайлмаг бодисын царцмал чулуулгууд жирэлзэн өнгөрч байв.

Нүдгүй харанхуйн дундаас, «Наутилус»-ын цахилгаан дэнгийн гэрэлд тодрон буй тэдгээр сайхан үзэмжит хөрөг бидний урдуур дурайн өнгөрч байх завсар би үнэн хэрэг дээрээ байсан эсэх нь надад ямар ч эргэлзээгүй болсон атлант омогтон ба Атлантид тивийн тухай Консельд ярьсан билээ.

Гэтэл Конселийн анхаарлыг ямар ч юм нь тагчихсан юм, тэр миний үгийг харангуут сонсч байв. Гэвч удсан ч үгүй бид түүхийн тэр агуу тааврыг тийнхүү амарлингуй чагнаж байсны нь учрыг оллоо. Тэхнээ нь бидний нүдний урьдуур элдэв

төрлийн загас эрчлэн өнгөрч байсан болохоор Консель маань загас харахтайгаа зэрэг л ангилан хувиарлахын гүн тайгад төөрөөд, явчихдаг өвчтэй хүн тул тэр үед нь хамаг ертөнц гэдэг түүнд юу ч биш болдог билээ.

Тийм болохсор би Атлантидын тухай яриагаа зогсч түүнтэй хамт загасаар оролдохоос өөр замгүй болов.

Жич хэлэхэд, Атлантын гадаад далайн загас бидний бусад далайд үзсэн загаснаас ялимгүй ялгагддаг билээ. Энд уснаас дэвхрээд дээр гарчихаж чадах асар чийрэг булчин бүхий, таван метр урт аврага том скат, түүнчлэн аврага загасны янз янзын дүрс байхын дотор, цэвэр туяатай ногоон өнгийн нэгэн дүрс байгаа нь гурвалжин хурц шүдтэй, уртаараа арван таван фут бөгөөд тэр нь далайн усны өнгөтэй адил өнгөтэй тул уул өнгийнхөө ачаар давалгаан дунд бараг үл үзэгдэнэ.

Тэнд бас спарын угсааны загас хүрэн ягаан сарги, Газрын дундат далайд бидний үзсэнтэй адилхан осетр, хөндлөн хар хүрэн судалтай, гуурс маягийн урт хушуу бүхий, тунгалаг хүрэн өнгийн зүү-загас зэрэг үзэгдэв. Тэдгээр загас усанд могой мэт гулдганаж явах юм.

Яслас загаснуудын дотор Консель хорт загас хэмээн тооцдог, далайн ямаан сээр гэдэг загас буюу далайн луу загас байхыг олж харлаа. Үнэхээр ч тэрхүү луу загасын нуруу ба толгой дээр ёрдойдог хоёр чичлүүр тус бүрдээ хоёр хоёр ховилтой бөгөөд дайсныхаа биенд чичлүүрээ зоох үед тэр ховилоор нь хортой шингэн бодис гүйдэг ажээ. Луу-загас боровтор улаан өнгөтэй бөгөөд нуруу уруугаа хүрэн болж өнгө хувьсах ба гэдсээрээ цайвар өнгөтэй ажээ. Луу загасны хамаг бие үл мэдэг харавтар толботой бүлгээ.

Консель цааш нь төмөрлөгийн хөх цэнхэр туяатай, маш гуалиг алтан шар өнгөтэй, алтан макрель, үзэмжит Скумбрий загас, ээрэнцэг дугуйтай адилхан дээгүүрээ хөх, хажуугаараа хүрэн ягаан, гэдсээрээ улаан ягаан, сэлүүр нь цусан улаан гайхмаар сайхан өнгөтэй сарны загас буюу ламприд зэрэг загас олж үзлээ. Далайн амьтны аймгийн тэдгээр олон төрлийн дээжийг ажиглах явдал Атлантидын хөндийг сонирхол миний хүслийг ч боогдуулсангүй ээ. Ингэтэл ч далайн овон товон муу ёроолоос болж “Наутилус” хурдаа сааж жигдрүүлж билээ.

Тэр үед “Наутилус” усан доорхи голдирол дундуур ёстой л загас шиг цовоо сүлжиж билээ.

Хэрэв ёроолын товцог хоорондуур онгоц явах боломжгүй явцуу болбол “Наутилус” агаарын бөмбөг шиг усны дээд давхарга өөд хөөрч тохиолдсон саадыг давмагц, дахин доошоо орж ёроолоос хэдхэн метрийн зайнд хурдан гүйдлээ



үргэлжлүүлж байв.

Энэхүү жуулчлал тун сайхан зугаалга болсон бөгөөд ёстой л агаараа нисэх бөмбөгөөр хөвөх мэт байсан боловч залуурчийн гарын хөдөлгөөнд манай “бөмбөг” сайн захирагдаж байснаараа л ялгагдаж байв.

Өдрийн дөрвөн цагийн үед чулуужсан гишүү мөчиртэй холилдсон лаг шавраар бүрхэгдсэн ёроолын байдал бага багаар өөр болж ирлээ. Далайн ёроол одоо чулуужиж конгломератууд, галт уулын туф, цардмал хайлшийн хэсгүүд ба хүхэрлэг обсидиануудаар ихэвчлэн дүүрсэн байв.

Халуун хайлш хальсан газар энд дуусвар болж, уулархаг орон эндээс эхэллээ гэж би бодлоо. Үнэхээр удсан ч үгүй оргилууд нь уснаас цухуйж, далайн төвшин дээр ил гарсан болохоор, бодвол хэрхэвч нэвтэршгүй өндөр уулсын бараа өмнө зүгт лүглийж харагдлаа. Тэр бол эсхүл ямар нэгэн эх газрын, эсхүл арлын эрэг бизээ. Тэнд магад ч үгүй, ногоон хушууны буюу эсхүл Канарын арлуудын нэг нь байсан байж.

Сүүлийн өдрүүдэд, санаатай ч байж болзошгүй, ажиглалтын дун зураг дээр тэмдэглэгдээгүй болохоор хаана бид явж буйг би мэдэхгүй байв.

Тэр боржин хад миний бодлоор бол бид, зөвхөн баганхи хэсгийг нь үзсэн, Атлантчуудын эх газрын эпоним хана ч байсан байж болох юм.

Би өөрийнхөө ажиглалтыг шөнө ч орхихгүй байв. Консель өрөөндөө унтахаар явчихсаны дараа би салонд ганцаараа үлдлээ. “Наутилус” гүйдлээ сааж, бүдэг бадаг харагдаж буй хадан хяр дээгүүр хөвөхдөө яг зогсчих гэж байгаа юм шиг тэднийг шүргэн алдаад л заримдаа далай дээр ил гарч ирээд л явж байв.

Яг тийм минутанд би, хэд хэдэн оддын бөөгнөрлийг усны нимгэн давхарга нэвт харсан минь, Орионы сүүл хэрд гялалзах тав зургаан од байсан шиг санагдана.

Хэрэв л цонхны халхавч гэнэт хаагдаагүйсэн бол би тэнгэр, тэнгис хоёрын гоёмсгийг ширтэн цонхны дэргэд бас л нилээд удаан суух байсан билээ.

Яг тэр минутад “Наутилус” өөдөө эгц босоо элэглэсэн хаданд тулж ирсэн бүлгээ. Тэр саадыг яаж гэтлэх бол? Би ойлгохгүй байв. Би өрөөндөө эргэж ирэхээс өөр арга олдсонгүй. Энэ хэр “Наутилус” хөдлөхгүй байв. Тэгээд би ямар боловч өглөө эртхэн босох эрс шийдвэртэйгээр нам унтсан бүлгээ.

Гэвч би маргааш өглөө нь зөвхөн л найман цагийн үед бослоо. Боссон дорхноо би салонд гүйж оров. Даралтын хэмжүүр “Наутилус”-ыг далай дээр ил хөвж буйг зааж байв. Гэвч би энэ тухай тавцан дээр хүн алхлах чимээгээр мэдэж болох билээ. Харин тэгэвч, далай дээр ил хөвөх үед зайлшгүй үүсэх хэлбэлзэл өчүүхэн төдий ч байсангүй ээ.

Би өөдөө гарах нүх рүү очвол тэр нээлттэй байв. Гэтэл харин намайг угтвал зохих гялбам хурц гэрлийн оронд намайг пад харанхуй хүрээлжээ.

Хаана бид байв аа? Үнэхээр би бүхэл бүтэн хоног таг унтчихлаа гэж үү? Тэгээд шөнө байв гэж үү?

Үгүй ээ. Тэнгэрийн мандалд нэгхэн ч од үл гялалзаж билээ. Ерөөсөө ч шөнө гэдэг хэзээ ч ийм нүдгүй пад харанхуй биш бизээ.

Чухам би юу гэхээ мэдэхгүй байтал харанхуйн дундаас нэгэн хүн гэв гэнэтхэн:

- Аа, эрхэм профессор та юу? гэж намайг угтлаа.

- Аа капитан уу! Бид хаа байгаа нь энэ вэ?

- Газар доор байна аа, эрхэм ноён профессор.

- Газар доор ий? хэмээн би хашгарч орхив. «Наутилус» ч бас явж л байна уу?

- Тэр хэзээ ч явж л байдаг.

- Гэвч... би ер нь юу ч ойлгохгүй байна...

- Хэдхэн минут тэс. Одоохон чийдэн асна. Тэхлээр л т аойлгоно доо.

Би чийдэнгийн суурин дээр сууж гэрэл асаахыг тэвчээртэйхэн хүлээлээ. Харанхуй гэдэг там учраас би капитан Немог харахгүй байв.

Нүдээ би дээш нь болгож харвал яг толгой дээрээ дугараг нүхээр нэвтэрч буй ямар нэгэн бүдэг үл мэдэг гэрэл шү юм олж үзэв. Гэтэл тэр минутанд цахилгаан чийдэн улсхийж, түүний гялбам хурц гэрэл өнөө үл мэдэг гэрэл шүү юмыг замхруулчихлаа.

Миний нүд гэрэлд дассаны дараа би орчин тойрноо ажиглаж эхлэв.

«Наутилус» маань далайн ямар нэгэн боомт хотын хэрэмтэй төстэй өндөр эргийн дэргэд яг зогсч байв. Усан доогуур явагч хөлөг маань тал бүрээсээ хадан ханаар хүрээлэгдсэн нууран дээр зогсч байв. Нуурын өргөн нь барагцаалбал хоёр миль, тиймээс эргэн тойрон зургаан миль ажээ. Нуурын усны хэм далайн усны хэмтэй яг нэг төвшинд байсан нь эргэлзээгүй бөгөөд энэ нуур далайтай заавал аль нэгэн газраараа холбоотой нь гарцаагүйг даралт хэмжих багажийн заалтаар ч нотолж болох байв.

Өндөр өндөр хадан хана нуурын дээрээс тонгойж дээгүүрээ тав буюу зургаан зуун метрийн өндөрт нийлж асар том хүнхэр адар үүсгэжээ. Тэр хүнхрийн хамгийн дээд талд бодвол нарийхан гэрэл оруулж агсан өнө нүх байгаа ажээ

Тэр асар том агуйн дотоод талыг анхааралтай судлах судалгаанд орохын өмнө, түүгээр ч барахгүй тэр агуй байгалиасаа тийм буюу эсхүл хүний гараар бий болоо юу гэдгийг нь мэдэхийн өмнө би капитан Немод ойртон очиж:

- Бид хаана байна? гэж асуулаа.

- Уул үүсэлтийн доргионд ямар нэгэн шалтгаанаар далайн усаар дүүргэгдсэн сөнөсөн галт уулын тэн голд байна даа гэж тэр хариулаад – Ноён профессор таныг унтаж байх үед “Наутилус” далайн төвшнөөс доош арван метрийн гүнд байдаг байгалийн нарийхан сувгаар энэхүү гүехэн усанд орж ирсэн юм. Энэ бол зүг бүрийн салхинаас бат хамгаалагдаж, хүмүүсийн хомхой нүднээс хол далдлагдсан “Наутилус”-ын найдвартай, сайхан зогсоолуудын нэг нь байгаа юм. Танай тэр арал, тивүүд дээр чинь хөлөг онгоцыг салхи шуурганы догшролоос энэ агуй шиг итгэлтэй халхлах, ядаж ганц боомт надад заагаад орхи л доо! гэв.

- Энд та, үнэхээр ямар ч аюулаас айхгүй юм байна. Энэхэн сөнөсөн галт уулын дотоод хөндийд танд юу заналхийлжэв дээ? Энэ агуйн адар цоорхой байх шиг надад санагдсан нь миний санаа дагаа юу, аль эсхүл үнэхээр байдаг юм уу, та хэлчихгүй юу? гэж би өгүүлэв.

- Тиймээ, Үнэн, тэр бол хэзээ нэгэн цагт гал утаа, хүхэрлэг уур, халуун хайлмаг бодис оргилон байсан галт уулын хуучин цооног, одоо тар цоорхой, бидний энэ амьс- галан буй амьдруулагч цэвэр тунгалаг агаарыг миний энэ онгоц татаад нэвтрүүлдэг юм.

- Энэ ямар гэгч галт уул вэ?

- Энэ бол тэнгисийн энэхэн хэсэгт үй олноороо байгаа арлын нэгэн дээр сүндэрлэн байдаг галт уул бөгөөд дэргэдүрээ явж өнгөрсөн жирийн нэг хөлөг онгоцонд бол уснаас цухуйж буй ердийн л нэгэн хадан цохио, харин бидэнд бол дэлхий дээр хамгийн таатай усан буудал болдог юм. Би үүнийг огт санамсаргүй олж нээсэн юм. Тэгээд ч энэ завшаан надад тун их тус хүргэсэн юм даа.

-Үүн рүү цооног нүдээр дүүжигнэн бууж болохгүй гэж үү?

- Тэр бол эндээс уул цооногоор буцаад дээшээ гарахтай ав адилхан болшгүй зүйл. Барагцаалбал дээшээ зуугаад фут хана дамжин авирч цаашаагаа хүнхэр тааз дагаж ямар ч аргагүй болдог юм.

-Миний харахад, капитан танд байгаль өөрөө хаана л бол хаана хэзээ ямагт туслаад байх шиг. Та газар доорхи энэ нууран дээр ямар ч аюул хөнөөл үзэхгүйгээс гадна, хэний ч найрсаг бус зочлолт таныг айлгахгүй санжээ. Гэвч танд ийм орогнох орон юундаа хэрэгтэй юм? Тэртэй, тэргүй “Наутилус”-т ямар татаал, зогсоол гээд байхын хэрэг байх биш?

- Үгүй ээ, эрхэм профессор минь тийм биш. «Наутилус» хөдлөхийн тул цахилгаан, цахилгаан энерги гаргахын тул цахилгаан зай үүсгэгч, тэгвэл тэр зай

үүсгэгчий чинь тэжээхийн тул натри, натирийг гаргахын тул нүүрс, нүүрсийг уудлахын тул уурхай хэрэгтэй байдаг юм. Энд геологийн тэрхүү дэвэн галбын үед ургасан ой тайгыг далай залгичихсан юм. Тэгвэл одоо тэр их мод чулуужаад чулуун нүүрс болчихсон болохоор наддаа барагдашгүй арвин их түлшний агуулах болж хувирсан юм.

- Тэгвэл, таны далайчид энд, уурхайчид болж хувирдаг байх нээ?

- Таны түмэн зөв. Эндхийн нүүрсний тухай нууц Ньюкестлийн нүүрсний уурхайнууд шиг яг л усан доор байдаг юм. Энд миний далайчид баг өмсчихөөд, хүрз, зээтуу барьчихаад нүүрс малтаж хуурай газраас нүүрс авах аюулаас намайг ангижруулдаг. Натри гаргахын тул би энд нүүрс шатаах үед утаа нь энэ уулын оройн цооногоор савсаж, оргилж буй галт уул мэт харагддаг гээч.

- Танайхан натрийг хэрхэн гаргаж буйг би үзэх бол уу?

- Үгүй ээ. Энэ удаадаа би дэлхий тойрох бидний усан доогуурхи аяллыг цааш нь үргэлжлүүлэхийг одоохондоо яарч буй тул үзэхгүй. Энд хадгалсан бэлэн натриа аваад л би болох нь тэр. Түүнийг маргаашнаас хэтрэхгүй хугацаанд онгоцондоо ачиж авмагц л бид аян замдаа орно доо Тиймээс, ноён профессор та, хэрвээ л энэ агуйтай танилцаж, энэ нуурыг тойрч үзэхийг хүсч байгаа бол зогсож буй энэ нэгэн өдрийг ашиглаж болно.

Капитанд би баяр талархлаа дэвшүүлээд одоо болтол өрөөнөөс гарч ирээгүй байсан нөхдийнхөө хойноос явав.

Бид чухам хаана байгааг би тэдэнд хэлэлгүй шууд л на майг дагалдахыг айлдлаа.

Тэд намайг дагалдан тавцан дээр гарч ирлээ. Ердөө юунд ч үл гайхан биширдэг Консель усан доор унтаад, газар доор сэрснээ мөн л тэр зангаараа угтсан нь мэдээж хэрэг билээ. Нед Лендийн хувьд бол ч тэр нэгэн агуйгаас тэнэгэр сэнгэнэм агаарт гарч очих ямар нэгэн нүх сүв байна уу л гэсэн нэгэн зүйлийг сонирхон байв.

Өглөөний зуушны дараагаар, арван цагийн үед бид эрэг дээр гарав.

- За тэр дээ, газар гишгэх маань энэ дээ! гэж Консель хэлэхэд, Нед Ленд:

- Үүнийг чинь ямар газар гэдэг юм! Түүнээс гадна бид газар дээр биш доор байгаа биш үү? хэмээн маргалдав.

Агуйн хананы хормой нуур хоёрын хооронд таван зуун футээс хэтрэхгүй өргөн элсэн хөвөө байх ажээ. Тэр элсэн хөвөөгөөр явж нуурыг хялбархан тойрч болох байв. Агуйн хананы ёроолд галт уулын элдэв төрлийн чулуулгууд эмх замбараагүй онгиролдон хэвтлээ.

Газрын дотоод галд хайлж, дахин царцсан агуйн хананы дотор тал онгоцны

цахилгаан чийдэнгийн цацралд мянга мянган өнгөөр туяаран гялтганаж байв. Бидний хөлөөр дээш дэгдсэн гялтгануурын тоос цасны ширхэг мэт язганан гялалзах ажээ.

Нуурын эргээс холдох тутам газрын хөрс шатны довжоо мэт үелэн өндөрсөж, хэн болгоомжтой явахгүй бол хоорондоо юугаар ч үл барилдан авцалдсан сул чулуунууд хөл доор ганхаж байв.

Тэрхүү асар том агуй галт уулын гаралтай гэдэг нь алхам бүрд нотлогдож байлаа. Энэ тухай би нөхөддөө анхааруулж л явав.

- Байгалийн хөгжлийн түүхийн тэрхүү алслагдсан өдрүүдэд, халуун хайлмаг шингэн бодис энэхүү агуйн дотоод хөндийд дүүрэн бялхаж, тэр галт шингэний дээд төвшин цооногийнхоо амсарт, ган хайлах зууханд шингэн металл бундах мэт тулаад байх үед энэ агуй чухам ямар шүү байдалтай агсныг та нар төсөөлөн ойлгож байна уу?

- Тун сайн төсөөлж байна хэмээн Консель хариулаад гэлээ ч гэсэн. яагаад тэр галт ажиллагаа шувтарч, яахаараа энэ галт уулын улайдаж уухилсан хөндий хоолойд одоо ус цалгилах болсныг бидэнд эзэнтэн хэлчихгүй балов уу гэлээ.

- Бодвол, Консель минь хэмээн -би энэ өөрчлөлт газар хөдлөлтийн нөлөөгөөр болсон буйзаа “Наутилус” энэ агуйд орж ирдэг тэр ангал, энэ уулын дор хормойд газар хөдлөлтийн эцэст бий болжээ. Атлантын тэнгисийн ус түүгээр дамжин энэ галт уулын гол гол голомт руу юүлчихсэн юм байна. Тэхлээрээ энд гал ус хоёр авцалдаж аймшигтай юм болсон нь зайлшгүй. Тэгээд ус нь дийлж л дээ. Түүнээс хойш олон олон зуун өнгөрч, усанд хахаж цацсан энэ галт уул энгийн нэгэн номхон нуур болон тогтсон байх ёстой гэв.

- Тун сайн хэмээн Нед Ленд илтгэж, би таны тайлбарлалыг хүлээн авах боловч таны саяны ярьдаг тэр ангал усан дээр биш харин усан доор бийд нь би тун харамсаж байнам. Бидэнд бол нөгөө тийшээ байвал зүгээр байсан юм гэв.

- Хэрэв тэр ангал далайн төвшин доор байгаагүй бол гэж Консель, түүний яриаг өлгөн авч, “Наутилус” түүгээр нэвтэрч энд, орж ирэх учиргүй гэдгийг та мартаж байна. Хэрэв л тийм бол түүнээс бидэнд ямар ч ашиг гарахгүйсэн биш үү гэлээ.

- Түүгээр ч барахгүй энэ галт уул сөнөхгүйсэн биш үү. Та дэмий л юманд харамсаж. байна даа гэж би нэмэрлэн хэлэв.

Энэ хэр бид дээшилсээрл байв. Бидний дагаж явсан жим улам бур нарийхан улам бур эгц болж байв. Гүнзгий ан цавууд зам хөндлөн боож тэр тутам харайхын зовлон тохиолдох боллоо.

Заримдаа зам дээр нурж унасан хад асга тойруу зам сонгох гэдсээрээ гулгах, дөрвөн мөчөөрөө мөлхөх аюулд хүргэж байв. Гэвч Конселийн цовоо шаламгай хөдөлгөөн Нед Лендийн чийрэг хүч тамирын ачаар бид эдгээр саадыг туулсаар явав.

Ийнхүү яв явсаар барагцаалбал гучин метрийн өндөрт газар хөрсний байдал өөрчлөгдөж, явган явахад тийм ч таатай биш боллоо Энд трахитууд ба галт уулын конглометратууд хөөс мэт цацарсан халуун хайлмаг бодисын тов толигор буюу эсхүл яльгүй бурзгар хар хүрмэн чулуулгуудаар болон доошоо нам суусан хүнхэр адрыг баганадсан, байгалийн уран барилгын урлагийн гайхамшиг нэгэн хэлбэр олон талт босоо багануудаар солигдож байв.

Хүрмэн чулуун хаддын хоорондуур халуун хайлмаг бодисын царцмал урсгал могой мэт тахирлан, түүн дотор битумт занарын хэлтэрхийнүүд толболон харагдаж, бургисан хүхэр шингэсэн өргөн хэсгүүд шарлан үзэгдэж байв. Энэхүү сөнөсөн галт уулын гүнд мөнх булшлагдсан орхимол чулуулгуудыг агуйн дээд цооногоор орж ирсэн өдрийн цайвар гэрэл бүдэг бадаг гэрэлтүүлж билээ.

Барагцаалбал 75 метрийн өндөрт бидний цаашлах өгсөлтөнд давж гаршгүй том саад учирсан нь хана нь агуй дотогшоо дэндүү тонгойж өнгийсөн тул дээшээ авирахаасаа татгалзахаас өөр аргагүй болж бид, адрын намхан ирмэг дагуу явлаа.

Энэ орчинд ургамлын ертөнц амьгүй байгалийн ертөнцийн өмнө зэвсгээ хураасангүй, хадан хананы ан цав руу үндсээ оруулан, хад чулууны хонхор хотгорт ганц нэг жижигхэн мод хэд хэдэн бут ургасан ажээ.

Энд би өөрийн биеэс идэмхий шингэн ялгадас гаргадаг молочайникийн бут, нарны гэрэл хэзээ ч үзэхгүй мөртөө “нар өөд хандмал” гэсэн грек нэрэндээ ер зохиогүй ямар ч үнэр танаргүй хэдхэн тооны гелеотроп хэмээх, нэгэн дүрс далайн ургамал, үзтэл үхэж буй агар модны дэргэд ургасан хатангар дохигор хризантемууд, хамгийн эцэст халуун хайлмаг бодисын халилга хооронд өөрийн жинхэнэ анхилам сайхан үнэрийг бүрэн хадгалж чадсан саргай цэцэг ургасан тул би тэдгээрийн үнэрийг дуртай нь аргагүй үнэрлэн амьсгалж агснаа шудрагаар хүлээх байнам.

Бидний дагаж явсан хилийн зарим хэсгээс тэр нуур бүхлээрээ үзэгдэж байв. “Наутилус”-ын чийдэн, түүнийг тодоос тод гэрэлтүүлэх тул түүний толь мэт гөлгөр гадаргууг салхины зөөлөн үлээлт, усны давалгаа хоёр үл бусниулж байлаа. “Наутилус” хөдлөхгүй яг зогсож, түүний тавцан ба нуурын эрэг дээр чийдэнгийн хурц гэрэлд тодорч буй усан цэргүүдийн хар хар дүрс нь илхэн харагдах ажээ.

Бид тэр үед агуйг бүтэн тойрсон, ирмэглэсэн хадны хамгийн өндөр хэсэгт авирсан байв.

Хэд хэдэн махчин шувуу агаарт халих буюу хэн ч ойртож хавьташгүй өндөр хадны ангалуудад үүрээ зассан хэсэг нь тэндээ бүгж байлаа.

Тэд бол цагаан цээжит харцага орлио кобчикууд ажээ. Нилээд хэдэн мундаг тарган тоодог хэвгий хадан хавцгай дагаж нааш цаашаа гүдэгнэж явлаа. Тэдгээр тарган шувуудын бараагаар канадын харъяатын хоёр нүд ямар их шунаг гялалзаж, буу авч гарсангүйдээ ямар их хар бууж агсныг төсөөлөн бодож болох юм. Тэр тугалган сумыг чулуугаар төлөөлүүлэхийг оролдож, олон дахин хий дэмий шидэж цөхөрсний эцэст нэгэн томоохон тоодог цохиж унагасан бүлгээ. Канад хүн шархадсан шувууг барьж авах гэж хорь гучин удаа нисч үхэхийн аюулаас нэг төө хүрэхгүй зайтай агсныг нэмж давсалж ярих нь ч биш шууд хэлж болно.

Гэлээ ч гэсэн хэргийн байдал ямар ч байлаа гэсэн өнөө шувуу, түүний ангийн богцонд аяндаа орж сэтгэл амарсан билээ.

Хад-хясаа яваа яваандаа авирах мацахын аргагүй болсон тул бид удсангүй доошоо бууж очихоос өөр замгүй боллоо. Галт уулын цооног. бидний толгой дээр нилээд өндөрт тээр дороос худгийн уужим асар шиг харагдаж байв. Бидний зогсож агсан тэр газраас өрнөтийн зөөлөн салхинаа хөөгдөж буй уул, цэнхэр тэнгэрийн өчүүхэн хэсгийг мөн цоорхойгоор харж болох байв. Тэдгээрийн зарим хөглөрсөн хэсэг нь цооногийн аман дээр утаа мэт хөврөлдөн хэдэн минут хэр тээглэж үзэгдлээ. Үүлс их бус өндөрт хөвж буй тул энэхүү уулын оргил далайн төвшнөөс дээш найман зуугаас доошгүй фут өндөрт өргөгджээ гэсэн дүгнэлт итгэл төгөлдөр хийж болох байв.

Нуурын эрэг дээр бууж ирсний дараа би түүний ургамал амьтантай танилцаж эхэллээ. Тэнд надтай хамгийн түрүүн дайралдсан нь хоолонд онц сайн хачир болдог том бус шүхэр маягийн ургамал укроп, хивс мэт дэвсгэрлэн байв. Түүнээс Консель хэд хэдэн баглаа түүж авлаа. Тэндхийн амьтдын талаар бол ч мянга мянган төрлийн янз бүрийн аалз, хавч, наймалж, том жижиг зөөлөн биетнүүд өдий төдийгөөрөө байв.

Энд бид зузаан, зөөлөн шаргал, торгон элс дэвсгэрлэсэн сайхан агуй оллоо. Хадаар мацаж ядарсандаа би, нөхдийнхөө хамт элсэн хэвтэр дээр дуртай нь аргагүй сунаж уналаа. Газрын доорхи гал тэр агуйн дотор талыг хайлган толийлгож, гялтгануурын тоос шигсэн нь алмас эрдэнэ мэт гялалзах ажээ.

Нед Ленд тэндхийн хананы зузаан нимгэнийг шалгаж тойруулан тогшиж үзлээ. Түүний ашиггүй оролдлогыг би хараад инээдээ барьж чадсангүй ээ. Бидний яриа аанай л мөн оргох зугатах тухай үүсэв Капитан Немо ийнхүү өмнө зүг эргэж одсон нь зөвхөн л натрийнхаа нөөцийг нөхөх зорилготой болов уу, гэвч тэр Европ ба

Америкийн эрэг рүү, умар зүг дахин эргэнэ гэж найдах горьдлого бас л байгаа тул тэхэд л оргох оролдлого нэн бүтэмжтэй дахин давтаж болох тал бий гэж Нед Лендийг би түр зуур боловч хуурч тайвшруулах эрхтэй хэмээн өөрийгөө үзэв.

Бид тэрхүү агуу сайхан агуйд цаг хэр боллоо. Эхлээд тун наргиантай байсан бидний яриа одоо бараг намжирчээ. Бид ямар нэгэн хачин нойрмог байдалд шилжиж байв. Даруйхан буцахыг яарахын хэрэггүй тул би нойртойгоо тэмцэхийг төдий л хичээсэнгүй.

Бид зүүднийхээ эрхшээлд байх хувьтай тул зөөлөн биетний бүдүүлэг амьдралтай болчихож, миний хоёр хавтастай хясаа хуяг энэ агуйд байна гаж зүүдэллээ. Тэгтэл намайг гэнэтхэн:

- Босоорой, хүүе босоорой! хэмээн хашгарч буй Конселийн дуу сэрээлээ.

- Юу болов со? Гэж би элсэн дээр босч суунгуут асуув:

- Ус, ус! гэж бархирч байв.

Би босон харайв. Бидний орогнож агсан агуйд далай юүлэн орж ирж байсан тул бид арчаагүй нялцгай биетэн биш болохоор амиа хаацайлах хэрэгтэй болжээ.

Хэдхэн минутын дотор бид ус хүрэхгүй газар агуйн хананд авиран гарчээ.

- Юу болж байна даа? Байгалийн бас л нэг шинэ сонин шид нь харагдах нь уу? гэж Консель асуув.

- Үгүй ээ хонгор минь, үгүй. Ердөө л нэг далайн энгийн түрлэг болж байна. Харин биднийг нойрон дээр маань золтой л залгичихсангүй. Агуйн гаднах тэнгисийн усны төвшин тэнгисийн түрлэгээр дээшээ хөөрч харьцах хоёр саванд буй шингэний хэмийн тэнцвэрийн хуулийг дагаж, нуурын ч усны төвшин дээшилсэн байна. Бид жаахан умбаж аваад л салсандаа баярлалаа гэж хэлэх ёстой. Одоо харин “Наутлус”-таа очиж хувцсаа солих хэрэгтэй гэж би хариулав.

Тэгээд дөчин таван минутын дараа бид уул нуурыг бүтэн тойрсны эцэст “Наутилус”-ын нөгөө талаас нь хүрч очлоо.

Усан цэргүүд натри ачих ажлаа дуусч “Наутилус” аян замдаа тэр дорхиноо хөдлөхөд бэлэн болжээ.

Гэвч капитан Немо хөдлөх тушаал өхгүй байв. Усан доорхи сувгаар шөнө сэмхэн гараад явчих гэж тэр бодсон юм болов уу? тэгсэн ч байж болох юм.

Дараачийн нь өглөө “Наутилус” харин өөрийнхөө нууц зогсоолоос хэдийн гарчихсан, хуурай газраас алс хол, Атлантын тэнгисийн уснаа, хэдхэн метрийн гүнд явж ахуйг бид мэдлээ.



## САРГАССЫНТЭНГИС

Харин тэгтэл “Наутилус” маань Европоос холдсоор байв. Түүний эргийг ойрхноос харах найдвараас хэсэг зуур боловч татгалзахаас өөр аргагүй болжээ.

Манай онгоц өмнө зүгийг чиглэн довтлов. Капитан Немо, өөрийн онгоцыг хааш нь авч одох нь тэр вэ?

Бүү мэд ээ, би учрыг нь олсонгүй. “Наутилус” тэр өдөр Атлантын тэнгисийн онц сонирхолтой газраар хөвж явав. Гольфстрим хэмээх, тэнгисийн их дулаан урсгал байдгийг хэн бүхэн мэднэ. Флоридин эргээс тэр Шпицберген руу чиглэдэг бүлгээ. Энэ урсгал Мексикийн буланд орохын өмнө умарт өргөргийн дөчин тавдугаар хоногт хоёр салаалан оддог билээ. Тэдгээрийн их салаз нь Ирланд, Норвегийн эрэг орчноор гарахад, бага салаа нь Азорын арлууд руу өмнө зүг одож дараа нь Африкийн эрэг тийш даялсаар, том цагираг үүсгэсний эцэст Атлантын арлууд руу эргэж ирдэг бүлгээ.

Тэрхүү хоёрдугаар салаа гэхээр цагираг гэвэл илүү тохирох урсгал Атлантын тэнгисийн овоо номхон болж ирээд хөдөлгөөн багатай хэсгийг нилээд бүлээн усаар тусгаарлан тойрох тул тэр хүрээлэгдсэн хэсгийг Саргассын далай гэж нэрлэжээ..

Тиймээ Саргассын далай нь Атлантын тэнгис дунд ёстой нуур мэт оршиж билээ. Гольфстримын дулаан урсгал бүтэн гурван жил явж гэмээ нь сая түүнийг бүтэн нэг тойрдог бүлгээ.

Би хувьдаа хэлэхэд, Саргассын далай Атлантын усан доогуур живж орсон бүх дэвсгэр дээгуур нөмөрдөг гэх байна. Зарим нэгэн хүмүүс түүний усан дээр хөвж яваа өвсийг тэрхүү алга болсон тивийн тал нутагт ургасан өвс гэсэн тааврыг ч хөгжөөсөн билээ. Гэвч тэр таавар найдвар багатай юм. Юу юунаас өмнө мөн л өнөө Гольфстрим маань тэдгээр өвс болоод замгийг Америк ба Европын эрэг орчноос Саргассын далайд урсгаж аваачдаг тул болой.

Энэ явдал бусдын нэгэн адил Колумбын толгойд шинэ ертөнц байгаа тухай бодол төрүүлсэн ажээ. Тэгээд аймшиггүй шинжээч Саргассын далайг гэтэлсний эцэст, замаг ба өвсөн дунд түүний хөлөг онгоц ороолдож, тэдний аян гурван сунагар

долоо хоногоор удааширсан билээ.

“Наутилус”-ын маань одоо хөвж яваа тэр далай ийм л далай даа. Энэ бол онгоцны хушуу арай ядан зүсэн зүсэн явах өтгөн сахлаг бөгөөд хөх замган хивс ногоорсон ёстой л нэг зүлэг ажээ. Тиймээс ч капитан Немо хөлгийнхөө сэнсийг тэрхүү гаталшгүй өтгөн шигүү ширэнгэн дунд хугалах буюу гэмтээх аюулаас айж Саргассын далайг туулах бүх хугацаанд үргэлж л хэд хэдэн арван метрийн гүнд явж билээ.

Энэ далайг Испанийн “sargasso” буюу замаг гэсэн үгнээс Саргассын буюу замагт далай гэж нэрлэжээ. Тэнд ургагч замгууд дийлэнхдээ хөвөгч замаг бөгөөд усны тэрхүү асар уудам хязгаарын ургамлын гол бүрхүүл болжээ.

Атлантын тэнгисийн тэрхүү амгалан буланд яахаараа замаг тийм олноороо хуримталсан тухай асуултанд “Дэлхийн бөмбөрцгийн физикийн газар зүй” гэдэг номыг зохиогч Мори хариуллаа.

“Энэ үзэгдэлд нийтэд ойлгомжтой байгаа туршлага тайлбар өгч байна. Хэрэв аягатай усанд үйсэн бөглөөний үйрмэгүүд болон зомгол, эсхүл өөр ямар нэгэн хөвөгч биес хийж, уул усанд эргэх хөдөлгөөн олговол, тэдгээр бутархай хэсгүүд бүгд аяганы голд буюу хөдөлгөөн багатай төвд цугларахыг төдөлгүй харж болно оо. Бидний сонирхож буй зүйлд Атлантын тэнгис аяга нь болж, Саргассын далай хөдөлгөөн багатай төв хэсэг нь буюу хөвөх чанартай биес цугларах гол нь болох ёстой” хэмээн тэр өөрийн номондоо бичжээ.

Морийн өгсөн тайлбарыг би бүрэн зөвшөөрнө. Бусад эрдэмтэн үл олдох нөхцөлийн дунд усан доор, тэр үзэгдлийг судлах завшаан надад олдсон юм. Тэнд хүрэн замгууд, өвс хулс, Андын ба Асгат ууланд үерт унаад, Амазонкийн буюу Миссипийн урсгалаар Атлантын тэнгист авчрагдсан моддын гол, онгоцны хитэг, хэрэглэлүүд, хавч хясаа, навч нахиа зэрэг уснаа хөвж чадахгүй болтлоо хүндэрсэн онгоцны хуяг, их биений үлдэгдэл, хөлгийн сүйрлийн олон янзын сэг манкай онгоцон дээгүүр хөвж явлаа.

Саргассын тэнгист олон зуун жилийн турш хуримтлагдаж буй бүх зүйлс далайн усны нөлөөгөөр минералжиж чулуун нүүрсний барагдашгүй арвин нөөц бүхий давхарга болон хувирна гэсэн Морийн бас нэг нотолгоо яваа яваандаа батлаглана гэдэгт би мөн үл эргэлзэнэ. Хүн төрөлхтөн дэлхий дээрх нүүрсний нөөцийг бүгдийг ухаж барах тэр нэгэн цагт ашиглалтанд оруулахаар байгаль урьдаас нөөцөлсөн бэлтгэл агуулах тэр болюу.

Эдгээр эмх замбараагүй замаг зэгсэн дунд би нарийхан тэмтрүүлүүд нь арвалзан

буй сэвсгэр сайхан цэцэгтэй актиний, улаан, ногоон, хөх өнгийн маш олон медуз, түүнчлэн бас тэдгээрийн дунд Кювьгийн медуз байхыг олж харвал хөхөвтөр өнгийн шүхэр нь ягаан өнгөөр эмжээрлэгдсэн ажээ.

Хоёрдугаар сарын 22-нд өдөржингөө би Саргассын далайд өнжвөл далайн өвс ургамлаар хооллодог загас тун элбэг тэжээлтэй нь илэрхий байлаа. Гэвч маргааш нь болоход тэнгис ердийнхөө байдалд шилжлээ.

Дараачийн саруудад хоёрдугаар сарын 23-наас гуравдугаар сарын 12-ыг хүртэл “Наутилус” өдөр бүр дөрвөн зуун километр давхиж өмнө зүгийг гуйвалтгүй чиглэн явав. Бодвол капитан Немо усан доогуур хийх дэлхий тойрох жуулчлалынхаа хувийн төлөвлөгөөг хэрэг дээр нь биелүүлж буй бололгой тул “Наутилус” Горны хушууг тойроод Номхон тэнгисийн өмнөт хэсэг руу эргэнэ гэдэгт би эргэлзсэнгүй бүлгээ.

Ингээд ирэхээр Нед Лендийн болгоомжилдог зөв байв. Усны энэхүү асар уудам цөлд арал атугай тун цөөн тохиолдох тул оргох тухай бодохын ч хэрэггүй байлаа. Гэтэл бас, нөгөө нэгэн талаар авч үзвэл бол капитан Немогийн төлөвлөгөөгөө биелүүлэхэд нь ямар ч саад хийх бололцоогүй бүлгээ.

Бид өөрсдийнхөө аз заяанд л итгэхээс өөр яаж ч эс чадах ажээ.

Гэлээ ч гэсэн аяыг нь олоод оргочих найдвар алга болсон юм бол эндээс сулрах бас нэг арга зам бий тул туршаад алдах хэрэгтэй билээ. Энэ нь дэлхий тойрох аян дууссаны эцэст түүний нууцыг бид хэзээ ч хэнд ч үл задлах ам өгч, биднийг суллан тавихыг капитан Немогоос би гуйгаад алдах нэг тал байсан юм. Бид тэр их итгэмжийг нь дүүрэн хүлээж түүний нууц бидэнтэй л хамт мөхөхсөн билээ.

Гэвч энэ явдалд капитан Немо чухам ямар шуу хандахыг сайтар хянах хэрэгтэй байв. Тэр бүр эхлээд л өөрийн нууцыг чанд хадгалахын тулд биднийг “Наутилус” дээр насан турш маань олзолно гэж шууд тулгасан биш билүү. Энэ асуудлын талаар би нэг ч удаа түүнд хандсангүй бүтэн дөрвөн сар болсныг тэр өөрийн төлөвлөгөөг уг дуугүй дагасанд бодож болох юм.

Энэ тухай одоо яриа дэгдээвэл цаашдаа хэзээ нэгэн цагт бидэнд оргож гарах ажилд садаа болж, түүнд сэжиглэл төрүүлж болох байв.

Энэ бүх бодол, миний оюун ухааныг үймүүлэх боллоо. Түүнийгээ би Консельтой хуваалцах боловч тэр энэ бүхнийг минь надаас доргүй эргүүлэн няцааж билээ. Би хэдийгээр тийм ч амархан гуньж гутахгүй боловч хүн нийгмийн дунд хэзээ нэгэн цагт эргэн очих бидний боломж өдрөөс өдөрт улам бүр найдваргүй болж, ялангуяа капитан Немо улам л шуурхайлан, ухаан жолоогүй, Атлантын тэнгисээс холдон холдон алс өмнө зүг гүнзгийрч буй нь бүр ч бидний байдлыг дортгож бүлгээ.

Саяхан өнгөрсөн арван найм хоногт бидний аялал ямар ч онцгой явдлаар гийгүүлсэнгүй ээ. Би капитан Немотой ховор тохиолдох боллоо. Тэр нь ажиллаж байв болтой. Номын санд би түүний дэлгээд тавьчихсан номыг, голчлон байгалийн судлалын ботиудыг үргэлж олж үзэх болов. Далайн ёроолын нууцын тухай миний номын зай чөлөөнд нь бичсэн онол, загваруудыг дандаа л няцаасан харагддаг билээ. Харин капитан Немо зөвхөн л миний алдааг номон дээр минь л засаж тэмдэглэхээс биш надтай шууд ном хаялцдаггүй байв.

Заримдаа би түүнийг хөгжмөөр тоглохы нь сонсдог бүлгээ. Тэр дарж буй хөгжимдөө гүнзгий автагдаж, тун чадамгай тоглодог бөгөөд ихэвчлэн эргэн тойрон хав харанхуй “Наутилус” хоосон тэнгист нам унтаж ахуйд шөнийн цагаар хөгжимддөг байв.

Энэ бүх өдрүүдэд бид ихэнх цагаа тэнгис дээр өнгөрүүлээ. Далай эл хуль, заримдаа Сайн итгэлтийн хушуу буюу Энэтхэг руу яарч яваа ямар нэгэн бяцхан хөлгийг хааяа хааяа олж хардаг билээ.

Нэгэн удаа биднийг халим гэж эндүүрээд халим агнах нэгэн жижиг хөлөг бидний хойноос элдэж билээ. Гэвч капитан Немо хөөрхий далайчдыг өрөвдөж, тэдний хүч хөдөлмөрийг хий үрэгдүүлж, цагийг нь барахгүйн тул уснаа шумбан орсноор тэрхүү мөрдлөг эцэс болж билээ.

Энэ явдал Нед Лендийн сонирхлыг харваас тун их хөдөлгөсөн бүлгээ. Манай энэ төмөр халимыг ган жадаар үхтэл нь бүлчихэж болохгүй гэдэгт Канад хүн цаанаа тун их харамссан байх гэж хэрэв хэлчихвэл алдаа болохгүй дэг гэж бодож байнам.

Энэ орчны загас умарт өргөрөгт учирсан загаснуудаас бага ялгаатай ажээ. Заримдаа бидний хажуугаар загасчдын яриагаар их ховдгоороо цуутай, томоохон хэмжээний нохой загас давхин өнгөрч байв.

Далайн эрх танхил гахайнууд өдөржингөө биднийг дагалддаг байлаа. Тэд өвлийн чоно шиг сүрэг сүргээрээ ан хийж, тав зургаагаараа явдаг ажээ. Далайн гахайнууд ч далайн нохдоос багагүй ховдог амьтад юм. Далайн гахайн язгуурт арван дүрс бий. Бидэнтэй тохиолдсон нь ч далайн гахайны дүрсэнд хамаарагдах ажээ. Тэдний толгой нь жижиг, урдуураа шонтгор, шувууны хушуу мэт урт шөвгөр хоншоортой байв. Тэд уртаашаа барагцаагаар хоёр метр ажээ.

Эдгээр далайд өргөн сэлүүртний багийн төлөөлөгч бөгтөр яргай буюу эсхүл хар сциен гэж нэрлэгддэг нэгэн сонин загас буйг тэмдэглэвэл зохино. Зарим нэгэн улсын эрдэмтэд байхаасаа юуны өмнө яруу найрагчид, эдгээр загасыг уянгалуулан дуулж чадах бөгөөд тэд сүргээрээ концерт тавивал ямар ч найрал дуучдын шилдэг

чуулгыг бүрхэгдүүлэх авъяастай гэдэг бүлгээ. Гэвч тэр нь шал худлаа гэдгийг бид дүүрэн нотолж чадахгүй боловч бидэнтэй зам зуур учирсан сциенууд л бидэнд ямар нэгэн уянгат дуу дуулж өгөөгүй нь харамсалтай.

Ингээд хамгийн эцэст тэмдэглэхэд бидэнтэй учирсан олон тооны нисдэг загасыг хэлэх хэрэгтэй. Тэгвэл далайн гахайнууд нисдэг загас агнахаас сонин юм гэж байж болшгүй дэгээ. Далайн гахайнуудын арга бодлого тун нарийн ажээ. Нисдэг загаснуудын нисэлтийн таяг тойруу хичнээн ч хол байлаа гэсэн гарцаагүй тохиох үйлийн үрээр далайн гахайн ангайсан том ам руу заавал очих бүлгээ.

Бидэнтэй учирсан загаснууд ихэвчлэн триглийн дүрсэд хамаарагдаж байв. Тэд харваж буй од мэт дахин шугам үүсгэн дэгдэж шөнийн агаарт гэрэлтэж байлаа.

Бидний жуулчлал анх эхэлсэн өдрөөс хойш бид арван гурван мянган бээр буюу тавин хоёр мянган километр газрыг явжээ. Одоо энэ үед бид өмнөт өргөргийн 45 дахь хоног 37 хувь, өрнөт уртрагийн 37 дахь хоног 53 дугаар хувьд явж байв. Яг энэ орчимд “Герольда” хөлгийн капитан цэнгэг усны гүнийг үзэхээр зонд оруулсан нь арван дөрвөн мянган метрийн гүн ёроолд нь хүрээгүй билээ. Мөн энд Америкийн “Конгресс” хэмээх дурсгалт хөлөгний дэслэгч Паркер арван таван мянга нэг зуун дөчин метрийн гүнд ч ёроолы нь тэмтэрч чадаагүй бүлгээ.

Иймд капитан Немо тэдгээр хэмжилтийг шалгахгаар “Наутилус”- тайгаа эцсийнх нь гүнд хүртэл шумбаж орохоор шийдлээ. Үзэсгэлэн танхимын цонхны халхавчууд нээгдмэгц шалган хэмжих багажуудын заалтыг тэмдэглэж, ажиглалт хийхээр гэгээвчний дэргэд би суулаа.

Тэр их гүнзгийд живж орохоор “Наутилус” бэлтгэж эхлэв. Бэлтгэл хөндий багтаамжуудыг л усаар дүүргэчихвэл тэр гүнзгийд хүрчихнэ гэж ярихын ч хэрэггүй болох нь мэдээж хэрэг билээ.

Энэ талаар бүр ярихыг байя гэхэд нэмэгдэл хүндрүүлэг хулдац байлаа ч гээд тэр зорилгонд хүрэхэд нэмэр болохгүй бөгөөд түүнээс гадна усан дээр буцаж гарч ирэхийн тул өнөө дүүргэж авсан усаа далайн ёроолд буцааж шахаж гаргах хэрэгтэйг урьдаас бодох хэрэгтэй билээ. Тэгтэл далайн тэр их гүнзгийд гаднын тэр их даралтыг давж багтаамжууд дахь усыг гэдрэг шахах чадалтай шахуурга ч гэсэн “Наутилус”-т байхгүй бүлгээ. Иймээс капитан Немо диагоналиар дайрч далайн ёроолд хүрэхээр шийдлээ.

Гүнзгийн залуурт 45 градусны хазайлтыг өгч сэлүүр сэнс хамгийнхаа эцсийн хурдаар эргэлдэж ирэхэд түүний далбаанууд усыг асар их хүчтэй зүсэж байв.

Энэ нэг хүчит гараа бүх хөлгийг донсолгож, тэр ч тэрхэн дороо урагшаа

дуулгавартай ухасхийсэн бүлгээ.

Капитан Немо над дээр ирж, бид хоёр хамтдаа даралт хэмжүүрийн зүүний хурдан хөдөлгөөнийг ажиглаж эхлэв. “Наутилус” удсан ч үгүй дийлэнх загас жараахай оршин байх амьдралын бүсийг гэтэллээ.

Хэрэв зарим нэгэн дүрсийн загаснууд тэнгис буюу гол мөрний зөвхөн өнгөн хэсэгт амьдардаг бол мөн гүнзгий хэсэгт нь амьдардаг нэгэн байдаг. Эдгээр сүүлчийн бүлэг загасанд мянган метрийн гүнд зуун хорин атмосферын даралтанд орших грендерууд, асар том дуран нүдтүүд, зургаан завсар заламгай бүхий савар шүдэт аврага загасны дүрсийн гексанхууд зэргийг олж үзэв.

Капитан Немогоос би усны асар их холгүй гүнд загас барихыг үзсэн үү та хэмээн асуувал:

- Загас уу? хэмээн тэр лавлан асууж, тийм их гүнд тун цөөн тохиолддог юм шүү. Гэвч одоо үеийн шинжлэх ухаан юу гэж үзэж байгаа юм? гэв.

- Бид зөвхөн л ийм ийм юм мэднэ. Усны дээд давхаргаас доошлох бүр ургамлын амьдрал, амьтныхаас хурдан үгүй болдог. Амьд амьтан тохиолдож л байгаа тэр газраас нэг ч ургамал олохгүй гэдгийг л бид мэднэ. Устрицууд ба бусад хясаа хоёр мянган метрийн гүнд байдаг гэдэг нь бидэнд мэдэгдэж буй хэрэг бөгөөд умарт тэнгисүүдийн баатарлаг далайчин Мак Клинтон хоёр мянган таван зуун метрийн гүнээс далайн амьд одон өгөөшдөж авсан болон, Английн “Бульдог” хэмээх фрегатын багийнхан дөрвөн мянган метрийн гүнээс далайн мөн амьд од гоходсон удаа бий. Энэ л байна даа, бидний мэддэг бүхэн. Харин капитан Немо та, бодвол манай шинжлэх ухааныг юу ч мэддэггүй гэж хэлэх гэж байна уу?

- Үгүй ээ, эрхэм профессор, тэгж хэтэрхий догшин авирлахыг би бодохгүй. Амьд амьтан ийм их гүнд оршиж чадахыг та юугаар тайлбарлах вэ? Үүнийг танаас асуучихвал болох уу?

- Энэнд хоёр шалтгаан бий хэмээн би өгүүллүүн: Юуны өмнө усны янз бүрийн гүнд, далайн усны тэгш бус давслаг чанар болон нягтралаас шалтгаалж үүссэн босоо урсгал далайн зараа, өд гэх мэт амьтны бүдүүлэг амьдралд хэр таарах нөхцөлийг бүрэлдүүлдэг юм.

- Зүйтэй гэж капитан дүгнэлээ.

- Хоёрдугаарт, усанд ууссан хүчилтөрөгчийн хэмжээ, гүнзгий усанд бага болдоггүй, харин өндөр даралтын үрээр, түүний хуримтлал, тэдгээр гүнзгий усанд, улам их болдог тул уул амьтдын амьдрах нөхцөлийг бүрэн хангадаг юм гэв.

- Мөн зөв, та бас үүнийг ч мэдэх юмаа? хэмээн капитан Немо өөрийн гайхсаныг

нуусан ч үгүй өгүүлээд - яая гэхэв би баярлаж л байна. Энэ ч маргаангүй зүйл юмдаг шүү. Би үүн дээр нэмж хэлэхэд их бус гүнээс барьж авсан загасны хийн саванд азот хүчилтөрөгчөөс их байдаг бол нилээд гүн уснаас барьсан загасны хийн саванд хүчилтөрөгч нь азотоос хэзээд их байдаг юм. Энэ бол таны хэлснийг хэрэг дээр нь нотолж байна. За алив, бидний ажиглалтыг цааш нь үргэлжлүүлэе гэв.

Дахин би даралт хэмжүүр руу харав. Түүний зүү зургаан мянган метрийн гүн зааж байлаа. Бид бүтэн цаг шумбаж яваа боловч ташуу шугамаар гулгаж яваа “Наутилус” мөн л доошилсоор байв. Ус энд гайхам цэвэр тунгалагаараа этгээд ажээ. Түүний тунгалгийг л өндөр уулсын сэрүүн агаартай зэрэгцүүлж болох байв.

Дахиад цаг болсны дараа бид арван гурван мянган метрийн гүнд орж очсон гээд тэнгисийн ёроол гэж мэдэгдэх юм алга байв.

Харин биднийг арван дөрвөн мянган метрийн гүнд ороход алсад би усан доорхи уулсын бараантах оргилуудыг олж үзэв. Тэгсэн ч гэсэн тэдгээр оргил бол манай Гималаи, Монблан мэт өндөр уулсад хамаарах оргил байлаа. Гэвч усны тэрхүү ёроолгүй тамын гүнзгийг бид мөн л урьдын адил тодорхойлж арайхан чадаагүй байсан тул манай тэдгээр уулсаас ч өндөр байж юу магад билээ.

“Наутилус”-ын их биед нөлөөлж агсан асар их даралтыг харгалзахгүйгээр бид доошилсоор л байв. Усан доогуур явагч хөлгийн маань төмөр бэхлүүрүүд яаж гяхтнаж, түүний тэлүүр төмөр баганууд яаж нахийж, түүний хашлага хаалтууд яаж чичирхийлж, үзэсгэлэнт танхимын цонх дотогшоо яаж шамбийж байсны нь биеэрээ мэдэрч байсан бөгөөд хэрвээ л манай хөлөг цутгамал цул биений бөхбат чанарыг хадгалаагүйсэн бол түүнийг усны тэр их зузаан давхарга хэдийн ганцхан секундийн дотор гамбир болтол нь хавтайлган нухахсан бүлгээ.

Бид усан дотор харлан харагдаж буй уулсын энгэр орчноор ойрхон явж өнгөрөх үед би далайн хэд хэдэн хясаа ба одод байхыг олж харлаа. Гэвч удсан ч үгүй амьтны аймгийн эцсийн төлөөлөгчид ч байхгүй болж “Наутилус” амьсгалж болохгүй давхаргаас дээш гарсан агаарын бөмбөрцөг шиг амьдрал түгсэн хязгаарын хилийг доош гэтэллээ.

Одоо бид арван зургаан мянган метрийн гүнд оржээ. Тиймээс “Наутилус” мянга зургаан зуун атмосферийн даралтыг биедээ хүлээж буй, өөрөөр хэлбэл, өөрийн биений нэгэн шоо дөрвөлжин сантиметр хэсэг тус бүр дээр мянга зургаан зуун килограмм хүнд жингээр дарагдаж байлаа.

- Юутай хачин хэрэг вэ. Хэзээ ч ямар ч амьдрал байгаагүй тийм гүн уснаа явна гэдэг юу гэсэн үг вэ! хэмээн би дуу алдаж - хар л даа та, капитан, хар, эдгээр агуу

сүрлэг хадыг эдгээр хоосон цөл уулсыг, эдгээр амьдралын өчүүхэн ч амьсгал үгүй, тэнгисийн эцсийн хязгаарыг! Эдгээрийн тухай бидэнд зөвхөн л нэг муу бүрэг бараг дурьтгал үлдэнэ гэдэг хичнээн харамсалтай вэ гэвэл:

- Тэр бүрэг бараг дурьдатгалыг тань бүрэг бараг ч бус болгож болно шүү гэж капитан өгүүлэв.

- Та юу гэх гэж байна? Би таны үгийг ойлгохгүй байна гэж би хэллээ.

- Эндхийн газар орны байдлын зургийг авчихаас хялбархан юм байхгүй гэж байна аа би гэв.

Капитан Немогийн тэр нэгэн шинэ саналын талаар би өөрийн гайхаж бахадсаныг хэлж амжаагүй байтал нэгэн усан цэрэг зургийн аппарат авч орж ирлээ.

Бидний нүдний өмнө налайж буй байгаль, цахилгаан прожекторын гэрэлд гайхам хурц тод өнгөөр ялгарч байв. Тув тунгалаг болж ирээд өчүүхэн ч хөдөлгөөнгүй шингэн орчин зураг авахад ёстой аятай, нарны гэрэлтүүлгээс ч хол илүү тааламжтай нөхцөлийг бүрэлдүүж байв.

Бид аппаратынхаа амыг усан доорхи уулсын зүг чиглүүлэн хэд дарсан нь тун сайхан зураг гаргаж билээ.

Бидний авсан зураг дээр өдрийн гэрлийг хэзээ ч олж үзээгүй эрт балар цагийн хадан хясаа, газрын хатуу бүрхүүлд шигдэж дагтаршсан бор боржин хадан хананд онгойж ёнхойсон гүнзгий гүнзгий нүх, агуй болон хамгийн эцэст ёстой л фламанд газрын зураачийн гараар зурагдсан мэт уулсын шовх гайхамшиг үзэмжит оргилууд тодхон ялгарч гарчээ.

Гэвч пид хар, өнгөлөгдсөн мэт тов толигор, өнгө ялгарах ганц ч толбогүй, хоорондоо ав адилхан, элсэн хөрсөн дээр бат суурьшин цахилгаан прожекторын гэрэлд гялалзаж буй тэдгээр хаданд амьдралын ямар нэгэн амьсгал өчүүхэнч байхгүй гэдэг айхтар сэтгэгдэл төрүүлж буй тэр нэгэн чанарыг тэдгээр зураг үл дамжуулж билээ. Зураг авч дуусмагц капитан Немо над руу хандаж:

- Дээшээ гарахаас даа, ноён профессор оо. “Наутилус”ыг ийм их даралтанд дэндүү удаах хэрэггүй гэлээ.

- Би зөвшөөрөх байнам, капитан.

- Бөх суугаарай гэж хэлэхэд нь би, капитан чухам юу гэж хэлснийг нь чухам юу гэж ойлгохоо, яагаад би бөх суух болсноо асууж амжаагүй байтал гэнэтхэн намайг шалан дээр аваад хаячихлаа.

Тэхнээ нь капитан Немогийн тушаалаар “Наутилус”ын сэнс зогсож, гүнзгийрэлтийн залуур босгогдсон тул яг л тэр секундэд онгоц маань агаарын



бөмбөрцөг шиг чанх дээшээ харваж, үнэнийг хэлэхэд толгой эргэм хурдтайгаар өөдөө дэгдэн, далайн усыг хангинан жингэнэн зүсч хөөрлээ.

Эргэн тойронд юу ч харахын аргагүй бөгөөд арван зургаан мянган метрийн гүн уснаас дөрөвхөн минутын дотор суга үсрэн хөөрч, цойлж буй загас мэт год харайн гараад уул манан шиг усан багана босгон буцаж буужээ.

[Тор](#)

---

## АВРАГА ХАЛИМ БА ШҮДЭТ ХАЛИМ

Гуравдугаар сарын 13-ны шөнө 14-ний өглөө “Наутилус” мөн л дахиад өмнө зүгийг чиглэв. Би бодохдоо Горнын хушуу орших өргөргөөс бид, өрнөд зүг номхон тэнгисийг чиглэн эргэж, дэлхий тойрох аянгаа дуусгана гэж санасан минь эндүүрэл болжээ. Тэхнээ нь “Наутилус” маань өмнө тийшээ явсаар л байлаа.

Тэр хаашаа одно вэ? Өмнөт туйл руу юу? Галзуурсан юм. Капитан Немогийн солио зан Нед Лендийн битүү сэжиглэлийг үнэхээр баталжээ гэсэн дүгнэлтэнд би хүрэв.

Канадын харъяат сүүлийн үед өөрийн оргох төлөвлөгөөг илчилж надтай ярихыг больжээ. Тэр бусадтайгаа ойртох нь багасаж, дорхиноо бие бөөцийлөх болов. Бид тийнхүү удаан хугацаагаар энд баригдаж байгаа явдал түүнийг зовоож буйг би ойлгож байлаа. Түүний цээжинд үзэн ядах үзэл оволзон байгааг ч би мэдэрч л байв. Тэр капитан Немотой учрахдаа ч нүдэндээ хилэгнэсэн гал бадруулах тул түүний төрөлхийн нь догшин авир, өөрий нь ямар нэгэн бодлогогүй хэрэг түлхчих бий дээ гэж би үргэлж айдаг бүлгээ.

Гуравдугаар сарын 14-ний өдөр Консель, Нед Ленд хоёр над дээр миний өрөөнд орж ирлээ. Би тэднээс чухам ямар хэргээр ирсэн тухай асуувал:

- Цор ганцхан л асуулт байна, профессор минь гэж Канад хүн надад хэлэв.

- Би таны үгийг сонсьё, Нед. Тани бодлоор бол “Наутилус” дээр хэд хичнээн хүн бий вэ?

- Бүү мэд дээ, хонгор минь.

- Миний бодвол хэмээн Нед Ленд цааш нь өгүүлээд - онгоцыг жолоодоход тийм ч олон хүн хэрэггүй дэг гэв.

-Тэр үнэн гээд би хариуд нь - үүний машин тун нарийн хийгдсэн юм болохоор

арваад хүнтэй баг бүх хөлгийг үйлчлэхэд дүүрэн хангалттай юм шүү гэв.

- Тийм л бол капитан Немо, олон хүнтэй том баг онгоцондоо авав гэж үү дээ гэж Нед Ленд өгүүлэв.

- Арай ч үгүй байх аа гэж би ундууцвал: Яагаад? гэлээ.

Би Нед Лендээс нүд үл салган сайн ажихад түүний яах гэж байгааг мэдэхэд хялбархан байв.

- Яагаад гэвэл хэмээн би түүнд, хэрвээ л капитан Немогийн тухай төсөөлж байсан минь зөв л бол, “Наутилус” зөвхөн л нэг ердийн хөлөг онгоц ч биш, мөн тэрнийхээ зэрэгцээгээр, яг өөр шиг нь хуурай газартай түнш тасарсан, тийм оргож зайлсан хүмүүсийн орогнох орон байхаас зайлахгүй.

- Тийм ч байж болох юм гээд одоо болтол үг дуугүй суусан Консель хариу өгүүлээд - Эзнийх зөв ч байж магадгүй. Гэлээ ч гэсэн “Наутилус” онгоц тоотой хэдэн хүн л багтах ёстой сав шүү дээ. Үүн дээр хамгийн дээд хэмжээгээр чухам хэд хичнээн хүнтэй баг байж болохыг бидэнд эзэн хэлчихгүй юу? гэлээ. Би яаж мэддэг юм?

- Бодож гаргах жирийн нэг аргаар, та бод онгоцны эзлэхүүнийг мэднэ, тэхээрээ түүнд байгаа агаарын багтаамжийг мэднэ. Нөгөө талаар хэлэхэд, нэг хүний амьсгалд шаардагдах агаарын хэмжээг мэдчихвэл “Наутилус”-ын агаар хорин дөрвөн цагт хэдэн хүнд хүрэлцэх...

Би түүний чухам юу хэлэх гэж буйг тэртэй тэргүй ойлгосон тул Конселийн дуусваргүй урт яриаг тасдан авч:

- Мэдлээ, мэдлээ. Тэгж бодож гаргах ч тун амархан. Гэвч нэн тодорхой бус дүн үзүүлэх шүү дээ гэв.

- За яахав тодорхой бус л байг гэж Нед Ленд шаардлаа.

- Нэг л хүн цаг тутам амьсгалдаа зуун метр агаарт холилдсон хүчилтөрөгч шаарддаг тул бүтэн нэг хоногт буюу хорин дөрвөн цагт хоёр мянга дөрвөн зуун метр агаар шаардана. Тийм учраас “Наутилус”-ын агаар хэдэн хүний амьсгаалахад хүрэх вэ гэдгийг олохын тул “Наутилус”-ын багтаамжийг хоёр мянга дөрвөн зуун литртээ л хуваачихгүй юу...

- Тун зөв гэж Консель хэлэв.

- Тэгвэл “Наутилус”-ын багтаамж бол мянга таван зуун тонн, тонн тус бүрд мянган литр агаар ноогдох тул уул хөлгийн нийт багтаамжинд сая хагас литр агаар орох нь ээ. Тэр багтаамжийг өнөө хоёр мянга дөрвөн зуун литртээ хуваачихвал - би цаасан дээр түргэн зуур сараачиж хаяад - яг зургаан зуун хорин тав гэсэн бүхэл тоо гарч

байна. Өөрөөр хэлбэл “Наутилус”-т багтах агаар бүтэн хорин дөрвөн цагт зургаан зуун хорин таван хүний амьсгалахад яг таарах ажээ.

- Зургаан зуун хорин таван хүн гэнээ! хэмээн Нед Ленд дуун алдав.

- Тэгвэл энд байгаа би, чи, та, эндхийн дарга, цэрэг бүгд нийлээд энэ нэгэн тооны аравны нэгэн хувьд нь ч хүрэхгүйг танд дүүрэн баталж чадах байнам гэвэл:

- Тэдний эсрэг гэвэл гурван хүн ч ярьдаггүй ээ хэмээн Консель бувтнав.

- Тийм болохоор, миний муу хөөрхий найз Нед чамдаа би тэсч л үз гэж зөвлөх байнам гэв.

- Зөвхөн тэсээд л зогсохгүй, эвлэрэхээс өөр аргагүй болжээ гэж Консель нэмэрлэн хэлэв. Консель аргагүй л зөв үг олж хэлжээ.

- Бүр дорд дордсоор, капитан Немо дандаа л өмнө зүг давхиад байх гэж хаанаас даа. Тэр хаа нэгэн газар, жишээлбэл, ядаж тэр мөсөн цэвдэгт тулж очоод нэг зогсоно шүү дээ! Боловсон орнуудын эргийг угаадаг далайнуудад эргэн очих цаг гарцаагүй нэг хүрч ирнэ. Тэхэд л оргох талаар бодох цаг дахин гарах бишүү! гэж Консель үргэлжлүүлэн ярилаа. Канад хүн толгойгоо нэг сэгсэрч, духаа нэг илчихээд, нэг ч үг хэлсэнгүй гараад явчихав.

Эзэн хэрэв зөвшөөрвөл би нэг юм хэлэхийг хүснэм хэмээн Консель өгүүлээд хөөрхий муу Нед дандаа л болохгүй юм бодож байх юм. Тэр аль дээр өнгөрсөн жаргал цэнгэлтэй үеэ санаж, бидэнд одоо болшгүй гүйцэтгэшгүй бэрх юм тэрэнд бол аятайхан, хялбархан юм шиг санагдах юм. Тэр элдэв юм дурсан санагалзахын хүндэд дарагдаж өдөржингөө уйтгарлах юм. Түүний зовлонг ойлгох хэрэгтэй. Тэр чухам юу хийх вэ? юу ч алга! Тэр тан шиг эрдэмтэн бус, тиймээс усан доорхи ертөнцийн агуу гайхамшиг танд сайхан ч, тэрэнд төдий сайхан биш. Тиймээс Нед Ленд өөрийнхөө эх оронд одож оройн цагаар ямар нэгэн наргианы газар шагайхын тул юугаа ч гарздахад бэлхэн хүн юм!

Тэгж ярьсан Конселийн нь зөв байв. Эрх дураараа, бүтээлч амьдралд дассан Канад хүн “Наутилус” дээрх нэг янзын суурин амьдрал тэсвэрлэшгүй байсан нь мэдээж хэрэг. Түүний дур сэтгэлийг татсан шинэ сонин явдал тун ховор тохиолдох ажээ.

Харин тэгтэл яг энэа өдөр түүний эрх чөлөөт тэнэгэр үеийнх нь байдлыг санагдуулбал зохих нэгэн сонин явдал боллоо.

Далай дээр ил хөвж явсан “Наутилус” өглөөний арван нэгэн цагийн үед сүрэг халимтай дайралдлаа. Хүмүүс хойноос нь салахгүй, улайран хөөцөлддөг эдгээр сүүгээр бойжигчид, халимын ангуучид ховор үзэгддэг холын өргөргүүдийн орчинд

амь зулбан орогнож орших тул энэ тулгаралт надад төдийлөн гайхагдсангүй ээ.

Халим загас тэнгис далайн ямар нэгэн албанд ихээхэн чухал үүргийг гүйцэтгэж, газар зүйн том том нээлтэнд тэдний нөлөөлсөн нөлөө тун их бүлгээ. Халимууд бүх цаг үеийн бүх л ястан, үндэстний ангуучдыг, эхлээд боскуудыг, дараа нь ассирчуудыг, сүүлд нь англичууд, голландчуудыг тус тус дагуулан алс одож билээ. Тэдгээр англичууд тэнгисийн аяллын аюултай тэмцэн тэмцсээр юунаас ч айхгүй болж, тэнгис далайг захаас нь захыг нь хүртэл хэрэн хэсүүчлэх болжээ.

Халимууд умартын ба өмнөтийн тэнгисүүдэд амьдрах дуртай амьтан билээ. Хуучны нэгэн домогт, англичууд халим загасаар алс умарт зүг одож, нэг мэдвэл умарт туйлд долоохон бээр ойрхон очсон байжээ гэж дурьддаг бүлгээ. Хэрэв л энэ хүмүүс санаанаасаа бодож гаргасан домог юм хэзээ нэгэн цагт үнэн хэрэг дээрээ биелэгдэж, хүмүүс бодвол хуурай газрын тэр нэгэн үл мэдэгдэх хэсэгт халимтай хөөцөлдсөөр хүрчих буйзаа.

Эна хэр бид тавцан дээр байцгаав. Тэнгис тун амгалан ажээ. Ер нь орчинд аравдугаар сард цаг агаар дандаа сайхан байдаг билээ.

Канад хүн далай дээр халим явахыг хамгийн түрүүн харсан билээ.

Түүний заасан зүгт би сайтар ажиглан харсаар “Наутилус”-аас таван миль хэрийн газар л гарч, далд орон яваа нэгэн хар юм олж үзэв.

- Ай даа хэмээн Нед Ленд бархирч - хэрэв л би одоо халим агнах хөлгөн дээр байсан бол энэ учрал намайг юутай их баярлуулахсан бол! Энэ ямар том амьтан бэ. Хар л даа, хичнээн их өндөрт ус, уур тургин явна гээч Би энэ муу тэвшинд баригдаж явах гэдэг юутай харамсалтай вэ! гэлээ.

- Та өөрийгөө жадчин гэж бас л үзсээр байх шиг байна даа гэж би хэлбэл:

- Халимын ангуучин хүн хэзээ нэгэн цагт мэрэгжлээ мартаж болох гэж уу? Тэр сайхан ангийн амтанд хэзээ нэгэн цагт ханах гэж байх гэжүү?

- Энэ орчны далайнуудад та хэзээ ч ангуучилж яваагүй юу, Нед ээ?

- Хэзээ ч үгүй, профессор гуай - Би дандаа л умарт далайнуудад Берингийн, Дэвисиин хоолойнууд хүтэл агнаж байсан.

Тэхээрээ та, өмнөтийн халимны ааш занг мэдэхгүй хүн юм аа? Тийм дээ, ер нь туйл орчны халимууд экваторын бүлээн усыг гэтэлж умартын усанд орохыг хэзээ ч зүрхэлдэггүй юм. Тэхээр та яаж ч мэдэх вэ дээ.

- Юу ярьж байна, та ноён профессор! Ямар юмаа та санаанаасаа гаргаж ирэв ээ! хэмээн Канад хүн итгэх янзгүй мэтгэлцэж байв.

- Би санаанаасаа гаргасан юм байхгүй, яг л үнэнээр нь ярьж байна...

- Арай ч үгүй дэг ээ! Би өөрийн гараар, жаран таван онд, одоогоос хоёр жил хагасын өмнө Гренландын эргийн дэргэд нэгэн халим унагасны минь гүзээнд Берингийн хоолойн халим агнах хөлгийн тэмдэгтэй жад ёрдойж байсан юм. Тэгвэл америкийн баруунтай шархадсан амьтан, хэрэв л тэр урьдуур туулж Горнын буюу эсхүл Сайн итгэлтийн хушууг тойрч экваторыг хөндлэн дайраагүй юм бол яахаараа америкийн зүүнтээ ирж алагддаг билээ.

- Миний найз Недийн нотолгоог би дүүрэн зөвшөөрөх боловч эзний хариултыг тэсч ядан хүлээж байнам гэж Консель өгүүлэв.

- Тэгвэл, хонгорууд минь, янз бүрийн тэнгист, янз бүрийн халим оршиж, тэр тэнгисээ хэзээ ч үл орхидог юм. Хэрэв тэдгээрийн нэг нь Берингийн хоолойгоос Дэвисийн хоолойд явж орчихсон бол тэдгээр далайн хооронд, эсхүл америкийн, эсхүл азийн эрэгт ямар нэгэн нүх сүв байна л гэж эзэн та нарт хэлнэ дээ.

- Тэгээд ч би үүнд тань үнэмших хэрэгтэй болж байна уу? хэмээн канад хүн нүдээ жартайлган өгүүлэхэд Консель: Энэнд үнэмших л хэрэгтэй гэлээ.

- Тэхээрээ та намайг энэ орчинд хэзээ ч гөрөөлөөгүй болохсор эндхийн халимыг мэдэхгүй гэж байгаа юм шив дээ гэж жад шидэгч хэлэв.

- Яг тийм.

- Яая гэхэв Нед, тэдэнтэй танилцахад танд, төдий л сайн шалтаг болно биз хэмээн Консель хажуугаас нэмэрлэлээ.

- Хараа ч хүүе! Хараач! гэж канадын харъяат хэлээд өнөөх чинь ойртож явна. Бидэн рүү бүр шууд ороод ирлээ. Намайг яаж ч чадахгүй гэж надаар доог хийж байгаагий нь! гэж хашгирав.

Тэр пид хийтэл дэвсэв.

Халимын ангууч нударгаа жад атгаж буй мэт зангидсан байлаа.

- Эндхийн халимууд хэмжээгээрээ яг л умартын халим шиг биз? гэж тэр асуув. Бараг л адилхан.

- Профессор минь, үүнийг би зуун фут хүртэл урт биетэй халим үзсэндээ асууж байгаа юм шүү. Халимын анчин, Алеутийн арлын дэргэд зуун тавин фут хүртэл том халим байдаг гэж надад ярьсан юм.

Бодвол тэд дэндүүлсэн байлгүй дээ. Нед минь хэмээн би татгалзаж тийм халим байгаль дээр байх ч үгүй, тэгвэл шүдэт халим, энгийн халимаас бага шүү дээ гэв.

- Ай зайлуул хэмээн тэнгисээс нүд үл салган байсан канад эр дахин дуу алдаж-өнөөх чинь бүр л ойртоод байна тэр удахгүй “Наутилус”-ын хажуугаар гараад явчина

аа! гэлээ. Тэр яриагаа үргэлжлүүлэх зуураа над руу хандаж:

- Шүдэт халимыг та бүр нэг муусайн жараахай шиг гэх нь ээ. Тэгвэл асар том шүдэт халим байдаг юм шүү. Тэд тун ухаантай амьтад болохыг та мэдэх үү? Тэдний зарим нь замган доогуур шургаж ороод замагтайгаа гарч ирдэг гэж надад ярьсан юмдаг. Тэр үед нь тэднийг арал гэж санах ч удаа байдаг. Тэгээд түүнд хөлөг онгоц ойртож очоод, хүмүүс нь бууцаагаад, галаа түүлцгээдэг гэнэлээ...

- Байшинн барилга болгодлог гэнэлээ гэж түүний яриаг Консель цааш нь бүр явуулан хэтрүүлбэл, Нед Ленд :

- Тиймээ, тийм хэмээн зөвшөөрч, дараа нь шүдэт халим маань, нэг сайхан өдөр шумбан одоодоо дээрээ байсан бүхнийг далайн ёроол руу авч ордог гэнэлээ гэв.

- Яг л Синдбад далайчийн адал явдал шиг болж байна даа гэж би инээмсэглэв. Эрхэм Нед Ленд таныг би ийм сүнс сүүдэр ор мөргүй худлаа юм зохиож ярихдаа эрлэг нь юм гэж ер мэдээгүй юм шүү? Бодвол та өөрөө тийм шүдэт халим байдагт арай итгэдэггүй биз гэж би бодож байна.

- Халимуудаас ер нь ямар ааш эс гардаг билээ, эрхэм эрдэмтэн профессор! хэмээн канад хүн үнэн голоосоо өгүүлрүүн-За тэр, хар л даа, тэр хичнээн хурдан туулгаж байна! Яаж шумбаж байна! Энэ амьтдыг чинь арван тав хоногт дэлхий тойрч чаддаг гэж ярьдаггүй билүү!

- Маргах юм алга.

- Дэлхий тогтох хамгийн анхны үед халимууд одоогийнхоосоо ч хурдан явдаг байсан гэж мөрийцсөнч болно эрхэм профессор.

- Нээрээ юу. Нед? Би үүнийг чинь ёстой мэдээгүй юм. Яахаараа тэр вэ?

- Яагаад гэвэл эхлээд тэдний чинь сүүл бусад загасных шиг босоо байсан тул усыг баруунаас зүүн, зүүнээс баруун тийш нь цохидог байсан юм. Гэтэл дараа нь халимууд дэндүү хурдан яваад байх шиг байхаар нь бурхан багш тэдний сүүлийг мушгиулчихсан тул сүүл нь хэвтээ хавтгай болж усыг дээрээс доош, доороос дээш цохих болсон нь хурдыг нь их хассан.

- Үүнд тань үнэмших хэрэгтэй болж байна уу? хэмээн би Нед Лендийг дуурайн асуувал:

- Албагүй хэмээн канад хүн өгүүлж, хэрэв би танд гурван зуун фут урт, таван зуун мянган килограмм хүнд халим байхыг үзсэн гэж хэлбэл та түүнээс илүүгүй итгэх хэрэггүй гэлээ.

- Тэгж ярьсан бол ч та арай дэндүүлэх байлгүй гэж би хэлэв. Гэсэн ч зарим нэгэн халим хэлбэртэн аврага том байдаг удаа бий юм шүү. Тэдгээрийн заримаас нь зуун

хориос зуун гучин тонн өөх шарлуулдаг гэж ярьдаг.

- Түүнийг ч би хоёр нүдээрээ үзсэн юмаа.

- Танд дуртай итгэх байнам. Зарим нэгэн халим хэмжээгээрээ зуун заантай тэнцдэгт итгэдэг шигээ танд би итгэх байнам. Бодоод үз л дээ. Та тийм нүсэр том амьтан асар их хурдтай давхихад ер нь ямар шуу сүртэй юм болохов!

- Халим, хөлгийг боловч хөмөр ч хаях чадалтай гэдэг үнэн үү гэж Консель асуув.

- Тэрэнд ч итгэхгүй байна хэмээн би хариулаад-харин 1820 онд энэ л өмнөт өргөрөг орчинд юм гэнэ билээ, нэгэн халим “Эссенк” гэдэг хөлөг рүү дайрч довтлоод, секундэд дөрвөн метрийн хурдтай гэдрэг нь түрж хөөхөд, онгоцны бөгсөн дээгүүр ус хальж хөлгийг дүүргэсэн тул тэр даруйхан далайн ёроолд живж орсон гэж ярьдаг юм гэв. Нед Ленд миний зүг тохуурхах байдалтай сүрхий харав.

- Надтай нэгэн удаа ийм юм болсон юм. Миний гөрөөлж агсан халим намайг сүүлээрээ гуядчихсан юм. Намайг ч гэж дээр нь сууж явсан завийг шүү дээ. Тэхэд би, нөхдийнхөө хамт зургаа орчим метр хол тээр тийшээ хийстлээ дэлсүүлчихгүй юу. Гэвч саяхан ноён профессорын ярьсан тэр халимын дэргэд ч надтай учирсан тэр халим ч бяцхан амьтан, хөхүүл хүүхэд байж л дээ! гэлээ.

- Халим ер нь урт настай амьтан уу? гэж Консель асуувал, канад хүн:

Мянга мянган жилийн настай даа хэмээн хэнэг ч үгүй тууж орхив.

- Та үүнийг хаанаас мэдсэн юм, Нед?

- Тэгж л ярьдаг юм

- Яагаад тэгж ярьдаг юм?

- Бүгдийн мэдээжийн хэрэг юм чинь дээ.

- Үгүй ээ. Нед Ленд минь, энэ бол хэний ч мэдээжийн хэрэг биш. Тэр бол зөвхөн таамаглал. Тэгвэл тэр таамаглал чухам юун дээр үндэслэж байна гээч. Халимыг анх авлах болсон тэр цагт буюу одоогос дөрвөн зуун жилийн өмнө .халим одооныхоосоо нилээд том амьтан байсан юм. Одоо үед халимууд тийм том биш байдаг нь тэд өсч торниж хүрвэл зохих хэр хэмжээндээ хүрээгүйгээс шалтгаалж буй нь хэний ч мэдээж хэрэг.

Гэвч Нед Ленд миний үгийг сонсохгүй байв. Халим улам ойртох тутам түүнийг тэр нүд чавчихгүй ширтэн авай.

- Ай, энэ чинь ганц халим бус болуу? хэмээн тэр гэнэт бархирч-Тэд энд арав хорь бүр сүргээрээ яваа биш үү! Тэхэд бид яаж ч чадахгүй, гар хөлөө баглуулчихсан адил дэмий хараад л өнгөрөөчих гэж үү! Ай' халаг халаг гэв.

- Байзнаж үз миний найз Нед, капитан Немогоос та тэдгээрийг агнах зөвшөөрөл

авч яагаад үл болох билээ? хэмээн Консель асуув.

Гэтэл Консель хэлэх гэсэн үгээ хэлж дуусаагүй байхад Нед Ленд капитаныг эрээд доошоо шатаар бууж хурдлан алга боллоо.

Хэдэн минутын дараа тэр хоёр тавцан дээр хамт гарч ирлээ.

“Наутилус”-аас дөнгөж нэг миль газар усан дээр наадаж бужигнаж буй халимын сүргийг ажиглаж эхлэв.

- Энэ бол өмнөтийн халим гэж тэр хэлээд энэ нэг сүрэг бүгдээрээ, халим агнуурын бүхэл бүтэн флотыг хөлжүүлж болох ажээ гэлээ.

- Тэгээд капитан та надад эдгээрийг агнах зөвшөөрөл өхсөн бол уу? Би жад шидэх өөрийн мэрэгжлийг ядаж мартахгүйсэн гэлээ.

- Амьтныг дэмий хөнөөхийн хэрэг юу байна? хэмээн капитан татгалзаж-бидэнд өөх тосны хэрэг ердөө ч алга гэв.

- Тэгвэл Улаан далайд дюгонь агнах зөвшөөрөл надад капитан та өгсөн шүү дээ хэмээн Канад хүн шалгааж байв.

- Дюгонийн мах бидэнд хүнсний нөөц болсон. Тэгвэл та одоо дэмий л амьтны амь бусниулах зөвшөөрөл гуйж байна. Таны энэ хүслийг би ер нь амьтны амь бусниулах хүний төрөлх зан гэдгийг тун сайн мэдэж буй боловч, иймэрхүү балмад хэрцгий байдлаар цаг нөгцөөх явдлыг хүсэхгүй. Ямар ч гэм хоргүй сайхан амьтад болох өмнөтийн халимыг хүйс тэмтэрснээр эрхэм Ленд та болоод тантай нэгийг сэтгэгчид бузар хорт хэрэг л үйлдэж байгаа юм. Иймэрхүүгээр тэд йаффинын буланд байсан амьд бүхнийг устгаж дуусгаад одоо эдгээр амьтдыг эцсийнхий нь хүртэл яргалахыг хүсч буй юм. Эдгээр хөөрхийсиг' орхи доо тэртэй тэргүй тэдгээрт шүдэт халим, сэлмэн хоншоорт мэтийн дайсан мунддаггүй юм.

Гэнэтийн энэхүү сэнхрүүлэх сургаал ярианы үед канад хүний царай ямар байсныг төсөөлөн бодож болно доо Халимын мэрэгжилд дадлагажсан ангуучинд ийм сургаал өгнө гэдэгт үгээ хий зарцуулна гэсэн үг биз.

Нед Ленд капитан Немо руу харах боловч тэр чухам юуны тухай яриад байгааг ердөө ч үл ойлгох мэт ажээ.

Үнэндээ капитаны зөв байв. Халимын ангуучдын ухаан бодлогогүй яргалал далай тэнгисүүдэд нэг ч халим үлдэхгүйд хүргэж болох юм.

Нед Ленд “Янки дудль” хэмээх дууны аялгуу шүдэн завсраараа исгэчин буруу харчихлаа.

Тэр хооронд капитан Немо халимын сүргийг ширтсэн янзаараа байтлаа над руу эргэж:



- Би саяхан ярьсан яриандаа, халиманд хүний ээрэгцээ байгалийн дайсан олон гэж хэлсэн минь худлаа бишээ. Жишээ нь энэ нэгэн сүрэг одоо хүчирхэг дайсантай тулгарах нь байна. Эрхэм профессор та харж байна уу, тэнд салхин доор, найман миль хэр газар хөдөлж буй хар хар юмыг гэж хэллээ.

- Харж байна, капитан хэмээн би хариулав.

- Тэд бол шүдэт халимууд, аймшигт амьтад даа Би энэ амьтны хоёр гурван зуугаараа яваа бүхэл бүтэн сүргүүдтэй дайралдаж л байсан юм! Ёстой л энэ хорт хэрцгий амьтдыг устгаж байвал таарна. Энэ үгийг сонссон канад гялсхийн эргэлээ!

- За яахав, капитан хөөрхий халимуудын тусын тулд эрхэм Нед Ленд... гэж би ярих гэтэл:

- Өөрийн биеийг хөнөөхийн хэрэггүй хэмээн капитан Немо миний яриаг тасдан – “Наутилус” онгоц өөрөө шүдэт халимын сүргийг бутрааж чадна. Миний онгоц бол ган мөргүүлүүдээр зэвсэглэсэн юм. Бодвол эрхэм Лендийн жаднаас төдий л доргүй биз гэлээ.

Канад хүн хэнэг ч үгүй мөрөө хавчлаа. Түүний байрыг ажвал: хөлөг онгоц халимын сүргийг мөргөж хөөнө гэдэг хэзээ хаана дуулдлаа? гэсэн янзтай байв.

- Эрхэм профессор та түр хүлээзнээрэй гэж капитан хэлээд-би танд таны бие хэзээ ч олж үзээгүй сонирхолтой ан хийж үзүүлнэ. Эдгээр араатанг чигчийн чинээ ч өрөвдөж болохгүй. Эдэнд зөвхөн л залгих ам, зажлах шүднээс өөр юм алга! гэлээ.

Заримдаа хорин таван метр хүрдэг зантгар толгойлсон шүдэт халимыг «Залгих ам, зажлах шүд!» гэж тодорхойлохоос өөр илүү юм бодож олоход хэцүү байв. Халим маягийн энэхүү амьтны асар том толгой нь бүх биеийнхээ гуравны нэгэн хувийг эзэлнэ. “Халимын сахал” хэмээн нэрлэгдсэн эвэрлэг далбангуудаар дүүрэн, ердийн халимын амнаас шүдэт халимын ам гучин есе буюу тавин хоёр тонн тус бүр хоёр фут жинтэй шүдээр зэвсэглэгдсэн байна. Шүдэт халимын дагзанд өөр хоорондоо харьцах хоёр мөрний хөндий байдаг бөгөөд түүн дотор спермацет гэж нэрлэгддэг тосорхог шингэн бодис гурваас, дөрвөн зуун килограмм хадгалагддаг нь маш их үнэтэй ажээ.

Шүдэт халим бол дэлхий дээр хамгийн болхи бөгөөд этгээд муухай амьтан болжуу. Түүний толгой тэнцвэргүйгээрээ нэн гайхагдана. Тэрнээс гадна хамрын нь тэнцүү хоёр хэсэг байвал зохихын нэг нь үгүй тул тал хамартай, түүнчлэн зүүн нүд нь баруунаасаа тун бага юм. Тиймээс ч урьд цагт анчид түүний зүүн талаас довтолдог заншилтай байв.

Энэ хэр араатны сүрэг ойртсоор байлаа. Тэр халимуудыг үзчихэв бололтой,

довтолгоонд бэлтгэж эхлэв.

Тэрхүү тэнцвэргүй тулалдаанд зөвхөн шүдэт халимууд, аврага халимаас чадалтай, илүү сүрхий араа шүдтэйгээрээ дийлнэ хэмээн урьдаас таамаглаж болох байснаар барахгүй шүдэт халимууд энгийн аврага халимаас илүү урт удаан хугацаанд усан доор байж чаддагт нь магад ялах давуу чанар нь байлаа.

Аврага халимуудад туслахгүй бол болохгүй боллоо. “Наутилус” уснаа шумбаж, Консель Нед Ленд бид гурав үзэсгэлэн тэнхимийн гэгээвчний дэргэд байраа эзлэв.

Капитан Немо онгоцоо өөрийн гараар жолоодож бүрэлгэн сүйтгэх шинэ зэвсгийнхээ ид шидийг гаргахаар жолоодлогынхоо бүхээгт орлоо.

Сэлүүр сэнс эрчлэн эргэж “Наутилус” онгоц урагшаа довтлон одов.

“Наутилус”-ыг хүрэлцэн очих үед шүдэт халим ба аврага загас хоёрын хоорондын тулалдаан эхэлсэн байв.

Капитан Немо шүдэт халимын сүргийг хоёр хэсэг тасдахаар шийдэж онгоцоо зална. Үзэгдэж харагдайгүй шинэ дайсан бий болсон явдал шүдэт халимуудыг эхлээд айлгасангүй боловч сүүлдээ тэд эндүүрснээ ойлгожээ.

Бидний нүдний өмнө ямар сүрт тулалдаан болсон гэж санана! Түүгээр ч барахгүй Нед Ленд хөхөн баярлаж эхлээд бүр сүүлдээ пажганатал алга ташиж билээ.

“Наутилус” өөрийн капитаны гарт дуулгаварт зэвсэг аврага том жад болон хувирсан юм. Тэр шүдэт халимын өөхөлсөн тарган бие рүү шумбан орж хоёр хэсэг болгон хувааж цус олгойдон үлдэж буй зэрэмдэглэгдсэн хоёр тал сэг болон үлдээж байв.

Тэр шүдэт халимын хүчирхэг сүүлний ширвэлтийг үл мэдэрч, догширсон аврага амьтны мөргөх дайрах довтолгооныг юманд эс санах ажээ. Тэр нэг араатантай тооцож гүйцмэгц нөгөө рүү дайран орж цаг хугацаа алдахгүйн тул тэнхлэгээ тойрон эргэлдэж, нүдэлсэн дайснаа гаргаахгүйн тул урагш чавхдан, гэдрэг довтлон хэрэв нөгөөх нь усны гүн рүү явчихвал дорогш шумбан, буцаж гарч ирвэл нь эргэж элдэн, хажуугаас нь, урьдаас нь, араас нь дайран тас татах буюу аль л дайрсан талаасаа ямар ч хурдтай явсан тасчиж хүүчиж байв.

Юутай бахтай хядлага гээч! Далайн дээр ямар их дуу шуугиан дэгдсэн бол! Айж сандарсан шүдэт халимуудын аахилах амьсгалахад хичнээн сүртэй шуухиан дэгдсэн бол! Араатнуудын хүчирхэг сүүлээр долгилж цалгилсан ус далайн үргэлж хөдөлгөөнгүй амгалан орших доод давхаргуудад хүртэл нөлөөлж байв...

Энэ хядлага бүтэн цаг илүү үргэлжилж нэгийн зэрэг ч араатан амьд үлдсэнгүй ээ. Шүдэт халимууд арав арван хоёроороо бүлэглэн нэгдэж хэд хэдэн удаа “Наутилус”-

ыг няцаахыг оролдон давшсан боловч амжилт олсонгүй.

“Наутилус”-ын гэгээвчээр тэдгээр ангайсан аймшигт том ам, хилэгнэж догширсон нүд сайн харагдаж байв.

Нед Ленд тэсвэр алдаж тэдгээрийг хараан зүхэж нудрага зангидан загнаж байлаа.

Ой тайгад гөрөөсний гүрээ багалзуур руу шигдэж буй нохой мэт шүдэт халимууд онгоцны хажуу бөөр рүү шигдэж байв.

Гэвч “Наутилус” өөрийнхөө дайсны тэр их хүчдэл, тэр хүнд жин зэргийг үл мэдэрч байв. Тэр шүдэт халимуудыг усны гүн рүү ч чирэн орж, дээш нь ч татан гаргаж хөөж яваа олзноосоо өчүүхэн зуур ч хоцрохгүй байлаа.

Ингэтэл ч араатны сүрэг цөөрлөө. Ус долгиотох нь ч багасчээ. “Наутилус” усан дээр ил гарч ирлээ Онгоцны дээд хавхаг сөхөгдөж бид ч дээшээ гарахыг яарч билээ.

Ажвал далай шүдэт халимын сэгээр дүүрэн харагдав. Хэрэв шүдэт халимын сүрэг дунд асар их бүрэлгэн сүйтгэх хүчтэй бөмбөг тэсрэх юм гэхэд тэдгээрийг ийнхүү хүүчин тасчин, хэсэгчин хаяж чадахгүй буйзаа. Ус хааш хаашаа олон олон миль газар ув улаан болж “Наутилус” цусан далай дунд хөвж явах мэт байв. Капитан Немо бидэн дээр иржээ:

- За, эрхэм Нед та юу гэмээр байна? гэж тэр канад эрд хандлаа.

- Надад хэлэх юм алга капитан минь хэмээн энэ завсар урам зориг нь хөөрч амжсан канад эр хариулаад, та бидэнд аймшигт юм үзүүллээ Тэр үнэн. Та бидэнд овоо зүгээр хядлага үзүүллээ. Гэвч би яргачин биш харин анчин хүн гэлээ.

- Энэ бол аймшигт хорт, араатан амьтдыг устгасан хэрэг хэмээн капитан Немо маргалдаж “Наутилус” ч яргачны хутга биш гэв.

- Ямар ч л гэсэн би өөрийнхөө жадыг л тоож үзнэ гэж канад хүн хэллээ.

- Хэн бүхэн өөр өөрийн зэвсэгтэй шүү дээ хэмээн капитан ямар нэгэн ширүүн үг хэлчих бий дээ гэж айж байлаа. Тэгтэл бидэнд муу юм болох нь зайлшгүй. Гэвч бидний аз болоход канад хүний анхаарал усан дээр хөвж яваа нэгэн аврага загасны зүг хандсан байлаа. “Наутилус”, уул халиманд ойртож явав.

Тэр амьтан шүдэт халимын дайралтаас бултаж чадсангүй. Би хавтгай толгойлсон хав хар зүсний өмнөтийн халим мөн болохыг танилаа. Энэ халим бие махбодын зохион байгуулалтын талаар умартын халим өөрийн төрөл төрөгсдөөсөө хүзүүний долоон сэлүүр үгэлж болон хоёр хавирга илүүтэйгээрээ ялгаварлагдана.

Хөөрхий тэр халим хажуулдан хөвж явлаа. Түүний гэдсийг шүдэт халимууд олон газраар хүү татжээ. Тэр хэдийн үхсэн байв. Түүний зэрэмдэглэгдсэн сэлүүр дор

бяцхан зулзага хоргодсон харагдлаа. Гэвч түүнийгээ ч хамгаалж чадсангүй ээ. Үхсэн эм халимын ангайсан амнаас далбан сахлуудын нь хоорондуур ус горхи мэт шорчигнож байв.

Капитан Немо халимын хүүрэнд ойртон очихыг тушаалаа. Хоёр усан цэрэг халимын бөөрөн дээр үсрэн бууж халимын хөхний сүүг нь юүлэн авч байхыг би гайхан харж байлаа. Тэд иймэрхүүгээр гурван торх сүү юүлж авлаа.

Капитан надад нэг аяга халимын бүлээн сүү уухыг зөвлөв. Би сэжиглэсэндээ ярвайчихгүй байж чадсангүй. Гэвч халимын сүү амтаараа үхрийн сүүнээс юугаараа ч ялгагдахгүй амт сайхан хэмээн тэр над ятгалаа. Би амталж үзэв. Үнэхээр амтлаг сайхан сүү байлаа. Тэр гурван торх сүү бол бидэнд үнэт олз болсон бөгөөд түүгээр хийсэн тос, бяслаг бидний хүнсэнд бас л нэг янз зүйл болон нэмэрлэж байв.

Энэ өдрөөс эхлэн би Нед Ленд капитан Немогийн зүг өдрөөс өдөрт л өширсөн янзтай хялайн харах болсныг ажиг сэтгэл гонсойх болсон бөгөөд ямар нэгэн дайсагнасан бодлогогүй явдал гарвал цаг тухайд нь хориглохоор халимын ангуучны хойноос сэрэмжлэн ажихаар шийдэв.

[Тор](#)

---

## **МӨСӨН ДУНД**

“Наутилус” өмнө зүгийг яг барьсан хэвээр тавьдугаар уртрагийн дагуу нэн их хурдтай явж байв. Үнэхээр тэр өмнөт мөсөн туйл хүрэх гэсэн юм болов уу? Өмнөт туйлын орнуудын гуравдугаар сар умартын орнуудын есдүгээр сар буюу намрын эхэн сартай адил тул түүнд би үл итгэж билээ.

Гуравдугаар сарын арван дөрвөнөө уртрагийн 55 дугаар хоногт анх би хөвж яваа мөс олж үзлээ. Тэр бол хориос хорин таван фут урт, хөхөвтөр туяа бүхий, мөсний их бус эмтэрхийн хэсэг байсан бөгөөд тэхдээ л далайн ус түүнийг шуугин шаагин мөргөж байв.

“Наутилус” усан дээр ил явлаа. Түүнээс урьд өмнө туйлын далайнуудаар үргэлж жуулчилж агсан Нед Ленд усан дээр ил хөвөгч мөс нэг бус удаа үзсэн ажээ. Консель, бид хоёр тэр нэгэн зүйлийг анх үзэн сонирхон буй бүлгээ.

Далайн алс төвшин дээр нүд гялбам цагаан зурвас туяа бий боллоо. Английн

халимын ангуучид түүнийг «Мөсөн гялга» гэж нэрлэдэг юм. Үүл хичнээн өтгөн гээд түүний туяарахыг халхалж чаддаггүй ажээ. Тэр зурвас цагаан гэрэл бол мөсөн цөл халж буйн эхний шинж тэмдэг ажээ.

Үнэхээр ч төдийлөн удсангүй нилээд том том мөс хөвөх нь харагдаж, тэдгээрийн гялалзах тод өнгө агаарын байдлаас шалтгаалж нэг хурц болж, нэг бүдгэрч байв. Зарим нэгэн хөвөгч мөснүүд буюу айсберг хэмээн нэрлэгддэг мөсөн уулнуудын хажуу тал хүхэр ислийн зэсэн судалтай мэт зурвас ногоон судлуудаар хэрчигдсэн харагдаж байв. Бас зарим нэг нь асар том эрдэнийн чулуу мэт нэвт гэрэлтэж харагдлаа. Тэгвэл өөр нэг хэсэг нь өөрийн мянга мянган тооны олон тал ирмэгээсээ нарны гэрлийг ойлгон цацаргаж байлаа. Хамгийн эцэст цасанд дарагдсан дөрөвдүгээр хэсэг нь бүхэл бүтэн хот барьсан ч хүрэлцэхүйц гантиг чулууны асар их нөөц мэт ажээ.

Өмнөт рүү хэдий гүнзгийрэх тутам хөвөгч мөс төдий олон болж тэдгээрийн хэр хэмжээ улам л аврага сүрлэг болж байлаа. Өмнөт туйлын жигүүртэн шувууд тэдгээр мөсөн дээр үүрээ засчээ.

Тэдгээр нь глупынууд, салхич шувууд, пуффинууд байсан бөгөөд тэд бидний чих дүлийртэл бархиралдаж байв.

Тэдний зарим нь “Наутилус” -ыг халимын хүүр хэмээн санасан болов уу, онгоцны тавцан дээр сууж жингэнэсэн төмөр хуягийг тоншиж байв.

Мөсөн дотуур үйлдсэн энэхүү аяны үед капитан Немо цаг үргэлж онгоцны тавцан дээр зогсч билээ. Тэр энэхүү цөл нутгийг асар их анхааралтай ажиж явлаа. Түүний ердийн хүйтэн харцанд зарим үе гал бадрах мэт болж агсныг би үзсэн билээ. Магад ч үгүй, хүн ирж үл чадах, энэхүү туйл орчны уснаа цор ганц эзэн нь хэмээн тэр үед, капитан Немо өөрийн биеийг бодож ч байсан байж болох талтай юм. Гэвч тэр энэ тухай дуулдахаар хэлсэн биш дээ. Капитан бүхэл бүтэн цагаар хөдөлгөөнгүй зогсож, гагцхүү л “Наутилус”-ыг тал бүрээс нь мөс хүрээлж, урхинаас мултарч гарах болсон цагт л тэр, нойроос гэнэт сэрэх мэт хөдөлгөөнд орж байлаа.

Тэхэд тэр жолооны ард өөрийн биеэр зогсож мөсөн уул, хадтай мөргөлдөх аюулаас булзайруулан «Наутилус»-ыг гайхамшиг чадмаг жолоодож байв.

Тэдгээр мөсний зарим нь уртаашаа хэд хэдэн миль хүрч, өндрөөшөө усны төвшнөөс дээш дал наян метр дөхөж байв.

“Наутилус”-ын зам хавтгай мөсөн ханаар дандаа л хаагдах шиг болно. Гэвч капитан Немо түргэн зуур ямар нэгэн ангал, нарийхан нүх сүв олж хэдийгээр түүнийг дахин битүүрнэ гэдгийг мэдэж байх боловч зоригтойгоор түүн рүү довтлон орж байв

Тийнхүү өөрийн капитаны чадмаг гараар залагдаж буй “Наутилус” мөнх наст мөсөн цөл дунд урагшилсаар байв.

Мөсийг хэмжээ ба хэлбэр дүрсээр нь тус бүрд нь ангилсан тусгай хувиарлалт байдаг нь Конселийн сэтгэлд нийцжээ. Түүнийг Консель тэр даруйханд нь тогтоож авлаа. Үүнд: айсберг буюу мөсөн уул, айсфильд буюу мөсөн цөл, драйфтайс буюу хөвөгч мөс, пэкс буюу мөсөн зуурмаг гэх мэт ангилагдана.

Агаарын температур нилээд хүйтэн байв. Термометрийн мөнгөн усны багана тэгээс нэг хоёр хэрчлээснээс дээш гарахгүй байлаа. Гэвч бид цагаан баавгай, далайн хав загас зэргийн арьсан дээлтэй тул даарахыг мэдэхгүй ажээ. “Наутилус” тусгай цахилгаан пийшингүүдийн хүчээр тогтмол температуртай байх тул гадны агаарын халуун хүйтэн хамаарахгүй бүлгээ.

Пийшингүүд нь гэнэт ажиллахаа байлаа ч гэсэн “Наутилус” халуун хүйтний тогтмол температуртай хэсэг рүү буюу усны гүн тийш хэдхэн метр доош шумбан орох л хэрэг гарах билээ.

Хэрэв бид энэ орчинд нэгхэн сарын өмнө хүрэлцэн ирсэнсэн бол бүтэн хоногтоо үл жаргах нарыг олж сонирхохсон бүлгээ. Гэтэл бид хожимджээ. Шөнийн харанхуй хоногийн хорин дөрвөн цагийн дөрөвний гурвыг эзлэх, өдөр хоног өнгөрөх тутам сүүдрээр туйл орчны нутгийг бүтэн зургаан сарын турш хучиж хулдахаар зэхэж байлаа.

Бид гуравдугаар сарын арван таванд шинэ. Шотландын ба Өмнөт-Олкней арлууд орших өргөргийг хөндлөн огтоллоо. Эдгээр арал дээр дөнгөж саяхан хав загасны тоо томшгүй олон сүрэг оршиж агсан боловч англи, америкийн үйлдвэрийн эздийн хөлжиж баяжих сохор шуналын харгайгаар тэдгээрийг эр, охин, зулзага, гөлөг гэж ялгахгүй хүйс тэмтэрсэн тул одоо энд үхэл сүйрлийн үл гэгээрэх харанхуй хар сүүдэр буужээ гэж капитан Немо надад ярьсан билээ.

Гуравдугаар сарын арван зургаанд өглөөний найман цагийн орчим “Наутилус” тавин тавдугаар уртрагийг даган орж өмнөт туйлын бүсийг огтоллоо.

Мөс биднийг тал талаас хүрээлж эргэн тойронд алсын барааг халхлав. Тэглээ ч гэсэн капитан Немо нэг ангалаас нөгөө ангал руу сүлжин орж, явах зам, нүх сүв эрж эс ядан өмнөт зүг довтолсоор байв.

- Биднийг капитан, хааш нь авч одох нь энэ вэ? хэмээн би өөрөө өөрөөсөө чихэнд дуулдахаар чанга асууж билээ.

- Хараа хаашаа л хандана, тэр зүг рүүгээ хэмээн Консель-надад хариулаад явах газаргүй ягдахаараа л сая зогсоно доо гэв.

- Тэгэв гэж үү, би л итгэхгүй байна гэж би хариуллаа. Бүр үнэнээ хэлэхэд, тэрхүү аймшигт жуулчлал миний сэтгэлд тун нийцсэнийг би хүлээх ёстой. Тэндэх сүрлэг мөсөн цөл ямар агуу үзэсгэлэнтэй агсныг дамжуулах арга алга. Мөснүүд тун санаанд үл ормоор хачин хэлбэр дүрстэй ажээ. Мөсөн цөл, зарим үе хурц хурц өндөр ганжиртай тоо томшгүй олон суврага бүхий дорнотын том хот мэт болно. Эсвэл газар хөдөлсний дараа нурж баларсан хот суурин газрын балгас мэт ажээ. Нар өөрийн эгц шулуун тусгалыг өөрчлөн ташуу тусч доошлон доошилсоор жаргах үед, мөсөн тайз, яг л илбэдсэн шиг танигдашгүй өөр боллоо.

Нар үүлийн цаагуур орох буюу мөсөн цөл дээгүүр манан татах үед, эсхүл хоёр том мөс мянган бууны ниргэлт мэт нүржигнэн мөргөлдөх үед тэдгээр үлгэр домог мэт үзэгдлийн тайз заслал бүр ч түргэн түргэн хувирах ажээ.

Тэр мөргөлдөөний үед, хэрэв “Наутилус” усан доор явах бол уул мөргөлдөөний дуун улам ч их хүчтэй сонсдож асар том мөснүүд ус руу унахдаа аюулт сүрхий усан эргүүлгүүдийг үүсгэх бүлгээ. Тийм үед “Наутилус” -ыг далайн шуурганд яваа энгийн нэгэн хөлөг онгоц мэт долгиогоор ийш тийш хаялан сэгсчиж байлаа.

Мөснүүдийн хооронд өчүүхэн ч завсар зай олж үл үзэх явдал олон тохиолдох бөгөөд тэр үед, мөсөн дунд бид нэгмөсөн ингээд түгжигддэг байжээ гэж би боддог байв. Гэвч, капитан Немо өөрийн хэзээ ч эндэшгүй дадлагаар баримжаалан дандаа л шинэ шинэ завсар зай олж аюулаас гардаг бүлгээ. Айсберг буюу мөсөн уулын хормойг тойрон урсч буй хөхөвтөр нарийхан харгиа түүнд баримжаа болон хэзээ ч тэр энддэггүй билээ. Тийм ч учраас би түүнийг өмнөт далайнуудаар нэг бус удаа хөвж буй хэмээн бодлоо.

Гэлээ ч гэсэн гуравдугаар сарын 16-ны үдээс хойш бидний замыг мөс бүрмөсөн хаав. Тэр нь мөнх мөсийн бүс бас л биш бөгөөд зөвхөн хахир хүйтэнд яв цав авцалдаж хөлдсөн зурвас мөсөн цөл ажээ. Тэгэвч уг боомт капитан Немо зогсоож чадаагүй юм. Тэр ч эрч авч мөсөн хана руу асар их хүчтэй давхин дайрвал үүрэмтгий буюу хялбар хагарах мөсөнд “Наутилус” шаантаг мэт чивчрэн орж байв. Тэхэд мөс айдас хүрэм их чимээ гарч, хоёр хэсэг болох ажээ. Энд хана хэрэм эвдэх тэр багажийг нь хэр хэмжээгүй лут хүчин хөдөлгөж байв. Мөргөлтөнд бутарсан мөсний хэлтэрхий биднийг тойрон мөндөр мэт асгарч байлаа. Ёвролт аргагүй л асар их хүчтэй тул хөлөг онгоцны маань өмнө явах зам гарч байв.

“Наутилус” заримдаа дайралтынхаа хар эрчинд мөсөн дээр авиран гарч өөрийн хүндээр мөсийг хотойтол дарах ажээ. Мөс онгоцыг даахгүй хагарах тул мөн л түрүүчийн адил үр дүнтэй төгсгөл болж бид ч урагшилсаар байлаа.

Энэ өдрүүдэд бид далайн ширүүн шуурганд нүдүүлэв. Байсхийгээд л мөсөн дээр манан татаж, онгоцны тавцангийн нэг үзүүрт зогсоход нөгөө үзүүр нь үл харагдана-Салхи чиглэлээ үргэлж өөрчлөх ажээ. Шөнөдөө орсон цас өглөөгүүр мөсжиж хатуурах тул зээтүүдэж цэвэрлэх хэрэгтэй болдог байв. Үүнд хүрз тус үл болох бүлгээ.

Агаарын температур тэгээс доош таван градус буухын хамт “Наутилус”-ын тавцан зузаан мөсөөр бүрхэгдэх ажээ. Далбаат хөлөгсөн бол үүгээр зорчиж чадахгүй бөгөөд түүний тоног төхөөрөмж мөстөж тас түс хөлдөхсөн бүлгээ. Иймэрхүү өндөр өргөрөгт жуулчлах гэдэг нүүрсээр гачигдах явдалгүй зөвхөн цахилгаан хөдөлгүүртэй хөлгөнд л боломжтой хэрэг билээ.

Энэ бүх хугацаанд агаарын даралт хэмжих багаж үргэлж бага даралт зааж цаашид бүр чдоошлох янзтай байлаа. Луужингийн заалтанд ч итгэх аргагүй болжээ.

Бөмбөрцгийн өмнөт соронзон туйлд ойртох тутам луужингийн зүү галзуурсан мэт чичигнэн зүг чиг хаа хамаагүй зааж байх нь дэлхийн жинхэнэ туйлтай үл нийцэх ажээ. Үнэндээ ч Гастены тодорхойлсноор дэлхийн өмнөт соронзон туйл өргөргийн 70, уртрагийн 130 дахь хоногт байдаг билээ. Гэвч Дфперей өргөргийн 70° 30, уртрагийн 135хэмээн арайхан өөрөөр бодож гаргасан юм. Тиймээс зүг чигээ зөв олохын тул одоо, луужинг онгоцны энд тэнд зөөвөрлөн аваачиж хэд хэдэн удаа ажиглалт хийсний дараа гаргаж авсан дундаж хэмжээг зөв зүг чиг гэж үзэх ёстой болжээ. Заримдаа хөлгийн явж буй орчинг зураг дээр тэмдэглэхийн тул зөвхөн лаг хэмээх багажийн заалтыг баримтлах хэрэгтэй болно. Энэ арга төдий л хангалттай бус үр дүнг үзүүлэх нь мөсний ангал дундуур минут тус бүрд годрилдон зүг чигээ цаг ямагт өөрчлөн явах учраас бүлгээ.

Гуравдугаар сарын арван найманд мөсөн дундуур өөртөө зам гаргах хэмээн оролдсон хорь дахь удаагийн дэмий оролдлогын дараагаар “Наутилус” мөсөн дунд бүрмөсөн авцалдан хөлдсөн билээ. «Наутилус» -ыг олзолсон энэ мөс, мөсөн цөл ч биш, хөвөгч мөсөн уулс ч биш, мөсөн цөл ч биш, харин харилцан бат бөх барьцалдан хөлдсөн хөдөлгөөнгүй, юунд ч авташгүй мөсөн уулс байв.

- Туждаа л мөс үү хэмээн канад хүн надаас асуув. Нед Ленд, умартын далайчдын нэгэн адил эдгээр саадыг гэтэлшгүй хэмээн үзэж байгааг нь би ойлгов. Үд дундын хэрд нар хэдхэн минут хэр ил гарч ирэх үед, капитан Немо нарийвчилсан хэмжилт хийлээ. Бид уртрагийн 61°, 30, өргөргийн 67° 39`-нд байгаа ажээ. Үүнээс үзвэл “Наутилус” Антарктикийн гүнд нэн гүнзгийрэн оржээ.

Бидний өмнө ч тэр, хойно ч тэр ил задгай ус үл үзэгдэнэ. “Наутилус” мөн явахын



өмнөхөн голын мөс онгиролдон оволзох мэт ямар ч эмх замбараагүй бөөгнөрсөн, ямар ч хэлбэр дүрсгүй асга хад мэт мөсөөр хучигдсан асар том бартаат орчин дунд байв. Өндрөөшөө хоёр зуу буюу түүнээс ч илуу фут өндөр мөсөн толгодын хянгалсан сэрвэн энд тэндгүй үзэгдэж, түүнээс цаашилбал манангийн боровтор утаархаг буданд хучигдсан эгц цавчим мөсөн цохио зэрэглэн харагдана. Тэрхүү гунигт байгалийн дунд, зөвхөн л салхич шувуудын час хийх дуун ба жигүүрийн нь дэвэлтэнд цочисхийх нам гүм байдал эзэгнэж бүлгээ. Тэр юм бүхэн амьгүй мэт ажээ...

За тэгээд иймэрхүү л газар “Наутилус” өөрийнхөө зоригт довтолгоог зогсоох хэрэгтэй болсон юм даа!

- Хэрэв, манай капитан үүнээс цааш явж чадахсан бол хэмээн тэр өдөр Нед Ленд надад хандаж-юу болохсон бол та юу гэж бодож байна, эрхэм профессор?... гэлээ.

- Юу болохсон гэж, Нед?

- Сайн эр болохсон доо!

- Яагаад?

- Яагаад гэвэл цул мөсий чинь хэн ч, хэзээ ч гэтэлшгүй юм! Танай капитан ч яаж ч мэднэ л дээ. Түүн дээр би маргахгүй. Гэвч тэр чинь байгалиас хүчирхэг биш шүү дээ. Чөтгөр аваг гэж! Хэрэв л энд байгаль гэтэлшгүй саад барьсан юм бол тэр дуртай зогсохоос өөр яах юм бэ?

-Бодвол таны зөв биз ээ. эрхэм Нед Тэглээ ч гэсэн энэ мөсөн доор чухам юу байгааг би мэдмээр байх юм. Энэ мөсөн хэрэм миний ч уур хилэнг хөдөлгөж байна!

- Эзний зөв хэмээн Консель өгүүлрүүн. Ер нь эрдэмтдийн уур хилэн хөдөлгөх л гэж зориут ийм мөсөн хана хэрэм байдаг юм. Миний дураар ч болдог болоосой доо, тэгвэл би эдгээр мөсөн ханыг бүгдий нь газар дээр зөөчихсэн!

- Шал дэмий хэрэг хэмээн канад хүн хэлээд эдгээр мөсөн хананы цаана юу байгааг би сайн мэдэж байна гэлээ:

- Юу байгаа гэж? гэж би асуув.

- Мөс л биз, зөвхөн л мөс байгаа! хэмээн канад эр хариулав.

- Та бүр дүүрэн итгэж байна уу, Нед? Хэмээн би мэтгэлцэж өгүүлрүүн, тэгвэл би үүнд эргэлзэж байна. Тиймээс ч би өмнө зүг аян замаа үргэлжлүүлэхийг хүсч байна.

- Тэр тусмаа л муу даа, эрхэм профессор гуай хэмээн Нед Ленд хариу өчиж-Та энэ бодлоосоо татгалзах байхаа. Бид үргэлжилсэн цул мөсний зааг хүрч ирлээ Үүгээрээ л сэтгэл ханавал зохино. Үүнээс цааш та ч тэр капитан Немо ч тэр, “Наутилус” ч тэр нэг ч алхаж чадахгүй .Та хүснэ үү, байна уу, харин бид л гэдрэг

эргэж хүн шиг хүн суудаг умарт газар одох болно гэв.

Нед Ленд нэг талаар зөв байсан гэдгийг би хүлээх ёстой: Үүнд далайн хөлөг онгоцнууд мөсөн цөл дундуур явж чаддаг болох тэр цагийг хүртэл тэд үргэлжилсэн цул мөсний хил зааг дээр л яг зогсохоос өөр аргагүй бүлгээ.

Үнэхээр ч мөсийг хагалж бутчин урагшлах гэсэн бүх л оролдлогыг харгалзахгүйгээр “Наутилус” ямар ч хөдөлгөөнгүй зогсож билээ.

Хэрэв хөлөг онгоц урагшаа ахиж чадахгүй бол арагшаа ухарч ирдэг нь зүй ёсны хэрэг билээ. Гэтэл энд арагшаа буцна гэдэг урагшаа ахихын нэгэн адил болшгүй явдал байв. Учир нь манай онгоц орж ирсэн ан цав битүүрэн хөлдсөн бүлгээ. Хэрэв л манай хөлөг хэсэгхэн зуур ямар ч хөдөлгөөнгүй зогссонсон бол тэр, мөстэй яг барьцалдан хөлдөх байв.

Өдрийн хоёр цагийн үед энэ аюул мэдэгдэхүйц. илэрхий болж ирлээ. “Наутилус”-ын зогсож агсан тэр нэгэн цөөрөм яах ийхийн зуургүй өрөмтөн мөстөж эхлэв. Капитан Немогийн хэтэрхий зоримог тэр нэгэн явдал одоо хянамж болгоомжгүйн туйлд хүрчээ гэдгийг зөвшөөрөн хүлээх ёстой.

Тэр үед би онгоцны тавцан дээр байв. Хэдэн минут хэр ус өрөмтөн хөлдөж буйг ажиглан зогсож агсан капитан Немо над руу хандаж

- Эрхэм профессор та өөрсдийн энэ байдал дээр чухам юу бодож байна даа?

-Бид ч нилээд бөх суучихав бололтой гэж бодож байнам, капитан.

- Суучихав ий? Тэр чинь юу гэсэн үг вэ?

- Бид хойшоо ч, урагшаа ч, баруун тийшээ ч, зүүн тийшээ ч, хаашаа ч хөдөлж чадахаасаа өнгөрчээ л гэж хэлэх гэсэн юм. Ийм янзтай байдлыг манай хөгжилт боловсон орнуудад “суучих” гэсэн ганц үгээр л дор хаяж ойлгодог юмдаа.

- Тэгвэл “Наутилус” эндээс гарч чадахгүй гэж та бодож байна уу?

- Гарч чадна гэдэгт ч би төдий л итгэхгүй байна шүү, капитан: Хамаг учир нь гэвэл антарктикийн өвлийн босгон дээр мөс нүүдэллэхэд найдахад хэцүү л хэрэгээ.

-Айдаа, профессор минь, та ч өөртөө л итгэхээс биш, өөр юмгүй санжээ хэмээн капитан Немо ёжтойхон өөлчихөөд:

Танд зөвхөн л саад боомт л зүүдлэгдэнэ.”Наутилус” энэүүу цагираг дундаас ч зөвхөн мултраад зогсохгүй бүр цаашаа явна гэдгийг харин танд мэдэгдчихье! гэв.

- Бүр цаашаа, урагшаа юу хэмээн би капитан Немо руу бүлтийн харж асуувал,

--Тиймээ, эрхэм профессор гуай, бүр цаашаа өмнөд туйл руу! гэлээ.

-Туйл руу гэнээ! хэмээн би өөрийнхөө үл итгэх байдлыг нууж эс чадан дуу алдаж билээ.

-Тиймээ, туйл руу хэмээн капитан хүйтэн царайлан дээр хэлснээ давтан баталж өгүүлээд,-Дэлхийн бөмбөрцгийн хамаг меридиан огтлолцдог тэр нэгэн таавар болсон газар руу юу хүссэн бүхнээ “Наутилус”-аар би хийлгэж чадахыг та мэднэ шүү дээ! гэлээ.

Тиймээ, түүнийг би мэднэ! Түүнчлэн би энэ хүнийг ч хэлэхийн аргагүй зоригтой хүн гэдгийг ч мэднэ. Тэглээ ч гэсэн ойртож очиход умарт туйлаас долоон дор,өмнөт туйлд хүрч очиход, гагцхүү ухаан солиорсон хүн л зам хаасан тоо томшгүй олон саад боомттой тэмцэлдэхээр зориглох бүлгээ.

Тэхэд Умарт туйлд хүргэхийн тулд хамгийн зоригтой, хамгийн хашир, дадлагатай далайчид дэмий үрэгдэж, эсвэл ухарч буцсан буюу эсвэл амь алдсан бус биш үү.

-Хүний хөл хэзээ ч гишгээгүй тэр туйлыг урьд өмнө нь капитан та нээсэн юм биш биз хэмээн би асуухад:

-Үгүй ээ хэмээн тэр хариулж харин тэгээд л бид хамтдаа энэ дээ, өөр хэн нэгэн хүнд нээх завшаан олдоогүй юм бол надад олдох юм. Би “Наутилус” дээрээ өмнөт туйлруу хэзээ ч ингэж алс гүнзгийрч яваагүй. Гэвч би танд дахиад нэг хэлчихье, бид эндээс улам цаашилна ч, өмнө туйл хүрнэ! гэлээ.

- Бид танд итгэхийг хүснэм, капитан хэмээн би ёжлон хариулаад би танд итгэж ч байна. Урагшиль! Бидэнд саад алга. Энэ цул хавтгай мөсийг зад цохье!Тэсэлье, дэлбэлэе хэрэв эсэргүүцэх бол “Наутилус”-таа жигүүр хийж нисгэе! гэв.

-Мөсөн дээгүүр нисгэх гэж үү, эрхэм профессор оо хэмээн капятан Немо аажуухан өгүүлээд үгүйээ, яах юм? Бид мөсөн доогуур нь орчихье! гэлээ.

-Мөсөн доогуур ий?хэмээн би дуун гарлаа. Үнэхээр ч би гэнэтхэн сэхээ орох шиг боллоо. Капитан Немо чухам юунд найдаж агсныг би сая ойлгов. “Наутилус”

гайхамшиг чадал капитан Немод бас нэгэн онцгой үүрэг гүйцэтгэх ёстой болжээ!

-Бид одоо л ойлголцож эхлэв шив хэмээн капитан Немо инээмсэглэв. Тийм нэгэн оролдлогоо болох талтай гэдгийг зөвшөөрөхөд бэлхэн байгаа бололтой. Миний хувьд бол амжилтанд дүүрэн итгэж байнам. Ердийн нэгэн хөлөг онгоцонд бодохын ч хэрэггүй зүйлийг “Наутилус” хялбархан гүйцэтгэнэ гээч. Хэрэв л туйл орчинд эх газартай тулгарвал “Наутилус” зогсох болно. Хэрэв өмнөт туйл тэнгисийн усаар угаагдаж байдаг юм бол бид жинхэнэ туйл хүртэл явна гэв.

-Нээрээ л хэмээн капитаны зүй ёсны сэтгэмжинд сэтгэл татагдсан би хариулруун, далайн гадаргуу мөсөөр хуяглагдсан цагт, түүний доод давхарга гэсгэлэн байх шүүдээ.Хэрэв эндүүрээгүй бол усан доор далд байгаа мөс усан дээр ил байгаа

мөстэйгөө дөрөв нэгний харьцаатай биш үү? гэлээ.

-Тиймээ, ноён профессор, бараг л тийм харьцаатай даа. Айсбергийн далай дээр ил байгаа хэсгийн фут тус бүрд, усан дээр далд байгаа хэсгий нь гурван фут харгалздаг юм. Тиймээс тэдгээр мөсөн уулс далай дээр зуун метр өндөр гарсан бол далай доорхи шувтарга хэсэг нь гурван зуун метрээс хэтрэх ёсгүй. Тэгвэл «Наутилус»-т гурван зуун метр дор шумбаж орох гэдэг юухан байх билээ?

-Юу байхав, юмгүй!

-Тэгвэл бид, бүх өргөргүүдийн дагуу температур яг л адилхан байх тийм гүнд, улам шумбаж орсон цагт, гадаа задгай агаарт догширч буй гуч дөчин градусын температурыг ямар ч ял зэмлэлгүйгээр элэглэн дооглож явах биш үү!

-Таны зөв капитан, таны түмэн зөв хэмээн би хэллээ.

-Бид өөрсдийн биеэр тэвчин өнгөрүүлж болох цор ганцхан жишээ л гэвэл-хэмээн капитан Немо үргэлжлүүлэн хэлээд амьсгалах агаараа шинэчлэхгүйгээр бүтэн хэд хоногийн турш далай доор байх л нэг явдал байна гэлээ.

-Зөвхөн тэр үү? хэмээн би маргалдаж- “Наутилус” дээр хүрэлцэхүйц багтаамжтай их их сав бий биш үү. Тэднийгээ д агаараар дүүргэж авахад тэд биднийг шаардагдах хэмжээний хүчилтөрөгчөөр хангах юм чинь гэв.

- Тун сайн эрхэм профессор хэмээн капитан дахин бодлогогүй юм хийлээ гэж танд би сүүлд зэмлэгдэхгүйн тулд, тантай бас нэгэн эргэлзээтэй зүйл хэлэлцэхийг зөвшөөрөхсөн л үү гэв.

--Та юунд эргэлзээ вэ? гэж би капитан Немогоос асуухад,

- Өмнөт туйл дээр далай, хэрэв л тийм далай байдаг: бол, бүхэлдээ мөсөөр бүрхэгдсэн байвал бид дээшээ гарч чадахгүй шүү дээ гэлээ.

- Түүнд санаа зовох юун билээ, капитан: «Наутилус» ган мөргүүлээр зэвсэглэсэн гэдгийг та мартчихсан гэж үү? Түүнийгээ та мөсөн тааз өөд диагоналаар чиглүүлж дайраад гадагшаа хялбархан гарах бишүү.

- Ингэхэд эрхэм профессор та өнөөдөр ер нь нэг л өөр хэлээр яриад байхчив.

- Жич хэлэхэд, өмнөт туйл дээр бид мөсөөр хучигдаагүй далай яагаад олж эс чаддаг билээ? хэмээн би бүр ч зориг бадран цааш үргэлжлүүлж Туйлуудын хүйтний туйл бөмбөрцгийн хүйтний туйлтай дэлхийн бөмбөрцгийн өмнөт хагаст ч тэр, умарт хагаст ч тэр үл тохирдог биш үү. Тиймээс чиг үүний эсрэг тал батлагдаагүй цагт дэлхийн бөмбөрцгийн энэхүү эсрэг хоёр цэгт хуурай газар буюу мөстөөгүй далай бий хэмээн бид яагаад бодож болдоггүй билээ.

- Би ч гэсэн бас тэгж боддог шүү, ноён профессор оо хэмээн капитан Немо

хариулаад-Миний төлөвлөгөөний эсрэг өдий их маргаж мэтгэсний дараа, та одоо түүний бүтэмжийн тул намайг элдэв л төрлийн нотолгоогоор булж байх шив дээ. Та өөрөө анхаарч хянаж үзээч гэлээ

Капитан Немогийн зөв. Одоо би түүнтэй эр зоригоор өрсөлдөж байв. Одоо би түүнийг туйл руу довтлон одохыг ятгах боллоо. Түүгээр ч барахгүй би түүнийг хол хаяжээ...

Ай үгүй ээ, хар галзуу! Капитан Немо болох “болохгүйг” аль дээр цэгнэн үзэж хэдийн судалсан бөгөөд, одоо тэр зөвхөн л миний нэг заагаас нөгөө зааг руу үсэрхийлэн дуулж хий хүсэлд автан хэрхэн омогдож буйг харж бах нь ханаж байлаа.

Энэ завсар капитан Немо цаг алдсангүй. Тэр өөрийн туслагчийг дуудан ирж надад үл ойлгогдох, өөрсдийнхөө хэлээр ярилаа. Капитаны төлөвлөгөөг туслагч нь урьд өмнө нь мэдэж ч байсан юм уу эсхүл түүний төлөвлөгөөнд хийж гүйцэтгэж болшгүй юм тэр олж эс үзсэн юмуу, юу ч л гэсэн түүний царайнд ядаж гайхсан янз үзэгдсэнгүй.

Тэр хэдий их амгалалан царайлавч капитан Немогийн өмнөт туйл орох гэсэн шийдийг би үнэнч нөхөддөө сонсгох үед Консель ажиггүй амгалан байдлыг давж унасангүй билээ. Энэ нэгэн эр зоригтоос эзний л таалал мэдэж гэсэн ганхан уужуухан хариултаас өөр юуг ч би олж сонссонгүй бүлгээ. Нед Ленд ч өөр хэрэг. Миний сонсголыг дуулаад канад хүн мөрөө хавчсанаас илүү мөр хавчих гэж ер нь байв гэж үү дээ.

Эрхэм профессор та мэдэж байна уу гээд тэр, та болоод таны капитан хоёр ч мөн хөөрхий л байна даа! гэлээ.

- Үгүй ээ; Нед минь ойлго л доо, энэ чинь бид туйл дээр өмнөт туйл дээр очно шүү дээ!

- Та очиж ч байж болох юмаа, харин тэндээс эргэж ирж хэрхэвч чадахгүй! гэв.

- Энэ үгийг хэлчихээд Нед Ленд “хэрэггүй юм болохоос өмнө би чинь явж өгнө” гэж хэлэхийн хамт хаалга хааж, өөрийнхөө өрөөнд явж одлоо.

Тэр завсар “Наутилус” өөрийн зоримог жуулчлалд бэлтгэж эхлэв. Цахилгаан хөдөлгүүрийн хүчээр хөдлөх хүчирхэг шахуургууд хийн багтаамжуудад өндөр даралттайгаар агаар шахаж гарлаа.

Өдрийн дөрвөн цагийн үед капитан Немо тавцангийн хавхаг хаах болсныг надад мэдэгдэв Бидний замыг хааж агсан үргэлжилсэн их мөсөн далайг сүүлчийн удаа нүд ширвэлээ. Өдөр тунгалаг, тэнгэр цэлмэг байж билээ. Агаарын температур тэгээс доош 12 зааж нилээд хүйтэн боловч салхигүй тул төдий л их хүйтэн шинжгүй байв.

Дотроос арваад далайчин зээтүү барин онгоцны тавцан дээр гарч ирээд “Наутилус”-ыг тойрон хөлдсөн мөсийг хагачиж гарлаа.

Мөс нимгэн тул онгоцыг тэд түргэн зуур мөснөөс суллаж амжив. Төдөлгүйхэн бид дотогшоо орж очиход тавцангийн хавхаг ч хаагдаж, “Наутилус” ч аажмаар живж эхлэв.

Би Конселийн хамт үзэсгэлэн танхимд орж очив. Бид гэгээвчний хажууд сууж өмнөт мөсөн далайн усны доод, давхаргыг ажиглаж билээ. Гадаад орчны температурыг хэмжих хэмжүүрийн мөнгөн ус түргэн зуур дээшилж, манометрийн зүү баруун тийш хазайж байв.

Капитан Немогийн тааварласнаар гурван зуун метрийн гүнд ус мөснөөс ангижирч бүлгээ. Гэвч “Наутилус” найман зуун метрийн гүнд ортол доошилсоор л байв. Усны тэрхүү давхаргат температур усны гадаргуу дээрх температурээс хоёр градус дулаан байв. Цаг ямагт цахилгаан пийшэнгээр дулаацуулагдан байх “Наутилус”-ын дотоод температур гадаа халуун хүйтнээс шалтгаалахгүйгээр үргэлж нэгэн хэм жээнд байдаг нь мэдээж хэрэг билээ.

“Наутилус” бүх л төрлийн хөдөлгөөнийг яг таг бөгөөд дуулгууртай нь аргагүй гүйцэтгэж байв.

- Эзэн хэрэв зөвшөөрөхсөн бол, миний бодлоор, бид мэнд сайн явж хүрнэ гэж би хэлэх байнам гэж Консель өгүүлэв.

- Найдаж байна хэмээн би дүүрэн итгэсэн байдлаа илтгэн хариуллаа.

Тэрхүү мөснөөс үүрд чөлөөлөгдсөн гүнд “Наутилус” тавин хоёрдугаар уртрагийн дагуу туйлруу шууд зүглэн чиг авлаа. Өргөргийн 67°30`-аас 90` хүртэл хорин хоёр хагас километр буюу хоёр мянга жаахан илүүтэй километр явах хэрэгтэй байв. “Наутилус” барагцаалбал цагт тавин километрийн буюу бараг буухиа галт тэрэгний хурдтай давхиж байлаа. Хэрэв л түүний зам зуур нь нэгэн саад учрахгүй бол дөч гаруйхан цагийн дараа туйл хүрэх ёстой ажээ. Усан доорхи байгалийн үзэсгэлэнт шинэ шинэ газрууд Консель бид хоёрыг үзэсгэлэн танхимын цонхны дэргэд шөнийн хагас саатуулж билээ. Цахилгаан прожектор усыг гялбам хурц өнгөөр гэрэлтүүлж байв. Гэвч далайн ус хов хоосон ажээ. Хүйтэн жавар тас хийсэн тэрхүү усанд загас байдаггүй юмсанж.

“Наутилус”-ын хурд зөвхөн түүгий их бие тасралтгүй чичирхийлэх доргиогоор мэдэгдэж байв.

Шөнийн хоёр цагийн үед би хэдхэн цаг унтахаар шийдэж өөрийн өрөө рүү явлаа. Консель ч гэсэн миний нэгэн адил явж одов. Гудам өрөөгөөр би дамжин, өрөөн

тийшээ очих замдаа капитан Немотой дайралдсангүй- Түүнийг би жолоодлогынхоо бүхээгт дежурлэж буй хэмээн бодлоо.

Дараачийн нь өглөө, гуравдугаар сарын 19-нд би үзэсгэлэн танхимын цонхны дэргэд өөрийн хянах байрыг дахин эзлэв. Цахилгаан лаг «Наутилус» багасгасан хурдтай явж буйг надад зааж байв. Тэр одоо хөөрч эхэлсэн бөгөөд гэхдээ цочир гэнэт хөөрсөн биш, харин ус дүүргэсэн багтаамжуудаа хоосолсоор аажмаар дээшилж байлаа. Миний зүрх дэлсэж эхлэв. Бид усан дээр ил гарч чадах болуу? Мөстөж хөлдөөгүй задгай ус бидэнд олдох бол уу?

Үгүй ээ. “Наутилус” нэг юманд лүгхийтэл тулсныг бодвол бид үргэлжилсэн хавтгай мөсний доод талаас нь мөргөчих шиг бололтой. Лүг хийх чимээгээр бол мөсний нэн их зузаан давхаргад тулчихав бий. Үнэхээр ч манометрийн заалт тэрхүү таамаглал зөв болохыг нотлов. Бид мянга таван зуун фут гүнд байгаа ажээ. Гэхээр чинь бидний дээрх мөс хоёр мянган фут зузаан бөгөөд түүний таван зуун фут нь усан дээр ил байгаа юм байна. Үүнээс үзвэл энэ орчны мөс бидний анх усан доор живж ордог орчны мөснөөс зузаан байв. Үүнд бидний сэтгэлийг тайтгаруулах ямар нэгэн зүйл үгүй ажээ.

«Наутилус» өдрийн турш усны гадаргуу дээр гарах оролдолгоо хэдэн удаа хийсэн боловч ямагт л нэн зузаан мөсөн таазанд тулж мухарддаг байв. Тэрхүү «тааз» заримдаа есөн зуун метрийн гүнд тохиолдож байсан буюу өөрөөр хэлбэл мөсний зузаан нь мянга хоёр зуун метр хүрч байсны гурван зуун метр нь далай дээр ил гарсан байх ёстой байв. Энэ нь бидний анх усан доор живж орсон орчны айсбергийн туйлын өндрөөс гурав дахин илүү ажээ. Би айсбергуудийн уснаа гүнзгийрч орсон суурийг хичээнгүйлэн тэмдэглэж, ус руу тонгоргосон тэрхүү хэлхээ уулсын бүдүүлэг зургийг гаргаж бүлгээ.

Орой тийшээ бидний байдал өөрчлөгдсөнгүй. Мөс үргэлж л дөрвөн зуугаас таван зуун метрийн гүнд тулгарсаар байв. Энэ нь ямар ч гэсэн нилээд нимгэрсэн мөсөн хуяг байсан бөгөөд гэлээ ч гэсэн задгай далай дээр гартал асар зузаан мөс бидний дээр байсан билээ.

Орой найман цаг орчим байв. Дөрвөн цагийн дараа «Наутилус» ердийн тогтсон заншлаар агаарынхаа нөөцийг сэлбэх ёстой байв. Капитан Немо бэлтгэл багтаамжуудаасаа нэг ч литр хүчилтөрөгч тавиагүй боловч надад амьсгаа давхцах ямар нэгэн шинж тэмдэг мэдэгдсэнгүй.

Энэ шөнө би нойр муутай хонолоо. Итгэл найдвар түгшүүр хоёр миний сэтгэлийг ээлжлэн донсолгож байв. Би орнооссо хэд дахин бослоо. “Наутилус” мөн л хөвж

гарах газар тэмтэрсээр ажээ. Өглөөний гурван цагийн үед би үзэсгэлэн танхимд орж манометр руу харвал мөсөн дээврийн доод тал дөнгөж тавин метрийн гүнд байлаа.

Хавтгайрсан цул мөс бага багаар айсфильд буюу мөсөн цөл болон хувирч байв. Усан доорхи тонгорсон мөсөн уулс тэгш толигор мөс болон солигдож байлаа.

Би манометрээс нүд салгалгүй ширтсээр байлаа. Манай прожекторын гэрэлд мянга мянган өнгөөр гал оч болон гялалзаж буй мөсний налуу гадаргууг даган диагнолоор бид өгсөн өгссөөр байв.

Үргэлжилсэн цул мөс километр бүрд нимгэр нимгэрсээр ингээд эцсийн эцэст, тэр нэгэн дурсгалт өдөр, гуравдугаар сарын 19-нд, үзэсгэлэн танхимын үүд нээгдэж капитан Немо босго алхан орж ирэхийнхээ сацуу:

- Далай чөлөөтэй гэлээ.

[Тор](#)

---

## ӨМНӨТ ТУЙЛ

Тэр даруй би онгоцны тавцан дээр гүйн гарлаа. Тийм байна. Далай мөснөөс чөлөөлөгдсөн байв, зөвхөн л хаа нэг газар айсбергууд том том мөс хөвж явах нь харагдав. Цаашилбал өмнө зүг мөс ердөөч үзэгдэхгүй байв. Мянга мянган шувуу агаарт элин хальж, хар хөхөөс авахуулаад бор шаргал хүртэл өнгө өнгийн мянган загас далайн давалгаа зүсэн зүсэн авай. Цельсийн термометр тэгээс доош гурван градус зааж байв. Далайн төвшин дээр бүдэг бараг үзэгдэж буй хавтгайрсан цул мөсөн дунд саяхан, үзэж өнгөрүүлсэн хүйтний дэргэд энэ нь бараг хаврын урь орсонтой адил ажээ.

- Бид хаана байгаа нь энэ билээ? хэмээн би капитанаас асуухад зүрх минь хүчтэй дэлсэж байв. Туйл дээр үү?

Би ч өөрөө мэдэхгүй байна хэмээн тэр хариулж-үд дунд бид байгаа газраа нараар оломз гэв.

- Энэ манан дунд нар үзэгдэнэ гэж үү? гэж би үүл бүрхсэн тэнгэр өөд харж найдвар муутайхан асуувал,

- Хэрэв л нар ядаж хагас минут хэр цухуйвал болох нь тэр хэмээн капитан хариулав.

“Наутилус”-аас урагшаа арваад миль газар далай дээр хоёр зуугаад метр ил



гарсан өнчин ганц арал үзэгдэв. Бид тэр зүг нэн удаан ойртож очив. Учир нь усан доор далд нуугдсан хад хясаа байж болох бүлгээ.

Цагийн дараа бид аралд хурч, дахиад бас хоёр цагийн дараа түүнийг бүтэн тойрлоо. Тэрхүү бяцхан арлыг бүтэн тойроход дөрөв тавхан миль ажээ. Түүнийг нэгэн нарийхан хоолой ямар нэгэн эх газраас тусгаарласныг бодвол тэнд магад ч үгүй нээгдээгүй шинэ тив байгаа ч байж. Тэрхүү эх газар тэнд байгаа явдал Морийн таамаглалыг нотлох мэт ажээ. Ухаалаг тэр Америк хүн өмнөт туйл ба жардугаар өргөрөг хоёрын хооронд далайн асар их талбайг эзэлсэн хөвөгч мөсөөр бүрхэгдсэн болохыг ажиглажээ. Тийм мөс бөмбөрцгийн умарт хагаст хэзээ ч үзэгдээгүй ажээ. Тэрхүү ажиглалт дээрээ үндэслэж өмнөт туйлын цагираг орчинд ямар нэгэн тив байна гэсэн дүүнэлт хийсэн бөгөөд айсбергууд зөвхөн хуурай газар дээр үүсэхээс биш далай дээр үүсэх учиргүй ажээ. Морийн бодож гаргаснаар өмнө туйлыг тойрсон мөс дөрвөн мянган километр диаметртэй асар уудам цагираг үүсгэж буй болно.

Тэр хооронд «Нуаутилус» газардах аюулаас болгоомжилж асар сүрлэг хад асга арвайсан эргээс гурван кабельт газар зогслоо. Усан дээр завь буулгасан байв. Капитан ба Консель бид хоёр элдэв багаж хэрэгсэл уурч дүүрсэн хоёр далайчийн хамт завинд суулаа. Өглөөний арван цаг орчим байв.

Энэ өглөө би Нед Лендийг олж үзсэнгүй. Тэр канад эр бодвол өөрийн ялагдсаныг хүлээх дургүй байгаа бололтой.

Сэлүүрийн хэдхэн дэвэлт бидний завийг элсэрхэг хаялга дээр аваачиж, завь ч тэнд зогсов.

Консель завинаас үсрэн буухыг завдтал би түүнийг хориглож зогсоогоод капитан Немод,

Энэ нэгэн газар дээр хөл гишгэх эрх хамгийн тэргүүнд танд хүртэх ёстой! гэж хэлэв.

- Тиймээ, эрхэм профессор хэмээн капитан хариулж- Үүнийг ч би эргэлзэх юмгүй одоохон үйлдэнэ. Учир нь надаас өмнө энэ нэгэн газар дээр хүний өлмий хүрээгүй юм гэв.

Тэгээд тэр элсэн дээр сэв хийтэл үсрэн буулаа. Бодвол түүний сэггэл ихэд догдолж, зүрх нь хүчтэй дэлссэн буйзаа. Тэр хад өөд авиран гараад хоёр гараа цээжин дээрээ зөрүүлэн тавьж хөдлөлгүй дув дуугүй, харах нүдэнд нь гал цог бадруулан зогсохдоо тэрхүү туйл орчны газрыг эзэмших эрхээ олсон мэт харагдлаа. Тиймэрхүү байдалтай хэдэн минут зогссоноо тэр бидний зүг хандаж:

- Эрхмүүд ээ! Бууж ирцгээнэ үү гэж хашгирлаа. Тэрхэн даруй би элсэн дээр үсрэн

буув. Консель мөн намайг дагалдан бууж ирэхэд далайчид завиндаа үлдэв.

Газрын хөрс нунтаг улаан тоосго цацсан мэт галт уулын улаавтар өнгийн чулуугаар хучигджээ. Түүнчлэн магмын царцмал хайльш, бөөгнөрч хатуурсан үнс чандруу зэргээр бүрхэгдсэн байв.

Тиймээс тэр нэгэн бяцхан арал гарцаагүй галт уулын үүсвэртэй ажээ. Гэтэл зарим газраар газрын хөрсөн дороос хүхрийн муухай үнэртэй зурвас утаа савсаж байв. Энэ нь газар доорхи ажиллагаа бас л зогсоогүйн гэрч бүлгээ. Антарктик орчны усан доор уртрагийн 167°, өргөргийн 77°32'-нд Джеме Рос гэгч Эребусба Террор хэмээх үйлчилж буй хоёр галт уул нээсэн явдал бий тул тэр бүх явдалд би ер ч сонирхсонгүй ээ. Би капитан Немогийн нэгэн адил хад өөд мацан гарч орчин тойрныг ажиглахыг яаравчиллаа. Тэгэвч би галт уулын цооног орой олж үзсэнгүй. Арал дээрх ургамлын баялаг нэн ядуу ажээ. Үүнд хадны хэд хэдэн төрлийн хаг, хад чулуунд наалдаж ургасан замаг хоёроор л эндхийн бүх ургамал хязгаарлагджээ. Эндхийн амьтны аймаг зөөлөн биетэн, хөндий хэвэлтэн шүр биетэн, далайн од. мэтчилэн хэд хэдэн дүрсээс бүрэлджээ. Шувууд! Шувууд гэж үү?. Эндхийн жигүүртэн гэдэг танагүй олон ажээ. Тэд олон мянгаараа агаарт баарцаглан элин хальж, бидний тархи толгой дөжрүүлэхийн зэрэгцээ, хад хясаа дээр мянга мянгаараа шавааралдан сууж, үй олноороо далайн тунгалаг толь мэт өнгөт толигор усанд умбан шумбан байв.

Тэнд пингвин хэмээх нүсэр хүнд болж ирээд газраар явахдаа нэн болхи хөдөлгөөнт, усанд бол загас мэт шаламгай гялалзуур нэгэн шувуу голчлон олон ажээ.

Агаарт халих шувуудын дунд дэлгэсэн жигүүр нь дөрвөн метр хүрдэг асар том альбатросууд эргэлдэх бөгөөд тэднийг далайн элээ хэмээн нэрлэсэн нь тун нийцлээ. Түүнчлэн далайн гахайнуудын аюулт дайсан болсон аврага биет калхич шувууд, нэгэн дүрс нугас морянка хэмээх жигүүртэн зөвхөн Антарктикт л орших хүрэн ягаан өнгийн эмжээр бүхий далавчтай цагаан ба цэнхэр өнгийн глупышуудийн бүхэл бүтэн сүрэг үзэгдэв.

- Эд мөн агуу тарган гээч хэмээн би Консельд Фарер арлынхан алсан шувуундаа шууд л гал хийчихээд дэн барьчихдаг юм гэв.

- Байгаль жаахан л хичээсхийвэл, маш агуу сайхан дэнлүү бий болохсон. Тэр дэнлүү нь гол байдаггүй нь юутай харамсалтай вэ: гэж Консель хариулж билээ.

Бидний бууснаас хагас миль зайтай газар, газрын хөрсийг нүхэлж сэндийлсэн нь пингвиний үүр байлаа. Капитан Немо тэдгээр шувуунаас хэдэн зууг барьж алахыг усан цэргүүддээ тушаасан бөгөөд үүний учир нь тэдний хэр мах тун амттай байжээ.

Галуун чинээ биетэй, хар өнгийн өд сөд бүхий элэг цээжээрээ цагаан толбо болсон, хүзүүгээрээ шар судалтай тэдгээр шувуу тэр байтугай амь зулбаж зугтахыг ч бодохгүй, чулуунд цохиулан алуулж байв.

Тэр завсар манан арилсангүй, өдрийн арван нэгэн цаг болсон боловч нар үзэгдсэнгүй ээ. Энэ явдал миний сэтгэлийг ихэд түгшүүлж байв. Хэрэв л нар үзэгдэхгүй бол бид ажиглалт хийж чадахгүй бүлгээ. Ажиглалт эс хийвэл бид туйл хүрсэн эсэхийг хэрхэн мэдэх билээ?

Би капитан Немод ойртон очвол, тэр хад тохойлдон далай руу ажиглан дуугүй зогсч байв. Тэр тэсч ядан заримдаа тэнгэр өөд харах дур муутай мэт байв. Тэгэвч одоо яая гэхэв? Эрэлхэг тэр хүн далай дээр эзэгнэдэг шигээ тэнгэрийг эзэгнэж чадахгүй билээ.

Өдөр ч бүр дундаа орчихов. Нар цухуйхгүй л байлаа. Түүгээр ч барахгүй тэнгэрийг битүү бүрхсэн өтгөн үүлийг нэвтлэн нарны бүдэг гэрэл ч туяарахгүй ажээ. Төдөлгүй цас орж эхлэв.

- Маргааш болтол хойшлуулахаасдаа хэмээн капитан хэлэхэд бужигнаж эхэлсэн цасан шамрага дундуур бид “Наутилус”-таа эргэж ирлээ.

Биднийг арал дээр байх завсар “Наутилус”-ын баг далайд тор хаяж татан амжжээ. Барьж авсан загасыг би нэн сонирхон орлоо. Антарктиктын далай, далайн гахай ба арслангийн аманд орохоос буюу далайн догшин шуурганаас амь зугадсан тун олон төрлийн загасны орогнох орон болсон ажээ.

Хүрэн хүрэн толбоор цоохорлогдсон мөнгөлөг цагаан хайрс бүхий хэд хэдэн бухандай загас утас адил урт нарийхан сүүлтэй, шөвөг мэт шунтан хоншоор бүхий амтлаг шараас хүрэн бор ба цайвар цагаан хүртэл өнгө ялгаран солонгорох, гулгамтгай гөлгөр хөрслөг, гурван фут урт биетэй антрактикийн химмер байхыг би олж үзэв. Түүний мах надад таалагдсангүй боловч Консель түүнийг нэн амтгайд тооцлоо.

Цасан шуурга маргааш өглөө нь болтол үргэлжлэв. Гадагш хамраа ч цухуйлгах аргагүй байв. Үзэсгэлэн танхимд сууж, сүүлчийн өдрүүдийн явдлыг тэмдэглэх зуураа би, тавцангийн сөхөөстэй хавхгаар, салхи шуургыг үл хайхран агаарт нисэн дүүлэн буй альбатросуудын хашгаралдах дууг сонсч байлаа. “Наутилус” эрэг даган явсаар урьд зүг арваад миль холдсон байв.

Маргааш нь гуравдугаар сарын 20-нд шуурга намдлаа. Гэвч хүйт жаахан нэмэгджээ. Температур тэгээс доош хоёр градус зааж байв.

Манан ч замхарсан тул би өнөөдөр л бид нараар ажиглалт хийж чадна гэж

найдаж билээ.

Капитан Немо гарч ирэхгүй л байв. “Наутилус”-ын завь Консель бид хоёрыг үл таньсан эх газрын эрэг дээр гаргалаа. Эндхийн газар хөрс мод л яах аргагүй галт уулын үүсгэлтэй байв. Галт уулын лав, үнс, хүрэн чулуу зэргийн ор мөр хаа сайгүй л харагдах боловч галт уулын цооног байхыг би хаанаас ч олж үзсэнгүй ээ. Энд мөн арал дээрхийн нэгэн адил мянга мянган шувуу бужигнаж байв. Жигүүртнээс гадна, эндхийн амьтны аймаг биднийг дэргэдүүрээ өнгөрөхөд бидэн рүү ажиггүй ширтэх далайн сүүгээр бойжигчдын их сүргүүдээр бүрэлдсэн ажээ. Тэд бол далайн гахайнууд байв. Тэдний зарим нь эргийн элсэн дээр тэрийж. зарим нь мөсөн дээр сунаж хэвтэх бөгөөд нөгөө зарим нь эрэг орчны усанд умбаж шумбан орж гарч байлаа. Биднийг ойртон очиход тэд айсан шинжгүйг бодвол тэд анх удаа хүн үзэж буй бизээ.

Тэр сүргүүдийг агнаж ачих юм гэхэд агнуурын хэд хэдэн хөлөг онгоц хэрэгтэй байлаа.

- Нед Ленд л бидэнтэй хамт ирээгүйд нь би тун их баярлаж байна. Нээрээ шүү: хэмээн Консель өгүүлэв.

- Яагаад, Консель оо?

- Яагаад гэвэл тэр ангийн өвчит чинь эндхийн хамаг гахайг бүгдийг нь хядчихсан биш үү!

- Бүгдийг нь хядчихаж чадахгүй байх аа. Харин энэ хөөрхийсийн нилээд хэд нь ч сайнаа үзэхгүйсэн биз. Гэвч тэр явдал гэмгүй амьтны цусыг дэмий урсгах дургүй капитан Немогийн сэтгэлд нийцэхгүй л дээ.

- Капитаны түмэн зөв.

- Тэгэлгүй яахав Консель минь. Жич чи далайн энэхүү сайхан амьтдыг ангилан хувиарлаж амжаагүйсэн биш билүү хө?

- Жинхэнэ биш дээр нь намайг барагтайхан ялгаж таньдгийг эзэн сайн мэдэх билээ. Хэрэв л эзэнтэн эдгээр амьтныг надад нэрлээд өгчихвөл ч би

- Эд чннь далайн гахай, далайн арслан хоёр биш үү.

- Тэгвэл суугээр бойжигчдын анги нэг хэвэлтний доод анги ластоногийн багт хамаарагдах хоёр дүрс байна гэж Консель яаравчлан ангилав.

- Зүйтэй Консель минь хэмээн би хариулж гэвч тэдгээр дүрс чинь, хэрэв л би эндүүрээгүй бол өөрийн бага дүрстэй биш билүү хө. Удахгүй бид энд олж үзэх болно. Явъя гэлээ.

Өглөөний найман цаг орчим байв. Капитан Немо үд дунд өөрийн ажиглалтыг хийх

ёстой билээ. Тиймээс бидний мэдэлд бүтэн дөрвөн цаг байв.

Энэхүү эх газар руу нэн гүнзгийрэн орсон уудам тохойн захыг барьж явахыг би Консельд илтгэж эргийг даган явбал эрэг орчны хад хясаа, мөс ус далайн тэдгээр сүүгээр бойжигчдын үй түмэн сүргээр шивээлэгдсэн байв. Тэнд голчлон далайн гахай олон ажээ. Тэд гэр бүлээрээ тус тус байх харагдлаа. Эр гахай өрхийн тэргүүн болж ирээд гэр бүлийг өмгөөлөн хамгаалагч ажээ. Үр хүүхэд тэжээн тэнхрүүлэгч эм гахай түүний өмгөөлөлд оршино. Бие гүйцэж чийрэгжсэн “эхнэр хүүхэдгүй” залуу гахайнууд бусдаас зайдуу бужигналдаж ноцолдоно.

Далайн гахай тун болхи үсрэлтээр газар дээгүүр мөн ч их зүдэргээтэй явдаг ажээ. Тэр эхлээд хойт хөл дээрээ оцойж хамаг биеэ урагш хаядаг бөгөөд дараа нь урьд тавхайгаа нугалан авч цээжин дээрээ хэвтэн нуруугаа үүдийлгээд бөгсөө татаж явдаг юм. Түүний дараа дахиад л хойт хөл дээр босч эхэлнэ. Тэгээд дээрх хөдөлгөөнийг давтан үйлддэг байна. Хэдийгээр тэр газар дээр тэдний болхи боловч өөрийн нэн их уян сээр нуруу шувтан аарцаг өтгөн болж ирээд богино үс, хальслаг сарвуу зэргийнхээ хүчээр усан дотор онцгой шаламгай ажээ. Усан дээр ил гарах буюу газар дээр гарсан хойно амарч хэвэхдээ сууж харагдана.

Тэдгээр ухаалаг амьтад хэдий цэлгэр уудам магнайтай болохыг Консельд би анхааруулав. Сүүгээр бойжигчдын дотор далайн гахайтай эн зэрэгцэх их тархитай амьтан хүнээс өөр нэг ч үгүй билээ. Тийм ч учраас далайн гахайг элдэв зүйлд амархан сургаж болдог юм. Тэд хүнд дасахдаа тун амархан бөгөөд зарим байгальчид тэднийг хэрэв зохих ёссор сургаж чадвал, загас барихад болон далайд ангуулчлахад хүнд нохойноос дутахгүй тус болно гэсэн зүйлийг би хуваалцдаг юм.

Биднийг явж өнгөрөх үед далайн гахайнуудын дийлэнх нь унтаж байв. Эрэг орчин элс хадан дээр долгиолог урт шируун сахал бүхий зузаан дээд уруултай, метр хагасаас хоёр метр хүртэл урт биетэй далайн ердийн гахайнуудыг үзэв. Тэдний чих нь бараг үзэгдэхгүй байсан бөгөөд чихний нь оронд жижигхэн товгор гурвалжин юм харагдаж байв.

Мен энд далайн гахайн нэгэн төрөл болох далайн заан байх нь харагдав. Тэд богино боловч заан мэт хушуутай ажээ. Уртаараа арван метр хүрдэг тэдгээр аврага амьтан биднийг юманд бодож анхаарахгүй байлаа.

- Эд чинь гайгүй байгаа? Аюулгүй биз? гэж Консель

- Зүгээр. Хэрэв л оролдохгүй бол гэж би хариулаад ганцхан тэдэн рүү довтолбол ялангуяа зулзага руу нь халдвал тэд аймшигтай догширдог юм. Болгоомжгүй ангуучдын завийг зомгол болгож хаясан явдал ч бий гэлээ. Консель:

- Хөөрхий тэдний түмэн зөв гэж байлаа.

- Маргах юм алга.

Цаашаа хоёр миль явсны дараа далай руу нэн их гүнзгийрэн тохойн усыг өмнөтийн салхинаас халхалсан, уртаас урт хадан хушуу бидний замыг хаачихав. Түүний хадад эгц дээшээ элэглэн эрэглэж хаяа хормойг нь далайн давалгаа хөөсрөн дэлсэж байв.

Яг энэ орчинд бид, ямар нэгэн хивдэг амьтдын сүрэг билчээрлэн яваа мэт, чанга чанга мөөрөх дуу гэнэт сонслоо.

- Үхэр энд яагаад байдаг билээ? гэж Консель асуухад би;

- Үхэр биш ээ хө, энэ чинь далайн илжиг.

- Тэд зодолдож байна аа?

- Эсхүл зодолдож байна, эсхүл тоглож байна.

- Эзэн хэрэв зөвшөөрөхсөн бол тэднийг би үзэхийг хүсэх байнам.

- За тэгвэл явж үзье, Консель со! Бид дахин хар хүрмэн хад даган явлаа. Бид үхэр чулуун дунд үсрэн дүүлэн, заримдаа мөсөнд өнгөлөгдсөн толигор гадаргуу дээр нь гулгаж хальтран явлаа. Би хэд дахин бү дэрч унахдаа хөл гараа ихэд өвтгөлөө.

Миний дэргэд нилээд хянуур болж ирээд тогтвортойгоороо Консель маань намайг татаж босгох болгондоо;

- Эзэн хэрэв хоёр хөлөө сайн алцайж, хол тавьж явбал тэнцвэрээ олоход амар байхсан гэж хэлж явав.

Бид хадан хушуун дээр авиран гарч ирвэл цасанд хучигдсан уудам хөндий дүүрэн бужигнаж буй илжигний их сүрэг олж харав.

Тэд тоглон наадаж буй ажээ. Бидний чихэнд сонсогдсон шуугиан хөгжөөн наадмын чимээ болохсос биш хэмхэлдээн тулалдааны дуу биш байжээ.

Илжигний сүргийг тойрсны дараа би буцахыг шийдлээ. Өглөөний арван нэгэн цаг орчим байв. Хэрэв л цаг агаарын байдал тохитой байж капитан Немо ажиглалтаа хийж чадах бол би тэр орчны орших цэгийг тодорхойлоход өөрийн биеэр байлцахыг хүсч байлаа.

Үнэндээ ч үүнд итгэхэд хэцүү байв. Тэнгэрийн мандлыг битүү хулдсан өтгөн үүлс нарыг халхалж байлаа. Ертөнцийн тэрхүү атаархуу галт бөмбөлөг дэлхийн энэхүү далд, онцлогийг хүмүүсээс нуухын тул зориут нуугдах мэт ажээ.

Бид хоёр хад хясаалаг сэрвэнг тойрсон нарийхан зөргөөр орж явлаа. Арван нэг хагасын үед бид завинаас буусан газраа хүрч ирэв. Капитан Немо хүрмэн чулуун хадны оройд хэдийн зогссон байв. Түүний хөлийн дэргэд астрономии багажууд байх

харагдана. Түүний хари үүлэн цаанаас үл харагдан буй наран зүг, умар тийш үл чавчлан ширтэж байв.

Би түүнтэй зэрэгцэн үг дуугүй хүлээн зогслоо. Үд дунд болов. Гэвч урьд өдрийн нэгэн адил нар ил гарсангүй.

Хэрэв л маргааш нар үл үзэгдвэл өмнөт туйлын орших цэгийг тодорхойлох оролдлогоос татгалзахаас өөр аргагүй болжээ.

Өнөөдөр гуравдугаар сарын 20 билээ. Маргааш гуравдугаар сарын 21-нд, хэрэв л нарны гэрэлт цацралтыг эс тооцвол, нар үл үзэгдэж, бүтэн зургаан сар үргэлжилж өмнөт туйлын урт шөнө эхлэх байв..

Өдөр шөнө тэнцэх есдүгээр сарын тэнцлээс хойш бөмбөрцгийн умарт хэсэгт мандсан наран гийчин арван хоёрдугаар сарын 21-ныг хүртэл улам бүр уртсах тойруу замаар дээш дэгдэх бөгөөд тэр үед, бөмбөрцгийн өмнөт хагаст зуны нарны мандал улам бүр доошилсоор эцсийн эцэст, маргааш, өөрийн сүүлчийн туяаг антрактитийн дээгуур цацаргах ёстой байлаа. Би өөрийн энэхүү зовнилыг капитан Немотой хуваалцвал:

- Таны зөв, эрхэм профессор хэмээн тэр хариулж, хэрэв маргааш, гуравдугаар сарын 21-нд далайн төвшин дээр мандсан нарны өндрийг би тодорхойлж эс чадвал энэ явдлыг зургаан сараар хойшлуулахаас өөр замгүй. Гэвч, маргааш нарны хэрвээ ядаж эгшин зуур боловч цухуйвал далайн төвшин дээрх нарны өндрийг олоход надад хялбар болох юм. Учир нь бид өөрсдийн хувь тохиолоор өдөр шөнө тэнцэхийн яг өмнө энэ газар ирсний үр билээ.

- Яагаад, капитан?

- Яагаад гэвэл нар дэндүү дээгүүр аялах цагт далайн төвшин дээрх түүний өндрийг тодорхойлоход тун хүнд байдаг юм. Тийм үед хэмжих багажийн заалт тэр болгон зөв байдаггүй.

- Тэгвэл маргааш юуны нь ялгаа байна?

- Маргааш би ганцхан л хронометрийн тусламжтайгаар бусад багаж хэрэглэхгүй, нарийвчилсан ажиглалт хийж чадах юм. Хэрэв маргааш, гуравдугаар сарын 21-нд үд дунд, нарны хүрээ түүний гэрлийн хугаралтыг бодолцолгүй яахав, далайн умарт төвшинд яг таалагдсан байвал бид яг өмнөт туйл дээр байна аа гэсэн үг.

-Тиймээ тэр ч тийм шүү- хэмээн өгүүлж, гэвч нөгөө талаар авч үзвэл, өдөр шөнө тэнцэх тэр эгшин үд дундтай тохирдоггүй тул таны тэр тодорхойлолт яг таг нарийвчлан гарахгүй шүүдээ гэлээ.

-Түүнийг би мэднэ ээ ноён профессор гуай, тэгэвч тэр нэгэн ялихгүй зөрөө хэдхэн

зуун метрийн алдаа болох тул миний гол зорилгод ямар ч нөлөөгүй юм. За, тэгээд маргааш больё, баяртай гэв.

Капитан Немо “Наутилус”-таа эргэж одлоо. Консель бид хоёр эрэг орчныг судлан шинжилж оройн таван цаг хүртэл байв. Хэрэв ер бусын том хэжжээтэйгээрээ бидний анхаарлыг татсан пингвиний өндгийг эс тооцвол сонирхолтой зүйл бид олсонгүй Ямар нэгэн дүрс үсэг мэт цэг зурвас зэргээр сараачигдан цоохорлогдсон, хөх.цэнхэр өнгөтэй хэнд ч хэрэггүй мөртлөө этгээд чамин эдлэл мэт тэрхүү өндгөнд сонирхсон дурласан хүн мянган франк ч тоолохсон буйзаа. Тэр өндгийг би Консельд гардуулж, миний хянуур туслагч хэмжээгүй их үнэт хятад ямпий авч явах мэт бөөцийлсөөр явж «Наутилус» дээр авч ирвэл тэр, музей үзвэрийн нэгэн шилэн гуун дотор байр сууриа оллоо.

- Би хоолон дээр далайн гахайн элэг нэн хорхойтой идэж орхивол амтаараа тэжээвэр гахайн махтай адил байлаа. Дараа нь би маргааш үд дунд нар гийчнийг мандан бадарч хайрлахыг урьдаар урин дуудахыг наранд бишрэн шүтэгч индианчууд мэт мартсангүй дуудаад хэвтэж унтлаа.

Маргааш нь гуравдугаар сарын 21-нд өглөөний тавам цагт намайг онгоцны тавцан дээр гарч очиход, капитан Немо тэнд зогсч байв.

- Тэнгэр цэлмэж байх шиг бололтой хэмээн тэр надад хэлж би найдах тийшээ хандаж байна. Өглөөний зоогны дараа хэдүүлээ эрэг дээр гарч ажиглалт хийхэд аятай байр сонгон авъя гэлээ.

Капитантай хэлэлцэж тохироод би Нед Ленд руу явав. Түүнийг би эрэг дээр хамт гаръя гэж урихыг хүссэн билээ. Гэвч гөжүүд тэр хүн эрс татгалзав. Түүнийг би өдөр өнгөрөх тутам нэг л царай нь барайгаад, ааш нь этгээд болоод буйг ажсан бүлгээ. Гэвч энэ удаа түүний тэр зөрүүд зан миний урмыг төдий л хугалсангүй. Учирнь эрэг дээр далайн тоо тоймшгүй олон гахай байгаа тул нүглээ үл наминчилдаг энэ нэгэн хүнд тэднийг хий дэмий бүрэлгүүлэн сүйтгүүлэх хэрэггүй байв.

Өглөөний зуушны дараа би эрэг тийш одов. “Наутилус” шөнөдөө өмний зүг мөн бас хэд хэдэн миль холдсон байв. Одоо эргээс дөрвөн километрийн зайтай газар задгай далайд зогсож байв Эрэг дээр дөрвөөс таван шовх оргил ёрдойж харагдав. Биднийг эрэг хүргэж яваа завинд капитан Немо “Наутилус”-ын багаас хоёр далайчин Консель бид хоёр бүгд тавуул явав. Капитан өөрийн биед хронометр, холын дуран, агаарын даралт хэмжих барометр хэмээх хялбар ажиллагайтай цөөн тооны багаж авч гарчээ.

Эрэг хүрэх тэр завсраа бид хэд хэдэн халимтай дайралдлаа.Тэдгээр сүүгээр



бойжигч аврага амьтан далайн амгалан уснаа сүрэг сүргээрээ тоглон бужигналдаж явах бөгөөд хүн хүрч үл чадах энэхүү өмнөт туйлын усан сан хайр гамгүй хөнөөгддөг халим мэтийн амьтдын амь хоргодох найдвартай мухар санжээ гэдгийг би ойлголоо.

Бид есөн цагт эрэгт хүрлээ. Тэнгэр цэлмэж, үүл өмнө зүг нүүж байв. Манан ч аажимдаа замхарлаа. Капитан Немо түрүүчийн уул өөд шууд зүглэн алхав. Бодвол тэр ажиглах байраа тэнд хийхээр шийдсэн биз. Мөстөж хөлдсөн гулгамтгай хад өөд авирах гэдэг тун хүнд байлаа. Гэвч капитан Немо хамгийн хэцүү эгц чавчим энгэр өөд нэн шаламгай авирах бөгөөд түүнийг янгирын анчин харсан бол үхтлээ атаархахсан билээ. Би арай чуу л гэж түүний хойноос амжин дагалдаж түүний шалмаг хурданд нь гайхан гүйж явлаа. Түүгээр ч барахгүй хуурай газраар явж дадаагүй тэр далайчин хүн хэрхэн тиймэрхүү цовоо болохыг гайхаж билээ.

Хоёр цагийн турш бид авирлаа. Оргилын шовх орой дээрээс бидний өмнө умарт зүгт үргэлжилсэн цул хавтгай мөсний ирмэглэсэн тод зурвас бараа, задгай далай агуу сайхан үзэмжтэй ялгаран үзэгдлээ. Бидний авирч гарсан өндрийн энгэр хормойд нүд гялбам хурц өнгөт цаст цагаан тал налайж байв. Бидний толгой дээр тэнгэр шингэн цэнхэр өнгөтэй болж ирээд үүлгүй байв. Умарт зүгт нарны дугариг хүрээ доод талаасаа далайн төвшний зурвас шугамаар зүсэгдсэн мэт харагдав. Халим загасууд тургиж байгаа олон зуун усан оргил далай дээр олгойдож байв. Алсад, задгай далайн дунд “Наутилус” унтаж буй халим мэт үзэгдэв, Өмнө ба дорно зүг хад чулуу эмх замбараагүй онгиролдсон хуурай газар үргэлжлэх нь нүдний хараа шалгах мэт ажээ.

Капитан Немо оргилын орой дээр гармагц, юуны өмнө өөрийн ажиглалтанд засвар оруулахын тул, бидний авирч гарсан толгойн өндрийг барометрийн тусламжтайгаар тодорхойллоо.

Арван хоёрт арван таван минут дутуу байхад агаар хугарсан гэрлийн цацралын улмаас өдий болтол ил мэт харагдаж агсан нар далайн төвшин дээр хөөрөн гарч ирээд, өөрийн гал улаан туяагаар одоо болтол биднээс өөр нэг ч хүн хөвж үзээгүй далай, эзгүй орхигдсон хоосон цөл газрыг гэрэлтүүлж билээ.

Капитан Немо нүдний харааг хуурах гэрлийн хугаралтыг үгүйсгэхээ тусгай толь бүхий алсын дурангаар мөсөн цөлийн умарт төвшин дээгүүр нэн урт нум үүсгэн аялж буй галт ертөнцийг дагуулан дурандаж эхлэв. Тэр завсар би гартай хронометр барьж хувиар бүхий дэнсэн дээгүүр нь аажмаар урагшлан буй зүүг нь ширтэж байв. Миний зүрх ширүүсэн цохилж гарлаа. Хэрэв л нарны тэн хагас нь далд орох тэр эгшинд яг жин үд болж тохирвол би өмнөт туйл дээр байна гэсэн үг.

- Яг жин үд боллоо! гэж бахиртал,

- Мөн, өмнөт туйл: хэмээн капитан Немо үнэн догдолсон сэтгэлээсээ надад хариулж бипээ. Тэр надад дурангаа шилжүүлэн өхөд би түүнийг нүдэндээ авч харвал газар тэнгэр хоёрын яг зааг дээр буй нарны алтан шаргал хүрээний тэн хагас нь алга болсон байв.

Нарны сүүлчийн цацрал оргилын шовх оройг гэрэлтүүлэх тэр үед шөнийн хар сүүдэр түүний хормойгоос энгэр талыг нь даган дээшлэн мөлхөж байв.

Капитан Немо, миний мөрөн дээр гараа тавимагц өгүүлрүүн:

- Эрхэм профессор та аан гэж бай. Анх 1600 онд Герик гэгч Голланд хүн далайн салхи шуурга, ширүүн урсгалд автан хөвсөөр өөрийн онгоцтойгоо өргөргийн 64 дахь хоног хүрч өмнөт Шотландын арлуудыг нээсэн юм. Дараа нь алдарт капитан Кук 1773 оны арван нэгдүгээр сарын 17-нд гучин наймдугаар уртрагийн дагуу хөвсөөр өмнөт өргөргийн 67 дахь хоног 30 хувь хүрсэн ба дараачийн нь 1774 онд зуун есдүгээр уртрагийг дагаж явсаар, нэгдүгээр сарын 30-наа өмнөт өргөргийн 71 дахь хоног, 15 хувь хүрчээ. 1819 онд оросын шинжээч Беллинсгаузен жаран есдүгээр өргөрөг дээр очсон ба хоёр жилийн дараа 1821 онд өрнөт уртрагийн III дахь хоног дээр жаран зургадугаар өргөрөгт тулжээ. 1820 онд Брунсфильд хэмээх англи хүн жаран тавдугаар өргөрөг хүрээд мөсөнд боогдсон юм. Яг тэр жил Морель гэгч америк хүн дөчин хоёрдугаар уртрагийг дагаж явсаар өргөргийн 70 дахь хоног 14 хувьд задгай далай байхыг харсан гэх боловч түүний мэдэгдлийг дүүрэн итгэхэд найдлагагүй байсан юм. 1825 онд Поуэль гэдэг англи хүн өргөргийн 62 дахь хоногоос цаашлахад мөс саад болжээ. Гэвч яг тэр жил Ведель гэгч англи хүн, далайн гахайн жирийн нэгэн ангуучин уртрагийн 35 дахь хоногт өргөргийн 72 дахь хоног 14 хувь ба мөн уртрагийн 36 дахь хоногт өргөргийн 74 дахь хоног 15 хувь хүрчээ. 1829 онд “Шантеклер” хөлгийн капитан Ферстер өргөргийн 63 дахь хоног уртрагийн 66 хоног 26 хувьд “Антрактит тив”-ийг нээжээ. Мөн 1831 оны хоёрдугаар сарын нэгэнд английн харъяат Бискоэ гэгч өргөргийн 36 хоног 50 хувьд Эндербийн газрыг нэг жилийн дараагаар 1832 сны хоёрдугаар сарын таванд өргөргийн 67 дугаар хоногт Аделандын газрыг, хамгийн сүүлд хоёрдугаар сарын нэгэнд өргөргийн 64 хоног 45 хоногт Гразмын газрыг тус тус нээсэн юм. 1838 онд өргөргийн 62 дахь хоног 57 хувьд үргэлжилсэн хавтгай мөсөнд боогдсон Францын далайч Дюмон Дюрвиль, Луифилиппийн газрыг хоёр жилийн дараагаар 1840 оны нэгдүгээр сарын хорин нэгэнд 66 хоног 30 хувьд Адели арлыг, түүнээс бас найм хоногийн сүүлд 64 дахь 40 хувьд Кларис арлыг тус тус нээжээ. 1838 онд Уилкс гэгч англи хүн зуудугаар

уртрагийг даган явсаар өргөргийн 69 дахь хоногийг хүрсэн. Бас 1839 онд английн харъяат Балленни гэгч өөрийнх нь нэрээр нэрлэсэн арлыг нээжээ. 1842 сны нэгдүгээр сарын хоринд “Эребусс” ба «Терроре» гэдэг экспедицийг толгойлж явсан Джемс Рос гэдэг англи хүн өргөргийн 76 дахь хоног 51 хувь, дорнот уртрагийн 171 хоног 7 хувьд викторин газрыг, мөн тэр сарынхаа хорин гурванд далан дөрөвдүгээр өргөрөг хүрч өмнөт зүг өөрөөсөө урьд өмнө зорчигч хэн нэгнээс алс хол гарчээ. Мөн тэр далайч нэгдүгээр сарын хорин долоонд өргөргийн 76 хоног 8 хувьд хорин найманд 77 дахь хоног 32 хувьд, хоёрдугаар сарын хоёронд 78 дахь хоног 4 хувьд тус тус хүрчээ. Дараа нь Рос 1842 онд антарактитэд эргэж ирсэн боловч өргөргийн 71 дахь хоногоос хэтэрч чадаагүй юм. Ингээд хамгийн эцэст, капитан Немо би энэ 1868 оны гуравдугаар сарын 21-нд өмнөт өргөргийн 90 дахь хоног буюу өмнөт туйлд хүрч, газрын бөмбөрцгийн энэ нэгэн хэсгийг эзэмшилдээ авлаа гэв.

- Чухам хэний нэрийн өмнөөс та энэ нэгэн тивийг эзэмшилдээ авч байгаа билээ; капитан аа?

- Өөрийн нэрийн өмнөөс дөө, ноён профессор оо? гэж хэлчихээд тэр “Н” гэсэн үсэг алтаар хатгасан том хар далбаа дэлгэн сүүлчийнхээ цацраг туяа бадран буй нарны зүг хандаж,

- Нар минь баяртай! Цацран бадрагч галт дэнлүү далд ор! Энэхөө чөлөөг задгай далайд умбан орж, миний шинэ эзэмшлийг шөнийн хар сүүдрээр зургаан сар хуч! хэмээн өгүүллээ.

[Тор](#)

---

### ЗАНГАНД

- Маргааш нь гуравдугаар сарын 22-ноо, өглөөний зургаан цагт “Наутилус”-аар буцах аян замдаа бэлдэж эхлэв. Оройн бүрэнхийн сүүлчийн гэгээ шөнийн харанхуйд шингэн орлоо. Хүйтэн жавар мэдэгдэхүйц чангарав. Баарцагласан одод тэнгэрийн тагт гайхмаар тод яралзан байна. Халз орой дээр бөмбөрцгийн өмнөт хагаст алтан гадсыг орлон гялалзах оддын нэгэн өмнөтийн загалмай нүд гялбам хурц өнгөөр бадранамой.

Термометр тэгээс доош 12 градус зааж, жавар салхи нүүр хайрч байлаа. Задгай далайн эрэг орчноороо өрөмтөн хөлдөж байх нь юу юугүй л бүх далай тэр чигээрээ

түс тас хөлдөх гэж буй мэт ажээ. Бүтэн зургаан сар үргэлжлэх шөнийн турш, өмнөт туйл орчны усны сан нэвтэршгүй болдог нь харваас мэдээж хэрэг байв. Тэр үеэр халим хайчдаг бол? Тэд мөсөн доогуур явсаар үл хөлдөх далайд очдог нь бүгдээс үнэн бизээ Хахир хатуу хүйтэнд дадаж дассан далайн гахай ба илжгүүд энэхүү мөсөн оронд үлдэж хоцордог ажээ. Эдгээр амьтан мөсөн цөлд өөрсдөө цоолго хийж чаддаг бөгөөд түүнийгээ хэзээ ч битүүрүүлж хөлдөөдөггүй юм. Тэр л цоолгоороо тэд амьсгалдаг ажээ. Жавар хүйтэнд туугдсан жигүүртэн шувууд умарт газар нилээд дулаан орноо нүүж ороход далайн гахай илжиг туйл орчны эх газрын эрх хэмжээ хязгааргүй эзэн нь болдог юм.

Тэр завсяр “Наутилу” багтаамжуудаа усаар дүүргэж аажмаар доош орж эхлэв. Мянган футийн гүнд түүний сэлүүр сэнс нь ажиллаж эхэлж, хөлөг онгоц маань умарт зүгийг барин цагт арван таван милийн хурдтай давхиж гарлаа. Орой тийшээ бид үргэлжилсэн цул мөсний асар зузаан адар доор орлоо.

“Наутилус” ямар нэгэн хөвөгч мөстэй мөргөлдөж болох тул болгоомжлохын үүднээс үзэсгэлэн танхимын цонхыг халхавчаар нь бин битүү хаасан бүлгээ. Тийм учраас би өөрийн тэмдэглэлийг цэгцэтгэх ажилд бүтэн өдөр зориуллаа. Ингээд би өмнөт туйлд учирсан үйл явдлын тухай дурсан санаж өөрийн бодолд бүрмөсөн шингэн орлоо.

Манай хөвөгч онгоц тэр зүгт төмөр замаар гулган гулгасаар очсон мэт бид дэлхийн бөмбөрцгийн тэр нэгэн цэгт нэн тааламжтай, ямар ч ядаргаагүй явж хүрсэн билээ.

Одоо бид мөн л тэр байдлаараа буцах замдаа орлоо. Энэ зам дээр биднийг ямар нэгэн шинэ сонин зүйл хүлээж буй бол уу? Тэнгис далайн гайхамшиг гэдэг яндаж барагдах биш. Ямар нэгэн гайхамшигтай бид дахин учирна гэдэгт би бараг итгэж байлаа.

Ер бусын хувь тохиолоор усан доогуур явагч хөлөг онгоцон дээр гарсан тэр нэгэн цагаас хойш өнгөрсөн таван сар хагасын дотор бид арван дөрвөн мянган бээр буюу тавин зургаан мянган километр явж газрын бөмбөрцгийн гол бүслүүр шугамаас бараг бүтэн хагас дахин урт энэ замд хэд хичнээн аймшигт болоод ер бусын гайхамшигт адал явдлыг үзэх завшаан бидний хувьд ноогдсон гээч!

Миний үзэж өнгөрсөн бүхэн шөнөжингөө амар заяаг минь үл үзүүлэн хавдаж улайсан зовхийг минь секунд хэр ч хамхиулсангүй билээ. Кресто арлын дэргэдэх усан доогуурхи ойд хийсэн ангуучлал, Торрессын хоолойд арга буюу зогсох болсон явдал, далайн шүрэн ёроол дахь хүүр оршуулах газар Цейлоны сувд эрдэний сан,

Арабын тоннель, Виго тохойд сул хэвтсэн алт, Антлантида, өмнөт туйл...зэргийг би дурсан саналаа.

Өглөөний гурван цагт би хүчтэй доргионд цочиж сэрлээ. Би орон дээрээ босч суугаад, хичээнгүйлэн чагнаж байтал “Наутилус” гэнэт сүрхий хазайж хавиргалан ирсэн нь намайг орон дээрээс минь ховх татаж өрөөний тэг дунд хүртэл авч хаяв.

Би хана түшин явж үзэсгэлэн танхимд орж очвол тэндхийн хамаг тавилга байрнаасаа хөдөлж, зарим нь шал дээр онхолдсон байв. Аз дайрахад үзмэрийн шилэн гуунууд хөдөлгөөнгүй бэхлэгдсэн байсан тул түүн доторхи зүйлс хэм-хэрсэнгүй ээ. “Наутилус”-ын нэг талын хананд дүүжилсэн зургууд ханатайгаа наалдсан мэт байхад, нөгөө талын ханан дахь зургуудын доод зах нь хананаасаа хөндий санжигнаж байв. “Наутилус” нэг талаараа хажуулдан хэвтэж, хөдөлгөөнгүй болжээ.

Энэ үед гудам өрөөнд хүний хөлмйн чимээ гарч, хүмүүс дүнгэр дүнгэр дуу гарах снсдов. Гэвч капитан Немо үзэгдсэнгүй. Үзэсгэлэн танхимаас намайг гарах гэж явах яг тэр үед Нед Ленд, Консель хоёр орж ирлээ.

- Юу болон оо? хэмээн би тэднээс даруйхан асуувал,

- Үүн тухай би эзнээс л асуух гэж ирлээ гэж Консель хариулав.

- Хар мянган савдгийг барьж тангараглая! хэмээн Нед Ленд өгүүлээд -Би мэдэж байна, юу болсныг “Наутилус” газардсан. Хэрэв л үүний хажуулдан хавиргалснаар нь бодож үзвэл, өнгөрсөн удаа Торрессын хоолойд газардсанаас ч бат суусан даа гэв.

- Тэглээ ч гэсэн, үгүйдээ бид далай дээр ил гарсан биз? гэж миний асуухад, Консель;

- Ээ, бүү мэд гэнээ.

- Үүнийг шалгахад маш амархан хэмээн би манометр руу хүрч очив. Миний гайхаш тасрахад, түүний ззз гурван зуун жаран метрийн гүн зааж байв.

- Энэ чинь юу гэсэн үг билээ? гэж би дуун алдвал,

- Капитан Немогоос асуух хэрэгтэй хэмээн Консель хэлэв.

- Түүнийг хаанаас эрж олох юм бэ? гэж Нед Ленд дургүйцсэн янзтай байв.

- За, миний хойноос хэмээн би нөхөддөө өгүүлээд, бид үзэсгэлэн танхимаас гарлаа. Номын санд хэн ч байсангүй, Капитан Немог би жолоодлогынхоо бүхээгт байгаа гэж бодлоо. Түүнд тэнд саад болох явдал эвгүй байсан тул бид үзэсгэлэн танхимд эргэж ирэв.

Нед Лендийн гунших, үглэхийг ч ярихаа больё. Энэ удаа түүнд уурлаж буцлахын үндэс бишгүй л байв. Түүнд би өөрийнхөө гуньж гутсан сэтгэгдлээ илтгэж яншихад нь

саад хийсэнгүй; мөн түүнд харш уг дуугарсангүй.

Тиймэрхүүгээр бид “Наутилус” -ын гудам өрөөнд гарах өчүүхэн боловч чимээг чагнан хориод минут суулаа. Тэгтэл ч капитан Немо орж ирэв. Биднийг тэр харахгүй байгаа мэт байлаа. Түүний амгалан царай энэ удаа сэтгэл ихэд түгшсэн байдалтай болчихсон байв. Тэр юу ч дуугарсангүй манометр луужин хоёр руу ойртон очсоноо газрын зургийн өмнө зогсож өмнөд туйлын тэнгис орчны нэгэн хэсгийг хуруугаараа хатгав.

Түүний бодолд би саад хийхийг хүссэнгүй. Гэвч хэдэн минутын дараа тэр над руу эргэж харахад би:

- Бас л саатах болчихов уу капитан? гэж асуув.

- Үгүй ээ хэмээн тэр хариулаад энэ удаа гэнэтийн аюулд учирлаа гэв.

- Ноцтой явдал уу?

- Магадгүй.

- Аюултай юу?

- Үгүй ээ.

- «Наутилус» хайрдчихав уу?

- Тэгсэн

- Яахаараа тэр билээ?

- Байгалийн тайлбарлашгүй нэгэн тохиол болжээ, энүүнд ямар ч буруу байхгүй. Тэр эндсэн ч юм биш-харин бид л дэлхийн таталтын хуулинд саад хийх чадалгүйдээ тийм боллоо. Хүн тогтоосон хуулийг юманд бодохгүй байж болно. Харин байгалийн хууль тийм бишээ:

Энэ удаа капитан Немо хууль зүй номлох тун тохьгүй цагийг сонгон авчээ. Үнэнийг хэлэхэд тэр өөрийнхөө хариултаар надад юу ч тайлбарлан ойлгуулсангүй.

- Энэ явдлын шалтгаан нь чухам юу болсныг та надад хэлж болох уу? гэж би асуув.

- Асар том мес, өөрөөр хэлбэл бүхэл бүтэн мөсөн уул нураад далайн дулаан урсгалд доод ёроолоороо идэгдэж нарийсахаар хүндийн жингийн төв нь шилжиж онхолддог учиртай. Усан доор явсан «Наутилус» дээр тийм л мөсөн уул нурж уналаа. Хөрвөж унасан мөсөн уул доод хормойгоороо “Наутилус”-ыг хамж аваад өөд нь өргөж хажуулдуулчихлаа. - Усны багтаамж савнуудаа хоосолчихоод онгоцоо хөнгөтгөж “Наутилус”-ыг ховхолж болохгүй гэж үү?

- Үүний чинь л бид яг одоо хийж байна, эрхэм профессор минь. Та сонс л доо. Усны шахуургууд ажиллаж байна биш үү манометрийн зүүг хар! “Наутилус” дээшээ

хөвж байнка. Гэвч мөсөн уул бас хамтдаа дээшилж байна. Энэ хөдөлгөөнд ямар нэгэн юм саад хийхгүй бол бидний байдал хэвээр л байх бий.

Нээрээ л «Наутилус» хажуулдсан тал руугаа хазайсаар байв. Мөсөн уул өөрийн хүндийн шинэ төвийг тойрч эргэлдэхээ больсон цагт тэр тэгширч ердийн байдалдаа орох нь эргэлзээгүй ээ. Гэвч мөсөн уул хавтгайрсан цул мөсний доод талд торж эргэлдэхээ зогсох ч юм уу, эсхүл бид асар их хүчээр мөсөнд шахагдаж, магадгүй хоёр мөсний хооронд няц дарагдах ч юм уу, хэн яаж мэдэх билээ?

Гэнэтийн аюулд автсан «Наутилус»-т тохиолдож болох бүх л талын хөнөөлийн тухай би бодолхийлэн байх завсар капитан Немо манометраас нүд салгахгүй байв. Мөсөн уултай мөргөлдсөн цагаас хойш «Наутилус» зуун тавин футийн өндөрт өргөгдсөн боловч, түүний хазайлтын өнцөг хуучин хэвээр байв.

Гэтэл усан доогуур явагч манай хөлгийн их бие гэнэт их доргив. Ажваас «Наутилус» тэгширч байлаа. Үзэсгэлэн танхимын хананд дүүжлээстэй зургууд хуучин байрандаа орж, хана туурга ч ман янзандаа болж бий нь харваас илэрхий байв. Бид бүгд анхаарлаа төвлөрүүлэн дуу чимээгүй байцгаав. Онгоцны их бие хэдий аажуу, удаан тэгширч байвч бид амьсгаа даран ажиж байлаа. Тэгтэл ч үзэсгэлэн танхимын шал тэгширч ирлээ.

- Ашгүй нэг сая тэгшрэв шив! гаж дуугарав.

- Тэглээ хамаэн хэлэх зуураа капитан Немо үүдрүү зүглэв.

- Бид одоо дээшээ хөвж гарах уу? гаж би асуувал

- Гаралгүй яахав. Усны багтаамжууд бүгд хоосроогүй шүү дээ. Шахуургууд бүгдий нь сулламагц л “Наутилус” дээшээ хөвж гарна гэж тэр хариулав.

Капитан Немо гарч одлоо. Түүний тушаалаар усны шахуургууд ажиллахаа зогсов. Тэхээрээ «Наутилус» дээшээ хөөрч байгаа хэрэг. Хэрэв л энэ чигээрээ хөөрөөд байвал бид үнэхээр дээрээ байгаа үргэлжилсэн хавтгай мөсний дороос мөргөчихнө гэсэн үг. Тиймээс энэ л орчиндоо үлдсэн маань дээрсэн билээ.

- Бидний аз дайрахад хялбархан мултрав бололтой! гэж Консель хэлэв.

- Тэглээ. Тэр мөсөн уулс биднийг амархаан няц дарчих байсан. Үгүйдээ, хамгийн сайндаа л биднийг нэг насаар маань олзолчих байсан. Тэгсэн цагт бид амьсгалах агаараа дахин сэргээх бололцоогүй болбол уу... Ай, бид ч автай л гарлаа:

- Үнэхээр л бид, бүрмөсөн мултарсан бол ч яахав? хэмээн Нед Ленд намуухан дуугаар өгүүлэв.

Би канадын харъяаттай дэмий маргахыг хүссэнгүй тул түүний өөлсөн үгэнд хариу өгсөнгүй.

Тэр минутад үзэсгэлэн танхимын цонхны халхавч сөхөгдсөн тул бид тэр зүг ухасхийн очлоо.

Прожекторын гэрэл усыг гэрэлтүүлж биднээс арваад метр зайтай толь мэт гялгар мөсөн хана онгоцны хоёр талаар сүндэрлэн байлаа. Тэр мөсөн хана бидний толгой дээрээс өнгийх нь нүсэр лут адар адил ажээ. Бидний доод талд хөмөрч унасан мөсөн уул хажуу хананд тулгуур цэгээ олж бат бэх суурьшин, бидэнд шал болж “Наутилус” өргөнөөрөө хорин метр, ёстой л нэг мөсөн тоннельд хашигджээ. Хэдэн зуун метрийн гүнд живэн орж хавтгайран үргэлжилсэн цул мөсний орчноос гарахын тул эсхүл урагшаа, эсхүл арагшаа явж түүн дороос саадгүй мултарч чадах байв.

Онгоцны таазны чийдэн асахгүй байгаа хэдий боловч үзэсгэлэн танхим хурц гэрлээр гэрэлтүүлэгдсэн байлаа. Энэ нь “Наутилус”-ын прожекторын гэрэл мөсөн хананд тусч эргэж ойн цацарсных билээ.

Тэрхүү гайхамшигт гэрэлтүүлгийн шидэт чанарыг би үгүүлэн ул чадах нь мөсний эмтэрхий бүр, өнцөг, ирмэг бүр өөрийн таласжсан хэлбэр дүрсээс шалтгаалж, өнгө өнгийн туяпа цацарган байсны учир бизээ.

Энэ нь бүх л төрлийн гэрэл туяа цацарган байх бадмаараг доржпалам мэт эрдэний үнэт чулуудын яндаж баршгүй их сан хуримталсан мэт ажээ. Прожекторын гэрэл, далайн гэрэлт цамхгийн зузаан шилний цаана буй дэнгийн гэрэл ихсэх мэт хэдэн зуу дахин нэмэгдсэн байв.

- Ай юутай гоё вэ! Юутай нүд гялбам гуа үзэсгэлэнтэй вэ? хэмээн Консель хөхөж байв.

- Тиймээ. Энэ бол мартагдашгүй үзэгдэл! Тийм биш гэж үү, Нед ээ? гэж би өгүүлэн;

- Тиймээ, чөтгөр ав? Тэр үнэн хэмээн канад хүн зөвшөөрч, үүнийг би дуртай ч, дургүй ч зөвшөөрөө болсондоо дотор минь цухалдана. Би хэзээ ч үүнтэй төстэй юм олж үзээгүй: Гэвч би энэ сайхныг үзсэнийхээ хариуд муугаа үзэх бий гэж санаа зовж байнам. Байгаль ер нь өөрийнхөө хамгийн гүн үнэт нууцад хүн оруулах дургүй юмдаг шүү гэв.

Нед Лендийн зөв байлаа. Энэ нэгэн үзэгдлийг хүн олж үзэхэд дэндүү сайхан ажээ. Тэгтэл Консель гэнэт хашгарахад би эргэж:

- Юу болов? хэмээн асуувал.

- Эзэн нүдээ ань! Эзэн бүү хар! гээд Консель хоёр гараараа нүдээ дарчихав.

- Миний нөхөр яав чи?

- Нүд-нүд, нүд минь! гэлээ.



Би өөрийн эрхгүй цонхны зүг эргэсэн боловч нүд сохормоор гялбам хурц гэрлийг харж чадсангүй тул нүдээ буруулав.

Юу болсны учрыг би олсонгүй. Тэхнээ нь “Наутилус” эрч аван урагшилсан юмсанжээ. Биднийг зогсож байх үед аажуухан бадарч байсан прожекторын гэрэл нүд гялбам хурц, багц зурвас болон цацарч алмас эрдэний гялгар түг түмэн цацраг туяа тууш нэгэн баглаа болж бадраад «Наутилус» цахилж цойлон буй цахилгаан цацраг дунд довтолж байв.

Тэгтэл үзэсгэлэн танхимын цонхны халхавчууд хаагдлаа. Гэрэлд бид нүдээ гараараа дарсаар боловч нар өөд удаан харсны дараа, нүдний урдуур дугуй дугуй цагаан цагираг жирэлзэн байдэг шиг тийм л дугуй юмнууд бидний нүдний урдуур нүүж байв.

Бид юм сайн харж чадах болтол нилээд цаг өнгөрлөө, Тэг тэгсээр сая нэг юм бид нүдээ нээж гараа авав.

- Ийм юм болсон гэж хэрэв надад хүн ярьсан бол би үнэмшихгүйсэн, бүр нээрээ шүү! хэмээн Консель хэлэв.
- Тэгвэл би, одоо ч гэсэн үнэмшихгүй байна гэж канад эр илтгэж байв.

Байгалийн өдий олон гайхамшгийг үзэж сэтгэл ханасан бид хуурай газраа эргэж очсон цагт, эх газрын элдэв юмс, хүний гараар бүтээгдсэн зүйлс ямар хөөрхий санагдах бол: Үгүй ээ, манай мэтийн ердийн нэг ертөнц, одоо бидний сэтгэлийг хангаж чадахаасаа өнгөрчээ.

Хэрэв л Консель, амгалангаас амгалан энэ нэгэн Фламанд хүн ингэж ярьж байвал бид бүгдийн урам зориг хэдийчнээн байсныг төсөөлж болох бизээ. Гэлээ ч гэсэн манкай Канад эр өөрийнхөө халбага давирхайг бидний торх баланд холихгүй байж чадсангүй.

- Эх газрын элдэв юмс гэнэ ээ? хэмээн тэр толгой сэгсрэн байж - санаа бүү зов, хонгор минь! Бид тэр эх газры чинь дахиад хэзээ ч эргэж харахгүй гэв.

Өглөөний таван цаг орчим байв. Тэр үед онгоц гэнэт сүрхий доргисон нь онгоц маань урьд талаараа юм мөргөчих шиг болов. “Наутилус”-ын мөргүүл мөс хөндлөө гэдгийг би мэдсэн билээ. Онгоц шургаж гарахад хялбар бус энэхүү мөсөн хонгил дотор залуурч хүн эвгүй мушгнсан бололтой. Тэр саадыг капитан Немо тойрон өнгөрч, чиглэлээ өөрчлөн бид цаашаа хонгилоо даган явна бий гэж бодож билээ. Харин тэгтэл миний бодсоноор болсонгүү “Наутилус” ухарч эхэллээ.

- Хүүе бид буцаж байх чинь гэж Консель өгүүлэв.
- Тийм байна. Мөсөн хонгил энэ талаараа битүү юм байлгүй ээ.

- Тиймээс...

- Тиймээс бид гэдрэгээ ухарч мөсөн хонгилын өмнөт онгорхойгоор гарчихгүй юу, Энэ тун хялбар хэрэг.

Би өөрөө хэдийгээр төдий л итгэлгүй байсан боловч нөхдийнхөө сэтгэлийг тайвшруулахыг оролдсон минь тэр.

Тэр завсар “Наутилус” -ын ухрах, бидний хөлөг энэ хэр хар хурдаар явлаа.

- Энэ ч аягүй л саад байна даа гэж Нед Ленд өгүүлэхэд...

- Нэгэнт л бид мултарч чадахаас хойш хэдэн цаг саатах ч юухан байхав хэмээн Консель хэллээ.

- Тиймээ хэмээн Нед Ленд хариулаад - хэрэв л бид үнэхээр мултарч чадах л юм бол гэв.

Би үзэсгэлэн танхим, номын сан хоёрын хооронд холхиж байв. Миний нөхөд зөөлөвчтэй сандал дээр амарлингуй сууцгаана Төдөлгүй би ч гэсэн сандал дээр сууж, гартаа ном аван уншихыг оролдсон боловч миний нүд мөрий нь даган хий гүйж байв. Арав гаруй минутын дараа Консель босон ирж:

- Эзэн аль зэрэг сонин юм уншиж байна гэлээ.

- Тун сонин ном гэж би хариулав.

- Би ч эргэлзээгүй л дээ. Эзэн өөрийнхөө бүтээлийг уншиж байна биш үү.

Үнэхээр тэхнээ нь би, өөрийнхөө бичсэн “Далайн ёроолын нууц” гэсэн номоо уншиж байв. Би түүнийг ер мэдсэнгүй. Номоо би хамхиж тавьчихаад дахиад л өрөөн дотуур алхалж гарлаа. Нед, Консель хоёр надад саад хийхгүйн тул суудлаасаа босон өрөө рүүгээ явахыг завдав.

- Бүү явцгаа нөхөд минь хэмээн би өгүүлээд хонгилоос гаран гартал хамтдаа байцгаая гэв.

- Эзний дур мэдэж гэж Консель хариу өчив. Тиймэрхүүгээр хэд хэдэн цаг өнгөрлөө. Би хананд өлгөөстэй багажууд руу байн байн харсаар байв. Манометрийн зүү бид үргэлж л гурван зуун метрийн гүнд буйг зааж байлаа. Луужин өмнө зүг явж байгааг илтгэн, лаг цагт хорин километр хурдалж ахуйг зааж буй нь иймэрхүү явцуу хонгилд асар их хурд байлаа. Гэвч капитан Немо минут нь жилтэй адил үнэлэгдэх ийм нөхцөлд ямар ч их хурдыг хэтэрсэн хурд гэж үзэхгүй байв.

Найман цагаас хорин таван минут өнгөрөх үед хоёр дохь удаагийн доргилт болов. Энэ удаа бид ухарч явсан тул онгоц маань бөгсөөрөө юм мөргөлөө. Тэрхэн завсар миний царай зэвхий цайж билээ. Нөхөд маань суудлаасаа босон харайж, над руу ойртон ирэв. Би Конселийн гарыг базсан байв. Бид нэг нэгнээсээ юм асуусан

янзтай бие бие рүүгээ ширтчихсэн бүлгээ. Бидний тэр нэгэн нүдээрээ харьцсан яриа өөр ямар нэгэн үгээр ярьснаас ойлгомжтой байж билээ.

- Тэр минутанд үзэсгэлэн танхимд капитан Немо орж ирэв.

Би түүн рүү гүйн очиж:

- Зам, урд талаас хаалттай юу? гэж асуувал:

- Тиймээ, ноён профессор оо, Айсберг, онхолдохдоо биднийг түгжчихлээ гэв.

- Бид занганд орчих нь тэр үү?

- Тиймээ.

[Тор](#)

---

### АГААР ДУТАГДЛАА

Тийнхүү “Наутилус” тал бүрээсээ нэвтэлшгүй мөсөн ханаар хүрээлэгдсэн бүлгээ. Бид мөсөнд тэгж олзлогдсон билээ.

Канадын харъяат нүсэр том нудрагаа ширээн дунд буулгав. Консель үг дуугүй сууна. Би капитанаас нүд салгалгүй ширтэж байв. Түүний царай дахин хэнэггүй байдалтай боллоо. Тэр хоёр гараа элгэн дээрээ зөрүүлэн тавьж бодлогошрон зогсов.

“Наутилус” хөдөлгөөнгүй зогсож байлаа. Тэгтэл, капитан Немо тэргүүлэн ам нээж:

- Эрхмүүд ээ, хэмээн нэн амгалан дуугаар - бидний байгаа одоогийн энэ байдалд амь наснаас хагацах хоёр боломж байна гэлээ.

Энэ нэгэн хачин хүн, бидний өмнө, оюутнуудад лекц уншиж буй тооны ухааны профессорын төрхтэй үг хэлж байв.

-Нэгдүгээрх нь мөсөнд няц дарагдах нэг боломж байнка. Хоёрдугаархи нь бүтэж үхэх боломж, турж үхэх боломжийг би бүрмөсөн үгүйсгэнэ. Учир нь “Наутилус” дээр байгаа хүнсний нөөц биднээс яавч илүү насална. Тиймээс үлдэх дээр дурьдсан хоёр боломжийг авч хэлэлцье.

- Миний бодоход бид бүтэж үхэхээс айх юм ер үгүй мэт санагдана, капитан хэмээн би өгүүлээд - яагаад гэвэл “Наутилус”-ын багтаамж савнууд шахсан агаар дүүрэн шүү дээ; гэлээ.

- Тэр үнээн хэмээн капитан хариулж - гэвч тэр агаар чинь биднийг зөвхөн л хоёр

хоног хангаж чадах юм. Гэтэл бид усан доор бүтэн гучин зургаан наг байхын тул онгоцон доторхи бохиртсон агаар одоо сэлбэлт хийхийг шаардаж байна. Тиймээс дөчин наймам цагийн дараа амьсгалах агаарын нөөц барагдах болно.

- Тэгвэл капитан минь, бид дөчин найман цагийн дотор эндээс мултарсан байвал зохих нь ээ?

- Тэгэхийн тул үзээд л алдна даа. Мөсөн ханыг нэвт өрөмдөөд үзнэ.

- Аль тал руугаа? гэж би асуув.

- Үүнийг бидэнд зонд хэлж өгнө. Одоо би “Наутилус”-ыг энэхүү мөсөн шоронгийн шал дээр буулгаад орхиё. Далайчид баг өмсгөл өмсч гараад хамгийн нимгэн ханатай талыг олж сонгог.

- Үзэсгэлэн танхимын цонхыг нээчихэж болохуу;

- Бололгүй яахав. Бид одоо ямар живж байгаа биш.. Тэгээд капитан Немо үзэсгэлэн танхимаас гарч одлоо. Төдөлгүй исгэрэх мэт чимээ сонсдов. Тэр нь “Наутилус”-ын усны багтаамжуудад ус дүүргэж байгаа хэрэг ажээ. “Наутилус” гурван зуун тавин метрийн гүнд мөсөн шалан дээр

- Миний найз нараа хэмээн Консель, Нед Ленд хоёр руу хандаж - бид хэдий аюултай байдалд орсон боловч та нарыг би сэтгэл санаа, хүчин зүтгэлийн хувьд эрх биш тэсвэрлэн өнгөрүүлнэ гэдэгт үл эргэлзэнэ гэлээ.

- Ийм хүнд минутанд намайг элдэв зовлон зүдгүүр тоочин гуншихгүй гэдэгт эрхэм профессор та дүүрэн итгэж болох биз. Нийтээр эсэн мэнд гарах үйл хэрэгт хэрэгтэй бүхнийг хийхэд би бэлхэн байнам гэж канад хун өгүүлэв.

- Сайхан үг байна Нед гэж би канад хүний гарыг атган хариулав.

- Түүн дээр нэмж хэлэхэд хэмээн тэр үргэлжлүүлж, би зээтүү эзэмшихдээ жад шидэхээсээ дутуугүй тул хэрэв би капитан Немод хэрэгтэй бол, тэр миний хүчийг өөрийн дураар ашиглаг гэв.

- Таны тусламжаас тэр татгалзахгүй гэдэгт би үл итгэнэ .Явъя, Нед ээ!

“Наутилус”-ын багийнхан усан доор орох өмсгөл өмсч буй хувцасны өрөөнд канад хүний хамт би явж орлоо. Капитан Немод би канад хүний үгийг дамжуулбал тэр, Нед Лендийг хүлээн авав.

Нед Ленд далайчдын нэгэн адил өмсгөл баг өмслөө. Тэд, хүн тус бүр хийн савнаас цэвэр агаараар цэнэглэсэн румкорфийн аппарат маравчилсан нь «Наутилус» дээрх амьсгалах агаарын нөөцийг хорогдуулж буй боловч тэр гарзыг дэмий үрэгдэл гэж үзэж болохгүй байв. Харин тэрхүү хурц гэрэлтүүлэгдсэн усан дотор румкорфийн дэнлүү өчүүхэн ч хэрэггүй ажээ.

Нед Лендийг өмсгөл баг өмссөний дараа би үзэсгэлэн танхимд эргэж ирвэл, түүний цонхны халхавчууд сөхөгдсөн байв. Конселийн хамт би цонхны дэргэд сууж “Наутилус”-ыг хүрээлсэн мөсөн хана хэрэм рүү ширтэж билээ.

Хэдэн минутын дараагаар өмсгөл багтай арван хоёр хүн онгоцноос гарч мөсөн шалан дээр буухыг бид харав. Тэдгээрийн дунд Нед Лендийг өндөр нуруугаар нь амархан таньж болох байв. Тэр бүлэг хүмүүс дунд капитан Немо ч өөрөө бас байлцав.

Мөсийг бутчин хагачиж эхлэхийн өмнө, цоолж гарвал зохих хамгийн ашигтай газраа юуны өмнө олох нь тул сорилтын хэд хэдэн цооног өрөмдөж үзэхийг капитан тушаажээ. Урт урт ган цоолтуур хажуугийн хананууд руу шөвөгдөн орж, мөсний гүн руу арван таван метр явсан боловч ус гарсангүй. Мөсөн хонгилын таазыг эвдэлнэ гэж санахын ч хэрэггүй бөгөөд тэр бол зузаанаараа дөрвөн зуун метр үргэлжилсэн цул мөсний доод ёроол билээ. Тиймээс капитан Немо мөсөн хонгилын шалыг цоочих тушаал өглөө.

Тэхнээ нь энэ чиглэлээрээ мөсөн давхаргын зузаан нь арван метрээс хэтрэхгүй ажээ. Тиймээс эндхийн мөсөн шаланд “Наутилус” багтаж шургахаар том нүх буюу барагцаалбал зургаан мямга таван зуун метр шоо дөрвөлжин мөс цөм цохин гаргаж усны авцалдаж хөлдөөгүй доод чөлөөт ус руу живж орох хэрэгтэй байв.

Усан доор орогсад уул ажилд тэр даруй шуурхайлан орж цуцалтгүй хөдөллөө. Тэхдээ капитан Немо, ажиллах нөхцөл нэн хүнд болох талыг харгалзан “Наутилус”-ыг яг халз доор нь ухуулсангү. Харин онгоцноос найман метр зайтай, онгоцны зүүн хажууд ухах шийд өгчээ. Усан доор ажиллагсад асар том хэмжээтэй зууван зураас мөсөн дээр гаргаж хэд хэдэн газар шууд ухаж эхэллээ. Тэдний зээтүү мөсний гүнд нэгэн зэрэг шигдэн орж том томоор нь ховх татаж байв. Энэ ажлын нэг сонин тал нь гэвэл, том томоороо ховхорсон мөс хувийн жингээр уснаасаа хөнгөн болох тул ховхормогц л хонгилын тааз өөд одох бөгөөд доорхи мөс хэдий нимгэрэх тутам тааз төдий зузаарч бүлгээ. Энэ явдал бидний сэтгэлийг өчүүхэн ч өвтгөсөнгүйн учир гэвэл мөсөн шал тэртэй тэргүй нимгэрч байсны улмаас билээ?

Бүтэн хоёр цагийн хүнд хөдөлмөрийн дараа Нед Ленд нилээд ядарч үзэсгэлэн танхимд эргэж ирэв. Тэрний ба түүний нөхдийн халаанд өөр хумуус гарч очиход Консель бид хоёр тэдэнтэй хамтарлаа. Бидний ажлыг капитаны туслагч удирдлаа.

Ус эхлээд надад нэн жиндүү хүйтэн мэт санагдсан боловч хэд зээтүүдсэний дараа би даруйхан дулаацав. Усны даралт гучин атмосфер байсан гээд миний ажиллахад саад болох ямар нэгэн ядаргаа үл мэдэгдсэн билээ.

Бүтэн хоёр цагийн ажлын дараагаар бага зэрэг амарч идэж уух гэж “Наутилус” дээр ирээд румкорфийн аппаратын цэвэр агаар ба “Наутилус” доторхи нүүрс хүчлээр дүүрч өтгөрсөн хүнд агаар хоёрын эрс ялгааг би шууд ялгаж мэдэрлээ. Онгоцон доторхи агаарыг бараг дөчин найман цагийн турш сэлгээгүй тул амьсгалахад хэрэгпээ бага болжээ.

Хорин цаг тасралтгүй ажилласны эцэст бид мөсөн дээр зурсан зууван зураасан доторхи мөснөөс дөнгөж нэг метр зузаан мөс ховхолж амжлаа. Хэрэв дараачийн метр тус бүрийг хагачиж ховхлоход бид, арван хоёр цагийн хөдөлмөр зарцуулдаг юм гэхэд бидэнд тэрхүү ажлыг дуусгахад таван шөнө, дөрвөн өдөр шаардагдах байв.

-Таван шөнө, дөрвөн өдөр шүү! гэж би нөхөддөө хэлээд, гэтэл манай багтаамжуудад буй амьсгалах агаарын нөөц дөнгөж хоёр хоног л хүрэх шүү дээ гэв.

- Бас тэхэд энэ нэгэн харлаж хэвтсэн хар шоронгоос гараад бид усан дээр шууд хөвөн гарч чадахгүй. Мөсөн доогуур нилээд хугацаагаар явахыг бодолцохгүйгээр шүү гэж Нед Ленд нэмэрлэв.

Нед Лендийн нэмж хэлсэн үг зөв байлаа. Үнэхээр ч энэ мөсөн дороос бүрмөсөн мултарч гарахад хэд хичнээн хугацаа хэрэгтэй болохыг бодож гаргах бололцоогүй байсан бөгөөд “Наутилус” усан дээр ил гарч очихоос өмнө бид бүгдээрээ бүтэж үхэх гэж үү. Бид бүгдээрээ тэрхүү мөсөн дунд авслагдах хувьтай ч байсан байж юу магад...

Бидний байдал үнэхээр хөөрхий байв. Гэвч бид үхлийн нүд рүү халз ширтэн, өөрсдийн үүргийг үхэн үхтлээ заавал гүйцэтгэхээр эрс шийдэж билээ.

Миний урьдаас мэдэж байснаар мөсөн дахь нүх тэр шөнөдөө нэг метр гүнзгийрсэн байв. Гэтэл би өглөөгүүр өмсгөл хувцсаа өмсч, мөсөн дээр гарч очвол мөсөн хонгилын хоёр хажуугийн хана хоорондоо нилээд ойртсон болохыг ажиглав. Тэдгээр хананд тулсан усны үе, усан доогуур ажиллагсдын хөдөлгөөнд зайлагдаж, үл бүлээцэх тул хөлдсөн байв.

Энэ явдал бидний амь гарах боломжийг тэг руу ойртуулж буй нэгэн шинэ, аймшигт аюул байлаа. “Наутилус”-ыг ямар нэгэн хэврэг шилэн сав мэт няц хавчихаар заналхийлэн, харилцан ойртож байгаа хонгилын мөсөн хана, орчны усны хөдлөлтийг юугаар яавал хориглож болох бол?

Тэр нэгэн шинэ аюулын тухай би нөхөддөө юу ч ярьсангүй билээ. Амь гарахаар зүтгэн хөдөлмөрлөж буй тэдний зоригийг мохоохын хэрэг юу байна? Гэвч би,онгоцондоо орж ирмэгц тэрхүү хүндэрч буй ноцтой аюулын тухай капитан Немод

мэдэгдвэл:

-Би ажсаан, ажсан хэмээн тэр сэтгэл түгшсэн янз ер үл мэдэгдэх зөөлөн дуугаар хэлээд, энэ ч шинэ л аюул заналхийлэл л дээ. Гэвч яая гэхэв, би түүнийг зогсоох чадал алга. Аврагдах ганцхан зам гэвэл эндээс мултрах хэрэг байна. Тэгээд л гүйцээ гэлээ.

“Тэгээд л гүйцээ” гэнэ шүү.Түүний хүнтай үг хэлцэх янзанд нь би даанч дасмаар цаг болсон л юмсандаа!..

Тэр өдөртөө би мөсөн дээр хэд дахин гарч шуурхайлан зээтүүдлээ. Тэр ажил намайг хөгжөөж билээ. Түүнээс гадна, гарч ажиллах гэдэг бол “Наутилус”-ыг орхиж одох боломж олж онгоцон доторхи хүчилтөрөгч багатай, бүгчим агаарын оронд амьсгалах аппаратын цэвэр хийгээр амьдарна гэсэн үг байв.

Орой тийшээ мөсөн дэх нүх нэг метр гүнзгийрлээ. Онгоцонд би орж ирмэгц нүүрсхүчлээр хэт ханасан агаар уушгиндаа гэнэт татаж арай л бүтэж үхсэнгүй. Ай харла гэж амьсгалахад хортой тэр хийг шингээн авах химийн ямар нэгэн бодис бидэнд байхгүй нь юутай харамсалтай, тэгвэл бид хүчилтөрөгчөөр дутагдахгүйсэн билээ. Тэр бодис бидний эргэн тойрсон буй их усанд уусмал байдалтай хадгалагдаж байгаа бөгөөд бид өөрсдийн гүйдэл үүсгэгчээс гарсан цахилгаанаар усыг задлан түүнийг амархан ялган авч болохсон билээ. Би тэр тухай бодсон боловч бидний амьсгаагаа гаргахад ялгарч бүх онгоцыг дүүргэж буй нүүрстөрөгчийг онгоцон дотроос зайлуулах асуудлыг шийдвэрлэх боломж үл олдох тул тэр бодлоосоо би татгалзлаа. Онгоцон доторхи нүүрстөрөгчийг шингээн авахын тул том том саванд идэмхий натри хийж зав чөлөөгүй хутгах хэрэгтэй байв. Гэтэл, “Наутилус” дээр идэмхий натри байхгүй бөгөөд түүнийг бид юугаар ч орлуулж үл чадах ажээ!..

Орой тийшээ капитан Немо агаарын багтаамж савнуудынхаа цоргыг нээж, онгоцондоо хэд хэдэн кубметр цэвэр агаар оруулахаас өөр аргагүй болов.

Хэрэв л тэр энэхүү арга хэмжээ аваагүй бол бид өглөө амьд сэрэхгүйсэн билээ.

Маргааш өдөр нь гуравдугаар сарын 25-нд би дахин малтагч хийж, нүхний тавдахь метрт орж ухав. Мөсөн хонгилын хажуу хана, тааз мэдэгдэхүйц зузаарчээ. Ажил иймэрхүү явцтай цагт “Наутилус” тэндээс мултарч амжихаас өмнө тэд, барьцалдаж хөлдөх нь ойлгомжтой бүлгээ.

Секунд хэр би бачимдаж ч үзлээ. Би арай л зээтүүгээ алдчихсангүй. Хэрэв бид тэртэй, тэргүй бүтэж үхэх юм уу, эсхүл чулуужиж буй усанд няц хавчуулах юм бол бид тэр мөсийг тийнхүү хагачихын хэрэг юу байна аа.

Би ямар нэгэн аймшигтай амьтны аманд үмхэгдэж тэр ам нь юу юугуй хамжих гэж

буй мэт надад санагдлаа.

Энэ минутанд бидний хэсэг хүмүүсийг удирдаж өөрөө ч гэсэн шуурхай зээтүүдэж агсан капитан Немо миний дэргэүүр явж өнгөрлөө. Би түүнийг зогсоож шоронгийнхоо хана руу заав Тэдгээр хана онгоц руу шөнөдөө дөрвөн метрээс доошгүй ойртсон байв.

Капитан Немо миний санааг ойлгож өөрийгөө дагах дохио өгөв.

Бид онгоцондоо орж ирээд өмсгөлөө тайлсны дараа би, түүнийг дагалдан үзэсгэлэн танхимд орав.

- Эрхэм Аронакс бид ямар нэгэн баатарлаг арга хэмжээ авахгүй бол мөсөн дунд, цементлэгдсэнээс ч бат бэх авцалдан хөлдөх болно гэв.

- Тиймээ гэж би хариулаад -гэвч бид яах ч арга алга шүү дээ? гэлээ.

- Ай даа хэмээн тэр -хэрэв л миний “Наутилус” шам шийчихгүй тэр их даралтыг тэсвэрлэн чадах бөхсөн бол уу? гэв.

- Тэгвэл яана вэ? гэж би капитаны саналыг ойлгосонгүй тул лавлан асуув.

- Усны хөлдөлт бидэнд тус болох нь нээрээ танд ойлгогдохгүй байна гэж үү? Ус мөс болж хөлдөх өөрөө эзлэхүүнээ ихэсгэж тэлдэг бишүү. Тэгсэн цагт ус, хөлдөхөөрөө хамгийн бөх чулууг боловч хага татдаг шигээ биднийг олзолсон мөсөн цөлийг зайлшгүй хага татах ёстой билээ. Тэр явдал бидний үхэл биш, аврал гэдгийг та ойлгохгүй байна гэж үү?

- Тиймээ капитан, тэгж болох юм. Гэвч, “Наутилус” ямар ч бат бэх байлаа гэсэн тийм аймшигт их даралтыг тэсвэрлэж чадахгүй л дээ. Тэхээр түүнийг мөсөн хана нимгэхэн хавтгай хар төмөр болтол нь хавччих шүү дээ.

- Үүнийг би мэдэж байна, профессор гуай. Тиймээс ч би байгалийн зүгээс тусламж эрэх нь биш харин зөвхөн л өөрөө өөртөө итгэж байнам. Ус, цаашлан хөлдөх явдалд ямар боловч аргаар саад хийх хэрэгтэй: Түүнийг зогсоох хэрэгтэй! Одоо харин бүр зөвхөн хажуугийн хананууд ойртоод зогсохгүй, “Наутилус”н хоншоорын өмнө, бөгсний ард арван футээс хэтрэхгүй зай үлдсэн байна... Бидний хоригдсон мөсөн хонгил тал бүрээс маань түрж эхэллээ!

- Багтаамжуудад буй агаар маань хэдий хэр хугацаанд хүрэлцэх вэ? гэж би асуув.

- Нөгөөдөр хуртэл хэмээн тэр хэсэг зуур дуугүй байснаа хариулаад тэгээд л хоосорно доо: гэлээ.

Миний духанд хүйтэн хөлс чийхрав. Тэхэд, тэр нэгэн хариулт намайг төдий л гайхуулах явдалгүй билээ. Гуравдугаар сарын 22нд “Наутилус” өмнөт туйлын орчинд



задгай далайд живж орсон бол өнөөдөр, гуравдугаар сарын 26 билээ. Тэхээрээ бид «Наутилус» доторхи агаарыг амьсгалахын хүчинд далай дээр тав хоножээ. Түүнээс гадна мөс хагачих, усан доорхи ажилд их агаар зарцуулагдсан билээ.

Одоо, эдгээр мөрийг бичиж суух завсар, миний өөрийн биеэр үзэж өнгөрүүлсэн тэр аюул түгшүүр миний сэтгэл санаанд тов тодхон тул тэр явдал санаанд минь орж, нүдэнд минь үзэгдэх шиг болж, айх сүрдэхийн эрхэнд гар хөл минь салганан чичирч, уушгинд минь амьсгалах агаар дутагдсан шиг би, амьсгалах агаар салхи хомхойрон залгиж билээ.

Тэр хооронд капитан Немо, нэг л юманд төвлөрөн дув дуугүй бодлогошрон зогслоо.

Гэнэт би ажвал, түүний ухаанд ямар нэгэн мэргэн бодол төржээ. Эхлээд тэр, уул бодлоо үлдэн хөөх мэт харагдсан нь бодвол санаанд нь нийцэхгүй биз. Гэвч дараа нь түүний амнаас:

- Ус! Буцалсан ус! гэсэн авиа гарлаа.

- Буцалсан ус ий? хэмээн би хашгарав.

- Тиймээ профессор оо. Бид тун нарийхан зайнд хашигдсан байгаа шүү дээ. “Наутилус”-ын шахуургууд зогсоо зайгүй олгойдуулдан чадах буцалсан усны урсгал биднийг тойрон буй усны температурийг ихэсгэж, мөстөж хөлдөх явцыг нь зогсоох юм!

- Үүнийг турших хэрэгтэй! гэж би өгүүлэв.

- Үзээд алдъя, профессор гуай. Онгоцны гадна гаргасан термометр тэгээс доош долоон градус зааж байв.

Би капитаныг дагалдан явсаар онгоцны гал тогооны өрөөнд оров. Тэнд далайн ус цэвэрлэдэг том тогоо байлаа.

Тогоонд ус дүүргэж “Наутилус” дээрх цахилгаан гүйдэл үүсгэгчийн бүх цахилгаан зайг хүйтэн ус гүйх тахир хоолойнуудыг халаахад зориулан залгав. Хэдхэн минутын дараа ус буцлах цэгтээ хүрлээ, Усны шахуургууд буцалсан халуун ус гадагш нь хаяж эхэллээ. Хоосорсон тогоонд хүйтэн ус шинээр халаагдаж байв. Цахилгаан гүйдэл үүсгэгчийн илч нэн их байсан тул тахир хоолой руу орж ирсэн далайн ус зуун градус хүртэл халаагдан гадагшилж байв.

Буцалсан халуун ус гурван цагийн турш зогсоо зайгүй гадагш ны шахсаны дараа термометрийн мөнгөн усан багана нэг градус дээшилж зургаан градус зааж байв.

- Нөлөөллөө шүү! хэмээн би термометрийн заалтыг хянаж байсан капитанд хэлээд одоо амжилт бүрэн хангагдлаа гэв.

- Тэглээ гэж капитан хариулаад -би ч мөн тэгж бодож байна. Бид юу ч л гэсэн няц хавчигдахаасаа өнгөрлөө. Тиймээс бүтэж үхэх заналхийллээс л амь гарах үлдлээ гэлээ.

Усны температур тэр шөнөдөө тэгээс нэг градус доор болтол ахижээ. Бид усны температурыг бас жаахан дээшлүүлэх гэж хэдий их оролдсон боловч тус болсонгүй. Гэвч, тэгэхийн ч хэрэггүй байлаа. Учир нь хажуу хана зузааран хөлдөхөө больсон байв. Дараачийн нь өглөө, гуравдугаар сарын 27-нд нүхний гүн зургаан метр хүрчээ. Иймээс ухаж гаргавал зохих дөрвөн метр зузаан мөс үлджээ. Энэ ажил дөчин найман цагийн хөдөлмөр шаардаж байв.

Тэр өдөр «Наутилус» доторхи агаарыг сэлгүүлсэнгүй. Учир нь багтаамжуудад үлдсэн ялихгүй жаахан цэвэр агаарыг капитан Немо усан доорхи ажиллагаанд ашиглаж байв. Онгоцон дээр амьсгалах гэдэг цаг өнгөрөх тутам улам бэрх болж байлаа.

Миний элэг цээжин дээр нэг л их нүсэр хүнд юм дарах мэт санагдав. Өдрийн гурван цагийн үед тэр шаналгаа тэсэхийн эрхгүй боллоо. Би зогсоо зайгүй эвшээлгэж байв. Миний уушиг “Наутилус”ын өтгөрсөн хүнд агаараас амьдруулах тэр хий –хүчилтөрөгчийн атомыг эрж, бохиртсон агаар чичигнэн сорж байхад тэр шидэт хий амьсгалах тутам багадсаар байлаа.

Бие нэг л хачин сулдчихаад, миний тархи, хөдлөх чадвар саарсан байв. Би бараг ухаангүй болж, ямар ч тэнхээ тамиргүй хэвтэж билээ.

Надаас багагүй зүдэрч агсан хөөрхий Консель намайг секундийн төдий ч орхиж холдсонгүй. Тэр гарыг минь барилан намайг зоригжуулж байв.

- Ай харла, амьсгалахгүй байж чаддаг ч болоосой доо, би тэгвэл эзнийхээ амьсгалах агаарыг арвилахсан гэж түүний шивнэж байхыг би сонсч билээ.

Тэр үгий нь би дуулаад нүдэнд минь нулимс гүйлгэнэсэн юмдаг.

Онгоцон дотор амьсгалахад хэдий хэцүү болох тутам, бид ажиллах ээлжээ болохоор өмсгөл багаа төдийчнээн дуртай өмсөцгөөдөг байлаа. Зээтүүнүүд мөсөнд зоогдон жингэнэж, ядрахын эрхэнд дал мөр, нуруу бөөр янгинан өвддөг байлаа. Гарын алганд эвэр ургасан байв. Гэвч цэвэр агаар цээж дүүрэн татан амьсгалах цагт тэр ядрах, өвдөх гэдэг юу ч биш ажээ.

Тэглээ ч гэсэн тогтоосон цагаас илуу хугацаагаар мөсөн дээр хэн ч үлддэггүй байв,

Хувьд ноогдсон хоёр цагаа ажилламагц л бидний хэн нь ч гэсэн онгоцон доторхи хордсон агаарт амь тэмцэн аахилж буй нөхөртөө амьсгалах цэвэр агаартай багаа

шилжүүлэхийг яаравчилдаг байв. Тэхэд муужирч агсан хүн дахин амьдардаг билээ.

Хатуу сахилга, дэглэмийн үлгэр жишээ капитан Немо өөрөө эргүүлэн үзүүлж байв Усан доор ажиллах цаг дуусмагц тэр, эрчлэн алхалж онгоцон доторхи хордсон агаарт эргэж ирдэг билээ. Түүний царай урьдын адил амгалан бөгөөд амнаас нь зориг мөхсөн авиа нэг ч удаа гараагүй юм.

Тэр өдрийн ажил тун шуурхай явж байв. Нэг хоногт хоёр метр зузаан мөс ховхлогдсон бөгөөд одоо бид сул уснаас бас хоёр метр зузаан мөсөөр тусгаарлагдаж байв.

Гэтэл амьсгалах агаарын багтаамжууд хов хоосорсон тул зөвхөн румкорфийн аппаратуудад байгаа тэр нэг яльгүй нөөц үлджээ.

Би онгоцон дээр эргэн ирж багаа мулталмагцаа золтой л бүтчихсэнгүй. Ай бүү үзэгд, ямар айхтар шөнийг бие өнгөрөөсөө гэж санана! Түүнийг тодорхойлон бичихийн арга алга, тийм их зовлон зүдгүүрийг үгээр хэлж, үсгээр бичиж болохгүй ажээ.

Өглөө тийшээ миний амьсгаа бүр ч давчидлаа. Толгой янгинах дээр бас толгой эргэх нэмэгдэж согтуу юм шиг гуйвж байв. Миний нөхөд мөн л над шиг шаналж байлаа. Далайчдын зарим нь бүр эхэр татаж байв.

Бидний олзлогдсоны зургаа дахь өдөр билээ. Капитан Немо зээтүүгээр тийнхүү ажиллах гэдэг дэндүү удаан, түүнчлэн ажил дуусгахаас өмнө амьсгалах агаарын нөөц, барагдахыг ойлгож биднийг далайн уснаас тусгаарлж буй мөсийг өөр аргаар цоолж үзэхээр шийдэв. Энэ хүн хучин чадал, амгалан сэтгэл, саруул оюун бүхнээ хадгалсаар байв. Тэр зөвхөн тэсвэр зоригийнхоо хүчээр зовж зүдрэхийн хүндийг үл мэдэрч байлаа. Тэр бодож, сэтгэж бүтээж, үйлчилж бүлгээ.

Түүний тушаалаар “Наутилус” -ын усан хүндрүүлгийн хагасыг шахаж гаргалаа.

Дараа нь онгоц мөснөөс өөдөө хөндийрэхийн хамт ухмал зууван нүхийг яг голлуулан зогсоолоо. Дараа нь усны багтаамжуудыг усаар дахин дүүргэж уул нүхний ёроолд буув,

Онгоцны баг онгоцондоо бүгд эргэн ирж, давхар хаалга бин битүү хаагдлаа.

“Наутилус” одоо нэг метрээс хэтрэхгүй зузаан мөсөн дээр элгээрээ хэвтлээ. Түүний зэрэгцээ уул мөс мянга түм нүхлэгдэж өрөмдсөн байв. Капитан Немо усны багтаамжуудыг хэмжээнд нь тултал дүүргэх тушаал өгснөөр “Наутилус”-ын жин зуун мянган килораммаар хүндэрлээ.

Бид өөрсдийн шаналгааг мартаж, чих тавин чагнаж хүчлэн хүлээв. Бид үхэх сэхэхийн зааг дээр байлаа.

Миний чих хэдийгээр дүнгэнэн шуугивч, би удсан ч үгүй “Наутилус”-ын их биений хүндийн жинг мөс хэрхэн тачигнаж буйг сонсов. Тэрхүү тас няс хийх чимээ улам бүр тодорсоор байлаа. Бид доош сууж буй нь ажваас илэрхий байв. Мөс урагдаж байгаа цаас шиг этгээд сонин дуутай хагарах ажээ. “Наутилус” доошилж эхэллээ.

- Бид цоолгоор гарч байна гэж Консель миний чихэнд шивэгнэв.

Би түүнд хариу хэлэх тэнхээгүй байлаа. Би түүний гарыг барин аваад, татваганан атгалав.

Өөрийн нүсэр хүнд усан хүндрүүлэгт татагдсан “Наутилус” юу ч үгүй хоосон орчинд хаягдсан цөм шиг гэнэт далайн ёроол руу чулуу мэт унаж эхлэв.

Цахилгаан үүсгэгчийн бүх гүйдлийг эгшин зуур шахуургуудад шилжүүлэн залгамагц усны багтаамжуудаас ус исгэчин шуугин олгодов. Хэдхэн минутын дараа бидний уналт удааширч бүр сүүлдээ яг зогсов. Манометрийн зүү одоо манай онгоц дээшээ хөөрч байгааг зааж байв.

Тэгтэл ч «Наутилус» ын сэлүүр сэнс маш хурдан эргэлдэж эхэлсэн нь онгоцны хамаг бие чичигнэн доргиж, бид умарт зүгийг чиглэн довтолголоо.

Гэвч, задгай далайд явж ортол мөсөн доогуур давхих энэ хэд хичнээн хугацаагаар үргэлжлэх бол? Бүтэн өдөр гэж үү? Тэгвэл ч би тэр болтол амьдардаггүй ээ...

Би номын санд олбогт сандал дээр хажуулж байв. Миний амь тэмцэн, царай хөхөрч, уруул харлажээ. Би хуруугаа ч хөдөлгөх тамиргүй байв. Би юу ч үзэхгүй, юу ч дуулахгүй байлаа. Түүнчлэн цаг хугацаа хэд хичнээн өнгөрч буйг ч мэдэхээ байжээ. Миний булчин шөрмөс агших сунах чадвараа алджээ...

Тиймэрхүү байдалтай хичнээн ч хэвтсэнээ хэлж би үл чадна. Ухаан хааяа орж гарч, түүртэж байхдаа үхлийн өмнөх бачимдал эхэлж буйг хааяа л нэг мэдэрч байв, үхэж байна гэдгээ би ойлгож л байв.

Тэгтэл би гэнэт ухаан орлоо. Цэвэр агаар миний уушгийг ариутгаж ч байх шиг, Бид далай дээр гарчихсан гэж үү? Нээрээ юу? Яагаад би үргэлжилсэн зурвас их мөс өнгөрснийг мэдэлгүй өнгөрөөчихдөг билээ?

Үгүй ээ? Бид мөн аанай л мөсөн доор явлаа. Миний үнэнч нөхөд Консель-, Нед Ленд хоёр намайг аврахын тул өөрсдийн амь насыг гарзанд нь гаргажээ. Руквейролийн аппаратуудын нэгэнд бас жаахан цэвэр агаар үлдсэн байжээ. Түүнийг тэд өөрснөө амьсгалахын оронд надад өгч, намайг амьдруулан өөрснөө аахилж байв.

Би мэдээ ормогц амьдруулагч аппаратыг түлхэж зайлуулах гэсэн боловч тэд миний гарыг барьчихаад хөдөлгөсөөгүй тул би хэдэн минутын турш уул хийг нэн их амтархан залгиж билээ.

Би цагаа харлаа. Өглөөний арван нэгэн цаг ажээ. Өнөөдөр гуравдугаар сарын 28 билээ.

“Наутилус” цагт дөчин миль хурдлан, усан дунд сум мэт шунгинан, аймшигтай хурдлан довтолж байв.

Капитан Немо хаа байгаа бол? Тэр амьд бол уу? Түүний нөхөд мэнд бол уу?

Яг тэр минутад манометрийн зүү биднийг далайн гадаргуунаас дөнгөж хорин фут зайнд буйг зааж байв. Сэлүүн задгай агаараас биднийг завхан л яльгүй нимгэн мөс тусгаарлаж байжээ. Тэгвэл түүнийг ив дайрч болохгүй гэж үү?

Үгүй ээ, болно! Ямар ч гэсэн “Наутилус” тэхээр зэхэж буй бололтой.

Тэр өөрийн бөгсөн биеийг доошлуулж хурц шөвгөр хоншоороо дээшлүүлж буйг би мэдэрлээ. Үүнд онгоц тиймэрхүү байдалтай болохын тул бөгсөн талынхаа усны багтаамж саванд жаахан ус оруулбал л гүйцэх бүлгээ. Дараагаар нь өөрийн хүчит сэнсэнд өөдөө хөөгдөн адар талынхаа мөс рүү аврага том мөргүүл мэт дайран орлоо.

“Наутилус” өөрийн хүндийн жингээр мөсөн давхаргыг нь цохин усан дээр ил гаран гартлаа гүйдэл дундаа цохисон нэг л цэг рүү хэд хэдэн удаа няцалтгүй давхиж дайрлаа.

Онгоцны тавцангийн таг нээгджээ. Үгүй ээ ховх татагджээ. Цэвэр агаар “Наутилус”-ын бүх л мухар тохой, булан бүр лүү орлоо.

[Тор](#)

---

## *ГОРНЫН ХУШУУНААС АМАЗОНКА МӨРНИЙ ЗҮГ*

Онгонцы тавцан дээр яаж гарснаа би мэдээгүй юм. Канад хүн намайг тэвэрч аваачсан ч байж магад. Би далайн амьдруулагч цэвэр агаар уушиг дүүрэн нэн тааламжтай татаж, цээж дүүрчэн амьсгалж байв. Нед Ленд, Консель хоёр далайн цэнгэг амьсгалыг ханатлаа залгилж байлаа.

Удаан өлссөн хүн түүнд өгсөн хоолыг тун болгоомжтой дасгаж идэх ёстой. Үгүй бол тэр үхэж ч болно. Тэгвэл бид ч өөр хэрэг. Бид өөрсдийгөө юугаар ч хязгаарлах явдалгүй тул биднийг мансууруулан байгаа цэнгэг агаарыг уушиг дүүрэн сорон

сорсоор билээ.

- Ай даа, цэвэр агаар гэдэг юутай сайхан гэж Консель дуугараад - эзэн дур мэдэн амьсгал, энд бүгдэд хүрэлцэнэ!гэлээ.

Нед Ленд юм ярихгүй боловч амаа асар том ангайн зогсохы нь харвал загас акул өөрөө атаархахсан буйзаа. Тэр ямар их хүчээр уушгидаа агаар татаж байв гээч! Канад эр түүнийг улайдсан халуун зуух мэт хүнгэнэтэл татаж байлаа.

Бид түргэн зуур тэнхэрлээ. Би ухаан сайн ормогцоо ойр орчиндоо ажиглан харвал тавцан дээр бид гурвуулхнаа байлаа. «Наутилус»-ынхнаас нэг ч хүн байсангүй. Капитан Немо ч үзэгдэхгүй байв Тэдгээр хачин хүмүүс бодвол, онгоцон дотуур хөвж буй агаараар сэтгэлээ хангасан буйзаа. Тэдний дотроос хэн нь ч далайн салхины сэлгүүн урсгалыг тамшаалахаар гарч ирсэнгүй:..

Миний ам нээж хэлсэн хамгийн анхны үг бол би өөрийнхөө дагалдагсад, үнэнч нөхөддөө хандаж хэлсэн баяр талархлын үг билээ.

Намайг үхлийн өмнөх бачимдал дундаа тийчилж ахуйд Нед Ленд, Консель хоёр миний амийг аварсан бүлгээ. Тэр их тусыг нь ямар ч үгээр хариу талархаж болохгүй байлаа:

- За боль л доо, эрхэм профессор минь хэмээн Нед Ленд миний хариу талархан ус цас шнг урсгаж байгаа үгийг минь таслан авч -үүн тухай ярихын хэрэггүй тус болоод байсан нэг их юм ер алга. Энэ бол хэний амь нас үнэтэй вэ? гэсэн ердийн л нэг асуудал байсан юм таных байх нь ойлгомжтой хэрэг. Тийм учраас юуны өмнө л таны амийг аврах хэрэгтэй байсан гэлээ.

- Тийм биш ээ, Нед минь- Миний амь нас таныхаас үнэтэй бус Сайн санаат сайн хүний амь наснаас хэний ч амь нас үнэтэй байх ёсгүй. Тэгвэл та бол сайн санаат, сайн хүн!

- За, за больё хэмээн жаахан ичингүйрэн бувтнав.

- Чи миний хайрт Консель их ядрав уу;

- Ядарсан надад яльгүй жаахан цэвэр агаар дутагдаад, гэвч би тийм? агаараар амьсгалж төдөлгүй л дадах байсан л даа.Тэрнээс гадна эзэн таныг би зовж атиралдаж байх цагт улсын ярьдгаар, миний дотор бачимдаад л... Ичсэндээ Консель, яриагаа ч дуусгалгүй дуугүй болчив.

- Миний хайрт нөхөд өө хэмээн би сэтгэл ихэт хөдлөн -бидний зовж өнгөрүүлсэн цаг биднийг эвдэршгүй бат нөхөрлөлөөр мөнх холболоо. Тиймээс та нар надаас шаардах шаардах гээд цааш нь ярих гэтэл канад хун миний яриаг таслан;

- Шаардана чиг! гэлээ.

- Юуг хэмээн Консель асуув.

- Энэ хар “Наутилус” дээрээс оргохоор биднийг шийдсэн цагт эрхэм профессор биднийг дагалдахыг хүсье.

- Тэхэд энэ «Наутилус» маань хаашаа явж байна даа. Бид хойшоо явж байна уу? гэж асуув.

- Тэгэлгүй яахав гэж би хариулаад -бид нарны өөдөөс явж байна. Энэ орчинд, нар гарах зүг бол хойт зүг гэв.

- Бид Атлант өөд үү, аль эсхүл Номхон далай руу юу, үгүй бол хүнгүй хоосон далай руу юу, хүн амьтан, хөл хөдөлгөөнтэй далай руу юу, ямар далай руу явж байна? үүнийг л мэдэх хэрэг байна гэж канад хун асуулаа

Тэр асуултанд би хариулт өгч чадсангүй. Гэвч би капитан Немо өөрийнхөө хөлгийг Ази, Америкийн эргийг угаах, усны тэр уудам сан өөд авч одох бий гэж айж байв Тэгвэл тэр дэлхий тойрох өөрийн жуулчлалыг туйлжуулж, “Наутилус” дүүрэн чөлөөтэй зорчин явах бөмбөрцгийн тэр нэгэн зайдуу орчинд эргэж ирэх болно.

Хэрэв л бид хүн амьтнаас алслагдсан хол газар номхон далайн эл хуль уснаа дахин орж очвол Нед Лендийн төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх билээ.

Энэ нэгэн чухал асуултанд бид хамгийн ойрын хугацаанд хариулт олох хэрэгтэй байлаа. “Наутилус” тун хурдан давхиж байв. Бид төдөлгүй туйлын цагиргийг гэтэлж Горнын хушуу руу чиг явлаа.

Гуравдугаар сарын гучин нэгнээ, оройн долоон цаг орчимд бид Америк тивийн хамгийн захын цэгт ирсэн байв.

Энэ үеэс эхлэн бидний үзэж өнгөрүүлсэн үйл зовлон мартагдаж эхлэв. Мөсөн дунд олзлогдсон өдрүүдийн тухай дурсамж бүрэг бараг болж байв. Бид зөвхөн ирээдүйгээ бодох боллоо. Капитан Немо үзэсгэлэн танхимд ч онгоцны тавцан дээр ч үзэгдэхгүй байв.

Капитаны туслагч газрын зураг дээр өдөр тутам тэмдэглэн байх тэмдэг манай онгоцны яваа орчинг надад илтгэдэг билээ. Тэр орой бид- Атлантын далайд орж буй нь тодорхой, болов.

Би өөрийн ажиглалтын тухай Нед Ленд, Консель хоёрт мэдэгдвэл, канад хүн;

- Энэ ч баяртай л мэдээ санж. Гэвч “Наутилус” хаашаа зорьж явна вэ? гэлээ. Одоохондоо би хэлж чадахгүй байнам Нед минь.

- Капитан Немо өмнөт туйлын дараа, магадгүй бас Умарт туйлыг нээж, тэндээсээ Умар-өрнөтийн алдарт хоолойгоор номхон далайд орж очих гэж байгаа юм биш биз?

- За ямар ч гэсэн бид л түүнийг хөгжөөхгүй юм даг гэж Консель хэлэв.

- Гэвч бид түүнийг төлөвлөгөөгөө биелүүлэхээс нь өмнө амжиж, түүнээс хагацахыг хичээлгүй дээ хэмээн Нед Ленд өгүүлэв

- За юу ч л болсон хэмээн Консель энэ капитан Немо гэдэг сайн эр, үүнтэй би танилцсандаа харамсахгүй л хүн дээ гэв.

- Ялангуяа түүнээс хагацан салсан хойноо харамсахгүй л байлгүй гэж канад эр ёжлов.

Дараачийн өдөр дөрөвдүгээр сарын 1-нд үд болохоонсхэдхэн мннутын өмнө «Наутилус» далай дээр хөвж гарахын үед бид ямар нэгэн эргийн бараа олж харав.

Тэр бол анхны шинжээчид, улаан арьстны овоохойнуудаас суунаглаж байсан олон утаагаар нь нэрийдсэн Галт газар байлаа.

Галт газар бол өрнөт уртрагийн 77 хоног 15 хувь ба 67 хоног 50 хувь, өмнөт өргөргийн 53ба 56 дугаар хоногуудын хооронд өргөнөөрөө гурван зуун хорь, уртаараа зуун хорин километр газар үргэлжлэх ольтриг юмаа. Бидэнд хамгийн ойр байгаа арлын эрэг намхан зугууд боловч цаашаа өндөр өндөр.уул харагдаж байв. Би далайн төвшнөөс дээш хоёр мянга долоон зуун метр өндөрт өргөгдсөн Сармиенто уулыг таних шиг боллоо.Тэр уулын шовх орой далайчид цаг агаарын байдал ямар болохыг заадаг. Түүний арсан дарсан хяр сэрвэн цэлмэг цэнхэр тэнгэрт тов тодхон харагдаж байвал агаар тогтуун болохын тэмдэг, хэрэв тэр будант манангаар хучигдсан бол агаар муу болохын тэмдэг ажээ. Үүнийг надад Нед Ленд ярьсан юмаа.

- За тэгээд. Нед минь, тэр барометр чинь аль зэрэг зөв заадаг вэ? гэж би асуув.

- Гайхалтай зөв заадаг юм шүү ноён профессор оо гэж канад хүн хариулаад бид Магелланы хоолойгоор хичнээн ч олон гарч байв даа. Биднийг тэр нэг ч удаа мэхлээгүй юм гэв

Тэр минутанд өнөө уулын орой тэнгэрийн цэв цэнхэр дэвсгэр дээр тод ялгарч байв Тэр нь агаар сайн байхын дохио ажээ. Үнэхээр ч тэр нь дараа нотлогдсон юм.

“Наутилус” усан доор дахин орж умар зүгийг чиглэн хурдаллаа

Орой тийшээ би Фальклендийн арлуудад ойртон очиж, маргаашийн нарнаар нь “Наутилус” далай дээр хөвж гарахад би тэрхүү арлуудын уулсын сүрлэг оргилыг олж харав. Далайн энэ орчинд гүехэн байв. Энэ явдал уул ольтригийн гол хоёр арал ба тэдгээрт ойролцоо жижиг арлууд дээр үед Магелланы галт газрын нэгэн хэсгийг үүсгэж байсан бизээ гэсэн бодол надад төрүүллээ.

Фальклендийн арлуудыг бодвол алдарт далайч Джон Дэвис нээж өмнөт Дэвисийн арлууд гэж нэрлэсэн бизээ. Нилээд хожуу Ричард Гаукинс тэдгээрийг гэгээн Дагины арлууд гэж нэрлэжээ. XVIII зууны эхээр Сен-малогийн далайчид тэдгээр арлыг



өөрийн төрөлх хот Малуины нэрээр нэрлэжээ. Ингээд хамгийн эцэст тэдгээрийг англичууд Фальклендийн арлууд хэмээн нэрийдэж одоо хүртэл эзэмшиж байгаа юм.

Онгоцны тавцан дээгүүр зэрлэг галуу, нугас сүрэг сүргээрээ эргэлдэж, тэдгээрийн нилээд олон нь тэр өдөр бидний хоолны ширээнд нэмэрлэгдэж билээ

Загаснаас би кольбневын язгуур нэгэн дүрс загас, ялангуяа шар хүрэн толбоор цоохорлогдсон хорин сантиметр урт биетэй колбне-бухандай руу нэн анхаарсан бүлгээ.

Фальклендийн арлуудын уулын орой далд орсон хойно “Наугилус” хорь хорин таван метрийн гүнд шумбан орж өмнөт америкийн эрэг даган хөвлөө. Капитан Немо урьдын адил үзэгдэхгүй л байв. Дөрөвдүгээр сарын 3-ныг хүртэл бид Патагон орчны уснаа нэг далд орон, нэг ил гаран хөвлөө. Дөрөвдүгээр сарын 4-нд “Наутилус” Ла-Платын усны адагт өргөн лиманыг өнгөрч, Уругвайн хилийн зааг дээр очсон боловч эргээс арван таван миль зайтай явав. Капитан Немо урьдын адил умрыг чиглэсээр америк тивийн эргийн бүх л голдрилыг дамжин хөвж байлаа. Японы далайд анх усан доогуур явагч хөлөг онгоцонд орж ирсэн тэр цагаас хойш «Наутилус» арван зургаан мянган бээр буюу жаран дөрвөн мянган километр явлаа.

Өглөөний арван нэгэн цагийн үед бид гучин долдугаар уртраг дээр матрын халуун бүсийг огтоллоо. Нед Лендийн аз дутахад, капитан Немогийн сэтгэлд бодвол, Бразилийн тэрхүү хүн олонтой орон ойр хавьцаа байгаа явдал нийцээгүй бол уу, өөрийн онгоцыг тэр нүд эрээлжлэм хурдтай довтолгож билээ. Нэг ч загас, нэг ч шувуу, хичнээн ч хурдан явдаг, нисдэг байлаа ч гэсэн «Наутилус»-ыг гүйцэж чадахгүй тул бидэнд эндхийн далайн амьтны аймгийг судлах завшаан олдоогүй билээ.

Дөрөвдүгээр сарын 9-нийг хүртэл бид мөн тийм галзуурсан мэт хурдтайгаа явлаа. Тэр өдрийн оройдоо бид өмнөт америкийн хамгийн дорнод сэжүүрт Рокийн хушуу орчим ирлээ. Гэтэл тэнд «Наутилус» замаасаа гэнэт гажиж Рокийн хушуу, африкийн эрэг дээр буй Леоны нуруу хоёрын хоороондох усан доорхи хотгор чиглэн одлоо. Тэр хотгор Антилийн арлуудын дэргэд хоёр салаалж, хойт хэсэгтээ есөн мянган метр хүртэл гүнзгийрэх асар уудам нам дор газар болон төгсөнө. Энэ орчинд далайн ёроолын геологийн зүслэлт, Антилийн бага арлуудыг хүртэл, өндрөөрөө зургаан мянган метр эгц элгэн улаан хад болдог билээ. Ногоон хушууны арлуудын дэргэд түүнээс төдийлөн намгүй өмнөтөөс сөнөсөн тив Атландыг холбох хоёр дахь хадан хана үргэлжилнэ. Усан доорхи тэрхүү хөндийд, ялангуяа тэндхийн байгалийг нэн үзэмжтэй болгон чимэглэж байдаг уулс энд тэндгүй үзэгдэх бүлгээ. Үүн тухай би голчлон гар зургийг баримтлан ярьж буй бөгөөд уул зургийг бодвол, капитан Немо

өөрийн ажиглалтын үндсэн дээр өөрөө гаргасан буйзаа.

Хоёр хоногт бид, энэхүү усны бүх л гүнд орж үзлээ. “Наутилус” өөрийн гүний залуурыг ажиллагаанд оруулсны үрээр босоо хавтгайд өөд уруугаа умбан шумбан явлаа.

Гэтэл дөрөвдүгээр сарын 2-нд бид гэнэт далай дээр ил гарч ирвэл Амазонка мөрний адагт хуурай газар олж харлаа. Уул мөрөн далай руу асар их ус авчирч юүлэх тул далайн эрэг орчны ус олон миль газар давсгүй байдаг юм.

Бид экваторыг өнгөрлөө. Францын колонн Гвиан биднээс баруунаа хориод миль үлдсэн бөгөөд тэнд бид хоргодсон бол онц таатайхан байхсан билээ. Гэтэл далайн салхи үерлэн шуурч, догширсон давалгаан дунд жирийн завь оруулж тавихыг бодохын ч хэрэггүй байв. Энэ нь Нед Лендэд харваас мэдээж хэрэг тул тэр оргох талаар надад юу ч дуугарсангүй бүлгээ. Би ч гэсэн өөрийн зүгээс зайлшгүй гай гамшгаар төгсгөл болох солиорсон дэмий оролдолгоо руу түүнийг түлхэн оруулахгүйн тул тэр талаар түүнд ямар ч санамж өгсөнгүйээ.

Жич хэлэхэд оргох явдлаа тийнхүү хойшлуулсандаа би өчүүхэн ч гуньсангүй, харин тун сонирхолтой зүйлийг ажиглаж судлан орлоо. Дөрөвдүгээр сарын 11-12-нд хоёр өдрийн турш «Наутилус» далай дээр үргэлж ил явсан бөгөөд усанд хаясан түүний тор хөндий биетэн, загас, мөлхөгчдийг баялаг ихээр шүүж авчрав.

Торонд орсон загасан дундаас нэгийг нь Консель сайн нүдлэх, нүдлэхээр ч барахгүй нэг насаараа үл мартаж санан санан явах хувь тавилантай байлаа. Ийм л нэг хэрэг болсон юм.

Далайчид далайд хаясан торон дотор бусад загасны дунд хэрэв сүүлийг нь чавччихвал дув дугариг хэлбэртэй болчих далбагар хавтгай биетэй нэгэн бага дүрс цахилгаан скат орсон байжээ. Тэр скат нилээд том хэмжээтэй, хос далбан бүхий сэлүүртэй гантиглаг толбоор цоохорлогдсон гөлгөр хайрстай хүрэн нуруу, цагаан гэдэс бүхий хорин килограммаас доошгүй хүнд ажээ.

Торон дотроос тавцан дээр сэгсрэгдсэн тэр, гэдсээрээ эргэхийг оролдон хар байдгаараа тийчилсээр, тавцангийн ирмэгт туин ойрхон гулгаж очсон билээ. Хэрэв л нэг секунд өнгөрсөн бол тэр скат усандаа эргэж унах сан билээ. Гэвч тэр загасыг сонирхож агсан Консель түүн рүү дүүлэн очиж миний хэлэхээс өмнө, хоёр гараараа барьж авав.

Мөн тэр секундэндээ бараг тал мэдрэлтэй болсон буй- заа. Консель тавцан дээр бөмбөрөн унаж:

- Ээ эзэн минь, эзэн минь! Авраарай намайг! хэмээн бархирч билээ.

Тэр бол хөөрхий муу Консель надтай танилцсан цагаасаа хойш надад анх удаа хандаж гуйсан нь энэ бүлгээ.

Канад хүн бид хоёр, түүнийг татаж босгоод аль байхаараа сувилж эхлэв. Консель маань хөл гараа хөдөлгөж чаддаг болмогцоо харин амьтны аймгийг ангилан хувиарлах хэзээний архаг хэнхэг хүн болох тул:

- Загасны анги, мөгөөрст загасны доод анги, скатын баг, цахилгаан скатын язгуур, гантиглаг цахилгаан скатын дүрс... хэмээн тасалданги дуугаар шивэгнэж байв.

- Зүйтэй, миний хонгор, гантиглаг цахилгаан скат л чамайг иймэрхүү хөөрхий болгочив гэж би хэлэв.

- Эзэн надад итгэж болно хэмээн Консель ундууцаж би түүнээс заавал өшөөгөө авна гэв.

- Яаж ?

- Би түүнийг идчихнэ!

Нээрээ ч тэр, өөрийн амаласандаа тэр оройдоо хүрсэн юм. Скатны мах ой гутам муухай амттай боловч бодвол тэр, өшөөгөө авна гэсэн амандаа хүрэх гэсэндээ л идсэн бизээ.

Хөөрхий муу Консель цахилгаан скат дотроос хамгийн аюултай дүрстэй тулгарсан билээ. Цахилгаан. Гүйдэл сайн дамжуулах усанд байхдаа тэр скат, загас жараахайг хэд хэдэн метрийн газраас алж чаддаг нь түүний биений цахилгаан цэнэг хичнээн хүчтэйг гэрчилнэ.

Дөрөвдүгээр сарын 12-ны өдөр “Наутилус” марони голын адагт Голландын Колонийн эрэгт ойртон ирлээ.

Тэнд бид, хэд хэдэн ширхэг ламантинтай тохиолдов. Тэдгээр нь дюгонийн нэгэн адил сиренийн язгуурт багтдаг ламантинууд ажээ.Тэд бол уртаараа зургаа долоон метр, хүндээрээ дөрвөн мянган килограмм хүрдэг том биетй амьтан билээ.

Сүүгээр бойжигч тэдгээр амьтанд хянуур байгаль ямар их ашигт үүрэг заяасан тухай Консельд би ярьж өглөө. Тэд далайн хавтай хамт усан доорхи өтгөн ширэнгэ дотуур билчээрлэн явж, халуун орны гол мөрний адагт шивээлэн ургадаг ургамлуудыг устгадаг бүлгээ.

- Өмнөт Америкийн эрэг орчимд эдгээр амьтныг хүмүүс бүрмөсөн хүйс тэмтэрсний дараа юу болсныг та мэдэх үү? гэж би нэмэрлэн өгүүлээд, гол мөрний адагт далайн замаг ялгарч өмхрөөд ус агаары нь хордуулж тэрхүү хордсон агаарт, тэдгээр гайхамшигт орны гурвалсан ташуур болсон халуун ханиад дэгдсэн юм даа. Хорт ургамлууд халуун орны далайнуудын эрэг орчны усыг буйгаар нь бузарлаж, тэр

аюулт өвчин Рио-де-ла-Платаас хаа байсан Флорид хүртэл дэлгэрсэн юм.

Хэрэв л Консель үнэн хэлж буй юм бол хамгийн эцсийн халим, хав загас хоёрыг хүйс тэмтэрсэн бидний хойт залгамж үеийнхэнд заналхийлж байгаа цагт гай тотгорын дэргэд энэ ч юу ч биш гэсэн үг. Тэр цагт урьд өмнө нь чөлөөтэй үржиж агсан кальмар мэтийн амьтад язалзаж байсан тэнгис далай тэр чигээрээ өвчин халдварын асар их голомт олж хувирах юм. Учир нь “Далайг цэвэрлэх үүргийг байгалиас заяасан тэдгээр арвин ходоод” байхгүй болчих юм гэв.

“Наутилус”-ын баг тэр онолд бодвол бага итгэдэг байсан биз. Тиймээс тэд арав шахам тооны ламантин алж нөөцлөхөөсөө зовсонгүй бөгөөд тэдгээр амьтны мах үхрийн махыг дагуулахгүй амттай бүлгээ.

Тэдгээр амьтныг агнах ажил ямар ч дур сонирхол төрүүлсэнгүй бөгөөд ламантинууд амиа хөмгаалж тэмцэхгүй, зугтааж зайлахыг оролдох ч үгүй алуулах ажээ. Тиймээс “Наутилус”-ын зоорь хэд хэдэн тонн махаар арвижиж дараа нь бид борцолж авсан нь биднийг амтат зоогоор олон хоног хангасан билээ.

Мөн тэр өдөртөө тэндхийн баялаг уснаа хийсэн бас нэгэн сайхан ангуучлал “Наутилус”-ын хүнсний нөөцийг нэмэгдүүлсэн бүлээг. Тэхнээ нь онгоцны тавцан дээр татаж гаргасан торон гогцоонд махлаг дэрэвгэр хөхүүл бүхий гонзгор мөгөөрсөөр шувтардаг толгойтой хэд хэдэн загас тээглэсэн байв. Тэдгээр бол макрелийн язгуурын прилипало гэдэг загас ажээ. Тэдний толгойн гонзгор мөгөөр хоорондоо хийгээр дүүрч түнхийх хөндий зай үүсэх бөгөөд түүний хүчээр тэд ямар ч юманд наалдаж бумбадан хөхлөг юм.

Торноос олдсон прилипалуудыг бүгдийг нь тэр даруй тусгай бэлдсэн хувинтай-усанд хийлээ.

Загас барих ажил дууссаны дараа “Наутилус” эрэг тийш ойртон очвол тун олон тооны яст мэлхий усан дээр унтаж харагдав.

Далайн тэр үнэт мөлхөгч амьтныг барьж авна гэдэг хялбаргүй хэрэг бөгөөд тэд өчүүхэн төдий чимээгээр нойроос сэрхийн гадна, тэдний бат бэх хуягийг нэвт жадлах аргагүй бүлээг. Гэвч, прилипал загасаар тэдгээрийг барих гэдэг тун амархан ажээ. Амьд гох болсон энэ загас ямар ч загасчин хүнийг нэн баярлуулахсан биз.

Далайчнд прилипалуудын сүүлэнд, хөдөлгөөнд нь саад болохгүй нилээд зугууд цагираг бөгжилж, түүнээсээ урт олс уяад нөгөө үзүүрийг нь тавцангийн хашлагад аргамжив.

Усанд тавьсан прилипал тар даруй яст мэлхийд ойртон очиж тэдгээрийн бат хуяганд бумбадан наалдах ажээ. Тэд маш бат хөхөж бумбадсан тул мэлхийн

хуягнаас ховх татахаас өмнө тэднийг өөрснийг нь тас татахаас нааш салахгүйгээр наалдана. Тиймээс одоо тэдний очиж наалдсан яст мэлхийг тавцан дээр татаж гаргахын тул аргамж олсноосоо л авч татах хэрэгтэй байв.

Энэхүү ангуучлалаар Амазонк мөрний адагт бидний саатал шувтарга болж шөнө болохын чацуу “Наутилус” задгай далайд гарч одлоо.

[Тор](#)

---

### НАЙМАЛЖУУД

Хэд хоногийн турш «Наутилус» америкийн эргээс холгүй явлаа. Бодвол капитан Немо, Мексикийн булан, Антилийн арал орчны уснаа явж орохыг хүсээгүй буйзаа Эдгээр усны гүн нь дунджаар мянга найман зуун метр, тэдгээр уснаа орохгүй шалтгаан нь усны гүехнээс болсон гэж болохгүй бизээ. Тоо томшгүй олон арал шивээлсэн, түүнчлэн далайн хөлөг онгоцнууд үргэлж хэрэн хэсч байдаг тэдгээр ус зөвхөн л капитан Немогийн сэтгэлд үл нийцсэн нь үнэнтэй хэрэг.

Дөрөвдүгээр сарын арван зургаанаа Мартинику арлыг бид бараг гучаад милийн холоос харлаа. Би түүний өндөр уулын сэрвэнг алсаас ялган танив.

Эсхүл эндхийн олон арал хооронд зорчигч онгоцнуудын нэгэнд амь зулбах, эсхүл хуурай газар хүрч нуугдах өөрийн төлөвлөгөөг энэ орчинд биелүүлэх хэмээн найдаж агсан канад хүн нэн их гутарсан бүлээг. Хэрэв л Нед Ленд капитан Немогийн нүднээс далдуур завь онгоцыг эзэмшин авч чадах бол оргох явдал дүүрэн бололцоотой байв. Гэтэл тэрхүү задгай далай дунд түүн тухай бодохын ч хэрэггүй байлаа.

Нед Ленд. Консель бид гурав уул байдлыг бүх л талаас нь авч хэлэлцэв. Бид “Наутилус” дээр бүтэн зургаан сар баригдаж байгаа билээ. Бид арван долоон мянган бээр буюу жаран найман мянган километр аялсан боловч Нед Лендийн хэлснээр бидний жуулчлал хэзээ нэгэн цагт дуусна хэмээн таамаглах ямар ч үндэсгүй байв. Тийм учраас биднийг хөлгөн дээрээ тэр хүн бүх насаараа тэгж барьж байхаар шийдсэн эссэний нь хариултыг дуулахыг оролдоод үзэхийг Канад хүн надад тулгав.

Тийм оролдлого ч надад дэмий мэт санагдлаа. Миний бодлоор бол ямар ч хэрэггүй байв. Капитан Немод найдахын хэрэг өчүүхэн ч үгүй гэдгийг бид дээр мэдсэн билээ. Түүгээр ч барахгүй тэр сүүлийн үед, урьд өмнөхөөсөө бүр ч ширүүн, бүр ч дуугүй, бүр ч хавчиг болжээ. Тэр надтай учрахаас зугатаад байх шиг санагдав.

Би түүний барааг нь удаж байж хардаг болов. Тэр нэгэн цагт энэ хүн надад усан доорхи гайхамшгуудыг үзүүлэн зугаацдаг байсач бол одоо үзэсгэлэн танхимд ч орж ирэхээ больжээ.

Түүний сэтгэл санаанд юу болчихов со? Юунаас тэр вэ? Би өөрийгөө зэмлэх гээд зэмлэх юм олсонгүй. Бид түүний онгоцон дээр байгаа явдал түүнд тээр болоо юу? Тэртэй тэргүй би энэ нэгэн хүн бидэнд хэзээ нэгэн цагт эрх чөлөөг маань эргүүлэн өгнө гэдэгт итгэхгүй байв.

Нед Лендээс би, түүний тулгасан зүйл дээр жаахан бодох бололцоо өхийг гуйлаа. Хэрэв л тэр оролдлого бүтэхгүй бол капитан Немод сэжиг төрүүлж Канад эрийн төлөвлөгөө хэрэгжүүлэх явдалд саад учрах байв. Тэгвэл тэнд бидний байх байдал бүр ч зовлонтой болох болно.

Бидний дотроос хэн маань ч биеийнхээ эрүүл мэнд бус байгаад ямар нэгэн талаар гуншиж зовлон тоочсон удаа байгаагүй гэдгийг би хэлэх хэрэгтэй. Хэрэв л өмнөт туй-лын мөсөн дунд бидний үйлээ үзсэнийг ул тооцвол бид хэзээ ч тиймэрхүү эрүүл саруул байгаагүй бүлээг. Тэжээлтэй хоол, цэвэр агаар, түвшин байдал, жигд температур энэ бүхэн өвдөхийн нөхцөлгүй болгож байв.

Харин капитан Немо бол хуурай газрын тухай дурсан харамсах өчүүхэн ч зүйлгүй бөгөөд тэр хаана ч явсан үргэлж өөрийн орон гэрт байх тул түүний тэр амьдрал өөрт нь зугаатай гэдгийг би ойлгож байв. Гэтэл бид, бид бол хүн төрөлтөнтэй холбоо тасраагүй, таслахыг ч хүсээгүй билээ. Жишээлбэл би, усан доор үйлдсэн өөрийн дуу шуугиан дэгдээм ховор сонин ажиглалтыг өөртэйгөө энд оршуулах өчүүхэн ч хүсэлгүй байв.

Одоо би, далайн ёроолын нууцын тухай ном бичих бүрэн эрх олсон бөгөөд өөрийн бичсэн номыг эрт орой боловч хэвлэгдэн гарсан байхыг хүсч билээ.

Ядаж энэ нэгэн хэсэг усанд энэ Антилийн арлуудын эргийг дэлдэн буй усны хэдхэн метрийн гүнд би хичнээн сонирхолтой ажиглалтуудыг хийж өдөр тутам тэмдэглэлдээ бичив гээч!

Энд биеэсээ шингэн бодис ялган гаргах, тэр мөртөө хал гай мэт түлдэг медузтэй ч учирлаа. Мөн цагирагт хорхойнуудын дотроос мянга долоон зуун тооны хөдлөх эрхтэнтэй ягаан хушуутай, метр хагас урт биетэй аннелид хэмээх хорхой энд бас байв. Усан доор тэд мушилзан явж өнгө өнгийн гэрэл туяа цацруулан харагдлаа. Мөгөөрст загаснаас толгойныхоо урд талд бүлтийлгэн байх нүдтэй, нурууныхаа голоор гөвгөр, цээжиндээ гурвалжин сэлүүртэй зургаан зуун фунт жинтэй, арван фут урт аврага скат байв. Тэд сүйрсэн онгоцны эвдэрхий мэт усан доор нэвсийн хөвж

манай онгоцны цонхонд ирж наалдан халхавч мэт бүтээж байлаа. Энд бас Америкийн спинорог үзэгдсэн нь байгалиас заяасан хоёрхон өнгө хар, цагаан хоёр ажээ. Түүнчлэн богинохон боловч хурц шүдтэй метр хагас урт биетэй макрель харагдав. Цаашилбал гайхмаар гоё сэлүүртэй; толгойноосоо сүүлээ хүртэл алтан шар судал бүхий султанк сүрэг сүргээрээ явав. Байгаль бодисын нэгэн ганган бүтээл болсон эдгээр загасыг хэзээ нэгэн цагт эх дагина Дианад зориулсан гэж байсан бөгөөд ромын баячуул ялангуяа их үнэлдэг байжээ. Түүгээр ч барахгүй тэдний тухай “Султанкийг барьдаг хүн түүнийгээ иддэггүй” гэсэн зүйр үг хүртэл байсан юм. Ингээд хамгийн эцэст Веронезийн зураг дээрх ихэмсэг эрхмүүд мэт торго хоргой өмссөн юм шиг ганган загаснууд бидний нүдний өмнүүр хөвөн хөвөн өнгөрсөн нь шүрэн арлын загасны язгуурын алтан хувраг гэдэг загас ажээ. Бяцхан биет, цовоо спарууд тэдний ойртон ирэхэд бут үсрэн зугатаж байв. Бас кефалууд өөрсдийн махлаг чийрэг сүүлээр ус зүсэн өнгөрч байлаа. Мөнгөлөг сараи загас, ёстой л тэнгэрт гийх сар шиг цагаан гэгээ цацарган явах нь аргагүй сараи загас гэсэн нэрээ хадгалах ажээ.

Хэрэв л «Наутилус» усны хамгийн гүнд живж ороогүйсэн бол би хичнээн гайхамшиг шинэ шинэ дүрс загас олж үзэх байв аа! Тэр гурван мянга таван зуун метрийн гүнд оров. Далайн энэ орчны амьдрал далайн одод, медузууд, хэдэн төрлийн зөөлөн биетнээс бүрэлджээ.

Дөрөвдүгээр сарын 20-ноо бид мянга таван зуун метрийн гүнд явлаа. Бидэнд хамгийн ойр байгаа хуурай газар гэвэл Багамын арлууд байв. Тэр арлууд далай дээр бул хар чулуу мэт ил гардаг бүлгээ. Тэнд усан доорхи өндөр хадад эрвийн гарч, эгц чавчим энгэр шил нь далайн уснаа гөлийтөл өнгөлөгдсөн байв.

Тэдгээр хад Фуко хэмээх аврага замганд битүү хучигдсан нь ёстой л эрлэгүүдийн ертөнцийн эзэд ноёрхож байх цэцэрлэг ажээ.

Тэр их замгийн ерөнхий байдал, бидний толгойд далайн аврага амьтдын тухай бодол төрүүлсэн нь мэдээж хэрэг билээ. Тэгэвч “Наутилус”-ын цонхоор миний харснаар бол тэдгээр замгийн усан доорхи урт урт мөчир дээр, зөвхөн л хавч хэлбэртний язгуурын хэд хэдэн төлөөлөгч урт доёгор хавчуур бүхий улбар ягаан өнгийн дигваранз үзэгдлээ.

Шигүү ургасан өндөр замган дотор болж байгаа ямар нэгэн юмны зүг Нед Ленд миний анхаарлыг хандуулах үед өдрийн арван нэгэн цаг болж байв.

- Энэ бол наймалжууд байхад тун тохиромжтой газар хэмээн би өгүүлж хэрэв тэр гайхлыг энд олж үзвэл би өчүүхэн ч гайхахгүйсэн. Тэгвэл Нед хонгор минь та эндүүрэв биз. Энд би сэжигтэй юм ер юу ч үзэхгүй байнам гэв.

Ай хайран хэмээн Консель дуугарч -би тэр наймалжийн чинь нэгий нь ч гэсэн ядаж ойроос сайн ажиж авахаас буцахгүйсэн. Тэрний чинь би бүхэл бүтэн хөлөг онгоцыг далайн ёроол руу аваад орчихож чаддаг гэж дуулсан юм. Тэр гайхлы чинь крак... хэмээн цааш нь ярих гэтэл Канад хүн түүний яриа тасдан авч:

- Крак-тэгээд л гүйцээ! хэмээн ёжлов. Гэвч Консель түүний ёжлохыг ер үл тоомсорлок:

- Кракен гэдэг юм гэв.

- Дэлхий дээр тийм гайхал байдаг гэж би үхсэн заяандаа ч үнэмшихгүй гэж Нед Ленд хэлэв.

- Яагаад байдаггүй юм? Нарвал байдаг гэдэгт бид үнэмшиж байсан биш билүү хө гэж Консель өгүүлэв.

- Бид тэгээд эндүүрсэн шүү дээ, Консель гуай!

- Тиймээ үнэн! Гэвч өөр хүмүүс түүнд бас л үнэмшсээр байгаа шүү дээ!

-Болох юм за, Консель минь, харин миний хувьд бол би тэр гайхлыг-чинь өөрийн гараар өвчиж задлан шинжлэхээс нааш үнэмшихгүй л дээ гэж хэлэв.

- Тэгвэл эзэнтэн та аврага наймалж бий гэдэгт үнэмшихгүй байгаа хэрэг үү?хэмээн Консель хэлэхэд, Нед Ленд:

- Хэн тэрүүнд чинь үнэмших байв аа? гэж бархирлаа.

- Олон хүн үнэмшиж байгаа юм аа, найз минь.

- За загасчид л үнэмшээгүй дээ. Харин эрдэмтэд л магадгүй.

- Уучлаарай Нед гуай, загасчид ч, эрдэмтэд ч аль аль нь үнэмшиж буй юм шүү.

- Тэгвэл би, би өөрөө хэмээч Консель үнэн голоосоо бололтой-өөрийнхөө энэ нүдээр, тэр наймалж гэдэг амьтан далайн том онгоцыг далайн ёроол руу аваад орчихыг үзсэн юм гэв.

- Та үүнийг үзсэн гэж үү? хэмээн Канад хүн асуув.

- Тиймээ, Нед ээ.

- Бүр өөрийнхөө нүдээр үү?

- Тиймээ, хонгор минь.

- Хаахна юм бол, мэдмээр байх юм?

- Сен-Малод хэмээн Консель ажиг ч үгүй хэлж суув.

- Боомтонд уу? гэж Нед доог хийж асуувал,

- Үгүй ээ, сүмд гэж Консель хариулав.

- Сүмд ий? хэмээн гайхаж хоцорсон Канад хүн лавлан

- Тийм ээ, Нед ээ. Тэнд яг бидний саяны ярьдаг тийм наймалж зурсан тийм хөрөг



байсан.

- Аа чи тэгнэ ээ! хэмээн Нед Ленд хашгараад, дараа нь тачигнатал инээж, Консель одоо надаар тохуу хийх нь хөөе! гэлээ.

Конселийн хэлдэг үнээн, би тэр зургийн тухай сонссон юм. Түүний сэдвийг домог ярианаас авсан юм билээ. Ялангуяа гайхал амьтдын тухай яриа дэгдсэн цагт байгалийн хөгжлийн түүхээс эх авсан домог ярианд хэрхэн хандах тухай та нар мэдэх ёстой. Энэ талаар хүмүүсийн дүрслэн бодох нь танагаа алддаг юм. Хүмүүс наймалжийн тухай ярианд сэтгэл ханадаггүй юм. Ялангуяа далайн ёроол руу бүхэл бүтэн онгоц аваад орчихдог гэвэл бүр ч дүүрэх нь тэр. Николай Магнус гэгч нэг этгээд амьд амьтан гэхээс арал хойг гэмээр, нэг миль урт биетэй тийм том наймалж олж үзсэн гэж ярьдаг. Бас тэр нэг этгээд хамба лам Нидроский гэгч асар том хадан хясаан дээр буян ном үйлдэж байгаад дууссаны дараа уул хадан хясаа нь харин хөдөлж хөвж одсон гэдэг. Тэхнээ нь тэр хадан хясаа нь наймалж байснаас зайлсангүй.

- Тэгээд гүйцэх нь тэр үү? гэж Канад хүн асуув.

- Үгүй ээ, гүйцээгүй хэмээн би хариулаад, өөр нэг хамба лам Понтопидан Берхемекий гэгч морин цэргийн бүхэл бүтэн хороо зорчиж уужуу багтмаар наймалжийн тухай мэдээлсэн удаа бий! гэвэл, Канад хүн:

За мөн, залдаг хүн байнадаа, тэр хамбатангууд чинь! гэлээ.

- Ингээд, хамгийн эцэст хэлэхэд, эртний байгальчдын ярьсан гайхлуудын амь нь далайн булан тохой мэт том, бие нь Гибралтарын хоолойгоор багтаж гарахгүй лужир байжээ гэнэ.

- За мөн, хэмжээ л гэгч байна даа тэр чинь гэж Канад эр өгүүлэв.

- Тэдгээр ярианд тэгээд үнэний хувь хэдийчнээн байна даа тэхэд хэмээн Консель асуув.

- Юу ч байхгүй. Үнэний сүүдэр ч алга. Үүнийг яригчийн санаанд хэрэв л шалтаг нь биш бол адаглаад өө нь хэрэгтэй буйзаа. Асар том биетэй наймалж дигваранз бий гэдгийг няцааж болохгүй, тэхдээ тэд халим хэлбэртний дэргэд юу шалихав дээ. Жишээлбэл, таван тохой буюу гурван метр арван сантиметр урт пальмир байдаг гэж Аристотель баталсан юм. Манай үеийн загасчид ихэвчлэн бараг хоёр метр урт кальмартай учирсан юм. Байгалийг судлагчдын бодож гаргаснаар кальмар ч юм уу, наймалж ч юм уу; ер толгой хөлт зөөлөн биетэн бүдүүнээрээ зөвхөн зургаан фут боловч хорин долоон фут урт тэмтрүүлтэй байдаг юм. Энэ нь аймшигт том гайхал гэж ярихад болох шалтаг бизээ!

- Одоо үед наймалж агнадаг юм уу? гэж Канад хүн асуув.

- Агнадаг уу; үгүй юу, бүү мэд. далайчид ч түүнтэй дайраллдаг л даа. Миний нэг найз, Гавр нутгийн далайчин, капитан Поль Бос энэтхэгийн гадаад далайд асар том наймалжтай нэг өдөр дайралдсан гэж ярьсан юм. Гэвч, тэр гайхал амьтан байдаг эсэхэд эргэлзэх явдлыг эцэс болгосон хамгийн сонирхолтой учрал анх 1861 онд болсон юмдаг.

- За тэр чинь юу билээ? хэмээн Нед Ленд асуулаз.

- Одоо ярья. 1861 онд Тенерифээс зүүн хойт зүгт, бараг одоо бидний энэ явж буй өргөрөг дээр “Алектон” хэмээх шуудангийн хөлөг онгоцныхон асар том хэмжээний наймал ж олж үзлээ

Онгоцны капитан Буге уул амьтанд ойртон очиж буудаж жадлан дайрсан боловч амжилт олсонгүй нь түүний сум, жад хөвөн мэт зөөлөн биеийг хий л сүлбэн гарахаас өөр үр үзүүлсэнгүй ажээ. Онгоцны баг урт удаан хугацаагаар түүнтэй хий дэмий хөөцөлдсөний дараа сая нэг бугуйлдаж авсан гэнэ. Гэвч, бугуйлын нь гогцоо шувтран уруудсаар сүүлний нь сэлүүрийн угт тогтжээ. Тэгээд тэр гайхлыг онгоцон дээрээ татаж гаргахыг оролдсон боловч түүний хүнд гэдэг нь учиргүй тул бугуйлын гогцоонд хоёр тус хэрчигдэж, сүүл нь тасарч үлдээд, суларсан бие нь далайн давалгаан дунд шурган орж алга болсон гэдээг.

- Энэ хэрэг тэгээд бодитой юм уу? гэж Нед Ленд асуув.

- Маргаангүй үнэн зүйл, Нед минь. Тэр гайхлыг Бугегийн нэрээр нэрлэх санал гарч байсан юм шүү.

- Уртаараа хэдий хэр байсан бол? хэмээн Канад хүн асуулаа.

- Зургаан метр сэн байх аа? гэж Консель хэлчихээд цонхны дэргэд зогсон доорхи хад хясааны завсар заальхай бүрийг дахин ширтэж эхлэхэд:

- Яг тийм гэж би хариулав.

- Тэгвэл тэрний чинь толгой үүрэндээ буй могой мэт арваганан байх найман тэмтрүүлтэй биз?

- Яг мөн.

- Нүд нь бүлтгэр биз?

- Тиймээ, Консель минь.

- Ам нь тотийн хоншоор шиг махир, зөвхөн л түүний дэргэд асар том хэмжээтэй биз?

- Тун зүйтэй.

- За тэгвэл нэн сайн! Эзэн хэрэв зөвшөөрөхсөн бол хэмээн Консель аажуухан

дуугаар, Бугегийн тэр наймалж чинь энэ л байна даа. Үгүй дээ л, ядаж түүний хамгийн ойр төрөл садангийн нь нэг нь байна даа гэв.

Би гайхахдаа Консель руу харав. Нед Ленд цонх руу гүйн очлоо.

- Яасан аймшигтай эд вэ! хэмээн тэр бархирав. Би цонхоор гадагш хараад жигшиж зэвүүцэх шиг боллоо. Ёстой хамгийн аймаар, үлгэр домогт гарч болмоор гайхал муухай амьтан миний нүдний өмнө илхэн байв. Тэр бол найм орчим метр урт, аврага том биетэй наймалж ажээ. Биднээс тэр, ногоовтор цэнхэр нүдээ үл салган, “Наутилус” руу тун хурдан ирж явлаа. Толгойноосоо шууд салаалсан кайман тэмтрүүл буюу хөл, энэ хэлбэрийн амьтныг толгой хөлтөн хэмээн нэрлэгдэх үндэс нь болж, түүний их биений хэмжээг хоёр дахин өсгөжээ. Түүний тэмтрүүлүүдийн дотор талд байгаа тал сар маягийн хоёр зуун таван тооны хөхүүлийг сайн ажиж болох байв. Заримдаа тэдгээр тэмтрүүл онгоцны цонхонд наалдах мэт болж байлаа.

Тэр гайхлын эвэрлэг махир ам тотийн хушуу адил ангайж хамхиж байв. Мөн бас л ямар нэгэн эвэрлэг эдээс бүрдсэн түүний хэлэнд олон эгнээ хурц хурц шүд ярзалзаж, түүний бахь мэт аймшигт том амнаас гозолзож харагдлаа. Байгаль гэдэг ер нь ямар хачин ааштайдаг вэ! Очиж очиж зөөлөн биетэнд шувуу хушуу бүтээнэ гэнээ!

Наймалжийн дундуураа цүлхгэр болж ирээд, зэрүүл маягмий бие дор хаяж хорь буюу хорин таван мянган килограмм хүрэх махлаг тэнтгэр зовлого байв. Түүний өнгө тогтмол бус, үнэслэг бороос, улаавтар хүрэн хуртэл тасралтгүй хувирч байлаа. Тэр нэгэн зөөлөн биетэн юунаас болж тэгж муухай аашилна вэ? Мэдэж ядах юу байх билээ. Түүний хөхүүл бүхий тэмтрүүлүүд, аймшигт шүд «Наутилус»-т ямар ч нөлөө үл үзүүлэх нь ууры нь хүргэхсэн биз.

Тэдгээр наймалж гэдэг ямар аймаар муухай амьтад вэ? Амьдралын ер бусын ямар их хүчийг байгаль түүнд заяаж, тэдгээрийн явах хөдлөх бүрд ямар их чадал харагдана вэ!

Ердийн нэгэн тохиолдол, биднийг наймалжтай золгуулсан тул хөл толгойны нь тэр нэгэн эрхмийг тодорхой судлах энэ нэгэн ганц бололцоог би орхигдуулахыг хүссэнгүй. Тэр амьтныг харж хэдий их зэвүүцэх боловч би биеэ барин, түүнийг зурж гарлаа.

- Энэ наймалж, өнөө “Алектон” онгоцны барьдаг тэр наймалж байж юу магад? гэж маргалдаж-энэ чинь бүтэн юм байхчив. Тэгвэл тэр өөрийнхөө сүүлийг гээсэн биш үү! гэв.

- Тэр баталгаа бишээ гэж би ундууцан өгүүлээд энэ амьтны сүүл, тэмтрүүл хоёр

дахин ургадаг юм. Тэгвэл Бугегийн наймалж өдий долоон жил өнгөрөхөд гүйцэж ургах цаг хэдийнээ болсон гэв.

- Гэлээ ч гэсэн энэ нэгэн эрхэм Бугегийн наймалж биш байсан ч эдгээрийн дунд байж юу магад вэ гэлээ.

Үнэхээр, хэд хэдэн том наймалж цонхон цаана бий боллоо. Тоолбол долоо байв. Тэд “Наутилус”-ыг тойрон арвалзаж, онгоцны ган хуягийг чахартал мэрж сонсдов. Ажиглалт хийхэд ёстой л сайхан тохиол аж: Тиймээс ч би ажлаа үргэлжлүүлээ. Гайхлууд биднээс ганц ч алхам холдохгүй байв. Тэд ер хөдлөхгүй мэт тул хэрэв л би хүссэн бол тэдгээрийн ерөнхий дурсийг цонхны шилэн дээр зурчиж болох байлаа. Түүгээр ч барахгүй тэхэд бид нилээд зөөлөрсөн жигд хурдтай явсан юм.

Тэгтэл “Наутилус” гэнэт зогсчихов. Чочирхон ширүүн ёворгоонд хөлгийн бүх бие доргин донслов.

- Бид ямар нэг юм мөргөчихөвөө дөө? гэж би асуулаа.
- Ямар ч гэсэн, тэр саад өнгөрөв шиг болтой. Бид дахин хөдөллөө хэмээн Канад хүн хариулав.

“Наутилус” яах ч аргагүй хөдлөхийг оролдон зүтгэсэн боловч байрнаасаа ахисангүй. Түүний сэлүүр сэнсний далбаа ус сэлэхгүй байв.

Минут хэрийн дараа капитан Немо, өөрийн туслагчийн хамт үзэсгэлэн танхимд орж ирлээ.

Би капитаны барааг олж хараагүй нилээд удсан билээ. Миний нүдэнд тэр нэг баргар царайтай харагдав. Биднийг тэр хараагүй ч байж магадгүй, бидний зүг өчүүхэн ч анхааралгүй яван явсаар цонхны дэргэд очиж, наймалжуудыг ширтэн зогссоноо туслагч руугаа хандан хэдэн үг хэллээ.

Тэр гарч одов Удсан ч үгүй цонхны халхавчууд хаагдан, үзэсгэлэн танхимын таазанд гэрэл аслаа. Би капитан руу ойртон очиж:

- Наймалжуудын гайхалтай сонин цуглуулга байна гэж тэхээс тэх гэж хэлэв.
- Тэр үнээн, эрхэм байгальч гуай гэвч бид эдэнтэй үхэх сэхэхээ үзэлцэнэ дээ!

Би капитан руу гайхан харав. Түүний үгийг дуулсангүй шиг санагдав.

- Үхэх, сэхэхээ үзэлцэнэ ээ? гэж би лавлан асуувал:

-Тиймээ, профессор минь. Сэнс эргэлдэхээ больчихлоо. Бодвол түүний далбаатай энэ наймалжуудыг эвэрлэг эрүү ам зууралдчихаа биз гэж би бодном. Тэгээд л биднийг хөдөлгөхгүй байхгүй юу.

- Та тэгээд яах гэж байгаа юм?

- Дээшээ гарч эдгээр муусайн хогийг устгах хэрэгтэй,

- Хүнд л хэрэг байна даа.

- Тэр үнэн. Эдний энэ сэвсгэр зөөлөн биед бидний цахилгаан сум юу ч хийж чадахгүй. Сумнууд маань эдгээрийн бие руу ороод эсэргүүцэл үзэхгүй болохоороо тэсрэхгүй гэсэн үг. Тиймээс сүх бариад л алалдаж орохоос биш яая гэхэв.

- Мөн түүнчлэн жад бариад хэмээн Канад хүн дуун гарч, хэрэв капитан та миний өчүүхэн туслалцаанаас үл татгалзах бол...

- Би юунд татгалзах билээ эрхэм Нед. Бид ч гэсэн тантай явна гэж капитанд хэлэв. Дээшээ гарах шатны дэргэд сүхээр зэвсэглэсэн арваад далайчин зогсч байв. Консель бид хоёр тус бүр нэг нэг сүх авлаа. Харин Нед Ленд жадаар зэвсэглэв.

«Наутилус» усан дээр хөвөн ил гарч ирлээ. Далайчдын нэг нь шатны хамгийн дээд гишгүүр дээр зогсч байгаад тавцангийн тагны эргийг мултлав Уул эргийг тэр дөнгөж мулталж амжтал, бодвол наймалжин тэмтрүүл хөлсний дотор хөхүүлд хөхөгдөн сөхөгдсөн болов уу, гэнэт гэдрэг шидэгдэв. Мөн тэрхэн зуур тавцангийн нүхээр түүний урт хөл могой мэт гулган орж ирлээ.

Тэр аймшигт тэмтрүүлийг капитан Немо сүхээрээ тас цавчин хаяхад, тасархай хэсэг нь мушгиралдан атрилдсаар шатны гишүүр дээгүүр гулган уналаа.

Бид тавцан дээр аль түргэн гарахыг яаран өөр хоорондоо түлхэлдэн чихэлдэх завсар өөр нэгэн, хоёр тэмтрүүл хөл яах ийхийн зуургүй мушгиралдан ирж капитан Немогийн өмнө зогсож агсан далайчныг ороон авч, аймшигтай их хүчээр зангирлаа. Капитан Немо муухай хашгаран ухас хийв. Бид ч гэсэн түүний хойноос дайрав. Ямир аймшигтай юм болов оо! Биед нь наалдан хөхсөн тэмтрүүлүүд баглагдсан тэр хөөрхий агаарт шидэгдэн гарч аахилан, гяхтнан сарвалзах зуураа:

- Туслаач! Туслаач! гэж бархирлаа. Францаар хашгирсан тэр үгс надад нэн гайхагдав. Тэхээрээ энд, энэ онгоцон дээр надтай нэг нутаг усны хүн нэг байсан байх нь ээ? Нэгээр ч барахгүй хэд хэд байж юу магад билээ. Тэр нэгэн элэг эмтрэм дууг би бүх насаараа мартаггүй.

Хөөрхий тэр эцэслэж байв.

Хэн түүнийг тэр сүрхий зангирсан баглаанаас ангижруулж чадах билээ? Капитан Немо наймалж руу гүйн очиж бас нэг хөлийг нь тас цохив. Түүний туслагч “Наутилус” өөд авирч буй хоёр наймалжтай галзуурсан мэт ялалдаж байлаа. Бид бүгд сүхээрээ л тулалдсаар билээ. Канад хүн, Консель бид гурав өөрсдийн зэвсгийг тэдгээрийн махлаг зөөлөн биед нь зоосоор бүлсээр л байв. Агаарт цусны хангинам хурц үнэр ханх тавив.

Наймапж ороож аваачсан тэр хөөрхий нэг үедээ надад тэр амьтны аймшигт

хөхүүлээс салгаж болмоор санагдав. Тэр наймалжийн найман хөлний долоо нь тас цавчигдаж, зөвхөн үлдсэн ганц л олзтой хамт өт мэт гозолзож байлаа. Гэвч капитан Немо, туслагчийнхаа хамт түүн рүү нь дайрахын хамт тэр наймалж ходоодон дотроо тусгай саванд хадгалан явах харавтар өнгийн шингэн бодис гаргаж цацлаа. Бид юу ч үзэхгүй болов. Тэрхүү шингэн хар хөшиг арилсны дараа, өнөө наймалж өөрийнхөө олзны хамт алга болсон байв!

Бид бараг галзуурахын эрхэнд ямар болсон гэж санана! Улангасахдаа бид бүр зэрлэгшжээ. “Наутилус”-ын тавцан өөд арав буюу арван хоёр наймалж авирч эхэллээ. Онгоцны тавцан дээгүүр хутгалдсан мах, цус, хар өнгийн шингэн бодис дунд могой мэт мурилзан тахиралдан буй тасархай чавхдас дотор бид бүр тэр чигээрээ умбаж байв.

- Тэдгээр наалданги нялцгай тэмтрүүл хөл, хөндий биетний олон толгой адил дахин шинээр ургаад байх шиг санагдав.

Нед Лендийн жад наймалжийн цэнхэр ногоон нүдэнд хатгах бүр тусч сохолж байв. Гэтэл манай эрэлхэг нөхрийг маань бултаж амжихаас нь өмнө гайхлын тэмтрүүл гэнэт ороон авлаа.

Тэхэд миний зүрх айсан сүрдсэндээ яаж эс хагарчихсангүй билээ? Наймалжийн аймшигт хушуу Нед Лендийн халз дээр нь ангайж харагдлаа. Нэг л секунд өнгөрсөн бол хөөрхий тэрнийг хоёр хэсэг болгочих байлаа. Би түүнд туслахаар яаравчлав. Гэвч капитан Немо надаас өрсөж амжив. Түүний сүх гайхлын асар том эрүүнд зоогдож, заяагаар аврагдсан Нед хөл дээрээ босч ирмэгц өөрийн жадыг наймалжийн зүрхний угт нь тултал шаачив.

- Би танд өглөгтэй байсан биш үү гэж капитан Немо Канад хүнд өгүүлэв. Нед дуу гарсангүй мэхийн ёсоллоо. Энэ тулалдаан цаг хагасаас хэтэрсэнгүй тагсгал болов. Ялагдаж, зэрэмдэглэгдсэн гайхлууд тулалдааны талбарыг орхиж, давалгаан дунд орж алга балов.

Хамаг нь цус болсон капитан Немо, прожекторын бүхээгний хажууд, нөхдийнхөө нэгийг залгисан далайг ширтэж зогслоо. Нулмисны том том дусал түүний нүднээс унаж байв.

[Top](#)

## ГОЛЬФСТРИМЫН ДУЛААН УРСГАЛ

Дөрөвдүгээр сарын 20-нд болсон тэрхүү аймшигт явдлыг бидний дотроос хэн маань ч, хэзээ ч үл мартана. Дөнгөж сая миний тийнхүү үзэж өнгөрсөн сэтгэл мэдрэлийн нэг түгшүүр гүйцэд арилаагүй байхад тэр явдлын тухай би тодорхой тэмдэглэн авлаа. Дараа нь би өөрийнхөө өгүүллэгийг дахин хянаж, нөхөддөө уншиж өгөв. Миний бичсэнийг тэд яг зөв гэж дүгнэсэн боловч төдий л хангалттай биш гэлээ. Иймэрхүү үйл явдлыг зурж бичихийн тул манай үеийн агуу их шүлэгчдийн нэг Виктор Гюгогийн авъяас чадвартай байх хэрэгтэй билээ.

Капитан Немо далай өөд ширтэн уйлж агсан гэж би дээр хэлсэн бүлээг. Тэр хязгааргүй их гашуудаж байв. Бид хамтран аялсан энэ хугацаанд хоёрдохь нөхрөө алдаж буй нь тэр билээ! Юутай аймшигтай үхэл бэ! Наймалжийн аманд үртэх, хөлд нугачигдан няцлагдаж талийгаач болсон тэр хүн; түүгээр ч барахгүй далайн шүрэн ёроолын амгалан уснаа бусад нөхдийнхөө хамт нойрсох хувьгүй ажээ.

Алалдааны үед гэнэт сонсодсон муухай дуунд миний ч гэсэн дотор шижигнэсэн билээ. Тэр хөөрхий Франц хүн үхлийнхээ өмнөх цагт өөрийн нууц хэлийг мартаж, төрөлх хэлээрээ хашгарсан ажээ.

Үүнээс үзвэл капитан Немод бүх л бие, сэтгэлээрээ үнэнч шудрага зүтгэж тэрний нэгэн адил хүн төрөлхтнөөс үүрд, зугатсан “Наутилус”-ын багийнхан дотор надтай нэг нутгийн хүн байсан бүлгээ. Бодвол нэн олон янзын үндэстэн ястнаас бүрдсэн энэ нэгэн хачин улс дотор тэр ганцаархнаа байсан болов уу? Энэ бол надад тулгарсан тааварлашгүй олон асуудлын нэг билээ..

Капитан Немо өрөөндөө одож, би түүнийг хэд хэдэн өдөр олж үзсэнгүй ээ.

Гэвч капитаны бүхэл сэтгэл зүрхний тольт болсон усан доогуур явагч хөлгийн хөвөх байдлаар капитан Немогийн эмгэнэл гашуудал хэдий хуурамч бус, хэдий асар их байсныг болон түүний сэтгэлийн шаналгаа хэр зэрэг байсныг би ажиж болох байв. “Наутилус” жолоодлогогүй болжээ. Тэр далайн давалгааны эрхэнд хүүр адил хааш л бол хаашаа л шидэгдэж явлаа. Түүний сэлүүр сэнс одоо суларсан боловч, дөнгөж хөдлөх төдий ажээ. Капитан Немо өөрийн нөхдийн нэгийг залгисан тэр далайн тулалдааны энэхүү талбараас хагацаж ядан байв. Тиймэрхүүгээр арав хонолоо.

Зөвхөн тавдугаар сарын 1-нд “Наутилус” умар зүг рүү шууд чиг авав. Багамын сувгийн адаг, Багамын арлууд тийш умарт зүг өөд эрслэн чиглэлээ.

Энэ хэр бид, өөртөө тусгай температур, ургамал эрэг хязгаартай далайн том

мөрний урсгал уруудан хөвж байв. Энд би Гольфстримын дулаан урсгалын тухай ярьж байна.

Нээрээ ч үнэхээр Атлантын гадаад далайн дундуур чөлөөтэй урсдаг, ёстой жинхэнэ энэ мөрний ус далайн устай хэзээ ч холилдоогүй юм.

Тэр мөрний ус түүний орчны далайн уснаас шорвог ажээ. Түүний дундаж гүн гурван мянган фут, дундаж өргөн жаран миль, урсгалын нь дундаж хурд цагт дөрвөн километр юм.

Атлантик далайн экваторын бүсэнд тогтмол салхилдаг умар дорнотын халуун салхины нөлөөгөөр. халуун орны галдам халуун наранд халж бүлээссэн далайн гадарга талын усны асар их цутгалан, Атлантын галаад далайг огтлон өмнөд Америкийн зүг тэмцдэг бүлээг. Тэгээд Америкийн эрэг орчинд уул урсгал Гольфстрим гэсэн өөрийн нэрийг олж, тэрхүү бүлээн уст арвин урсгал Антилийн далайн халуун усаар дамжин гарахдаа бүр ч халдаг ажээ. Дэлхийн бөмбөрцгийн температурыг тэнцэтгэх тавилантай Гольфстрим яг энд л өөрийн үүрэгт ажилдаа ордог билээ!

Мексикийн буланд бараг буцлах болтлоо халсан тэр урсгал умарт зүг рүү хойт Америкийн эрэг өөд өгсөж Нью фауленд хүрч Дэвисийн хоолойн хүйтэн урсгалд түрэгдэн чиглэлээ өөрчлөн их цагиргийн гадаад хүрээгээр тойрч, задгай тэнгис өөд дахин ордог билээ.

Дөчин гуравдугаар өргөргийн дэргэд Гольфстрим хоёр салаалж, нэг нь умарт дорнотын бүлээн салхины нөлөөгөөр Азовын арлууд руу Бискайскийн буланд эргэж орох бөгөөд нөгөө нь Норвеги, Ирландын эрэг орчмын усыг бүлээцүүлж, цаашлан Шпицберген хүрээд, дөрвөн градус хүртэл хөрч умарт туйлын задгай далайг үүсгэдэг юм.

Гольфстрим Багамын сувгаас гармагцаа, өргөөшөө арван дөрвөн бээр, гүнээрээ гурван зуун тавин метр багтаамжийг эзлэн цагт найман километр хурдтай урсана. Энэ хурд нь хойшлох тутам багасч ирдэг билээ. Хурд нь тийнхүү аажим алгуур багасдагийг нь л шүтэн биширдэг байвал зүйтэй бөгөөд хэрэв урсгалы нь тэр хурд чиглэл хоёр гэнэт хувирчихвал Европын уур амьсгалд ямар аюул учирч болохыг тааварлан бодоход ч хэцүү аюултай юмаа. Ийм л мөрнийг даган “Наутилус” хөвж явав. Үд дунд Консель бид хоёр тавцан дээр зогсч байлаа. Би түүнд Гольфстримын зарим онцлогийн тухай ярьж өгч байв.

Яриагаа дууссаны дараа би түүнийг гараа усанд дүрж үзэхийг зөвлөвөл Консель миний үгэнд орж усны халуун хүйтний алиныг ч мэдэрсэнгүйдээ нэн их гайхаж билээ.



- Үүний учир бол хэмээн би түүнд тайлбарлаж-Гольфстримын урсгалын температур Мексикийн булангаас гарахдаа хүний биений температураас бараг ялгагдахгүй юм. Гольфстрим бол дулааны эх үүсвэрийн арвин их сан. Түүний үрээр Европын эрэг мөнхийн ногоон ургамлаар бүрхэгдэн байгаа юм. Нарийн бодож гаргаснаар Гольфстримын усыг бүлээцүүлэхэд байгалиас зарцуулж буй дулааны энерги Амазонка буюу Миссурийн нэгэн адил төмөр мөрөнг хайлмаг байдалтай цалгиулж байхад элбэг хүрэлцэхүйц юм.

Гольфстримын урсгалын хурд энэ орчинд секундэд хоёр метр хагаст хүрч байв. Түүний урсгал орчны далайн уснаас эрс ялгаварлагдах ажээ. Түүний давсаар баялаг цэвэрхэн цэнхэр хөх өнгөөрөө далайн усны нов ногоон дэвсгэр дээр тод ялгарч байлаа.

Тэдгээрийн хоорондын зааг шугам маш тод байсан нь Каролины арлуудын орчинд “Наутилус”-ын хоншоор Гольфстримын усыг зүсэн явахад, сэнс нь тэнгисийн усыг хөөсрүүлсээр явахыг ажиглаж болох байж билээ.

Түүнчлэн Гольфстрим амьд байгалийн бүхэл бүтэн ертөнцийг хойноосоо дагуулж явлаа. Энд Газрын дундат далайд оршдог аргонавт сүрэг сүргээрээ аялж байв. Мөгөөртний дотроос хамгийн ил танигдахуйц нь скатууд байсан бөгөөд тэдний зөвхөн сүүл нь бүх биеийнхээ гуравны хоёр хувийг эзлэх ажээ. Үүнээс үзвэл, тэд уртаараа хорин тав орчим фут, асар урт ташуу өнцөгт мэт харагдаж байв. Бид бас толгой томтой боловч ахар богино дугуй хоншоор бүхий түүнчлэн олон эгнээ хурц хурц шүд ба хамаг бие нь хайрсаар бүрхэгдмэл мэт нэгхэн метр урт биетэй бяцхан акул олж үзлээ.

Яслаг загаснаас, ихэвчлэн эдгээр далайд оршдог губанууд, солонгорхог хальс нь гал мэт бадарч харагдах хэлтгээ загас, сүүлнийхээ угийг хүртэл цоохорлогдон эрээлжилсэн судалтай нэг метр урт биетэй могой толгойт, цэнхэрдүү туяатай, сайхан алтлаг өнгө бүхий макрель, баруун талдаа нүдтэй палтусууд буюу флетан, нүд ба өргөн ам нь зүүн талдаа байх, мөн палтусын язгуурт багтдаг ромууд, гэдсээрээ мөнгөлөг, нуруун талаараа цайвар улаан өнгөтэй.цорго маягийн хушуу бүхий олон бекасууд, түүнчлэн сөмгийн язгуурын олон янзын төлөөлөгчид харагдлаа.

Гольфстримын ус шөнийн цагт манай онгоцны прожекторын цахилгаан гэрэлтэй өрсөлдөн туяарч байв. Тэр туяарал, ялангуяа үерийн өмнөх үед бүр ч тодорч байлаа.

Тавдугаар сарын наймнаа бид Умарт Каролины өргөрөг дээр Гаттерасын хушуу хавьд явлаа. Гольфстримын өргөн нь энд далан таван миль хүрч гүн нь хоёр зуун

метр байв.

“Наутилус” урьдын адил таамгаар хөвж билээ. Бүх талын сэрэмж орхигдсон мэт ажээ. Иймэрхүү нөхцөлд бидний оргох бодол дүүрэн боломжтой байв. Нээрээ ч үнэхээр ч хүн амьтантай хуурай газрууд хаана л бол хаана хоргодох нөхцөлийг маань бүрэлдүүлж байлаа. Тэрнээс гадна, Бостон ба Нью-Йорк, Мексикийн булангийн хооронд үргэлж сүлжилдэн байх олон тооны хөлөг тэнгис далайг зорчин, америкийн эргийн олон буудалд ачаа зөөгч жижиг онгоцнууд өдөр шөнөгүй дүүрэн ачаатай энэ орчныг хэрэн хэсэж бүлгээ. Тэд биднийг замдаа дайж авахад найдаж болох билээ. Америкийн эргээс бид бүхэл бүтэн гурван зуун миль хол байгааг харгалзахгүйгээр бидний эртнээс хүсч хүлээж байсан тэр нэгэн тохиромжтой нөхцөл бүрдсэн ажээ.

Гэвч, Канадын харьяатын төлөвлөгөө биелэхэд саад болсон ганцхан харамсалтай зүйл байсан юм. Энэ нь цаг агаарын байдал тун муухай байв. Бид цаг үргэлж үер шуурга догшрон байдаг газар руу ойртож явсан юм. Энэ орчин бол аанай Гольфстримын дулаан урсгалын нөлөөгөөр дэгддэг усан хуй, ширүүн салхины төрөлх нутаг билээ. Далайн шуурган дунд хэврэг нэгэн завинд сууж замд гарна гэдэг бол жинхэнэ үхэл рүүгээ одно гэсэн үг.

Нед Ленд үүнийг ойлгох тул хий л уур хилэндээ багтарч, шүд хавиран сууж, оргох зорилгоо өдөр өдрөөр хойшлуулсаар байлаа. Эцсийн эцэст тэр, эх нутгийнхаа зүг гиюурэн тачаадаж бүр өвдчихсэн бөгөөд зөвхөн оргож гарсан цагт л тэр өвчин нь эдгэрэх байв.

- Ноён профессор оо? хэмээн тэр над руу хандаж-энэ бүхнийг ерөөсөө дуусвар болгох хэрэгтэй! Танай тэр Немо, хүн амьтантай газраас холдож умар зүг явж байна. Өмнөт туйлыг үзсэн. Хойт туйл дээр надад хийх юм алга гэж танд дээр хэлсэн биш үү гэв.

- Яая гэхэв, Нед ээ нэгэнт л энэ хэр оргох бололцоогүй байсан хойно?

- Би дээр хэлснээ давтахыг хүсч байна. Капитантай ярих хэрэгтэй. Таны төрсөн нутгийн эргийн дэргэдүүр бид явж өнгөрөхөд та дуугүй байсан. Одоо бид миний төрөлх нутгийн эргийн дэргэдүүр хөвж байна. Тэгвэл би дуугүй байж чадахгүй! Хэд хоногийн дараа “Наутилус” Шинэ Шотландын ойролцоо очиход, Нью-фаундлендийн тэнд, уужим сайхан тохой бий болж, тэр тохойд цутгасан миний төрөлх хот Квебекийн дундуур урссан умбаж шумбаж өссөн төрөлх гол минь, ариун Лаврентийн гол минь харагдах болно гэж би бодохтойгоо зэрэг л энэ бүхнийхээ тухай дурсахын хамт л галзуурмаар болж хамаг бие минь салгална: Ай ноён профессор минь би

тэсэшгүй, эсхүл тэнгис рүү үсэрсүгэй! Би энд л үлдэхгүй. Би амьдаршгүй нь! гэдэг байв. Бодвол Канад хүн эцсийнхээ тэсвэрийг алдав бололтой. Түүний гүжирмэг ааш ингэж урт удаан хугацаагаар хоригдон байхыг тэвчээгүй биз. Тэрний царай өдрөөс өдөрт л барайсаар байв. Би түүний шаналгаа сайн ойлгож байсан минь өөрөө ч гэсэн нутгаа санасан бүлээг. Бид хуурай газартай бүх талым холбоо тасарсаар бүтэн долоон сар боллоо. Түүнээс гадна наймалжнуудтай тулалдсан цагаас хойш эрс өөрчлөгдсөн капитаны зан ааш, түүний үг дуугүй таг болсон болон тэрүүхэндээ бөглүү битүү бай- дал гаргах зэрэг явдал хэргийн байдлыг эрс өөрчиллөө. Зөвхөн хүмүүст биш, харин халимуудад болон далайн бусад амьтанд л тун дүйсэн энэ нэгэн эвгүй байдалтай эвлэрэхийн тул яг Консель шиг фламанд хун байх хэрэгтэй байв. Хэрэв л энэ нэгэн бэрх хөвгүүн уушигны оронд заламгайтайсан бол нэн их хүндтэй загас байхсан билээ.

- Та тэгээд юу гэж шийдэв ноён професор? хэмээн Нед Ленд, миний хариу өчихгүй байхыг ажиж асуулаа.

- Ингэхэд, Нед Ленд та, бидний талаар түүний бодол ямар буйг, капитан Немогоос би асуухыг хүссэн билүү?

- Тиймээ, профессор гуай.

- Нэг удаа тэр, санасан бодсоноо бидэнд хэлчихсэнийг харгалзахгүйгээр та шалж байгаа юм уу?

- Тиймээ би бүр эцсийг нь хармаар байна. Хэрэв та хүсвэл миний тухай хэл, зөвхөн миний л тухай.

- Гэвч би түүнтэй бараг уулзахгүй байгаа шүү. Тэр надаас зайлсхийгээд байгаа юм.

- Тэр тусмаа, түүнтэй уулзах шалтаг нь тэр?

- За тэгье, би асуучихъяа, Нед.

-Хэзээ?

- Уулзсан цагтаа л

- Аронакс гуай, би өөрөө яваад капитаныг эрж олъё.- Тэх үү?

- Үгүй, үгүй, би өөрөө маргааш уулзъя.

- Үгүй ээ, өнөөдөр уулз.

- За яахав, сайн. Өнөөдөр би уулзъя гэж түүнийг хамаг хэрэг хөөдчихөөс нь айж хариуллаа.

Би ганцаараа үлдэв. Нэгэнт ам өгсөн болохоор би түүнийгээ даруйхан биелүүлэхээр шийдэв. Жаргалын удаан зовлонгийн түргэн гэдгийг би хэзээд

эрхэмлэдэг билээ.

Би өрөөндөө эргэж ирлээ. Хананы цаана капитан Немогийн алхлах хөлийн чимээ сонсдож байв. Тэр сайхан тохилыг алдаж хэрхэн болох билээ. Тиймээс би очиж түүний хаалгыг тогшив. Хариу дуулсангүй. Би дахин тогшиж хаалганы бариулыг мушгиж татвал хаалга нээгдэв.

Би орж очив. Капитан өрөөндөө ажээ. Тэр ажлынхаа ширээн дээр тонгойж, ямар нэг юм бичиж байв. Тэр миний хөлийн чимээг сонссонгүй ээ.

Би явахгүйгээр шийдэж, мөн түүнтэй үг өдөөж дуугарсан ч үгүй ойртон очлоо. Тэр толгойгоо чочир өргөж, хөмсгөө зангидсанаа нилээд ширүүн дуугаар :

- Та энд байгаа юм уу? Танд юу хэрэгтэй вэ? гэв.

- Тантай ярих юм байна, капитан.

- Би завгүй байна, эрхэм ээ, би ажилтай байна. Би танд ганцаар тусгаарлах бүрэн бололцоог хангаж өгсөн. Тэр эрхийг эдлэх заяа надад байхгүй гэж та бодоогүй биз?

Энэ нэгэн хүлээн авалт бидний ярилцан тохирохын амжилт төдий л бүтэлтэй биш болохын тэмдэг байв. Гэлээ ч гэсэн би хэргийн эцсийн байдлыг харахаар шийдлээ.

- Ноёнтоон хэмээн би хүйтэн царайлж-би тантай хойшлуулшгүй чухал хэргийн тухай ярих гэж байна гэв.

- Юун хэрэг билээ. Профессор гуай? хэмээн тэр-ёжлох байдалтай асууж миний анхаарлаас холуур өнгөрч амжсан ямар нэгэн нээлт хийчих завшаан олдоо юу? Далай танд, ямар нэгэн шинэ нууцаа задлаа юу? гэлээ.

Миний хариу хэлэхээс өмнө тэр ширээн дээрээ байгаа хуудаснууд руу зааж, нэрлэн өгүүлрүүн:

- Энэнийг хар, ноён Аронакс энэ бол хэд хэдэн хэлээр бичсэн гар бичмэлүүд байгаа юм. Энд миний эрдэм шинжилгээний ажлын үр дүн бичээстэй байгаа. Тэхээрээ миний энэ бүтээл надтай хамт мөхөхгүй гэдэгт би итгэнэм. Миний нэр ус бичигдэж миний бие түүгээр баяжсан энэ гар бичмэл усанд живдэггүй жижиг аппарат дотор хийгдэх болно. “Наутилус” дээр амьд хамгийн сүүлчийн хүн уул аппаратыг далайд хаяхад давалгаа түүнийг гардан авах юм.

Нэрээ бичнэ гэнээ! Бас өөрийн нь түүх! Тэхээрээ түүний нууц хэзээ нэгэн цагт тайлагдах нь ээ?

Гэвч тэр үедээ би, энэ мэдэгдлийг нь миний сонирхон буй сэдэвт шилжин орох яриа үүсгэх арга гэж санаж билээ.

- Капитан минь хэмээн би өгүүлрүүн-таны хийх гэж буй алхмыг би зөвхөн зөв

хэмээн дүгнэх байнам. Хэрэв таны хийсэн хөдөлмөрийн үр ашиг мөхөж сөнөх юм бол тэнэг юм болно. Гэвч таны бүтээсэн энэ нэгэн зүйл надад хэтэрхий бүдүүлэг юм мэт санагднам. Таны энэ аппаратыг ямар салхи, хааш нь хийсгэж, хэний гарт оруулахыг хэн мэдсэн юм! Үүнээс арай найдвартай өөр нэг юм хийчихэж болохгүй гэж үү? Магадгүй, та өөрөө ч юм уу, эсхүл таны нөхдийн нэг...

- Хэзээ ч тэхгүй, эрхмээ? гэж капитан миний яриаг тас татан эрс хэллээ.

- Тэгвэл миний бие өөрийн нөхдийн хамт таны энэ гар бичмэлийг чанд хадгалахад бэлхэн байнам. Хэрэв л та бидэнд эрх чөлөөг маань эргүүлж...

- Эрх чөлөөг чинь үү?

- Тиймээ, капитан үүний л тухай би тантай ярих гэсэн юм. Бид “Наутилус” дээр гарч ирсээр бүтэн долоон сар боллоо. Тэгээд би, энэхүү усан доогуур явагч хөлөг онгоцон дээрээ биднийг та бүх насаар маань барихыг хүсч буй эсэхийг өөрийн болон өөрийн нөхдийн нэрийн өмнөөс, өнөөдөр танаас биечлэн асуух гэсэн юм?

- Эрхэмсэг ноён Армяке, танд би одоогоос долоон сарын өмнө өгсөн хариугаа л давтан хариулах байнам. “Наутилус” дээр гарсан хэн боловч хэзээ ч түүнийг орхиж үл одно.

- Тэгвэл таны энэ чинь ёстой боолчлол байна!

- Юу л гэж хэлнэ тани! дур мэдэж.

- Тийм бол боол хүн эрх чөлөө эрмэлзэх эрхтэй байдаг юм! Үүний тул арга бүхэн сайхан!

- Тэр эрхий чинь танаас хэн ч булаахгүй гэж капитан Немо хариулаад, таныг би аль, нэгэн талаар тангараглуулаагүй байхаа гэв.

Капитан Немо хоер гараа цээжиндээ зөрүүлэн авч над руу харан зогсч байв.

- Ноёнтон минь-хэмээн би түүнд-энэ нэгэн сэдвээр хоёр дахь удаагаа дахин ярилцахыг би ч, та ч, хэн маань ч хүсээгүй. Гэвч бид, нэгэнтээ л хөндчихсөн болохоор шувтаргах ёстой. Давтан хэлэхэд, ганц миний тухай ярьж буй хэрэг биш, шинжлэх ухаан гэдэг миний хувьд бол миний аврага тулгуур, саатал, хөгжил цэнгэл юм. Хэрэв та мэдэхийг хүсвэл юуг боловч мартаход минь тусалдаг ганц хүслэн минь юм. Би яг л таны нэгэн адил, өөрийн хийсэн хөдөлмөрийн үр дүнг далайд хаясан ямар нэгэн аппаратаар дамжуулан хүн төрөлхтөнд гэрээслэн үлдээх итгэл найдвараар сэтгэлээ цагаатган, тань шиг л хол далд амьдарч чадна. Нэг үгээр хэлэхэд, таны энэхүү аялалд би гар бие оролцож явсандаа өөрт мэдэгдэхүйц хангалуун их тааламж эдлэн, мөн зарим нэгэн талаар таны үнэн зөвтэй талыг ч зөвшин хүлээж, таныг санан санан бахдан баясч явж чадах билээ. Гэвч миний бие

болон миний нөхдөд ямар ч хамаагүй, таны амьдралын бас өөр талууд бий. Түүгээр ч барахгүй, таны оюун, ухаан, авьяас чадварт хөхөж биширсэн буюу таныг уй га шуудалд автагдсан үед таны зүрхтэй бидний зүрх нэгэн адил цохилон байсан цагт ч бид, тэр бүх л сайн сайхны нөлөөгөөр бидний сэтгэлд зайлшгүй ундрах дотно хүндэтгэл ямар нэгэн хэлбэрээр өчүүхэн боловч илэрчих бий гэхээс арга буюу болгоомжлох ёстой байсан юм.

Энд бас бид юм бүхэнд өөрийн мэт хандах эрхгүй, хүнийрхэх явдал, биднийг энд байх нөхцөлгүй болгож байгаа юм. Тэр байтугай миний хувьд мөн адил байна. Энэ байдал, ялангуяа Нед Лендэд тэсвэрлэшгүй нөлөөлж байгаа юм. Ямар ч хүн, өөрийгөө хүн гэж тооцохыг хүсдэг бизээ. Ингэхэд ер нь та боолчлолыг үзэн ядаж эрх чөлөөг эрмэлздэг хүний толгойд ямар бодол төрж болохыг эрэгцүүлэн бодсон уу? Жишээлбэл манай Канад хүн шиг хүний толгойд? Та тэхэд ер нь өөрөө өөртөө асуулт тавьж тэр хүн чухам юу сүвэгчилж явахаар шийдэж болохыг... хэмээн үргэлжлүүлэн ярих гэтэл капитан Немо босон ирж:

- Танай тэр Нед Ленд юугаа сүвэгчилж яахаар шийддэг билээ? Тэр бүхэн надад ямар хамаатай юм. Түүнийг би ямар эрж хайсан биш! Бас би түүнийг энд дуртайгаа барьж байгаа гэж санана уу? Харин таны хувьд ноён Аронакс та бол хүн таг дуугүй байсан ч юмны учир ойлгох хүн. Өөр танд хэлэх юм надад алга. Энэ нэгэн сэдвээр надтай ярих гэсэн таны эхний оролдлого эцсийнх тань болог. Хоёр дахь удаагаа ярих гэвэл би таны үгийг сонсох ч үгүй гэлээ.

Би явж одлоо. Энэ өдрөөс хойш бидний харьцаа тун хүндэрлээ.

Нөхөддөө би, уг ярианы тухай ярьж өгөв.

- Энэ хүнээс бидэнд горьдох юм юу ч алга. «Наутилус» Лонг-Айлендад ойртож байна. цаг агаар ямар ч байсан бид зугатах л хэрэгтэй гэж Нед Ленд өгүүлэв.

Тэнгэрийн байдал улам л түгшүүртэй болж байв. Их үер буухын ёр орж байлаа. Агаарт сүүн цагаан үүлс хөвөрнө. Тэнгэрийн хаяа үерийн хар үүлсээр зузаарч байв. Уулс далай дээгуур, маш доогуур хөвж ер бус хурдан нүүх ажээ. Далай догширч гарлаа. Үер, шуурганы хань ижил болсон салхивч шувуудаас бусад шувуу бүгд алга болсон байв. Барометрийн заалт буурч байв.

“Наутилус” Лонг Айлендийн зааг дээр Нью-Йоркоос хэдхэн миль зайтай явж байх яг тэр үед тавдугаар сарын арван хоёрноо, өдрөөр үер буулаа. Капитан Немо далайн гүнд шумбан орж нуугдахын оронд, үл ойлгогдох бас нэгэн ааш нь хөдөлж «Наутилус» далай дээр ил хөвж явсан тул байгалийн тэрхүү шируун догшролыг би тодорхой бичиж чадах байнам.

Салхи зүүн өмнө зүгээс секундэд арван таван метрийн хурдтай үлээж өдрийн гурван цагт түүний хурд секундэд хорин таван метр боллоо. Энэ нь далайн жинхэнэ хүчит шуурга ажээ.

Капитан Немо онгоцны тавцан дээр байраа эзэлж далайн шуурганд автдахгүй гэж онгоцны тавцангийн хашлаганаас биеэ барьж хүллээ. Би ч гэсэн түүнтэй зэрэгцэн зогсч, биеэ барьж бэхлээд, үер шуурга өөд дальдралгүй сөрөн зогсч байгаа тэр хүн, догшин салхи хоёрыг эн тэнцүү бахдан биширч бүлгээ.

Хөглөрсөн саглагар хар уулс, хөөсөрсөн далайн давалгаа шүргэн хөврөлдөж тэдгээрийн зангирсан их мушгираан дунд үүсэх жижиг долгиог би олж үл үзэх бөгөөтөл үелсэн сүрт усны хөө мэт хар дэл сэрвэн хүртэл бутран үл цацрах нь давалгаа нэн чийрэг нягтрууг гэрчлэх ажээ. Тэдгээр их давалгаа улам улам л дээр хөөрч байв.

«Наутилус» эсхүл хажуулдан хавиргалж, эсхүл шураг мод мэт эгц өөдөө босон ирж, усанд бөгсөөрөө шааж орон, савлан шидэж явлаа. Орой таван цаг орчимд усан бороо цутгасан боловч тэр, салхи далай хоёрын аль алиныг нь ч номхотгосонгүй. Далайн хүчит шуурга секундэд дөчин таван метрийн хурдтай нүдсэн нь цагт дөчин бээр илуу хурдална гэсэн үг ажээ. Иймэрхүү шуурга байшин сав нурааж, вааран дээвэр хуу татан, төмөр сараалж хуга хуга дайрч онгоцны тавцан дээрх үхэр буунуудыг бөмбөг мэт элддэг билээ. Гэвч “Наутилус” энэхүү эмх замбараагүй давилгаан дунд хөвж “Ганцхан бөх л хийгдсэн бол далайтай тэмцэлдэж үл чадах онгоц гэж байхгүй” хэмээн алдарт нэгэн инженерийн хэлсэн үгийг нотолж байв. Энэ онгоц бол далайн давалгаанд хээмх цохигдох бул хар хад биш, харин хүний эрх мэдэлд бүрэн захирагдах шураг мод, тоног татлагагүй хөдөлгөөнт ээрүүл мэт ган хөлөг тул догширч ширүүлсэн шуургатай ач тач тэмцэлдэн билээ.

Би, тэрхүү гинжнээсээ мултарсан адил галзууран буй долгиог анхааралтай ширтэж байв. Тэдгээр долгио өндрөөшөө арван таван метрт хөөрөн, уртаашаа зуун тавиас зуун далан метрт хөврөлдөж салхинаас арай яльгүй жаахан хурдтай эрчилж байлаа. Тэдний хэмжээ, хүчин чадал далайн гүнээс шалтгаалж өсч байв. Тэхэд л би өөртөө, агаар салхи хумхин авч далайн гүнд орвол, тэр орчинд хүчилтөрөгч хүргэдэг, тэдгээр давалгааны жинхэнэ үүргийг ойлгож билээ. Эрдэмтдийн бодож гаргаснаар, тэдгээрийн даралтын дээд хязгаар нь өөрсдийн дэлдэн бууж буй гадаргын тэгш дөрвөлжин фут тус бүр дээр гурван мянган килограмм хүрдэг ажээ. Яг л ийм давалгаа Гебридийн арлууд орчимд наян дөрвөн мянган Фут хүнд хадан хясааг байрнаас нь хөдөлгөсөн юм. Тэр л давалгаа 1864 оны арван хоёрдугаар сарын 23-ны догшин

шуурганаар, Японы Иеддо хотын тэн хагасыг устгаад, тэнгис дундуур цагт долоон зуун километрийн хурдтай довтолгосоор, үхлээ эрж зүтгэхдээ тэр л өдөртөө Америкийн эргийг хүрч мөргөсөн юм даа.

Шөнө болохын хэрд бид шуургатай амь тэмцэн тулалдаж буй том хөлөг онгоцны бараа харлаа. Тэр далайд зангаа хаяж давалгаан дунд сул орхигдсон байв. Тэр бодвол, Нью-Йорк, Ливерпуль хоёрын хооронд буюу эсхүл Нью-Йорк, Гавр хоёрын хооронд гүйдэг хөлгүүдийн нэгэн байсан буйзаа. Төдөлгүй тэр харанхуй бүрийд далд орлоо.

Орой арван цагийн үед, хурмаст тэнгэр гал түймэрт автсан мэт боллоо. Гал цахилгаан агаар тэнгэрийг зүсэн зүсэн байв. Би тэдгээрийг харж чадахгүй байхад, капитан Немо тэдгээрээс нүд салгахгүй байлаа. Тэр хүн салхи шуурганд сэтгэл ханасан мэт ажээ.

Бие биеийг мөргөн бутарч буй мушгирсан их давалгаа нижигнэн, салхины исгэрэлт аянгын дуу...бугд нийлж байж үл болом сүрт чимээ агаар тэнгэрийг донсолгон байв. Зүүнээс дэгдсэн циклон, тэнгисийг хойгуур баруугаар, урьдуур бүтэн тойроод, эхэлсэн зүгтээ эргэн очиж үргэлж чиглэлээ өөрчлөн байлаа. Ай даа, энэ Гольфстрим уу! Аргагүй л тэр шуурганы эзэн гэсэн нэрэндээ дүйсэн ажээ! Түүний усны янз янзын халуун хүйтэн, түүний урсгал доогуур хөвөх агаар салхины тогтворгүй байдал эдгээр аймшигт циклоныг төрүүлэхгүй бол өөр юу төрүүлэх билээ!

Борооны дараа ёстой л жинхэнэ галт үер буулаа. Усны ширхгүүд хайлсан төмрийн урсгал болон хувирах шиг боллоо.

Капитан Немо шилдэг үхлийг эрж, үхэх үхэхдээ аянганд ниргүүлж үхэхээр шийдсэн юм болов уу гэж бодож болох байв.

Бөгсөн талын аймшигт сэгсрэлтийн үед “Наутилус”-ын аянга зайлуулагч мэт ган мөргүүл дээшээ ёрдойн ирж түүний үзүүрт гал бутран харагдлаа.

Би донсолгоонд сэгсрэгдэж ядарч туйлдсандаа онгоцны тавцангийн таг хүртэл арайхийж элгээрээ гулган очоод, тагийг сөхөж, үзэсгэлэн танхимд бууж очлоо. Энэ үед шуурга дээд хэмжээндээ хүрч байв. “Наутилус” дотор секунд хэр ч хөл дээрээ тогтож зогсох аргагүй ажээ.

Капитан Немо зөвхөн шөнө дунд л бууж, ирлээ. Усны багтаамжууд усаар хэрхэн дүүрч буйг би сонсов. Тэгтэл ч “Наутилус” тэнгисийн амгалан гүнд алгуур живж орлоо.

Үзэсгэлэн танхимын цонхнууд нээлттэй тул би том том загасны бүхэл бүтэн сүргүүд олж үзсэн бөгөөд тэд гал улаан усан дотор сандралдан давхилдаж тэдний



заримыг миний харсаар байтал аянга ниргэсэн билээ.

«Наутилус» доошилсоор л байв. Түүнийг би арван таван метрийн гүнд амгалан уснаа орно гэж бодож билээ. Гэтэл, тэнгисийн өнгө талын ус урвалдан хөрвөж байсан нь тун их тул бид тавин метр хүртэл гүнзгийрч бүлгээ.

Энд далайн энэ их гүнд, хичнээн амгалан тайван хичнээн нам гүм санж вэ! Тэгвэл энэ хэр, далай дээр аймшигт шуурга дошгирсоор буй гэж хэн яахин бодох билээ!

[Тор](#)

---

### **ӨРГӨРГИЙН 42 ДАХЬ ХОНОГ 24 ДАХЬ ХУВЬ, УРТРАГИЙН 17 ДАХЬ ХОНОГ 28 ДАХЬ ХУВЬД**

Биднийг тэнгисийн шуурга дорно зүг элджээ. Нью-Йоркийн эрэг орчинд буюу эсхүл Лаврентийн голын адагт оргох бүх найдвар маань үгүйсэв. Хөөрхий муу Нед байж ядсандаа капитан Немогийн нэгэн адил, цор ганцаар далдын далд орж, нам гүм болчив. Консель бид хоёр л салахгүй байв.

“Наутилус” зүүн тийшээ элдэгдсэн гэж би дээр хэлсэндэг. Гэвч яг үнэнээрээ бол зүүн хойшоо юм шүү. Хэд хэдэн өдрийн турш тэр эсхүл усан доор далд орж, эсхүл усан дээр ил гарч бараг л үргэлж далайчдад нэн аюултай их манан дундуур явлаа. Тэдгээр манан ихэвчлэн мөсний хайлалтаас шалтгаалах бөгөөд тэр нь агаарыг усны уур цангаар хэтэртэл нь нэвтрүүлдэг бүлгээ.

Эх газрын эрэг хүрэхийг эрмэлзэн тэндхийн хуурамч гэрлээр баримжаалан явсаар энэ хязгаарт хичнээн олон онгоц сөнөдөг гээч! Энэ манангаас болж хичнээнч гай зовлон учрав аа! Эсрэг яваа онгоцнуудын дэнгийн гэрэл, яндангийн дуу, хонхны түгшүүрт жингэнээн аль алийг нь харгалзахгүйгээр хичнээн олон хөлөг сүйрсэн гээч! Далайн хад мөргөх дууг дарсан салхинаас болж усан доорхи хад мөргөсөн тохиол хичнээн олон билээ!

Энэ орчны далайн ёроол алалдааны талбараас холгүй байдаг нь гайхалтай биш. Энд далайн ёроол онгоцны сүйрлийн сэгээр хучигдсаны нэг зарим нь зэвэрч, хуучирсан байтал, нөгөө хэсгийн нь өнгөө ч алдаагүй зэс тавцанд манай онгоцны прожекторын гэрэл тусан ойж шив шинэхэн ажээ.

Ор сураггүй алга болсон, хичнээн ч олон онгоц дүрвэгсэд буюу амьд ачаатайгаа,

бүх багтайгаа энд хэвтэв гээч. Бүх л лавлах бичигт тэмдэглэсэн Лавренти голын судаг, Бель-Илийн хоолой, Расын хушуу Сен-Полийн арлуудын орчин дахь энэхүү аюулт газруудад хэд хичнээн сүйрэл гардаг гэж санана!

Зөвхөн сүүлийн хэдэн жилд энэ орчинд живсэн хөлөг онгоцнуудын харамсалтай хар дансанд: “Сольевея”, “Изиду”, “Параматту”, “Венгерца”, “Канадца”, “Англосакса”, “Гулмбольдтай”, “Нэгдсэн шатат” зэргийг, далайн шуурганд сөнөсөн “Арктика”, “Лионца” хоёрыг мөргөлдөж сүйрсэнд “Президент”, “Номхон далай” “Глазго хот” зэргийн хөлгүүдийг үл мэдэгдэх шалтгаанаар үгүй бологсдын тоонд оруулж тус тус бүртгэх хэрэгтэй болжээ.

«Наутилус» хөнөгөөл сүйрлийн сэг дундуур, үхэгсдийн хүүрэнд үзлэг хийх адил сүлжин явав.

Тавдугаар сарын тавнаа бид Ньюфаундлендийн хаялгын хамгийн урд үзүүрт хүрлээ. Тэрхүү хаялга далайн ус эрж дээр гаргаж хаясан хурднаас тогтжээ. Тэр бол америкийн хойт эргийг ороосон умарт туйлын хүйтэн урсгалаар эсхүл экватор орчмоос Гольфстримээр хүргэгдэн ирсэн, долоон жорын органик үлдэгдлүүдийн асар их хэмжээний хурдас байв. Түүнчлэн энд энэ орчинд хэдэн бумаараа үхэж үрэгдэх хөндий биетэн зөөлөн биетний үлдэгдэл, загасны ясны гайхамшиг их бөөгнөрөл үүсчээ.

Ньюфаундлендийн хаялгад далайн гүн маш гүехэн байсан нь хэдхэн зуун футээс үл хэтрэх ажээ. Гэвч өмнө зүг рүүгээ далайн ёроол гэнэт гүнзгийрэн хотойж гурван мянган метр там мэт гүнзгийрч байв. Гольфстрим энэ орчинд өргөснө. Энд тэр бүхэл бүтэн далай болох авч өөрийн урсгалын хурд, дулаан хоёрыг алдана.

“Наутилус” үргээн яваа загасан дунд би, ягаан элэг, харавтар сэрвээтэй, хагас метр урт дугуй сэлүүртэнг ялган таньсан нь тэд, хос хосоороо ханилан амьдрахын үнэн шудрагын үлгэр жишээг үзүүлдэг билээ. Мөн тэнд нэн сайхан, амттай, оюун эрдэнэ мэт нов ногоон уртаас урт мурен, нохойтой зарим талаараа нилээд адил толгойтой, том нүдэлсэн карракс, бухандай, губан зэргийн олон загас харагдав. Гэвч бидэнтэй сагамхай загас цаг ямагт тохиолдож байсан нь Ньюфаундлендийн хаялга буюу дуртай газар нь бид түүнтэй дайралдсан билээ. Ньюфаундленд бол яах аргагүй л усан доорхи уул байхаас зайлахгүй тул сагамхай загасыг уулын загас гэж зоригтой хэлж болно. «Наутилус» сагамхай загасын нягт цуваан дундуур өөртөө зам гарган явах үед Консель гайхаж хөхөхийн эрхэнд дуу алдахгүй байж чадсангүй.

- Юу? Энэ чинь сагамхай загас гэж үү? хэмээн тэр хашгараад, аа тэгвэл би,

үүний чинь хэлтгий загас мэт хавтгай амьтан гэдэгт бүрэн итгэж байсан юм гэв.

- Дэний юм бүү ярь! Сагамхай загас зөвхөн л загас худалдах мухлагт хавтгай байдаг юм Тэнд түүнийг гэдэс доторгүй аваачдаг учраас тийм байдаг. Далайдаа бол голавль шиг л усанд шумбахад нэн зохицсон бөөрөнхий шувтан загас гэж мэд!

-Эзэн илүү мэдэх биз гэж Консель хариулаад-энд яасан олон загастай юм бэ? Бүр шоргоолжны үүр шиг! гэв.

- Хэрэв л түүний дайсан хүн үгүйсэн бол үүнээс ч бүр олон байхсан л даа найз минь, нэгэн эм сэгамхай хичнээн үр цацдагийг чи мэдэх үү?

- За яахав, таван зуун мянга гэе

- Арван нэгэн сая байдаг юм, хонгор минь:

Арван нэгэн сая ий! Үүнд ч би, өөрөө л нэг нэгээр нь тоолж үзэхээс нааш, хэзээ ч үнэмшихгүй ээ.

- Тоол л доо яахав! Гэвч чи, хэрэв л надад итгэж үзвэл, цагаа гамнах байлгүй. Францчууд, англичууд, америкчууд Данийнхан, Норвегууд сагамхайг асар олноор нь барьдгийг бүү мартаарай. Үүнийг хоол хүнсэнд хэмжээгүй их хэрэглэдэг тул хэрэв л энэ загас өсч үржих ер бусын агуу чадалгүйсэн бол хэдийн нэг ч үлдэхгүй алга болохсон билээ. Зөвхөн Англи, Америк хоёрын далан таван мянган далайчидтай таван мянган хөлөг онгоц л сагамхай загас барих ажил эрхэлдэг юм даа. Тэхэд хөлөг тус бүр агнуурын нэг улиралд, дунджаар дөчин мянган ширхгээс доошгүйг барьдаг бол нийтдээ хорин сая орчмыг барих биш үү. Норвегийн эрэг орчинд түүнийг мөн өдий хэртэй л барьдаг юм.

- За нэн сайн! хэмээн Консель хэлээд “би эзэнд итгэж тоолохоо больё” гэлээ.

- Юу тоолохоо больё гэж Консель оо?

- Арван нэгэн сая үр. Гэвч би, нэг л юм өөлж хэлмээр, байна.

-Ямар юм?

- Хэрэв л үр тус бүр амьдарч загас болдог юм бол бүх Америк, Англи, Норвеги гурвыг тэжээхэд зөвхөн л хосоор хоёр сагамхай загас болох юм биш үү.

Биднийг яг Ньюфаундлендийн хаялга дээгүүр өвчүүгээрээ арай л шаачихгүй явж байх тэр үед би сагамхай барих хоёр зуун дэгээ бүхий урт нарийхан олс байхыг харав. Тийм дэгээ, загасчны завь тус бүр дээрээс ус руу хэд хэдэн арваар нь хаядаг бүлгээ. Нэг үзүүрт нь дэгээ уясан олсны нөгөө үзүүр далай дээр тусгай хөвүүрт тээглэсэн байдаг юм. “Наутилус” тэрхүү усан доорхи торон дотуур сүлжин явах хэрэг гарлаа.

Гэвч манай усан доогуур явагч онгоц энэхүү хүнтэй газар удаан байсангүй. Тэр

Европыг, Хойт Америктай холбосон цахилгаан мэдээний атлантын далай доогуурхи шугамын америкийн үзүүр нь ил гарч ирдэг Сен-Джонс арал орчинд, Ньюфаундлендийн өргөрөг хүртэл өгслөө.

“Наутилус” эндээс умарт зүг өөд аян замаа үргэлжлүүлэхийн оронд, цахилгаан мэдээний усан доорхи шугам байгаа тэгш өндөрлөгийг шинжлэх гэсэн шиг зүүн зүг руу чиг авав. Гэвч өндөрлөгийн тогтоц байдал далайн гүнийг хэмжих тоймгүй ажиллагааны эцэст маш тодорхой мэдэгдэж байв.

Тавдугаар сарын арван долоонд Сен-Джонс арлаас тавин миль зайтай, хоёр мянган найман зуун метрийн гүнд би, элсэн дээр зурайн хэвтэж буй бүдүүн утас олж үзэв. Энэ тухай урьд нь би Консельд учрыг нь хэлж амжаагүй тул тэр уул утсыг далайн асар том аврага могойд үзэж өөрийн заншлаар ангилан хувиарлахыг шахаж билээ. Гэвч би тэр утасны тухай, хэрхэн тэрний тавигдсан тухай, түүнийг тайтгаруулахаар бүхэл бүтэн түүх намтар ярьж, тэр хөөрхий хөвгүүнийхээ урмыг хугалсан билээ.

Анхны утсыг 1857-1858онд тавьсан юм. Гэвч тэр шугам дөнгөж дөрвөн зуухан цахилгаан мэдээ дамжуулчихаад гэнэт ажиллахаа больжээ.Тэгээд 1863онд инженерүүд гурван мянга дөрвөн зуун километр урт,дөрвөн мянга таван зуун тонн хүнд шинэ утас дахин хийж, тэр их хүнд тээшээ аваачиж хөвөхийн тул тусгайлан зориулж бүтээсэн «Great Eastern» хэмээх галт онгоц ашигласан боловч уул оролдлого амжилт олоогүй юм.

Тавдугаар сарын хорин таванд “Наутилус” гурван мянга найман зуун гучин зургаан метрийн гүнд уул шугам тас үсэрсэн яг тэр газар орсон байв.

Энэ нь Ирландын эргээс зургаан зуун гучин найман миль зайтай газар ажээ. Өдрийн хоёр цагийн үед Европтой харилцаа тасарсныг мэдсэн байжээ. “Great Eastern” онгоцны дээр байсан инженерүүд шугам тасарсан газрыг олж шөнийн арван нэгэн цаг орчимд түүний хоёр үзүүрийг гарган иржээ. Тэд гэмтлийг засварлаад усанд буцааж хийсэн боловч хэд хоногийн дараа дахин тасарчээ. Энэ удаа далайн гүнээс шугам утсыг татан гаргаж чадсангүй ажээ.

Гэвч америкчууд бэрхшээлийн өмнө ухарсангүй. Энэ бүх хэргийг зоригт санаачлагч бөгөөд уул хэрэгт бүх хөрөнгөө оруулсан Сайрус фильд шинэ гэрээнд үсэг зурах ажил зохион байгуулжээ. Шинэ маягийн гэрээ бичиг тэрхэн даруй эзнээ олсон байв. Нэгэн төрөл ургамлын хатаасан шүүс хийсэн шир мэт мөртөө уян эдээр тусгаарлагдах багц багц төмөр утас шөрвөслөг бодисоор үйлдсэн зөөлөвчөөр хам - гаалсан төмөр хоолойд агуулагдсан ажээ:

“Great Eastern” 1866 оны долоодугаар сарын 13-наа далайд гарлаа

Эхлээд юм бүхэн бүтэмжтэй байв. Гэвч нэг өдөр ийм юм болжээ. Шугам утсыг усанд оруулахаар хөвж байх зуураа инженерүүд уул утас хэдэн газраа хадаасанд цоо хатгагдсан байхыг олж үзжээ. Бодвол шугам утасны гол хэсгийг гэмтээхээр шууд санаатай үйлдсэн хэрэг буйзаа. Онгоцны капитан Андерсен, инженерүүд, дарга нар цуглаж уул хэргийг хэлэлцэн үзээд хэрэв л гэмт этгээдийг илрүүлж олох юм бол түүнийг ямар ч хуульгүй шууд далай руу авч хаяна гэж тогтоожээ. Түүнээс хойш гэмт хэрэг хийх оролдлого дахин давтагдсангүй ээ. Долоодугаар сарын 23-нд Ньюфаундлендээс найман зуу илүү километрт явсан “Great Eastern” Содавын дэргэд болсон тулалдааны дараагаар Австрий Прусс хоёр найрамдал тогтоолоо гэсэн цахилгаан мэдээ Ирландаас авчээ. Долоодугаар сарын хорин долооноо мөн онгоц далайн манан дундуур мөргөлдсөөр явж Америкийн эрэг хүрчээ. Цахилгаан мэдээний усан доогуурхи шугам тавих уул ажил амжилттай дуусвар болж шинэ залуу Америк тив хуучирч өтөлсөн Европт найрамдал тогтоосонд баяр хүргэн мэндчилж цахилгаан утас цохижээ.

Цахилгаан мэдээний утсыг үйлдвэрийн газраас анх гарсан чигээр нь, цоо шинээр нь олж үзэхийг би бодоогүй минь мэдээж хэрэг.

Өөрийн чулуулаг дэвсгэр дээр могой мэт гүрвийн хэвтэж буй төмөр хоолой цоо идэгч-зөөлөн биетнээс хамгаалсан шохойлог бүрхүүлээр хуяглагджээ.

Уул шугам далайн цалгиа долгионоос хамгаалагдаж түүгээр дамжих цахилгаан гүүйдэл Америк, Европ хоёрын хооронд нэгэн секундийн зууны гучин хоёр хувийг дөнгөж эзлэх бүлгээ. Энэ шугам утас үүрд мөнх тэнд байх болно. Учир нь гутта перч хэмээх тэр нэгэн бодис далайн усны нөлөөлөлд удам бэхждэгийг ажиглажээ. Түүний зэрэгцээ шугам утасны тавигдсан чиглэлийг тун зөв сонгон авсан тул ямар ч нөхцөлд доошоо сууж усны асар их даралтыг үзэхгүй учир тасрахын аюулгүй ажээ.

“Наутилус” шугам утас тавигдсан хамгийн их гүнд дөрвөн мянга дөрвөн зуун гучин нэгэн метрт, уул утсыг даган явсаар хүрч билээ.

Тэндээсээ бид 1863 онд шугам утсанд гэмтэл гарсан тэр зүг рүү явлаа.

Тэр орчинд далайн ёроолоор, өргөөшөө зуун хорьхон метр нарийхан хоолой үзэгдэв. Хэрэв энд Монолан уулыг авчирч болдогсон бол түүний орой далайн уснаас цухуйхгүйсэн билээ. Тэр хоолой зуун хэсэгтээ хоёр мянган метр өндөр эгц цавчим хадан хясаагаар шувтарч байв. Тэр хоолойнд бид тавдугаар сарын 28-наа хүрсэн юм. “Наутилус” Ирландийн эргээс энэ хэр зуун тавин милиэс хэтрэхгүй хол байв.

Капитан Немо арай Британы арлуудыг хүрэх гэсэн юм биш байгаа? Үгүй, тийм

биш. Миний гайхаш тасрахад харин тэр Европын далайнуудын зүг дахин өмнө тийшээ чиглэж одлоо.

Бид Энглези арлыг тойрч гарах үед би түүний гэрэлт цамхгийн галыг харлаа Тэр цамхгийн гал Глазгогоос Леверпуль орох мянга мянган онгоцонд чиг заадаг бүлгээ.

“Наутилус” ингэхэд Ла-Маншийн хоолойд орохыг зориглох бол уу, үгүй бол уу гэдэг нэгэн чухал асуудал миний оюун ухааныг эзлэн байв.

Бидний хуурай газарт ойртон ирэхийн хамт өөрийн ичээнээс шурган гарч ирсэн Нед Ленд тэр тухай надаас асууж цөхрөхгүй байв. Би түүнд юу хэлж чадах вэ дээ? Капитан Немо урьдын адил үзэгдэж харагдахгүй байв. Тэр хэрэв Америкийн эргийн дэргэдүүр явж Нед Лендийн дотрыг маажсан бол одоо Францын эрэг орчноор явж миний дотрыг маажих гэсэн юм биш байгаа?

Тэр завсар “Наутилус” өмнө зүг хөвсөөр байв. Тавдугаар сарын 30-наа тэр, Британы арлуудаас холгүй Ленд арлын ойролцоо явж өнгөрлөө.

Хэрэв л капитан Немо Ла-Маншийн хоолойгоор явж гарах гэж буй бол зүүн тийш чиг явах ёстой. Гэтэл тэр тэгсэнгүй ээ.

“Наутилус” тавдугаар сарын 31-нд өдөржингөө тэнгис дотуур ямар нэгэн хачин тойрог цагираг гаргаж давхилаа. Энэ нь миний сэтгэлийг нэн үймүүлсэн билээ. Тэр ямар нэг юм эрээд л олохгүй байгаа мэт ажээ.

Үдэд капитан Немо өөрийн биеэр ажиглалт хийв. Тэр надтай нэг ч үг сольсонгүй. Түүний царай хэзээ хэзээнийхээсээ бүр ч баргар байв. Түүний сэтгэл юунд тэгж үймэрсэн юм бол? Европын эрэг ойр байгаа болоод тэр үү? Эсхүл орхиж одсон эх орныхоо хойноос ямар нэг юм бодсон юм бол уу? Гэмшсэндээ тэр үү, харамссандаа тэр үү? Энэ нэг бодол миний ой ухаанаас нилээд удтал гарсангүй ээ. Ямар нэгэн тохиолдол капитан Немогийн нууцыг яавч илрүүлэх цаг хэзээ нэг ирэх бий гэсэн нэгэн зөн надад байх шиг санагдав.

Маргааш нь зургаадугаар сарын 1-нд «Наутилус» өөрийн өнөө л хачин аяллыг дахин үргэлжлүүлэв. Тэд далайн ёроолд ямар нэгэн тодорхой газрыг эрж буй нь мэдээж боллоо. Капитан Немо мөн л урьдын нэгэн адил үд дундын ажиглалтыг өөрөө үйлдэв. Далай амгалан, тэнгэр цэлмэг байв. Зүг зүгт далайн төвшин дээр, биднээс найман миль газар хар хурдаараа явж байгаа том хөлгийн бараа дүхийн харагдаж байв. Түүн дээр ямар ч туг далбаа байсангүй тул би түүнийг хаанахын онгоц болохы нь тодорхойлж чадсангүй ээ.

Огторгуйн наран уртаргийг яг огтлон гарах яг тэр эгшинд капитан Немо сектантаа авч тун их хичээнгүйлэн ажиглалт үйлдэв. Далай тун амгалан тул үүнийг үйлдэхэд

нэн хялбар байлаа. Өчүүхэн ч хөдөлгөөнгүй зогсч байгаа «Наутилус» аль ч талын хэлбэлзэл үзэхгүй байв.

Тэр үед би тавцан дээр агсан бүлгээ. Ажиглалт дөнгөж дуусахын хамт капитан Немо:

-Тэр энд бий! хэмээсэн товчхон үг хэлэв, Дараа нь тэр шатаар дамжин доошоо орлоо. Бодвол хурдаа хасаад бидэн рүү ирж яваа бололтой тэр хөлгийг капитан үзсэн бол уу, үгүй бол уу, бүү мэд би түүнийг мэдсэнгүй.

Би үзэсгэлэн танхимд эргэж ирэв. Тавцангийн таг хав хийж усны багтаамжуудад ус орж шуугих чимээ сонсогдлоо. «Наутилус» доошилж эхлэв. Тэр яг босоо шугамаар уруудаж байв. Учир нь сэлүүр сэнс эргэлдэхгүй байлаа.

Хэдэн минутын дараа тэр, найман зуун гучин гурван метрийн гүнд ороход хушуугаараа ёроол шүргэв.

Үзэсгэлэн танхимын гэрэл унтарчихав. Гэвч цонхны халхавчууд сөхөгдөж ирэхэд би, манай хөлгийн прожекторт гэрэлтүүлэгдсэн далайн ёроолыг хагас милийн хэмжээнд ил харж байв. Зүүн талын цонхны цаана би зөвхөн амгалан уснаас өөр юу ч үзсэнгүй билээ

Харин баруун өрөөний цонхоор би миний анхаарлыг татах, ямар нэгэн бөөн хар юм олж харлаа. Тэр бол дун цагаан дун хорхойн хуяг, цасан цагаан нөмрөгөөр бүтээгдсэн мэт ямар нэгэн зүйл байв. Би нилээд анхааралтай ажигласаар бодвол, доошоо хоншоороороо живж орсон бололтой, шураг модгүй хөлөг онгоцны бүдэг дүрс ялгаж танив Аюул сүйрлийн энэ нэг сэг, ийм болтлоо шохойлог бүрхүү лээр хучигдахыг бодоход, далай доор олон жил хэвтсэн буйзаа.

Тэр ямар гээч онгоц юм бол? Яахаараа «Наутилус» түүний булшийг эргэж ирдэг билээ? Түүний үхлийн гай шалтгаан нь далайн шуурга биш ч байж яаж мэдэхэв?

Юу гэхээ би мэдэхгүй байж байтал капитан Немо гэнэт намуухан дуугаар ярьж эхлэв.

- Тэр нэгэн цагт энэ онгоцыг “Марселец” гэдэг байсан юм. Үүнийг анх 1762 онд усанд оруулж тавихад энэ онгоц тавцан дээрээ далан дөрвөн их буутай байсан юм. 1778 оны наймдугаар сарын арван гурванд капитан Ла-Поипа-Вертриегийн командын доор энэ онгоц “Престон”-той ширүүн тулалдсан юм. 1779 оны долоодугаар сарын 4-нд адмирал д.Эстений хөлгүүдийн бүрэлдэхүүнд Гренадыг явах тулалдаанд оролцжээ. 1781 онь! Есдүгээр сарын 5-нд ван де Грассын удирдлагын доор Чизпик тохойд тулалдсан. 1754 онд Францын засгийн газар түүний нэрийг өөрчилжээ. Тэр жилийнхээ дөрөвдүгээр сарын арван зургаанд тэр адмирал

Ван-Стабенийн командын доор америкаас үр тариа тээж Франц хүргэхээр явсан - Виларе-Жуаезын хөлгүүдийн бүрэлдэхүүнд Брестэд ирж нэгдсэн юм. Эдгээр хөлгүүд Бүгд Найрамдах засаг тогтсон хоёрдахь жилийн февраль сарын арван нэгэн арван хоёронд английн хөлгүүдтэй тулгарсан ажээ. За тэхэд ноён профессор минь өнөөдөр чинь февраль сарын арван гурван буюу 1868оны зургаадугаар сарын нэгэн биз Тэгвэл яг далан дөрвөн жилийн өмнө өргөргийн 47 дахь хоног 24 хувь, уртрагийн 17 дахь хоног 28хувьд яг энд цус урсгасан баатарлаг тулалдааны эцэст бүхий л шураг мод тоног төхөөрөмжгүй болж, багийнхаа гуравны нэгэн хувийг алдан далайд дутуу хагас далд орж буй энэ онгоц бууж өхөөр живж үхэхийг илүүд сонгожээ. Тэгээд амьд үлдсэн гурван зуун тавин зургаан далайчид онгоцныхоо хоншоор дээр Бүгд Найрамдах Улсынхаа тугийг хатгаад, “Бүгд Найрамдах Улс мандтугай!” гэсэн уриагаа хангинуулсаар далайн ёроолд шингэсэн юм аа.

- Энэ чинь тэгвэл «Өшөө авагч» байх нь ээ?! хэмээн би хашгарчихад капитан Немо хоёр гараа цээжин дээрээ зөрүүлэн тавих зуураа:

- Тиймээ эрхэм ээ, энэ бол “өшөө авагч”, мөн сайхан нэр дээ гэж шивгэнэлээ.

[Тор](#)

---

## ӨШӨӨ АВАГЧ

Ужуухан эхэлж, ямар нэгэн онцгой байдалтай сэтгэл түгшингүй ярьж дуусгасан энэ бүх үзэгдлийн нэгэн тохиол хувьсгалт хөлөг онгоцны нэгэн түүх миний анхаарлаас зайлж чадаагүй утга учиртай “өшөө авагч” гэсэн тэр нэр энэ бүхэнд гайхаж гиюурсэн минь хэмжээгүй билээ. Би капитан Немогоос нүд салгаж чадахгүй байв. Тэр хүн тэнгисийн зүг хуруугаараа зааж тэрхүү онгоцны ариун сэг рүү шунахай нүдээр ширтэн бүлгээ.

Ер нь капитан Немо гэдэг чухам хаа газраас хаана хүрэхээр яваа хэн гэдэг хүн болохыг би хэзээ ч олж мэдэж эс чадах байж юу магад билээ. Гэвч би түүний царайнд эрдэмтэн хүнээс бүр илүү ямар нэгэн төлөв байдал олж харав.

Үгүй ээ? Капитан Немо болоод түүний нөхдийн энэ төмөр ханан дотор хүн төрөлхтөнг үзэн ядах жирийн нэг үзэл нуугдан байсан бус харин хэд хичнээн ч цаг хугацаа өнгөрсөн мартагдан үл арилах аймшигт догшин өс хорсол хадгалагдсан байсан биз.



Өшөөгөө авахыг тэр хүлээж байж ядан байсан байж юу магад?

Тэр зуур «Наутилус» өөдөө алгуур хөөрсөөр байв. Тэхэд “Өшөө авагч” бүдэг дүрс бага багаар алга болж харагдлаа. Удсан ч үгүй хөлөг яльгүй далбилзан ирсэн нь бид усан дээр ил гарсны тэмдэг байв. Яг тэр эгшинд би алсалсан дэлбэрэлтийн дуу сонсов. Би капитаны царай руу харвал тэр ажирсан ч үгүй.

- Капитан? гэж би дуудав.

- Тэр хариу дуугарсангүй.

Тэхээр нь би түүнийг орхичихоод онгоцны тавцан дээр гарлаа. Консель, Канад хүн хоёр хэдийн тэнд байжээ.

- Юун дэлбэрэлт вэ? хэмээн намайг асуухад Нед Ленд

- Их буун дуу гэж хариулав.

Би түрүүчийн хөлөг зогсож байсан зүг рүү харав. Тэхнээ нь тэр онгоц “Наутилус” руу хар хурдаараа ирж явав. Бидний хооронд зургаагаас хэтрэхгүй миль зайтай байв. Ямар онгоц вэ? Нед ээ?

- Үүнийг би цэргийн хөлөг гэж мөрийцөх байнам хэмээн Канад хүүн хариулж, энэ нь түүний аргамж төхөөрөмж, шураг модны өндрөөр шууд мэдэгдэж байна. Ай зайлуул, энэ хөлөг бидэн рүү довтолж энэ муу харласан хар «Наутилус»-ыг живүүлээд орхидог ч болоосой доо.

- Нед найз аа? хэмээн Консель хариулруун: Энэ онгоц “Наутилус”-т ямар ч гэм хийж чадна гэж дээ?Тэр «Наутилус»-ыг ямар усан доор дайрч, усан доор буудаж чадах биш

Энэ онгоц чухам хаанахын харъяатын онгоц болохыг та хэлчихэж чадах уу? гэж би Недээс асуув.

Канад хүн хөмсгөө зангидан нүдээ жартайлган багаж уул онгоцон тийш хүчлэн харж байснаа:

- Чадахгүй нь ээ, профессор гуай хэмээн хариулаад,

- Түүн дээр туг алга. Тиймээс би хаанахын харъяатын болохыг нь хэлж чадахгүй нь. Гэвч би түүнийг цэргийн онгоц мөн гэдгээ дахин давтах байна. Учир нь түүний гол шурган дээр урт хийморь хийсч байна биш үү.

Бид цагийн хагасын хагас хэр бидэн рүү шууд чиглэн яваа онгоцыг ширтэн зогслоо.

“Наутилус”-ыг тэр едий хол газраас танилаа гэж би бодохоосоо, манай энэ усан доогуур явагч хөлөг онгоц байдаг эсэхийг тэр мэддэг эсэхийг би тааварлан эс чадах билээ.

Тэгтэл ч тэр онгоцыг давхар ган хуяг ба мөргүүл зэвсэгтэй цэргийн том хөлөг гэж надад Нед Ленд тайлбарлан өглөө. Түүний яндангаас өтгөн хар утаа баргилж байв.

Буулгасан далбаанууд нь шурагнахаа хөндлүүдэд эвхэгджээ. Түүн дээр ямар ч туг далбаа харагдсангүй. Агаарт нарийхан тууз мэт намирч байгаа хийморийн нь өнгө холоос танигдахгүй байв.

Уул хөлөг түргэн ойртож явав. Хэрэв л капитан Немо түүнд ойрхон ирэх боломж өгвөл бидэнд аврагдах завшаан тохиолдож болох байв.

Профессор гуай? хэмээн Нед Ленд өгүүллрүүн - энэ онгоц бидэнд нэг миль хэр ойртон ирэхэд нь би ус руу үсэрнэ. Та ч гэсэн миний үлгэрээр орохыг зөвлөх байнам.

Би Канад хүний хэлсэнд юу ч хариулсангүй зөвхөн л харваас бараа нь улам бүр тодорч буй хөлгийн зүг ширтсээр байв. Хэрэв л бид тэрэн хүртэл самарч чадах юм бол уул онгоц англи, Франц, америк, орос хаанахынх ч байв заавал биднийг тосон авах билээ.

- Эзэн хэрэв мартчаагүй бол бид усанд самрах бага сага барил бий сэн байх аа хэмээн Консель хэлээд, хэрэв л эзэнтэн эрхэм Нед Ленд үгэнд орохоор шийдэх бол өөрийн биед туслалцах эрх надад өгч болох байнам гэв.

Түүнд нь би хариу хэлэхийг завдтал, цэргийн хөлөгний урд хоншоор дээр цагаан утаа бургих харагдлаа. Хэдэн секундйн дараа ямар нэгэн хүнд юм унасны улмаас хөөсөрч давалгаалсан ус “Наутилус”-ын хойт тал руу цалгилаа. Гэтэл миний чих буун дуунд дүлийрч явчихав!

- Юу? Биднийг тэд буудна гэнэ ий? хэмээн би бархирч билээ.

- Зоригтой л улс байна гэж Канад эр шивгэнэж байв.

- Тэхээрээ тэд, биднийг аюул сүйрэлд учирсан улс гэж тооцохгүй байгаа байжээ! хэмээн би дуун гарлаа.

- Эзэн хэрэв таалахсан бол.,. хэмээн Консель эхэлтэл бас нэгэн сум түүнд нэн ойрхон тусч, түүнийг хөлөөс нь толгой хүртэл нь усаар булаав.

- Эзэн хэрэв зөвшөөрөхсөн бол хэмээн тэр яриагаа залгуулж тэд биднийг нарвал хэмээн бодож буудаж байгаа биз гэж би хэлэх байнам гэлээ.

Гэвч тэд хүн байгааг харах ёстой байсан шүү гэж би хашгарав.

Харсан байгаад л тэд, тэр тусмаа буудаа биз хэмээн Нед Ленд над руу сорих байдалтай харлаа.

Энэ үг үнэхээр ч үнэн үг юм шиг надад санагдав-Нээрээ ч өнөө үл танигдах гайхлыг одоо чухам юу гэж үзэхийгээ бүх дэлхий бүгдээрээ мэдэж буй нь

эргэлзээгүй “Авраам Линкольн”-той тулгарах тэр цагт канад хүн өөрийн хурц жадаар түүнийг бүлэх үед, тэрхүү аймшигт “гайхал” гэдэг нь юун хамгийн том нарвалаас ч нэн аюултай, усан доогуур явагч хөлөг онгоц байснаас эс зайлсныг капитан Фарагут таньж амжсан байх ёстой.

Тэр их сүрт мэдээ бух улс түмнийг донсолгон доргиж, одоо биднийг орон бүхний цэргийн хөлгүүд мөрдөж буй гэж мэдэх хэрэгтэй байв.

Хэрэв л капитан Немо «Наутилус»-ыг өөрийн өс хонзонгоо авах хэрэгт зориулсан нь ил бол энэ нь хэн хүний сэтгэл санаанд үл ором хамгийн аюултай, хамгийн догшин зэвсэг мөн тул тэгж мөрдөх нь ч зүйн хэрэг билээ.

Тэр нэгэн шөнө Энэтхэгийн гадаад далайд, капитан Немо биднийг шоронд хорьсон тэр нэг удаа «Наутилус» ямар нэгэн халаг онюцтой тулалдсан гэдэгт одоо би үл эргэлзэх боллоо. Түүнчлэн бас хүүр оршуулах далайн шүрэн ёроолд амгалан нойрсч буй тэр хүн, «Наутилус» -ын зориут өдөөсөн тэр хэргийн золиос мөн гэдэгт би үл эргэлзэнэ.

Капитан Немогийн далд амьдралын урдуурхи хөшиг жаахан боловч сөхөгдөж байв. Хэдийгээр түүний бие хэн болох нь танигдаагүй боловч ямар ч л гэсэн үндэстэн бүхний төлөөлөгчид одоо хүч хавсран мөрдөж буй нь зүүд зэргэлээ мэт хий хоосон амьтныг биш, харин бүх хүн төрөлхтөнтэй үл эвлэрэх тангараг тавьсан, хүний өшөөт дайсанг мөрдөж байв.

Энэ бодол миний тархинд орж ирэхийн хамт, бидэн рүү ойртож яваа тэр онгоцон дээр бид хань нөхдөө олох нь биш, харин өөрсдийгөө үзэн ядах дайсантай учрахаа сая ойлголоо.

Энэ завсар их буун сум биднийг тойрон буусаар байв. Усны гадаргуу дээр тодорхой өнцгөөр туссан зарим сум, ус долоон хальт үсрэхдээ, алслан одож давалгайн дунд шигдэн үгүй болж байв. Гэвч “Наутилус”-ын тавцан дээдэр нэг ч сум туссангүй.

Энэ хэр, цэргийн хөсөг биднээс гурван миль, хүрэхгүй зайтай байлаа.

Улам бүр ширүүсч байгаа буудлагыг харгалзахгүйгээр капитан Немо гарч ирэхгүй байв.

Хэрэв л тэдгээр гозгор сумны нэг нь “Наутилус” -ын хуягийг шууд ирж мөргөөгүй бол тэр их буудлага усан доогуур явагч хөлөг онгоцонд аюул учруулж болохгүй байв. Тэгтэл Канад хүн айн өгүүлрүүн:

- Ноён гуай, тэд бидний тухай муу юм санахыг цаашид зөвшөөрч болшгүй: Дохио өгөөд үзье. Хар мянган чөтгөр гэж! Тэд чинь шудрага хүмүүстэй ийнхүү харьцаж

байгаагаа мэдэж ч юу магад;

Нед Ленд халааснаасаа нусныхаа алчуурыг гаргаж, эвхээсий нь дөнгөж задалж амжтал бахь мэт хатуу гар түүнийг барьж аваад онгоцны тавцан дээр асар их хүчээр гуядав.

- Заяа чинь харламар! хэмээн капитан хашгараад;

- Энэ муу хөлгийг би няц дайрахаас өмнө надад чи нам цохиулах чинь дутаа юу? гэв.

Капитан Немогийн үгийг сонсоход зүрх шимшрэм авч түүний царайг харахад бүр ч аймаар байв. Түүний царай үхдэл хүүр мэт цонхийж хөхрөөд уурсаж хилэгнэсний улмаас харц нь жартай хялайсан байлаа. Тэр дуугарахаасаа архирч бүлгээ. Хөөрхий муу Недийг тавцан дээр хэвтээгээр нь золтой л няхчихсангүй.

Нед Лендийг тэр, сая нэг орхиод биднийг өдий болтол буудсаар байгаад нөгөө цэргийн хөлөг рүү хандлаа.

- Намайг чи хэн болохыг мэдэх үү! хэмээн тэр тэнгэр адил тачигнан загнаж, чамайг би танья гэвэл тугий чинь үзэхийн хэрэг надад алга! Хар чи! тэгвэл би чамд өөрийн тугийг үзүүлье! гэж бархирлаа.

Тэгээд капитан Немо, өмнөт туйл дээр хатгасан тугтай адилхар туг дэлгэлээ.

Яг энэ уед «Наутилус» -ын хойт тал дээр нэгэн сум туссан боловч гэмтэл учруулсангүй. Гэвч тэр капитан Немо арай л хөндсөнгүй далайд элс унав.

Капитан мөрөө хавчисхийж над руу эргэнгүүт :

- Та ч тэр, таны нөхөд ч тэр, доошоо орцгоо!.. гэж ширүүн зандрав.

- Капитан та, хөлгийг үнэхээр дайрах гэж байгаа юм биш биз? гэж би хашгарлаа.

- Дайрахаар ч барахгүй устгана гээч!

- Та тэгж болохгүй.

- Тэхээр ч барахгүй хэмээн капитан хүйтэн царайлан хариулаад, танд намайг шүүх эрх алга! Танд үзүүлэх ёсгүй юмыг та санамсаргүй үзчихлээ. Миний дайсан над руу дайрсан болохоор би түүнд зохих хариулт өх болно гэв.

- Гэвч энэ хэний хөлөг бол?

- Та танихгүй байна уу,? Тэр тусмаа сайн. Юу ч боловч хэний болох нь танаас нууц үлдэх болно. За, яв та?

Канад хүн, Консель бид гурав түүний үгнээс зөрж зориглосонгүй. “Наутилус”-ын арван таван усан цэрэг ойртож яваа хөлгийг үзэн ядаж, өшин хараасан нүдээр ширтэж капитанаа тойрон зогслоо. Намайг шатаар дамжиж доошилж явах үед бас нэг сум ирж “Наутилус”-ын бөгсөн бие дээр тусав. Тэхэд капитан:

- Бууд, чи муу бүтэлгүй онгоц! Хэнд ч хэрэггүй сумаа барж л бай! Чи «Наутилус»-

аас зугатаж гарна аа. Гэвч чамайг энд энэ орчинд устгахгүй чиний муусайн хэмхэрхий сэг «өшөө авагчийн» ариун үлдэгдэлтэй холилдон байхыг би хүсэхгүй гэж хашгачиж байв.

Би өрөөндөө орж очлоо. Капитан, өөрийн туслагчтайгаа дээр үлдсэн билээ. Тэгтэл ч сэнс эргэлдэн ирж, “Наутилус”) хурдлан зайллаа. Удсан ч үгүй нөгөө хөлөг онгоцны сум үл хүрэх газар холдсон байв. Гэвч биднийг мөрдөх явдал дуусвар болсонгүй тул капитан Немо саяын авсан зайгаа яг хадгалан явлаа.

Өдрийн дөрвөн цагийн үед би сэтгэл догдлон байж ядахын эрхэнд шатанд ойртон очив.

Тэндэх үүд нээлттэй тул би тавцан дээр сэм шурган гарлаа. Тэнд капитан сэтгэл үймэрсэн янзтай урагш хойшоо алхалж байв. Биднээс ямар нэгэн тав зургаан миль зайтайгаар, салхин доод талд яваа онгоцноос тэр нүд салгахгүй байлаа. «Наутилус» тэр хөлгийг зэрлэг араатан мэт тойрон давхиж өөрийн хойноос мөрдөх боломж олгон зүүн тийш нь дагуулж бүлгээ. Капитан энэ завсар, шийдвэрээ өөрчилж эргэлзэж ч байж юу магад?

Тиймээс би уул хэрэгт дахин оролцохоор шийдэв. Гэвч намайг дөнгөж хэдхэн үг хэлж амжтал, капитан Немо миний дуугарахыг яг хорилоо.

- Хэргийн зөв шудрага тал миний талд гэж мэд хэмээн тэр хэлээд - Би дарлагдсан хүн, харин тэр бол дарлагч этгээд! Үүнээс л болж би ах орон, эхнэр хүүхэд, эцэг эх аль бүхнээ надад үнэтэй хайртай юу л байдаг бол, тэр бүхнээ бүгдий нь алдсан юм! Миний үнэн голоосоо үзэж яддаг бүхэн энэ л онгоцон дээр байгаа! Дуугаа тат! гэлээ.

Би, наашаа хар хурдаараа довтолж буй цэргийн хөлгөн зүг сүүлчийн удаа хараад доошоо бууж Нед Ленд, Консель хоёр дээр очлоо.

- Бид эндээс яавч зугатах ёстой! хэмээн хашгарав.

- Тун сайн хэмээн Нед хэлээд - Гэвч тэр хэний хөлөг вэ? гэж асуув.

- Тэрнийг би мэдэхгүй. Хэнийх ч байсан тэрнийг шөнө болохосс нааш устгаж живүүлэх болно. Зөв бурууг нь бид тунгааж эс чадах гэмт хэрэгт гар бие оролцохоос, тэр онгоцтой хамт үхсэн маань дээр.

- Миний бодол ч мөн тийм байна. Шөнө болохыг хүлээе гэж Нед Ленд хэлэв.

- Шөнө ч болов. Онгоцон дээр чив чимээгүй байв. “Наутилус” өөрийн чиглэлийг өөрчилснийг луужин зааж байлаа. Би түүний сэлүүр сэнсний жигд эргэлтийн чимээг сонсч байв. Тэр усан дээр ил явлаа.

Бид тэрхүү хөлөг онгоц биднийг харж чадах буюу ядаж бидний дууг сонсох, тийм ойр зайнд ойртон ирэхэд нь зугатахаар тогтлоо. Гурав хоногийн дараа хуучин сар

далд орох учиртай бөгөөд энэ хэр далай дээр сав саруул байв. Тэр хөлгөн дээр гараад бид, түүнийг үхлээс аварч эс чадсан ч, ямар ч л гэсэн цаг үеийн байдлаас болж чадах бүхнээ хийхийг оролдоод алдах байлаа.

“Наутилус” тулалдах гэж байх мэт надад олон удаа санагдлаа. Гэвч дайснаа тэр нэг хэсэг ойртуулаад дахин хурдалж зугатан одож байв.

Шөнийн хагас амар тайван өнгөрлөө. Бид оргон гарах зохистой минут хүлээн хааяа нэг хоёр үг солилцож байв. Нед Ленд нөгөө онгоц руу самран хүрэхээр шийджээ. Түүнийг би түр хүлээлгэж бүлгээ. “Наутилус” өөрийн дайсан руу, усан дээр ил дайрна гэдэгт би итгэж агсан тул бидний зугаталт зөвхөн боломжтойгоор барахгүй хялбархан байлаа.

Өглөөний гурван цагт би, тэсч ядахын эрхэнд тавцан дээр дахин явж гарав. Капитан Немо мөн тэнд ажээ. Тэр онгоцныхоо хоншоор талд зогсож хар туг нь толгой дээр нь дэрвэж байлаа. Тэр, нөгөө онгоцноос нүд салгахгүй л байв. Түүний хүчлэн ширтсэн харц, тэр онгоцыг илбэдэх мэт, өөр рүүгээ татан, үл үзэгдэх ган аргамжаар хойноосоо чирэх шиг надад санагдав.

Сар яван явсаар уртраг давж байв. Алс дорно зүгээс Бархасвадь гарч байлаа. Эргэн тойрон чив чимээгүй ажээ. Тэнгис далай, тэнгэр газар бүгд л аль маань амгалан бэ хэмээн өрсөлдөх шиг санагдлаа.

Байгалийн тэрхүү амгалан тайван байдлыг, баригдаж танигдашгүй “Наутилус”-ын мухар бүхэнд буцлан буй үзэн ядах үзэлтэй жишиж би бодоод, хамаг бие минь халуун оргих шиг боллоо.

Нөгөө хөлөг биднээс хоёр миль зайтай байв. Тэр онгоц “Наутилус”-ын прожекторын цацаргах гэрэл туяагаар баримжаалан бидний араас давхиж ойртон явлаа. Би түүний дохионы улаан ногоон гэрэл фок-мачтын штог дээр дүүжлээстэй цагаан гэрлийн дэнлүү зэргийг ялган таньж байв. Түүний яндангаас улаан оч бутран явахыг харвал, уул онгоц уурынхаа даралтыг хязгаарт нь тулгасан бололтой.

Би онгоцны тавцан дээр өглөөний зургаан цаг хүртэл зогслоо Капитан Немо урьдын адил намайг анзаарахгүй байв. Нөгөө цэргийн хөлөг онгоц биднээс дөнгөж миль хагасын зайтай явлаа. Тэр дөнгөж үүрийн гэгээ манхаймагц буудаж эхлэв.

«Наутилус» дайснаа дайран орох цаг ойртсоор байлаа. Тэхтэй нь зэрэг л би болоод миний нөхөд зориглон буруушааж чадахгүй байгаа тэр нэгэн хүнийг үүрт орхиж одох ёстой билээ. Би Консель Нед хоёрт анхааруулахаар доошоо бууж орохыг завдан байтал, капитаны туслагч хэдэн усан цэргийн хамт тавцан дээр гарч ирэв.

“Наутилус” тулалдаанд бэлтгэж байв. Түүний бэлтгэл ажил тун хялбархан ажээ. Үүнд; тавцангийн хажуу хашлагыг буулгаж прожекторын ба жолоодлогын бүхээгийг дотогш нь татаж оруулаад л гүйцэх нь тэр. Түүний дараа үзвэл, урт гонзгор ган хөлгийн гадаргуу талд нэг шовгор товгор юм үл үлдэж, түүний шумбалт дайралтанд юу ч саад үл болох ажээ.

Би үзэсгэлэн танхимд эргэж ирэв. Өглөөний нарны анхны цацраг туяанд гэрэлтэж буй “Наутилус” онгоц далайн гадаргуу дээр ил хэвээрээ л байв. Нарны туяаны улаавтар цацрал цонхны шилэнд гялалзсан байлаа. Зургаадугаар сарын 2-ны аймшигт өдөр ингэж эхэллээ. Өглөөний 5 цагт “Наутилус” хурдаа хассаныг илт зааж байв. Нөгөө цэргийн хөлгийг ойртуулах гэж буй санааг нь ойлгов. Буун дуу улам л тодорсоор байв. Тэдгээр сум нэг л хачин исгэрч ус руу шөвөгдөн орж биднийг тойрон асгарч байлаа.

- За нөхөд өө хэмээн би өгүүлрүүн бидний зугатах цаг болжээ? За гар гараа барьчихъя, юу л болбол юу болог!

Нед Ленд шийдвэр дүүрэн байв. Консель мөн л амгалан хэвээр харин би л түгшсэн сэтгэлээ арай ядан далдалж байв. Бид явж номын санд орлоо. Би цааш нэвтрэх хаалгыг түлхэх яг тэр үед, тавцангийн дээд таг гэнэт хаагдчих чимээ сонсогдлоо.

Канадын харъяат шатны зуг ухасхийсэн боловч би түүнийг барьж зогсов. Бидэнд хэзээний танил. шуугин исгэрэх дуун “Наутилус”-ын багтаамж савнууд усаар дүүргэгдэж буйг гэрчилж билээ. Нээрээ ч хэдэн минутын дараа “Наутилус” арван метрийн гүнд орлоо.

Түүний энэ аашны учрыг би ойлгов. «Наутилус» тэр онгоц руу дээгүүр дайрахыг хүссэнгүй. Учир нь тэрхэн хэсэгтээ уул онгоц нэвтэлшгүй ган хуягаар хамгаалагдсан байх ёстой. Тиймээс, түүнийг гол шугамнаас нь доогуур, ган хуягны нь шувтрага хэсгээр усан доогуур доороос нь дайрах гэсэн байв.

Ингээд бид дахиад л олзлогдогсод болж хувирваа. Түүгээр ч барахгүй болох гэж буй энэ айхавтар хэргийн гэрч болох ажээ. Гэвч бодол болохын зав алга байлаа. Бид, миний өрөөнд хоргодцгоон бие бие рүүгээ дуугүй л ширтэж сууцгаав. Миний бодох сэтгэхийг аймшигт их аюул эзэлжээ. Би ямар нэгэн аймшигт явдлын урьд өмнө, хэн бүхэнд учрах аюул түгшүүрт автагдан нэн хүнд байдалд байлаа. Би өөрийн балрал сүйрлийг хүлээн шоржигнох чимээ бүрийг чагнаж, тэр чигээрээ сонор болон сууж билээ.

Энэ завсар “Наутилус” хурдаа нэн их нэмлээ. Бодвол тэр холоос хүч авч байх шиг

түүний хамаг бие донсолж байв.

Би гэнэтхэн чарлачихав. Тэхнээ нь “Наутилус” нөгөө онгоцыг мөргөсөн байлаа. Энэ бол санаснаас яльгүй ёворгоон болжээ. Гэлээ ч гэсэн түүний ган мөргүүл, тэр онгоцны модон ёроолыг ямар их хүчээр ив дайрсныг би мэдэрч байв. Юм хяхтнан, шажигнах чимээ дуулж билээ. Гэтэл, өөрийн дайралтын хар хүчинд тэр чигээрээ шуугин довтолж буй “Наутилус” нөгөө онгоцон дотуур даавуу нэвт гарсан зүү шиг цөм дайран гарчээ.

Би түүнээс хэт тэсч чадсангүй. Аюул хөнөөлийн хүчинд бараг галзуурсандаа өрөөнөөсөө үзэсгэлэн танхимд гүйж орлоо. Капитан Немо тэнд байв. Тэр баргар царайлан, үг дуу ч үгүй, үг дуулах ч янзгүй зогсон цонхон цаана болж буй юмыг ширтэж байв.

Бараг тийм гэхийн тэмдэггүй, асар том хар юм усан доор харлан харагдахад, түүний үхлийн эцсийн амьсгалыг үзэх гэсэн шиг, “Наутилус” мөн түүнтэй зэрэгцэн доошилж бүлгээ. Би өөрөөсөө арваад метр зайнд, бараг хоёр хэсэг болчихсон хөлөгний сэг байхыг олж үзэв. Түүн рүү ус айхтар сүрхий чимээ гарган, хүрхрэн юүлж байв. Дээхэн талд нь хоёр эгнээ зэрэгцүүлсэн гунан буу байх харагдлаа.Түүний тавцан дээр олон хар хар юм хөдөлж байв.

Ус юүлсээр л байлаа. Хөөрхийс дээшээ цоройлон, шураг өөд маажлан, усан дотор сарвалзан байв.Тэр бол үерт гэнэт автсан, хүмүүсийн үүр үлий байлаа.

Тэрхүү аймшигт үзэгдэлд элий балай болж, үстэй толгой минь өрвийн, арай чуу амин голтой байсан би цонхноос нүдээ салгах тэнхээгүй гөлөрсөн байв.

Тэр асар том онгоц аажуухан доошилсоор бүлгээ. “Наутилус” ч түүнийг дагалдан доошилж байв. Тэгтэл гэнэт дэлбэрэлт болов. Нягтарсан хий уул онгоцны тавцанг дэлбэ татсан нь дарь агуулах зоорь дэлбэрэхтэй адил байв. Дэлбэрэлтнээс шалтгаалсан усны тийрэлт нэн хүчтэй агсан тул “Наутилус” хол шидэгдлээ.

Одоо хөөрхий тэр онгоцны живэх нь хурдсав. Хүний хүүр бөгтөрсөн шураг модод тэдгээр хүүрний хүндэд дарагдан нумласан хөндлөвчүүд жирэлзэн өнгөрч дараа нь гол шургийн орой шоволзон далд орвол, хамгийн сүүлд далайн гүн цүнхлэгт өөрийн бүх багийн хамт шингэж орлоо.

Би капитан Немо руу эргэж харав. Тэр аймшигт шүүгч, үзэн ядах үзлийн жинхэнэ тэр эрлэг, урьдын адил харанхуй хар усны зүг ширтэн зогсов. Тэгээд хамаг хэрэг шувтарсны дараа тэр, өөрийн өрөөнд чиглэн одож, үүдий нь нээнгүүт босгыг нь алхав...Би түүний хойноос мөрдөн харж байв.

Өрөөний гүнд, түүний хайрт баатруудын хөргөн доор, бүр цэл залуугаараа буй



эмэгтэй хоёр хүүхдийн хамт авахуулсан зургийг би хананд өлгөөстэйг олж харав.

Капитан Немо тэднийг хэсэгхэн зуур ажиглан зогссоноо гэнэт сөхрөн унаж, хэнгэнэтэл уйлан хайлж билээ.

[Тор](#)

---

### КАПИТАН НЕМОГИЙН СҮҮЛЧИЙН ҮГ

Цонхны хаалтууд хаагдахын хамт аймшигт тэр үзэгдэл алга боллоо. Гэвч үзэсгэлэн танхимын гэрэл асахгүй л байв. “Наутилус” дээр нүдгүй харанхуйн зэрэгцээ чив чимээгүй ажээ. Энэ нэгэн аймшигт орчноос капитан Немо хурдлан зугатаж байв. Тэр хаашаа яваа бол? Урагшаа юу, хойшоо юу?

Би, Консель, Нед хоёр намайг чив чимээгүй суун хүлээж байсан өөрийн өрөөнд эргэж ирэв. Би капитан Немогоос болж тэсвэрлэж баршгүй их зовлонд учирсан билээ. Хүмүүсийн өөрсдийн нь үйлдсэн уршгаар, тэр хичнээн ч зовж зүдэрлээ гэсэн тэдгээрийг капитан ийнхүү цээрлүүлэх эрхгүй юм. Түүнчлэн тэр бас энэ хэргийн нэгэн гэмт этгээд надаар хийгээгүй ч гэсэн, өөрийн өшөө хорслыг авч буйн гэрч хийсэн билээ. Энэ нь даан ч дэндүү хэрэг болсон бүлгээ.

Арван нэгэн цагт цахилгаан гэрэл асав. Би үзэсгэлэн танхимд явж орлоо. Тэнд хэн ч алга. Би багаж руу харав. «Наутилус» умар зүгийг чиглэн цагт хорин таван миль хурдалж байв. Тэр усан дээр ил гаран, далд орон явлаа. Энэ хэр гучин футийн гүнд явав. Зураг дээр би өөрсдийн яваа газрыг эрж олбол, бид Ла-Маншийн арал орчноор өнгөрч, умарт далайнуудын зүг их хурдтай довтолсон ажээ.

Орой тийшээ бид Атлантын тэнгисээр хоёр зуун бээр давхисан байв.

Үдшийн бүрий өтгөрч, сар гартал далай дээр харанхуй болов.

Тэр шөнө би нойрсж чадсангүй. Намайг хар дарж байв. Нөгөө хөлгийн үхлийн аймшигт үзэгдэл миний нүднээс зайлахгүй байлаа.

Энэ өдрөөс эхлэн өдөрт явж өнгөрсөн замаа үзэсгэлэн танхим дэх зураг дээр тэмдэглэхийг зогслоо.

Умарт газрын уур манан дотуур, бууршгүй хурдтайгаар, Аглантын тэнгисийг туучин давхиж буй “Наутилус” умар зүг хэдий хэр хол гарсныг хэн хэлж чадах билээ? Тэр, Шпицбергенд үү, аль эсхүл Шинэ газрын эрэгт үү, чухам хаа дөхөж явна вэ? Магад ч үгүй. Цагаан далай, Карскийн далай, Облип мөргөцөг зэрэг бага

судлагдсан далайгаар дамжиж, Ляховын ольтриг, умарт Азийн бараг үл шинжлэгдсэн эрэг орчмоор гарсан ч байж. Үүнд ч би хариулт өгч чадахгүйсэн билээ.

Тэр байтугай цаг хугацаагаа ч би мэдэхээ байв. Өдөр шөнө жирийнхээрээ ээлжлэн ирэхээ ч больчихсон шиг санагдлаа. Би өөрийн сэтгэх мэдрэхүйг амьдралын үнэн бодит байдалд автагдахаасаа, Эдгар Погийн эрүүл бус сэтгэхүйд л нийцэх, ил далдын хүч, аймшигт орчинд нэрвэгдсэн шиг санаж байв. Тулж ирэх минут тутамд л Погийн зохиолын баатар Артур Гордон Пимийг үзсэнтэй адил, “Газар дэлхий дээрх хамаг амьтнаас хамаагүй том хүн дүрстэй амьтан бүтээлэг нөмөрчихөөд, умарт туйл хүрэх замыг хаан зогсож буй мэт” тийм амьтан надад үзэгдмээр шиг оргиж байв.

Миний бодвол гэвч би эндүүрч байж магадгүй-энэ нэгэн жуулчлал бидний аз дайрахад арван тав буюу хорь хоног үргэлжилсэн болов уу, тэрчлэн хэрэв л бидний энэ жуулчлалыг бүрмөсөн эцэс болгосон, тэр нэгэн хэрэг мандаагүйсэн бол энэ жуулчлал маань хичнээн ч удаан үргэлжилж байсныг би бас хэлж чадахгүйсэн билээ. Капитан Немо онгоцон дээр, ерөөсөө урьд өмнө байгаагүй мэт ер үзэгдэхгүй байв. Түүний туслагч ч гэсэн мөн адил. Онгоцны багийнхнаас хэн нь боловч нэг минут харагдахгүй ажээ. “Наутилус” бараг л үргэлж, усан доогуур явж байв. Тэр агаар сэлгээх гэж усан дээр ил гарч ирвэл түүний тавцангийн таг өөрөө нээгдэж өөрөө хаагдаж байв. Бид чухам хаа явааг бүр ч мэдэхээ байчихлаа.

Энэ бүх явдлын улмаас Канад эр маань бүр ч бухимдаж цөхрөнгөө бараад, өрөөнөөсөө гарахыг ч байв. Тэр дуугаа зориут хураажээ. Консель түүнийг дуу гаргаж нэг болбой нь үг хэлүүлж чадсангүйн зэрэгцээ, түүнийг эх нутгаа эрмэлзэн тэчьяадаж, байж ядахдаа-амиа хоролчих бий гэж айж байв.

Консель, Нед Лендийн хөдлөх бүрийг салахгүй ажиглаж байлаа. Иймэрхүү нөхцөлд амьдрах гэдэг тэсвэрлэшгүй гэдэг нь -мэдээж билээ.

Нэг өдөр чухам хэдний өдрийг нь хэлж үл чаднам, үүр цайхын үеэр би, шаналгаатай, хүнд нойрондоо дарагдан нам унтаж байв. Би нойроос гэнэт сэртэл, Нед Ленд миний толгойн тушаа над руу бөхийж зогсохыг харав.

-Зугатцагаая! хэмээн надад тэр шивнэх сонсдов.

-Хэзээ гэж асуулаа.

Өнөө шөнө «Наутилус» дээр одоо ямар ч ажиг сэжиг алга. Хөлгийнхөн ичээндээ орсон юм шиг болчихож. Та зөвшөөрнө биз.

- Зөвшөөрнө, Бид хаана явнаа?

- Ямар нэгэн үүл таних газар орчинд түүнийг би өнөө өглөө манан дунд эндээс зуун

зүгт хориод миль зайтай байхыг харсан.

-Ямар гээч газар вэ?

Би мэдэхгүй. Гэвч ямар ч газар байсан тэнд бид хоргодох арга сүвэгчлэх хэрэгтэй,

-Тэгье ээ, Нед минь... Бид далайд цацаж үхэх хувь тавилантай ч байсан өнөө л оргох ёстой;

- Далай догшин салхи хүчтэй байгаа хэдий боловч “Наутилус”-ын хөнгөн завиар хорин миль явах тийм ч хэцүү биш. Завинд би аахар шаахар юм, мөн хэдэн шил ус аваачиж хийсэн. Би таныг дагалдахад бэлэн байна!

-Хэрэв л бид баригдах болбол биеэ хамгаалан тэмцэнэ гэдгийг харин сайн мэдээрэй. Би бууж өгснөөс үхсэн нь дээр гэж бодном!

-Үхвэл бид хамт үхэцгээнэ, Нед ээ? Би яахаасаа ч буцахгүй байв. Канадын харъяат явж одлоо.

Би дээшээ тавцан дээр гарав.Тэнд далайн давалгаа нэн хүчтэй дэлсэж буй тул хөл дээрээ дөнгөн данган тогтож болох байлаа. Тэнгэр сүрдмээр муухай ажээ. Гэвч, энэ нэгэн өтгөн манангийн цаана хуурай газар буй тул оргох л хэрэгтэй билээ. Бид нэг ч өдөр нэг ч цаг дэмий өнгөрөөж болохгүй.

Би үзэсгэлэн танхимд эргэн ирлээ. Түүний хажуугаар би бас капитан Немотой тулгарахаас айж явав. Түүний хараа барааг үзмээр ч юм шиг, үзмээргүй ч юм шиг санагдав. Би түүнд юу гэх билээ? Түүний надад төрүүлж агсан тэр үр, аюулт байдлыг би түүнээс нууж чадах бол уу? Үгүй ээ! Бид учирсны хэрэггүй! Түүнийг таг мартсан минь дээр! Үгүйээ ямар ч болбой нь «Наутилус» дээр миний өнгөрөөвөл зохих энэ нэг өдөр сүүлчийн өдөр, юутай удаан үргэлжилнэ вэ! Би өдрийн турш гав ганцаар байв. Нед Ленд, Консель хоёр сэжиг авахуулчихаасаа айж, надтай үг ярихгүй байлаа. Зургаан цаг хагаст Нед Ленд миний өрөөнд орж ирэхэд :

-Бид оргон орготлоо дахин уулзахгүй гэж мэдээрэй. Арван цагт сар гараагүй л байх болно. Харанхуйг ашиглан завь руу шууд очоорой. Консель бид хоёр таныг тэнд хүлээнэ гэж хэллээ.

Канад хүн хариулах амжил надад өгсөнгүй гарч одлоо. Би “Наутилус”-ын явж буй чигийг шалгах гэж үзэсгэлэн танхимд эргэж ирлээ. Бид умарт-умарт дорнотыг чиглэн, тавин метрийн гүнд, гайхамшиг их хурдтай давхиж байв.

Энэ нэгэн музейд хадгалагдан буй байгалийн ба урлагийн гайхамшигт бүтээлүүд хуримтлуулсан эзэнтэйгээ хамт мөхөх хувь тавилантай, газар дэлхий дээр өөрсөдтэй ижилсэх тийм хосгүй ховор эрдэнэсмйн цуглуулга руу сүүлчийн удаа харцаа

хандуулав.Тэдгээрийг би ой ухаандаа удаан хугацаагаар дурсан хадгалахыг хүсч билээ. Таазнаа тунарч буй цахилгаан гэрлийн зөөлөн туяанд гэрэлтэн буй тэдгээр эрдэнийн үнэт сан шилэн бүрхүүл доор гялалзсан мяралзаж байхыг бүхэл бүтэн цагаар би ажиглан зогсч билээ.Дараа нь би өрөөндөө эргэж ирэв.

Тэнд би зузаан хувцсаа өмсч, өөрийн бүх тэмдэглэлийг цуглуулан хувцсан доороо нуулаа.Миний зүрх хүчтэй дэлсэж байв.

Сэтгэл түгшсэн миний байдал, сандарч тэвдсэн янз, хэрэв л би капитан Немогийн нүдэнд харагдвал намайг заавал илрүүлэх байлаа.

Энэ хэр тэр юу хийж буй бол? Би түүний өрөөний үүд рүү очиж чагнав. Алхлах хөлийн чимээ сонсдоно. Капитан Немо өрөөндөө ажээ. Юм шарчигнах чимээ болгон намайг цочоож байв. Тэр одоохондоо гарч ирээд л та яагаад оргох гэж байнаа гэж надаас асуумаар юм шиг санагдлаа. Намайг аймшиг түгшүүр эзэлж бодох сэтгэл минь хэмжээ алдлаа. Тэр байдал нэн шаналгаатай байсан тул капитаны өрөөнд шууд орж очоод л түүнтэй нүүр тулгарсан минь дээр биш үү? гэж би өөрийн эрхгүй өөрөө өөрөөсөө асууж билээ.

Тэр ч солиорсон хэрэг бололгүй яахав, аз дайрахад би, өөрийн биеийг яг цагт нь барьж чадсан юм. Би өрөөндөө буцаж ирмэгц орон дээрээ сунан унаж, тайвшрахыг оролдлоо.

Сэтгэл хөдлөх минь жаахан намдсан боловч уураг тархи хүчлэн ажилласан хэвээр байв.

“Авраам Линкольн”-ы тавцан дээрээс далайд унасан тэр цагаас хойш, “Наутилус” дээр амсаж өнгөрөөсөн азтай, азгүй явдлуудыг би дурсан санав. Усан доогуур үйлдсэн ан, Торрессын хоолой, Шинэ гвинейн зэрлэг хүмүүс, хайрдаж саатсан явдал, хүүр тавих шүрэн ёроол, Арабын хонгил, Санатории арал, Критийн усчин, Атлантид, мөсөн дэх олзлогдол, өмнөт туйл, хавтгайрсан их мөс, наймалжтай хийсэн тулалдаан, Гольфстримын догшин шуурга,«өшөө авагч» ингээд хамгийн сүүлд энэ нэгэн цэргийн хөлөг онгоц өөрийн бүх багийн хамт сөнөсөн аймшигт явдал, энэ бүхэн, тайзныхаа чимэглэлийг зогсоо зайгүй өөрчилж байдаг театрын үзэгдэл мэт, миний нүдний өмнүүр жирэлзэч өнгөрөхөд тоглолт болгонд капитан Немо бахь байдгаараа л оролцож харагдлаа. Энэ бол бусад хүмүүстэй адил хүн биш, харин усны ямар нэгэн нууц төрөлтөн, тэнгисийн суут ухаантны нэгэн байлаа.

Есөн цаг хагасын харанга цохилоо. Миний толгой балмагдан дүрэлзэх мэт тул би түүнийг хоёр гараараа дарж нүдээ аньсан билээ. Би юу ч бодохгүйг оролдов. Ахиад хагас цаг үлджээ... Энэ тарчилж үхэм хагас цагт би, ухаан солиорсон буйзаа;..

Тэгтэл ямар нэгэн дууны уйтгарт аялгууны үл мэдэг дуу гэнэт надад сонсдов. Би арай чуу амьсгалан, хөгжмийн уянганд бүрмөсөн нэрвэгдсэн капитан Немогийн нэгэн адил тэдгээр аялгууг аль байхаараа хичээж чагналаа.

Гэтэл нэг бодол гэнэт намайг ниргэх шиг болов. Тэхнээ нь завь руу очихын тул би зайлшгүй дайрч гарах үзэсгэлэн танхимд капитан Немо хөгжимдөж байгаа ажээ. Тиймээс би түүнтэй сүүлчийн удаа уулзах болно. Тэр надтай яриа үүсгэх ч юу магад: Тэрний нэг зангалт намайг устгаж нэг үүг нь энэ онгоцон дээр насаар минь үлдээж чадах бүлгээ.

Тэгтэл ч ашгүй арван цагийн харанга цохив өрөөгөө орхиж, нөхөдтэйгөө очиж нийлэх цаг болжээ. Иймд капитан Немо миний зам хөндлөн зогсдог юмаа ч гэсэн эргэлзэн гуйвж би үл чадах байв.

Би тун их болгоомжилж хаалга нээвэл тэр муу хаалга нугасан дээрээ маш муухай чахран дуугарах шиг санагдав. Энэ чахаргаа зөвхөн миний санаа дагасан ч байж магадгүй. “Наутилус”-ын харанхуй хонгил дундуур би тэмтчин явж, зүрхнийхээ цохилтыг дарахын тул алхам тутамдаа зогсож билээ.

Арайхийж сая нэг юм, үзэсгэлэн танхимын үүд хүрч аяархан нээв.

Үзэсгэлэн танхимд пад харанхуй ажээ. Гэвч, ятга хөгжмийн эгшиг намуухан дуугарч байв. Капитан Немо тэнд байлаа. Тэр намайг харахгүй байв. Миний бодоход намайг тэр өдрийн хурц гэрэлд ч гэсэн үзэхгүй байсан биз. Түүний уярсан, гунихарсан нь даан ч их байв.

Би дотогш орохын хамт, өчүүхэн боловч чимээ гаргаж капитан Немод мэдэгдчихээсээ айж хивсэн дээр гишгэв. Тэндээс цаашилж үзэсгэлэн танхимын цаад талд байгаа, номын сан руу дамжин орох үүд хүрэх гэж бүхэл бүтэн таван минут гарзадлаа.

Би үүдийг нээж орохоор зэхэж байтал, капитан Немо санаа алдах дуу гэнэт сонсодлоо. Тэр дуу намайг газартай хадчих шиг болов. Капитан Немо ятга хөгжмийн дэргэдээс босч явахад би, түүний бүдэг дүрсийг номын сангаас тусч байгаа өлбөгөр гэрэлд ялгаж байв. Капитан хоёр гараа цээжин дээрээ зөрүүлэн тавьж, над руу алгуур ойртож байлаа. Тэр явах биш, сүүдэр мэт гулгах шиг санагдав. Капитан мэгшин уйлах тул түүний хэнхдэг дээр дээр гарч байв. Би түүний шивнэн яваа сүүлчийн үгийг сонсов.

- Болог, гүйцэг! гэсэн үг би сонссон билээ. Тиймээс юу ч л болсон энэ нэг хүнийг нинжин сэтгэл хэмэлсээр байгаа ажээ.

Миний ухаан санаа өөрийн биш болж, номын санд харайн орсон билээ. Би

шатаар дээшээ дамжин нөхөд рүүгээ очлоо.

- Зугатцагаая! Зугатцагаая! гэж би шивнэв

- Одоохон! хэмээн Канад хун хариулах сонсдов. «Наутилус» -ын төмөр хуягны дээд нүхний хүрээ англи түлхүүрээр эрэгдэгддэг билээ. Гэвч Нед Ленд тийм түлхүүр хэдийн урьдчилан зэхжээ. Уул нүхний таг мөн тийм аргаар бөхлөгджээ. Усан доогуур явагч хөлгөнд бидний завийг барьж тогтоож байсан эцсийн тэр нэг эргийг Нед Ленд мулттрахаар ажиллах үед, онгоцны гүнээс наашилж буй хүнгэнэх чимээ гэнэт бидэнд сонсдов. Тэр юу байдаг билээ? Тэнд бидний алга болсныг мэдчихсэн юм болов уу?

Нед Ленд миний гарт хутга шургуулж байхыгби мэдрэв.

- Тиймээ хэмээн шивнэн өгүүлэхдээ, бид үхэхэд бэлэн байх л ёстой гэлээ. Канад хүн ажлаа зогсоов.

Тэгвэл, арав хорь дахин давтсан цор ганцхан аймшигт үгний утга л “Наутилус” доторхи хачин үймээний учрыг надад хэлж өгсөн билээ.

Тэр үг бидэнд ямар ч хамаагүй байлаа. Үүнд “Наутилус”-ынхан “Мальстрем, Мальстрем” хэмээн шуугилдсан бүлгээ.

“Мальстрем!” энэ бол бидэнд сонсогдошгүй хамгийн аймшигтай үг байв.

Тиймээ бид Норвегийн эрэг орчны хамгийн аюултай газар яваа ажээ! Биднийг эндээс мултарч гарахаар завдан байсан яг тэр эгзэгтэй минутад “Наутилус” тэнгисийн энэхүү үхлийн эргүүлгэнд орж явчих хувьтай байв гэж үү?

Тэнгисийн үүрэлтийн үед, Франц ба Лофотенын арлын хооронд шахагдсан ус үүгээр булай их хүчтэй урсдаг нь мэдээж билээ. Тэр их ус энд, аймшигт хүчтэй эргүүлэг үүсгэх бөгөөд орчихсон хөлөг онгоцон дундаас одоо болтол нэг нь амьд мэнд гарч байсангүй ээ. Далайн төвшний дөрвөн зүг найман зовхисоос, энэ рүү аврага аврага мушгирсан их давалгаа орж ирдэг бүлээг. Тэд эндхийн ийнхүү ёроолгүй гүнд, уул эргүүлгийг үүсгэж, төв рүү тэмүүлэх хүчин нь хааш хаашаа арван таван километр орчинг хамардаг билээ. Энэ усан эргүүлэгт зөвхөн далайн хөлөг онгоцнууд сөнөөд зогсдоггүй тэр байтугай умарт газрын цагаан баавгай, халим хүртэл орж үхдэг байв.

Тэгээд л энэ рүү капитан Немо еерийн “Наутилус”-ыг магад ч үгүй тэхээс тэгэх гэж, эсхүл өөрийн эрхгүй хөөж авчирсан бизээ. Манай хөлөг алгуур тойруу замаар гүйж байхад, дугуй замын маань радиус улам богиносож байв. Түүний зэрэгцээ “Наутилус” - ын бөөрөнд бэхлээстэй бидний өчүүхэн завь ч гэсэн аймаар хурдан эргэлдэж эхлэв. Би эргэлтийг мэдэрч, толгой нүд эрээлжилж зовлонт хүнд байдалд орлоо. Ухаан зайлам аймшигт бодолд бид автагдсанд маань гүйх цус зогсчих шиг

болов. Зүрх цохихоо болив. Бид үхлийнхээ эцсийн эгшинд тарчлах мэт хамаг хүйтэн хөлс маань цутгаж байлаа! Бидний энэ нэгэн хэврэг завийг тойрон ямар их шуугиан дэгдэнэ вэ? Арван миль газар тасралтгүй дахин давтан цуурайтаж буй юун их хүрхрээ билээ; Хамгийн мундаг бүдүүн модны гол боловч шальгүй зомгол болтлоо зад цохигддог тэр их гүн усан доорхи хаддын өнцөг ирмэг халз мөргөн бут үсэрч буй долгион, сүртэй хүржигнэнэ вэ!

Юутай их аймшиг вэ?

Биднийг аймаар сүрхий савлан шидэлж байв. “Наутилус” давалгааны дэлсэлтийн эсрэг амьд амьтан шиг үзэлцэж байлаа.

Түүний ган булчин шажигнана. Заримдаа хөлөг маань бөгсөн дээрээ өөдөө цоройн босч байв.

- “Наутилус”-аас сайн барих хэрэгтэй хэмээн Нед ! хэлээд - Эрэгдэж авсан эрэг эрэгнүүдээ буцааж чангалахыг оролдоё. Хэрэв л бид “Наутилус”-аас салахгүй л бол амь гарч магадгүй...

Түүнийг яриагаа төгсгөж чадаагүй байтал нь аймаар хий чимээ гарлаа. Тэхнээ нь завийг хөлөгтэй барьж бэхэлж агсан эрэгнүүд тас тас үсэрч, өөрийн хэвтэр хонхроос ховх татагдсан бяцхан завь маань усан эргүүлгийн гол дунд нь дүүгүүрийн чулуу мэт шидэгдсэн билээ.

Би хөлгийн төмөр хуягийг толгойгоороо мөргөж хүчтэй дэлсэлтэд ухаан алдлаа.

[Тор](#)

---

## ТӨГСГӨЛ

Усан доогуур үйлдсэн бидний жуулчлал тийнхүү төгсгөл болсон билээ.

Тэрхүү айхгар усан эргүүлэгнээс, манай завь мултарч гарсан тэр аймшигт шөнө юу болж өнгөрсөн, Нед Ленд, Консель бид гурав ёроолгүй гүн тамаас чухам яаж аврагдсан зэргийг би хэлж үл чадна, Би, Лофотенийн арал дээр загасчны муу овоохойд ухаан орсон билээ. Миний хоёр нөхөр, эндэж осолдсон юмгүй хоёулаа миний дэргэд зогсож гарыг минь баяртай нь аргагүй барилан байв. Бид чанга тэврэлдэн уулзлаа.

Жилийн энэ нэгэн үед, францад эргэж очих тухай бодохын ч хэрэггүй байв.

Умарт ба өмнөт Норвег хоорондын харилцааны зам муу билээ. Цаг агаар сайжрах үеэр Умарт хушуун тийш явдаг галт онгоцыг бид хүлээх хэрэгтэй байв.

Биднийг аварсан эдгээр жирийн найрсаг хүмүүсийн дунд байх завсраа би өөрийн адал явдлын тэмдэглэл өгүүллэгүүдийг дахин хянаж үзэх болю. Тэмдэглэл маань аргагүй л хангалттай байв. Нэг ч зүйл орхигдсонгүй, нэг ч юм буруутсан буюу гуйвсангүй. Энэ бол хэзээ нэгэн цагт шинжлэх ухаан өөртөө чөлөөт зам тавих, одоо хэрдээ хүн хүрч очихын аргагүй орчинд үйлдсэн ер бусын аян замын үнэн баримтат түүх бүлгээ.

Миний бичсэнд ер нь хүмүүс итгэх бол уу бүү мэд. Үгүй ээ, надад ямар ч хамаа байхав дээ?

Миний хувьд л би, зөвхөн арван сар хүрэхгүй хугацаанд дэлхий тойрсон жуулчлал хийж, улаан ба Газрын дундат, Атлант Номхон, Энэтхэгийн, Умарт ба Өмнөт мөсөн далайн усан доогуур хорин мянган бээр аялсан минь л үнэн байвал барав.

Тэхэд “Наутилус” юу болоо бол? Тэр усан эргүүлэгнээс мултарч чадаа бол уу? Капитан Немо одоо амьд байгаа бол уу? Тэр өшөө авах аймшигт хэргээ үргэлжлүүлсээр бол уу, эсхүл тэр нэгэн цэргийн хөлгөөр эцэс болгоо бол уу? Түүний амьдралын бүх түүх намтар бичигдсэн тэр нэгэн гар бичмэлий нь далайн долгио хэзээ нэгэн цагт авч ирэх болов уу? Тэр нэг сөнөсөн онгоцны гарал үүслээр, капитан Немогийн яс үндсийг мэдэж болох бол уу?

Үүнд би итгэнэм. Түүнчлэн түүний гайхамшигт хөлөг онгоц тэнгисийн тэрхүү, аймшигт цүнхэл ус, эргүүлгийг ялсан гэдэгт ч миний бие итгэнэ. Төдий олон онгоц сөнөж мөхсөн тэр газраас “Наутилус” мэнд гарсан байх ёстой! Хэрэв л энэ үнэн бол, хэрэв капитан Немо өөрийн эх орон болсон тэнгис далайгаар дахин зөрчин яваа бол, түүний догширсон зүрхний үзан ядах үзэл унтрах болтугай. Тэрний харж үзэж яваа гайхамшигт зүйлсийг гэрэл туяа өс хорслын нь галыг унтраах болтугай! Аймшигт ширүүн тэр шүүгч тэнгис далайд энх амгалан судалгаа хийж буй эрдэмтэнд байр сууриа тавин өгч, бүрмөсөн арилах ёстой. Капитан Немогийн хувь заяа ер бусаар ч барахгүй агуу их юм. Тэр нэгэн үл танигдах хачин хүнтай, арван сарын турш суудал зэрэгцэн суусан би түүний тухай мэдэхгүй бол өөр хэн мэдэх билээ. За тэгээд, одоо зургаан мянган жилийн өмнө “Тэнгис далайн ёроолгүй гүн цүнхлийг, хэзээ нэгэн цагт, хэн хэмжсэн юм бэ?” гэж “Экклезиастын” асуусан асуултанд замбуулин дээрх бүх хүмүүсийн дотроос хоёрхон хүн “Би!” гэж хариулах эрхтэй билээ. Тэр бол капитан Немо, бид хоёр бүлгээ.



[Тор](#)

Эх сурвалж:

[www.e-pada.com](http://www.e-pada.com)

Формат, фонт зэргийг бага зэрэг янзалж pdf  
хэлбэр уруу хөрвүүлсэн:

The Weatherman

<http://weatherman.blog.banjig.net/>